Спартак миний өмч хэвээр үлдэнэ гэж тэр найдаж байсан учраас Спартакт баяр хүргэх гэж хүүр зайлуулагч хүмүсийн хамт талай дээр үнэхээр гарч ирсэн байжээ. Гэвч одоо Акциан Спартакийн баатар зоригийг хараан зүхэж байв. Яагаад вэ гэвэл ард түмний мунхаг өрөвдөх сэтгэл, Суллын цагаа олоогүй өршөөл хоёр түүнд арван хоёр мянган сестерцийн гарц учруулжээ.

Спартак эзэн байсан хүнийхээ тэр үгийг сонсоод санагалзан зүүдэлсэн биш гэдгийг сайн мэдэж, аварга том бие ийнхээ бүх мөчийг тэнийлгэн сүртэй гэгч босч, эхлээд Суллад дараа нь ард түмэнд мэхэсхийн ёслоод, хүмүүсийг нижгэнтэл алга ташуулсаар циркийн талбайгаас гарч одов.

Бяцхан Кассий нь мөн өөрийн хамгийн сайн найз Кай Меммий Геммел гэдэг залуу хүү хоёртой ярилцаж байсан Тит Лукреций Кар тэр яриагаа цааш үргэлжлүүлэн, үгүй! Эд юм бүхнийг тэнгэр бурхан бүтээсэн биш ээ! гэж энэ үед хэллээ. Лукреций аль тэр үед сэдэвлэн бодож байсан. “Эд юмын мөн чанар” гэсэн найраглалаа хожим Геммелд зориулсан билээ.

-Тэгвэл ертөнцийг бүтээсэн юм бий? Гэж Кассий асуув.

Материйн мөнхийн хөдөлгөөн нүдэнд үл үзэгдэх молекул биесийн нийлбэр л бүтээсэн юм. Ай чи дэлхий дээр, тэнгэрт үүсч байгаагүй олон биесийг хараад бий болгогч нууц шалтгааныг мэдэхгүй, тэдгээрийг тэнгэр бурхан бүтээсэн гэж боддог биз. Оргүй хоосон юу ч хэзээ ч үүсэн гараагүй бөгөөд гарч чадах ч үгүй юмаа.

-Тэгвэл Юпитер, Юнова, Сатурн чинь юу вэ? … гэж сандарч гайхсан Кассий асуув.

-Тэр чинь хүмүүсийн мунхаг байдал, айх сэтгэлийн бүтээ юмаа. Хонгор хүү минь ээ! Хилэгнэн дуугарах тэнгэр, дэлхий ертөнцийг айлгайн донсолгож хөдлөх газар илт хүчтэй бурхан тэнгэр хүмүүсийн сэтгэн боддог тэдний аянгын алинаас ч айлгүй байгалийн хамгийн нандин нууцаднэвтрэн хүрч эд юмны гарал эх шалтгааныг нээж чадсан агуу их Эпикурын ганцхөн зөв номлолтой би чамайг танилцуулъя.

Энэ үед Кассийг хүмүүжүүлэгч нь циркээс гаръяа гэж ятгасанд тэр хөвүүн зөвшөөрөн боссон бөгөөд хойноос нь Лукреций Меммий хоёр дагалдан босов.

Суллын хүү Фауст болон түүний дэргэд зогсож элдэг ярилцаж байсан агуу Помпейн дэргэдүүр гарах зуураа Кассий зогсож Фауст надад хандаж.

-Чиний эцэг Ромыхны эрх чөлөөг булаан аваад, манай эх орныг харгисласныг сайн явдал болсон гэж гурав хоногийн өмнө сургууль дээрээ хэлсэн тэр балай үгээ агуу их Помпей мэтийн алдартай иргэний нүүр дээр давтан хлэхийг би чамаас хүсч байна. Одоо Помпейн дэргэд гуравн хоногийн өмнө нүүрий чинь нударгаараа цохисон /ор мөр нь одоо хүртэл байна/-оос илүү хүчтэй дахин цохих учир тэгж хүсч байгаа юм! гэж хэлэв.

Гэвч Кассий Фаустаас хариу дуулах гэж дэмий хүлээжээ. Эх орныхоо эрх чөлөөнд хязгааргүй хайртайн улмаас Ромын захирагчийн хүүг зодохоосоо айгаагүй, тэр хүүгийн гайхамшигт зоригийн өмнө Фауст толгойгоо бөхийлгөн нүүрээ буруулав.

Тэгэхэд Помпейг хүндэтгэн мэхэсхийж ёслоод, Меммий, лукреций нар болон хүмүүжүүлэгчийнхээ хамт циркээс гарч одлоо.

Энэ үед үхлийн хаалганы дээд талын эгнээнээс хорин узргаа орчим насны нэг залуу хүн бослоо. Энэ хүн цонхигор булбарай царайтай, хүн аргагүй хүндэтгэж үзмээр жавхлантай ажээ.

Тэр хүн залуухан сайхан эмэгтэйн гарыг үнсэж баяртай Валерия минь! гэлээ.

-Баяртай Марк Тулий! Миний оролцон тоглох Софоклийн “Электра” гэдэг ший тавьж, Апполонийн театр дээр би чамайг нөгөөөдөр хүлээж байна гэдгийг чи бүү мартаарай гэж Валерия нь хариулав.

-Намайг тэнд заавал очно гэдэгт чи лав итгээрэй гэлээ Тэр үед

-Тумий баяртай! Гэж олон хүмүүс зэрэг зэрэг хашгирав.

Тавин тав орчим насны их л төлөв томоотой, элдэг аагтай бололтой бөгөөд үнэртэй ус ханхлуулж, хацартаа энгэсэг тавьсан нэг хүн нөгөө залуу хүний гарыг атгаж:

-Цицерон баяртай! Гэж хэлэхэд нь:

Цицерон их жүжигчний гарыг барьж

-Их чадамгай Эзон чамайг Талия ямагт өршөөж байх болтугай гэж хариулав.

Цицерон Валериятай ойролцоо вандан дээр сууж байсан дөч орчим насны тун цэвэрхэн нэгэн хүний дэргэд дөхөж очоод гараа сарвайж:

-Миний хайрт нөхөр хоёгүй Квинт Росций чиний дээгүүр урлагийн есөн охин тэнгэр элин хаин нисч байх болтугай! Гэв.

Цицерон олны дундуур найртай зөөлөн явж гарах чиглэлэд очлоо.

Нэвтэрхий саруулхан ухаан гайхалтай сайхан ой билэгтэй бөгөөд төрөлхийн уран үгтэй Цицерон эцэлт цуцалтгүй шунаж ажилласны ачааар хорин зургаан насандаа гүн ухаантан, шүлэгч, уран илтгэгч гэж их алдаршжээ.

Катон Цепион хоёры ннаана байсан эгнээ сандлуудыг өнгөрөөд Цицерон тэд нарын дэргэд очиж өөрийн их л сайшаан үздэн Катонтой ярилцлаа.

-Чиний тухай улсын ярилцдаг үнэн үү? Гэж залуу Катоноос асуухад:

-Үнээн, надад буруу байсан гэж үү? Гэж залуу хүү хариулав.

-Яагаад? Гэтэл тэр хүүгийн хүмүүжүүлэгч:

-Сллын тушаалаар өдөр бүр хүмүүсийг алдаг болсон учир би арга буюу энэ хөвүүдийг дагуулан дарангуйлан захирагчид барагцаалбал сар тутам нэг удаа бараалхдаг болсон. Яагаад вэ? гэвэл энэ хоёр хөвүүдийг Сулла сайн нөхдийнхөө тоонд оруулан авч ивээн өршөөж, хэзээ нэгэн цагт эд нарыг хөөн цөлөх тэнэг муу санаагаа гаргахгүйсэнх болов уу гэж бодсон юм. Нэг өдөр Суллын байшингаас гарч Форумийг дамжин явтал хүний сүс зайлмаар ёолон орилох дуу Мамертины гяндан дотроос бидэнд сонсогдлоо гэж хэлж байгаад Катон түүний яриаг тасалж:

-Энэ ямар хүн ингэж орилж байна вэ? гэж би Сарпедоноос ч асуусан билээ.

-Суллын  тушаалаар цаазлагдаж байгаа иргэд ингэж орилж байгаа юмаа? гэж Сарпедон надад хариуллаа.

-Ямар хэргийн учир тэд нар цаазлагдах болсон юм гэж миний асуухад “эрх чөлөөнд дуртай” учраас цаазлагдаж байгаа юм гэж Сарпедон хариулсан гэж хэлэв.

Гэтэл Сарпедон Катоны яриаг тасалж:

-Тэгээд энэ мунхаг хүү хоолойгоо муухай болгож, орчин тойрны хүмүүст сонсогдтол өндөр дуугаар “Чи юунд надад одоо хүртэл сэлэх өгөөгүй вэ? Эх орны минь харгислагчийг бид аль эрт алах байсан юм” гэж хашгирсан юм гэж хэллээ.

Катон хөмсгөө зангидаж:

-Бүх хүмүүсийг сүрдүүлэн чичрүүлж байгаа боловч жаахан хүү намайг сүрдүүлж чадахгүй. Тэр хүний нүүр дээр ч гэсэн би энэ үгээ давтан хэлэхсэн, Олимпийн олон тэнгэрийн өмнө ам алдъя гэж хэллээ.

Цицерон Сарпедон хоёр, хүүгийн толгой дээгүүр бие биеэ их л гайхсан маягтай харж, минут хир болтол:

-Ай би эр хүний тога өмсөх насанд хүрсэн ч болоосой гэж хүчтэй гэгч дуу алдав.

-Мунхаг хүү минь чи тэгээд яах гэсэн юм бэ? гэж Цицерон асуусна, дуугүй байсан дээр шүү гэж нэмж хэлэв

-Би тэгвэл Луций Корнелий Суллыг шүүхэд дуудан аваачиж, ард олны өмнө яллах байсан… гэлээ.

-Дуугүй, дуугүй! Чи бид бүгдийг аюулд учруулах гэв үү?

Харамсалтай нь гэвэл айн сүрдэх явдал Ромын хааны судсан дахь эртний уламжлалт цусыг харцгааж Сулла үнэхээр хамгийг чадагч зол заяат хүн болжээ! гэж Цицерон хэлэхэд

-Тэр зол заяатай гэж нэрлэгдэх үү? Зол заяатай хүн болохын оронд шударга хүн болохыг оролдсон бол дээр байхсан гэж шивнэн хэллээ. Тэгээд жаахан үглэж байснаа, Цицероны хүчлэн гайсныг дагаад тайтгарчээ.

Энэ үед андабатууд үхэшгүй муухай цуст тоглоомоор үзэгч олныг дугаацуулж байсан бөгөөд энэ тогломын дүнд хөөрхий хорин глаидатор бүгдээрээ аминаас хагацах ёстой байжээ.

Сулла үзэх харах энэ юмнаас аль түрүүн уйджээ. Одоогоос, хэдхэн цагийн өмнө түүний сэтгэл санаагтатсан ганцхан тэр зүйлийг бодсоор босч Валериягийн сууж байсан газар руу очоод түүнд мэхийн ёсолж хараагаа чадах чинээгээр аль болох дуулгавартай эелдэг зөөлөн болгохыг оролдж байснаа:

-Валерия чи нөхөргүй юу? гэж асуулаа.

-Би хэдхэн сарын өмнө нөхөртөө хаягдсан юм. Гэхдээ миний талаас ямар нэгэн бузар явдал гарсан биш харин…

-Тэр тухай би мэднээ гэж Сллын хэлэхэд Валерия хүүхэн дур сэтгэлээ илэрхийлсэн тормогор хар нүдээрээ түүнийг талархан харлаа.

-Тэгвэл чи надад дурлах уу? гэж Сулла асуугаад түр дуугүй болсноо:

-Чи надад дурлах уу? гэж нам дуугаар дахин асуулаа.

Валерия их луяхан инээмсэглэн доошоо харж:

-Чи сэтгэлээсээ дурлана гэхэд нь Сулла:

-Валерия би чамд бас хайртай, би хэзээ ч хэнд ч ингэж дурлаж байсангүй мэт санагдана гэж чичирсэн дуугаар хэлжээ.

Түр зуур дуугүй байснаа Ромын захирагч агсан Сулла гоо үзэсгэлэнт авхайн гарыг үнсэж:

-Нэг сарын дараа чи миний эхнэр болно гэж хэлээд, нөхдөө дагуулсаар циркээс гарч одлоо.

## ЛИБИТИНИЙ ВЕНЕРИЙН НЭРЭМЖИТ ГУАНЗ

Либитиний Венера буюу өөрөөл хэлбэл нас барагсдыг оршуулах ёслол болон үхээрийн газрыг эрхлэн соёрхох дагина хэмээх Оршуулгын Венерийн нэрээр нэрлэсэн нэгэн гуанз, Сервий Туллийн үеийн хуучин хэрмийн дэргэдэх хамгийн буйд нарийн бохир гудамжны нэгэнд өдөр шөнөгүй буюу чухамдаа шөнийн цагт л голдуу онгорхой байдаг билээ. Тэр гуанз энгийн бор хүмүүсийг оршуулдаг газар, мөн боолчууд болон хамгийн шоовдор улсын хүүрийгш хаядаг тал хоёрын завсар байгаа болохоор нь тэгж нэрлэсэн бололтой. Тэр тал дээр Меценат гэгч нэгэн баян хүн тавин жилийн дараа алдар цуутай цэвэрлэгээ байгуулсан нь плейбейчүүдийн ясаар бордсон амттай ногоо, сайха жимс эзний тансаг сайхан нандин идээнд нэмэр болсон билээ.

Энэ гуанзанд орох хаалган дээр Венерийн хөргийг зурсан нь гоо сайхны охин тэнгэртэй адил биш харин өшөө хонзонг ивээн хөхүүлэгч үзэшгүй муухай мегерагийн дүрстэй төстэй болон байжээ. Энэ хөргийг ямар нэгэн согтуу будагчин зурсан бизээ. Салхинд ганхсан дэнлүүний бүдэгхэн гэрэл, харсан байсан хоёр ялгаагүй шахам хөөрхий тэр Венерийн хөргийг гэрэлтүүлнэ. Гэвч ойр хавьд яваа улс амьтан гуанзны хаалган дээр хадаастай хуурай мөчрийг уг бүдэг гэрэлд эрхбиш олж харахаар билээ.

Энэ гуанзанд орсон хүмүүс намхан жижиг явган хаалгаар нэвтрэн шатны хоронд хайш яйш тавьсан хэдэн хавтгай чулуун дээгүүр дамжин доош бууж, утаа болсон чийгтэй тасалгаанд ордог байжээ.

Үүдний нь баруун гар талын хананы дэргэд задгай зуух сүндэрлэн, гал дүрэлзэж цагаан тугалган сав суулганд янз бүрийн хоол чанадаг бөгөөд гахайн цусан хиам болон чухам юугаар хийсний нь сонирхмооргүй шанз хэзээд чанадаг ажээ. Тэр идээг энэ бохир байгууллагын эзэн өрөөсөн нүдэт Лутация авгай өөрөө хийдэг ажээ.

Хананы дагуу хоолны хэдэн хуучин ширээ цувуулан өрж тэдгээрийг тойруулан эв хавгүй урт вандан, хөлтэй хөлгүй сандлууд тавьжээ.

Гаднаас орох, хаалганы эсрэг талын хананд бол нэгэн хаалга байх бөгөөд энэ нь нэгдэх өрөөнөө арай бага боловч төдий л бохир биш тасалгаанд орох хаалга байжээ. Тэр тасалгааны ханыг ичиж зовохыг огт мэддэггүй бололтой зураачин элдэв муухай агуулгатй зургаар шалиглан чимжээ.

Үүрийн туяаны анхны цаг /шөнийн нэг цагийн орчим/ Либитиний Венерагийн гуанз дүүрэн хүнтэй байлаа. Хүмүүс энэ тэр юм чалчин шуугилдаж, шуугиан нь муу орон байшинд төдийгүй, харин ойр хавийн гудамжинд тарж байлаа.

Тал бүрээс нь дуудаж байгаа өлсөж, цангаж, шамдаж шаардсан улсын шаардлагыг хангах гэж өрөөсөн нүдэт Лутация өөрийнхөө боол, тогооны хөө шиг тас хар царайтай Эфиоп нутгийн хүүхэнтэйгээ хоёулаа байдаг чадлаараа чармайн сандарна.

Ром хотын хамгийн муу доорд язгуурын хүмүүс Либитанийн Венера хэмээх энэ гуанзанд ордог ажээ.

Лутациягийн энэ гуанзад байнга ордог улс гэвэл мужаан, шаварчин, ясчин хүмүүс циркийн тамирчид, доорд зэргийн алиа марзан хүмүүс гуйланчид, завхарсан шалиг охид юм.

Ийм газар банкны эзэд, морин цэргийн хүмүүс болон ноёд ордоггүй нь лавтай. Гэвч өрөөсөн нүдэт Лутаций нь гутаж гуньхардаг хүн биш билээ. Тэгээд ч баян хоосон гэж ялгалгүй нэгэн адил гийгүүлж байг гэж Юпитер бурхан нарыг тэнгэрт байлгасан байхаа. Баячууд архины зоорь, хол хүнсний лангуу, ресторан, зочид буудалтай байж болсон болохоор ядуучууд яагаад өөрсөддө тохирсон гуанзтай байж болдоггүй юм гэж энэ сайхан санаата авгай боддог байжээ. Ядуу хүний квадрант, сестерций мөнгө нь хотын чинээлэг иргэн буюу бардам ноёдын мөнгөнөөс юугаараа я алгаагүй гэдэгт Лутация мөн итгэжээ.

-Чи бидэнд наад муу буруутсан хар шанз шиг юмаа өгөх үү, үгүй юу? гэж нүүр царай хэнхдэг цээжээрээ дүүрэн сорвитой нэгэн өвгөн гладиатор аймшигтай өндөр дуугаар бачимдан хашгирав. Тэгэхэд нь өвгөн гладиаторын дэргэд сууж байсан нэг гуйлгачин

-Би сестерций тавья. Хэрээний хоол болгож Эсквилиний талд хаясан хүний махнаас Лувений авчирч өгсөн байх. Цаадах чинь тамынхаа шанзыг тэр махаар л хийж байгаагаас гарцаагүй гэж дуу алдав.

Ямар ч өвчингүй мөртлөө баашлах өвчтэй, хүний маяг гаргасан гуйлгачны тэр шог үгэнд хүмүүс их л хөөрөлдөв. Пагдгар бүдүүн биетэй болхидуу ясчин Лувенийд гуйлгачингийн тэр шог үг аягүй санагдаж:

-Би шударга ясчны хувьд батлан амлая! Яртай хүн болж энэрэнгүй сэтгэлтэй иргэдээс илүү мөнгө салгаж авах гэж утсаар оосорлон цээжиндээ зүүж явдаг тэр түүхий махаар нь наад өдгүй Веллүнийдэ гуйлгачингийн нэр ийм байжээ. Лутация чи шанз хийж өгөх хэрэгтэй байжээ гэж сөөнгө дуугаар хашгирахад нь тэнд байгчид дахин нир хийтэл инээлдэв.

Хэрэв Юпитер бурхан залхуу бишсэн бол энэ муу ёроолгүй үмхий тулам болсон ясчин Лувенийг аянгынхаа нэг сумаар ниргэж орхивол нүгэл болохгүйсэн гэхэд ясчин галзуурсан юм шиг суудлаа босон харайж,

-Плутоны хар пайзыг дуудан ам алдъя. Чиний муу хоншоор дээр том гэгчийн яр сийлээд өгнө шүү. Тэгээд чи улсуудаас өршөөл гуйх эрхтэй болно гэж хашгирав.

Веллений суудлаасаа бас босон харайж гар зангидан:

-Тэнэг муу чи хүрээд ир, хүрээд ир, чамайг би Хароны оронд тонилгоод өгье гэж өндөр дуугаар хэлэв.

-Хөгшин адсагууд та нар больцгоо. Хоёулы чинь барьж аваад өгөөд идэгдэж өмхөрсөн ясы чинь хэмхэртэл хооронд чинь мөргүүлэн уранхай новш шиг болгож орхино шүү. Ромын тэнгэр бүхэнд амлая гэж циркийн тамирч аймшигтай том биетэй Кай Тауривий зандарлаа.

Аз болоход энэ үед Лутация хар арьстай хүүхэн Азур хоёр том гэгчийн хоёр саваар дүүрэн шанз овоолж уур савсуулан авчирч ширээн дээр тавихад хүлээж байсан хүмүүс ховдоглон тал талаас нь шамдан идэж гарлаа.

Гэтэл бусад хүмүүс нь өдрийн хамгийн сонин зүйл болох циркийн гладиаторуудын тоглолтын тухай яриа болж байлаа. Тоглолтыг орж үзэх завшаантай чөлөөтэй иргэд нь циркийн хашаанд орох эрхгүй боолчуудад гладиаторуудын тухай гайхалтай сонин юм ярьж өгч байлаа.

Бүгдээрээ Спартакийн эрэлхэг зориг, хүч чадлыг шагшин магтана.

-Хэрвээ тэр ромын хүн болж төрсөн бол зориг чадлынхаа хувьд баатар болж лав чадахсан гэж Ром гаралтай циркийн тамирч Кай Тауривий ихэмсэг янзтай хэллээ.

Садар самуун хэтэрхий явсны улмаас нас залуу атлаа хөгшин царайтай болж нүүр нь үрчийж эхэлсэн хорь орчим насны сайхан залуу Эмилий Варин:

-Тэр нь харь газрын бдүүлэг хүн болох нь харамсалтай байна даа гэж эгдүүрхсэн байртай хэлэв.

-Гэвч тэр Спартак их заяатай хүн гэж урьд Африк легион цэрэгт алба хааж байсан, духан дээрээ өргөн сорвитой хижээл насны хүн хэлэв. Тэр чинь оргодол

ч гэсэн чөлөөтэй хүн болж чадаж дээ… үзэгдээгүй юм үзэгдэж байна шүү! Ийм их өршөөл энэрэл үзүүлсний нь бодвол тэр үед Сулла тун ч их сайхан зантай байж дээ. Гладиаторуудын сургуулийн захирал Акциан мөн их уурлав гэж нэг өвгөн гладиатор дурсав.

-Тиймээ. Тэр ч тэндээ явахдаа намайг тонолоо, дээрэмдлээ хоосруулдлаа гэж чарласан юм гэжээ.

-Түүний эд тавaарт Сулла тэртэй тэргүй их үнэ өгсөн шүү дээ.

-Сулла залуудаа нилээд ядуу хүн байсан юм. Тэр чинь бие өвчтэй байхад нэгэн айлд жил тутам гурван мянган сестерцийг төлж тэднийхээр бүрэн тэжээлгэн хэдэн жил хэвтсэн юм. Түүний байж байсан айлын хүмүүсийг би таньдаг байлаа. Сулла дараа нь Митридатын эсрэг дайнд, мөн Афиныг бүслэн эзэлж авах үед олсон олзны ихэнхийг авчирсан юм шүү. Тэгтэл хуулиас гадна болгох хүмүүсийн жагсаалт бичгийн үе эхэлж Суллын тушаалаар консул агсан арван долоон хүн, долоон претор, жаран эдил болоод квестор, мөн гурван зуун сенатын түшмэд, бас морин цэргийн албаны мянга зургаан зуун хүн, далан мянган иргэдийг яргалан алж, тэр хүмүүсийн хөрөнгө хогшлыг хурааж авсан юм. Тэр хураагдсан хөрөнгөнөөс Суллад ноогдоогүй гэж үү?

-Тэр бол Суллад ноогдсон хөрөнгөний өчүүхэн хэсгийг боловч би авахсан гэж циркийн тамирчин хэлэв.

Энэ орой элдэв юм цэцэрхэх дуртай байсан Эмилий Варин:

-Тэгвэл энэ хоосон ядуу байснаа баяжиж, хэн ч биш байснаа Ромын диктатор, триумфатор болсон бөгөөд "Эзэн хаан, хувь заяат Корнелий Сулла" гэсэн гарчигтай алтан баримтаа Росторын өмнө тавиулсан бүхнийг чадагшч энэ хүн чинь эм уувч эдгэрэхгүй, алт идэвч анагаагдахгүй хүнд өвчинтэй болсон хүн шүү гэхэд нь:

Урьд Африкийн дайнд оролцож явсан болохоороо Кай Марийн дурсгалыг хүндэтгэгч хазгар цэрэг:

-Тэгвэл таарна хүний дүртэй зэрлэг араатан мангаст тийм өвчин тусах ёстой. Зургаан мянган самнитын цус идсэний нь хариу тэр болог. Амий чинь аварна гэж Суллын амлахада түүнд хууртан бууж өгч алуулсан зургаан мянган самнитын өшөөний хариу ингэж гардаг байжээ. Тэднийг Сулла циркт оруулаад бүгдийг харваж алагтун гэж тушаасан юм. Хөөрхий тэр амьтад сүнс тонилмоор муухай бархиралдахад Гостилийн чуулганд цугларсан сенатч түшмэдүүд айн сандарч байрнаасаа босоцгооход нь Сулла "өвгөд сенатч түшмэд ээ, сэтгэлээ бүү зовогтун хэдхэн муу сайн буруу номтонг миний тушаалаар залхаан цээрлүүлж байгаа нь энэ. Хурлаа үргэлжлүүлцгээ гэж огт зовсон шинжгүй хэлсэн юм гэдэг гэж дуу алдлаа.

-Өөрийгөө асрамжлуулж байсан айлынхаа хүнээс бусад арван хоёр мянган хүнийг эр, эм хөгшин залуу гэж ялгалгүй ганц шөнийн дотор хүйс тэмтрэн алах тушаал өгч үйлдсэн яргы нь яахав?

-Хүүшээ нөхөд минь! Та нар хувь заяатай Сулла захирагчийг муу хэлж байх шиг надад санагдана. Та нар амаа хумхивал дээр шүү. Ромын их иргэний нэрийг гуанзан дотор муучлахыг би хүсэхгүй шүү гэж Лутация сууж байсан вандан дээрээсээ хашгирав.

-Мөн таарч ээ! Энэ муу золигийн долир эм чинь бас Суллын намын хүн байх нь ээ! гэж өвгөн гладиаторын дуу алдахад тэнд сууж байсан ясчин тосч аваад:

-Хүүеэ чи Меций ээ! Миний эрхэм Лутацияг хүндэтгэн ярьж үзээрэй гэж хашгирав.

Ингэж байтал олон эмэгтэйн муухай дуу гудамжнаас зэрэг зэрэг сонсогдоход хүмүүс бүгдээрээ хаалга руу харлаа. Нүцгэн мөр нь харагдсан үзэмжгүй муухай ботинохон хувцастай таван охин орилолдон бүжиглэсээр орж ирлээ. Дотор байсан улс хашгиралдан угтахад тэд ичгүүр алдсан муухай үгээр хариулав.

Лутация зарч охинтойгоо нөгөө өрөөндөө оройн хоол бэлдэж байсныг харвал арвин их хоол хийж байгаа бололтой.

-Туулайн оронд шарсан тэр муурынхаа махаар чи энэ орой болсон хойно хэнийг зочлох гэж байна гэж гуйлгачин Веллен,ий асуулаа.

-Чи оройнхоо хоолон дээр Марк Крассыг хүлээж байгаа юм биш биз дээ?

-Үгүй. Энэ хүүхэн энэ орой агуу их Помпейг хүлээж байгаа м.

Гэтэл асар өндөр нурутай их чийрэг биетэй хэдийгээр бууралтаж яваа боловч үзэмжтэй сайхан хэвээрээ нэгэн хүн орж ирлээ.

-Требоний…

-Требоний сайн байна уу?…

-Требоний морилон ор гэж олон хүн зэрэг зэрэг дуу алдлав.

-Требоний бол урьд гладиаторуудын сургуулийн эзэн байсан бөгөөд сургуулиа хэдэн жиүийн өмнө бүрмөсөн хааж, тэр их аймшигтай мэргэжлээр олж авсан хөрөнгөөрөө одоо амьдрах болсон хүн юм. Гэлээ ч гэсэн Требоний гладиаторуудад дасаж, тэднийг талархдаг болохоороо хөөрхий гладиаторуудын цуглардаг Эсквилина, Субура хоёрын хямд үнэтэй хоолны гуанз ресторанд байна очдог байжээ.

Үүнээс гадна иргэний самууны үед патрийций нар олон гладиаторыг элсүүлэн авах даалгавар өгч өөрсөддөө тулуулдаг улсын нэгэнд энэ хүн ордог гэж сэм ярилцдаг. Түүний мэдэлд мянга түмэн гладиатор байдаг бөгөөд Форумд юм уу? эсвэл комицад чухал хэрэг хэлэлцэн, шүүгчдийг сүрдүүлэх буюу үймээн дэгдээх,заримдаа зодоон гаргах хэрэгтэй болоход тогтсон цагт тэр олон гладиатораа дагуулан хүрч очдог гэж бас хэлэлцдэг билээ. Требоний гладиаторуудтай танил болохоороо их ашиг олдог гэж ярилцана.

Юу ч л гэсэн Требоний гладиаторуудын сайн нөхөр, тэднийг дэмжин хамгаалагч хүн байсан нь үнэн юм. Ийм учраас ч тэр өдөр циркт үзэгдэл төгсмөгч хаалга руу яаравчлан очиж Спартакийг хүлээж уулзаад тэврэн үнсэн

баяр хүргээд түүнийг Либитиналийн Венерийн гуанзанд оройн хоолонд очихыг урьжээ.

Требоний Спартак болоод бусад олон гладиаторыг дагуулсаар Лутациягийн гуанзанд орж ирлээ.

Тэнд очоод байсан хүмүүс орж ирэгсдийг шуугилдан угтаж авлаа. Тэдний дотроос циркийн тулалдааныг нүдээр үзэгшчид нь нөгөө үзэж чадаагүй хүмүүсдээ энэ өдрийн баатар эрэлхэг зоригтой хувь зкаяат Спартакийг харуулах завшаан тохиолдсонд их л баясан бахархана. Лутация нөгөө нэгэн тасалгаа руугаа Спартак, Требоний хоёрыг хойноосоо дагуулан орох зуураа:

-Нааш ир, нааш ир, үзэсгэлэт гладиатор минь энд та нарт би оройн хоол бэлдсэн юм. Нааш ир, нааш ир, Лутация чинь Требоний чамайгаа бодсон шүү. Өнөөдрийн миний шарсан туулайн махтай тэнцэх тийм хоол Марк Крассынд ч байхгүй биээ гэж би бодож байна гэлээ.

Тэгэхэд нь Требоний гуанзны эзэн авгайн нурууг тоглон алгадаж:

-Зальт эм чиний ямар юм хийсний чинь одоохон бид амталж мэднэ. Харин одоо нэг сав велитерны дарс аваад ирж, хуучин дарс биз дээ? гэж хариунд нь хэллээ.

Удалгүй хөгжүүн, хошин үг, тааламжтай ярианы шуугиан тасалгаагаар дүүрэв. Хүн бүр Спартакийг магтан энхрийлж эрхлүүлэх боловч энэ нэгэн өдрийн дотор өдий төдий удаа ч сэтгээлэ ихэд хөдөлгөсний улмаас тэр юм уу. Спартакийг магтан энхри йлж эрхлүүлэх боловч энэ нэгэн өдрийн дотор өдий төдий удаа сэтгэлээ ихэд хөдөлгөсний улмаас ч тэр юм уу. Спартак л ганцаараа уйтгарлан яриа хөөрөөнд огт оролцохгүй бас хоолоо ч дуртай дургүй идэж суулаа. Спартакийн уйтгарыг алиа хошин үг, инээдэм тоглоомж, энхрийлэх хүндэтгэлийн аль нь чогт гаргаж чадсангүй.

Спартакийн хундага дүүрэн хэвээр байхыг харж Требоний

-Геркулесын нэрийг дуудан ам алдъя. Би чиний учрыг олохгүй байна, Чи яав? Чи дарсаа уухгүй юм… гэж сая нэг хэлэхэд уригдан ирэгсдийн нэг:

-Чи юунд уйтгарлав? Гэж асуулаа. Хэлний нь аялгууг сонсвол Самнит хүн гэж мэдэгдэхүйц өөр нэгэн гладиатор:

-Тэнгэр шүтээний эх болсон Юноны нэрийг дуудан тангаргалая. Бидп нар нөхөрсөг найр дээр цугларсан биш харин нас барагсдыг дурсаж байгаа юм шиг, эрх чөлөө олсондоо баярлаж байгаа биш, харин нас барсан эхийгээ дурсан гашуудаж байгаа юм шиг байна шүү гэж дуун алдав.

Спартак энэ үгийг сонсож сэтгэл нь ихэд хөдлөн:

-Ээж минь ээ! гэж санаа алдав. Тэгээд Спартак эхийгээ санаж улам ч гунигтай болсон тул урьд гладиаторын сургуулийн эзэн байсан Требоний суудлаасаа босож хундага өргөөд:

-Эрх чөлөөний төлөө ууцгаая гэж өндөр дуугаар хашгирав.

Хөөрхий гладиаторын нүд нь гялалзан суудлаасаа босож хундага өргөн:

-Эрх чөлөө мандтугай гэж хашгиралдав.

-Спартак чи мөн их заяатай хүн байна. Чи эрх чөлөөгөө амьд насандаа олж авч чадлаа. Харин бид үхсэн хойноо л эрх чөлөөгөө олж авна биз дээ! гэж цайвар үстэй залуухан нэгэн гладиатор гутаж гуньхарсан дуугаар хэлэв.

Эрх чөлө өгэдэг энэхэн үг дуудахад Спартакийн царай өнгө зүс орж, магнай тэнийж инээмсэглэсээр босож ирээд хундагаа өндөр өргөж:

-Эрх чөлөө мандутайг гэж шингэхэн бөгөөд саруулхан чанга дуугаар хэлэв.

Гэвч нөгөө гладиаторын хэлсэн эмгэнэлт үгийг санаж хундагаа амандаа дуртай дургүй хүргэв. Спартак амтат идээгээ амталж, чадсангүй цөхөрч гутраад толгойгоо гудайлган хундагаа тавьж доошоо суугаад уруулаа жимийлгэн бодол болов.

Бүгдээрээ чимээгүй болцгоов. Арван гладиатор аз заяатай найз нөхөр өөдөө баярласан мөртлөө атаархсан байртай ширтэн харж байлаа.

Ингэж дуугүй байснаа Спартак бүх юмыг мартсан юм уу эсвэл гав ганцаараа сууж байсан юм шиг ямар нэгэн юмыг эрэгцүүлэн бодож ширээ ширтэн Акцианы сургуулийнхан жадлах дасгалын хичээл хийж байх үедээ дуулдаг дууны нэгэн бадгийг үг үгээр нь таслан:

Эрх чөлөөтэй төрсөн тэр
Ингэж бөхийж үзээгүй ер
Харь газарт ирээд
Хатан төмөр торонд орлоо.
Эх нутгийнхөө талаа ч биш
Энхрий тэнгэрийнхээ төлөө ч биш
Одоо дайтах ёстой болжээ тэр
Хайрт хүнийхээ төлөө ч биш
Халз тулалдан үхдэг гладиаторууд…

гэж алгуурхан шивгэнэв

-Бидний дуулдаг дуу байна шүү гэж зарим нэгэн гладиатор сайхан баясаж ярилцлаа.

Спартакийн нүд маш сүрхий гялалзаж байхыг харахад сэтгэл нь хэмжээлшгүй их тэнэгэр болсон нь ил байлаа. Гэвч царай нь дахин барайж хайхрамжгүй шинжтэй болж:

-Та нар ямар сургуулийнхан бэ? гэж өөртэйгээ алдилхан заяа муутай нөхдөөсөө хайш яайш асуулаа.

-Юлий Рабецийн сургуулийнхан

Спартак ширээн дээрээс хундагатай архиа авч уугаад энэ үед гаднаас орж ирсэн боол бүсгүйд хандв уу гэмээр янзтай

-Гэгээн гэрэл гэж хайхрамжгүй хэлэв

Тэгэхэд нь гладиаторууд бие бие өөдөө түргэн түргэн харцгаав. Цайвар үстэй залуу урьдах яриагаа үргэлжлүүлж байгаа юм шиг:

-Бас эрх чөлөө! Баатар зоригт Спартак чи эрх чөлөө олох эрхтэй! гэж хайш яайш байртай хэлэхэд:

Спартак тэр залуу хоёр бие биеэ учиртайхан харалцав.

Энэ үед  гаднаас орж ирсэн хүн, өндөр дуугаар:

-Ялагдашгүй Спартак чи эрх чөлө олох эрхтэй хүн! гэж хэлэв.

Бүгдээр хаалганы зүг эргэж харахад эрэлхэг зоригт Луций Сергий Катилинын өргөн хар нөмрөг нөмрөн орж ирээд зогсож байлаа.

“Эрх чөлөө” гэсэн үгийг Катилинын хэлэхэд Спартак болон бусад гладиатор түүн өөд гайхан харцгаав.

Буруу хараад сууж байсан учраас орж ирсэн хүниг харж амжаагүй Требоний:

-Катилина аа! гэж сүүрс алдаад  түүний өмнөөс нь яаран очиж заншлаараа гараа уруулдаа хүргэж түүнийг үлэмж хүндэтгэн мэхийн ёслоод:

-Алдарт Катилина сайн байна уу? сайн байна уу? Ямар их аврал ивээлээр та хүрч ирэв? Гэхэд:

-Би чамайг эрж явна Требоний минь гэж Катилина хэлээд Спартак руу эргэн:

-Мөн бас чамайг ч эрж явна гэлээ.

Хэрцгий авиртай, зориг эрэлхэг гэж Ром даяар алдаршсан Катилинын нэрийг сонсмогц гладиаторууд бие бие рүүгээ гайхсан буюу бүр ч айсан царайтай харж заримын нь царай хувхай цайчихав. Аюулаас айж зүрх нь чичирч үзээгүй зоригт Спартак ч энэ патрицийн аймшигт нэрийг сонсон цочиж, хөмсөг зангидан Катилинын нүдийг ажиглан:

-Намайг уу? хэмээн гайхан асуулаа.

-Катилина түүнд тавьж өгсөн бандан дээр сандайлж бүгдийг суу гэж дохиод:

-Тийм ээ! Чухамхүү чамайг эрж явна гэж ажиггүй хариулав.

-Би чамтай энд уулзана гэж зүүдэлсэн ч үгүй уулзах байх ч гэж бас найдсангүй. Харин энд Требоний чамтай уулзах байх, тэгээд эрэлхэг озоригтой баатар эр Спартаки йг олох газрыг заалгаж авна гэдэгт би итгэж энд ирлээ.

Спартак улам бүр гайхаж Катилиныг ажсан байдалтай ширтэн харна.

-Чамд эрх чөлө өгчээ. Чи бол эрх чөлөө олох эрхтэй хүн мөн. Гэвч ажил хийж мөнгө олох аргаа олтлоо хэрэглэж явах мөнгө чамд өгсөнгүй. Би өнөөдөр Кней Корнелий Долабеллатай мөрийцөн чиний эрэлхэг зориг чадлын ачаар арван мянган сестерций хонжсон юм. Тэгээд тэр мөнгөнийхөө нэг хэсгийг чамд өгөх гэж чамайг эрсэн юм.н Үнэндээ тэр мөнгө бол чамд очвол зохих мөнгө шүү. Хэрэв би мөнгөөр мөрийцсөн бол чи амь наaраа мөрий тавьж хоёр цагийн турш тулалдсан шүү дээ гэлээ. Тасалгаанд байсан хүмүүс энэ язгууртныг сайшаан талархан шивнэлдэнэ.

Спартак хүний сайн санааг үзээгүй удсан болохоор ингэж санаа тавьсанд нь уярчээ.

-таны сайхан санаатайд тун их баярлаж байна. Катилина гэвч би таны хишгийг хүртэж чадахгүй хүртэх ч ёсгүй. Би амь зуух мөнгөө барилдаан, биеийн тамир, хатган жадлах хичээл зааж өөрийн хөдөлмөрөөр олноо гэхэд:

-Катилина хундагаа Требонийд өгч велитернийн дарсыг устай найруулж аль гэж тушааж түүний анхаарлыг түр санрниулан Спартак руу тонгойж чихэнд нь:

-Цөөхөн дээдэс язгуууртны хорслоос болж би ч бас зовж байгаа хүн юм. Би бол бас замаа алдсан үзэшгй муухай Ромын хааны боол юм. Дээдэс язгуууртны дунд бол би гладиатортай адил хүн болохоор эрх чөлөөг чиний нэгэн адил хүсдэг тэгээд.. хамаг юмы чинь мэднээ… гэж дөнгөж сонсогдмоор яаруу хэлэв.

Спартак цочиж толгойгоо гэдийлгэн Катилина өөд санаагий нь сорьсон байдалтай ширтэн харсан учир Катилина цааш нь үргэлжлүүлэн:

-Би цөмийг мэдэж байна би та нартай нэгдлээ… үүнээс хойш ч хамт явна гэж хэлээд ялихгүй өндийж бүгдэд сонсогдмоор арай өндөр дуугаар:

-Үүний тулд ч шинэхэн хээтэй бяцхан хэтэвчтэй хоёр мянган сестерцийг эрхбиш авах бизээ гэв.

Тэгээд Спартак руу бяцхан хөөрхөн хэтэвчийг сарвайн:

-Би үүнийг чамд бэлэглэж байгаа хэрэг биш, үүнийг чи өөрийнхөө хүчээр олж авсан юм. Энэ бол чиний мөнгө. Энэ бол чи бид хоёрын өнөөдрийн олсон олны чамд ноогдох хувь нь юм шүү гэж нэмж хэллээ.

Тасалгаан доторхи хүмүүс Катилинын өглөгч сайхан чанарыг хүндэтгэн магтаж шагшингайхацгааж байх үед Катилина Спартакийн баруун гарыг барьж янзтай гэгч атгасанд Спартак цочлоо.

-Хамг юмы чинь мэдсэн гэдэгт чи одоо итгэв үү? Гэж тэр язгуууртан шивгэнэх шахам намуухан дуугаар асуулаа.

Зарим нэгэн нууц үг дохио тмдгийг яахин мэдэж авсны учрыг Спартак олж чадахгүй байсан боловч Кати лина бол бидний хамаг юмыг үнэхээр мэдсэн байна гэдэгт бүрэн итгэж хариуд нь гары нь атгаж, өгсөн хэтэвчтэй мөнгий нь өвөртөлж:

-Таны хайр хишигт миний сэтгэл их хөдөлж шагшин гайхсан болохоор сайн санаатай танд зохих ёсоор талархаж ч чадахгүй байна гэвч хэрэв та зөвшөөрвөл би маргааш орой танай гэрт очиж талархал бүх сэтгэлээ илэрхийлье гэв.

Спартак сүүлчийнхээ үгийг онцлон өргөж, мөн нүднийхээ харцаар учрыг мэдүүлсэн тул нөгөө язгуууртан нь зөвшөөрч толгой дохив.

-Спартак чи манайд очвол хэзээд хамгийн хүсэлт зочинх болно гэж Катилина тэр даруй нэмж хэлээд, Требоний болон бусад гладиаторууд руу хандэж, хэрвээ энэ муу нохойн хэвтэрт фалернын дарс байдаг бол бүгдээрээ нэг нэг аяга ууцгаая гэлээ.

Фалернын дарсыг төдий л удалгүй амтлан үзэж санаанд хүрэхээр удаан дарсласан архи биш боловч овоо аятайхан дарс байна гэцгээв.

-Алдарт Катилина танд энэ дарс ямар санагдав гэж Лутация асуулаа.

-Овоо дарс байна.

Катилина гартаа цагаан тугалган сэрээг дэмий л эргүүлэн дүрэлзсэн нүдээрээ ширээ ширтэж хөдлөх ч үгүй, чимээ ч үгүй суухад түүнтэй нэгэн ширээний  ард суугчид бас дуугүй байлцжээ.

Нүдэнд нь цус шиг улаан туяа харагдан гар нь чичгнэн бүх булчин шөрмөс нь таталдан магнай дээгүүр нь хөндлөн гарсан бүдүүн судас гэнэт хөөж ирснийг үзэхэд Катилинын сэтгэл их л хямралдан цээжинд нь ямар нэгэн сүртэй бодол төрж байгаа бололтой байлаа.

Архирах мэт чимээтэй санаа алдахы нь сонсож требоний:

-Катилина чи юун  тухай бодоо вэ? гэж асуухад:

-Энэ фалерныг дарсыг савлан дарсан тэр жил трибун Ливий Друз байшингийнхаа тагтанд сууж байгаад санаандгүй алагдсан нь түүнээ хэдэн жилийн өмнө трибун Луций Апулей Сатурнин, мөн бүр түрүүнд манай эх орны чимэг болсон агуу их сэтгэлт Тиберий ба Кай Гракхи нар зэрлэгээр хядагдсантай адил болжээ гэж би бодлоо. Тэгээд тухай бүр үгээгүй ядуу, дарлагдсан олны үйл хэргээс болж, шударга ёсыг мартсан язгууртны гэмт муу гараар тэгж алагджээ гэж Катилина хариу хэлээд нэг минут хир бодол болсноо:

-Дарлагдсан хүн амар жаргалан хэзээ ч олохгүй, үгээгүй ядуу чууд хоолоо хэзээ ч олохгүй, хүн төрөлхтөн хонь чоно хоёр шиг, идэж залгигч, идэгдэж үргэдсэгч гэж хоёр хэсэгт үргэлж хуваагдсан байна гэж агуу их тэнгэр бурхдын хэрээсэнд бичигдсэн байдаг гэж үү? гэж  дуу алдав.

-Тийм биш ээ.Олимпийн хамаг шүтээнд тангараглая гэж Спартак ширээ шааж сүртэй дуугаар хашгирав.

Энэ ярианы үед нөгөө өрөөнд улсын хашгиралдах чимээ шуугиан уусан архиныхаа хэмжээгээр улам бүр ширүүлсэж байлаа.

-Родопья байна! Родопея байна! гэж хашгиралдах чимээ Катилина болон хамт сууж байгаа хүмүүст гэнэт сонсогдлоо.

Спартак энэ нэрийг дуулангуут дав хийж цочлоо. Тэр нэр,  төрсөн фракий нутаг, уул хад, гэр орон, төрөл садны нь санагдуулжээ. Хичнээн ариун сайхан боловч гунигтай дурдатгалыг хөөрхий тэр хүний сэтгэлд төрүүлсэн бол!

-Үзэмжтэй сайхан Родопея минтй. Морилон ор, морилж ор гэж согтуурсан хориод хүн зэрэг зэрэг хашгиралдав.

Родопея гэдэг нь хорин хоёр настай өндөр гоолиг биетэй, цовоо сайхан цэнхэр нүдтэй бүсгүй байлаа. Түүний тэгшхэн цэвэр царайг урт гэгчийн шар үс эмжин хүрээлжээ. Бүсгүй мөнгөн саагаар эмжсэн хөх туник өмсөж гартаа миөнгөн бугуйвч зүүгэд толгойдоо ноосон эдээр хийсэн хөх туушин зангиджэ. Түүний бүх байдлыг харахад Ромын бүсгүй биш харин бол гэдэг нь ил бөгөөд хачин зовлон зүдгүүрт амьдралтай нь андашгүй байлаа.

Либитиний Венерийн гуанзнаас салдаггүй ичиж зовохоо мэддэггүй танхай хүмүүс тэр бүсгүйтэ хүндэтгэсэн байртай элдэг зөөлөн ярихыг бодоход энэ бүсгүй, хүнд хүчир амьдралтай ч гэсэн цагаан сэтгэлтэ өнгөн дээрээ хөгжилтэй ч гэсэн туйлын зовлонтой гэдэг нь ил ажээ.

Энэ бүсгүй нэгэн өдөр, хоёрыг нийлүүлэгч ажилтай эзэндээ одуулан цус нөж болсоор Лутациягийн гуанзанд орж ирээд, биеэ жаахан ч гэсэн тэнхрүүлье гэж ганцхан балга дарс гуйж уужээ. Родопея хүүхэн тэр өдрөөс эхлэн хоёр гурав хоногт нэг удаа бололцоо гарах бүрд Лутациягийн гуанзанд ирдэг болсон юм. Энэ гуанзанд ирдэг болсон юм. Энэ гуанзанд арван хэдэн минут тавтай сууж өнгөрүүлэх нь аргагүйн эрхэнд амьдран байдаг тэр тамыг бодвол жаргал шиг санагддаг ажээ.

Хэтэртэл балгаж, нилээд хөлчүүрсэн ясчин Лувений түүний нөхөр Арезий, мөн хуурмаг гуйлганч Велленийн нар Катилинын тухай ярьж гарлаа. Катилина зэргэлдээ тасалгаанд бий гэдгийг тэд мэдсээр байж түүний тухай сайн муу элдвийг ярилцахрад нь болгоомжтой ярилцвал дээргүй юу? гэж бусад нь хорихыг оролджээ.

-Үгүй, үгүй Геркулесын нэрийг дуудан ам алдъя, бидний цусыг сосрогч энэ муусайн хорхойнуудыг энд огт оруулахгүй байвал зохино. Бидний цугладаг энэ газрыг тэд ирж бузарлах ёсгүй.

-Наргих, гэмт хэрэг өдүүлэхээс өөр ажилгүй. Суллын хөлсний яргачин энэ баян Катилина юу юм? Түүний олон нөхөд язгууртан дээдсийн нь уршгаархоосорсон бидний ядуу дорой байдлыг шоолох гэж тэр хэргэмийнхээ сайхан хувцыг өмсөж энд ирээ юу? Гэж Лувений хашгичан Катилинын байгаа тасалгаа руу хэрүүл өдөхөөр тэмүүлсэн боловч циркийн тамирч түүнийг гар дээрээс нь барьж хөдөлгөсөнгүй.

-Хараал идсэн согтуу минь дуугүй бай! Чамд гар хүрээгүй хүнийг муучлах хэрэг юу байна? Түүнтэй хамт арав юм уу, арван хоёр гладиатор ирснийг үзэхгүй байна уу? Тэд нар чиний муу хөгшин арьсыг тас татаж хаяна шүү.

-Гладиаторууд хамаа алгаа!… тэд яадаг юм?… гэж Эмилий Варин улам агссан юм шиг орилов.

-Бүхнийг чадагч Юпитерийн аянгын өмнө ам алдъя. Та нар чөлөөтэй иргэд атлаа бие биеэ алж биднийг цэнгүүлэх тавилантай тэр муу сайн боолчуудаас айж байгаа юу? Охин тэнгэр Афродита Венерийн гоо үзэсгэлэнт дүрийг дуудан ам алдъя сайхан гоё тога өмссөн боловч биендээ патрицийн хамгийн муу муухай бүхнийг шингээсэн тэр өөдгүй хүнийг ядуу хоосон плебейчүүдийн зовлон зүдгүүрийг сонирхох гэж наашаа хэзээ ччиглэхгүй болгоод өгье л дээ.

-Палатиндаа тонилог гэж Белий хашгирав.

-Газрын гав руу орог! Эндаас зайлбал таарна гэж Арезий нэмж хэллээ.

-Патрицууд эндээс тонил! Эрхтэн ямбатан эндээс тонил! Катилина эндээс тонил! Гэж найм, есөн хүн зэрэг хашгиралдав.

Катилина энэ чимээг сонсож хөмсгөө ууртай зангидан суудлаасаа босож харайхад Требоний ба бас нэгэн гладиатор түүнийг барьж тогтоох гэсэн боловч

Катилина урагш ухасхийн хаалганы дэргэд гүйж очоод гараа элгэн дээрээ зөрүүлэн толгойгоо дээш өргөж аймаар сүртэй дууныхаа байдаг чадлаар:

-Тархигүй муусайн мэлхийнүүдээ юэ гэж орилолдож байгаа юм. Та нар Катилинын нэрийг боолын бузар амаар юунд бузарлаж байгаа юм бэ? Үзэшгүй муусайн өт хорхойнууд та нар надаар яах гэв? Гэж зандарлаа.

Үймэгчид энэ сүртэй дуунаас айх шиг болсон боловч

-Чамайг эндээс яваасай гэж хүсэж байна бид гэж тэдний дотроос аль нэг нь хэлэхэд бусад нь бүгдээр:

-Чи Палатинадаа тонил, Палатиндаа оч гэцгээлээ.

-Эсвэл чи гемонидоо оч, чиний байр тэнд л байна! гэж Эмилий Варин гингэсэн чанга удугаар орилов.

Тэгвэл намайг эндээс хөөгөөд үз л дээ. Наашаа гараад ир муусайн амьтад аа! гэж Катилина чарлаад гараа барилцах гэж байгаа м шиг сунгасанд

Плебейчүүд түр зуур эргэлзэж байтал ясчин Арезий:

-Тамынх шулмасыг дуудан ам алдъя. Хөөрхий тэр Гратидианыг араас нь шүүрч авсантай адил чи намайг барьж авч чадахгүй бизээ. Чи ямар Геркулес биш! гэж хашгиран Катилина руу дайрсан боловч Катилина түүний цээжний гол руу аймшигтай чанга цохисон тул тэр гуйвж байгаад ардаа байсан хүмүүсийн гарыг налж ойчлоо. Тэгтэл нөгөө нэг ясчин Лувений бас дайрч очсон боловч цахилгаан шиг хурдан хөдөлгөөнтэй Катилинын зангидсан гарт дайрагдан халзан толгойгоо дүйртэл хоёр удаа цохиулан зэргэлдээ ханын дэргэд ар зоогоороо ойчлоо.

Хүүхнүүд сандарч уйлалдан чарлалдан Лутацияг лангууны цаагуур орцгоолоо. Том тасалгаагаар дүүрэн бужигнаан болж ойчиж байгаа бандан хэмхчиж байгаа сав суулга пижигнэн хашгиралдах, хараах зүхэх дуун сонсогдоно. Нөгөө тасалгаанд байсан Требоний, Спартак болон бусад гладиатор зодоонд оролцох бололцоо бидэнд өгч хаалганаас зайлж өгөөч гэж Катилинаг гуйна.

Гэтэл Катилина хутга барьж дайрсан гуйлгачин Велленийн гэдэс рүү нь хүчтэй өшиглөсөнд нөгөө гуйлгасан өнхрөөд явчихлаа.

Катилинад дайсагнагчид гуанзны хоёрдахь өрөөний үүдэн дээр бөөгнөрч байснаа гуйлгачийн ойчихыг харж гэдрэг ухрадад Луций Сергий богинохон илд сугалан авч урагшаа ухасхийн согтуучуудын нуруу руу илднийхээ хавиргаар аймаар хүчтэй балбөаж зэрлэг араатны дуун мэт сөөнгө дуугаар:

-Ичгүүрээ алдсан өөдгүй муусайн амьтад аа! та нар өөрсдийнхөө гишгэлэн дарж байдаг хүмүүсийн хөлийг долооход бэлхэн байдаг мөртлөө та нарыг талархан, та нарын зүг гар сарвайсан хүнийг муучлан доромжилно гэж дуу алдав.

Катилиныг хаалганаас дөнгөж хөдөлмөгц тэр хаалгаар Требоний, Спартак хоёр нөхдийнхөө хамт гүйж ирлээ.

Катилинад нүдүүлэн тэртэй тэргүй ухарч эхэлсэн муусайн амьтад гладиаторуудын довтлоход бүр ч хурдлан зугтав.

Удалгүй гуанзанд хүнгүй болж гагцхүү балайртлаа жанчуулан хөсөр унаж ёолж байсан Веллений Лувений хоёр зодоонд огт оролцолгүй зуухны дэргэд элгээ тэврэн харж зогссон Кай Тауривий нар л үлдсэн байлаа.

Катилина зугтагсдын хойноос хаалга хүртэл хөөж:

-Өөдгүй хогууд! Гэж амьсгалаа давхцуулан үлдэв.

Тэгээд уйлж орилсоор байсан хүүхнүүд рүү харж:

-Дуугүй байцгаагаач дээ, золигийн уйланхайнууд минь! гэж бархирав.

Бас лангууныхаа ард ороод хэмхэрсэн сав суулга, зугтагсдад идүүлж уулгасан хоол унд, архи дарсныхаа үнэ мөнгийг олж авагүй алдсандаа гаслан уйлж байсан Лутациягийн лангуун дээр таван алтан зоос хаяад:

-Май үүнийг чи ав! Үл бүтэх юмнуудын өмнөөс Катилина мөнгө тоолж байна. Май үүнийг ав, заяа муутай уйланхай минь гэлээ.

Энэ үед Катилина болон түүний нөхлийг айж сандарсан байдалтай ширтэн харж байсан Родопея хүүхний царай гэнэт хувхай цайж Спартак руу ухасхийж:

-Спартак мин чи мөн байна. Чи миний Спартак байна. Би танилаа, би танилаа гэж сүүрс алдан дуу тавихад Спартак дуугарсан зүг рүү гүйж очоод тэр бүсгүйг сэтгэл нь хязгааргүй хөдөлсөн шинжтэй харж:

-Юу гэв ээ чи? Чи минь үү? Мирца минь би мөнх үү? Дүү минь гэж хашгираад тэврэлдэхэд хүн бүхэн маш их гайхжээ. Нулимсаа мэлмэрүүлэн нэгэн хэсэг тэврэлдэнх үсэлдэж байснаа, Спартак охин дүүгийнхээ тэвэрсэн гараас нь мултран, гараас нь барьж аваад биеэсээ холдуулаан хөлөөс нь аваад толгойгий нь хүртэл харснаа царай нь аймаар хувхай цайж:

-Үгүй чи! Ээ дээ! гэж эхүүрхэн дургүйцсэн байртайгаар хүүхнийг гэдрэг түлхэж чи чинь… гэж дуу алдав.

-Би боол болсон гэж хөөрхий бүсгүй аман дотроо үглэн цурхиртал уйлж, би нэгэн өөдгүй хүний боол болоод торлог, шүүлт, халуун төмрөөр хайруулах зовлон эдэлж байна… ойлгож байна уу? Спартак минь ойлгож байна уу? гэлээ.

Гладиатор эр, өрөвдөж хайрласнаас чичигнэсэн дуугаар

-Хөөрхий минь! Хонгор минь! Нааш ир, нааш ир, ахынхаа зүрхэнд наалд гэж хэлээд Мирцаг татаж авчран чанга гэгч тэвэрч үнслээ.

Спартак эгшин зуурын дараа нулимс гүйлгэсэн боловч уур хилэн нь бадарсан нүдээр дээш таазны зүг харж хүчирхэг гараа зангидан заналхийлэн зангаж:

-Юпитер аянга бий гэж үү? Юпитер тэнгэр бурхан мөн гэж үү, үгүй, үгүй Юпитер чинь амилан хошигногч хамгийн муу өөдгүй амьтан юмаа гэж дуу алдав.

Энэ үед Мирца Спартакийн аврага цээжинд нүүрээ наалдуулан цурхиртал уйлж байжээ.

Фракийн хөөрхий иргэн Спартак хоромхон зуур чимээгүй байснаа:

-Улс амьтныг чөлөөтэй иргэн, боол гэж хоёр хэсэг болгон хуваасан анхи түрүүний тэр хүний хоолойноос гарч болшгүй муухай дуугаар хашгиран хэлжээ.

## СПАРТАК ОЛСОН ЭРХ ЧӨЛӨӨГӨӨ ХЭРХЭН АШИГЛАСАН НЬ.

Үүний урд бүлэгт бидний өгүүлсэн хэрэг явдал болсноос хойш даруй хоёр сар өнгөрлөө.

Дараачийн 676 оны нэгдүгээр сарын идийн урьд /нэгдүгээр сарын 12-ны/ өдрийн өглөө Ром хотын гудамжаар умарт зүгийн хүчтэй нөөлөг салхи салхилан, огторгуйг гунигтай уруу шинжтэй болгосон бор бор үүлийг хөөн тарааж хүмүүс дор дорынхоо хэрэг ажлаар Форумын зүг яарч ганц нэгээр буюу бөөн бөөнөөр явж өнгөрнө. Форум, түүний хавь ойрын орон байшин саравчин доор хэдэн мянган хүн цугларан бөөгнөрчээ. Ялангуяа зүүн баруун жигүүр нь бас нэг нэг саравч салбарлуулсан үзэсгэлэнт сайхан баганат нэн өргөн төв саравчнаас бүрдсэн Эмилийн Базилика гэдэг сүртэй их барилга доор хүмүүс олон байлаа.

Тэнд ноёрхох ангийн хүмүүс, патрицууд, мөн бүрэн бус эрхтэй иргэд болох плебейчүүд, илтгэгчид ажил, хэргийн хүмүүс, энгийн иргэд, худалдаачид, цөөн цөөн хэсгээрээ ялгаран дор дорынхоо ажил төрлийг ярилцан ямар ч замбараагүй чихэлдэнэ.

Олон амьтны дуу хүнгэнэж, олны зогсо зайгүй хөл үймээний шуугиан сонсогдоно.

Гол баганат танххим дотор хаалганы яг урдаас харсан хээтэй урт өргөн хайс байгаа нь баганат дээврийн нэгэн хэсгийг нөгөө танхимаас тусгаарласан тул дуу чимээ, дуулдахааргүй тусгай өрөө шиг болгожээ. Энд шүүгчид хэрэг шүүдэг, илтгэгчид өмгөөлөл үг хэлдэг ажээ. Баганат дээвэр дээр танхимыг нийтэд нь тойруулан тагт хийсн нь доор юу болж байгааг харахад тун ч тохиромжтой билээ.

Энэ өдөр чулуучин, шаварчин, дархчууд тагтыг хүрээлсэн хээтэй хайс дээр ажилалаж Кимврын дайнд Марийн байгуулсан гавъяа зүтгэлийг гайхамшигтай урнаар дүрслүүлэн хүрлэн бамбайгаар чимэглэж байлаа.

Эмилийн танхимыг Марк Эмилий Лепидийн өвгөд бариулсан юмсанжээ. Энэ жил Квинт Лутацийтай хамт консцлын албан тушаалд сонгогдсон Марк Эмилий Лепид нь Марийн намын хүн юм. Энэ хүн консулын албан тушаалд соногдсоныхоо дараа хийлгэсэн төрийн их үйл хэргийн нэг нь элэнц эцгийнхээ бариулсан танхимыг тэр бамбайнуудаар чимэглэж эрэлхэг цогтой өрсөлдөгчийнхөө дурсгалд нь зориулан босгосон бүх хаалга хөшөөг устгасан Суллын эгдүү хүргэх ажил байжээ.

Дээд тагт дээр цугларагсад доор бөөгнөрсөн олон улсыг сонирхон харж байсан хүмүүсийн дунд Спартак гантиг хашлага түшин зогсож, тэр доор үймэлдэж байгаа хүмүүсийг хайхрамжгүй хайш яйш харж байлаа.

Спартак цэнхэр өнгөтэй туник өмсөж дээрээс нь грек маягийн хүрэн улаан өнгийн богинохон нөмрөг нөмрөөд түүнийгээ энгэр дээрээ, цэвэрхэн хийцтэй мөнгөн даруулгаар бариулан торгон тогтоожээ.

Түүний хажууханд гурван хүн хоорондоо шамдуу ярилцаж байгаа харагдана. Тэдний хоёры нь манай уншигчид мэднэ. Нэг нь циркийн тамирч Кай Тауривий, нөгөө нь Эмилий Варин ажээ. Гуравдахь хүн нь аль нэгэн патрицийн өглөг хишгийг өдөр бүр олж хүртэн амьдарч дэмий тэнүүчлэн явдаг ни лээд олнгы нэгэн байжээ. Энэ мэт хэсүүчлэн явдаг хүмүүс өөрсдийгөө ямар нэгэн патрицийн клиент гэж нэрлээд түүнийг дагаж Форум, комиц зэрэг газраар явдаг, түүний тушаалаар саналаа гаргадаг, өөрий нь магтаж бялдуучилдаг, бас үргэлж л юм гуйж тэднийг залхаадаг ажээ.

Энэ үе бол Ромынхон Африк, Ази тивүүдэд дайн хийж ялаад дорно зүгийн зангаар баян өргөн, эрх ямбатай суух заншил авсан бөгөөд Ромын Зэвсэгт ялагдсан грек улс эрх ямбанд задгайрч завхайрсан суртахуунаар ялагчдыгаа эргүүлэн ялсан үе билээ. Энэ үед хөдөлмөрт дуртай чөлөөтэй иргэд үүнээс өмнө гүйцэтгэж ирсэн бүх ажил хөдөлмөрийг улам улмаар олширч байсан боолчууд дангаараа хийдэг болсны харгаагаар Ромынхан хүч чадал, ариун зан суртахуун, зол жаргалын хамгийн хүчирхэг эх булаг болсон ажил хөдөлмөрийг орхисон билээ. Гадаад италаас нь харахад үзэгдэх сүр жавхлан баян өргөн байдлын цаана Ром хот хожим балран унахын аймшигтай уг сурвалж мэдэгдэж байлаа. Бидний өгүүлж байгаа үед Ромын төрийн багууллагыг дээд хэмжээгээр бутарган сарниулж байсан гэмийн нэг бол клиентийн ёс байжээ. Патриций бүхэн төрийн эрх барих консулын нэр зүүсэн иргэн бүхэн нэр сүрд дуртай баян чинээлэг хүн бүхэн тав зургаан зуун клиентийг тэжээдэг бол гоц баян бөгөөд нэр сүрийг онц эрхэмлэдэг иргэд мянга гаруй клиенттэй байжээ. Хөдөлмөр хийх чадалтай тэр хүмүүс клиентийн үүргийг дээр үед тэдний эцэг өвгөд нь уран дархан чулуугаар юм урлах, гутал оёх ажлыг хийж байсантай яг адил гүйцэтгэдэг байжээ. Өмч хөрөнгөгүй,хувцас нь хир буртаг болсон ч гадна гэмт хэрэг үйлдэж, бие худалдсан тэр хүмүүс хов жив хөөцөлдөх, саналаа бусдад худалдах, юм гуйх, бялдуучлах ажилаар амиа тэжээдэг юмсанжээ.

Эмилийн танхимын тагт Кай Тауривий, Эмилей Варин нартай чалчиж байсан тэр хүн Марк Крассын клиентийн нэгэн байжээ. Түний нэр Апулей Тудертин гэнээ.

Тэр гурван хүн худал үнэн юм чалчиж Спартакийн дэргэд зогсож байсан боловч Спартак нь гунигтай бодол бодож байсан учир тэдний яриаг дуулсангүй.

Шившигчт муухай байдалд орсон дүүгээ олж авсан тэр өдрөөс эхлэн, Спартак дүүгээ үл бүтэх эзний нь гарас салгаж авах санааг нэн тэргүүнд бодож арга сүвэгчлэн болжээ. Тэгээд Спартакийг Мирца дүүгээ худалдан эргүүлж аваг

гээд Катилина Долабеллаас хожсон бусад найман мянган сестерцийг уг өглөгч зангаараа болович энэ удаад далд санаа огт үгүй байх гэж арай ч бодож болмооргүй байдалтай өгчээ.

Спартак, таны энэ мөнгийг би эргүүлэн өгнө гэж амлаад дүүгээ худалдан авахаар эзнийд нь хүрч очсон ажээ. Тэр хүн Спартакийн шамдаж шаардахыг хараад дүүгээ худалдан авч чөлөөтэй хүн болгох их хүслий нь мэдэж хачин их үнэрхсэнийг мэдэж ядах юу билээ. Тэр хүн тал хувийг худал хэлж: Би Мирцаг хорин таван мянган сестерцээрхудалдан авсан юм. Мирца бол даруу зантай, цэвэрхэн бүсгүй болохоор тавин мянган сестерцийн үнэтэй хөрөнгө минь юм гэжээ. Энэ үнэнээс би ганц сестерцийг ч саахгүй гэж Мурсийн Венерийн нэрийг дуудан тангараглажээ.

Энэ үгийг сонсмогц хөөрхий тэр гладиатор яасныг үгээр бичсэнээс бодож үзвэл хялбар бизээ.

Амьд хүнийг панзлагч тэр үзэшгүй бузар худалдаачныг Спартак цөхөртөл гуйвч өөдгүй тэр хүн хууль цааз миний эрхийг хамгаална гэдэгт ер итгэж хөдөлсөнгүй.

Тэгэхд нь Спартак өөдгүй тэр хүнийг ууртай гэгч багалзуурдаж аваад, хэрвээ гэнэт ухаан орж тавиагүйсэн бол хэдхэн хормын дотор боож алах байсан билээ. Луйварчингийн заяа болж Спартакийн санаанд түүний охин дүүр, төрсөн нутаг, өөрөө толгойлохоор нууц санаачилсан их хэрэг орж тэр хэрэг минь зайлшгүй баларна гэсэн бодол төржээ.

Спартак бищэ барьж дүүгийнхээ эзний багалзуурыг тавьжээ. Нөгөө муу нь бараг ухаан алдаж нүд нь орой дээрээ гарчихаад царай нь хөхрөн хөдлөх сөгөөгүй зогсож байлаа. Спартак түр зуур бодол болсноо нөгөө хүн рүү эргэж хараад сэтгэл нь хөдлөн уурлаж бүх бие нь чичирч, царай нь хувцхай цайсан хирнээ тайван дуугаар:

-За тэгээд тавин мянган сестерций авах санаатай гэнээ? гэж асуулаа.

-Би… юу… юу ч авахгүй, тонил… там руу тонил… үгүй бол би боолчуудаа бүгдийг дуудна шүү.

Би буруугаа хүлээе… намайг уучлаарай… би жаахан түргэдүү зан гаргачихлаа… би дүүдээ хайртай. Би ядуу хоосон хүн… чи сонсож бай, хоёулаа хэлэлцэж тохиръё гэлээ.

Тэгэхэд нь Мирцагийн эзэн бага зэрэг тайвшран гэдрэг ухарч хоолойгоо барьж үзээд:

-Хүрч ирэнгүүтээ хүний багалзуур шахдаг хүнтэй яаж хэлэлцэж тохиролцох вэ? Яв эндээс тонил гэжээ.

Гэвч Спартак тэр дээрэмчний санааг аажмаар засаж тайтгаруулаад ингэж ярилцан тохирчээ. Спартак түүнд одоохон хочр мянган сестерций өгнө. Нөгөөх нь Мирцад тусгай нэгэн байр гаргаж өгнө. Түүнд нь Спартак бас орж сууна. Харин Спартак нэг сарын дотор дүүгээ худалдан авч эс чадвал эзэн нь Мирцаг эгүүлэн авахаар тохиролцсон билээ.

Алтан зоосууд сэтгэл татам сайхан гялалзаж байсны дээр юугаа ч алдалгүйгээр наад зах нь мянган сестерций олж авах тул тэр болзол Мирцагийн эзэнд тун ашигтай байжээ.

Мирцаг аятайхан жижиг тасалгаанд оруулсныг мэдэж аваад Спартак Требоний суудаг Субунррад очиж түүнд бүх юмаа ярьж өгөөд тусламж зөвлөлгөө гуйжээ.

Требоний Спартакийн сэтгэлийг засах гэж чамайг санасан санаандаа хүрч охин дүүгээ чадвал бүрэн чөлөөлж, эс чадвал элдэв дорожиллоос мултлан авах хэрэгт чинь тусалъя гэж амлажээ.

Спартакийн санаа бага зэрэг амарч тэр даруй Катилинынд очиж урьд зээлсэн найман мянган сестерций одоо нэгэнт хэрэггүй болсон тул баяртай буцааж өгчээ. Түвшин биш сэтгэлтэй тэр патрицфий номын сангийнхаа өрөөнд гладиатортой удтал ярилцжээ. Ингэж ярилцах үед хэн нэгэн хүн саад болсон бий гэж Катилина их хянуур болгоомжилсныг бодоход тэд нар их ачхолбогдолтой нууц юм ярьсан бололтой. Энэ өдрөөс эхлэн Спартак тэр патрицийнд байн байн очдог болж тэр хоёр бие биеэ хүндэтгэннөхөрсөгхарилцаатай болсон болов уу гэмээр болжээ.

Энэ завсар сургуулийн эзэн Акциан Спартакийг орхилгүй дагаж, байдал чинь тогтворгүй байна. Чи хувь заяагаа бат тогтвортой болгохыг бодох хэрэгтэй гэх зэрэг зах зааггүй яриа ярьж залхаадаг байжээ. Энэ яриа бол Спартакийг өөрийн сургуулийн захирал болгох гэх юм уу эс бол өөрийгөө гладиатор болгон сайн дураар худалдвал бүр ч сайн гэсэн утгатай бөгөөд хэрэв чи дахин гладиатор болбол чамд эрх чөлөөтэй төрсөн ямар ч хүнд урьд хожид өгч байгаагүй их мөнгө өгнө гэдэг ажээ.

Гладиатор болгохоор худалдагдсан хөөрхий муусайн боолчууд мөн тийм ажилд тохогдонх шийтгэгдсэн хүмүүсээс гадна сайн дурынхан гэж бас байсныг мэдэх хэрэгтэй юм. Сайн дурынхан гэдэг нь өр ширэндээ баригдаж жаргал цэнгэлийг мөрөөдсөн тачаангуй хүслээ хангаж чадахгүй болсон үхэхээс буцахгүй залхуу шалиг танхай хүмүүс байдаг ажээ. Эд нар гладиаторын сургуулийн эзэнд тангараг өргөн, биеэ худалдаад амфитеатр буюу циркийн талбай дээр амь үрэгддэг байжээ.

Спартак хуучин эзнийхээ үгэнд огтхон ч орохгүй байхад нөгөө эзэн нь салахгүй мөрдөн дагаж муу зүгийн савдаг шиг дэргэдээс нь холдохгүй байжэ.

Гэтэл Требоний Спартактай дотно болсноос гадна түүнийг хожмын цагт түшиглэх гэж бодсон ч байж магадгүй тул Мирцагийн хувь заяаг нэгэн тийш болгохоор шуурхай хөөцөлдөжээ. Энэ хүн Квинт Гортензийг сайн таньдаг болохоор Мирцаг худалдан авч, эзэн авхайг үйлчлүүлэхээр тусгайлан тавьсанх боол хүүхнүүдийн тоонд авахаар, түүний дүү Валериятай ярилцан тохиролцсон билээ.

Мирца хүмүүжил боловсрол сайнтай, грек хэл тун сайн мэддэг, язгууртан авхай нарын соёл хэрэглэх үнэртэн танартны зүйлийг зүгээргүй мэддэг бүсгүй юмсанжээ.

Хэрэв санаанд тохирвол тэр бүсгүйг авахад татгалзахгүй гээд Валерия түүнтэй уулзахыг хүссэн бөгөөд, уулзаж ярилцахад Мирца түүний санаанд тохирсон тул өнгөрсөн оны арван хоёрдугаар сарын 15-наас эхлэн Суллын гэргий болсон Валерия дөчин таван мянган сестерцийн үнээр Мирцаг худалдан авч бусад шивэгчдийн хамтаар Суллын ордонд аваачжээ.

Энэ бүхэн нь дүүгээ чөлөөтэй хүн болгох гэж бодсон Спартакийн хүслийг бүэрн хангаж чадаагүй больвч Мирцаг гутамшигт доромжиллоос үүрд салгахын тулд одоогийн нөхцөл байдалд бүтэн болох хамгийн олигтой үйл хэрэг шиг санагджээ.

Спарта дүүгийнхээ төлөө сэтгэл зовохоо больж Катилинатай байн байн уулзаж ярьдаг, Ром хотын гладиаторуудын бүх сургууль дээр өдөр бүр очдо, мөн үдшийн цагт Суббура, Эсквилин хоёрын гуанз цайны газраар явж гладиатор, боолчуудын дунд байхыг эрмэлздэг болсныг бодоход ямар нэгэн нууц бөгөөд тун чухал ажил хийсээр байгаа ажээ.

Спартак юу хүсч мөрөөдөв? Ямар хэрэг үүсгэв? Юу сэдэвлэж бодов? Тэр бүхний уншигч та бүхэн удалгүй мэдэх болно.

Спартак Эмилийн базиликийн тагт дээр зогсож байхдаа маш чухал юм сэдэвлэн бодож байсан нь лав учраас ойр хавийнхаа улс амьтны ярианаас юу ч олж дуулсангүй бас дэргэд нь зогсоод бүдүүлэг чанга дуугаар гар нүүрээ хөдөлгөн ярилцаж байсан Кай Тауривий, Эмилий Варин, Апулей Тудертин нарын зүг нэг ч удаа эргэж харсангүй нь энэ удаад мэдэгдэж байна.

-Та нар харж байгаарай, энэ жил урьд зэгдээгүй ямар нэгэн үйл явдал болох ёстой гэж Варин ярилцаж байсан нөгөө хоёртоо хэлэв.

-Яагаад тэр вэ? гэж нөгөө дүүгийнхээ асуухад:

-Яагаад вэ гэвэл Армины тойрогт үнэхээр гайхамшигта хэрэг гарчээ.

-Тэнд чухам юу болоов?

-Валериягийн эдлэлд нэгэн азарган тахиа, тахиа шиг дуугарахын оронд хүн шиг ярьсан гэнэ.

-Уухай! Хэрвээ тэр үнэн бол үнэхээр ер бусын сонин хэрэг байна даа. Бодвол ямар нэгэн аймшигт үйл хэргийн зөн билэг биз.

-Хэрвээ тэр үнэн бол гэнээ? Энэ сургийг Валерия болоод түүний гэр орныхон, найз нөхөд, боол зарц нар Арминумаас буцаж ирсэн доороо тархаасан болохоор одоо Ром даяар ярилцаж байна шүү дээ.

Апулей Тудерти сүсэг бишрэл ихтэй, элдэв зөн билэгт итгэдэг тул дуугарч:

-Тэр үнэхээр ер бусын гайхалтай хэрэг байна даа гэж аман дотроо дуугараад, бат үнэмшиж тэнгэр бурхны хилэн гэж болсон тэр хэрэг явдлын далд агуулгыг эрэгцүүлэн бодлоо.

Энэ үед дунд хирийн нуруутай, ханхар чийрэг цэжтэй, эрэлхэг зориг төгөлдөр царайтай хар нүдтэй, гялтганасан хар сахалтай нэгэн хүн Спартакийн мөрөн дээр зүүн гараараа аяархан алгадаж орхив.

Чи төлөвлөгөөгөө хичээнгүйлэн бодож, хүнийг эгцлэн харсан хир нь юу ч олж үзэхгүй байна даа? гэлээ.

-Ээ% Крикс үү! Гэж Спартак дуу алдаад бодлоо сарниулах гэсэн юм шиг баруун гараараа духаа илбэж –би чамайг харсангүй шүү гэв.

-Манай эзэн Акциантай цуг тэр дор явж өнгөрөхөд чи над руу харж байсан шүү дээ.

-Хараал идмэрээ! … за ажил хэрэг ямар байна гэж Спартак асуулаа.

-БиАрторикстай буцаж ирснээс ньхойш уулзсан.

-Тэр чинь Капуяд очиж гэнэ үү?

-Очон гэнээ.

-Хүн амьтантай уулзаа юу?

-Бусад нөхдийнхөө дотрос хамгийн бяртай гэгддэг Эномай гэгч герман хүнтэй уулзсан байна.

-Тэгээд! Тэгээд яаж вэ? гэж Спартак сэтгэл нь улам бүр түгшсэн байртай асууж, түүний нүд нь итгэл найдвар, баяр баясгалангаар гялалзаж байлаа.

-Тэр Эномай гэгч хүн бидэнтэй адил мөрөөдөл болж байсан хүн юм. Тийм ч учраас бидний төлөвлөгөөг чин үнэнээсээ зөвшөөрч Арторикст тангараглан манай шударга ариун үзлийг Лентул Батиатын сургуулийн хамгийн зоригтой гладиаторуудын дунд тараах ам өгчээ. “Чиний шударга ариун үзлийг гэхийн ород “Бидний” гэж миний хэлснийг уучлаарай гэхэд нь Спартак сэтгэл гүйцэд ханасан янзтай санаа алдан:

-Олимп ууланд орогногч бурхад дарлагдсан олны зорьсон хэрэгт нь тусалбал боолын ёс газрын хөрснөөс бүрмөсөн арилах тийм азтай сайхан цаг удахгүй ирнэ гэж би сэтгэж байна гэж аяархан хэлжээ.

-Гэлээ ч гэсэн тэр Эномай гэдэг хүн сүрхий зоригтой мөртлөө болгоожм муутай, хөнгөмсөг, бодол султай хүн байна гэж Арторикс надад хэлсэн шүү гэж Крикс нэмж хэлжээ.

-Геркулесын нэрийг дуудан ам алдъя. Тэр муу хэрэг байна даа. Тун муу хэрэг. Би ч бас тэгж бодлоо.

Ингээд хоёр гладиатор дуугүй болчихлоо.

Крикс эхлэн дуугарч:

-Катилина ямар байна? гэхэд Спартак:

-Катилина манай зорьсон хэргийн төлөө бидэнтэй хамт ердөө цуг явахгүй байх гэж би боддог боллоо гэж хариу хэллээ.

-Тэгвэл түүний алдар нэр нь хуурмаг ч ззүйл. Сэтгэл зориг нь магтагдсан цог жавхлан нь худал хэрэг болж байна даа?

-Тийм бишээ. Тэр агуу их сэтгэлтэй, бүр ч их ухаантай, гэвч жинхэнэ ром ёсны хүмүүжлийнхээ бүхий л хоцрогдсон үзэл санаанд автагдсан хүн юм. Миний бодоход тэр хүн одоогийнх засаг төрийн ёс дэглэмийг устгахын төлөө бидний зэвсгийг ашиглах гэж бодсоноос биш бүх ертөнцийг Ром ганцаараа атгаж харгислах болсон тэр хуулийг устгахын төлөө ашиглах гээгүй гэж би бодож байна гээд

-Спартак түр зуур дуугүй болсноо:

-Би өрөө орой гэрт нь очиж түүнтэй ба нөхөдтэй нь уулзаж хамтран босох тухай ярьж тохирох санаатай байна. Гэвч бид ам хэлээ ололцохгүй байх даагэж бодох юм гэж нэмж хэллээ.

-Бидний нууцыг тэр чинь нөхөдтэйгөө цуг мэдсэн хэрэг үү?…

-Бидний нууц илэрлээ ч гэсэн ямар ч аюул байхгүй. Бид хэлэлцэн тохирдоггүй юм гэхэд биднийг эрхбиш барьж өгөхгүй. Ромынхны боол, зарц, гладиатор бид нараас айх нь тун бага шүү дээ. Тийм ч учраас биднийг засаг төрд сүрхий занал учруулж чадахгүй гэж үздэг юм. Одоогоос арван найман жилийн өмнө Сирийн нэгэн боол Эвнгийн удирдлагаар Сициллд босч Ромтой ширүүн тэмцсэн боолчуудыг биднээс илүүд тооцсон юмдаг.

-Зөвдөө тэд нар чинь хүн шүү дүрстэй юм шүү.

-Харин бид бол тэдэнд хүн биш доорд араатан л даа.

Криксийн нүдэнд хачин их уур хилэнгийн гал дүрэлзэх мэт үзэгдэж:

-Ай Спартак минь ээ, Спартак минь, хэрэв чи өөрийнхөө зорьсон хэцүү бэрх үйл хэрэг юугаа туйлд нь хүргэвэл циркийн талбай дээр халуун амий минь аварч өгсөнд талархдагаасаа илүү би чамд талархана. Чи биднийг нэгтгэж удирд. Бид зэвсгийнхээ хүчийг гаргая. Тэр язгууртан дээрэмчидтэй ил тулалдан хүчээ үзэлцэх бололцоо буй болгож аль. Тэгвэл бид доорд амьтан биш тэд нартай адилхан хүн гэдгээ үзүүлье гэж шивнэв.

-Ээ манай үйл хэргийн төлөө би амь насныхаа эцсийг хүртэл шамдан тэмцэж гуйвшгүй зориг, цуцашгүй зүтгэл, сэтгэл санааныхаа хамаг хүчийг гарган энэ хэргийг ялгуусан төгсгөлднь хүргэнэ. Эсвэл түүний төлөө тэмцсээр амиа өгнө.

Спартак энэ үгийг Криксийн баруун гарыг чанга атган итгэл төгөлдөр баттай хэлэхэд нөгөөдөх нь Спартакийн гарыг атган цээжиндээ нааж:

-Ээ Спартак аа, аврагч минь ээ, чи их үйл хэрэг бүтээх гэж төрсөн хүн, чам шиг ийм хүмүүсийн дотроо баатрууд төрж гардаг юм! гэж Крикс сэтгэл их л хөдөлсөн байртай хэлэв.

Спартак гүнээ гашуудсан шинжтэй толгойгоо гудайллгаж.:

-Эсвэл зовлон амсах хүн ч төрж гарна гэж шивгэнэв.

Хоёр гладиатор хоорондоо ярилцсаар базиликийн саравч руу орсон гадна шат чиглэн явав.

Тэр хочрыг саравч дөнгөж хүрэнгүүт нэгэн хүн Спартакийн дэргэд ирээд:

-За Спартак аа! Чи хэзээ миний сургуульд эргэж очих гэж шийдэв? гэж асуулаа.

Тэр бол гладиаторын сургуулийн эзэн Акциан байжээ.

Гладиатор Спартак урьд эзэн байсан этэр хүн рүү уууртай гэгч эргэж хараа:

-Ээ чамайг Стикс амьдаар чинь залгих болтугай!Гайтай хүсэлтээрээ намайг зовоохоо хэзээ больж амар байлгах юмбэ? Гэж дуу алдав.

Уран аргат уяхан хоолойгоор:

-Үгүй би чиний л төлөө чамд гай болж яваа юм. Чиний хожмыг бодож л би… гэж Акциан ая дагуулсан ялдам дуугаар хэлэв.

-Акциан чи миний үгийг сонсож, цээжиндээ сайн гэгч шингээж ав. Би хүүхэд биш, надад асран тэтгэгч хүн хэрэггүй. Хэрэгтэй байлаа ч гэсэн чиний дэмжлэг тусламжийг би хэзээ ч авахгүй. Замд минь дахиж бүү дайралд. Эцэг өвгөдийн минь тэнгэр Родопсын Юпитерийн нэрийг дуудан ам алдъя. Хэрэв эс тэгвэл чиний хөгшин халзан толгойг хэмх дэлсэж, чамайг тамын оронд тонилгоно. Тэгээд юу болбол болог. Үүнийг санаж яваарай! Гэснээ эгшин зуур дуугүй блж

-Надаар хатгах цавчих хичэл заалгаж байсан чиний арван боол – корсикчууд нэгэн өдөр модон жад барьж намайг дайрахад би энгэ нударгаараа тэднийг яасныг чи өөрийнхөө нүдээр үзсэн байх. Миний гарын хүчийг чи мэднэ шүү дээ гэж нэмж хэллээ.

Гладиаторын сургуулийн эзэн буруугаа хүлээж чин үнэнчээ илэрхийлэхэд нь Спартак:

-Тонил тэгээд? Үүнээс хойш миний нүдэнд битгий үзэгдээрэй гэж хэлэв.

Нөгөө хоёр гладиатор ичиж зовсон Акцианыг саравчийн гол дунд орхиод Катилинатай уулзахаар Катуллын саравч руу Палатиныг чиглэн Форум дайран явлаа.

Катилины байшин Ром хотын хамгийн үзэсгэлэнтэй сайхны нэгэн билээ. Тэр байшингийн урд талд байгаа саравчийг дайнд Кимврүүдээс булааж авсан олзны зүйл ба мөн ромын дайснуудын өмнө нь зогсож тангараг өргөдөг байсан хүрэл бух тавьж чимэглэжээ. Тэнд Ромын бүсгүйчүүд цугларан нийлж зугаацдаг буюу биеийн тамир хийдэг тул Квиринын үзэсгэлэнт сайхан охидыг харж сэтгэлээ баясгах гэсэн дэгжин залуучууд, патриций нар, морин тэрэгнийхээ мөн энд цуглардаг байжээ.

Хоёр гладиатор Катуллын саравчинд хүрч ирэхэд хүүхнүүдийг харагсад тэр саравчийг нэлд нь бүслэн хүрээлсэн байлаа. Энэ өдөр цас бороотой байсан учир энд хэзээ хэзээнээс улам олон хүн цугларчээ.

Нарийн ноос, мяндсаар хийсэн түмэн янзын өнгөтэй хувцас, гялалзсан, сувд, эрдэнийн чулууны дунд бөмбөрч байгаа гоё охидын сийлсэн юм шиг цэвэрхэн цагаан гар, эрхэм үзэсгэлэнт дал мөр сэлт нь үнэхээр сэтгэл татам сайхан харагдана.

Охидын дунд Катилинын янаг АврелияОристиела, сайн зан чанартай саруул ухаантайнхаа ачаар хожим алдарт гэж нэршиж дараа нь Писторийн дэргэдэх тулалдаанд Катилинатай мөр зэрэгцэн явж зоригт дайчин эр шиг амь үрэгдсэн, одоо идэрхэн ч гэсэн жавхлант сайхан бүсгй Сомпрониня нэр гоо үзэсгэлэнгээрээ гоц ялгарна.

Саравчин дотор бас Цезарийн эх Авралия, Суллын гэргий Валерия, галын бүсгүй Лициния, нар болон Ромын хотын хамгийн алдартай айл гэрийн хэдэн зуун хатагтай, охид байгаа харагдана.

Үзэмжит өргөн их саравчинд патрицийн тэр охидын нэг хэсэг нь дүүжин дээр дүүжигнэн, нөгөө хэсэг нь Ром хотын эрэгтэй, эмэгтэй хөгшин, залуу, баян хоосон бүх иргэдийн хамгийн дуртай тоглоом болох бөмбөг тоглож байна.

Спартак Крикс хоёр өөрсдийн нь адил байр байдалтай хүмүүсийн зоогсвол зохих газарт, патриций, морин цэргийнхний ар талд очиж зогсоод, Луций Сергий Катилиныг олох санаатай ийш тийш харлаа. Катилина хожим түүний хуйвалдааныг илрүүлсэн Квинт Курий болон хуйвалдааны тэр жил ард түмний трибун болсон идэр залуу Луций Кальпурний Бести нартай хамт баганын дэргэд зогсож байгаа харагдлаа.

Энд цугларсан явгууртнуудыг түлхчихгүйг хичээж явсаар хоёр гладиатор аймшигт патрицид арайхийж дөхөж очлоо. Нөгөөдөх нь ёстой инээмсэглэн:

-Бүдүүн Марк Крассын таалан эрхлүүлдэг галын охин Лициниятай ямар нэгэн аргаар танилцаж, Красс, Эвтибадад сэтгэлтэй болсныг хэлж өгөх юмсан гэж нөхдөд ярьж байлаа.

-Тийм, тийм Эвтибидад хоёр зуун мянган сестерций өгсний нь бас хэлээрэй гэж Луций Бестиягийн хэлэхэд Катилина

-Марк Красс хүүхэнд хоёр зуун мянган сестерций өгнө гэнээ! … тэр чинь Арминумд азарган тахиа хүний хэлээр ярив гэж шагшин ярилцдаг тэр гайхалтай явдлаас илүү сонин хэрэг байна даа гэж дуу алдав.

-Тэр чинь жигтэй харамч хүн учраас л сонин хэрэг болохоос биш уг нь Марк Крассаас хоёр зуун иянган сестерций гарна гэдэг чинь тунгалаг Тибр мөрний элснээс ганцхан ширхгийг авсантай адил юм шүү дээ гэж Квинт Курийн хэлэхэд:

-Чиний хэлдэн зөвөө, долоон мянга гаруй талантын хөрөнгөтэй Марк Красст тэр чинь юу ч биш л дээ гэж Луций баттай хомхой байртайгаар нүдээ бүлтийлгэн хэлэв.

-Тэгвэл тэр чинь бүтэн хагас билмон сестерций гэсэн хэрэг үү?

-Хэрэв төдийчинээ хөрөнгөтэй гээг нь үнэхээр мэдэгдээгүйсэн гэж санагдмаар шүү!

Манай нарийн чанд засаг захиргаатай улсад муу санаатай, мохоо ухаантай хүн, нэр алдар, эрх ямба олж авах өргөн дэлгэр зам ингэж нээгддэг байна шүү. Би ямар ч байлдааныг амжилттай төгсгөж чадах чадалтай гэж өөрийгөө санавч, ядуу хоосон, өр ширэндээ баригдсан хүн болохоор жанжны тушаалд хэзээ ч

томилогдож чадахгүй. Хэрэв Красс алдар нэр олохын тулд ямар нэгэн мужид цэрэг дайны ажлыг удирдан явуулах томилолт олж авах гэвэл зөвхөн хоосон ядуу жирийн ард түмнийг хэрэггүй ховдон сенатын түшмэдийг худалдан авч чадах учраас түүнийг төвөггүй олж чадна гэж Катилина гутарсан байртай хэлжээ.

-Тэр хэмжээгүй их хөрөнгө зөөрийг ямар бузар аргаар олж авсны нь бодоод үзээч гэж Квинт Курийн үг нэмэрлэхэд залуу Бестия тэр үгий нь өлгөж аваад:

-Тийм ээ, тэр хөрөнгийг яаж олж авсан бэ? гээч. Хууль бус аргаар Суллын цаазалсан улсаас хурааж авсан хөрөнгийг маш хямд үнээр худалдан авсан, бас асар их хүүтэйгээр мөнгө зээлдүүлсэн, уран барилгач, чулуучин таван зуун боолыг олж аваад, урьд харц ардуудын орон байшин байгаад олон удаагийн түймэрт шатаж үрэгдсэн хоосон газруудыг бараг зүгээр авч тоо томшгүй олон барилга байшин бариулсан юм гэнэ билээ гэхэд нь Катилина яриаг тасалж:

-Тэгвэл одоо Ромын бүх орон байшингуудын тэн хагас нь түүний хөрөнгө байх нээ гэж хэллээ.

-Энэ чинь шударга хэрэг үү? Үнхэнч ажил уу? гэж Беттия ууртай асуулаа.

Энэ чинь эвтэйхэн хэргээ! Гэж  Катилина гутрангуй инээмсэглэн хэлжээ.

-Ийм явдлаа үүнээс хойшид ч бас үргэлжлүүлнэ гэж үү дээ? гэж Квинт Курий дуу алдав.

-Тэгэх ёсгүй, гэвч хүмүүсийн хувь заяагзаах дархан судар номд юу гэж бичээстэй байдгийг хэн мэдэх ажээ? Гэж Катилина аман дотроо дуугарлаа.

-Хүснэ гэдэг чинь чадна гэсэн үг гэж Бестия түүнд хариу хэлэв. Ром хотноо оршин суухдөрвөн зуун жаран гурван мянган иргэдийн дотроос дөрвөн зуун гучин гурван мянга нь гэдэс цатгалан явах мөнгөгүй, талхиулж ядарсан ясаа тавих газаргүй байгаа бол нөгөө гучин мянган иргэд нь их хөрөнгө шударга бусаар цуглуулсан юм. Тэд нар хууль бусаар тэрхөрөнгийг эзэмшиж байна гэдгийг тэд нарт үзүүлж өгөх зоригтой хүмүүс олдоно. Тэгэхэд өлсөж зовсон хөөрхий ард түмний цусыг сорж амьдардаг үзэшгүй муухай тэр бирдүүдэд үгээгүйчүүд хүч чадлаа үзүүлэх арга олж чадах уу, үгүй юү гэдгийг Катилина чи хараарай гэж хэллээ.

-Залуу нөхөр минь ээ, санасан санаагаа хоосон гомдол, дэмий сул үгээр илэрхийлдэггүй юм шүү залуу минь гэж Катилина үнэн голоосоо хэллээ. Бид нар чимээ багатай, орон байшиндаа, өргөн дэлгэр төлөвлөгөө зохиогоод түүнийгээ чичрэхгүй, хатуу чанга гараар гардан цаг тухайд нь биелүүлэх ёстой. Дуугүй хүлээж бай Бестия минь биднийг дарлан шаналгаж байгаа энэ өмхөрсөн байгууллагыг нэгмөсөн шийдэмгий айхавтар дайран бут ниргэх цаг холгүй болсон байж магадгүй. Энэ байгууллага гаднаас нь харахад гялалзсан сайхан боловч ялзран бутарч байгаа юм гэж Катилина төлөв бадйалтай хэлэхэд Курий энэ ярианы чигийг өөрчлөх гэсэн бололтой:

-Хараач, хараач уран илтгэгч квинт Гортензий ямар их хөгжилтэй бах юм? Тэр Форумын хурлууд дээр өрсөлдөх хүнгүй боллоо гэж Цицероны явсанд баярлаж байх шив гэлээ.

-Мөн л аймхай хүн юм даа тэр Цицерон чинь! Залуугинхаа харгаагаар Марийгмагтаж Суллад буруушаагдсаныгаа мэдэнгүүт хөлөг онгоцонд суугаад Грек рүү оргосон гээч гэж Катилина дуу алдав.

-Тэр чинь Ромоос алга болсоор даруй хоёр сар шахам боллоо.

-Ээ дээ би түүнтэй адилхан уран үгтэйсэн бол хоёрхон сары ндотор Ромын эрхт эзэн болохсон гэж Катилина гараа хүчтэй гэгч зангидан аман дотроо шивэгнэв.

-Чамд Цицероны үгийн уран чадвар дутаж, Цицеронд чиний хүч чадал дутжээ.

-Тийм ч гэсэн бид Цицероны үгийн уран чадвар дутаж, Цицеронд чиний хүч чадал дутжээ.

-Тийм ч гэсэн бид Цицероныг өөрийнхөө талд татаж эс оруулбал /номой зантай болохоор тэгж орж өгөхдөө бэрх л байх/ тэр чинь хэзээ нэгэн цагт манай дайсанд шиглагдан бидний эсрэг аймшигтай зэвсэг болон хувирч болох юм гэж Катилина бодол болсон баяртайгаар чин үнэнээсээ хэлэв.

Ингээд гурван патриций дуугаа хураав.

Энэ үед алтан хээ оёсон ув алаан даавуугаар чимэглэсэн тууз руу Суллын эхнэр Валерий чиглэсэн тул саравчийг хүрээлэн зогссон олон хүмүүс зай тавьж өглөө. Валерияг хэд хэдэн патриций дагаж яваагийн дотроос тарган Деций Цедиций, туранхай Эльвий Медуллий, Квинт Гортензий нар ялгаран харагдана.

Байгаль ертөнцөөс харамгүй заяасан Валериягийн гоо үзэсгэлэнг дорно зүгийн хар хөх өнгөтэй өргөн нөмрөг дурлан харагчдын шунахай нүднээс далдалжээ.

Хүүхний царай л цонхигор бөгөөд ялихгүй бүлтийсхийж гөлөрсөн том хар нүдний нь харц талимааран уйтгарласныг харахад ганцхан сарын өмнө гэрлэсэн авхай тэгж баймааргүй санагдана.

Мэхэсхийн мэндэлсэн патриций нарт Валерий толгойгоо үл мэдэг дохиж хариулна. Мөн эвшээснээ инээмсэглэн баллаж дэгжин Эльвий Медуллий, Деций Цедиций хоёрын гарыг барьж мэндчиллээ. Энэ хоёр патриций Валерияг салахгүй дагаж яваа нь түүний сүүдэр шиг харагдана. Валерияг жуузанд суулгаж өгөх завшааныг тэр хоёр хэнд ч найр тавин шилжүүлэхийг бодоогүй нь лавтай.

Валерия жуузандаа сууж хөшгий нь буулгаад сахиул боолуудыг хөдөл гэж дохио өглөө.

Кайппадок нутгаас авчирсан боолууд жуузыг дамнаж аваад хөдлөхөд замчны үүрэгтэй тусгай нэгэн боол газарчлан явлаа. Жуузны араас зургаан боол хүндэт харуул болж явна.

Валерия талархан дурлагч олон улсыг орхиж хөдлөхдөө сэтгэл сая нэг ханасан байртай урт санаа алдаж, нүүрнийхээ сиймхий торыг нүүр дээгүүрээ буулган, нойтон зам ба уйлагнаж байгаа бүрхэг тэнгэр өөд гунигтай байдлаар ийш тийш харж байлаа.

Спартак бидний өгүүлсэн ёсоор олны ард Криксийн хамт зогсож байгаад жуузан дотор орсон тэр авхай дүүгийн нь эзэн болохыг таньж сэтэл нь ялихгүй догдлолн хамт байсан нөхрийгөө тохойгоороо нударч:

-Хараач!… Суллын гэргий Валерия байна гэж чихэнд нь шивгэнэв.

-Арелатын ариун тахилыг нэрлэн ам алдъя. Энэ хүүхэн Венера дагинатай яг адил гоё байсан гэлээ.

Энэ үед хувь заяат захирагч агсны гэргий морилж явсан жуузыг нөгөө хоёр гладиаторын дэргэдүүр дамнан өнгөрөхөд Валерия цонхоороо хайхрамжгүй харж явснаа Спартакийг онцлон харжээ.

Эрхэм авхай гэнэт цочсон юм шиг болж царай нь үл мэдэг ягаарч ирээд, гялалзсан хар нүд нь гладиаторт тусаж жууз түүнээс холдсон хойно ч сайн харахсан гээд толгойгоо хөшигний цаанаас ялихгүй цухуйлгажээ.

Зол заяатай нөхөрт нь язгууртан хатагтай дотночлон талархсаны гарцаагүй тэр шинж тэмдгийг Крикс олж хараад:

-Энэ чинь сонин хэрэг байна даа эрхэм Спартак минь ээ! Фортуны дагина, энэ муутай зальхай эм, чиний толгойтой үсэн дээрээс шүүрч, авах нь энэ үү, эсвэл чи өөрөө тэр олон ааштай дагиныг гэзэгдэн авах чинь энэ үү? Юу ч л гэсэн чанга барих хэрэгтэй. Хэрэв чамаас зугтах гэвэл гартаа юм үлдээж хоцрохоор чанга барих хэрэгтэй гэж дуу алдаж Спартак руу эргэж харахад нөгөөдөх нь сэтгэл хөдөлсөн янзтай хувхай цагаан царай гарган зогсож байлаа.

Спартак биеэ хүчлэн барьж аль болохоор хэвийн байдалтай байхыг хичээж инээмсэглэн:

-Галзуу минь чи дуугүй бай! Фортуна гэзэг үсний тухай чи юү дэмий чалчиж байгаа юм? Геркулесын бороохойг нэрлэн ам алдъя, чи Андабат шиг сохор амьтан байна! гэж хариу хэлэв.

Спартак аягүй яриаг тасалбар болгоё гэж бодоод Луций Сергий Катилина руу ойртон очиж:

-Би өнөө орой танайд очих уу? Катилина? гэж аяархан дуугаар асуулаа.

Катилина эргэж хараад:

-Очилгүй яахав, харин одоо нэгэнт шөнө болсон учир "өнөө орой" гэж хэлэхийн оронд одоохон гэж хэлэх хэрэгтэй гэж хариулав.

Спартак патрицийд мэхийн ёслоод Крикссийн дэргэд буцаж ирлээ.

Хоёулаа ямар нэгэн юмны тухай шивнэлдэн ярилцаж байснаа Форумын дундуур гарч Ариун гудамжийг чиглэн явж одлоо.

Гладиатортай Катилины дотночлон ярилцаж байхыг гайхан харж байсан Бестия:

-Плутон бурхны нэрийг дуудан ам алдъя!

Чиний хэцүү төвөгтэй сэтгэл санааг үүний урьд мэдэж байснаа одоо учраа бүрмөсөн алдаж орхилоо гэж хэлжээ.

-За юу болов! гэж Катилина гэнэн байдалтай асуув

-Ромын патриций хүн чи, жигшүүрт муу, доорд төрлийн гладиатортой нөхөрлөнө гэнээ!

Патриций эгдүүцэн инээмсэглэж:

-Ээ ямар бузар хэрэг вэ! Бас муухай яа? гэж хэлээд хариу хэлсэнгүй дуугаа өөрчлөн:

-Би таныг үүр цайхын үед өөрийнхөө гэрт хүлээж байя. Тэгээд оройн хоол идэж наргиад, чухал ажил төрлийн тухай ярилцъя гэлээ.

Спартак Крикс хоёр Палатиныг чиглэн Ариун гудамжаар явж байтал гоё дэгжин хувцасласан шагшин гайхмаар сайхан залуу хүүхэн гэнэт тулгарчээ. Дунд хир насны шивэгчин бүсгүй, бас нэгэн педиссека угсааны боол хойноосоо дагуулсан тэр хүүхэн хоёр гладиаторын зорьж очих зүгээс гарч ирсэн билээ.

Улбар шар үстэй дунд цагаан царайтай, гүн далайн ус шиг цэв цэнхэр том нүдтэй энэ хүүхний гоо үзэсгэлэнг хараад, Крикс зогтусан гөлөрч түүнийг гайхан ажиглаж:

-Гезийн нэрийг дуудан ам алдъя! Яасан гайхамшигтай гоо хүүхэн бэ? гэж дуу алдав.

Гунигтай бодол болон уруугаа хараад явж байсан Спартак толгойгоо өргөж хартал өмнө нь нэгэн бүсгүй зогсож байлаа. Тэр бүсгүй Криксийн шагшин гайхсаныг огтхон ч хайхарсангүй харин Спартакийг ажиглаж байгаад таньдаг хүнээ гэнэт харсан юм шиг түүнд хандан:

-Спартак чамайг тэнгэр ивээх болтугай! Гэж грек хэлээр хэлжээ.

Спартак жаахан зовсхийж:

-Үнэн зүрхнээсээ чамд баярлалаа сайхан бүсгүй минь. Чамд тун их баярлалаа чамайг ч Книпын Венера дагина энэрч байх болтугай гэж хариулав.

Гэтэл нөгөө сүгүй Спартакийг хөтөлж ирээд:

-Эрх чөлөө, гэгээн гэрлийг хүсье зоригт Спартак аа! гэж аяархан шивнэв. Спартак энэ үгийг сонсонгуут цочиж охин өөд харж:

-Чиний тоглоомын үг ямар учиртайг би ойлгож мэдэхгүй байна сайхан бүсгүй минь… гэхэд

-Энэ тоглоомж бишээ. Чи учир мэдэхгүй царай гаргаад дэмий. Энэ чинь дарлагдсан олны мэндчилэх нууц үг. Би Эвтибида гэдэг хүүхэн. Грек нутагтай Урьд би шивигчин байсан хүн. Би ч бас дарлагдсан үй олны нэг нь гээд тэр бүсгүй Спартакийн аварга том гарыг шүүрэн барьж стгэл татам элдэг сайхан зөөлөн гараараа атгав.

Гладиатор дахин цочиж:

-Энэ бүсгүй үнэнээсээ ярьж байна шүү. Бас нууц дохио мэдэж байна гээч гэж гайхсан байртай шивнэн хэлэв.

-Би ариун гудамжны их Янусын сүмийн дэргэдхэн суудаг, манайд очорой. Чиний гардаж авсан сайн сайхан үйл хэрэгт чинь би багагүй тус хүргэж чадна шүү гэлээ.

Спартак эргэлзэн гайхаж байсан болхоор хүүхэн үнэн голоосоо гуйж мөрөөдсөн шинжтй гараа хөдөлгөн маш эелдэг зөөлөн дуугаар

-Манайд очоорой гэж нэмж хэллээ.

-Очно гэж Спартак хариу хэлжээ.

Дээд язгуурын сээтгэнүүр хүүхэн гараараа даллан хоёр гладиаторт баяр хүргэн:

-Баяртай гэж лат хэлээр хэлэхэд

-Баяртай гэж Спартак хариулав.

Крикс Спартактай зэрэгцэн зогсож тэр сайхан бүсгүйгээс нүд салгалгүй ширтэж байснаа:

-Гоо сайхан дагинуудын дотроос хамгийн шилдэг сайхан бүсгүй минь баяртай гэж дуу алдан холдож яваа Эвтибидаагийн хойноос хөдлөлгүй ширтэн харсаар хоцорлоо.

Спартак түүнийг дуудаж:

-Криксээ чи эндээс хөдлөх санаа байна уу гэж хэлээгүйсэн бол тэр нь эндээ хэдий болтол алмайран зогсохыг хэн мэдэх ажээ.

Крикс сая нэг сэргэж урагшаа явахдаа байн байн эргэж харсар явлаа. Тэндээ гурван зуугаад хир алхам газар явсны дараа Крикс:

-Фортунын хайрт хүү гэж чамайг нэрлэхэд чи бас л дургүй байна уу? .. чи ачийг мэддэггүй хүн юм даа… чиний дээгүүр жигүүрээ дэлгэсэн тэр олон ашигт дагинад зориулан дурсгалын сүм босгох хэрэгтэй гэж дуу алдав.

-Энэ хөөрхий хүүхэн надтай яах гэж яриа үүсгэв?

-Энэ хүүхэн хэн болохыг би мэдэхгүй. Мэдэхийг ч хүсэхгүй.н Харин Венера дагина гэж үнэхээр байдаг юм бол энэ бүсгүй л хөөрхөн байж чадахгүй гэдгийг л би лавтай мэдэж байна гэлээ.

Саяхан Валерияг дагаж явсан боолуудын нэгэн хоёр гладиаторын дэргэд хүрч ирээд:

-Та хоёрын хэний чинь Спартак гэдэг вэ? гэж асуулаа.

-Би байна гэж Спартак хэлжээ.

-Чиний охин дүү Мирца энэ шөнө хамгийн нам гүм байх үед чамайг Валериягийн байранд хүлээж байна. Тэгээд чамтай хойшлуулшгүй хэрэг ажлын тухай ярилцах хэрэгтэй гэнэ гэлээ.

-За би очно гэв.

Нөгөө боолын буцаж явахад, хоёр гладиатор цаашаа явж удалгүй Палатины гүвээний цаагуур далд орлоо.

## КАТИЛИНЫН НАЙРЫН ТАНХИМ, ВАЛЕРИЯГИЙН ЗОЧИД ХҮЛЭЭН АВАХ ӨРӨӨ ХОЁР.

Палатин хэмээх толгойн овгор дээр барьсан Катилинын байшин тэр үед Ромын хамгийн том сайхан байшингийн нэг нь байсан бөгөөд дараа тавин жилийн уран илтгэгч Гортензийн байшинтай хамт Августын байшингийн тоонд багтаж орсон билээ. Уг байшин, дотор талдаа тэр үеийн анхны патрицуудын орон байрнаас дутахгүй тохилог сайхан юмсанжээ. Тэр өдрийн үдэш Катилина нөхөдтэйгөө хамт орон дээрээ налайж хэвтээд найрлаж байсан найрын танхим нь Ромдоо хамгийн баян гоё сайхан танхимын нэг байжээ.

Тэр гонзгой дөрвөлжин уудам их танхимыг гиволийн гантигаар хийсэн зургаан багана дундуурнь тасалсан бөгөөд линхуа, саргай цэцгийн хэлхээгээр чимэглэсэн багануудаас сайхан үнэр анхилна.

Танхимын ханаа, багана, цэцгийн хэлхээнүүдийн дунд хосгүй уран чадварлаг хийсэн боловч ичиж зовох ёсыг алдсан гантиг баримлууд тавиатай ажээ.

Зүймэл шал дээр нь усан дагина, дарсны ба тариалангий сахиусууд бүжиглэж багааг дүрсэлжээ. Тэд нарыг зуруучин санаанаасаа сэдэвлэн зурсан бүдүүн хадуун бие харуулан элдэв бузар бүжиг хийж хэлхэлдэж байгаа үзэгдэнэ.

Танхимын гол дунд үнэхээр сайхан гантигаар хийсэн дугуй ширээний дэргэд хоол идэх үед суух өдөн дэвсгэр, гал улаан өнгийн нарийн эдээр хийсэн бүтээлэгтэй өндөр том гэгчийн гурван хүрэл ор тавьжээ.

Уран хийцтэй алтан мөнгөн дэнлүүнүүд таазнаас дорогш унжиж, танхимыг гэрэлтүүлэхээр барахгүй, харин согтууруулан бодол санааг талимааруулан тогтоох сайхан үнэр анхилуулна.

Хананы дэргэд цэцэг навч, хээ угалз гарган онцгой уран гараар бүтээсэн гурван хүрэл шүүгээ тавьсан бөгөөд дотор нь янз бүрийн хэлбэр хэмжээтэй мөнгөн сав суулга хийжээ. Үнэтэй чулуу, сувд зэргээр сүрхий гоё чимэглэн эфиоп хүнийг дүрсэлсэн хорин жижиг хүрэл баримлыг лааны мөнгөн тавиур бариулан зогсоосон бөгөөд лааны нь гэрэл танхимын нийт гэрлийг улам их болгоно.

Хоолны орон дээр Катилина, Курион хожим ардын шүүгч болсон цочмог түргэн зантай залуу эр Луций Бестия, 691 оны хуйвалдаанд Катилинатай хамт оролцож байгаад дараа нь Цицеронтой цг консулын алба хааж явсан бөгөөд олиггүй дорой зантай өр ширд баригдсан залуу патриций Кай Антоний нар улаан өнгийн дэр тохойлдон, шанаагаа тулж, залхуухүрсэн байртай налайж хэвтэнэ. Цицероны хүч чармайлтын ачаар Кай Антоний хамтран зүтгэгч агсан Катилиныг тэр жил устгасан гэдэг. Өрнөөс гарахаа больсон завхай патриций Луций Кальпурий Пизон Цезоний бас энд байцлаа. Энэ хүн 691 онд Катилиныг аварч чадаагүй боловч 696 онд консул болж Цицероныг цөлж Катилинын өмнөөс өшөө авах заяатай байжээ.

Пизонийн дэргэд хацартаа энгэсэг тавьж, үсээ буржийлгаж үнэртэй ус түрхсэн үрчгэрдүү хацартай боловч хүүхэмсэг цэвэрхэн, царайтай хэзээд согтуу хүн шиг сөөнгө дуутай явдаг хориод насны хүн хэвтэнэ. Тэр бол Катилинын хамгийн дотно нөхөр бөгөөд хожим 696 онд консул болж Цицероныг хөөн зайлуулах хэрэгтэй ПИзонтой хамт сүрхий дэмжлэг үзүүлсэн Авл Габиний Напот гэгч хүн ажээ.

Габинийг эрхэм суудалд суулгасан тул хоолны газар руу орох үүдний баруун гар дахь том орон дээр хэвтэж байлаа. Ингэхлээр энэ хүн нойрын ноён нь байжээ.

Түүний дэргэд өөр нэгэн орон дээр шалиг завхайн хувьд бусдаасаа дутахгүй бас нэгэн залуу патриций хэвтэж байсан нь Корнелий Лентул Сура гэгч бяр ихтэй эрэлхэг эр ажээ. Катилинын бослогод гар бие оролцон багагүй үүрэг гүйцэтгэх ёстой байсан энэ хүн бослого эхлэх тэр өдрийн өмнөхөн 691 онд шоронд Цицероны тушаалаар багалзуурдагдан алагдсан юм. Сурагийн дэргэд омгорхуу зоригтой залхуу эр харагдана. Эгнээний адагт Кай Веррес гэдэг ямбанд дуртай, ширүүн догшин авиртай сүрхий шунахай зантай хүн хэвтэж байна.

Энд уригдаж ирсэн хүмүүс бүгдээрээ цаас шиг цагаан өнгөтэй нарийн ноосоор хийсэн ёслолынхувцастай бөгөөд толгойгоо саргай, лавр, мөлхөгч цэцгүүдээр хийсэн хэлхээгээр орложээ.

Катилинын найз нөхөд түүний зочлон дайлсан нарийн хоолыг идэж дуусж байлаа. Есөн патрицийн хөгжүүн яриа, гар хурууны хөдөлгөөн, ичгүүртэй шалиг завхай үг, аяга шаазангийн тачигнах дуу, хөгжилтэй хүүрнэлдээн нь Катилинын тогооч, архи аягалагч нарын эрхэм сайхан чанарыг лавтай гэрчилнэ.

Сенатын түшмэл Курион дэргэдээ ойр байсан архи аягалагч нэгэн хүнд агаа сарвайн согтуурч сөөсөн дуугаар:

-Надад Фалерны дарс хийгээд аль би Катилинын баян өргөөгий нь магтъя, харамч муу Красс хамаг баялгийнхаа хамт тэсрэг гэж хашгирна.

-Красс!… Красс!… миний санааг зовоож, сэтгэл бодолд минь шингэж, шөнийн зүүд болсон хүн чинь тэр дээ! гэж Кай Веррес санаа алдан хэлжээ.

Авл Габиний чадалтай гэгч буржийлган, үнэртэй ус түрхсэн үсээ цагаахан гараараа засаж хөршийнхөө зүг туршингуй байрын харцаар ёстой харж:

-Түүний тоо томшгүй их баялаг чиний амар заяаг үзүүлэхгүй байна уу, хөөрхий Веррес минь? гэж асуулаа.

Веррес санаа алдан:

-Тэгш эрх олох өдөр байхгүй гэж үү дээ? гэж дуу алдав.

-Өнөө тэнэг Грекүүд, бас нөгөө маанаг дрүз нар плебейчүүдэд газар хуваж өгөх гэж хотынхныг босгохдоо юу бодож байсныг би үнэхээр мэдэхгүй юм. Тэр нар хөөрхий патрицуудын тухай огтхон ч бодсонгүй байна шүү. Банкийн ховдог шунахай эзэд манай эзэмшлийн газрын орлогыг залгиж байхад аргагүй зүгээр сууж байх үйлтэй биднээс өөр дорой заяатай хэн байнаа? Хэн байна? Бидэн

зээлдүүлсэн мөнгөнийхөө хүүг авах нэрийдлээр уг өрийг төлөх хугацаа яагаа ч үгүй бахад тэд бидний орлогыг хураагаадавч байна  гэж Кай Антоний хэлэв.

Луций Бестия шүдээ ярзайлган саяхан уусан дарсныхаа аягыг чичигнэсэн гараараа атгаж:

-Хүний үнэргүй эцэг өвгөдийн харамч сэтгэл бүхнээс хүчтэй хууль ёсны харгаагаар насныхаа шилдэг сайхан үеийг биелэгдэшгүй санаа санан зовж, ядуу зүдүү өнгөрүүлэх үйлтэй биднээс ядуу хүн хэн байна? гэж нэмж хэлэв.

Элэг доог болох гэж л патриций болж төрсөн бөгөөд хэргэм цолныхоо л ачаар энгийхн ард олон хүндэтгэлийг хүлээсэн биднээс ядуу хэн байна? гэж Лентул Сура их л гунигтай хэлэв.

-Бид ч тога өмссөн навсгарууд шүү дээ!

-Бид гоёлын улаан хувцастай боловч эрхгүй улс!

-Бид Ромын Бүгд Найрамдах баян улсын найрт суух байргүй дарлагдсан гуйланчид!

-Мөнгө хүүлэгчид-банкны эзэд сөнөтүгэй!

-Арван хоёр хүрдийн бүх хууль тамд унатугай!

-Шүүгчдийн тунхаглал ч мөн тийшээ тонилог!

-Эцэг өвгөдийн засаг төрийг Эреб рүү тонилгоё!

-Аянгын эзэн Юпитерийн хүчтэй аянга сенатыг ниргэж үнсэн товрог болгог!

-Харин Юпитер ниргэх өдрөө надад л урьдаас дуулгаасай би тэр өдөр нь сенатад очихгүй! гэж бүр согтуурсан Курион там тум дуугарав.

Архичны суут мэргэн үгэнд бүгдээрээ нир хийтэл инээлдэн хараал зүхэл төгсгөл болжээ.

Энэ үед хоолны танхимд орж ирсэн боол гэрийн эзний дэргэд ирж чихэнд нь хэдэн үг шивнэн хэлсэнд: Катилина баяртай царай гарган:

-Тамын эздийн нэрийг дуудан ам алдъя! Ашгүй сая нэг ирэв үү. Түүнийг дагуулж ирсэн сүүдрийн нь хамт нааш нь шалавхан оруул! Гэж  өндөр дуугаар хэлэв.

Боол мэхэсхийн ёслоод эргэж явах гэтэл, Катилина түүнийг түр саатуулан:

-Тэдэнд бүрэн хүндэтгэл үзүүл. Хөлий нь угааж тос түрхэж өгөөд ёслолын хувцас өмсгөж, мөн цэцгийн хэлхээ өгөөрэй гэж нэмж хэлжээ.

Боол мэхийн ёслоод гарч одлоо.

Дараа нь  Катилина найрын танхимын эрхлэгчийг дуудан:

-Эпафор, ширээн дээрээс найрын үлдэгдлийг шалавхан цэвэрлээд ирэх хоёр зочинд гол байрны урдаас харуулан хоёр бандан бэлд. Хөдөлгөөнчид, хөгжимчид болоод боолчуудыг энэ танхимаас зайлуулан, тэгэх хоорондоо зэргэлдээ өрөөнд удтал хөгжилдөн тавтай найрлахад хэрэгтэй бүхнийг бэлд гэлээ.

Хоолны танхимыг цэвэрлэж байх үед мөнгөн аяганд хоосорч байгаа тавин жил даршлагдсан фалерныг дарсыг чимээгүй ууж шинэ тутам ирэх зочдыгилт сонирхон тэсвэр алдан хүлээж суулаа. Удалгүй хоол идэх ёслолын цагаан тога өмсөж, саргай цэцгийн хэлхээг толг%ой дээрээ тавьсан зочид нэгэн боол дагасаар орж ирлээ.

Эдгээр нь Спартак, Крикс хоёр билээ.

-Энэ байшин, энд байгаа сайн удамт зочдыг тэнгэр ивээх болтугай! Гэж Спартак өрөөнд орж ирэнгүүтээ хэлэхэд Крикс:

-Бүгдээрэнд баяр хүргэе гэлээ.

-Нэн зоригт Спартак чиний болоод найз нөхрийн чинь алдар бадрах болтугай! Гэж Катилина хариу хэлээд рудиарий гладиатор хоёрын өөдөөс босож очоод Спартакийн гараас хөтөлж өөрийнхөө сууж байсан байранд суулгаж Криксийг хүндэт суурийн урдаас харуулан тавьсан бандангийн нэгэн дээр суулгаж, өөрөө нөгөө дээр нь түүнтэй зэрэгцэн суулаа.

-За Спартак чи энэ оройг энэ сайхан удамт эрэлхэг зоригтой, залуучуудтай хамт миний ширээний ард өнгөрүүлэхгүй гээ юү? Гэж Катилина хэлээд зочдыг заажээ.

-Өнгөрүүлэхгүй гээ юү гэнээ? Би амжсангүй. Катилина минь. Хэрэв чиний хамгаалагч мини өгсөн даалгаврыг ёсчлон биелүүлсэн л бол би чамд тэр тухай урьдчилан хэлсн юмсан.

-Тиймээ чамайг оройн хоолон дээр ирж амжихгүй гэдгийг надад хэлсэн.

-Миний ирж амжаагүй шалтгааныг чи мэдээгүй биз. Чиний хаалгачийн үнэнчийг мэдэхгүй болохоор тэр шалтгааныг мэдэгдэж чадсангүй. Гладиаторуудын очдог нэгэн хоолны газарт очиж тэр хөөрхий улсад нөлөө ихтэй хүмүүстэй уулзах хэрэг надад тохиолдлоо.

-За тэгээд гладиатор бид нар эрх чөлөөгөө олох тухай бодож эрх мэдлийнхээ тухай ярилцан, тэр эрх мэдлийн төлөө зэр зэвсэг барих гэж байна гэсэн хэрэг үү? Гэж Луций Бестия ялихгүй ёжилсон дуугаар гэнэт асуулаа.

Спартакийн царай хувьсхийн ширээ алгадан ухасхийж босоод:

-Тийм ээ, тэгэлгүй яахав. Юпитер бурхны бүх аянгыг дуудан ам алдъя! Харин…. Гэж дуу алдсанаа гэнэт бие барьж дууныхаа ая өнгийг хувирган:

-Үүнийг дээдэс тэнгэр удамт патриций тан нар зөвшөөртүгэй. Тэгвэл бид дарлагдсан олны эрх чөлөөний төлөө зэвсэг барин босоцгооно! Гэж тайван хэлжээ.

Энэ үед халзан толгойгоо баруун зүүн тийш ганхуулан зүүрмэглэж байсан Курион:

-Наадах гладиатор чинь үхр шиг мөөрөх юмаа гэж там тум дуугарав.

-Ийм ихэмсэг зан гагцхүү зол заяат захирагч Луций Корнелий Суллад баймаар байна! гэж Кай Антоний нэмж хэллээ.

Зочдын ийм ёжилсон үг юунд хүргэж болохыг Катилина урьдаас мэдсэн тул суудлаасаа босч ингэж хэллээ.

-Агуу жавхлант сэтгэлтэйгийн хувьд эдэлбэл зохих эрх чөлөө, эрх мэдэл, хөрөнгө, өөдгүй хувь заяаны харгаагаар алдсан Ромын удамт Патриц та бүхэн сайн чанартай эрэлхэг та бүхэн, зоригтой сэтгэлий чинь би сайн мэдэх та нар минь, үнэн шударга найз нөхөд та бүхэнтэйгээ биеийн бяр тэнхээ, зориг чангын хувьд фракий язгуурт биш харин Ромын иргэн бөгөөд патриций болж төрвөл бүрэн тохирох байсан гарамгай рудиарий Спартактай танилцуулья. Энэ хүн манай цэрэгт орж тулалдаж яваад эрэлхэг зоригоо үзүүлж, иргэний тэтэм аравтын даргын цолоор шагнагдсан юм… гэлээ.

Луций Бестия Катилинын яриаг тасалж

-Гэлээ ч гэсэн аятайхан завшаан гарангуут л манай цэргээс оргосон хүн шүү дээ гэв.

Катилина нилээд хурцдан Спартакийг өмгөөлж:

-Тэглээ гээд яадаг юм! Бид нар түүний төрөлх орны нь эсрэг дайтаж байхад энэ хүн эх орон төрсөн нутаг ларыгаа хамгаалахаар биднийг орхиж явлаа гэж үүнийг буруушаах уу? Хэрэв бидний дотроос хэн нэгэн маань Митридатад оллогдон цэрэгт нь дайчлагдвал Ромын бүргэд үзэгдэнгүүт л зэрлэгчүүдийн жигшүүрт тугийг орхин нэгэн нутгийнхныхаа тугийн дор буцаж ирэхийг дурлахгүй юу?

Энэ үгийг бүгд зөвшөөрөн сайшааж шивнэлдэхэд Катилина сонсогчдын аятай сэтгэлийг ашиглаж яриагаа үргэлжлүүлэн:

-Энэ нэн их чадалтай хүн циркийн талбай дээр ялагдашгүй зориг гарган тулалдаж байхдаа гладиатор биш харин авъяаслаг жижны бүтээлээр гавъяа байгуулсныг та бид нар болоод Ромынхан бүгдээрээ үзсэн. Одоогийн байр байдал хөөрхий хувь заяагаа бодвол эрхэм дээд чанартай энэ хүн маш хүнд бэрхшээлтэй гэвч ариун сайхан үйл хэргийг сэдээд даруй хэдэн жил болжээ. Юу вэ гэвэл гладиаторуудын дотор нууц хуйвалдаан хийжээ. Энэ хүн ариун тангарагаараа холбоотой гладиаторуудыг үхэж зовох зовлонд учруулж байгаа тамлагчдын эсрэг нэнэг өдөр босож эрх чөлөөтэй болгон эх оронд нь буцаах гэж бодож байгаа юм байна гээд нэгэн хэсэг дуугүй байснаа:

-Та нар ч гэсэн яг ийм л юм сэдэвлэсэнгүй бил үү? Гладиаторууд эрх чөлөөнөөс өөр юуг шаардажбайна? Бид юуг шаардаж байгаа билээ? Бид хэдхэн хүний эрхэнд байгаа нөгөөдөх засгийн эсрэг л тэмцэх гэсэн биш үү? Яагаад вэ? гэвэл манай Бүгд Найрамдах Улс тэр хэдхэн хүний дур зоригийн дор орсноос хойш тэдэнд, зөвхөн тэдэнд л хаан зарцгүй бүгдээрээ албан татвар төлж зориг төгөлдөр бусад иргэд язгууртай, язгуургүй цөмөөрөө эрх чөлөөгүй дарлагдсан хөөрхий хүмүүс нийгмийн шаар болж хувирсан билээ! гэж ярилаа.

Залуу патрифууд ам амандаа дуугаралдан нүдэнд нь хорсол хилэн өшөө авах гэсэн хомхой сэтгэд тодрон харагдав.

Катилина үгээ үргэлжлүүлэн:

-Бидний гэр орон хоосон ядуу боллоо. Гэрээс гарвал өр шир хэцүүдлээ. Одоогийн байдал гунигтай, ирээдүй маань бүр ч дорой байна. Ийм зовлонт

амьдралтай байгаад яахав? Одоо нойрноосоо сэрэх цаг болсон биш үү? Гэхэд тэнд зүүрмэглэж байсан Курион Катилинын ярины хамгийн сүүлийн үгийг сонсож, утгыг олигтой ухаж мэдсэнгүй:

-Сэрцгээе гэж сөөнгө дуугаар хэлээд нүдээ нухлав.

Хуйвалдагчид Сергий Катилинын яриаг их л анхааралтай сонсож байсан боловч Курионыг харж аргагүй инээд алджээ.

Катилина гар зангидан тэр арчаагүй архичныг зүхэн занаж:

-Архи хог хоёрын сав болсон аргагүй мунуухай чамайг Минос аваачиж хийсэн хэргийн чинь хирээр шийтгэх болтугай гэж ширүүн дуугарав.

-Хараал идсэн муу амьтан чи дуугүй унт! Гэж Бестия хашгираад Курионыг түлхэж орхисонд тэр нь орон дээрээ сунаж ойчлоо.

Катилина фалерны дарснаас хэдэн удаа яаралгүй балгаж түр чимээгүй сууснаа:

-Ингээд одоо эрхэм иргэд та нарыг энд цуглуулахын учир бол бид өөрсдийнхөө ажилд Спартак болоод түүний гладиаторуудыг татан оролцуулбал ашиг байна уу гэдгийг та нартай хамтран зөвлөх гэсэн юм. Засгийн дээд эрх, улсын сан, ширүүн хүчтэй цэргийг гартаа барьж байгаа эрхт хэдэн хүн болоод сенатын эсрэг бослогыг бид дангаар гаргавал ямар ч амжит олохгүй нь лав. Ийм учир энэ хэрэгт тохирох улс гэж бүрэн эрхтэйгээр үзэж болох тэр хүмүүсийн тусламжийг заавал эрэх хэрэгтэй болно. Бүх хөрөнгийг гартаа барьж байгаа хүмүүсин эсрэг үгээгүй хоосон хүмүүсийн хийх дайн, эздийн эсрэг боолчуудын хийх дайн, дарлагчдын эсрэг дарлагдагсдын хийх дайх бол бидний хийвэл зохих хэрэг байх ёстой. Ингэхэд энэ ажилд бид яагаад гладиаторуудыг татан оролцуулж, өөрсдөө тэднийг удирдан Ромын цэрэгт нийлүүлж эс болдог билээ. Би үүнийг ер ойлгож мэдэхгүй байна. Ингэх хэрэггү йбол надад санхрүүлэн тайлбарлаж аль. Тэгвэл бид зорьсон төлөвлөгөө хэрэг ажлаа түр хойшлуулан зохистой цагийг хүлээе гэлээ.

Катилинын ярианы дараа улсуудын шуугианыг ажиж харвал түүний үг олонхийн сананд тохирсонгүй бололтой.

Спартак гэрийн эзнийг ярьж байх үед, цугларсан хүмүүсийн сэтгэгдэхүүнийг их л хянуур ажиглан харж байсан тул царай нь хэдийгээр хувирсан боловч тогтуухан дуугаар ингэж хэллээ.

-Катилина чиний саналыг эдгээр сайн язгууртан марицууд дэмжихгүй байх гэдгийг би хэдийгээр мэдэж байсан боловч чамайг тун их хүндэтгэдэг болохоор чиний хүслийг хангах гэж би танайд ирсэн юм. Иймд та бүхэнд илэн далангүй ярьж бодсоноо илчлэхийг чи надад зөвшөөрнө үү. Бас чиний гарамгай нөхөд чинь надад зөвшөөрөл олгох бизээ. Ард түмний эсрэг зоригтой бөгөөд шинэ хүмүүсийн эсрэг зогсож байгаа засгийн эрхийг гартаа шүүрч авсан хэдхэн тооны хүмүүс эрх мэдлээрээ Ромын улсыг зуу гаруй жилийн дотор үймээн самуун, зөрчил хагарлын байдалд байлгасан тэр хэдхэн хүмүүс язгууртан гарлын чөлөөтэй иргэд та бүхнийг засгийн удирдах ажилд оролцуулахгүй

тусгаарлая та бүхэнд хөрөнгө баялаг өгөхгүй байна. Иймийн учир та нарын хийх гэж байгаа бослогын гол зорилго бол одоогийн сенатыг түлхэн унагж, одоогийн мөрдөгдөж байгаахуулийг өөрчлөн эрх мэдэл, эд хөрөнгийг жигдхэн хуваах, одоогийн хуулиудыг бодвол ард түмэнд арай ивгээлтэй хууль тогтоох, сенатын түшмэдийг өөрсдийнхөө дотроос тавих ийм зорилготой байна. Иймийн учир та нар засгийн эрхийг гартаа авсныхаа дараа, одоо засгийн эрхэд байгаа хүмүүсийн нэгэн адил, Аьпын нурууны цаадах ба далайн цаадах улс түмнийг хоцрогдсон зэрэг хүмүүс гэж үздэг хэвээр байх болно. Та нар тэдгээр ус түмнийг Ромын ноёрхолд хэвээр нь үлдээж тэднээс урьдын адил албан татвар авсаар байх болно. Та нар гэр орноо боолуудаар дүүргэж бас одоогийн адил амфитеатруудаар гладиаторуудын цуст тулалдааныг үргэлжлүүлсэн хэвээр байлгахыг хүсэх болно. Одоогийн засгийн эрх баригчдыг түлхэн унагаж тэдний орыг эзлэх та бүхэн хүнд албанаас чөлөөтэй цагаа гладиаторуудын цуст тулалдааныг үзэж биеэ амраах болно. Үүнээс өөрюуг ч та бүхэн хүсэж чадахгүй. Нэг үгээр хэлбэл та бүхний хүсэл одоогийн засгийн эрхэд байгаа хүмүүсийн оронд өөрсдийгөө оруулахыг л хүссэн хүсэл л дээ.

Дорой заяатай гладиатор бидний хүсэл бол та нарын хүслээс огт өөр юмаа. Эх орон ч үгүй, эрх чөлөө ч үгүй, бусдыг цэнгүүлэхийн тул бие биеэ цавчлан алж байх хувьтай хүн бүхний доромжлол болсон хөөрхий гладиатор бид нар бол ёстой бүрэн дүүрэн эрх чөлөөг хүснэ. Бид өөрийн гэр, өөрийн эх орноо байлдан олж авахыг хүсэж байна. Ийм ч учир засгийн эрхийг одоо барьж байгаа хүмүүсийн эсрэг тэмцэх төдий ч биш, харин Сулла Катилина Цетег, Помпей, Лентул буюу Крассын хэн нь ч байв ялгаагүй дараа засгийн эрх барих тэр хүний эсрэг тэмцэх тэмцэл болно.

Дангаараа боссон гладиатор бидэнд аймшигт Ромын ялагдашгүй их хүчийг дийлэх ямар нэгэн найдвар байна уу? Ямар ч найдвар байхгүй юмаа. Иймийн учир бослого зохиох байгууллага ч байж болохгүй нь илэрхий байна. Харин Катилина чамайг болон чиний нөхдийг бидний удирдагчид болох байхаа гэж найдаж байх үедээ бас консул болон патрицийн алдар нэрийг хүлээсэн та бүхний манай гладиаторын цэргийн хороодын удирдагчид болж, нэр хүнд, мэдлэг чадвараа дайны хэрэгт өгөх байх гэж найдаж байх үедээ бол өөрийнхөө ба өөртэйгээ адил дорой заяатай нөхдийнхөө найдварыг сэргээж байсан юм. Та нар хүмүүжил хүсэл бишрэлийн шалтгаанаар бидний удирдагчид хэзээ ч болохгүй нь гэдгийг ойлгож мэдсэний дараа одоо хүртэл сэтгэлдээ бодож, энхрийлж явсан тэр бодол хүсэл минь хэзээ ч бүтэхгүй хэрэг байжээ гэдгийг би ойлгож мэдлээ. Ингээд би үүнээс урагш хүсэж явсан тэр хүслээ их тэнэг хүсэл байжээ гэж үзэж, хэдийгээр харамсалтай байгаа боловч үүрд орхилоо. Бид тав арван мянган глаиаторуудыг босгож чөдлөө ч гэсэн энэ бослогыг тэнэг хэрэг гэж үзэхээс өөр юу гэж зэх вэ? Би буюу бидний ангийн өөр нэгэн хэн боловч ямар нэг хүнд, ямар ач холбогдолтой баж болох билээ. Одоогоос хорин жилийн өмнө Миндуций буюу Веций нэртэй Ромын морин

цэргийн гарамгай нэгэн эрийн Капуя хотын дэргэд цуглуулсан хэдэн мянган гладиаторуудын бослого арван тавхан хоногийн дотор бут ниргэгдсэнтэй адил, манай тэр хоёр легион цэрэг бут ниргэгдэх болно гэлээ.

Энд цугларсан зочдын бодлоор, хамгийн зэрлэг бүдүүлэг гэж тооцогдох Спартакийн энэ үг тэдний дотор ямар сэтгэгдэхүүн төрүүлснийг мэдэх арга алгаа. Гэвч зарим нэгэн нь Спартакийн ярианы уран чадварыг гайхаж, бас нөгөө зарим нь түүний агуу өндөр сэтгэл, бусад нь түүний улс төрийн онолын гүн гүнзгийг гайхан бодоцгоож нийтдээ бүхнийг ялгуусан Ромын их нэрийг хүндэтгэн Спартакийн хэлсэн үгэнд сэтгэл их л ханамжтай хоцорчээ. Ромын ихэмсэг бардам зантай тэд боол агсан Спартакаас эвий нь олж аятахан дайрсан үгийн үнэн санааг ойлголгүй харин Ромынхныг үнэхээр хүндэтгэн магтлаа гэж бодож фраки язгуурын зоригт эр Спартакийг илт магтан сайшааж Луций Бестиягаас эхлэн бүгдээр Спартакийг дэмжин туслаж, түүнтэй нөхөрсөг харилцаатай байх тухай илэрхийлцгээжээ.

Энэ асуудлыг их л удаан шийдвэрлэн янз бүрийн санал гаргаж зөвлөсний дараа уг ажлыг зохистой өдрийг хүртэл хойшлуулан, ирэх цагаас эрхэм сайн зөвлөгөөнийг хүлээх, энэ төлөвлөгөөг биелүүлэх явдалд их Фортунаас сайн өршөөлөө соёрхох тэр өдрийг хүлээхээр шийдлээ.

Би болон надад итгэж, намайг хүндэтгэдэг цөөн тооны гладиатор бид Катилина болон түүний нөхдөд туслахад бэлхэн байна гэж хэлэхдээ цөөн тооны гладиатор гэдэг үгийг онц тодруулан хэлж өглөө.

Нөхөрлөлийн билэг тэмдэг болгон жороо дугарааны хундага бүгдийг дэмжин эргэж, зочид титмийнхээ саргай цэцгийн дэлбээг таслан авч тэр хундган дотор хийж байлаа.

Спартак энэ жороо хундаганаас өөрөө ууж мөн Криксийнхээ уусны дараа гэрийн эзэн ба түүний зочидтой салах ёсоо гүйцэтгэж Криксийгээ дагуулан патрицийн гэрээс гарч Суллын гэрийг чиглэн явлаа.

Крикс эхлэн дуугарч:

-Саяны ярианы учрыг надад хэлж өгөхгүй юу? гэхэд

-Геркулесийн төлөө чи минь дуугүй байгаач! Хожим чи бүгдийг ойлгоноо гэж Спартак нам дуугаар түүнийг хорьж огсоолоо.

Хоёулаа гурван зуу гаруй алхам газар нам гүм явснаа Спартак галл нөхөр Криксдээ хандаж бас зүг бүхнээ болгоомжлон харсны дараа:

-Тэнд хэтэрхий олон хүн байлаа, зарим нь манай талын хүмүүс ч биш бололтойн дээр согтууран ухаан балар болсон хүмүүс ч мөн олон байлаа. Ийм болохоор тэр залуу хүмүүст итгэж болохгүй балаа. Чи өөрөө сонссон шүү дээ. Хуйвалдааны тухай саяын бидний яриаг эрүүл бус хүний чалчсан үг мэтээр тэд бүрмөсөн мартах болно. Чи одоо Акционы сургуулийн гладиаторууд дээр очиж мэндлэх, гар барих зэрэгт хэрэглэдэг нууц тэмдгээ өөрчлөх тухай мэдэгд “гэгээн гэрэл, эрх чөлөө” гэдэг нууц үгийг “тогтвор ялалт” гэдэг үгээр соль. Даруй даруйхан гурван удаа гар атгах дохио бол үүнээс хойш манай дохио тэмдэг биш,

харин гарын алган дээр гурван удаа дарах тэмдэг бол манай тэмдэг болог гэж цаадуулдаа хэл гээд Спартак Криксийн баруун гарыг барьж долоовор хуруугаараа алган дээр нь гурван удаа дарж:

-Ингэж мэдэв үү? Гэхэд

-Мэдлээ гэж Крикс хариулжээ.

-Чи одоо яв, цагаа дэмий бүү өнгөрүүл. Бушуу явж хэсгийн дарга бүрд тус бүрийнхээ таван гладиаторт таниулан хэлж өг гэдгийг сайтар хэлж өгөх хэрэгтэй. Бас бидний хэрэг ажил илрэх шахсан гэдгийг тэд нарт таниулан хэлж өг. Хэрэв манайхны хэн нэгэн хүнээс урьдынхаа дохио тэмдэг, нууц үгийг хэвээр хэрэглэхэд хүрвэл бидний зорьсон хэргийг аюултай болгохоор ч барахгүй манай осолтой санаачлагыг гүйцэтгэхээр оролдох ч нөхцөлгүй болгоно гэдгийг бас хэлж өгөх хэрэгтэй. Маргааш өглөө Юлий Рабецийн сургууль дээр уулзъя гээд Спартак Криксийн гарыг барьж явуулаад өөр Суллын байшингийн зүг хурдлан явж одлоо.

Хаалгы нь тогши дуудсанд Спартакийг дотогш нь оруулан дүүгийн нь байдаг ббяцхан тасалгаанд дагуулан оруулж өглөө. Энэ завсар эзэн аьвхайн итгэл талархлыг олсон Мирца Валериягийн хувцасны эрхлэгчийн чухал албан үүрэг гүйцэтгэх болсон байжээ.

Сэтгэл зовон хүлээж байсан Мирца ахыгаа орж иэрэхэд тосож очоод хүзүүгээр нь тэврэн нүүрий нь олон үнсжээ.

-Надаа олон удаа лавлан асууж чиний тухай ихэд сонирхдог миний эзэн авхай –Валерия надад тушаагаагүйсэн бол өдий орой болсон хойно би чамайг энд урьд ирүүлэхгүй байсан билээ гэж Мирца их л баягалантай царайгаар ахдаа хэлээд: Бас манай эзэн авхай чамайг ямар нэгэн ажилд ороогүй байгааг мэдэж Кумы дахь зуслангийнхаа байранд Суллын саяхан байгуулсан гладиаторын сургуулийг захируулахаар өөртэй чинь ярилцах гэж энэ орой чамайг энд урьж ирүүл гэж надад тушаасан юм гэлээ.

Мирцагийн энэ үгийг сонсож Спартакийн баярласныг өгүүлэхэд бэрхээ. Санаандаа орсон элдэв бодлыг биенээсээ холдуулахыг хүчилсэн мэт толгой санжуулан бодол болно.

-Хэрэв би тэр гладиаторын нь жижиг сургуулийн захирал болохыг зөвшөөрвөл Валерия авхай намайг биеэ дахин худалдахыг шаарддаг болов уу? Аль чөлөөтэй хэвээр минь байлагдаг болов уу? гэж дүүгээсээ дэмий л асууна.

-Миний эзэн авхай энэ тухай надад юу ч хэлсэнгүй гэвч тэрнь чөамайг их л талархан үздэг учир чөлөөтэй хэвээр чинь үлдээхийг зөвшөөрөх байлгүй гэж Мирца хариулав.

-Тэгвэл тэр Валерия чинь их л сайн хүн байх нээ гэж ахыхаа хэлэхэд

-Манай эзэн авхай бол үзэсгэлэнт гоо сайхантайгаа адил үнэхээр хосгүй сайн хүн юм шүү гэлээ.

-Тэгвэл түүний тунсаг сайн чанар нь хэмжээ хязгааргүй юмаа.

-Чи Валерия авхайд хүчтэй дурласан бололтой надад санагдаж байна гэж Мирцагийн хэлэхэд:

-Би юу? Над шиг дорой бадалтай хүн, төдий их алдартай авхайд хандаж болох сайн ивгээл ерөөлөө дэвшүүлэн шүтэж хүндлэх асах их дурлалаар би түүнд дурладаг юм гэлээ.

-Тэгвэл чи сонсож бай… энэ тухай валерия авхай ганц ч үгүй цухуйлгахгүй гэдгээ чи тангарагла! Учир нь энэ тухай намайг чамд битгий хэлээрэй гэж маш чангалан хориглосон юм, юу вэ гэвэл чамд төдий л их энэрэл өршөөлийг үзүүлсэн Валерия авхайн ачийг хариулан түүнд энэрэнгүй сэтгэлийнхээ дурлалыг өргөн дэвшүүлэхийг чамд тэнгэр дээдэс заажээ. Учир нь тэр өдөр циркт чамайг чөлөөтэй хүн болгон суллуулахыг гагцхүү Валерия Суллыг ятган зөвшөөрүүлсэн юм гэлээ.

Спартак палхийтэл цочиж царай нь цагаан болж:

-Юу гэнээ? Энэ авхай юу? Үнэн гэж үү? Гэлээ.

-Үнэн, үнэн… харин энэ тухай мэдсэн гэдгээ түүнд хэрхэвч мэдэгдэж болохгүй шүү гэж Мирци давтан хүсчээ.

Спартак толгойгоо тонгойлгон юм бодож суулаа.

-Чиний ирсэн тухай Валерия авхайд мэдэгдэхээр би одоо явлаа. Хүлээ навахыг зөвшөөрмөгц чамайг дагуулан оруулж өгнөө гээд дэнгийн эрвээхий шиг хөнгөн Мирца охин бяцхан халгаар гарч явлаа.

Лдвийг бодож байсан Спартак дүүгийнхэ гарч явахыг ч мэдсэнгүй.

Спартак дүүтэйгээ уулзах гэж Суллын ордон руу очиж явах замдаа Валерийг анх харж билээ. Тэгэхд Валерия гэрээсээ гарч жууз руугаа очиж явсан юм. Тэр цагаас хойш даруй сархагас болжээ.

Тэгэхэд Валериягийн цаган царай, гялалзсан том хар нүд, хав хар үс нь Спартакийн сэтгэлд гал цахилгаан мэт хүчтэй сэтгэгдэл төрүүлж билээ. Тэгэхэд Спартак ямар учраас юм бүү мэд Валерияд маш их стгэлтэй болсон юм. Охин тэнгэр шиг энэ сайхан авгайн хувцасны сэжүүрийг боловч үнсэж болох бол уу гэж найдах найдвар хүртэл хамгийн зоригтой найдвар шиг санагаж байсан юм.

Тэр үед Спартак Валерия хоёрын завсар хүний нүдэнд үл үзэгдэх цахилгаан гүйдэл харвасан бизээ. Хэдийгээр Валерия авхай удам гарал, одоогийн байдлын хувьд бие барих ёстой боловч гладиаторын сэтгэлтэй адил ихэд хөдөлсөн нь илэрхий байсан юм. Анхандаа фракий нутгийн эр, өөрийн цээжингд дүрэлзэн шатсан дурлалыг замхруулан тараахыг оролдсон юм.

Учир нь энэ дурлал бол огт биеллээ олж чадахгүйгээр ч барахгүй юутай ч зэрэгцүлэн тэнцүүлшгүй тэнэг хэрэг мэт байжээ. Түүний дурлах сэтгэл бол ухаан солиорсон хүний дурлал, тэр дурлалын өмнө давагдашгүй даваа тохиолдох нь зайлшгүй байсан юм. Олон зүйлийг сэтгэлчилсэн Спартакийн зүрхэнд энэ авхай улам бүр суурьтай оршсоор дараа түүнийг дангаар ноёрхох болсох юм.

Заримдаа Спартак ямар нэгэн далдын хүчинд автагдсан юм шиг өөрийн эрхгүй яван явсаар Суллын ордны жигүүрийн багануудын дэргэд хүрч ирээд, Валериягийн гарч ирэх цагийг хүлэн ширтдэг болсон юм. Ингэж Спартак тэр авхайг өөрт нь мэдэгдэлгүйгээр далдаас олон удаа харсан юм. Харах бүрд нь тэр улам сайхан санагддаг болсон юм. Нэг өдөр ингэж харж байтал нь Валерия Спартакийг харчихсан юм. Тэгэхэд нь нусаа татаж, царай нь цав цагаан болсон Спартакт Валериягийн харц их л талархалтай, их л уяхан хонгор мэт бодогдож намайг Валерия дурласан нүдээр харлаа гэж саналаа. Үгүй тийм байж болохгүй, энэ бол түүнийг хэтэрхий мөрөөдсөн миний сэтгэлийн хий үзэгдэл биз. Энэ мэтээр хэтэрхий мөрөөдвөл би солиотой болох нь байна гэж бодсон юм.

Иймд Мирцагийн хэлсэн тэр үг хөөрхий СПартакийн дотор ямар сахйан сэтгэгдэл төрүүлснийг мэдэхэд хялбар байна.

Тэнгэрийн дагина мэт энэ сайхан авхайд, Спартак бүх амьдрал, бүлээн цус, алдар гавъяагаа бүрэн зориулахад бэлэн байсан юм. Одоо Спартак Суллын ордон дотор тэр авхайгаас хэдхэн алхам зайтай байжээ. Спартак одоохон Валериягийн дэргэд очно. Хүнгүй газар хоёулхан ч уулзаж юуны магад, тэгэхэд Валериягийн нүүр царай саөхан, нүд мишилзэн инээмсэглэхий нь харж магадгүй, түүнийинээмсэглэхийг Спартак огт харагүй билээ. Бодвол тэр сайхан хүүхний инээмсэглэж байгаа нь хаврын тэнгэрийн хаяа мэт байх ёстой

Хүсэж мөрөөдөх нь байтугай сэтгэл нь багтаж боломнүй тэр их хувь заяанд хүрэх цагаас Спартакийг хэдхэн хормын хугацаа зааглаж байжээ… юу болж байгаа нь энэ вэ? Хэтэрхий дурлалынхий сэтгэлийн сүүсмэлзэн үзэгдэх дүрсүүдийн дунд, амтат хүслийн мананд өөрийн эрхгүй автагдаж байна уу?… аль ухаа минь солиорч эхлэв үү?… эсвэл хөөрхий амьтан би аль хэдийн галзуурсан байна уу?….

Энэ мэт зүйл санхагдан Спартак пал хийтэл цочиж сандран нүдээ эргүлэн харж охин дүүгэ эрсэнд тэр нь дэргэд нь байсангүй.

Хагартал цохилж байсан шанааныхаа судлыг тогтоох, толгойдоо манарч байсан бодлыг тархаан сарниулах гэсэн мэт гараараа духаа барилан:

-Ээ, тэнгэр минь, намайг ухаан солиорон галзуурахад бүү хүргээч гэж дөнгөж сонсогдох төдий дуугар аман дотроо шивнэн хэлжээ.

Спартакийн дотор аажмаар онгойж хаана байгаагаа мэдэрч эхлэв.

Түүний байсан газар нь дүүгийн нь өрөө бйжээ. Хананы дэргэд алтан борозоор будсан хоёр бандан харагдана. Асаасан бамбар аманд нь зуулган ногоон өнгийн шавраар хийсэн гүрвэл-дэнлүү тасалгааг гэрэлтүүлжээ.

Ухаан нь орж байсан боловч бас л тээнэгэлзэж байсан Спартак ухаан минь солиоров уу, аль хэтэрхий хүсэлд автагдав уу гэдэгт итгэхгүй зүүн гарынхаа долоовор хурууг дэнлүүний асаж байсан галт хүргэж үзсэнд өвчлөх мэдрэлтэй байсан учир унтаагүй сэрүүн байна гэдгээ ойлгож мэдлээ.

Спартак буцаж байсан цусаа чанга зоригоороо тогтоон номхтгож, сэтгэл мэдрэлээ бүрэн эргүүлэхийг оролжээ. Аажмаар санасандаа хүрч сэтгэлийнхээ

дөлийг номхотгож чөдлөө. Хэдэн минутын дараа Мирца эргэж ирээд ахыгаа Валериягийн зочид хүлээн авах тасалгаанд хүргэж өгөхөөр дуудлаа. Спартак энэ мэдээг нилээд даруу тогтуун хүлээж авсан боловч нүүр нь үхсэн хүний царай шиг хувхай цагаан болсон байлаа.

-Үүний нь Мирца харж сэтгэл нь зовж:

-Спартак минь чи яав?… бие чинь муу байна уу? гэж асуулаа.

-Зүгээр, үгээр… миний бие одоогийнхоос илүү сайн хэзээ ч байсангүй билээ гэж Рудиарий хариуллаа.

Дүүгээрээ хүргүүлэн, байсан өрөөөөсөө доош нарийн шатаар /ромын боолчууд эзнийхээ байшингийн дээд давхарт байрладаг заншилтай байжээ/ бууж Валериягийн хүлээж байсан зочид хүлээн авахтасалгаанд очихоор явлаа.

Ромын язгууртан авхайчуудын бусдаас тусгаарлан ном унших мөн ойр дотно нөхөдтэйгөө уулзаж сэтгэлийнхээ үг ярилцдаг өрөөг хүлэн авах өрөө гэж нэрлэдэг байжээ.

Валериягийн өвлийн байран дахь “Патрицууд жилийн дөрвөн улирлын тоогоор дөрвөн тусгай байр ордонтой байдаг байжээ” хүлээн авах тасалгаа нь их л гоё тохилог боловч бяцхан тасаг байлаа. Гөлмөн төмрөөр хийсэн хэдэн яндан тасагаан дотор дулаан илчийг тараана. Гадаа хэдийчинээ хүйтэн байх тутам яндангаас гарах дулан илч төдийчинээ сайхан санагдана. Дулааны илчийг тараах яндангууд нь тасалгааны бүх ханыг бүрхэж байгаа хөшгийг уран нугалааны цаагуур эвтэйхэн далдажээ. Цэнхэр өнгийн үнэтэй торгон эдээр уран гоё нугалаа атираа гаргаж хийсэн хөшгөө таазнаас эхлэн бараг шал хүртэл ханын дотуур унжиж түүний дээгүүр мөн үнэтэй нарийн сиймхий эдээр бүрхсэн нь тасалгааны таазан талыг хөвөн цагаан үүл бүрхсэн мэт болгожээ. Бас тасалгааны хөшгөн дээгүүр үй олноор нь тогтоон чимэглэсэн шинэхэн сартай цэцгүүдээс маш сайхан үнэр анхилж байлаа.

Грекийн урчуудын бүтээсэн сартай цэцгийг дууриалган алтаархийсэн гурван салаатай дэнлүү таазнаас унжина. Дэнлүүний гэрэл цэнхэр өнгийн бүдэг гэрлээр тасалгааг гэрэлтүүлнэ. Дэнлүүний тосонд хольсон арабын нарийн үнэртнээс тасалгаан дотор сайхан үнэр тархжээ.

Дорнодын байдлаар сайхан зассан энэ тасалгаанд цэнхэр ба цагаан өнгийн нарийн торгоор бүрхсн өдөн зөөлөвчтэй нэгэн түшлэгтэй ор, мөн ийм маягаар зөөлөвчлөн хийсэн хэдэн бандан, дөрвөн нүдтэй бөгөөд нүд бүрийн нүүрэн талд Суллын дөрвөн ялалтыг сийлбэрлэн урлаж хийсэн, маш үнэтэй намхан мөнгөн шүүгээ эдгээрээс өөр зүйл байсангүй.

Анхилам үнэр дүүрсэн, нам гүм, тусгаар энэ тасалгааны нэгэн зөөлөн бандар дээр цэнхэр эдээр эмжсэн цас шиг цагаан ноосон хувцастай сайхан Валерия авхай үүр шөнийн завсар сууж байлаа. Валериягийн дал мөр ба гар нь зааны яс мэт дун цагаан өнгөтэй бөгөөд барагнүцгэн байгаа цээжин биеий нь сүлбилгүй задгай орхисон өтгөн хар гэзэг нь нөмөрчээ. Валерия зөөлөн жинтүүн

дээр тохойлдон цас шиг цагаан өнгөтэй бөгөөд хүүхдийн гар шиг жижигхэн гараараа шанаагаа тулж байжээ.

Бяцхан нээлттэй нүдээр нэгэн зүг ширтэн огт хөдөлгөөнгүй сууж байсан тэр авхайг харахад зүүрмэглэж байна уу гэмээр байлаа. Бодвол түүний дотор хөөрцөглөж байсан үй түмэн амттай сайхан бодол хүсэлдээ нэгмөсөн автагдан дуниарч орчин тойронд болж байсан зүйлийг огтхон ч ухаарахгүй байсан нь тэр бизээ. Мирца Спартакийг дагуулан орохдоо гаргасан хаалганы чимээгээр Валерия огтхон ч хөдөлсөнгүйн дээр бас боол бүсгүйн эргэж гарахдаа нээсэн хаалганы чимээгээр ч мөн хөдөлсөнгүй, урьдын байдлаар нам гум суусаар байлаа.

Спартак гайхамшигтай сайхан язгууртан авхайг харж, дуугарах ч тэнхээгүй, нэгэн газартаа хадагдан зогсож, царай нь пароссын гантиг шиг цав цаган болж зүрх нь цэжиндээ багтаж ядан цохилж, сэтгэл санаа нь урьд үзэгдээгүй хэмжээгээр үймэн сандарч, галын дөл мэт хурц харцаар тэр сайхан авхайг ширтэн зогсож байлаа.

Спартак ийм байдалтай хэдэн минут зогсчээ. Хэрэв Валерия анхааран сонссон бол Спартакийн зүрх хэтэрхий цохилон амьсгал нь давхцаж байсныг төвөггүй мэдэхсэн билээ.

Ингэж байтлаа хэн нэгэн хүн дуудаж Спартак энд ирээд байна гэж хэлсэн юм шиг Суллын гэргий, ямар нэгэн юмнаас цочих шиг болж бие нь зарсхийн өндийж суугаад Спартакийн зүг харж, царай нь дорхиноо улайж, бас сэтгэл ханасан байдалтай санаа алдан:

-Аа чи энд ирээд байна уу? гэж их л элгэсэг дуугаар хэллээ.Валериягийн энэ үгийг сонсож, Спартакийн нүүрэнд гал гарах мэт болж, түүний зүг нэгэн алхам дөхөж үг хэлэх гэсэн боловч юу хэлсэннь мэдэгдэхгүй авиа төдийгөөр өөр дуу гаргаж чадсангүй

Валерия биеэ барьж маш хонгор дүрээр инээмсэглэн

-Эрэлхэг Спартак чамайг тэнгэр ивгээх болтугай гэж хэлээд бандангуудын нэгэн рүү гараараа зааж, тэгээд… тэгээд суу л даа гэлээ.

Энэ удаад Спартак бүх хүч зоригоо шавхан дайчилж чивчирсэн дуугаар:

-Миний хүртвэл зохих хэмжээнээс хэтэрвэл бурхан намайг ивгээж байна охин тэнгэр Валерия минь жирийн үхэлтэн хэнд ч тохиолдоогүй нь ивгээлээр бурхад намайг ивгээж таны өршөөл энэрэл надад соёрхлоо гэлээ.

Баярын магнай тэнийж нүд нь гялалзаж байсан Валерия:

-Чи эрэлхэг зоригтойгоор барахгүй бас ивгээн талархагч хүн байна гэснээ гэнэт грек хэлээр:

-Чи олзлогдохынхоо барахгүй бас ивгээн талархагч хүн байна гэснээ тэнэг грек хэлээр:

-Чи олзлогдохынхоо өмнө орон нутагтаа байхдаа өөрийнхөө ард түмний удирдагчдын нэгэн байсан нь үнэн биз? гэлээ.

-Тиймээ би Родопсын ууланд нутгийн хамгийн хүчирхэг фракий омгийн удирагч байсан юм гэж мөн грек хэлээр аттик аялгуугаар биш боловч Александрийн аялгуугаар хариулж- би гэртэй олон сүрэн хонь үхэртэй, өгөөмөр баян бэлчээр нутагтай хүн байсан юм охин тэнгэр Валерия минь үнэмшин үү! Би баян чадалтай, хувь заяатай өглөгч сайн чанартай, үнэнч шударга зантай хүн байсан юм… гээд түр зуур зогсож гүнээ санаа алдсанаа сэтгэл ихэд хөдөлсөн байдалтай хоолой нь чичрэн:

-Тэгэхэд би харь нутгийн зэрлэг, бусдын доромжлол болсон доорд заяатай гладиатор биш байлаа гэлээ.

Энэ үгийг сонсож, өрөвдөх сэтгэл Валериягийн дотор төрж, бас дурлах сэтгэл бадран, урсгал зөөлөн урьхан хонгор харцаар рудиарийг харж:

-Би чиний охин дүүтэй олон удаа чиний тухай удтал ярилцаж байсан, чиний ер бусын зоригтойг мэднэ. Бас одоо чамтай ярилцаж үзвэл чи хэзээ ч бусдын доромжиллыг хүлээж явсангүй боловсрол хүмүүжилтэй, зан байдлын хувьд харь нутгийн зэрлэг хүнтэй адилгүй байна гэлээ.

Валериягийн маш урьхан дуугаар өгүүлсэн үг, Спартакийн сэтгэлийг хэрхэн хөдөлгөснийг өгүүлэхэд бэрх юмаа. Спартакийн сэтгэлийг хэрхэн хөдөлгөснийг өгүүлэхэд бэрх юмаа. Спартакийн нүдэн дээгүүр нулимс гүйх мэт болж, чичирсэн дуугаар:

-Энэ эрхэм сайхан сэтгэлийн үг хэлсэн ариун сэтгэлтэн бүхний дотроос хамгийн ариун сэтгэлтэй авхайтан чи сайн ивгээл хүртэх болтугай!… тэнгэр бүхний дээдэс жирийн үхэлтний дотроос гагцхүү чамайг сонгон ивгээтүгэй! Чи тэр ивгээлийг хүлээх ерөөлтэй ажээ. Чамайг хүн бүхний дотроос хамгийн заяатай хүн болгог гэлээ. Валериягийн сэтгэл бас хөдөлж түүний тунгалаг сайхан нүд нь гялалзан, амьсгал нь давхцаж байлаа.

Спартакийн тухай өгүүлбэл: тэр нь сүнс зайлах мэт болж, үг дуугүй даган бишрэх харцаар Валерияг ширтэн Аполлоны төгөлдөр хуурийн эгшиг мэт уянгат дууг сонсон дурлалын дөл бадарч байсан харцаар түүнийг шумбан ширтжээ. Галт уулын хайлмаг оргил мэт гялалзаж байсан Валериягийн нүдэнд тусч байсан талархлыг мини й бадарсан дурлалын хуурмаг үзэгдэл биз гэж үнэмшихгүй байсан боловч Валериягийн нүднээс Спартак нүд салгаж чадсангүй.

Спартакаас үгээ хэлж дүүрснээс хойш тасалгаан дотор удтал чив чимээгүй болж харин язгууртан авхай ба фракийн нутгийн р хоёрын хүнд амьсгалын чимээ нам гүмийг зөрчиж байлаа. Энэ хоёрын зүрхэн завсар нэгэн санаа нэгэн хүслийн холбоо тогтож хоёулы нь ичингүйрүүлж чимээгүй догдлон суухад хүргэжээ.

Ингэж чимээ аниргүй зүрх догдлон суух аюултай байдлаас чөлөөлөгдөх ородлогоог Валерия эхэлж:

-Чи нэгэнт чөлөөтэй хүн болох учир, жаран тооны боолчуудаас бүрдсэн сургуулийг удирдах ажлыг хүлээж авахгүй юу? Сулла Кумынхээ ордны дэргэд тэр боолчуудыг гладиаторын мэргэжилтэй болгох гэсэн юм гэлээ.

Спартак Валериягийн зүг туйлын урсгал зөөлөн бөгөөд түүний хэлсэн бүхнийг ёсчлон дагахад бэлэн байна гэж байгаа мэт харцаар харж:

-Би бүх сэтгэл зүрхээр чиний номхон боол мөн, би чиний мэдлийн хүн болох учир чиний хүссэн бүхнийг хийхэд бэлэн байна гэлээ.

Валерия нилээд хар. Спартакийн өөдөөс халз харж дуугүй суусснаа босож тасалгаан дотуур өөдөө сөөргөө хэд холхиж явснаа рудиарийн дэргэд хүрч ирээд бас удтал чимээгүй түүнийг харж байснаа:

-Спартак чи надаас нуулгүй хэлж аль, одоогоос олон хоногийн өмнө энэ байшингийн нэгэн жижүүрийн баганын ард нуугдан чи юуү хийж байсан бэ? гэж дөнгөж сонсогдом дуугаар асуулаа.

Цусаа хурааж хувхай цагаан болсон гладиаторын нүүрэнд гал асах мэт болж, үг дуугүй толгой даран зогсож, Валериягийн зүг харж, ам нээн үг хэлэхээр хоёр дахин оролдсон боловч бүх нууц нь илрэн Ромын язгууртан авхайчуудын дотроос хамгийн хүндтэй, хамгий гоё авхайг шохоорхон харахыг хүссэн доорд муу гладиаторын тэнэг сэхүүн санааг Валерия авхай үнэн зүрхнээсээ шоолон инээх байх гэж ичгүүрлэн зовж ам ангайж чадсангүй. Спартак өөрийнхөө үл бүтэх байдлыг хүнд гашууныг амсаж мэдэрч аман дотроо, ромын ноёрхол, дайн байлдааныг хараан зүхэж, ичих, гутах гайхах зовох айх эмээхээс бүх бие нь дагжин чичирлээ.

Валерия Спартакийн дуугүй болсны шалтгааныг ойлгосонгүй хэдэн минут болсны дараа түүнд дахин нэгэн алхам ойртож улам уяхан дуугаар:

-Чи юу хийж байсан бэ? Надад хэлж аль гэлээ.

Спартак толгой өргөж чадсангүй. Валериягийн хөлийн дэргэд сөргөн унаж:

-Уучил! … Уучил!… бараа бологчиддоо тушааж намайг торлогдуулагтун! Би гэмт хэрэг үйлджээ. Сессорын тамд аваачин намайг тэлж алагтун! Гэж аман дотроо шивгэнэжээ.

-Чи яав? Бос бос! Гэж Валерия хэлээд Спартакийн хоёр гараас дэмжин татаж босголоо.

-Би чиний өмнө батлан ам алдъя, и чамайг гоо сайхны охин тэнгэр Венератай, Юнонтой адилтган тахиж биширдэг билээ… гэлээ.

-Ээ тэгвэл чи намайг харах гэж тэнд очсон байжээ гэж сэтгэл ханасан байдлаар язгууртан авхай хэлжээ.

-Уучил намайг, уучил! Би чамд мөргөхөөр тэнд очдог байсан юм гэхэд

-Хонгор сэтгэлтэй Спартак минь бос бос гэж гараас нь чанга атган сэтгэл хөдөлсөн чичирсэн дуугаар хэлжээ.

-Үгүй, үгүй охин тэнгэр Валерия минь чиний байр энд чиний хөлийн дэргэд байх ёстой… гэж Спартак хэлээд:

-Тэгээд Валериягийн хувцасны хормойг шүүрэн ач шунамхай үнсжээ.

Валериягийн бүх бие дагжин чичирч:

-Бос, бос чиний байр тэнд биш гэжээ.

Спартак өндийн босч Валериягийн гарыг барьж олон олон үнсэж түүнийг маш дурласан нүдээр ширтэн харж:

-Ээ Валерия минь, охин тэнгэр минь, охин тэнгэр минь… гэж сөөнгөдүү, бөглүү дуугаар дэмийрэх мэт ахин дахин хэлжээ.

**ЗАНАЛ, ХАТГАЛГА, АЮУЛ.**

Өөрийнхөө байрны зочид хүлээн авах тасалгааны нэгэн суудлын улаан эдээр бүрхсэн олон зөөлөн жинтүүн дээр тохойлдон хэцийлдэж байсан Эвтибида хүүхэн:

-Энэ тухай чи ямар нэгэн юм мэдэх үү, үгүй юү? Энэ будлиантай хэргийн оньсон түлхүүр чамд байна уу?, үгүй юу? Энэ будлиантай хэргийн оньсон түлхүүр чамд байна уу? үгүй юу? Хэлж аль гэж байлаа.

Энэ нь эмэгтэй хүн шиг царайтай, сахалгүй, үрчгэр нүүртэй, нүүрэндээ оо энгэсэг тавьсан тавь орчим насны хүнтэй Эвтибида ярилцаж байсан хэрэг байжээ. Хувцасны нь маягаас үзвэл эвтибидатай ярилцаж байсан тэр хүн нь жүжигчин хүн болох нь илтэй байлаа.

-Би чамайг хэрхэнг үнэлдгийг чи надаас сонсохыг хүсч байна уу? Метрободий? Би чамайг хэзээ ч үнэлж үздэггүй байсан юм. Харин одоо бол чамайг бүр хүн ч гэж үзэхгүй байна гэж Эвтибидагийн хэлэхэд нөгөө Метробий нь хонгиносон дуугаар:

-Намайг ямагт ивгээн тэтгэгч Момын багийг нэрлэн ам алдъя Корнелий Суллын хамгийн дотно нөхөр Метробий би батлан хэлж байна. Хэрв чи Дианаас давуу сайхан, Капридаас илүү сэтгэл татах Эвтибида биш өөр ямар нэгэн бүсгүй байсан бол би чамд үнэхээр уурлах байсан юм. Бүхнийг ялагч Геркулесийн нэрийг дуудан ам алдъя. Эдгээр үгийг хэрэв чамаас өөр хүн, надад хэлсэн бол би тэр хүнийг тсикс голын эрэг рүү саадгүй тонил гэж хараагаад, шууд л явж олох байсан юм гэнэ.

-Ингэхэд, чи энэ талаар юу хийв? Энэ төлөвлөгөөний тухай чи юу сурвалжилж мэдэв? гэж Эвтибида асуулаа.

-Тэгээд… би чамд хэлье л дээ.. би их юм мэдсэн… тэгэвч бас юу ч юм гэж Метробий хэлтэл:

-Чи жаахан тэсвэртэй бай л даа! Би чамд бүгдий нь хэлж өгье. Чиний санаа зорилгыг мэдэхийг хүсч байагаа тэр хүмүүс үл барам, чамаас ч хэт адгийн гладиаторууд байна. Үүнээс гадна бас бусдын санаа сэтгэлийг мэдэхэд хамгийн хэрэгтэй зэвсэг болох алт мөнгө надад байна, иим учраас, услын баяр энгэлд гучин жилийн турш эмэгтэй хүний рольд тоглосоор ирсэн, өвгөн жүжигчин намайг, тэдний зорилго төлөвлөгөөг тагнан мэдэж чадах байх гэдэгт бодвол чи итгэх биз гэж Метробийн хэлэхэд:

-Чамайг тэдний эв аргы нь олж чадах байх гэж найдсандаа, тэрхүү даалгаврыг өгсөн юм, гэтэл харин чи… гэж Эвтибидагийн хэлтэлт:

-Үзэсгэлэнт Эвтибида минь ээ? Чи миний арга мэхийг гладиаторуудын хуйвалдааныг олж мэдсэнээр сорих байжээ. Одоо миний арга мэхийг өөр зүйлээр шалгаж мэдэхээс өөр аргагүй болжээ. Учир нь гладиаторууд ямар ч хуйвалдаан санаачилсангүй байна. Иим учир гладиаторуудын хуйвалдааны тухай би яаж мэдэж чадах ажээ гэж өвгөн жүжигчин хариулав.

-Ийм байж болох уу? гэж Эвтибидагийн асуухад Метробий

-Тэр бүр үнэн шүү, үүнд ямар ч эргэлзээ байхгүй, үзэсгэлэнт гоо бүсгүй минь ээ! гэжээ.

Одоогоос хоёр сарын өмнө гладиаторуудын нууц холбоо байгуулагдсан тьэд нар өөрийн нууц дохио тэмдэгтэй, нууц яроиатьай, бас өөрийн дуулалтай болсон юм. Бодвол тэд Сицилд гарсан үймээнтэй адил бослого гаргахыг сэдэвлэж байсан биз гэж Эвтибидагийн хэлэхэд

-Гладиаторуудын бослого гарч болно гэдэгт чи үнэхээр үнэмшлээ гэж үү? Гэж жүжигчин асуулаа.

-Яагаад үнэмшиж болдоггүй юм… тэд чинь тулалдаж чаддаггүй бас үхэж чаддаггүй хүмүүс юм уу?

-Амфитеатрт уу…

-Олон түмнийг цэнгүүлэхийн тулд тулалдан амиа алдаж чаддаг хүмүүс болохоор эрх чөлөөнийхөө төлөө тулалдан амиа өгч бүр ч чадах учраас л би тэгж асууж байна л даа гэж Эвтибидагийн хэлэхэд:

-Тэд дээр үед ямар нэгэн хуйвалдаан санаачилж байсан байж болох юм. Юу ч л атугай, одоо тэдэнд ямар ч хуйвалдаан байгуулсан юмгүй байна гэж Метробий хэлэхэд:

Цаглашгүй сайхан грек хүүхэн үл мэдэг санаа алдаж:

-Үүний шалтгааныг би олж мэдхгүй байна мэдэхээс ч үнэндээ айж байна гэжээ.

-Тэгэх тусмаа л сайн. Би түүнийг мэдэхгүй байна, бас мэдэхийг ч хүсэхгүй байна гэж Метробий хэлжээ.

-Гладиаторууд завсраа хуйвалдаан байгуулсан юм. Одоогийн мөрдөж буй хууль бас сенатыг дайсагнан үзэж түүний эсрэг байгаа патрицууд гладиаторуудыг удирдахыг зөвшөөрсөн бол тэд босох байсан юм шүү гэж Эвтибида хэлжээ.

Ромын патрицууд хэдийгээр үл бүтэх муусайн этгээдүүд боловч гладиаторуудын бослогыг толгойлохдоо арай хүрээгүй байж л дээ!

Гэвч тийм нэгэн үе байсан юм… за болъё доо. Энэ тухай цааш нь яриад байх хэрэг алга байна. Харин Метробий чамаас асууя гэж Эвтибидагийн хэлэхэд:

-Харин чи урьдаар миний сонирхож байгаа зүйлийг хэлж аль. Гладиаторуудын бослогын тухай чи хэнээс сонсож мэдэв? гэж жүжигчин асуулаа.

-Би манай нутгийн нэгэн грек хүнээс олж мэдсэн юм. Тэр маань бас гладиатор хүн юм… гэж Эвтибида хариулжээ.

-Эвтибида аа, огторгуйд Юпитер хүчтэй гэхэд газар дээр чи түүнээс ч хүчтэй ажээ. Чи өрөөсөн хөлөөрөө олигархуудын олимпийг дарангуйлан номхотгож, нөгөө хөлөөрөө муу сайн хүмүүсийг дарж байна гэж жүжигчин хэлжээ.

-Би зорьсондоо хүрэхийн тул бололцоотой бүхнийг үйлдэнэ гэхэд нь:

-Чи зорьсон юундаа хүрэх тухай хэлж байна? гэж Метробийн асуухад Эвтибида суудлаасаа босон харайж, царай нь хорсол заналаар хувиран өөрчлөгдөж, нүд нь ууртай гялалзан, маш гүнээ үзэн ядах байдалтайгаар, ийм гоо сайхан бүсгүйд байж болшгүй, юуны өмнө шантаршгүй зориг хүчээр:

-Эрх ямбаа олж авахын төлөө гэж чичирсэн дуугаар хэлээд, бас үргэлжлүүлэн –эрх ямба олон авч хүн бүхний атаархлыг дуудмаар, тийм баян чинээлэг хөрөнгөтэй болохын төлөө, бас өшөө хонзонгоо эгүүлэн авахын төлөө, улам ч их хүч чадал надад хэрэгтэй байна гэж их л зөөлөн дуугаар давтан өгүүлэв.

Метробий нь янгаалан ярваганах янз бүрийн зан байдлыг тайзан дээр олон удаа үзэж сайн мэддэг болсон хүн хэдий боловч, Эвтибидагийн эвгүй болсон нүүрийг их л гайхан ширтэж байтал нь Эвтибида гэнэт биеэ барьж чанга дуугаар инээд алдаж:

-Би Медейн ролийг Галерия Эмболариятай адил сайхан тоглож чадаагүй атугай ч, бас муугүй тоглож байгаа биз ээ! Харин хөөрхий мууМетробий чи минь бул чулуу шиг болжээ. Чи настай томоотой бас туршлагатай алиа жүжигчин атлаа үүрд эмэгтэйчүүд ба бага насны хөвгүүдийн рольд тоглон байх болно гээд Эвтибида улам инээхэд Метробий бүр ч гайхжээ.

Ингэж байснаа сээтгэнүүр бүсгүй бага зэрэг чимээгүй болсноо дахин дуугарч:

-Зорьсонх юундаа хүрэхийн тул гэж чи асуув уу? Хөгшин хожуул минь ээ! гэж хэлэх зуураа Метробийн хамрыг няслан улам бүр инээж:

-Би хөгшин сээтгэнүүр хүүхэн Флора шиг, бас Суллын янаг Никополия хүүхэн шиг баян болохыг хүссэн юм. Маш баян болохыг би хүссэн юм. Хөгшин тэнэг минь ойлгож байна уу? Тэгээд би бүх талаар баяр хөгжил, жаргал цэнгэлийг дураараа эдэлж Эпикурийн номлодгоод жаргал бүхний дээдэд хүрэх гэсэн юм. Ийм ч учраас би байгаль ертөнцөөс надад заясан уран чадвар, бусдын дур сэтгэлийг татах зэвсэг бүхнээ хэрэглэж байгаагийн учрыг одоо чи мэдэв үү? Чиний хэлдгээр нэг хөлөөрөө Олимпийг дарангуйлан номхотгож, нөгөө хөлөөрөө муу сайн хүмүүсийг дарж байх гэсэн юм гэвч…

-Шавхайтай хутгалдчихаж магадгүй юм…

-Дараа нь бас угаачихаж болно шүү дээ. Ямар Ром хотод халуун усны газар шүршүүр цөөдсөн биш? Ямар миний энэ байшинд бие угаах онгоц байхгүй гэх биш? Ээ бурхан тэнгэр минь, хамгийн доорд бохир бузар, хамгийн үзэшгүй муухай ажил явуулгатай хутгалдан бүх насаа өнгөрүүлж байгаа энэ хүн надад хэв суртахууны номлолыг заахаар шийдэв үү? Гэхэд нь:

-Миний зургийг ингэж тодхон үзүүлэхээ боль л доо! Тэгвэл чи миний зургийг маш адилхан дүрслэж болзошгүй байна. Тэгвэл хүн бүхэн тэрхүү бузар явуулгатай хүн болох надаас зугтах болно. Эд бүхнийг би чамд тоглоом болгон хэлсэн юм. Миний хэв суртахуун хөлийн минь өсгийд байдаг юм. Чи тэгээд намайг хэв суртахуунаа яаг гээв? гээд

Метробий, Эвтибидагийн дэргэд очоод, түүний гарыг барьж үнсэн:

-Чиний шагналыг би хэзээ хүртэх вэ? гэж асуулаа.

-Шагнал гэнээ, хөгшин шогч чи юу бүтээсэндээ надаас шагнал авах гэж байна? гэж Эвтибида уурлан гараа түүний гараас мулт татан авч, бас нүүр рүү нь алгадаж, чи гладиаторуудын юу сэдэвлэн хуйвалдаж байгааг мэдсэн үү? Гэлээ. Метробий, тасалгаан дотуур зогсолгүй өөд сөөргөө явж байсан Эвтибида хүүхний хойноос нүд салгалгүй дагаж, их доромжлол хүлээсэн хүний байдалтайгаар харин нилээд гомдсон дуугаар

-Үнэн хэрэгтээ байхгүй юмыг би яаж олж чамд хэлэх ёстой байв? Миний хамгий сайхан Эвтибида янаг дурлал минь, би түнийг яаж гүйцэтгэж чадах байв? гэлээ.

Эвтибида алиа жүжигчний зүг эргэж гайхамшигтай хөөрхнөөр инээмсэглэв.

-За тэгвэл сайн байна, хэрэв чи миний талархлыг олж авахыг хүсч байгаа бол хэрэв надаас гавъяа шагнал хишиг хүртве гэж байгаа бол… гэхэд

-Надад даалгах юмаа бүгдийг хэлж тушаа, охин тэнгэр минь!

-Тэгвэл чи, гладиаторуудыг хянан мөрдөх ажлаа үргэлжлүүл. Гладиаторууд бослогын тухай бодлоо бүрэн орхисон гэдэгт би бас л итгэхгүй байна гэлээ.

-Тэгвэл би Кумын байдлыг хяная, бас Капуяд очиж ирье гэж Метробий хэлжээ.

-Хэрэв чи юм олж мэдье гэж байгаа бол юуны өмнө Спартакийг сайтар хянаж байх байр хэрэгтэй шүү гэж Эвтибида  хэлжээ.

Эвтибида Спартак гэдэг нэрийг хэлэхдээ хоёр хацар нь час улаан болсон байлаа.

-Спартакийн тухайд гэвэл би зөвхөн чиний тулд ч биш, бас өөрийн тул, үнэнийг хэлбэл Суллын тул салалгүй мөрдөн дагадаг болсноос хойш би даруй сар боллоо.

Сээтгэнүүр бүсгүй гэнэт сэтгэл нь сэргэн, Метробийн дэргэд гүйж ирээд:

-Юу? гэнээ Юү гэж чи хэлэв? Гэж асуулаа.

Метробий ямар нэгэн хүн сэм чагнаж байх бий гэсэн шиг эргэн тойрон сайтар ажиглан харж, аюулгүйг мэдэж авсныхаа дараа баруун гарынхаа долоовор хурууг доод уруулдаа хүргэн итх л намуун дуугаар:

-Тэр бол миний хардан сэжиглэж байгаа зүйл юм. Иймээс би ташаараан эндүүрч Суллын хэрэг ажилд дэмий хутгалдан орох аюул болж болох юм. Тэр тухай, лавтай баримт мэдээгүй байгаа цагтаа нэг ч амьд амьтанд хэлэхгүй. Тэр бол миний сэжиглэл, тэр бол мини й нууц мөн гэлээ.

Метробийн энэ үгээ хэлж байх зуур Эвтибидагийн нүүрэн дээр сэтгэл зовсон байдлын илрэл тодорч байсан боловч, шалтгааны нь Метробий мэдсэнгүй.

Энэ үгийг сонссон Эвтибида хүүхэн гэнэт, нэг гараараа Метробийн гарыг барьж, нөгөө гараараа түүний нүүрийг илж чи намайг итгэхгүй байна гэж үү? Чи миний төлөв томоотой, бусад хүүхнүүдтэй адилгүй болохыг туршлага дээрээс олж үзсэнг_үй гэж үү? Чи өөрөө, намайг грекийн найм дахь цэцэн нь байж болох хүн гэж надад олонтой өгүүлж байсангүй билүү?… миний хайртай Метробий чи тэр тухай одоо наддаа хэлж өгнө үү? Хонгор минь. Намайг ямагт өршөөж байдаг. Кельдийн Аполлоны нэрийг дуудан ам алдъя чиний хэлсэн зүйлийн тухай надаас хэн ч сонсож чадахгүй. За хэлж аль! Сайн Метробий минь. муу Эвтибидадаа хэлж аль даа. Тэгвэл би чамдаа хэмжээгүй их баярлана шүү дээ гэлээ!

Эвтибида хүүхэн өвгөн Метробийн өмнө эрхлэн янаглан байж, уран зөөлөн харц, хонгор янаг инээмсэглэлээ түүнд соёрхон өгч, хүссэндээ хүрчээ.

-Хүслий чинь хангаж өгөхөөс наш ч чи надаас салахгүй болсон бололтой за хэлж өгье л дөө. Спартак Валерияд сэтгэлтэй болсон бололтой байна. Мөн Валерия ч бас Спартакт тийм болсон бололтой гэж би боддог болсон. Бас ингэж бодох ч үндэс багагүй байгаа юм гэж Метробий хэлжээ.

Эвтибидагийн царай гэнэт хувхай цагаан болж галзуурсан юм шиг гараа зангидан чарлаж,

-Ээ өшөө хонзон авагч -Эринийн бамбарыг дуудан ам алдъя. Тийм гэж үү дээ? гэлээ.

-Хэдийгээр надад батлах баталгаагүй боловч, би л хувьдаа гарцаагүй тийм байх гэж боддог болсон юм. Харин чи энэ тухай ганц ч үг цухуйлгаж болохгүй шүү гэж өвгөн жүжигчин хэлжээ.

Эвтибида их л бодолхийлсэн царайтай болж, өөрөө өөртэйгөө ярьж байгаа юм шиг:

-Тэр тийм учиртай байх нээ!… түүнээс өөр учир байх ч аргагүй л боллоо доо!… өөр авгайд… өөр… өөр авгайд тэр, тэр авгайн үзэсгэлэн сайханд сэтгэл нь татагджээ, ухаангүй хөөрхөн чамайг… түүнийг сайхан ялжээ гээд Эвтибида хоёр гараараа нүүрээ дарж учиргүй бачимджээ.

Эвтибида Спартакт хичнээн дуртай хайртай болсныг гэрчлэн үзүлж буй түүний тэр утга учиргүй, үг дараа нь цурхиртал уйлсан явдлыг Метробий харж, хичнээн гайхсаныг ойлгоход хялбар бизээ! Ромын аль нэртэй, аль баян патрицуудын дур сэтгэлийг биедээ

татсан тэдний санаа алдах явдлын шалтгаан болсон боловч өөрөө одоо хүртэл, хэнд ч дурлаагүй явсан, үзэсгэлэнтэй сайхан Эвтибида хүүхэн, тэр зоригт гладиатор Спартакт зүрх сэтгэлээ нэгмөсөн өгч галзуу хүчтэй дурласан байжээ. Дур сэтгэлээрээ унасан баяд, хэргэмтэн хэнийг боловч доромжилж сурсан Эвтибида хүүхний үнэн дурлалыг өчүүхэн рудиарий бут цохисон нь тэр байжээ.

Метробий тэр аз заяатай бүсгүйг өрөвдөн, түүнд ойртон очиж эрхлүүлэн, сэтгэл санаагий нь засахыг оролдож:

-Тэр тийм биш байж болох юм… би ташаарсан ч байж болно шүү дээ… тэр бол миний хий хардлага ч байж болно гэжээ.

-Үгүй чи ташаарсангүй, тэр чинь чиний хий хардлага ч биш, үнэхээр тийм байж таарна. Би бүр мэдэж байна гэж уйлсан нүдээ улаан дээлийнхээ хормойгоор арчиж хүүхэн хэлжээ. Тэр чимээгүй байснаа дахин дуугарч:

-Юу ч гэсэн энэ тухай мэдэж авсан минь сайн хэрэг боллоо. Мөн энэ тухай надад чиний хэлж өгсөн чинь маш сайн болжээ… гэж аярхан дуугаар баттай хэлжээ.

-Тэр тухай намайг хэлсэн гэдгийг хэнд ч дурсаж болохгүй шүү гэж хичээнгүйлэн гуйяа.

-Бүү зов Метробий бүү зов. Хэнд ч хэлэхгүй нь дээр, чамайг би чадах хирээрээ шагнана. Хэрэв чи миний төлөвлөгөөг биелүүлэхэд тусалбал Эвтибида хүүхэн, хүний ачийг хэрхэн хариулж чаддагийг чи үзэх болно гээд, нэг минут хир дуугүй байснаа зангирсан хоолойгоор:

-Одоохон чи яв! Кумад оч… одоохон… өнөөдөр чи яв… тэр хоёрын хөдөлгөөн бүр, амьсгал, алхам бүрий нь ажиглаж хар. Надад хэрэг байдлын баримтыг мэдэж ир! Тэгээд Суллын алдар нэг доромжлогдсон хөөрхий эмэгтэй миний хорслын төлөө өшөөгөө хоёулаа зэрэг авъя гэснээ:

-Намайг жаахан хүлээж бай… би одоохон ирнээ гэж явангуут хэлээд сэтгэл нь хөдөлсөн хүүхэн тасалгаанаас санд мэнд гарч гүйлээ.

Минут хиртэй болоод Эвтибида зочид хүлээн авах тасалгаандаа буцаж ирээд Метробийд хүнд арьсан хэтэвч өгч:

-Энэ хэтэвчийг ав, дотор нь нэг мянган аурей бий боолуудад нь хээл хахууль өг, мөн шивэгчнүүдийн нь сэтгэлийг татаж, ямар аргаар боловч, тэр хоёрын дурлал үнэн гэдгийг батлах баталгаа олж ир, ойлгож байнауу?… хэрэв дахиад мөнгө хэрэгтэй бол…

-Энэ чинь хүрнэ.

-Тэгвэл сайн! Мөнгө бүү нарийл, би чамд өгнө… тэгээд одоохон яв… өнөөдөртөө яв. Замдаа ер бүү саат… бушуухан надад баримтат мэдээ олж ир гэлээ. Эвтибида зочид хүлээн авах тасалгаанаасаа жүжигчнийг түлхэн гаргаж гэрийн шүтээний тасалгаа ба борооны ус цуглуулах өрөө, зургийн үзэсгэлэнгийн танхимыг тойрон гарсан коридороор дагуулан явж, байшингийн төв дундад зайг тойрон өнгөрч гадагш гарах хаалганы өмнөх зайд хүргэж, тэнд хаалгачийн үүрэг гүйцэтгэж байсан өөрийн нэг боолыг дуудаж:

-Гермоген чи энэ хүнийг харж байна уу? Энэ хүнийг хэзээ эргэж ирсэн цагт нь миний тасалгаанд саадгүй оруулах хэрэгтэй гэж тушаажээ.

Эвтибида, Метробийг гаргаж өгөөд өрөөндөө шалавхан эргэж ирээд дотроос нь түгжиж тасалгаан дотуураа удтал өөдөө, сөөргөө алхлан явжээ. Сэтгэл маш хөдлөн зовуурилж царайд нь түмэн зүйлийн санаа, түмэн зүйлийн хүсэл тусч, уур хилэн нь бадарч байсан тэр бүсгүйн нүд галзуу араатны нүд мэт байлаа. Ингэж байснаа ахин цурхиртал уйлж зөөлөн бандан дээрээ унаж, цас шиг цагаан гараа цус гартал хазлан:

-Эвменида минь! өшөөгөө авах бололцоог надад соёрхон хайрла, тэгвэл би тэсгэлгүй сайхан шүтээний ордон бүтээж танд барья!… түүнээс өшөөгөө авахыг би тэсгэлгүй мөрөөдөж байна… өшөөгөө авахыг маш хүсч байна… өшөөгөө… гэжээ.

Энхрий хүүхэн Эвтибидагийн энэ галзуу хорслыг тэсвэролэхийн тулд Валерия Спартакт тэсгэлгүй дурласан сэтгэлдээ автагдан, түүнд бие сэтгэлээ бүрмөсөн өгсөн тэр өдрөөс хой, өнгөрсөн энэ хоёр сарйн дотор чумах юу болсон тухай товчхон хэдэн үгээр өгүүлье.

Гладиатор Спартак нь гайхамшигт эрэлхэг чийрэг биетэй, сайхан царайтай, сайн хүний шинж бүрдүүлсэн усга зөөлөн харцтай, том цэнхэр нүднээс нь гүн дурлалын алтан цацралын мөнх урсгал гийсэн тийм нэгэн үзэсгэлэнт эр байжээ. Ийм ч учраас энэ эр өөрийнхөө зүрхэнд оршиж байсантай адил тийм хүчтэй дурлалыг бас Валерия авхайн зүрхэнд асаасан нь гайхалтай хэрэг биш ажээ. Энэ залуу эрийн хосгүй сайхан сэтгэл зүрхэнд, цаг тутам, улам улам шинэ сайн чанарыг олж мэдэрч байсан алдартай авхай Валерия тун ч удалгүй бүх зүрх сэтгэлэрээ дурласан юм. Валерия авхай Спартакт тэсгэлгүй стгэлтэй болсноор ч үл барам, би Луций Корнелий Сулладүнэхээр дуртай болж чаддаггүй ч юм гэхэд энэ хүнийг би хязгааргүй хүндэтгэн бишрч байна гэж Валерия хэдхэн сарын өмнө бодож байсантайгаа адил, одоо Спартакийг хүндэтгэн бишрдэг болсон байжээ.

Спартак ч бас өгүүлж баршгүй их баяртай жаргалтай хүн болжээ. Спартак энэхүү бадарсан дурлалынхаа сэтгэлд согтууран дээд жаргалдаа ташуурч оргилсон сэтгэлийнхээ мананд автагдан хувиа бодогч хүн болж, өөртэйгөө адил доод заяатай нөхөд, өчигдрийг өдрийг хүртэл хөлдөө хангинаж байсан төмөр гинж, ямар нэгэн аргаар боловч төгсгөлд нь хүргэхээр ам тангаргаа өгсөн эрх чөлөө гэдэг ариун үг тэргүүтнээ бүрмөсөн мартсан байлаа. Ингэж сэтгэл нь туйлдаа хүртэл ханаж өөрийгөө ертөнц дээр хамгийн их аз заяатай хүн гэж Спартакийн бодож байсан тэр үед Эвтибида хүүхэн түүнийг хэдэн удаа гэртээ урьсан юмаа! Эвтибида Спартакийг урихдаа, гладиаторуудын хуйвалдааны асуудалтай холбогдолтой хэргийн нэрийдлээр урьдаг байжээ. Нэг өдөр Спартак арга буюу тэр хүүхний гэрт зочлон очсон юм.

Одоо хир хорин дөрвөн нас хүрээгүй байгаа энэ хүүхэн Афин хотын ойролцоо төрсөн бөгөөд хожим Ромыг байгуулсны он тооллын 668 онд буюу өөрөөр хэлбэл бидний үгүүлж байгаа энэ хэрэг явдлын болж байгаа үеэс найман жилийн өмнө Сулла, Афин хотыг удтал бүсэлж байснаа эзлэн авах үед арван дөрвөн настай байсан энэ бүсгүйг боол болгон Ром хотноо авчирсан байжээ. Төрөлхийн атаархаг ихэмсэг зантай, муу хүмүүжил рүү хялбархан татагдах төлөвтэй байсан энэ бүсгүй завхай өвгөний ачаар эрх чөлөөгөө олж авсан байж түүгээр ч барахгүй Эвтибида нь ичгүүртэй амьдралаар амьдрах болж, бас бусдын дотор нөлөөтэй, хүчтэй баян хөрөнгөтэй хүн болжээ. Байгалиас энэ бүсгүйд ховорхон сайхан үзэсгэлэнтэй царай хүртээсний дээр, сэргэлэн ухаан бас заяажээ. Эвтибида байгалиас хүртсэн энэ ухаанаа элдэв нэгэн хорт явуулга, хатгалга санаачлан зохиож, үймүүлэх хэрэгт бүх хүчээ дайчлан хэрэглэх болжээ. Муу явдлын бүх нууцыг мэдэж, тачаангуй хурцлын бүх талыг цадтал амссаныхаа дараа энэ бүсгүй, завхай хөнгөн амьдралыг жигшин үздэг болж чухам энэхэн үедээ анх Спартакийг олж харсан юм. Спартакийн прекулес шиг асар их хүч чадалтай мөн түний ер бус гоо сайхан үзэсгэлэнг харсан энэ бүсгүйн зүрхэнд шунахайран хүсэх сэтгэлийн хүчтэй дөл асч, бас хүссэн санаандаа хүрч чадна гэдэгт өчүүхэн ч эргэлзсэнгүй байжээ. Ингээд энэ бүсгүй элдэв аргыг хэрэглэн, хууран мэхэлж Спартакийг урьж авчран түүнтэй ярилцсан юм. Энэ ярианы үед Эвтибидагийн олж мэдсэн нь: бусдыг биедээ татдаг миний элдэв арга заль,

Спартакийн сэтгэлийг татаж ер чадахгүй нь байна, энэ рудиарий миний арга мэхэнд автагдахгүй нь байна. Миний дурлалыг ертөнц дээр анх удаа няцаах хүн бол энэ байна гэдгийг мэдэж авсан билээ.

Энэ бүхнийг мэдмэгц, Спартакт дурласан сээтгэнүүр хүүхний дурлал бүр шатаж тачаангуйн аймшигт дөл болон оволзжээ.

Спартак, Суллын өмчийн гладиаторуудын багш болсноос хойш төдий л удалгүй Кумад очиж суусан юм. Их дарангуйлагч захирагч Кумын дэргэд үнэхээр үзэсгэлэнтэй сайхан ордон хөршид гэр бүл айлаараа суудаг байжээ. Спартакийн өмнө, өөр сайхан бүсгүйн тод дүр харагдаж, түүнд сэтгэлтэй болсон учир, миний дурлалыг тосч авахгүй байна гэдгийг Спартакт дурлалаа няцаагдан, тэсгэлгүй сэтгэл хорсч гомдсон Эвтибида адгуусан амьтны төрөлх авъяасаар таавaрлан мэдсэн ажээ.

Ингээд: Энэ бүсгүй тэр рудиарийг үүрд мартаж, өөрийн зүрх сэтгэлээс түүний дурсгалыг хол таягдан орхих гэж хичнээн оролдовч огт чадсангүй. Эвий хүний сэтгэл зүрх гэж ийм л аж! Хүний сэтгэл гэдэг бол олоход хялбар бус үхнийг хүсдэг, хүссэн хүслийг хангах замд хичнээн хүнд бэрхшээл саад байх тутам төчнөөн хүчтэй, тэр зүг тэмүүлдэг байна. Эвий хүний зүрх сэтгэл гэдэг ямагт ийм байдаг ажээ.

Иймийн ч учир өнөөгийн өдөр хүртэл, эрх ямба, зол жаргалаар төгс байсан Эвтибида гадаад өнгөндөө баян тансаг эд хөрөнгөтэй, хувь заяатай хүний хэлбэртэй боловч бүх хүмүүсийн дотроос хамгийн доорд заяатай нь одоо болсон байжээ. Ийм учраас дурлал хорсол хоёры нь зэрэг татаж байсан тэр хүн ба мөн хувьтай өрсөлдөгч бүсгүй хоёроос нэгэн зэрэг өшөө хорслоо авч болох нөхцөл бололцоо харагдмагц Эвтибида ямар их баяртай угтан авсныг манай уншигчид харсан биз дээ. Хартай сэтгэлийнхээ хорсолд автагдан өөрийнхөө тасалгаанд Эвтибида цурхиртал уйлж, мөн Метробий сайн морь унаж Кумын зүг жолоо хумхилгүй хурдлан давхиж байх энэхэн үед Либитиний Венера гэдэг гуанзанд дээрхээс бага бус хэрэг явдал болж байжээ.

676 оны дөрөвдүгээр сарын Календын арван долоо дахь өдрийн /3-р сарын 16/ үдшийн бүрэнхий болох үед гладиаторууд, гахайн шарсан мах мөн зайдас идэх гэж велитерны ба тус куланы дарс уухаар өрөөсөн нүдэт Лутациягийн гуанзанд цугларсан байжээ. Энд цуглaргсдын найрын тэргүүн нь галт язгуурын гладиатор Крикс болж, хоолны ширээний эхэн дээр сууж байжээ. Энэ хүн нь хүч чадал, эрэлхэг зориги йнхоо хувьд өөрийнхөө нөхдийн дунд хүндтэй, мөн Спартакийн итгэл найдвар, хайр хүндэтгэлийг хүлээсэн хүн юм.

Эдгээр гладиаторуудын тойрон сууж хоол идэж байсан ширээ нь гуанзны хоёр дахь тасагт байжээ. Иймийн учир тэд энд тохилог тавтай сууцгаан өөрсдийнхөө хэрэг ажлын тухай айж болгоомжлох зүйлгүйгээр харилцаж ярилцаж байсан бөгөөд бас хоёрдугаар тасагт хүмүүс цөөн байсан ба энэ цагаар энд орж ирж байсан цөөн хэдэн хүмүүс нь яаравчлан аяга хоол идэж, мөн гускуланы дарс бага зэрэг уугаад гуанзнаас гарч өөрийн замаар одох хүмүүс байлаа.

Крикс нөхдийнхөө хамт ширээний ард суух зуураа гуанзангийн тасалгааны нэг буланд бяцхан ширээ байхыг ажсан бөгөөд түүн дээр, идэш уушны үлдэгдэл аяга шаазан хэвээр үлдсэнийг харж энэ ширээн дээр хоол идсэн хүн тун саяхан явсныг мэдэв. Крикс хоолны ширээний дэргэд, ямар нэгэн юм хийж байсан гуанзны эзэн авгайн зүг харж,

-Тэнгэрийн эх-Лутация Кибела! Тэр ширээн дээр хэн хоол идсэнийг надад хэлж аль гэлээ.

Лутация ширээний зүг эргэж харангуут гайхаж:

-Хаашаа явчихав? Хачин юмаа!… гээд хоромхон зуур чимээгүй байснаа, дахин дуугарч:

-Ээ … надад Юнона Луциан тус хүргэх болтугай… гэхэд нь

-Чиний мигуйн чинь төрөхөд үү… гэж тэнд байсан нэг гладиатор аман дотроо өгүүлнэ.

-Тэр хоолныхоо үнийг төлөлгүй явж намайг хохироов? Гэж хэлээд Лутация, ширээний зүг гүйн очиход:

-“Тэр” гэдэг нэрээр халхлан, жинхэнэ нэрий нь нуугаад байгаа үл мэдэгдэх хүн чинь чухам хэн гэдэг хүнхюм? Гэж Крикс дахин асуулаа.

Өрөөсөн нүдэт авгай сэтгэл амарсан янтай санаа алдан:

-Би мэдсэн юм, тэр сайн хүн байх ёстой байсан юм. Түүний би дэмий хараажэээ… ширээн дээрээ найман сестерций орхиод явсан байна. Тэр нь надад төлбөл зохих үнээс даруй дөрөв хагас ассаар илүү байна гэжээ.

-Яр шарх чамайг идээсэй, чи ер нь тэр хүнийхээ нэрийг хэлж өгөх юм уу? Үгүй юм уу? гэж дахин асуулаа. Лутация ширээгээ цэвэрлэн,

-Ээ хөөрхий минь, тэмдэглэлийнхээ самбар, бас хуйтай нарийн хутгаа мартаж орхисон байна шүү гэлээ.

Лутациягийн хэтэрхий олон үгийг сонсож тэсч яда Крикс зандарч:

-Муу хөгшин метера чиний хэлийг амттай шөөөнд чанаж, Прозерпина өнөөдрийн дотор залгих болтугай! Чи тэр үл мэдэгдэх хүнийхээ нэрийг бидэнд хэлж өгөх юм уу? Үгүй юм уу? гэж зандарлаа.

-Та нар түүний нэрийг мэдэж яах гэсэн юм, муу сайн эмүүдээс ч илүү, юманд дуртай, гуйлгачингууд вэ? Энэ ширээний ард, Ром хотоос хувийн хэргээр энд ирсэн Сабинын буудайн наймаачин нэг хүн хэдэн өдөр дараалан манайд ирж, яг энэ цагаар хоол иддэг болсон юм. Тэгээд яах гээв гэхэд нь Крикс алив наадахиа үзүүл гээд тэр хүний ширээн дээр мартаж орхисон лааны тос түрхсэн жижигхэн модон самбар ба ясан үзгийг Лутациягийн гараас нь авч тэр наймаачны тэмдэглэлийг уншлаа.

Үүн дээр нь үнэхээр янз бүрийн будааны нэрс, мөн түүний хажуу талд төрөл бүрийн будаа тус бүрийн үнэ, түүнчлэн, бодвол дэнчин барьсан будааны эзэн хүмүүсийн нэрс бололтой хүмүүсийн нэрсийн дор есөн шидийн тоо тэмдэглэсэн байна.

Өрөөсөн нүдэт Лутация мөн үглэн:

-Түүний чухам хэдийд явж одсоныг би огт мэдсэнгүй. Та нарын энд орж ирэх үед лав байсан юм гэдгийг би батлан тангараглаж чадна. Аа!-мэдлээ Миний та нарт зайдас бэлтгэж завгүй бах үед намайг дуудаж ядаад яарч явсан учир шударга хүний ёсоор хоолны үнийг ширээн дээрээ орхиод явсан хэрэг байх нь шүү гэнэ.

-Лутация түүнд эргүүлэн өгсө тэмдэглэл бүхий самбар ба үзгийг авч холдох замдаа тэр маргааш манайд заавал ирэх байх. Хэрэв ирдэг л ю бол мартсан бүх юмы нь өөрт нь эргүүлж өгөх юм шүү гэж аман дотроо хэлэв.

Гладиаторууд бараг таг дуугүй шахам сууцгаан хоолоо идэж нилээд болсны дараа тэдний дотроос нэг нь дуугарч:

-Нарны[1] талаар ямар ч мэдээ байхгүй юу? гэхэд Крикс хариулж:

-Нар ямагт үүлний[2] цаана байна гэлээ.

-Энэ чинь гайхалтай хэрэг байна даа гэж бас нэгэн гладиаторын хэлэхэд нөгөө нэгэн гладиатор:

Тун ойлгогдохгүй хэрэг байна гэж шивнэн хэлэв. Бас нэгэн гладиатор Крикс тийш харж:

-Нөгөө шоргоолж[3] яаж байна?

-Зун болохыг[4] хүлээж улам олон болж ажлаа шуурхай хийсээр л байна.

-Аа тэгвэл даруй зун болж нар ялгуусан цацргаараа хөдөлмөрт дуртай шоргоолжуудыг гийгүүлэн муусайн зөгийнүүд[5] далавчаа шатаах болтугай.

-Криксээ одоо хэдэн од[6] үэгдэж байна хэлж өгнө үү?

-Өчигдөр хоёр мянга хоёр зуун жар үзэгдэж байна.

-Дахиад шинэ өдрүүд бий болж байна уу?

-Од мичид огторгуйг битүү бүрхэж манай дэлхий ертөнцийг гийгүүлэх хүртэл улам бүр нэмэгдэж байх болно.

Дарс оруулж ирсэн хар арьстай боол бүсгүйг харж:

-Сэлүүрээ[7] харагтун гэж нэгэн гладиатор хэлжээ.

Тэр хүүхнийг гарсны дараа энд байсан галл гарлын нэгэн гладиатор:

-Ингэхэд бид энд дангаараа байна. Би та нартай саяханнийлсэнх учир нууц яриагаар сайн ярилцаж чадахгүй байна. иймийн учир нууц үг хэрэглэх гэж биеэ зовоохгүй шууд асуувал:

-Манай талынхны тоо нэмэгдэж байна уу? Үгүй юу? гэж барагтайхан лат хэлээр хэлжээ.

-Ингэхэдэ бид хэзээ нэг босч их завтай ноёдтой тулалдан тэдний зоригоос дутахгүй, магадгүй тэдний зоригоос илүү ч зоригтой хүмүүс байна гэдгээ үзүүлж өгөх гэж байна! гэхэд,

Крикс инээмсэглэн Брезовир минь, чи дэндүү яаравчилж, дэндүү омгорхож байна. Арай л эртдэж байна. Манай холбооны талынхны тоо өдөр ирэх бүр олон болж байна. Ариун хэргийг хамгаалагчдын тоо цаг бүр, хором бүр нэмэгдэж байна… жишээлбэл энэ орой анхдугаар бамбар цохих үеэр, Субмицийн гүүрийн цаадах Авентин ба Яникуль толгодын завсар байх охин тэнгэр Фурринын дурсгалд зориулсан ой дотор шалгарсан үнэнч, арван нэгэн гладиатор, дагаж мөрдөх ёслолыг үйлдэн, манай холбооны гишүүдийн бүрэлдэхүүнд бас элсж орно гэжээ.

-Охин тэнгэр Фурринийн ойд гэнэ үү? Тэр дархан цаазат газрын хөрсөнд үзэшгүй муусайн патрицуудын хорсол, Кай Гракхын ариун цус шингээсэн юм. Дайсны хорсолд дарагдаагүй Кай Гракхын сүнс тэндэх ойн царс модны навчин дотор ёолон дуулж байдаг юм. Эрх чөлөөгөө олохын төлөө дарлагдсан хмүмүүс чухамхүү тэр ойд л цугларч нэгдэж байвал зохино гэж түргэн зантай Бреновир хэллээ.

Самнит язгуурын нэг гладиатор тосч аваад:

-Чухам өөрийн тухай хэлбэл би бослого гарах цагийг тэсч ядан хүлээж байна. Учир нь босогчид ялна гэдэгт бат итгэснээс биш, харин Ромынхонтой барилцан авч иргэний шударга дайнд амь үрэгдсэн самнит болон Марсын язгууртны өмнөөс өшөөгөө авах гэсэн юм. Гэвч би энэ зөв хэргийн ялалтад итгээгүй байсан бол дарлагдагсдын холбоонд орохгүйл байсан л даа гэв.

Тэгэхэд нь бас нэг хүн дуугарч:

-Би хувьдаа, тэртэй тэргүй зайлшгүй үхэх мөрт энэ холбоонд орсон юм. Циркийн талбай дээр алагдсанаас тулалдаанд амь үрэгдвэл дээр гэж бодсон юм гэлээ.

Энэ үед нэг гладиатор ойчсон сэлмээ өөд татаж авахаар доошоо бөхийтөл нь хүний хөл ба ногоон өнгийн хувцасны хормой хоолны шрээн доор харагдах шиг болжээ.

-Хүүш ширээн доор хүн байна гэж цочиж дуугартал тэнд байсан хүмүүс бүгдээрээ сандран босоцгооход Крикс

-Сэлүүрээ харагтун! Брезовир Торкват хоёр ялаа шумуулыг хөөгтүн[1] бид нар загасаа шарж болгоё[2] гэлээ.

Хоёр гладиатор тушаал биелүүлэн, хаалганы дэргэд зогсож, дэмий үг ярилцав. Бусад нь хоолныхоо ширээг шалав өргөж, байсан газраас нь зайлуултал ширээний дороос гуч орчим насны нэгэн эр гарч ирлээ.

Хөвчин биеэ агсайтал хураасан хөөрхий тэр муу тагнуулыг дөрвөн талаас нь дөрвөн хүчтэй гар зэрэг шүүрэн барьж авмагц, тагнуул амь уучил гэж гуйлаа.

-Нэг ч үг бүү дуугар өчүүхэн ч бүү хөдөл, эсхүл чамайг доор чинь ална гэж Крикс зөөлөн дуугаар боловч ширүүн тушааж хэллээ.

Өчүүхэн боловч чимээ гаргавал хоромхон зуурын дотор чиний сүнсийг тонилгоно гэж заналхийлэн хэдэн арван хурц сэлмийн гар бас гялалзана. Хоёр нүд нь цусаар дүүрчээ. Их л зовж байсан тэр тагнуулыг Крикс харж:

-Аа чи сестерций мөнгөө тоололгүй ширээн дээр орхиод явдаг Сабинын будааны худалдаачин хүн гэдэг чинь чи юу гэлээ.

Айж сандран бүх бие нь хүйтэн болсон тэр залуу, үгээ сунгаж:

-Зоригт хүмүүс минь ээ! Надад үнэмшээч би… бишээ… гэтэл нь

-Аймхай муу чи дуугүй бай! гэж хэлээд нэгэн гладиатор түүнийг хүчтэй өшиглөжээ. Тэгэхэд нь Крикс хориглох дуугаар… Эвмакл аа!… азна … яах гэж энд ирсэн, хэн үүнийг нааш нь илгээсэн тухай наадах чинь өөрөө яриг гэснээ худалдаачин хүн бологч тэр хүн тийш харж:

-Ингэхэд чи будаа наймаалах гээгүй харин тагнуул хийх тэрслэх гэж энд иржээ… гэлээ.

Заяа муутай тэр амьтан, үгүй… дээдэс тэнгэрт залбирна… намайг хүн илгээсэн юм гэж чичирсэн дуугаар түгдчин хэлжээ.

-Чи хэн гэгч вэ?… чамайг хэн нааш нь явуулав? Гэхэд

-Амий минь уучил… би бүх зүйлээ хэлж өгье. Харин намайг өрөвдөн үзэж…. Энэрэнгүй сэтгэлээрээ амий минь уучил! Гэлээ.

-Тэр тухай бид дараа болъё. Харин чи одоохон хэлж аль гэхэд нь:

-Миний нэр Сильвий Кордений Веррес… гэдэг. Би бол грек хүн… урьд боол байсан юм… одоо Кай Верресийн чөлөөлөгдсөн хүн мөн гэлээ.

-Аа тэгвэл чи түүнийхээ тушаалаар нааш ирсэн хүн байх нь ээ гэхэд:

-За тиймээ. Би түүний тушаалаар наашаа ирсэн юм гэлээ. Кай Верресийг бид яасан юм? Яагаад тэр чинь биднийг тагнах, мөрдөх, бидний тухай хов мэдээ хэрэглэх болсон юм? Хэрэв тэр чинь бидний нууц цуглааны зорилгыг мэдэхийг хүссэн бол дараа бидний тухай сенатад мэдээлэх гэсэн хэрэг байх нь ээ…

Кай Верресийн чөлөөлөгдсөн тэр хүний бие нь зогсолгүй чичирч:

-Би мэдэхгүй… тэр тухай би мэдэхгүй байна гэлээ.

-Юу ч мэдэхгүй хүн болох гэж оролдох хэрэг алга… бидний өмнө тэнэг мангуу амьтан мэт болохыгородох хэрэггүй….Хэрэв Кай Веррес ийм нарийн бөгөөд аюултай ажлыг чамд даалгасан болохоор энэ ажлыг дуустал бүтээж чадах хүн гэж чамд итгэсэн хэрэг байнха. Тэгээд чи мэдсэн бүхнээ хэлж байна. Нуух далдах юм бол бид чамайг уучлахгүй шүү гэхэд:

-Эдгээр хүмүүстэй хайш хэрэг байж үл болно. Үхэх аюул өөрөөс минь хэдхэн алхмын цаана байна гэдгийг Сильвий Кордений ойлгож, усанд үхэх гэж байгаа хүн, амиа аврахын тул ганцхан ширхэг сүрлээс боловч барьж авдагтай адил, аль байдаг бүхнээ

шударга илэрхийлэн өгч амь мэнд гарах аргыг сүвэгчлэхээр шийдэж мэдсэн бүхнээ гладиатиоруудад хэлж өглөө.

Ромын эсрэг бослого зохион гаргах зорилготой гладиаторуудын холбоо байсан юм байна гэдгийг Катилинын зочид хүлээн авах өрөөнд мэдэж авсан Кай Веррес, үхлээс айдаггүй зоригтой хүмүүс болох гладиаторууд өөрсөддөө хохиролгүйгээр ч барахгүй, харин өөрчдөд нь ашигтай байж болохуйц тэр ажлаасаа тийм хялбархан буцлаа гэдэгт үнэмшсэнгүй байжээ. Тэр нэгэн орой Катилинын зочид хүлээн авах өрөөнд бослогын тухай ямар нэгэн хүсэл санаагаа үүрд орхисон мэтээр Спартакийн хэлсэн үгийг Кай Веррес огт үнэмшсэнгүйгээр барахгүй нууц хуйвалдаан далдуур улам бүр өсч байна. Тэгээд ямар нэгэн өдөр гладиаторууд, патрицуудын тусламжгүйгээр өөрсдөө, бослогын тугийг мандуулна гэдэгт тэр бат итгэж байжээ.

Хэрэг явдал ийм байсан энэ үед, мөнгөнд хэтэрхий дуртай бөгөөд баяжиж л байвал ямар ч аргаар баяжсан хамаагүй гэж үздэг Кай Веррес чухам яавал дээр юм бэ гэж удаан бодсоныхоо дараа гладиаторуудыг сайтар тагнаж тэдний хуйвалдааны гшогцоо шижим бүхнийг мэдэж, сенатад мэдэгдье. Тэгвэл сенат намайг шагнаж, эсвэл их хөрөнгө өгөх байх, эсвэл нэгэн мужийн захирагч болгох байх. Тэгвэл би бусад квестор претор, проконсулуудын нэг адил албат иргэдээ зад мөлжиж хурдан бөгөөд их баяжих болно гэж боджээ. Учир нь биеэ худалдан бусдаас хээл хахууль авахад хэзээ ч бэлэн байдаг сенатын түшмэд дарлагдсагсдын гомдол хүсэлд зовж байсан удаа огт үгүй билээ.

Веррес хүссэндээ хүрэхийн тул гладиаторуудыг ажиж тагнан, тэдний төлөвлөгөөг мэдэх даалгаврыг өөртөө үнэнч зарц, шударга чөлөөлөгдч Сильвий Корденийдаа нэг сарын өмнө өгсөн байжээ.

Кордений нэг сарын турш тэсвэртэй явж гладиаторуудын олонтаа цугладаг газрууд болох Ром хотын аль хоосон ядуу районуудын гуанз, янхны газар мөн зуушийн газраар уйгагүй хэсүүчлэн явж зогсолтгүй ажиглан чагнаж, зарим нэгэн нууц яриа дохиог мэдэж, үнэхээр хуйвалдан байгаа аюул, түүний удирдагч нь Крикс мөн байна гэдэг дүгнэлттэй болсон байжээ. Иймийн учир Кордений нь Криксийг тагнан ажих болж галл язгуурын эрийн олонтоо ордог Венера Либитинийн гуанзанд зургаа долоон хоног өдөр бүр заримдаа өдөрт хоёр удаа ч ирдэг байжээ. Харин энэ орой энд бүлгийн дарга нарын хурал болно, үүн дээр Крикс байлцана гэдгийг мэдмэгц гладиаторуудын иржь, өрөөсөн нүдэт Лутациягийн анхаарлыг татах зуур залилан хоолны ширээн доор нуугдахаар шийдсэн байжээ.

Айн сандарч хоолой чичрэн ярьж байсан Сильвий Корденийн үгээ хэлж дүүрэхэд түүний үгийг их анхааралтай ажиглан сосож байсан Крикс нэг хэсэг дуугүй байснаа дуугарч

-Чи бол ховорхон муу этгээд юм аа! гэж их л тайван байдалтай хэлжээ.

-Сайн гаралт Крикс та намайг зохих хэмжээнээс хэтрүүлэн бүү үзэгтүн гэхэд нь Крикс:

-Үгүй чи бол харах царайнаасаа илүү юм хийж чадах хүн байнха. Харвал хонь шиг мөртлөө ухаан чинь нарий, алдар нэрийн төлөө чи заль ихтэй байна гэхэд нь:

-Гэвч би тан нарт ямар нэгэн муу ззүйлийг хийсэнгүй. Би эзнийхээ тушалыг л биелүүлж байсан юм. Та бүхэн миний үнэнч шударга илэрхийллийг анхааран үзэж, бас мэдсэн сонссон зйүлүүдээ хэнд боловч Веррест боловч хэлэхгүй гэж Олимпийн ба тамын бүх тэнгэрийн өмнө ам алдан хэлсний минь анхааран үзэж та нар намайг уучлан чөлөөтэй буцах бололцоог надад олгох байх гэж би итгэж байна гэлээ.

-Эрхэм Сильвий та бүү яар бид энэ тухай бас ярилцана гэж Крикс ёжлон хэлээд хэдэн гладиаторыг дуудаж ирүүлэн:

-Түр гадагшаа гарцгаая наадахыгаа харж бай. Харин гар хүрч болохгүй шүү гэж үлдэгсдэд хэлээд, Крикс өөрөө түрүүлэн гарч явлаа.

Гадна гарагсад Криксийг хүрээлэн огсож байсан нөхөд тийшээ харж:

-Энэ муу үл бүтэх амьтныг яах вэ?гэж асуулаа.

-Яах вэ гэдэг чинь юу гэсэн үг вэ? Тэр муугий чинь галзуу нохойг алахтай адил алж л орхихгүй юу? гэж Брезовир хэлэв.

-Түүнийг зүгээр явуулах юм бол өөрсдөө өөрсдийгөө ховлосонтой адил хэрэг болно гэж бас нэг нөхөр нь хэлжээ.

-Түүний амийг уучлан олзны хүн болгон авч байна гэдэг чинь бас  л аюултай хэрэг юм гэж гурав дахь нь хэлжээ.

-Хаанаа ч түүний чинь барьж байдаг мю билээгэж дөрөв дэх нь хэлжээ.

-Тэгээд түүни чинь алж орхих уу? гэж Крикс асуугаад нөхдийнхөө харцы нь ажиглан харлаа.

-Одоо шөнө орой болсон байна…

-Гадамжинд хүн амьтангүй байна…

-Бид түүнийг энэ гудамжны нөгөө үзүүрийн толгойн орой дээр гаргаад… гэтэл нь

-Mons sua vita nostra[1] гэдэг дөрвөн латин үгийг Брезовир харь газрын хүний ялгуугаар хэлж энэ зөвлөлгөөнийг төгсгөл болгожээ.

Энэ зүйтэй бизээ гэж Крикс хэлээд гуанзны хаалга чиглэн нэг алхсанаа зогсож,

-Тэгээд түүний чинь хэн алах вэ гэж асуулаа.

Нэг минут хир хэн ч дуугарахгүй байсны дараа нэг нь:

-Гартаа зэвсэггүй мөн эсэргүүцэл тавих чадалгүй хүнийг ална гэдэг чинь… гэхэд

-Хэрэв түүний гарт сэлэм байсансан бол… гэж нөгөө нэг нь өгүүлэв.

-Хэрэв тэр амьтан биеэ хамгаалж чадах юм уу хамгаалахыг ородохсон бол тэр даалгаврыг би авахсан гэж Брезовир өгүүлэв.

-Зэвсэггүй амтныг зүгээр очоод л зүсч хаяна гэдэг чинь гэж самнит язгуурын торкват хэлэхэд Криксийн сэтгэл хөдлөн:

-Та нар бол зориг чангатай, сайн гаралтай эрх чөлөөгөө олбол зохих хүмүүс ёстой мөн байна! Гэвч бүгдийнхээ эрх ашгийн төлөө өөрийн хашралыг ялж дарлагдагсдын холбооны тэр хүнд ноогдуулан, надаад хэлүүлсэн тэр ял шийтгэлийг та нарын хэн нэг нь гүйцэтгэх хэрэгтэй байна гэлээ.

Бүгдээрээ номхон зогсож толгой дохин бэлхэн байгаагаа илэрхийлэв.

Крикс үгээ үргэлжлүүлэн:

-Тэр чинь ямар бидэнтэй адил зэвсэг барьж ил тулалдахаар ирсэн хүн биш, тэр чинь тагнуул шүү дээ! Хэрэв  бид түүнийг нууц газар дарьж орхихгүй юм бол тэр биднийг хоёр цагийн дараа ховлож, бид маргааш Мамертинын шоронхд хоригдож хоёр хоногийн дараа Сессорын талд хэрээс модонд тэлэгдэх болно гэлээ.

-Тэр зөв, тэр зөв гэж хэд хэдэн хүн зэрэг хэлжээ.

Дарлагдагсдын холбооны шүүхийн нэрийн өмнөөс тэр хүнийг цаазаар авах явдлыг Брезовир, Торкват нарт би даалгаж байна гэж  Крикс хэлжээ.

Тэр хоёр гладиатор толгой дохиж Криксийн тушаалыг хүлээн авахад бусад нь Криксийг дагалдан гуанзанд эргэн орлоо.

Хувь заяа нь хэрхэн шийдвэрлэгдэхийг хүлээж байсан Сильвий  Корденний Веррес зогсолтгүй дагжин чичирч  минутын хугацаа түүнд зуун жил мэт урт санагдаж байжээ.

Тэр нь маш их айж Крикс ба түүний нөхдийн царайг ширтэн харж, сайн зүйлийг огт олж үзсэнгүйдээ царай нь хувьсхийн цайрав.

Нулимсаа асгаруулан:

-За тэгээд та нар амий минь уучлах уу? Амий минь орхих уу? … би… өвдөг сөгдөн та нарын эцэг, та нарын эх, та нарын дотнын хүмүүсийн амь насаар… тангараглан гуйяа… гэхэд царай нь барайж харлан аймшигтай болсон Брезовир ууртай хариулан:

-Одоо бидэнд эх, эцэг гэж үлдсэн юм байгаа юм уу гэлээ.

-Бидний хайртай юмнаас та нар юу үлдээж өгсөн билээ? гэж бас нэг гладиаторын нүд нь хорсол заналаар дүүрэн хялалзан асуулаан.

-Бас муу аймхай гэж Коркват зандарлаа.

Крикс, Кай Верресийн тагнуулын зүг харж:

-Дуугүй бай! Чи бидэнтэй явна. Энэ бяцхан гудамны адагт бид зөвлөлгөө хийж чиний заяаг шийднэ гэж зандарлаа.

Дуу бол бүх гудамжны хүмүүсийг босгуузай гэж түүнд сүүлчийн найдварын бяцхан шижим үлдээн өгч авч гарах дохио Крикс нөхөддөө өгөөд, амд хүнтэй адилгүй, харин үхсэн хүүр мэт болсон түүнийг дамжлан яваа гладиаторуудын хамт өөрөө гарч одов. Сильвий Кордений эсэргүүцсэн ч үгүй дуу ч гарсангүй билээ.

Хэрэглэсэн зүйлийнхээ үнийг Лутацияд төлөхөөр гуанзанд нэгэн гладиатор үлджээ. Лутация, сайхь гарсан, хорин гладиаторын дунд будаа наймаалагчийн гарахыг ажсангүй хоцорчээ. Гладиаторууд гуанзнаас гармагц баруун гар тийш эргэж шавхайтай нарийн гудамжаар явжээ. Энэ гудамж нь хотын хэрмийн дэргэд төгсдөг бөгөөд түүнээс цааш задгай газар болдог байжээ.

Тэд нар энд ирж зогслоо. Сильвий Кордений өвдөг сөгдөн уйлж гладиаторуудын өрөвдөх сэтгэлийг дуудав.

Арчаагүй амьтан аймхай муу чи, адил зэвсэг барьж бидний нэгэнтэй тулалдахыг хүснэ үү? Гэж Брезовир сэтгэл санаагаар унасан тэр тагнуулаас асуув.

-Үр хүүхдийн минь төлөө миний амийг өршөөхийг гуйя… намайг өрөвдөн энэрч хайрла гэжээ.

-Бидэнд хөвгүүд байдаггүй! гэж глади аторуудын нэг нь зандран хашгирав.

-Бид хэзээ ч үр хүүхэдгүй байхаар шийтгэгдсэн хүмүүс юм гэж нөгөө нэг нь архирав.

-Чи нууган тагнаж чадахаас биш үнэнчээр тулалдаж чаддагүй гэж үү? Гэж Брезовир тэсч ядан асуулаа.

-Амь өршөө… амий минь өршөө, би та бүхнээс амиа гуйна гэхэд нь Брезовир богино сэлмээ түүний цээжинд нэвт зоож

-Ингээд аймхай муу чи тамдаа оч! Гэжээ. Самнит гарлын Торкват унасан түүнийг хоёр удаа цавчиж:

-Нэрээ гутаасан үл бүтэх боол бүгд чинтй хамт үхэх болтугай гэж хараажээ.

Гладиаторууд үхэж байгаа хүнийг тойрон бодол болон хөдлөлгүй зогсож сүүлчийнхээ амьсгалыг хураахы нь ажиглан харцгааж байжээ.

Брезовир, Горквит хоёр мэлмүүдээ хэдэн удаа газар хатгаж, наалдсан цус хатахаас нь өмнө арилгаад хуйнд нь хийлээ.

Харин гладитор хүнгүй гудамжаар даруу номхон үг дуугүй явсаар Ром хотын шуугиантай гудамжинд хүрэв.

Дөнгөж саяхан ярьсан хэрэг явдлын болж өнгөрснөөс найман хоногийн дараахь өдрийн үдэш анхны бамбар асах үеэр Аппиевын зүгээс нэгэн морьтой хүн гарч ирээд,

Капуягийн хаалгаар Ром хотноо орж очлоо. Энэ хүн хотын гудамжуудыг хэдэн цагийн турш усалж байсан ширүүн борооны уснаас биеэ бага зэрэг боловч хамгаалахын эрхээр эвхрэн цувандаа шигджээ. Унасан эзэн, униулсан сайн угсааны морь нь урт замын аянд тамирдан амьсгаадаж хөлрөн бас толгойноос аваад хөл хүртэл шавхай болсон байжээ.

Удалгүй энэ хүн гэгээн гудмжинд хүрч Эвтибидагийн суудаг байшингийн дэргэд зогсов. Энэ хүн мориноосоо үсрэ нбууж, хаалганы дэргэд хүрээд тэнд байсан хүрэн дохиурыг шүүрэн авч түүгээр хаалгыг хэдэн удаа чанга цохисонд Ром хотын байшин бүхэнд заавал байдаг манаач нохойн хуцах чимээ гарах нь сонсогдов.

Хэдэн минутын дараа энэ хүнд хаалгачийн алхлан ирж яваа чимээ сонсогдлоо. Хаалгач хаалгаа нээхээр яаравчлан очиж чимээгүй бол гэж өндөр дуугаар нохойдоо тушаана.

-Сайн Гермоген минь! Тэнгэр чамд сайн ерөөлөө ивээх болтугай, би Метробий байна. Кумаас ирлээ гэхэд нь:

-Мэнд сайн явж ирсний баярыг хүргэе гэж тэр хариулжээ.

-Би загас шиг болтлоо бороонд нэвтэрлээ. Борооны тэнгэр Юпитер усан хаалтуудаа хэрхэн ажилладгий нь надад үүзүүлж зугаацахаар шийдсэн юм байхдаа гээд

-Чи зарц нарын нэгийг дуудаж ирүүлээд, хөөрхий энэ морийг зэргэлдээ байгаа гуанзны морьдын жүчээнд аваачуулж овъёос тэжээл өгүүл гэж хаалгачид тушаажээ.

Хаалгач баруун гарын дунд хуруug эрхий хуруугаар тулж хөвчлөн мулталж алган дээрээ тогшиж чимээ гарган, боол дуудаад /боолыг дуудан ирүүлэх дохио нь ийм байжээ/ өөрөө Метробийн морийг цулбуурдан авч:

-Метробий минь орогтун! Чи өөрөө энэ байшингийн дотоод байгуулалтыг мэднэ биз. Ноёгтойн аягач Аспазия галерейн дэргэд байгаа тэр, чиний ирсэн тухай ноёгтойд айлтгана биз, морий чинь би аргалъя чиний тушаасан бүхэн биелэгдэнэ гэлээ.

Метробий хальтарч унахгүйн тул их болгоомжлон босго алхаж оржээ. Хальтарч унах гэдэг бол хамгийн муу билэг тэмдэг байхсан билээ. Үүдний тасалгаанд ороход нь таазнаас дүүжлээстэй байгаа хүрэл дэнлүүний гэрэлд, гэгээтэй шилэн дээр salve[1] гэсэн ердийн бичиглэл үзэгдлээ. Зочдыг цааш алхмагц хананд өлгөөстэй байсан тор дотор байгаа тоть шувуу мөн тэр үгийг бас давтаж хэллээ. /энэ үеийн ёс журам ийм байсан ажээ./

Үүний зай дараа нь атриумийг өнгөрч зургийн үзэсгэлэнгийн ордны гудамд оржээ. Миний ирсэн тухай чи Эвтибидад айлтга гэж аягач хүүхэнд тушаав.

Энэ үед Эвтибида өвлийнхөө байрны зочид хүлээнавах тасалгаанд байсан бөгөөд түүний хөлийн дэргэд нэг залуу сууж бүсгүйд дур сэтгэлээ илэрхийлэн тоочиж байжээ.

Эвтибидагийн хүлээн авах тасалгаа нь үнэтэй хэрэглэлээр чимэглэгдсэн үнэртэн ханхлуулсан өрөө байлаа.

Эвтибида, залуугийн зөөлөн хар үсийг таван хуруугаар онгичиж байхад, нөгөө залуу нь дурлалын дөл бадарсан харцаар бүсгүйг ширтэн, хонгор сэтгэлээ түүнд илэрхийлж байжээ. Энэ залуу нь Тит Лукреций Кар гэдэг хүн байжээ.

Хүсэх хүслээ хангах чигт хандан тэмүүлэхийн цагт ухаан балартан хүсэх нөгөө л зовлон дахин эргэж ирдэг билээ гэсэн Эпикурын номлолд бага наснаасаа нэвтэрсэн энэ залуу байнгын ноцтой дурлалыг мөрөөддөггүй харин шинэ дурлалын сумаар хуучин дурлалыг түрж зайлуулахын тул түр зуурын хүсэл дурлалыг мөрөөддөг хүн байжээ.

Энэ хүн хожим дөчин дөрөвтэйдөө амиа хорлож үхсэн юм. Хүмүүсийн таавaрлан ярилцахыг сонсвол, өөрөө хэтэрхий дурласан боловч түүнд дурлахгүй хэлтгий дурлалтай тулгаран давж чадахгүй болсон учир амиа хорлосон биз гэдэг билээ.

Лукреций нь бусдын дурыг татахуйц сайхан залуу бөгөөд ухаан сэргэлэн, хөрөнгө зарахаас гар татдаггүй хүн юм.

Энэ залуу Эвтибидагийн гэрт цаг өнгөрүүлэхээр олонт ирдэг байжээ.

Хурц хурдан үгтэй ярилцахад таатай түүнийг Эвтибида ч бусдаас улам дотно таалалтай хүлээн авдаг байжээ.

Сээтэн хүүхэн түүний үсээр тоглон:

-Чи тэгвэл надад хайртай байх нь ээ? Чи надаас уйдахгүй байна уу? гэж аальгүйтэн асуухад

-Би чамд улам хайртай болж байна. Учир нь янаг дурлал гэдэг бол хүрч эзэмших тутам, хүсэл сэтгэлийн дөлийг цэжинд улам бүр шатаадаг ганцхан зүйл мөн юм гэлээ.

-Хэн бэ? гэж Эвтибидагийн асуухад Аспаиягийн зөөлөн дуу сонсогдон: -Метробий Кумээс ирлээ гэж хариулжээ.

-Аа тийм үү? Гэж Эвтибида баясгалант дуугаар хэлээд бандан дээрээсээ шалав босч, царай нь хувьсхийн улайж Метробий ирсэн гэнэ?… түүнийг өрөөнд оруул би одоохон очно гэлээ.

Эвтибида Лукрецийн зүг хандаж их л янаг зөөлөн боловч яаран сандарсан дуугаар:

-Чи намайг эндээ хүлээж бай… би одоохон буцаад ирнэ. Хэрэв тэр хүний олж ирсэн мэдээ, миний найман өдрийн турш тэсгэлгүй хүлээж байсан мэдээ мөн байгаад өнөө орой үзэн ядах өшөө хорслоо авч чадах бол их баярлана. Тэгээд баяр хөгжлий минь зарим хэсэг чамд ноогдох болно гэж хэлээд сэтгэл их л хөдөлгөөнтэй болж, хүлээн авах тасалгаанаасаа гарч явлаа. Залуу нэг талаас гайхан сонирхож бас дургүйцсэн байалтай хоцорчээ.

Залуу толгой сэгсрэн их юм бодож тасалгаан дотуур өөд сөөргөө алхлав.

Гадаа хүчтэй салхи салхилан ахин дахин цахилах аягийн гэрэл хүлээн авах өрөөнд дүүрч бас үргэлжлэн дуугарах тэнгэрийн дуу байшинг донсолгон ширүүн бороо мөндөр орох ер бусын хүчтэй чимээ тэнгэрийн дууны завсар сонсогдон умарт зүгийн хүчтэй салхи галзууран оволзож, байшингийн цонх хаалгын онгорхрой цоорхой бүхнээр чих дөжрөм шуугин гасалж байлаа.

-Цадиг замбараагүй бөөгнөрөгсдийн тэнгэр Юпитер эвдлэн сүйтгэх хүчин чадлынхаа нэгэн хэсгийг үзүүлэн зугаацаж байгаа нь энэ бизээ гэж залуу аман дотро үгүүлэн үл мэдэг инээмсэглэжээ.

Тасалгаан дотуур бол нилээд хэсэг явж байс наа энэ болж байгаа цаг бусын тэмцлээр хүрч ирсэн мэдрэх сэтгэлийн хүчинд автагдсан мэт болж бандан дээр суугаад уран хийцтэй бичгийн шүүгээн дээр байсан хэдэн жижиг самбарын нэгийг авч түүн дээр төмөр хушуутай мөнгөн үзгээр хурдан бичиж гарлаа.

-Энэ үед Эвтибида хүүхэн өрөөндөө хүрэлцэн очжээ. Тэнд Метробий гуньсан байдалтай цувныхаа энгэр талыг харж байжээ. Сээтэн хүүхэн гадагш гарахаар завдаж байсан шивэгчин бүсгүйг дуудаж:

-Чи задгай зууханд их гал түл, хувцас бэлд, манай Метробий хувцсаа солиг, зочид хүлээн авах тасалгаанд олигтой хоол бэлд гээд төдхөн Метробийн зүг эргэж:

-За яав? Метробий минь сайн мэдээ авчрав уу? гэлээ.

-Хүнээс сайн мэдээ олж ирсэн боловч харин замаасаа хамгийн саар мэдээ сонсож ирлээ гэхэд нь:

-Тийм байна, тийм байна, хөөрхий алдарт Метробий минь. Галд ойртож суу гэж хэлээд сандал дөхүүлж өгчээ.

-Хүссэн баталгаагаа олж ирж чадав уу? Шалавхан хэлж аль гэлээ.

-Алт минь, хамгийн сайхан Эвтибида минь, чиний мэдэж байгаа ёсоор Данайн цамхгийн хүрэл хаалгыг Юпитер нээж өгсөн байна гэжээ.

-Чи дэмий юм донгосохоо болихгүй юу?… саяны чиний шумбан орсон усан онгоц дэмий донгосох дуу хүслийг дарж чадсангүй юу? гэж Эвтибида асуулаа.

-Би нэгэн шивэгчин эмийг хөлслөн авч хаалганд бяцхан нүх гаргуулж тэр нүхээр ажиглан Спартак Валериягийн тасалгаанд хэдэн удаа эр тахиа донгодох үеэр орж байхы нь харлаа гэхэд Эвтибида зэрлэр араатны баяраар баярлана.

-Ээ тийм үү, тамын тэнгэр надад туслах болтугай гээд нүүр царай нь хувиран улангассан охин барс шиг болж Метробийг сэгсчин:

-Урвагч муусайн тэд нар… өдөр бүр… тэгж… Суллын шударга нэрийг гутааж байдаг байжээ гэлээ.

-Миний бодвол тэд хэтэрхий дурлалдаа автагдан ганц бор хоногийг боловч зүгээр өнгөрүүлдэггүй бололтой гэж Метробий хариулжээ.

-Зүгээр одоо тэдэнд ёстой л бор өдөр нь ирнэ дээ! Би тэдний буруудсан толгойнууды нь тамын тэнгэр зориулна! Гэж Эвтибида их л баяртай хэлээд гадагш гарахыг завдатлаа зогсож Метробий тийш харж:

-Чи хувцсаа сольж өмсөөд, зочид хүлээн авах өрөөнд хоол идээд тэндээ намайг хүлээж байгаарай гэлээ.

Алиа жүжигчин зочдын өрөөнд орж хувцсаа сльж өмсөхөөр явж байхдаа “би ямар нэгэн муу хэрэгт хутгалдан орохгүй юмсан” гэж бодож явжээ.

Гэвч хувцсаа сольж өмсөөд элбэг арвин бөгөөд амттай хоол, фалернын дарс бэлдэж тавьсан тасалгаа руу орох замдаа санаагаа өөрчлөн хортой мэдээ ирсэн саяын аяллы тухай ба бас ойртож ирж яваа аюул заналын зөн билэн мэтээр сэтгэлдээ орж ирж байгаа муу зөн билгийг мартах гэж оролдсон юм.

Метробий цадатлаа хоол идэж амжаагүй байтал нь Эвтибида хуйлсан цаас гартаа барьж зочид хүлээн авах өрөөндөө орж иржээ. Түүний царай хувхай цагаан болсон боловч байдал төлөв нь түвшин байжээ. Тэр хулдаасыг олон өнгийн будагтай нимгэн цасаар давхар ороож хоёр үзүүрий нь лааны тосоор лацдаж, олсон утсаар боож бөгжөөр тамгалсан байжээ. Эвтибидагийн бөгжитн тамга нь алайн хөөснөөс гарч байгаа охин тэнгэр Венераг дүрслүүлсэн тамга байжээ.

Эвтибидагийн гэнэт орж ирсэнд бага зэрэг гайхсан Метробий

-За хамгийн сайхан Эвтибида минь… би хүсэж байна… би мөрөөдөж байна… наад захидал чинь хэнд очих захидал вэ? гэлээ.

-Чи бас хэнд очих захидал вэ гэж асууна уу? Луций Корнелий Суллад очих захидал гэлээ.

-Ээ Мом тэнгэрийн багийг дуудан ам алдъя! Бид энэ хэргийг ингэж яаруу шийдвэрлэх хэрэггүй байна хүү минь глээ.

-Манай шийдвэр гэнэ үү чи? Үүнд чи ямар холбогдолтой юм? гэж Эвтибидагийн хэлэхэд

-Тэгэлгүй яахав. Бүгдийг ялгуулагч их Юпитер надад туслах болтугай?… түүний дотоод хэрэгт хутгалдан оролцсон явдал Суллын санаанд тохирохгүй бол яахав?… хэрэв өөрийнхөө гэргийг хараан занаж, үзэхийн оронд хов хүргэсэн биднийг занаж үзвэл яахав?… бүүр болиод бид бүгдийг занаж үзвэл яанаа?… энэ бол магадгүй хэрэг байгаа юм гэж Метробий хэлжээ.

-Яах нь надад ямар хамаатай юм? гэж Эвтибидагийн хэлэхэд:

-Тэгээд охин минь ээ. Суллын уур хилэн чамд хамаагүй боловч надад маш их холбогдолтой юм шү гэж Метробий хэлжээ.

-Чиний тухай хэн бодсон юм? гэж Эвтибидагийн хэлэхэд Метробий яаравчлан:

-Хүн бүхэн, тэнгэр бүхний таалал болсон Эвтибида минь ээ, би чамд хэтэрхий хайртай байдаг юм гэлээ.

-Чиний нэрийг би захидал дотроо огт дурдсангүй… иймийн учир тохиолдож болзошгүй бүх зүйлээс чи хэзээд гадна байх болно гэлээ.

-Их сайн байна…. би ойлгож байна… охин минь ээ би Суллын хамгийн дотно сэтгэлийн нөхөр болсоор гучин жил болсон юм  шүү гэж Метробий хэлэхэд:

-Тимээ, би тэрий чинь мэднээ сайн алдар олохын төлөө бол чи хэрэглэгдэх хэмжээнээс хэтэрсэнхдотно сэтгэлийн хүнх л дээ… гэлээ.

-Тэр чухал биш ээ… олон жил нөхөрөлөсний хувьд би тэр араатны чинь… үгүй тэр хүний чинь сайн мэдгнээ. Тэр чинь миний толгойг тахианы толгой хуга мушгиснаас хялбар хуга мушгиж орхиод хүүрий минь хамгийн хүндтэй ёсоор арван таван глаиаторыг тулалдуулах ёслолоор оршуулахаас огт буцахгүй хүн байгаа юм. Тэгвэл мини й хувь заяа дутаж тэр ёслолыг би өөрөө үзэж чадахгүй болно шүү дээ гэлээ.

-Бүү ай, бүү ай, чамд ямар ч аюул тохиодохгүй гэж Эвтибида хэлжээ.

Энэ үед замын  хувцас өмссөн нэгэн боол Эвтибидагийн зочид хүлээн авах өрөөнд орж ирлээ.

-Демофил аа, минтй зааврыг санаж явах хэрэгтэй. Зума хүртэл зам зуур саатаж огт болохгүй шүү гэж Эвтибида хэлжээ.

Боол Эвтибидагийн гараас захидлыг авч цамц хүрэм хоёрынхшоо завсар хийж түүнээ бүслэхийгээрээ олсоор бүслээд эзэн авхайдаа мэхэсхийн ёслоод гадагш гарлаа.

Өөрийнхөө болгоомжлолын тухай дахин ярих гэж шийдэж байсан Метробийд, маргааш хоёулаа уулзана гэж хэлж түүнийг тайвшруулан Эвтибида зочид хүлээн авах өрөөнөөсөө гарч нөгөө өрөөндөө түргэн буцлаа.

Тэнд Лукреций гартаа бяцхан самбар барьж түүн дээр бичсэн зүйлээ уншихаар завдаж байлаа.

-Чамайг ганцаарангий чинь орхиё гэж бодсон хугацаанаасаа хэтэртэл удсаны минь бурууг надад хүлээлгээрэй!

Харин цагаа дэмий үрсэнгүй байх шив дээ. Энэ шүлгээ надад уншиж өгнө үү? Чиний сэтгэлийг зөвхөн шүлгээр, тэгэхдээ ямар нэгэн шүлгээр биш харин сайхан шүлгээр тодорхойлж болох бизээ гэлээ.

-Чамайг болон гадаа догширч байгаа салхийг санаж энэ шүлгий би зохиолоо. Иймийн учир үүнийг одоо би чамд уншиж өгөх ёстой. Тэгээд буцаж харих замдаа салхинд унхшиж өгнө гэлээ.

Аймшигт салхин далайн усыг давалгаалуулан
Асар том хөлөг онгоцыг эвдлэн, агаарын үүслийг хуйлруулан намнана
Эс бол тэр тал газраар довтлон хуйлран оволзож шуурна.
Эс бол тэр онгон уулын модыг орвонгоор нь булгална.
Ой модыг боловч онгичин, сэгсчин шуурна
Оволзон шургалж галзууран аймшиг хөнөөлөөр довтолдгий нь үзвэл
Огторгуйн салхи овор биетэй боловч нхүдэнд үл үзэгдэнэ.
Ухасхийн боссон хүчээрээ далай дэлхий донсолгож
Огторгуйн үүлсийг ч хуйлруулан бөөгнөрүүлэн намнадаг байна.
Учирсан бүхнээ сүйтгэлгүй өнгөрч ер чаддагүй байна.

Устай адил зөөлөн биетэй боловч
Үерийн борооны урсгал шиг аймшигт хүчээр довтлон
Өндөр уулын оройгоос өнхрөн бууж ирээд
Унанги модыг урсган ургаа чулууг хэлтлэн
Үнэхээр бат гүүрийг ч эвдэлдэг байна.
Агшинд боссон ус эргэлдэж ширүүн урсдаг
Аадраар гарсан урсгал эрэг гангыг ч дэлбэлэн ингэж сүрхий довтолцдог
Бул хар чулууг ч бутлан бүхнийг эвдэн довтолдог
Бүх зүйлийг хамран үгүй хийж урсгалдаа татаж аваачдаг
Хүчтэй салхи шуурга яг үүнтэй адил
Хүрхрэн урсах усны урсгал мэт дайралдсан бүхнийг сөнөөн эвдэж
Ахин дахин оволзон нөөлөглөж аюулт хуй болон босож
Аль дайралдсаныг хамран шүүрээд хийсгэн дэгдээж явдаг гэж уншив

Эвтибида нь грек хүүхэн юм гэдгийг бид дээр өгүүлсэн билээ. Иймийн учир энэ шүлгийн яруу найргийн хүч чадлыг шагшин гайхах сэтгэл түүнд төрөхгүй байж чадсангүй. Энэ хир лат хэл төдий л баян биш байсны дээр Энний, Плавт, Луцилий, Теренций нараас өөр алдартай шүлэгчид үгүй байсан учир Эвтибида хүүхэн чин сэтгэлийн угаас Лукрецийн энэ шүлгийг гайхан магтаж хэлсэнд шүлэгч байрнаасаа босч явах ёслолоо үйлдээд хариу болгож,

-Чи миний шүлгийг магтан сайшаасан тул энэ бяцхан самбараа надад өгөх болно. Би үүний чинь аваад явлаа гэжээ.

-Бичсэн шүлгээ цаасан дээр  хуулж авсныхаа дараа самбараа эргүүлэн надад авчирч өгөөрэй гэж Эвтибида хэлжээ.

Эвтибида хийсэн бүх хэрэг явдлаа сайтар сэнхрүүлэн бодох бас өшөөгөө авсандаа сэтгэл амрах гэж Лукрецийн явсны дараа зочид хүлээн авах өрөөнөөс гарч Аспазияг дагуулан унтах өрөөндөө очлоо. Тэсгэлгүй хүлээж байсан зүйл нь бүсэн боловч Эвтибидагийн сэтгэл дүүртэл ханасангүй. Юуны учир сэтгэл бүрэн хангагдсангүйгээ Эвтибида өөрөө ч үл мэднээ. Явуулсан тэр захидалдаа чухам юу гэж бичсэн билээ. Захидлын үг ямар дүнд хүрэх билээ гэдгийг Эвтибида эрэгцүүлэн боджээ. Уурлан хилэгнэсэн Сулла шөнө орой болтол хүлээж, дурлалцсан тэр хоёрыг ажиж байгаад тэврэлцэн таалалцаж байх үед нь шүүлэн авч хоёулыг нэгэн зэрэг алж ч болно гэж түүнд бодогдлоо.

Өөрөө ариун биш явдалтай боловч намайг хялайн доромжилж үздэг, их зантай, хэрцгий муу эм Валерия чамайг нэрээ хугалан алагдсан тухайг би удахгүй сонсох байх аа. Тэр муу зусарч ихэмсэг эмийн алагдсан тухай би сонсох байхдаа гэж бодоход нь Эвтибидагийн сэтгэлийн зовлон намдаж урьдын хэвээр хардаж байсан дотор нь бага бловч тайтгарч байлаа.

Харин Спартакийн тухайд Эвтибида дээрхээс эрс өөр зүйлийг бодож байжээ. Спартакийн гэмт явдлыг уучлах шалтгааныг олохыг оролдон бодож үзтэл хөөрхий тэр фракий эрийн хийсэн хэрэг Валериягийн хийсэн хэргийг бодвол өчүүхэн бага мэт санагджээ. Ерөөс бодож үзтэл Суллын гэргий сайхан муухай ямар боловч ядуу хоосон рудиарий эрд охин тэнгэр мэт санагдах нь ззүйн хэрэг. Харин тэр завхай эм түүнийг эрхлүүлэн биедээ татсанд, хөөрхий тэр амьтан биеэ барьж чадаагүй байлгүй яахав … тэгсэн л байж таарах байлгүй яахав. Түүнээс биш өчүүхэн гладиатор яаж Суллын гэргийд халдаж чадах билээ. Хөөрхий Спартак анх ингэж тэр энхнэрийн дурлалыг эзэмшээд дараа нь өөрөө түүнд хүчтэй дурлаж бусад ямар нэгэн эхнэрт дурлах тухай бодож ч чадахгүй

болсон нь тэр балйгүй гэж мэтчилэн Эвтибидагийн санаанд оржээ. Иймийн учир Спартакийн амь үрэгдэх явдал шударга бус зүйл мэт бас түүнд санагджээ.

Элдэв үйл, эсрэг тэсрэг зүйл сэтгэл санаанд нь хутгалдан орж Эвтибидагийн нойр хүрсэнгүй. Орон дотроо тийчигнэн хоёр хажуугаа сэлж байсан боловч ядарсан учир үе үе зүүрмэглэж байжээ.

Ингэж байтлаа Эвтибида гэнэт айн цочиж орноосоо босон харайж ирээд:

-Үгүй Спартак минь би чамайг алж байгаа хэрэг биш! тэр чинь чамайг алж байгаа нь энэ.. чи минь үхэхгүй… гэж зангирсан дуугаар бархирав.

Энэ нь өрөвдөх сэтгэлээ илгээхийг мөрөөдсөөр үхэж байгаа Спартакийн дүр ганцхан зүйлийн тухай үгширтэл бодсоор хоромхон зуур зүүрмэглэсэн Эвтибидагийн зүүдэнд орсон бизээ.

Эвтибида өргөн цагаан нөмрөг нөмөрч орноосоо босч Аспазияг дуудаж ирүүлээд чи Метробийг сэрээж авчир гэж түүнд тушаажээ.

Одоогоос гуравхан цагийн өмнө Демофилаар явуулсан захидлаа Суллынх гарт хүрэхээс нь урьд эргүүлж авчруулахын тулд Метробийг Демофилын хойноос чухам ямар арга хэрэглэн мордуулсныг бид энд бичихгүй.

Замд явж ядарсны дараа хэтэртэл уусан дарсандаа цохигдон унтаж, өдөн хөнжлийн дулаанд бие нь тавьж байсан Метробийг хоёр цагийн дараа замд дахин мордуулахын тулд Эвтибида багагүй арга мэх, чадвар хэрэглэсэн юм.

Демофил чамаас таван цагийн түрүүнд явсан учир морины хурдаар явах төдий биш харин хисэх мэт явах хэрэгтэй гэж Эвтибида Метробийд захижээ.

-Миний морь хэрэв жирийн морь биш далавчит морь байсан бол би түүнийгээ нисгэх байсан гэж Метробий хариулжээ.

-Тэгвэл хожмоо чамд ч бас сайн болох юм шүү гэж Эвтибида хэлжээ.

Ингээд хэдмэн минутын дараа хар хурдаараа давхисан морин туурайн чимээ Квиранын хөвгүүдийн заримыг сэрээжээ. Сэрсэн хөвгүүд морин туурайн чимээг хальт мөлт сонсож энэ шөнө орой болсон хойно нэвт шувт шуурч байгаа салхин дундуур, хээр задгай газар явах хэрэгтэй болсон заяа муутай хүн олон байдаг байхдаа гэж бодон дулаан хөнжилдөө шурган хэтэж байх нь тэдэнд маш сайхан санагдаж байжээ.

---

[1] Хуйвалдаанд оролцоогүй гадны хүнийг байхад буюу мөн гладиаторуудын сургуулиудаар завсар-чөлөөтэй ярилцаж байхын тулд гладиаторуудын зохиосон нууц ярианы үг бөгөөд Нар гэдэгнь агуу их багш буюу Спартак гэсэн үг.
[2] Тушаал ирээгүй хэвээр л байна.
[3] Хуйвалдагчид
[4] Бослогын дохио
[5] Ромынхон
[6] Манай талынхан хэд болж байна.
[7] Анхаараарай! Ямар хүн ирэв гэсэн үг
[1] Хаалгаа хаа гэсэн дохио
[2] Тагнуулыг барья гэсэн дохио
[1] Түүний үхэл бидний амьдрал
[1] Баяр хүргэе

## ДЕМОФИЛ БА МЕТРОБИЙ НАРААС ҮХЭЛ УРЬТЖЭЭ.

Ром хотоос Капуягийн хаалгар гарч Аппиевын замаар явж Капуя хүрээд тэндээс Кумын зүг эргэсэн хүн, үзэсгэлэнт сайхны хувьд үнэхээр гайхалтай газрыг үзнэ. Үүгээр явсан хүний нүдийг жимст сайхан цэцэрлэг цэцэглэж байгаа оливын ба амтат жүржийн модтой толгод, олон хонь, үхрийн билчиж яваа ногоорон харагдах нуга ба шарлаж байгаа үржил шимтэй бургас эрхбиш татна.

Энэ анхилам сайхан үнэртэй үзэсгэлэнит сайхан газраас бага цаашилбал, далайн хөвөө болж, түүн дээгүүр, ид шидээр аяндаа бүтсэн юм шиг, Литернум, Мизенум, Кумы Баин, Путеслы, Неаполь, Геркуланум болон Помпей мэт хотууд зэрэгцэн орших бөгөөд үзэсгэлэнт сайхан орд харш, өргөө гайхамшигт сайхан орон байшин , үнэхээр сайхан ширэнгэ сөөг, олон тооны тосгон , нуур байна. Эндээс бас цаашилбал янаглан тэвэрч байгаа юм шиг үзэсгэлэнт сайхан эрэг хөвөөн дотор талимааран дуниарсан цэв ц энхэр устай тогтуухан далай байна. Мөн далай дотор гайхалтай сайхан. Орд харш орон байшингаар дүүрсэн элбэг дэлэг ургамалтай Исхияг , Прохита ,Незис , Каприе гэх мэт олон арал холооё харагдана. Энэ хязгааргүй сайхан орон нутгийн наран мандлын хурц гэрэл гийгүүлж , бүлээхэн слахины зөөлхөн үлээлт илбэж байжээ . Тэр өдрүүдэд үхэгсдийн сүнсийг , Елисейн төлд аваачдаг Харон, заавал энд завьтайгаа хүлээж байдаг байх гэдэг сэтгэлийг энэ үнэхээр сайхан газар нутаг хүмүүсийн дотор санагдуулсан нь санамсаргүй хэрэг бишээ . кумы нь олон хүнтэй баян тансаг хот юм . Түүний зарим хагас нь эгц хажуутай уулан дээр нөгөө хагас нь налуу бэл ба далай хөвөөний тэгш тал газар байдаг. Энэ нь хүмүүсийн хамгийн олноор ирж очиж байдаг хотын нэг юм . далайн усанд ору сэрззцэх цаг сан бол энд ромын патрицууд өдий төдийгөөр байх сан билээ . Патрицуудын дотроос далайн хөвөө дээр өөрийын ордонтой нэг ньв хавар намрын хагасыг

энд дуртайя өнгөрүүлдэг юм . иймч учраас тэр үед ромын баян чинээдэг, эрхтэн ямбхатан хүмүүсийн өөрсддөө кориулан хийлгэсэн гоё сайхан, тохилог тухлаг кэрэг нь Кумыд байдаг ажээ . Кумыд портик, базилик форум болон цирк, мөн аврага том амфитеатр (эн. Амфитеатрын балгас одоо хүртэл тэнд байдаг юм) байдаг байжээ . Бүх Италийн дотор хамгийн гоя сайхан баян чинээлэг ордны нэг болох Аполлогн тэнгэрт зориулсан маш сайхан орд Акропольп уулын орой дэр байпаг юм . Кумээс холгүй газар% далайн булан ба эргэн тойрны хөвө илхэн харагдюаж байдаг нэгэн сайхан толгой дээр , Луций Корнелий Суллын агуу сайхан орд харш байна.

Бусдад гайхуулдаг ухаан билэг баялаг бөгөөд өвөрмөц санаачлага чад ах бүхнээ хир хэмжээгээрээ Суллаа энэ орд харшийг бариулахдаа гаргаж хэрэглэсэн юм . Энэ орд нь толгойн оройгоос аваад далайн хөвөө хүртэл үргэлжилжээ . Бас энд тэжээмэлд загас агуулж байх тусгай байр далай хөвөөн дээр байгуулж тэнд байхдаа загасуудыг тусгай хүн харж байг гэж Сулла тушаасан байжээ .

Түүний энэ орд байшин нь Ромд боловч хамгийн сайхан байшинд тооцогдмоор бөайжээ .

Энэ байшингийнхаа дотор халуун , хүйтэн , бүлээн гэх зэрэг янз бүрийн устай тавин хэсэгтэй , бие угаах онгоцны тасгийг гантигаар хийжээ . Суллын зуны ордон нь тусгай хашаатай , хашаан дотроо дүүрэн цэцэг бас жигүүртэн шувуу бүхий таримал цэцэрлэг , мөн зулзаган модны цэцэрлэгтэй ажээ. Бас энэ цэцэрлэгийн нь дотор буга согоо , гөрөөс, үнэг гэх зэрэг янз бүрийн ан амьтан байдаг байжээ .

Бидний одоогийн бичиж байгаа хэрэг явдлаас хоёр сарын урьд Ромын аймшигт бүгдийг ноёрхогч их дарангуйлан захирагч хувиараа тусгаарлан суухаар таалж , энэ үзэсгэлэнэт сайхан газраа ирсэн байлаа .

ЁСулла энд байх үедээ энэ үед Митридатынхантай зоригтой тулалдаж байсаг агуу их бас баян Луций Лициний Лукуллд өгөх

“Заавар зөвлөгөө” төлөвлөн түүнээ эрэгцүүлэн болож өдөр өнгөрүүлдэг бай лаа . Лукуллын алдар нэр , үеийн үед дамжин ирсний учир бол түүний байгуулсан гавъя зүтгэлийн ач биш харин толж барамгүй баян хөрөнгө , нарийн нандин эд хогшлын нь ач байсан юм . Сулла нь өөрийнхөө найз нөхөдп болох алиа наадамч хүмүүс хошин жүжигчдийнхээ хамт садар завхай найр наадмаар шөнө бүрийг өнгөрүүлдэг байсан бөгөөд шөнийг өнгөрүүлсэн ширээнийхээ ард согтуу нойрмоглож байх үед нь өглөөний нар гардаг байсан юм .

Үүний урьдах бүлгийн төгсгөлд бичсэн хэрэг явдлын болсноос гурав хоногийн дараа Сулла агуу том гантиг ордныхоо албан хэргийн дөрөв танхимын аль том сайхан нь болох Дельфийн Аполлоны нэрэмжит албан танхимдаа оройн хоолны ширээ засах тушаал өгчээ .

Булан бүхэнд нь хурц гэрэлтэй бамбар асаж, Сайхан үнэрээ тархаагч цэцгүүд дүүрэгн байсан том танхимын дотор найр хэвийн байдлаар эхэлж , нүцгэн бие хувцасныхаа завсраар улалзуулан янагийн дөлийг , бүрээний хөгжилтэй дуу, хангинан найр нь хумих жолоогүй үймээн болон хувирчээ. Энэ асар том танимын дотор хорин зургаан хүн есөн ширээний ард наргиж байжээ . Харин энэ найран дээр Суллын хайртайы нөхөр Метробийн суудал хоосон байлаа . Дарангуйлан захирч агсан Сулла хоол идэх үед өмсөх цэв цагаан хувцастай , саргай цэцгэн титэмтэй , дунд талын ширээний арын голын сандал дээр энэ өдрийн найрын эзэн, өөрийнхөаө сайн нөхөр жүжигчин Квинт Росцийнхаа дэргэд сууж байна.

Хөгжилтэй инээж, ярьж хөөрч янга чанга дуугарч байхы нь харвал Суллаа санах бодох юмгүй үнэхээр дүүрэн жаргалаар цэнгэж байх мэт байлаа .

Гэвч , анхааралтай ажиж харвал дөрвөн сарын дотор түүний бие турж хөгшрөн, урьдынхаас улам муухай болсон нь илт байлаа . Нүүрий нь бүрхсэн цуст яр шарх нь улам олширч үс нь цав цагаан болж, сэтгэл доройтсон , өвдөж шналсан

бие нь алдарсан байдал галдна талаас ил харагдаж байсан нь олон шөнө нойргүй хоносны нь шалтгаан бизээ .

Хэдий ийм болovч нэвтэрхий харцтай цэнхэрдүү бор нүдэнд нь хүч чадал харагдсаар байлаа . тэсэхүйеэ бэрх шаналгаж б айсан өвчнөө, бусдаас нуухын тулд өөрөө мартахыг оролддог байсан бөгөөд заримдаа, ялангуяа ма задарсан найрын үед бол үнэхээр ч мартах шиг санагддаг байлаа .

- Алив Пон циан чи яриач, Граний юу гэсэн гэнээ гэж сулла кумын нэгэн партизаний н зүг хандаж хэллээ .

- Үгүй би, түүний үгийг дуулаагүй гэж тэр патриций гэнэт царай нь цайж , ээдрэн хариулжээ .

Суллаа хөмсөг ширүүн зангидсан боловч тайван дуугаар:

- Миний чих сонор гэдгийг Понциан чи мэднэ шүү чиний Элий Луперкад хэлсэн үгийг би сонссон шүү гэхэд нь:

- Үгүй , бүхнийг чадагч хувь заяатай дарангуйлан захирагч минь намайг ү нэмш … гэж понциан ичингүйрсэн байдалтай хариуллаа.

- Суллын ногдуулсан торгуулийг төл гэхэд Кумын одоогийн адил грани й үгүй би түүнийг төлөхгүй , учир нь гээд цааш нв юм хэлэх гэтлээ намайг хараад, хэлсний минь сонсчихлоо гэж мэдээд чи ярихаа зогссон шүү дээ. Тэгээд граний юу гэж хэлсэн юм түүний нь надад хэлж аль гэж би одоо чамаас шаардаж байна гэж суллын хэлэхэд:

- Ай ромынхны дотроос хамгийн агуу их нь болох Сулла минь надад зөвшөөрнө үү гэхэд:

- Сулла сандлаасаа босч зангидсан гараараа ширээ шааж:

- Худалч муу чиний магтаал надад хэрэггүй. магтаал гэвэл түүний чинь би консулын тэмдэглэлд орсон гавъяа зүтгэл ялалтаараа өрөө олж авсан юм , муу чалчаа шаазгай чамд тэр бүхнийг давтах хэрэг ер алга!

Ганцхан , Граний хэлсэн үг л надад хэрэгтэй байна., үүнийг чи надад дамжуулан хэлж аль. Хэрэв хэлж өгөхгүй бол чи үхдэл хүүрээрээ миний ногооны газрыг бордох болно гэдгээ мэдэж ав. Намайг ивээгч Аполлоныг дуудан ам алдъя. Луций Корнелий Суллын нэрэр ам алдъя гэж ширззн зандарчээ .

Сулла энэ үгийг хэлэхдээ, нарийн хийцтэй алтан оосроор хүзүүнээсээ ямагт зүүж явдаг ,
Дельфийн сүмээс авчирсан Аполлон тэнгэрийн дүрд баруун гараа хүр гээн юм . Сулла нь Аполлоныг олон жилийн өмнөөс эхлэн онцгойлон шүтдэг болсон юм .

Суллын ингэж хэлэхэд энд байсан түүнхий дотнын танил нөхдийн нь царай хувьсхийн цайрч би е бие өөдөө гайхан харцгааж , бүжиг хөгжим, яриа шуугиан нэгэн зэрэг зогсож чив чимээгүй боловч хөөрхий Понциан хэтэрхий айн сандарч :

- Одоо би төлөхгүй: Сулла удахгүй үхнэ, тэгээд би төлбөрөөс чөлөөлөгдөнө гэж граний хэлсэн юм гэлээ .

Суллаа уурлаж унтууцаж эхлээд улаан байса царай нь цагаан болон хувирч:

- Аа тийм үү! Тийм үү! … Граний миний үхэхийг хүлээж ядаж б айгаа гэнээ ?… Граний миний үхэхийг хүлээж ядаж байгаа гэнээ ?… Граний ч сүрхий хүн юмаа!… тэгвэл тэр эндүүрчээ … гээд уураа барьж ядан , нүд нь гялалзан .. тэр чин урьдаас тааж мэддэг гэнэ !… урьдаас мэднэ гэнэ! … гээд түр зуур чимээгүй болсноо , хуруу хавсарган дуугаргаж:
- Хризогон ! гэж дуудлаа
- Үзнэ дээ гайгүй чи тооцоо алдаагүй л байх болтугай гэж Сулла аймшигт дуугаар дахин өгүүлэв.
- Хризогон нь чөлөөлөгдсөн хүн бөгөөд Суллын гарын зарц хүн юм . Хризогоны дэргэдээ ирэхэд ,

түүнд аяархан дуугаар тушаал өгсөнд,
тэр толгой дохин хариулаад хаалганы зүг чиглэ. Сулла хойноос нь хашгаран:

- Маргааш шүү гэв.

Дараа
нь сулла баясгалант царайгаар зочдынхоо зүг харж, фалерны архи х өөсөрсөн хундагаа өргөж,

- За! Яацгаав? Юунд чимээгүй болж орхивоо ? Олимпийн тэнгэр бүхнийг дуудан ам алдъя ! Миний бодвол , та нар аймхаай хонь, юм намайг оршуулсан дурсгалын найр пээр байцгааж байна гэж бодоо юу? гэхэд нь:

- Энэ тухайн бодлыг , тэнгэр чамаас холдуулах болтугай!

- Бүтэмжтэй бүхнийг Юпитер чамд
илгээх болтугай, чамайг Аполлон өршөөх болтугай !

- Хүчирхэг Сулла урт удаан наслах болтугай ! гэж зочдын олонхи нь нэгэн зэрэг хашгаралдан фалерны архи хөөсөрч байсан хундагануудаа өргөжээ .

- Квинт Росций хундагаа өргөж тодхон чанга дуугаар дуугарч,

- Хувь заяат Луций Корнелий Суллын алдар ,
эрүүл мэндийн төлөө бүгдээрээ ууцгаая гэв.

- Бүгдээрээ энэ ерөөлд даган баясаж ,
дор бүрийнхээ хундагыг тогтоосонд ,
анхандаа хөгжилтэй болсон сулла росцийнд баярлан түүнийг үнсэ ж байснаа, бишгүүрчид нүүрийн хөдөлгөөнөөр тоглогчдоо зандарч,

- Ээ муу сайн бузарлагчдаа, юу хийэ байгаа нь энэ вэ? …

- Та нар муусайн миний фалернийн архи л уухаас өөр юм хийж чадахгүй … үл бүтэх , буруудсан муу сайн та нарыг одоо үхлийн нойр үүрд аваачиг! Гэж хашгираю.

- Сулла нь голдуу завхай танхай үгтэй , ширүүн ааштиай хүн юм . Энэ удаа түүний үргэлжилсэн хараала дуусгаагүы байтал нь хөгжимчид нв хөгжмөө дарж , нүүрийн хөдөлгөөнөөр тоглогчид бүжиглэн , гар хуруугаар янагдах дүрээр хөдөлгөн бүжиглэж гарлаа .

- Бүжиг дууссанбы дараа , Суллаа ба росций нарын сууж байсан голын ширээн дэр амьд юм шиг дүрслүүлэн өд гуурсар чимсэн бүргэдийг авчирч тавилаа . Энэ бүргэдэд амандаа ув улаан туушингаар уясан лаврын хэлхээ зүүжээ . Энэ лаврын хэлхээ дээр “Suilae Feliki Epafrodito” гэсэн үгийг алтан үсгээр бичсэн байлаа . Энэ нь охин тэнгэр Венерийн хайр дурыг хүртсэн хувь заяат Суллад гэсэн үг байжээ . “Эпафродит” гэсэн хоч Суллын чихэнд хамгийн тохиромжтой санагддаг байжээ .

- Зочид алга таүиж , Росций бүргэдийн амнаас лаврын хэлхээг авч Суллын хажууд суусан, Суллын хишгээр чөлөөлөгдөгч сайхан хүүхэн Аттилия Ювентинад гардуулан өглөө. Найрын ширээний ард эрэгтэйчүүдийн завсраар сууцгааж байсан Кумын бүсгүйчүүдийн дотроос энэ хүүхэн, энэ өдрийн найран дээр бүгдийг сэтгэлийг татаж б айсан юм .

- Аттилия Ювентина лаврын хэлхээг ав, Суллын толгойг чимэглэж байсан саргай цэцгийн хэлхээ титэм дэ эрээс нь тэнгэрийн хайр дур болсон ялагдашгүй эзэн хаан чамд энэ лаврын хэлхээг бүх ертөнцийн гайхамшиг чамд шагнажээ гэж урьхан дуугаар өгүүлэв.

- Сулла хутга авч, бүргэдийн гэдэс баг хүзүүг хага зүссэнд дотроос нь олон тооны өндөг гарч ирлээ . Тэднийг найрлагчидад тархаан өглөө . Зочид бүрийн өндгөн дотор, шарж болгосон таван халуунтай шар шүүсээр амталсанг усны шувууны мах гарлаа .

- Жаахан азнасны дараа асар том хэмжээний боов оруулж ирлээ . Энэ боовны гадар талаар ордны гадуур дугуйруулан тарьсан баг

ануудыг яг дууриалган зөгийн бал бурмыг гурилтай базаж яимсэн байлаа . Энэ боовйыг дөнгөж хагалмагц дотроос нь хэсэг бор шувуунууд гарч ниссэн нь зочдын тоогоор нэг байлаа . Бор шувуу бүхний хүзүүнд туушин зүүлтэй байх бөгөөд тэр туушингаас зочдын нэр цохсон бэлгүүд зүүлттэй байла а .

-

Суллын гайхамшигт тогоочийн санаж гаргасан энэ шинэ сонихо н бэлгйг зочид инээлдэн алга ташиж хүлээн авлаа
. тал бүрээс битүү танхимаас , нисэн гарах газар эрж байсан бор шувуунуудыг
барьж авахаар зочид хөөцөлдөн анхимын дотор удтал бөөн шууги ан орь дуу болцгоожээ . Энэ шуугианыг Сулла зогсоолоо. Өөрийгөө эрхлүүлэн таалуулж байсан Ювентинаасаа Сулла түр чөлөөлөгдөн:

- Зэ !… энэ орой би их хөгжилтэй байна, найр хөгжим бүхэн дээр дохиолддоггүй сонирхолтой зүйлийг үзүүлэн өөрийгөө болон та нарыг зочлъё… хайрт нөхөд минь ээ… сонсоцгоо … Энэ танхимын дото гладиатаруудын тулалдаан үзэхийг та нар хүсэж байна уу? гэж өндөр дуугаар асуулаа .

- Үзье, үзье! гэж тавин хүн нэгэн зэрэг хашгаралдав. Гладиатаруудын тулалдаан харахыг зөвхөн зочид сонирхож байснаар ч барахгүй бас бишгүүрчид , биүжигчид их сонирхож байсан ажээ . иймийн учир бишгүүрчид биүжигчид нь хэдүйгээр Суллын асуулть тэнэднд хамаараагүй болов “Үзье” гэцгээсэн юм.

- Гладиатар!… гладиатаруудыг үзье!… Сулла мандтугай! … харамгүй сэтгэлт Сулла ! гэцгээлээ .

Удалгүй танхим дотор арван гладиатарууд орж ирлээ . Эдний тав нь фракий гарлын хүний хувцастай , бусад тав нь самнит гарлын хүний хувцастай ажээ .

- Спартак яаве гэж Сулла Хризогоос асуув.

- Спартакийг бид сургууль дээр нь эрээд олсонгүй, бодвол тэр дүүгийндээ байгаа юм болов уу даа гэв.

Яаран сандарсан Спартак энэ үед танхим дотор орж ирээд, амьсгал нь давхцан , хуруугаа амандаа хүргэж Сулла болон түүний зочдыг мэндэллээ .

- Спартакаа ! Би чиний хатгах жадлах сурлагад хүмүүсийг сургах, уран чадварыг ч инь үнэлэх гэж байна. Бид одоо чиний сурагчид юу сурсан,% юу чаддагийг үзнэ гэж сулла рудиарийд хэллээ .

- Эд нар , хатгах жадлах сургуулийн дадлага хийж эхэлснээр дөнгөж хоёрхон сар болж байна. Эд нарын цөөнх нь миний заасныг давж гарсан юм гэж Спартакийн хэлэхэд Сулла:

- Одоо л мэдэгдэнэ , одоо л мэдэдэнэ! Гээд зочдын зүг хандаж:

- Найрын үед та нарт зориулан гладиатаруудын тулалдаан үзүүлэж байгаа нь манай заншилд шинэ юм гаргаж байгаа хэрэг биш ээ . Кумынг хүвүүд минь ээ, одоогоос хоёр зуун жилийн өмнө энэ мужийн анхны хүмүүс болох Кампанид оршин суугчид – бидний өвгөд хуучдын дунд байсан заншдыг сэргээж б айгаа хэрэг м гэлээ .

Урьдаас төлөвлөгдсөн ёсоороо хүний цусыг асгаруулан наадъя гэдэг үзэгдэшгүй муухай энэ үгээ юм ч хэллээ гэж үзээгүй , зэрлэн араатан мэт амгалан дүрээр айлдсан явдал нь Спартакийн уурыг хүргэж уушиг зүрхийг нь дэлсүүлжээ .

Чөлөөтэй орны чөлөөтэй иргэд болж төрсөн боловч заяа муутай арван залууг , бие биендээ айсагнах ямар ч сэтгэлгүй айтал нь олонхийн саналаар биш, харин ганцхан хүний дур
зоргоор ингэж хатгалцуулж байгалиас тогтоосон хугацаанаас нь хамаагүй урьд, гутамшигт үхлээр үхэх болгосонд Спартакийн сэтгэл ихэд хорсчээ .

Спартакийн дургүйцлийг энэ ерөнхит й шалтгаанаас гадна ондоо бас нэг шалтгаан улам хүчьэй хүргэж байжээ- дурдвал Спартакийн хамгийн хайртай, ер бусын сайхан залуу нөхөр Арторикс нь түүний нүдний өмнө алагдах аюулд ороод байжээ .

Байлдагчдаа жагсаах зуураа,

- Чи юунд ирэв? Гэж Спартак Арториксаас маш нам дуугаар асуув.

- Хэн маань өнөөдөр үхлийн өөдөөс очих вэ гэдгээ , бид аль хэдийн нь шоодсон юм тэгээд би очихоор болсон учир э нд ирлээ
  . завсар хоорондоо тулалдах Суллын анхны арван гладиатарын нэг нь би
  байх ёстой болсныг миний заяа өөрөө шийджээ гэж намхан дууга ар Арториск хариулав.

- Үүнийг сонсоод Спартак Арторикст юу ч хэлсэнгүй, хэсэг дуугүй б айснаа суллад хандаж:

- Агуу сэтгэлт Сулла, энэ яасан…
  үүний оронд өөр гладиатарыг сургууль дээрээс авчруулахыг зөвшө өрөнө үү гэж гараар Арториксын зүг заалаа .

- Аа энэ чинь яагаад тулалдаж чадахгүй болсон м? гэж дарангуйлагч агсан хүн асулаа .

- Учир нь энэ бол бусдаасаа хүчээр даанч давуу хүн юм, тэгээд үүнийг оролцулбал фракийнхан тал онцгой хүчтэй болох болно… гэж Спартак хариулжээ .

- Үүнээс болж чи биднийг хүлээлгэх гэж байна уу?…

Зоригтой энэ хүн ч нь тулалдаг. Бид цааш нь хүлээж чадашгүй , самнитчуудад л муу болно биз! Өөр яахав гэж Суллаа хэлжээ.

Гладиатруудын тулалдааныг тэсгэлгүй хүлээж байсан хүмүүсийн дотор Сулла өөрөө байсан юм . Ингээд тулалдаан эхлэх дохиог Сулла өгчээ.

Тулалдаан удсангүй . Хорин минутын дараа фракчуудийн нэг хүн , самнитуудын хоёр хүн тус тус алагдаж , бас самнитуудын заяа муутай нөгөө хоёр хүн нь хүнд шарх олж , шалан дээр унаад Суллаас амиа гуйж байлаа . гэвч тэдний амийг уучилсангүй .

Ганцаараа хөл дээрээ үлдсэн самнит хүний тухай хэлбэл, тэр нь бие хамгаалан ,
дөрвөн фракийн өөдөөс галзуу тулалдаж байан боловч бүх биеэр дүү рэн шарх олсон байлаа . тэр хүн хээтэй шалан дээгүүр , тал бүр тийш урсах байсан цусан
дээр төд хальтарч унав. Үхэж байгаа тэр самнит хүнийг анд нөхөд Арторикс нь харж хоёр нүдэн дээгүүр нь нулимс гүйлэгнэж байснаа, тулиахгүйн эрхээр нэвт жадлан алав.

Нэгэн зэрэг алга таших чимээ гарч, найрын танхимыг донсолгов.

- Аливаа хамгийн хүчтэй хүн Спартак чи саяны тулалдаанд алагдагсдын нэгийнх нь бамбай ав, бас алагдсан фракийн юлд ав. Тэгээд амьд үлдсэн энэ дөрвийн урьтдаас ганцаараа тулалдаж хүчээ үзүүл гэж согтуу Суллын дуугарах дуу танхим дотор тод сонсогдов.

Суллын гаргасан саналыг бусад нь шагшин шуугиж дэмжжээ. Харин хөөрхий радиарийн дотор манаран толгой руугаа мунаар цохи улсан юм шиг болжээ . Ухаан алдав уу, ташаа дуулав уу гэж түүнд санагдан, царай ь цав цагаан болж Суллыг ширтэн гөлөрчээ.

Спартакийн сэтгэл маш алдарсныг Арторикс мэдэж:

- Зоригтой бай! гэж түүнд шивэгнэн хэлэв.

Спартак Арториксын энэ үгийг сонсож, цочсоноо эргэн тойронд хараад, параа нь Суллын зүг эргэж :

- Агуу их , хувь заяат дарангуйлагчаа би бол радиарий хүн , чөлөөтэй хүн, чиний гладиатруудын сургуулийн захирлын үүргийг гүйцэтгэж байгаа хүн болохоос биш, гладиатар хүн биш гэдэгт чиний анхааралыг хандуулахыг би хүсэж байна гэлээ .

- Сулла согтууран , Спартакийн хорыг маажин ха… ха… ха… гэж инээснээ нөгөө, тэр зоригт Спартак маань чи юү? Чи үхлдээс айж байа. Айж байна! үзэшгүй муу гладиатарын удам судар!… гэвч би Ялгуугч Геркулесын бороохойг нэрлэн, батлая чи тулалдах л болно доо гээд түр зуур чимээгүй байсныхаа дараа зангидсан гараараа ширээгээ шааж , шууд тушаан зандарч аймхай муу зэрлэг минь хэн чиний амийг өршөөж чөлөөлсөн билээ… Сулла чөлөөлсөн биш бил үү?… Сулла чамд тулган тушааж байна … тэгээд чи тулалдах л болно доо! Олимпийн тэнгэрийн өмнө ам алдъя… Чи тулалдах л болно доо! гэлээ .

- Барёс ши догшрон алагдсадын нэгний нь сэлмийг шүүрэн авч, цахилгаан мэт хурдлан очиж Суллыг тас цавчиж орхиё гэж Спартакт хэдэн уда санагдсан боловч их хүчдэлийн ачаар арайхан биеэ барьж чадсан юмаа . ингэж байтлаа , өөрийн эрхгүй юу хийж байснаа ч мэдэлгүй араатан архирах мэт дуу гарган амьсгалаа цээжнээсээ гарган , бамбайгаа өргөж, илд шүүрэн авч:

- Би аймхай ч хүн биш, би зэрлэг ч хүн биш. Луций, Сулла чиний сэтгэлийг хангахын төлөө тулалдая , чиний тахидаг тэнгэрийн нэрийг дуудан ам алдъя . Миний аз доройтож би Арториксийг шархдуулах юм бол харин чамайг… гэж чанга хэлж байтал нь царгиа чанга дуугаар хашгарсан бүсгүй хүний дуу сонсогдон түүний үгийг тасалжээ . Энд байгсдын анхаарал тэр орилох дуу гарсан зүг тийш хандлаа .

- Сулла ба бусад олон зочдйын ар талаас орох хаалган дээр Валщрия ирсэн байлаа . Түүний царай цав цагаан болж нэгэн газраасаа хөдлөлгүй яг зогсож байлаа .

- Сулла дуудаж байна гэж Спартакад хэлэхээр боолын очих үед, тэр нь Валщриягийн дэргэд байсан ажээ . Энэ цагт ингэж дуудсан явдалд Спартак ч гайхаж бас

валериягийн сэтгэл ч зовёон юмаа . Урьд өмнө нь тохиолдож байсан аюулаас улам айхтар аюул Спартакат тохиолдов уу ? гэж Валщрияд санагджээ . Фракийн хүнд хайртай сэтгэл нь Валерияг хөтөлж, ёс сахисан хүний бүх журмыг хол таягдан урьдаас болгоомжлох сэргийлэх дүрмийг мартаж, энэ оройн цагаар Валерия найр болж байсан газар руу ирсэн байжээ .

- Хаалганы хөшгийн ард нуугдан зогсож байсан авхайтан, гладиатаруудын зэрлэг тулалдаан ба мөн Спартак , Сулла хоёрын хооронд болсон хэрэг явдал бүхнийг харж байсан ажээ .

- Спартак Арторикст их хайртай гэдгийг Валерия мэдэх бөгөөд Спартакийг Сулла албадан Арторикстай гь тулалдуулах гэснийг харж, бас эцэстээ Суллыг за авал занах замд хүрэх чиглэлтэй Спартакийн үгийг сонсож хэрэв одоохон энэ хэрэгтйэн хутгалдан оролцохгүй бол Спартакийн амь үрэгдэнэ гэдэг Валериад тодорхой боллоо.

- Ингэж Валерия , бүр зүрхнийхээ угаас гарсан дуугаар хашгаран сулла болон тэнд байсан бүх зочдын анхааралыг өөр дээрээ татлаа.

- Сулла гайхаж

- Валерия! …- Валерия!… чи энэ оройн цагаар энд ирэв үү?… гэж сандал дээрээс босохыг оролдсон боловч идсэн хоол уусан архиа дааж боссонгүй .

- Зочдын зарим нь босч, бусад нь биеийнхээ тэнцүүрийг олж чадахгүй байсан учир босохыг оролдон салгачихсан байсан боловч дуугүй дөхөж Валерия авхайд яахав даа нэг , мэнд хүргэжээ .

- Чөлөөлөгдөгч Ювентина хүүхний царай, анхандаа ув улаан болж байснаа дараа ньв хүн аймаар хөх саарал болж , гулган бууж төдхөн ширээн доор орж бүтээлгийн хормой доор далд орон нуугджээ .

Валерия биеэ
тогтоож сэтгэл номхотгохын тулд том танхимыг тойруулан хурдан ха рж, минут хир болсноо:

- Бүгдэд баяр хүргэе Сулла болоод түүнийг нөхдийг тэнгэр ивээх болтугай гэлээ . мөн ингэж байх зуураа Валерия Спартактай харц солилцон харилцан ойлголцож амжлаа . Энэ үед рудиарий тулалдан эхэлсэнгүй харин валерияг ширтэн харж байлаа . Энэ оройн цагаар Валериягийн энд орж ирсэн яьдал огт байж болшгүй гторгуйн үзэгдэл мэт Спартакат санагджээ .

Сулла авхайтан дээрээ харцаа тогтоон ширтсэнд:
Валерия инээмсэглэн:

- Суллааа , яи намайг найрандаа олон удаа урьсан билээ . жнэ орой миний нойр хүрсэнгүй дэмий хэьтэж байснаа та нарын чимээнээр зарим нэгийг сонсож, хоолны ёслолын хувцас өмсөж ирлээ . нөхөрлөлийн төлөө нэг хундага дэвшүүлье тэгээд, эрүүл мэндээ бодож үүрийн хяраанаас наана өрөөндөө оч гэж чамд хэлэх гэж ирсэн юм . харин энд ирсэн яинь юлд гялалзан , бас шалан дээр алагдсан хүмүүсийн хүүр хэвтэж байгааГ харлаа . Юу болж байгаа нь энэ вэ? Та нар цирк болон амфитеатруудаар тоогүй олгоор алагдагсдыг үзэж ханаагүй байна уу , аль та нар эрт хоригдсон зэрлэг заншлыг сайшаан дахин сэргээж байна уу? Жрагал цэнгэлийнхээ хажуугаар үхлийнхээ өмнөх зовлонг эдлэн т арчилж ам хамар нв таталж багаа хүмүүсийг ширтэн сонирхох гэв үү? Аль архинд согтуурсан ам хамраа таталдуулан тэднийг дууриах гэв үү? Гэж их жигшин үзсэн байдалтай Валериягийн хэлэхэд бүгд толгой санжуу лан дуугүй байжээ .

Анхандаа дуугүй байсан
сулла, дараа ганц хоёр үг болож хэлэхийг оролдсон боловч хэлж чад сангүзй дуугүй болон суужээ .

Харин гладиатрууд тэдний дотроос ялангуяа Спартак, Арторикс нар Валерияд баяр талархал илэрохийлсэн урин харцаар түүнийг ширтэж б айлаа .

Суллын гэргий минут хир чимээгүй байснаа боолчууд тийш харж:

- Алив та нар , алагдагсдын хүүрийг одоохон эндээс зайлуулж оршуул, шалыг сайтар угааж үнэртэн боло н тос шүрш. Тэгээд бас Суллын хундаганд фалерны архи дүүргэн сөгнөж нөхөрлөлийн тэмдпэг
болгон зочдын дунд жороо дугараа барь гэж тушаажээ .

Валериягийн тушаалыг боолчууд шаламгайлан гүйцэтгэж гладиаторуу д гарч одлоо.

Танхимын дотор огт чимээгүй болж нөхөрлөлийн жороо хундага зочдыг тойрсонд түүний
дотор саргай цэцгийн дэлбээ тасдан хийсэн хүн тун цөөн байлаа . Дараа нь зочид б ас л их чимээгүй цувсаар танхимаас гарч яьцгаалаа . зочдын зарим нь асар том энэ ордны дотор зориулж бэлтгэсэн тасалгаанд очиж, нөгөө зарим нь зэргэлдээ Кумы тийш очжээ .

Сулла сандал дээрээ хэцийлдэн чимээгүй хэвтэж б айлаа . тэр нь ямар нэгэн юм бодож байгаа мэт байсан боловч , үнэн хэрэг дээрээ согтууран мансуурсан нь тэр байжээ .

Валерия түүнийг сэргээж:

- Анхны тахиа дуугарах цаг боллоо чи унтах өрөөндөө одоо нэг очих юм уу , үгүй юм уу? гэнэ.

Сулла энэ үгийг сонсож их хүч дайчлан , толгойгоо дөнгөж өндийлгөн хоолойдоо тээглэсэн үгээ арайхийн шах аж,

- Чи… энд… ирж… үймүүлэн… миний ж аргал цэнгэлд саад болов… Юпитер Статор нарын өмнө ам алдъя … үүнийг юутай ч адилтгаж болшгүй… бүхнийг ялгуулагчийыг … хувьтай Суллыг … Эпафродитыг … дарангуйлагчийг… бүгдийг дээд

тэнгэрийн өмнө ам алдъя …
би ромд ноёрхож байгаа хүн мөн бүх дэлхийд
… намайг ноёрхох хүн байхыг би зөвшөөрөхгүй …
би хүсэхгүй гэлээ .

Валерий , Суллыг нэгэн талаа үзэн ядаж, нөгөө талаас хөөрхийлөн харж б айжээ .

Гэтэл Сулла дахин дуугарч,

- Метробий , миний эрхэм Метробий чи хаа байна? наашаа ирж надад тусал, би
үүнээс салахыг хүсч байна… үүнийг хөөж тонилгохыг хүсч байна … гэдсэн дотрохи хүүхдээ аваад энэ яваг …
би түүний нь миний хүүхэд гэж үзэхгүй байна … гэлээ .

Уурын оч Валериягийн хар
нүдэн цахилж Суллыг занал хийдэн ухасхийснээ зогсож:

- Хөөе Хризогон , боолуудаа дуудуулж үүнийг унтах өрөөнд нь аваачуул, танай энэ ноён чинь , бохир ясчин шиг, хагартлаа гударч балайртлаа сонтсон байна! гэлээ .

Сулла шөнийн үлдсэн хэсгийг мөн дараа өдрийн ихэнх хэсэгтэй орон доо унтаж өнгөрүүлжээ . валерия огтхон ч цурам хийсэнгүй хоножээ .

Сулла үдийн хирд сэрлээ . Суллын арьс өнгөний өвчин нь сүүлийн өдрүүдэд шаналгаж , хорсох загатнах нь тэсэхүйе бэрх болсон б айжээ . Сулла орноосоо босмогц , цамцан дээрээсээ өргөн тога нөмөрч зориуд тусгайлан түүний биеийг аарч халамжлахаар байдаг боолуудаараа хүргүүлэн мөн, хамгийн хайртай Хризогоныхоо мөрийг түшиж , дорнодын маяг оруулан гоёж хийсэн гайхамшигт сайхан багануудаар чимэглэсэн өрг өн уудам атриумыг дамжин , бие угаах газар очлоо.

Сулла , дулаан өрөө ба хүлээх танхимыг дайран өнгөрч хувцас тайчих өрөөнд орлоо. Энэ танхимд нь хээ угалз бзхий шалтай гантиг ханатай сайхан том танхим байлаа

. Энэ танхимаас гурван тийш хөаалга байх бөгөөд үүний нэг нь биенд хүйтэн ус шүрших цорготой өрөө, нөгөө нь бүлээн усны лайртай танхим , гуравдахь нь халуун уурын өрөө рүү тус тус орох хаалга ажээ.

Сулла ув улаан бөс ба жинтүүнүүдээр бүрхсэн гантиг чулуун бандан дээр сууж, боолуудын тусламжтай хувцсаа тайчиэн халуун уурын өрөөнд орлоо.

Энэ нь мөн гантиг чулуугаар хийсэн өрөө байжээ . Шаланд нь хэдэн нүх байх бөгөөд эдгээрээс халуун уур гаргч , энэ өрөөг халааж байдаг ажээ .

Гантигаар хагас дугуй хэлбэртэй хийсэн альк баруун гар талд нь байх бөгөөд түүний дотохр бас гантиг бандан байна.

Сулла альк дотор орж суугаад , хөлс гаргахад зориулсан янз бүрийн жинтэй годилуудыг өргөж б айлаа .

Сулла , тэр дотроосоо гарч , халуун устай лайранд орш, гантиг бандан дээр суужээ .
Түүний царайг харвал бүлээн усанд орж бие амсхийж үнэхээр жарга ж байх мэт санагдлаа
. Сулла бие дарах нухдах үүрэг гүйцэтгэж байсан боолчуудынхаа нэгэн тийш харж :

Аа мөн!… үзээгүй болсоор удсан , таатай аятай юмаа үзэж, сэтгэл ханаж байна … Диодоор маажуураа шалав авч миний энэ шархтай газруудаар мааж гэж хэллээ .

Дараа нь сулла , Хризогон уу харж :

- Уржигдарын цаад өдөр бичүүлж дуусаад, өчигдөрийн чамд өгдөг миний хорин хоёрдугаар боть “зөвөлгөөг” чи хавтасласан уу? гэж асуужээ .

- Өглөгч сайн ноён минь ээ. Зөвхөн чиний өөрийн бичсэн хувийг хавтаслуулсанаар барахгүй бичээч бо олчуудын хуулж бичсэн арван хувийг ч бас хавтаслуулсан шүү гэлээ .

- Хризогон минь чи их сайн байна… тэгвэл чи арван хувь буулгуулахаар зохион байгуулжээ гэж Сулла аргагүй л нэг сэтгэл ханамжтай бололтой хэлжээ .

- Зөвхөн сүүлчийн ботийг арван хувь болгуулж , нэг хувийг нэг ордны номын сан, нөгөө нэг хувийг Ром дахв чиний ордны номын сан , гуравдахь хувийг өөрийнхөө номын санд тавьж , бас боть бүхний үлдсэн хувийг би Лукулл Гортензийн нарт бэлэг болгон өгсөн. Өдий олон хувийг газар газк ар тараасан учир
  бол чиний зохиолуудыг гал түймэрт автах буюу үрэгдэх аюулаас х амгаалах зорилоготой билээ гэлээ .

- Алив чи цаашаа шалав харааё , тэнд юу болж байна. Тайчих өрөөнд ямар нэгэн чимээ гарах шиг надад санагдлаа гэж Сулла Хризогонд хэллээ .

Хризогон тэнд хэн байгааг харах гэж онгоцны өрөөнөөс шалав гарч одлоо.

Шөнө турш нойргүй наргисны уршиг ч б айж магадгүй юу ч атугай өнөөдөр
Суллын царай урьд урьдынхаасаа улам хөгширч ядарсан байдалтай б олсон байлаа . суллын бие , хүчтэй өвдсөн учир ёолж урьдын хэвээр цээжин дээр минь өвдөж байна гэлээ .

Суллын энэ үгийг сонсож, түүнийг биеийг арчилж байсан Диодор Суллатай үргэлж хамт байж түүний эмчилдэг эмч Сирмионыг дуудаж ирэхээр явлаа . Энэ эмч нь Родос нутгийн бөгөөд чөлөөт хүн байжээ .

Нойр хүрч толгой нь хүндэрсэн учирСулла лайрын хашлага дээр толгойгоо санжуулан сууж байгаа нь унтсан юм шиг байлаа .

Хэдэн минутын дараа Хризогоны хүрч ирэхэд Сулла хирдхийн цочиж, толгойгоо өндийлгөв.

Чөлөөлөгдөгч хүн сандран, лайрын дэргэд гүйж хүрээд,

- Яав? Гэхэд нь:
- Зүгээр… зүүрмэглэн … зүүдэллээ гэжээ .
- Ямар зүүд зүүдлэв? Гэхэд,
- Би өнгөрсөн жил нас барсан хайрт гэргийн Цецилия Метеллатайгаа уулзаж зүүдэллэ э . Тэр минв намайгаа нааш ир гэж дуудлаа гэхэд нь:
- Энэ тухай юм бодох хэрэггүй гэж Суллад, Хризогон зөвлөжээ .
- Юм бодох хэрэггүй гэнэ үү чи?
- Бишрэл гэнэ үү ? Зүүдний тухай юунд тэгж санав. Тэгж хааш хэрэг байж болохгүй байхаа, Хризогон минь?
  Би зүүдэндээ ямагт бат итгэсээр ирсэн юм , зүүдээр дамжуулан тэнгэрээс надад тушаасан бүхний нь би ёсчлон дагасаар ирсэн юм . тэгэвч хожим нь гэмшин удаа, надад ер тохиолдож байсангүй билээ гэлээ .
- Хэрэв чи дайн тулаанд явж байсан тухайгаа одоо хэлж байгаа бол , тэгэхэд чи өөрийнхөө ухаан , өөрийнхөө эр чадлаар тэгж явсан болохоос биш
  ямар зүүднийхээ заавраар тэгж явсан биш гэж Хризогон хэлэхэд:
- Хризогон минь ээ, ивээлт миний хувь заяа, ухаан ба эр зоригоос минь илүү их тусыбг ямагт надад хүргэсээр ирсэн юм шүү. Иймийн учир би ганцхан түүнд найддаг юм . Намайг чи үнэмш миний явуулсан дайн байлдаануудын дотроос , ямар ч бодох санах юмгүй довтолдсон нь улам илүү амжилт болж б айсан юм .

Олонхи нь олиггүй бузар боловч , бас олон нь үнэхээр агуу сайхан хэрэг байсан үйл явдлуудынхаа тухай дурсан санахдаа суллын сэтгэл амсхийж , бас толгой нь бага зэрэг сэргэх шиг болжээ . Суллын толгой сэргэсэн энэ үеийг Хризогон ойлгож түүнд айлтгал хийвэл зохистой байна гэж Хризогон ойлгож таны тушаал

ёсоор Граний Кумаас ирээд , таны тушаалыг хүлээж байна гэж Сулладаа айлтгажээ .

Сулла энэ нэрийг сонсмогц , гэнэт уур хилэн нь манасхийж нүүр нь таталдан нүд нь зэрлэгээр гялалзан:

- Түүнийг … одоохон… над дээр … нааш нь оруулаадп ир… ичгүүргүй тэр муу… бүх дэлдхий дээр ганцаараа миний шийдвэрийг доромжилсон хүн байгаа юм… бас намайг үхээсэй гэдэг хүн байгаа юм! гэж сөөнгө дуугаар галзуурсан юм шиг
  хашгичин туранхай ясархаг гараараа, лайрын хөвөөг чанга тагаж б айлаа .

- Онгоцноос гарах хүртлээ хүлээж чадахгүй байна уу? гэж Хризогон асуухад:

- Үгүй … үгүй… одоохон… нааш нь миний урьд аваад ир… гэлээ .

Хризогон гарч очоод тэр дотор , эдил Гранийг оруулж ирлээ .

Энэ нь дөч орчим насны , аврага том биетэнй хүн байлаа. Энэ хүний бүдүүвтэр хэьтэй
боловч хэвийн царайнд хорсол заль хоёр хослон харагдаж б айлаа . Энэ хүн оногцны өрөөнд ,
суллын дэргэд ирээд царай нь илт цайвар цагаан болсон байлаа .

Мэхэлзэн ёсолж , суллын гарыг үнсэн түүнд хандаж :

- хувь заяат , агуу сэтгэлт суллыг , удаан хугацаанд тэнгэр өршөөж б айх болтугай! Гэж айн санадрсандаа болж чичирсэн дуугаар өгүүлрүүн .

- Үл бүтэх муу чи, уржигдарын цаад өдөр ингэж хэлээгүй шүү дээ! Улсын санд торгуулийг төлөх ч амд ноогдуулсаан миний шийтгэлийг шоолон инээжэ, өнөө маргаашигүй сулла үхнэ , тэгээд би торгуугиас чөлөөлөгдөнө гэж байсан шүү дээ гэхэд:

- Айн сандарсан граний аман дотроо дуугарч,

- Үгүй үгүй энэ худал үгийг хэзээ ч бүү үнэмш… гэлээ

- Аймхай муу чи , одоо чичирч байна уу? Бүх хүмүүсийн дотроос хамгийн чадалтай , хамгийн заяатай хүнийг л доромжилж байхдаа чи чичирч байх ёстой байсан… аймхай муу ч и! Гэлээ .

Сулла энэ үгийг хэлж, тэсгэлгүй уурлан заяа муутай түүний нүүр рүү цохисонд , тьэр уучлал гуйж уйлсаар лайрын дэргэд очлоо.

- намайг өрөвдөн үз … намайг өрөвдөн хайрла… гүйж наманчилан … уучлан өршөөнө үү! Гэж тэр хөөрхий амьтан орилжээ .

- Өрөвд гэнэ ? … аймшигт өвчнөөр өвчлөн шөнөлж б айгаа үед минь намайг доромжилсон хүн чамайг .. би өрөвдөнөө б ас . Аймхай муу чи, энд одоохон , миний нүдний өмнө үхэх болно… үхлийнхээ өмнөхөн
таталдаж байхын чинь харах сүүлчийн амьсгалыг хурааж б айхыг чинь харах, миний хүсэл гал шиг шатаж б айна гэж сулла их л ууртай хараажээ. Суллын уур хязгааргүй хүрч, бие нь мушгиран таталдаж галзуу мэт хашгиран ,боолчуудаа дуудаж:

- Та нар яачихсаан … залхуу амьтад вэ… юунд ангайн зогснов. Наадхаа шүүрэн авч, үхтэл нь занчаад , наадахаа , энд, миний урьд… багалзуурдаач … алаач! … гэж бачимдсан дуугаар галзуу мэт хашгирлаа .

Боолчууд нь бас л нэг шийдэж чадахгүй бололтой байхад нь сулла сүүлчийнхээ хүчийг шавхан маш аймшигтайгаар дуугаар:

- Наадахаа багалзуурдаж алаач , эсхүл би Эриннийн бамбар Эриннийн могойг дуудан ам алдъя , та нарыг өөрсдий чинь тэлж алах тушаал өгнө шүү гэж зандарлаа .

- Боолчууд ухасхийн, заяа муутай тэр хүнийг барьж аваад шалан дээр унагаж тал бүрээс нь зодож , өшиглөж гарсанд сулла цусны үнэр авсан
зэрлэг араатан мэт оволзон давшилж,

- Уухай! ..дэлсээч, дэвс! .. м үл бүтэх мууг багалзуурдаач! .. наадхаа багалзуурд багалзуурдаач! .. гэж хашгарсаар л байлаа.

Граний биеэ хамгаалан, өөрөөсөө хүчтэй дөрвөн боолын урьдаас эсэр гүүцэн, тэднийг хүчтэй цохиж байлаа .

Анхнадаа , боолчууд тушаал дагасан бол ,Гранийг аяархан зодож байсан юм . Харин дараа гранийг эсэргүүцэн өөрсдий нь
балбаж эхэлхэд боолчууд уурлан ухасхийж шавсанд Граний хөдөлж ч чадахгүй болжээ . тэгж байтал боолчуудын нэг нь гарний цээжин дээр нь өвдөглөн хоёр гараараа багалзуурыг нь шахаж хэдхэн секундийн дотор алж орхилоо.

Суллын нүд нь ухаргайгаасаа хальтран бүлтийж , уруул дээгүүр нь хөөс цахарч энэ бүхнийг , бие сэтэглээрээ шимтэн харж, зэрлэг араатнйы шуналаар баясан:

- Уухай! .. уухай!.. улам хүчтэй .. дпар .. багалзуурд гэж суларсан дуугаар уухайлж байлаа .

Саяны хэрэг яьдлыг үед биеэ
хэтэрхий дайчлан хашгирч тамирдсанг ба тэсгэлгүй хүнд өвчин нь сэргэсний улмаас суллын бие алдарч, Гранийн амь тавих үеэр, өөрөө Лайран дотроо түрүүлгээ харан унаж:

Туслаач … үхлээ!… туслаач! Гэж сонсогдохгүй сулхан дуугаар хэлжээ .

Суллын царай үхсэн хүний царай шиг болж, зовхи нь бууж, шүдээ хавиран уруул нь таталдан мурийлаа .

Хризогон болон бусад боол , Суллыг сахиж байлаа . тэгж байтал Суллын бие гэнэт таталдан , бас маш хүчьэй ханиалгажээ . Дараа жаахан азнаж байгаад , цээжнээс нь асар их цус гарч, бөглүү дуугаар ёолсоор нүдээ ч нээж чадалгүй байсаар нас баржээ.

Хэмжээгүй агуу ихийнхээ хирээр муу арга амэхтэй энэ хүн ингэж жаран насандаа ертөнцийг орхижээ . Энэ хүний аврага их авъяас чадвра, сайн сэтгэл бүхэн

нь харгис догшин авир зан, жаргал цэнгэлийн хойноо ё хөөцөлдсөн мөрөөдөлдөө булагдсан ажээ. Энэ хүн агуу их хэрэг ажлуудыг бүтээснийхээ зэрэгцээгээр, заягүй муу зовлон зүдгүүрийг ч эх орондоо багагүй авчирчээ. Агуу их жолоодогч гэж алдаршин энэ хүн хамгийн муу иргэн гэдэг дурсгалыг түүхэндээ бас орхижээ. иймийн учир, энэ хүнээс амьдралынхаа үед хийсэн бүх зүйлий нь судлахад, энэ хүний эрэлхэг зориг, чадал хүч нь их байв уу, аль худал хуурмаг муу байв уу гэдгийг шийдэхэд хялбар биш юмаа.

Ийм учираас, Суллатай удаа дараа дайтаж б айсан, Марийн намын консул, Кней Папирий Карбон өнгөрснийг санаж дурсахдаа: суллын сэтгэл зүрхэнд оршиж байпаг арслан, үнэг хоёрыг урдаас тэмцэж байхад үнэг нь надад илүү төвөгтэй байдагсан гэдэг билээ.

Суллын дөнгөж саяхан нас бараад байхад боол Диодор, эм Сирмионы хамт онгоцны өрөөнд орж ирмэгцээ:

- … аас их чухал захидал авч Ромоос элч ирлээ … гэтлээ Суллын нас барсан явдалд сандран үймж байсан хүмүүсийг харж, үг нь хоолойд нь зангиран дуугүй болжээ.
- Сирмион ухасхийн орж ирээд: нас барагчийн биеийг, одоохон онгоцноос гаргаж шалан дээр жинтүүнүүд эгнүүлээд засаж түүн дээр хэвтүүл гэж тушаагаад Суллын судсыг барих, зүрхийг чагнах зэргээр үзээд царай нь хувьсхийж:
- Өнгөрчээ… нэгэнт нас барчихсан байна! гэлээ.

Эвтибадигийн захидлыг авчирсан түүний боол, Диодорын хойноос онгоцны өрөөнд орж ирээд, энд болж б айсан хэрэг явдлыг харж, найн гайхаж, өрөөний нэгэн буланд зогсож байснаа энд байсан хүмүүсийн дотроос хамгийн голлох хү нь тэр байна гэж Хризогоны дэргэд хүрч очоод:

-Миний нёогттой үзэсгэлэн гоо Эвтибида , энэ захидлыг суллын гарт нь хүргэж өг гэж надад даалгасан юм . Гэтэл энэ хүн бүхний дотроос хамгийн агуу их хүний нас бараад байх үед тохиолдох шийтгэлийг , тэнгэр надад ноогдуулах гэж нэгэнт шийдсэн учир,
Суллад гардуулан өгвөл зохих байсан энэ захидлыг чамд өгье гэж хэлээд захидлаа Хризогонд гардуулалан өгчээ .

Амссан гашуудалдаа болж , ухаангүй шахам байсан Хризогон асралт сайын ноёныхоо хүүрийн дэргэд
түүртэн хэвээр байж, тэр захидлы нь авч цамц туник хоёрынхоо завсраар өвөрлөн тэр тухай огт мартаж орхижээ.

Суллын нас барсан тухай мэдээ ордны дотор тархан, амьтан санд мэнд болцгоолоо . Уйлсан ёолсон боолчууд тал бүрээс цугларан онгоцны өрөөнд орж ирцгээлээ . хэдхэн минутын дараа алиа жүжигчин Метробий уухилсаар бас орж ирлээ . Энэ нь ромоос гарч галзуу хурдаг довтолсоор явж дөнгөж сая ирсэнб айжээ .

Метробийг онгоцны өрөөнд орж ирэхий нь харваол хувцас нь уранхай тасархай , царай нь цав цагаан болсон байсны дээр, хоёр нүднээс нь нулимс асгаран байжээ . тэр нь:

- Үгүй … арай ч ийм байж болшгүй! Үгүй, үгүй… энэ худал гэж хашгачсаар явжээ .
- Метробий , суллын үхэж хөшсөн биеийг нүдээр харж улам гашуунаар уйлж а мсгалгүй болсон хүүрий нь дэргэд шалан дээр сууж, Суллын нүүрийг олонт үнсэн:

Үлгэрлэшгүй анд минь.. хайрт нөхөр минь… чи
миний үгүй хойгуур нас баржээ … би
чинийхээ сүүлчийн үгийг сонсож чадсангүй …
би чинийхээ сүүлчийн үнсэлтийг хүлээн авч чадсангүй ээ, миний хайрт
Сулла минь ээ, миний эрхэм Сулла минь ! гэлээ

**СУЛЛЫН НАС БАРСНЫ ДАРАА БОЛСОН ХЭРГҮҮД**

Суллын нас барсан тухай мэдээ бүх Итали даяар цахилгаан шиг хурдан тархаж, газар сайгүй, ялангуяа Ромд их сандрал болж байлаа.

Энэ тухай бүх нийтээрээ гайхаж байжээ. Суллын хэзээ, хаана, яаж нас барсан тухай хүн бүхэн бие биесээ асууж, мөн тааж тоймлон ярилцах болжээ.

Суллын нас барсан явдлыг олигарх, патриций болон баячуудын намынхан аймшигт их гарз хохирол, бүх нийтийн аюул гэж үзэж харамсан гашуудаж байлаа, мөн эдгээр хүмүүс нь чанга орь дуу болж, нас барсан тэр хүний биеийг эзэн хааны хүүрийг оршуулах ёслолоор оршуулах хэрэгтэй, тэр хүн бол тус Бүгд Найрамдах Улсыг аврагч, тэнгэр шахам хүн юм, түүнд зориулан баримал дүрс, орд харш бриулах хэрэгтэй гэж бусдаас шаардаж байжээ.

Эдгээр хүмүүсийн хойноос, Суллын өршөөлөөр чөлөөлгдсөн арван мянган боолчууд дагалджээ. Хүмүүсийг хууль бусаар шийтгэж хурааж авсан хөрөнгийнхөө зарим хэсгийг Сулла тэр боолчуудад өгсөн юм.

Энэ арван мянган хүн, Суллад үнэхээр баярлан талархсан учраас, түүнийг хүндэтгэн тахиж байсан биш, харин Суллын ажилд байхдаа тэдэнд өгсөн юм шиг үхсэний нь дараа эргүүлэн авчих бий гэж айж байснаас тэгж түүнийг хүндэтгэн биширдэг байсан юм.

Суллын цэргийн легионуудад албан хааж, митридатын эсрэг дайн ба иргэний дайны үед Марийн эсрэг тэмцэж явсан зуун хорин мянган хүн Италид байдаг бөгөөд тэд нар нь Суллын талд байсан юм. Цэргийн энэ хүмүүс нь Суллаас Митридаттай тэмцэж байх үедээ, оршин суугчды нь хөөж зайлуулсан буюу хүйс тэмтрэн үгүй хийсэн хотуудаар голлож суудаг байлаа. Ялагдагчдын хөрөнгөнөөс энэ цэргийн хүмүүст Сулла хувь хүртээсэн бөгөөд мөн энэ зуун хорин мянган цэргийн хүмүүс нь Суллыг ихэд хүндэтгэж үздэг байсан юм. Иймийн учир эдгээр хүмүүс нь Суллын хийсэн бүхний хамгаалахад бэлэн байсан юм.

Энэ хүчтэй намынхны эсрэг, хэдэн зуун мянган цөлөгдөгсөд, Суллын довтолгоонд хохирсон хэдэн зуун мянган хүмүүс бас Марийн намынхнаас үлдэж байсан их хүч болох олон мянган хүмүүс зогсож байсан явдлыг баяр хөөрөөр тэмдэглэж байжээ.

Суллын дайснууд нь хамаатан садан хань нөхдий нь алж талж, хөрөнгө зөөрий нь үрж бусниулсан тэр хүн болох Суллыг ил хараан зүхэж түүнээс өшөөгөө авахыг уриалж хүзсэж, бас шинэ эргэлтийг хүсэж байсан юм.

Суллын уршгаар олон тооны эрх мэдлээсээ хасагдаж бас урьд эдпэлж байсан олон хөнгөлөлтүүдээ хасагдсан плебейчүүд дээрх хүмүүстэй санаа нэгтэй байлаа. Тэд нар хасагдсан бүхнээ эргүүлэн олж авахыг хүсэх нь зүйн хэрэг байжээ.

Иймийн учирдарангуйлан захирагч агсан хүний нас барсан тухай мэдээ, олон жилийн дотор тохиолдож байгаагүй их хөл хөдөлгөөн, яриа хөөрөөг Ром даяар гаргасан юм.

Форум, базалик, портик, орд харш, гудамж, дэлгүүр, зах зээл, гназар сайгүй янз бүрийн насны, янз бүрийн хүмүүс шинэ зүйлийг бие биеэсээ асууж мэдэлцэн хариулж, тайлбарлан, зарим нь тохиолдсон гай гарзыг гашуудан тэмдэглэж уйлалдан, бас зарим нь тэр тамлан зовоогч Суллад хараал зүхлийг явуулж, Суллыг тонилгон аваачиж Бүгд Найрамах Улсыг чөлөөлсөн тэнгэрт чанга дуугаар баяр хүргэнэ. Хоёр янзын саналтай хоёр хэсэг хүмүүсийн хоорондох хэрүүл маргаан гарч, бие биеэ айлган занах далдуур бие биеэ үзкэн ядах, бие биендээ хорсох явдал их дэлгэрч байжээ.

Энэ үймээн хөдөлгөөн улам хүчтэй боллоо. Завсан хоорондоо тэмцэлтэй намуудын консулууд, энэ хүртэл зөвхөн хоорондоо тэмцэл явуулж байсан бол одоо тэмцэл нь улам хурцдаж, урд урдаасаа жагсан босдог болжээ. Ач холбогдол ба нэр хүндийн талаар энэ хоёр нам тэнцүү байсны дээр удирдагчид нь ч бас тэнцүү байсан юм. Ингээд иргэний дайн үүсэх нь зайлшгүй болсны дээр үүсэх цаг нь ч ойрхон болжээ.

Олон сенат, иргэд, чөлөөлөгсдөд, гашуудлын тэмдэг болгон сахлаа тавьж, хар өнгийн тога өмсөж уйтгартай царайлан явцгааж байна. Олон эхнэр ч бас гашуудан үсээ задгай тавьжээ. Суллын үхсэн явдал Ромд асар их гай гамшиг авчрах мэт тэр эхнэрүүд тэнгэрээс өршөөл гуйж нэгэн сүмээс нөгөө сүм рүү гүйлдэж байжээ.

Суллын дайсныыд, түүний үхсэн явдалд баясан, Форум ба гудамжуудаар баяртай алхлан явцгаах бөгөөд бас шаналан уйлагчдыг шоолж, тэднийг дорожлон тавлана.

Хотын төвд байдаг, зарлал наах газарт, тусгай хүснэгт дээр бичсэн шог шүлэг наалттай байжээ. Энэ нь Суллын нас барснаас хойш гурав хоногийн дараа байсан юм.

Тэр шүлгийн үг нь иим байжээ.

Ромын эзэн, хувьтай дарангуйлагч гэж
Сулла өөрийгөө нэрлэжээ.
Тусгүй муу хүслийнх нь хариуд
Тэнгэр түүнийг шийтгэжээ.
Гутамшигт байдлаар Ромыг сөгдүүлэн
Гашуун зовлонд хүргэх гэж найдсан түүнийг
Гайхамшигт тэнгэр шийтгэн залхааж
Өг бөөсний хоолонд илгээв гэжээ.

“Найр цэнгэлийн зардлын хууль сөнөтүгэй! Трибунуудад үл халдах эрхийг шаардаж байна!” гэсэн бичиг бас үүзэгдлээ. Суллын шууд дарангуйлах харгислал нь ялангуяа энэ хуулиадад тодролоо олсон байжээ. “Кай Марий алдарштугай!” гэсэн үг бас зарим нэгэн газар дайралдаж байлаа.

Энэ баримтууд ба энэ догшин явуулгууд нь хүмүүсийн ухаан санаа эргэснийг гарцаагүйгээр гэрчилж байжээ. Суллын амьд байх үед хүртэл дургүйцлээ нуудаггүй байсан Марк Эмилий Лепид нь миний ард, ард түмэн

банйа, миний хамт Марийн намынхан байна гэж хатуу итгэж улам ч зоригтой улам ч шийдвэртэй болсон юм.

Харин өөр нэгэн конгсул Лутаций Катул би сенат ба хуулийн талд хатуу зогсоно гэдгээ бусдад ойлгууллаа.

Катилина, Суллатай ямагт сайн харилцаатай байсан боловч энэ үймээнд оролцсон юм. Учир нь Катилина шинэ юм бүтээх хийхийг олон жил мөрөөдөж ирсэн хүн болохоороо тийм шинэ юм бүтээхэд надаас гарз гарахгүй боловч бүтээсний дараа надад их ашигтай болох юм гэж ойлгодог хүн байжээ.

Иймийн учир Катилина ба түүний нөхөд олигархыг үзэн ядаж дургүйцлээ дүрэлзүүлж байсан хүмүүсийн дунд, ухуулга хийж, түүдэг шатаан, тэдний дургүйцлийг улам дүрэлзүүлжээ.

Харин Кней Помпей ба Маръ Красс хоёр иргэний дайн шинээр гарахад хүрвэл эх орон Бүгд Найрамдах Улс маань хохирох болно гэдэг сэтгэлийг хүмүүсийн дунд төрүүлэх, тэднийг хууль хүндэтгэх ёсонд итгүүлэх, тэдний санал сэтгэлийг тайвшруулах эхэргт өөрсдийнхөө нэр хүнд алдар гавъяагаа ашиглахыг ородсон юм.

Митридатыг ялсан ялгуулагч нь хүн нас барсан Суллын хүүрийг яаж хүндэтгэн оршуулах тухай асуудлыг зөвлөхөөр сенатын хурал Гостилияд боллоо.

Хурлын танхим ба зэргэлдээ барйуудад хүн дүүрэн цугларсан байлаа. Сенатчуудын байранд ер бусын үймээн зогсолтгүй хөдөлгөөн үзэгдэж байлаа.

Зориг чадал, оюун ухаанаараа гарамгай гэж алдаршсан бөгөөд урьд консул байсан, Публий Сервилий Ватия Изаурик энэ хурлыг даргалжээ. Тэр нь хурлаа нээж үг хэлэх зөвшөөрлийг Квинт Лутаций Куталд олгов.

Үг хэлсэн энэ хүн, Суллыг үзэн ядагчдын дургүйцлийг дуудахаар түүнийг магтсангүй зөвхөн түүний замнаж ирсэн алдарч өдрүүдин тухай энгийн даруу үгээр сайшаан дурлаж: Суллаас, Югуртыг Африкт олзлон авсан тухайг Архелайг Керонийн дэргэд бут ниргэсэн тухайд бас Суллын эрэлхэг зоригтойг тэмдэглэн хэлээд ийм хүний хүүрийг хүндэтгэн оршуулах хэрэгтэй юм. Суллын хүүрийг хүндэтгэн оршуулбал зохино, тэгж оршуулах нь ч ромын ард түмний нэр хүндэд Суллын өөрийн нь нэр хүндэд зохих хэрэг юм гэж энд байсан хүмүүст хандан хэлээд:

-Суллын биеийг гоё сайхан ёслолоор Кумыгээс Ромд аваачиж Марсын талд оршуулах саналыг үгийнхээ төгсгөлд гаргажээ.

Катулын товчхон үгийг, сенатын түшмэдийн баранд сууж байсан бараг бүх хүмүүс, шуугин сайшааж, харин галерейд байсан хүмүүс дургүйцэн шүүмжилж, хүчтэй шуугианаар хариулав.

Чимээ намдсаны дараа Лепид босч:

-Эцэг сенатын түшмэд нар аа сайхан сэтгэл, эрэлхэг зоригийн нь хувьд үнэлдэг, алдартай нөхөр Катултайгаа өнөөдөр би санал зөрөх болсондоо үнэхээр харамсаж байна. Миний бодвол Ктул, улсынхаа сонирхлын үүднээс ч биш мөн

эх орныхоо алдар хүндийн үүднээс ч биш, харин уяхан сэтгэлийнхээ нөлөөгөөр, огт нийлэлцэхгүйгээр ч үл барам, шударга бус бөгөөд хортой санал гаргаж байна. Тэр нь бүх зүйлийг Суллын ашиг тусын тул өгүүлсэн нь энэ хүндэт хурлаас шийдвэр гаргуулан, нас барагчийн хүүрийг эзэн хааны хүндэтгэлийн ёслолоор ёслон, Марсын талд хаадыг оршуулдаг журмаар оршуулахад хүргэж магадгүй байна. Гэтэл манай эх оронд Суллын авчирч өгсөн гамшиг зовлонгийн тухай, яргалан алж, нэрээ хөөдсөн тухай нь ч Катул мартсан байна. Тэр тухай мартвал нь түүн дээр байсан байлгүй Суллын нэрээ хөөдсөн тэр гутамшигт бузар явдлуудын нь тухай айх ичих, нуух далдлахгүйгээр хэлэх хэрэгтэй байна гэлээ.

Энэ удаад дургүйцлийн хүчтэй шуугиан сенатын түшмэдийн дотор гарч, харин галерейд маш хүчтэйгээр алга таших чимээ нирхийлээ.

Ватия Изаурик бүрээчдэд дохио өгч, тэд бүрээгээ дуугарган ард түмнийг чимээгүй болоход уриалав.

Эмилий Лепид үгээ үргэлжлүүлэн:

-Далдлахгүй ярьцгаая, Суллын нэр нь Ромд гай зовлон авчрагч хүний нэр мэт сонсогддог юм. Ялт тэрслэл ба гутамшигт бузар явдлын уршгаар дарангуйлан захирагч агсан Суллын нэр бузардсан юм. Эх орныхоо хуулиудыг хааш хэрэг хаяж, консулуудын сайн чанар бүхнийг хог шороотой хольсон явдал, трибунуудын нэр хүндийг барсан явдал, захиргааны зарчимд оруулсан хэмжээгүй харгис ноёрхол, мянга мянган гэмгүй иргэдийг алсан явдал, хууль бусаар шийтгэн зовоох ичгүүртэй явдал, дээрэм хүчирхийлэл, хоосруулан тонох явдал гэх мэт болон бусад бузар явуулга бүхэ нь Суллын нэртэй холбоотой бөгөөд Бүгд Найрамдах Улсаа устгах эх орондоо хор хүргэхэд чиглэсэн юм. Иймд Суллын нэр, шударга хүн бүхэнд зөвхөн муу бүхнийг санагууладг юм. Хүсэл дур, авир зан бүхнээ хууль болгож байсан тэр хүний хүүрийг өнөөдөр бид хүндэтэл ёслолоор оршулж, бүх нийтийн гашуудал хийх гэж байнам.

Яаж ингэж болох вэ?… Бүгд Найрамдах Улсыг сарниан бутаргасан Луций Суллын хүүрийг, энэ Бүгд Найрамдах Улсыг анх үндэслэн байгуулагсдын нэг нь байсан нийтийн хүнэдтгэл болсон Публий Валерия Публиколын шарилын сүндэрлэж байдаг Марсын талд оршуулж яаж болох вэ? Манай өнгөрсөн үеийн аль алдартай ба гавъяатай иргэдийн шарилыг, сенатын тусгай тогоолоор оршуулсан тэр газарт манай үеийн аль гарамгай гайн иргэдийг алж, цөлсөн хүний хүүрийг оршуулна гэдэг чинь байж болох хэрэг үү? Манай эцэг өвгөдөөс сайн үйл хэрэг бүтээсэн хүнд шагна бологон хүртээж заншсан тэр зүйлийг саар муу явдалтай хүн олгож өгнө гэж үү?

Энэ манай алдар нэрд таарахгүй, энэ нүүргүй явдлыг бид яагаад хийх болсон билээ.

Энэ чинь Суллын, хамгийн хүчтэй ширүүн харгислал хүчирхийлэлд дайрагдсан газрууд болох, Италийн хамгийн гоё сайхан газраар байртай болсон.

Суллын талд байлдаж байсан хорин долоон хорооны цэргийн хүмүүсээс айж байгаа хэрэг үү?

Аль энэ чинь бид Суллаас дур зоригоороо аашлан, ганцаар ноёрхох эрхэндээ эрэлхэж, манай хэв заншил, хууль ёсыг зөрчиж, чөлөөтэй хүмүүс болгон суллаж, хамгийн хүндтэй хамгийн эрхэм нэр болох Ромын иргэд гэж нэрлэсэн, тэр арван мянган хамгийн доорд муу сайн боолчуудаас нь айж байгаа хэрэг үү?

Газар сайгүй тархан дэлгэрч байсан, Суллын хүчирхэг бөгөөд хортой муу үйл явдлаас газар сайгүй айн чичирч сэтгэл санаагаар унаж байсан учир эх орныхоо хуулийг хамгаалкъя эгж сенат болон ард түмнийг уриалах хүн, Муллын амьд байх үед ард түмний дотроос гараагүй йбайж гэж бодъё. Харин одоо бол яагаа үнэнч бус байсан хүнийг үнэнчид тооцох, хорт муу хүнийг агуу сэтгэлтэнтэй адилтган үзэхэд хүрч байгаа билээ? Ромыг өршөөн ивгээгч тэнгэрийн өмнөөс эцэг сенатын түшмэд та нараас асууя%

Эцэг сенатын түшмэд ээ эх орныхоо хувь заяанд итгэл бүрэн тасрахад намайг хүргэхгүй биз ээ, нэр хүндээ бодох санаа, эрэлхэг зориг, сайн үйл бүтээх хүсэл энэ эрхэм хурал бий байх гэж найдах зөвшөөрлийг надад олгоно уу, сенатын түшмэдийн дотор айх муу сэтгэл ноёрхож байдаггүй харин өөрслийнхөө агуу өндөрт бат итгэх сэтгэл ноёрхож байдаг юм гэдгийг батална уу.

Луций Корнелий Суллын хүүрийг Марсийн талд агуу их иргэн алдарт эзэн хааны шарилыг оршуулахад гүйцэтгэдэг хүндэтгэлийн ёслолыг гүйцэтгэн оршуулах тухай гаргасан саналыг, иргэний шинэ үймээний бамбар гэж үзэж бас нэр хүндэд таарахгүй ёс журамгүй хууль гэж үзэж няцаагтун гэлээ.

Марк Эмилий Лепидын энэ зоригтой бөгөөд гүн сэтгэлийн үгийг хүмүүс их л шуугин ала ташиж хүлээн авлаа. Галерейд цугларсан ард түмнээр ч барахгүй бас олон сенатын түшмэд хүгтэл алга ташицгаажээ.

Чимээ намдсаны дараа Ромын сенатын түшмэдийн дотроос хамгийн залуугийн нэг, хамгийн хартай, юу ч л гэсэн хамгийн алдартай нь болох агуу их Кней Помпей босож, ерөөс уран үгтэй хүн биш учраас, нарийн гоё үгээр биш боловч зүрхний угаас гарсан гүн сэтгэлийнхээ үгээр Луций Суллын хойтох магтаалын үг хэллээ. Энэ хүн Суллын гарамгай гавъяа зүтгэл бас сайн үйл хэргий нь магтсангүй, бас зүй ёсоор буруу нь түүнд хүлээгдвэл зохих, түүний үйлдсэн хэргийн бузар баримтууды нь ч хамгаалсангүй, харин тэр гутамшигт үйл явдлууды нь Суллад биш харин төрийн толгойд Суллын сууж байсан үед тохиолдсон. Бүгд Найрамдах Улсын сарнисан хэвийн биш байдал , энэ аймшигт цаг үед зайлшгүй тохиолдох захирах тушаах явдалд ноогдуулжээ.

Помпейгийн хэлсэн, нуух далдлах санаагүй, энгийн гүн сэтгэлийн уг нь хүн бүхэнд, ялангуяа сенатын түшмэдэд их сэтгэгдэхүүн төрүүлэв. Үүний дараа Лентул Мура, Квинт Курион нар, хурлын шийдвэрийг, консул Квинт Лутаций

Катулын гаргасан саналын эсрэг чиглүүлэхийг ородсон боловч амжилт олсонгүй.

Энэ саналыг суудлаасаа босох журмаар тасалсан бөгөөд энд байлцсан сенатын түшмэдийн тавны дөрөв нь зөвшөөрчээ.

Зарим нэгэн түшмэдийн шаардлагаар явуулсан нууц сонгуулийн дүнд Катулын саналыг гурван зуун хорин долоон хүн зөвшөөрч ерэн гурван хүн татгалзжээ.

Шуугиантай энэ хурал ингэж Суллын намынхны ялалтаар таржээ. Хурлын шуугиан байрнаас гадагш гарч, Гостилиягаас Комицид хүртэл тарж, олон нийтээрээ, янз бүрийн санал хүслээ оргилуулан илэрхийлэх шалтгаан болжээ. Зарим хэсэг нь алга ташин Лутаций Катул Ватия Ицаурик, Кней Помпей, Марк Красс нарт баяр хүргэж хүлээн авч байжээ. –Энэ хүмүүс бол Суллын талынхан байжээ, нөгөө хэсэг нь Катулын эсрэг суурьтай тэмцсэн нь бүгдэд илэрхий болсон Марк Эмилий Лепид, Сергий Катилина, Лентул Сура нарыг улам ч их хөөр шуугиан, баяр талархлаар хүлээн авч байлаа.

Энэ хурал дээр блсон тэмцлийн тухай завсраа их л халуунаар хэлэлцсээр, Помпей, Лепид, Сергий Катилина, Лентул Сура нарыг улам ч их хөөр шуугиан, баяр талархлаар хүлээн авч байлаа.

Энэ хурал дээр болсон тэмцлийн тухай завсраа их л халуунаар хэлэлцсээр, Помпей, Лепид хоёрыг хурлын байрнаас гарч ирэх үед бөөгнөрөн чихцэлдэж байсан хүмүүсийн дунд мөргөлдөөн гарах ч бүр шахжээ. Хэрэв Помпей, Лепид хоёр сугадалцан, бөөгнөрөх шахцалдаж байсан тэр хүмүүсийн дундуур өнгөрөхдөө, өөр өөрийнхөө талын хүмүүсийг номхруулан тогтоож, ёс журам дагаж чимээгүй болцгоон гэр гэртээ харьцгаа гэж өндөр дуугаар хориогүйсэн бол энэ мөргөлдөөн заавал цус асгаруулахад хүргэх мөргөлдөөн болох байсан билээ.

Гэвч тэдний энэ аргадалт нь хотын хүн олонтой гудмууд гуанзнууд Форум ба базиликууд, портикуудын доогуур болсон ширүүн хэрүүл шуугиан, цус асгаруулсан мөргөлдөөнийг урьдаас царан зайлуулж чадсангүй юм. Иймийн учир, энэ шөнө алагдсан олон хүний хойноос уйлах ба улам ч олон тооны шархдагсдын төлөө шаналан гаслах явдал тохиолджээ. Ард түмний намын талыг баримтлагчдын гол хэсэг нь Суллын талынхны гол хэсгийн хүмүүсийн орон байрыг шатаах гэж ч оролджээ.

Ийм явдал Ром хотноо болж байх үед, манай ярианд бахадвал зохих үүнээс ч багагүй чухал өөр явдлууд Кумыд болж байжээ.

Дарангуйлан захирагчийн гэнэт нас барснаас хойно, хэдхэн цагийн дараа, өмссөн хувцас, гадаад байдлаас нь харвал гладиатор бололтой нэгэн хүн Капуягийн зүгээс Суллын байшингийн дэргэд ирж, Спартактай уулзаж болно уу гэж асуулаа.

Энэ хүн дөч орчим насны бөгөөд, асар өндөр нуруутай аварга биетэй ажээ. Энэ хүнийг харвал ер бусын хүч тэнхээтэй хүн байх ёсто йгэж бодмоор.

Түүний царай боровтор нүүр нь хэв ур муутай, бас цагаан бурхны сорви барзан цоохортож тогтсон баргар хүйтэн царайтай, бараг муухай гэгдмээр хүн байлаа.

Түүний зоригтой бөгөөд цогтой, хурц харцтай хар нүдэнд нь зэрлэг араатны ширүүн янз байлцана. Түүний дэл шиг өтгөн үс, бас арзайтал боссон сахал нь зэрлэг байдлы нь улам ч хүчтэй болгоно.

Хэдий ширүүн дүртэй бловч энэ хүн, хүний талархлыг тэрхэн дороо татдаг байжээ. Зэрлэг боловч үнэнч, бүдүүлэг боловч шударга бадйал түүний нүүрэнд илхэн тусч, ахрц бүхэн хөдөлгөөн бүхэнд нь омог бардсан сайхан чанар тодрон гэрэлтэж байлаа.

Суллын ордны дэргэд гладиаторуудын сургууль төв ордноос нилээд зайтай байсан учир Спартакийг дуудахаар нэгэн боолын очих зуур, энэ асар том биетэй хүн, Суллын ордон ба гладиаторуудын сургууль хоёрын завсрын хоёр талаараа таримал модтой гудамжаар өөдөө сөөргөө алхлан зугаацаж явжээ.

Арван таван минут болоогүй байтал боол буцаж ирлээ. Түүний хойноос Спартак яарсаар ирж хоёр гараа дэлгэж зочныхоо урдаас тосож очлоо.

Хоёр гладиатор тэврэлдэн үнсэлдлээ.

Спартак эхлэн дуугарч:

-Эномой, сонин юу байна? Гэхэд

-Сониноос цөм хуучнаар л байна юу ч хийдэггүй, юунд ч хөдөлдөггүй, сэргэлэн бадаггүй тэр хүн бол ёстой л залхуу хүн мөн гэж би хэлж байна. Хайрт Спартак минь ээ, миний бодвол гартаа илд барьж бослогынхоо тугийг өргөх цаг болсон байхаа гэж санагдана гэж гладиатор, эрс бөгөөд гүн, чанга дуугаар хэллээ.

-Эномой, чи дуугүй бай! Германчуудыг өршөөгч тэнгэрийн нэрийг дуудан ам алдъя чи зорьсон хэргээ нураах гэв үү! Гэлээ.

-Хаанаас тэр хэрэг маань гялалзсан амжилт олоосой гэж би хүсэж байна гэж Эномойгийн хэлэхэд Спартак:

-Тэгэхгүй яахав гэхдээ харин, дэмий чалчсанаар биш сайтар бодсоноор сайтар болгоомжилсноор бид амжилтыг олно, чи бол би их адгуу халуун хүн шүү гэлээ.

-Амжилт олох байгаа? Чухам хэзээ вэ… гэдгийг л би мэдэх хэрэгтэй байна гэж Эномойгийн асуухад:

-Манай хувалдаан бойжиж гүйцсэн тэр цагт л болно доо гэж Спартак хариулжээ.

-Азнатал, бүгд бэлэн болно! Манай бослого шиг жимс хичнээн амархан боловсордгийг чи мэдэх үү? Эрэлхэг чадал, зориг, муйхар л хэрэгтэй даруйхан эхэлье, урагшаа хөдөлье, чи харж байгаарай! нэгэнт л бид гудамжинд гарсан байвал хэрэг ажил аяндаа бүтнэ.

-Миний үгийг сонсож бай… тэсвэрлэ! Гурван сарын дотор Лентул Батиатын сургуулиас манай холбоонд хичнээн хүн нийлсэн бэ?

-Нэг зуун гуч

-Арван мянгаас ердөө зуун гуч ирсэн гэх… тэгээд манай хөдөлмөрийн үр бүтээл сайн болжээ гэж чамд санагдаж байна гэж үү! Гэж Спартакийн хэлэхэд:

-Хэзээ гладиаторуудын бослого үүсэн гарсан тэр цагт интоор жимс боловсорч эхлэхтэй адил м болно. Нэг нь нэгийгээ дагуулах болно гэж Эномой өгүүлжээ.

-Юу болж байгааг ч мэдэхгүй, биднийг хэн болохыг ч мэдэхгүй, юу руу зорьж яваа, төлөвлөгөөгөө амжилттай биелүүлэхийн тул ямар хөрөнгөтэй байгааг ч мэдэхгүй байж яаж тэд нар бидэнтэ йнийлэх юм бэ? … адилхан зовж байгаа нөхөддөө итгүүлэх итгэл хэдийчинээн гүн байх тусам манай ялалт төдийчинээн магадтай болно.

Шатамгай зантай Эномагийн бодол болон, чимээгүй болоход Спартак үгээ үргэлжлүүлэн:

-Лентул Батиатын сургуулийн арван мянган гладиаторын дотроос хамгийн хүчтэй нь болох Эномай чи, өнөөдрийн өдөр хүртэл юу хийв дээ? Эр зориг, хүч чадлаараа тэдний дунд олж авсан нөлөөгөө яаж чи ашиглав? Хичнээн хүнийг маанй байлдааны холбоонд татаж оруулав? Бидний бодож гаргасан үйл хэргийн мөн чанарыг мэддэг хүн хичнээн байна? Чамайг төдий л итгэдэггүй, чиний хөнгөн хийсвэр адгуу яаруу зангааж айж болгоомжилдог хүн бий юу? Намайг юм уу, ядахдаа Криксийг ч таньдаг хүн олон байна уу? гэж Спартакийн асуухад: Би чамтай адил боловсролтой хүн биш болох учраас сайхан сэнхрүүлэхээр яржьж чаддагүй юм гэвч сургуулийн эзэн Батиат чамайг урьж сургуульдаа хатгах жадлах хичээл заагаасай гэж бүх хүчээрээ л ородлоо.

Би хүссэнээ ч бүтээлээ. Чамайг Капуяд ирээч гэж урьж энэ захидал надаар явууллаа гээд: бүснээсээ багавтар хуудас цаас гаргаж Ёпартактд өглөө.

Спартак тэр цаасы нь чичирсэн гараараа шүүрэн авч лацы нь ховхлон, сэтгэл догдлон уншлаа. Захидлын үгээс үзвэл тэр хүн Спартакийн уран чадвар, эрэлхэг зоригийн тухай дам сонссон байх бөгөөд чи зөвшөөрвөл Капуяд ирж манай сурагчдад хичээл зааж өгөхгүй юу гэж Спартакийг урьжээ. Сайхан хоол их цалин хүртээж олгож байна гэж бас бичсэн байжээ.

Спартак захидлаа өвөрлөн –ухаангүй амьтан минь ээ. Дэмий үг ярьж л байхын оронд ирсэн дороо энэ захидлаа юунд надад эс өгөв? Хэдийгээр найдаж зүрхлээгүй байсан боловч, би үүний чинь л хүлээж байсан юм гэжээ.

Адилхан дорой заяатай арван мянган нөхдийнхөө дунд орно гдээг чинь миний байвал зохих байр ёстой мөн гэж Рудиарийн нүүр нь өнгөтэй болж баясгалант царайгаар хэлж, би:

-Тэнд хүн бүхэнтэй ярилцаж, цээжиндээ дүрэлзэж байгаа үнэмшлээ бүгдэд нь итгүүлнэ. Тэндээс нэгэн өдөр тогтсон дохиогоор арван мянган байлдагчидтай цэргийн анги гинжээ таслан, гинжнийхээ гогцоог дарлагчдынхаа нүүр рүү хаялах арван мянган боол өөрсдийнхөө гутамшигт гинжнийхээ төмрөөр ялагдашгүй илдднийхээ ирийг давтах арван мянган боол гарцгаана… одоо л нэг … одоо л нэг… Ромын бардам бүргэдүүдийн жигүүрийг хорт

шүдээрээ тас хэмлэх могойн шүд хурцлах үүрэнд одоо л нэг хүрэх минь тэр! Гэлээ.

Рудиарий, ухаанаа гартал баярлан, солиорсон юм шиг холбоогүй үг ярьсаар хурдан хурдан алхлн Эномайгаас нэг холдож нэг ойртож байжээ.

Эномай, их баярлан Спартакийг ажиглан харж байснаа, Спартакийн сэтгэл нилээд намдсаны дараа:

-Чиний сэтгэл баяртай байгаад би их баярлаж байна. Манай холбооны зуун гучин нөхөд улам ч их баярлах болно. Тэд нар чамайг тэсгэлгүй хүлээж байгаа, чамайг агуу үйл явдал бүтээнэ гэж тэд найдаж байгаа… гэхэд нь:

-Тэд дэмий их юм горьдож байгаа юм байна даа… гэж Спартак хэлжээ.

-Тэд, үймүүлэгчдийг түвшитгэхээд чи тэдний дунд очвол их чухал болно… гэж Эномайгийн хэлэхэд:

-Тэд бол чиний хамгийн дотно нөхөд болох учир чамтайгаа адил хазааргүй улс байгаа бизээ…Ойлгож байна! … ийм ч учраас миний Капуя очих явдал, манай хэрэг ажилд ашигта йболно. Нурах уюлд хүргэж болох ямар нэгэн гэнэтийн бодолгүй хөнгөн хэргийн гарах явдлыг би хорьж тогтоож чадна… гэж Спартак хэлжээ.

-Спртак аа, би хэзээд чиний дэргэд явалцаж, чиний үгийг тэсвэртэй дагаж, чиний тушаасан бүхнийг биелүүлж байна гэж чиний өмнө баталъя гэж Эномай хэлжээ.

Хоёулаа дуугүй боллоо.

Эномай, догшин хацртай нүднийхээ харж чадах хэмжээгээр Спартакийг усгал зөөлөн бөгөөд хайр дураа илэрхийлсэн харцаар харж байтлаа гэнэт дуугарч:

-Спартак аа, одоогоос сар гаруй хугацааны өмнө би чамайг анх харсан билээ. Родоо бол чи улам ч гоо, улам ч сайхан болсон шиг байна! Чи намайг уучлаарай, эхнэр хүн шиг гоо сайхан болжээ гэж чамайг одоо хэлж болохоор бана… гэвч энэ эхнэр хүн шиг гэдэг үг чамд тохирохгүй юмаа гэж хэлтэл Спартакийн царай мэдэгдэхүйц цайвар болж:

-Тэнгэр минь ээ!.. тэр минь яадаг билээ?… гэж маш нам дуугаар аман дотроо хэлэх нь аварга биетэй Эномайд бүүр түүр сонсогдлоо.

Эрх чөлөөнд дуртай, дарлагдагсадтай ах дүүгийн барилдлагаатай бөгөөд ялалтанд итгэсэндээ болж хайртай бүхнээ түр мартах ёсто боллсон хөөрхий тэр рудиарий, санаандаа гэнэт орсон хүнд зүйлийг бодолхийлэн зогсож байжээ.

Спартак ингэж удаан зогслоо. Спартак уйтгарласан сэтгэлдээ дарагдан, ганц ч үг дуугарсангүй. Сэтгэлийн зовлонитой байгаа Спарткийг харж Эномай ч бас уйтгарлан зогсож байлаа.

Эелдэг зөөлөн дуугарахыг аль болохоор хичээн оролдож:

-Тэгээд, Спартак, чи биднийг орхих нь уу?… гэж герман хүний асуухад, Спртакийн тунгалаг харцтай цэнхэр нүдэн дээгүүр нь нулимс гүйлгэнэн Эномайг харж:

-Би та нарыг хэзээ ч орхихгүй! Хэзээ ч орхихгүй! Урьтаж би охин дүүгээ, урьтаж би… орхино гэж чичирсэн дуугаар хэлжээ.

Спартак түр зуур чимээгүй байснаа, үгээ үргэлжлүүлж:

-Би бүгдийг… бүгдийг… орхивч, би дарлагдасдын үйл хэрэг, бүгдэд мартагдсан боолчуудын үйл хэргийг… хэзээ ч орхихгүй!…. хэзээ ч орхихгүй! Гээд

Бас хэсэгхэн чимээгүй байснаа, нэмж:

-Эномай саатах хэрэг алга, нааш ир , явъя хэдийгээр өнөөдөр энэ башийнд гүн гашуудалтай байгаа боловч, Суллын гал тогооны газраас чамд юм олдох байхаа. Бидний холбооны тухай хэнд боловч ганц ч үг хэлж болохгүй, ямар ч уур хилэн, хараал зүхлээ цухуйлгаж огт болохгүй! Гэж хэлээд Спартак галадиаторыг дагуулан ордны дотуур явлаа.

Луций Корнелий Суллын биеийг улсын хөрөнгөөр хүндэтгэлийн ёслол үйлдэн оршуулах тухай сенатын хурлын тогтоол гарснаас хойш арван хоёр хоног өнгөрсний дараа, оршуулах ёслолын аялал дарангуйлан захирагч агсан хүний байрнаас гарч Ром хотыг чиглэн хөдлөв.

Нас барагчийг хүндэтгэхээр, Италийн өнцөг булан бүхнээс хүмүүс энд цугларчээ.

Шарил залсан тэрэг, Кумээс гарахад түүнийг дагалдан явсан консул Лутаций Катулаас гадна сенатын хоёр зуун түшмэд мөн өдий тооны Рмын морин цэргийн хүмүүс Кумы Капуя, Бай Геркуланум, Неаполь, Помпей, Путесл, Литернум хотууд болон кампанийн бусад хот тосгоны бүх патриций Италийн бүх хот ба орон нутгийн захиргааны төлөөлөгчид, хорин дөрвөн ликтор консулын далбаа Суллын төлөө байлдаж байсан цэргийн бүх хорооны бүргэдүүд ялагдашгүй жолоодогчдоо сүүлчийнхээ хүндэтгэлийг ёслон өргөх гэж зэвсгээ зүүж ирсэн тавь орчим мянган цэргийн эрчүүд, гашуудлын хувцас өмсөж Ром хотоос ирсэн, олон мянган чөлөөлөгдөгч олон хүнээр бүрдсэн бүрээ, бишгүүрчдийн отряд хамгийн гүн гашуудлын байдалтай, бор өнгийн тога өмссөн хэдэн мянган язгууртан авхайчууд гэх зэрэг Кумыд Италийн өнцөг булан бүрээс ирсэн тоо том шгүй олон хүн явжээ.

Эзэн хааны алтан туяат гал улаан баринтагт ороож янз бүрийн үнэртэн хүж шингээж Суллын шарилыг залсан тэрэгний араас Суллын түрүүчийн гэргийгээс төрсөн Фауст ба Фауста гэдэг хоёр хүүхэд нь Валерия, Гортензий болон бусад төрөл сада нь, мөн маш олон тооны чөлөөлөгдөгч зарц нар нь хар өнгийн тога өмсөж дагалдах бөгөөд эд нар бүгдээрээ тайтгаршгүй уйтгараа харуулах гэж оролдож байжээ.

Энэ хүнэдтгэлийн удаан аялал арав хоног үргэлжилжээ. Дайрсан хот суурин бүхнээс хүмүүс нэмэгдэж, аялал улаам бүр өргөжиж улам бүрс айхан болж байжээ.

Суллын шарилыг дагалдсан ёслолын аяллыг угтахаар Ром хотын арав орчим мянган хүн Аппийн замаар гарчээ.

Энэ ёслолын аяллыг Капуаны хаалга хүрэхэд оршуулгын ёслолын захирал, аяллыг улам журамтай, улам гоё сайхан болгожээ. Хэдэн цаг өнгөрсний дара ёслолын аялалд хот хүрэхдээ, дор дурьдсан  дараалаар явжээ.

Бүгдийн түрүүн оршуулах ёслолын захирал явж түүнийг хорин ликтор хүндэт харуулын хорин хүн гашуудлын хар хувцас өмсөн дагажээ. Түүний хойноос, гашуудлын урт лимбэ үлээх хэсэг хөгжимчид, мөн тэдний араас гашуудлын хвцастай, таван зуу гаруй тусгай уйлагчид явжээ. Энэ, тусгай уйлагчид, нулимсаа асгаруулан уйлалдаж, бас үсээ угзчин нас барагчийн гавъяа зүтгэл, гарамгай чадварыг хоолойныхоо хирээр, чанга магтан сайшааж явжээ.

Энэ оршуулах ёслолд улсын сан, хайр найргүй шан хөлс олгоно гэж оршуулах ёслолын дарга зориуд уйлагчдад урьдчилан сануулсан учир, уйлагчид Суллын төлөө зогсолтгүй уйлалдан, нулимс нь үнэн зүрхнээс нь гарч байгаа  юм шиг байлаа. Зориуд уйлагчдын үгээр бол Ромын энэ дарангуйлан захирагчийн үйлдсэн сайн явдал нь Камилл, Цинциннат, Фабриций, Фабий, Мксим, Катон Сципион нарын бүгдийнх нь үйлдсэн сайн үйл явдлыг хамтарснаас ч илүү юм шиг байжээ.

Зориуд уйлагчдын араас бас баахан хөгжимчид, гашуудлын уйтгарт аялгуу дарж явах бөгөөд тэдний хойноос Суллын талд байлдажбайсан хот ба цэргийн ангиудаас ирүүлсэн сайхан хийцтэй хоёр мянга гаруй алтан титмүүд ба бэлгүүдийг хүмүүс авч явна.

Эд нарын хойноос, нас барагчийн хамгийн хайртай  амьтды нь түүдгийн дэргэд аваачиж алах втктмаариуд явцгаалаа.

Тэдний араас, Суллын өвгөд хуучцуулын нь дүрсүүд, Грек Ази ба Италийн дайнуудад ялж  олзлон авсан зүйлүүд ба бас гавъяа байгуулан шагналд авсан зүйлүүд, титэм, сүлжмэл зүүвч зэргүүдий нь зарц нар нь авч явлаа.

Үүний холйноос, бас л баахан хөгжимчид, араас нь Суллын анд нөхөр Метробий явах бөгөөд тэр нь нас барсан найзтайгаа аль болохоор адил болохыг оролдон нүүрээ засаж, мөн нөхрийнхөө хувцсыг өмсөж, ёслолын нь тэмдгүүдийг зүүж явлаа. Нас барсан Сулла амьд байхдаа ямар байсныг дүрслэн үзүүлэх жижигчний роль түүнд ноогдсон байжээ.

Зам дагуу байсан үй түмэн хүмүүс Метробийг шунамгай ширтэн хаж байжээ. Метробийн архан дор, алтан ба эрдэнэсийн чулуугаар үргэлж бүрхэн чимэглэсэн жууз явах бөгөөд энэ жуузыг хамгий чадалтай залуу түшмэд ээлжлэн мөрөн дээрээ дамнан явлаа. Жуузан дотор Луций Корнелий Суллын бие эзэн хааны эдлэлүүдээр хүрээлүүлэн оршиж байжээ. Жуузны ард, нас барагчийн хамгийн ойрын садан төрөл, хайртай зарц нар н вн.

Төрөл садны нь хүмүүсийн араас, Митридатыг ялагчийн шарилыг дагалдан, бүх тахилчил явцгаажээ.

Эдгээр хүмүүсийн хойноос сенатын түшмэд морин цэргийн хүмүүс, хотын патрицууд, иргэдийн аль алдартай бүсгүйчүүд болон тоо томшгүй олон иргэд явцгаажээ. Эд бүхний араас нас барагчийн зарц нар ба боолчууд

явцгаалаа. Зарц нар Суллын байлдааны нь морь, мөн түүнийноход болон бусад амьтды нь авч явжээ. Суллын хүүр шатаах үед тэр амьтдыг алж шатаахад зориулсан ажээ.

Энэ ёслолын аяллын шувтарганд, урьд Суллын командлалын дор байлдаж явсан аль сахилга сайнтай хороодын цэргүүд жагсан явжээ.

Ёслолын аялалд Форумд хүрч, Суллын шарилыг сенатын хурлын байрад илтгэгчийн индрийн яг эсрэг талд тавилаа.

Энд, илтгэгчид, хагацах ёслолын үг хэлж, олигархи намынхан бүгд гашуудлын орь дуу болцгоожээ. Ингэсний дараа, ёслолын аялла, дээрх дарааллаараа аялж, Марсын талыг чиглэв.

Тэнд оршуулах ёслол үйлдэх хэрэгтэй бүх зүйл бэлэн байжээ. Шарилын жуузыг түүдгийн дэргэд газардуулан буулаж, Валерия,  Суллын шарилын дэргэд очиж, заншлын ёсоор түүний зовхийг буулган нас барсан хүний сүнсийг Ахероны давалгаан дээгүүр тэсвэрлэн гаргаж өгөх Хароны хөлсөнд төлөх ёстой гуулин зоосыг аманд нь хийж өгөөд, уруул дээр нь үнсэж, үүрд баяртай! Бид ч болов байгалиас тогтоож өгсөн хугацаа дүүрмэгц чиний хойноос очно гэж хэллээ.

Тэгэхд бүх хөгжимчид гашуудлын аялгуу дарж, хөгжмийн дууны дундуур виктиариуд маш олон амьтдыг тахил болгон алжээ. Тэр амьтдын цусыг сүү, бал бурам болон архитай хольж эргэн тойрон цацжээ. Тэнд байсан үй түмэн хүмүүсийн дотроос түүдэгт аль ойролцоо байгаа зарим нь өтгөн шингэн тос, үнэртэй ус, анхилам зүйлс, цэцэг болон лавраар үйлдсэн тоо томшгүй олон титэм тэргүүтнийг тшүүдэг дотор хийсэн учир түүдэг бүрэн дарагдсанаар ч барахгүй, тэр хавийн газар дарагдсан балйаа.

Энэ үед Суллын ордны дэргэдэх гладиаторын сургуулийн бүх гладиатор түүдгийн дэргэд тулалдан эхэлжээ. Оршуулгын ёслолын үед, заяа муутай энэ хүмүүсийн дотроос хэний боловч амийг уучилж болдоггүй ёстойн учир, хэдхэн минутын дараа тэд нараас нэг ч хүн амьд үлдсэнгүй. Ордны дэргэдэх гладиаторын сургуулийн гладиаторуудын дотроос энд гагцхүү Арторикс байсангүй. Учир нь Спартакийн хүссэн ёсоор түүнийг Кумыд үлдэхийг Валерия зөвшөөрсөн байжээ.

Заншлын ёсоор эн ёслолын дараа нас барагчийн хүүрийг түүдэг дээр шатаах бөгөөд, түүдгийг тусга хүн асаах ёстой байжээ. Нас барсан нөхөртэй улам их хүндэтгэл илэрхийлэхийн тул агуу их Помпей_, түүдэг асаах тусгай хүний гараас бамбарыг авч, Суллын шарилын доор овоолготой байсан шатах зүйлсийг өөрөө асаажээ.

Африкийн байлдаанд ялж ирсэн залуу эрээс нас барагчиийг  хүндэтгэсэнд үй түмэн хүн нижигнэтэл алга ташиж, асартом  галаар дүүрэнх их чимээ болжээ. Түүдгийн гал нэгмөсөн дүрэлзэн асаж мянган үзүүртэй мушгиралдан оволзож, сайхан үнэртэй тгөн хар утаатай холилдон босчээ.

Хагасхан цагийн дараа өдий олон жилийн турш Ром болоод Италийг донсолгон, алдар нэр нь дэлхий дахинаа тархаж байсан энэ хүний бие махбодоос өчүүхэн яс үнс төдийхэн үлджээ. Тэр үлдсэн зүйлүүдий нь зориуд уйлагчид сайтар цуглуулан авч, алтан шигтгээтэ ймөнгөн угалз товойлгон чимж хийсэн мш үнэтэй бумбан дотор агуулжээ.

Марсын талынхан ялсан тэ газар, одоогоос хэдхэн жилийн өмнө Суллын өөрийн нь тушаалаар бариулсан ордонд, энэ бумбыг тавьжээ. Сулла энэ ордныг ялагч Геркулест зориулсан юм. Дараа тэр бумбыг энэ ордноос авч, сая түүдэг  шатаасан газар Марсын талд улсын хөрөнгөөр бариулсан үнэхээр сайхан бунханд шилжүүлэн тавьсан юм.

Спартак ннэгд Суллад албан хааж түүний гладиаторуудын сургуулийн багш нь байсан учир, гашуудлын хар өнгийн хувцас өмсөж, оршуулах ёслол дээр байлцжээ. Хатгах жадлах урлагийн нууцад сургаснаар ч барахгүй, бас дарлагсдын холбооны нууцтай танилцуулсан хөөрхий сурагчдаа яргалуулж байхыг харж, арай ядан тэсч байх ёстой байжээ.

Иймийн учир оршуулах ёслол төгсөхөд, Спартакийн дотор онгой, санаа алдлаа. Спартак одоо чөлөөтэй болж , хаашаа ч явсан дур нь болжээ.

Оршуулах ёслолоос тарж, яаралгүй буцаж яваа хүмүүсийн дунд бас Спартак явжээ. Өнөөдрийн өдөр, хүний ухаан санааг эзэлж байсан энэ хэрэг явдлын тухай, хэлэлцэж байгаа яриа зогсолтгүй сонсогдож байжээ.

-Чи юу гэж санаж байна, энэ бумба ялагч  Гекулесын ордонд уддаг болов уу? гэж нэгэн хүнийг асуухад:

-Ромын нэр хүнд, ард түмний нэр хүндийн төлөө, үй олны ширүүн довтолгоо гарч тэр бумбыг тэндээс авч таягдан хамхчиж, доторхи үнсий нь салхинд хийсгэж алга болгоно биз гэж би найдаж байна.

-Тийм биш, харин Ромын тэнгэрийн төлөө та нар мэтийн Маригийн намынхны хогуудыг Туллианумд багалзуурдан алах бай гэж найдмаар байна.

-Хөөрхий Ром минь, давтан хэлье, хөөрхий бид нар, Суллын минь эрүүл саруул байх үед түүний эзгүй хойгуур ч гэсэн өөрчлөлтийн тухай хэн ч бодож  зүрхэлдэггүй байсан билээ.

-Харин одоо бол… хууль гэдэг хөөрхий болжээ… Юпитер минь арай ч тийм байдалд хүргэхгүй бизээ.

-Вентудей, цаад хар хүүгийнхээ халж байгааг дуулаач:

-Хууль гэнээ?… хуулийн тухай хэн ярьж байна? Хууль гэдэг юу болохыг бид мэднээ… хууль гэдэг чинь аалзны шүлс гэсэн үг шүү дээ! Түүнд ялаа, шумуул л баригдахаас биш хэдгэнэ бол түүнийг тастаад гардаг шүү дээ гэх мтийн олигархийг эсэргүүцсэн хортой шог үг өдий төдийгөөрөө асгарч байлаа.

Тохойгоороо зам ярж явсан Спартак анхны хүмүүсийн хам хотын хэрэм хүрчээ. Хэрэм отор ороход сөнөсөн хотод орсон юм шиг санагдлаа. Хэзээ ямагт дүүрэн хүнтэй байдаг Ром хотын гудамж энэ үед огт хүнгүй зэлүүд байжээ.

Иймд Спартак саадгүй явж Юлий Рабецийн сургуульд хурдан хүрлээ. Спартак энд Крикстэй уулзах болзоотой байжээ.

Хоёр гладиаторын яриа нөхөрсөг, урт бөгөөд хөгжилтэй байлаа. Суллын түүдгийн дэргэд гладиатруудыг алалдуулсан явдлыг Крикс Спартакийн нэгэн адил жигжин үзжээ. Аргагүйн эрхээр тэнд байцсан Спартакийн уур хилэн нь одоо ч хүртэл намдаагүй байжээ.

Төлөвлөгөөгөө биелүүлэх явдлаа битгий хойш тавь. Лентул Батиатын сургуулийнхаас мана йхэрэг ажилд талархагчдыг аль болох олноор олохын тул, түүний уриалгыг шалавхан хүлээ ав гэж Крикс Спартакийг ятгажээ.

Галл гарлын энэ эр бүдүүүлэг боловч сэтгэлийнхээ үгийг хэлж:

-Спартак аа, одоо манай байгууллагын амжилт, чиний гарт байна, хэрэв чамд боолчуудыг чөлөөлөх, сайн үлйт хүсэл санаанаас өөр, улам хүчтэй хүсэл байгаа бол байгулулагад ялалтын баярыг үзэх найдмар манай агуу их байгууллагад үүрд үгүй болно гэжээ.

Спартак гүнээ санаа алдаж:

-Миний сэтгэлийг мар нэгэн дур хүсэл хөдөлгөж байвя% тэр бол өчүүхэн хэргээ, Крикс минь, тэр бол өчүүхэн хэрэг сонсдож байна уу! Тэр ариун хэрэгт өөрийн биеийг зориулах явдлаас намайг ертөнц дээр юу ч самууруулж чадахгүй, шилж авсан замаас минь намайг юу хоромихон зуур боловч хэлбийлгэж чадахгүй, зорьсон зорилгоос минь намайг хэн ч юу ч буцааж чадахгүй! Гэлээ.

Энэ хоёр удтал ярилцлаа. Спартак бүх зүйлийнхээ тухай Крикстэй ярилцаж тогтоод, Юлий Рабецийн сургуулиас гарч, Суллын үе залгамжлагчдын гэр лүү оёлоо.

Спартакийг босго алхан ормогц авхайтны үүдний өрөөнд Мирца чамайг хүлээж байгаа гэж хаалгач түүнд хэллээ.

Ямар нэгэн гайтай хэрэг явдлын зөв тэмдэг мэдсэн мэт болж Спартакин зүрх цохилон Валериягийн тасалгаа руу гүйж орлоо.

-Одоо л нэг ашгүй ирэв үү! … чамайг, авхайтан бүтэн цаг хүлээж байна гэж Мирца түүнд хэлжээ.

Спартакийн ирсэн тухай авхайтандаа илтгэхээд Мирца хурдан явж миунт хир болсны дараа буцаж ирээд, Спартакийг дагуулан Валериягийн хүлээн өвөх өрөөнд оруулав.

Валерия хар өнгийн тога өмсөж бор нөмрөг нөмөрсөн байлаа. Түүний царай нь цав цагаан болон хувирсан байх бөгөөд энэ үедээ урьд урьдынхаасаа улам сайхан болсон мэт Спартакт санагджээ.

Юм бодолхийлсэн хүни йбайдалтай намуун царай энэ хүүхэнд их л зохижээ.

Валерия суудлаасаа босож, их л санадарсан байдалтай Спартакийн зүг хэд алхаж:

-Спартак минь! Миний, Спартак! чи надад үүрд хайртай байх уу? … ертөнц дээр юм бүхнээс илүүгээр надад хайртай хэвээрээ байна уу? гэж асуулаа.

Валеригийн гэнэт тавьсан асуултад Спартак түр тулгамдаж байснаа:

-Валерия минь, чи яагаад ингэж асууж байна? Би чамайгаа ямар нэгэн зүйлээр гомдоов уу? чамайг би үнэн голоос шүтэж явдаг, чамд үнэн, чамд энхрий гэдэгт итгэхгүй бролгох үндийг би чамд өгөв үү? Миний бүх хүсэл санаа бол, ганцхан чи мөн, ерөнц дээр ганцхан чи минь л байна.. бүх сэтгэлээрээ би чамтай холбоотой, би бүх зүрх сэтгэлээ чамдаа зориулсан… гэхэд нь Валериягийн нүднь хурц гэрлээр гэрэлтэн, баясгалант дуугаар Спартакийн үгийг таслаад:

-Чухамхүү тийм л дурлалаар би чамайг надад дурлаасай гэсэн юм. Спартак минь, чи надад ямагт тэр дурлалаараа дурлах бизээ, тийм үү? Гэхэд нь:

-Тэгэлгүй яахав! Хэзээд чамдаа тэгж дурлана гэж рудиарий, язгуурт энэ авхайн өмнө өвдөг сөгдөн сууж, түүний гарыг шүүрэн авч, яна дурлалаар зай завсаргүй үнсэн: -Валерия би чамайг ямагт хүндэтгэнэ охин тэнгэр мэтээр чамайг би хүндэтгэнэ…. Гэсэн… хэзээ ч гэсэн… гээд Спартак цааш нь үгээ үргэлжлүүлж чадсангүй халуун нулимсаа асгаруулан мэлмэртэл уйлжээ.

-Чи минь яав?… юунд уйлав? Юу болов –Спартак минь… яав … наддаа хэлээч? Гэж Валерия рудиарийг энгэр дээрээ эрхлүүлэн түшүүлж, чанга тэврэн, духы нь үнсэн, сандарч давхацсан дуугаар ахин дахин асуулаа.

-Энэ үед хаалга зөөлхөн тогших чимээ сонсогдлоо.

-Бос! Бос! Гэж Валерия нам дуугаар шалавхан хэлээд,, аль болохоор ердийн байдлаар дуугарахыг оролдон:

-Мирца юу гээ вэ? Гэлээ.

-Гортензий ах чинь ирээд чамайг асууж байна гэж шивэгчин бүсгүй хаалгын цаанаас хариуллаа.

-Ар ирчихсэн үү? Гэснээ.

Тэгвэл түүнийг тэндээ жаахан хүлээж байна гэж хэл  гэж Валерия Мирцад хариулжээ.

Мирца:

-За гээд явлаа_

Валерия чагнаж байгаад, Мирцагийн хөлийн чимээ намдсаны дараас:

-За… ах цаана чинь ирчихсэн банйа…

Ингэх л байсан юм… тэгээд л би чамайг тэсгэлгүй хүлээж байсан юм… тэгээд ч би миний төлөө чи яахаасаа ч буцахгүй юу гэж чамаас асуусан юм… бидний тухай Гортензий… бүгдийг мэдсэн… би ч чамд хайртай,… чи ч надад  хайртай гэдгийг, чи мэдэж ав… гэж Валерия их л яаран хэллээ.

-Юу гэнээ? Яаж тэр мэдэв? Гэж Спартак, сэтгэл ихэд хөдөн асуухад:

-Дуугүй, яаж мэдсэний нь би өөрөө мэдэхгүй байна…. Энэ тухай тэр надад товчхон хэлээд… өнөө орой ирнэ гэсэн юм, тэгээд тэр ирсэн бaнй… одоо чи нуугд … гээ Валещрия нэгэн хаалганы хөшгийг сөхөж нааш ир…. Хүнд

мэдэгдэхгүй нуугдаж байгаад бүгдийг сонсож ав… бас Валерия хүүхэн яаж дурлаж чаддагийг ч мэдэж ав гэж хэлээд рудиарийг зэргэлдээ тасалгаанд түлхэн оруулж:

-Энд юу ч болж байсан миний дуудаагүй байсан агт гэнц ч үг бүү дуугар. Өчүүхэн ч бүү хөдөл гэж Валерия нам дуугаар түүнд хэллээ.

Валерия хаалганыхаа хөшгийг буулгаад, ширүүн цохилж байсан зүрхээ номхотгохоор гараараа цээжээ дарж сандал авч суулаа. Удалгүй биеэ гартаа авч, биеэ барьсан янзгүй болсныхоо дараа% ердийн дуугаар:

-Мирца! Гэж дуудлаа.

Бүсгүй орж ирлээ.

-Намайг, хүлээн авах тасалгаандаа ганцаараа байна гэж чи Гортензийд хэлсэн биз? Гэлээ.

-Би чиний тушаалыг биелүүлсэн гэж Мирца хариулжээ.

-За тэгсэн бол сайн, одоо түүнийг нааш нь руул гэлээ.

Минутын дараа, уран үгч энэ хүн , уур хүрсэн байдалтай, хөмсөг зангидан, охин дүүгийнхээ өрөөнд орж ирлээ. Гортензий нь бараан өнгийн тога өмссөн байлаа. Бас сахлаа арван таван хоног хусаагүй байжээ.

Валерия

-Хонгор, Гортензий сайн байна уу? гэлээ.

-Сайн байна, дүү сайн байна уу? гэж тэр царай өгөхгүй бадйалтай хариу мэндлэв.

-Надад бүү уурла, суу ах аа, хэлэх юмаа нуулгүй шулуун хэл гэж Валериягийн хэлэхэд:

-Бидний хайр хүндэтгэл болсон Суллын нас барах гай зовлон мини толгой дээр тусаад зогсохгүй, бас өөр санамсаргүй, гутамшиг гай тусах ёстой байжээ. Миний эхээс төрсөн охин чи өөрийн болоод миний нэр, масссалынхны цус, Суллын гэр бүлийг хүндэтгэх ёс журмыг мартаж, үзэшгүй муу гладиатортай ичгүүрт холбоотой болж нэрээ бузарлан гутаасныг олж мэдэх үйл бас надад тохиолдох ёстой байжээ. Ээ Валерия минь. Валерия минь!.. яах чинь энэ вэ? Гээд сандлынхаа хавирга түшлэгийг тохойлдон, гараараа толгойгоо тулж чимээгүй болон их юм бодолхийлэн суужээ.

-Гортензий сонсож байгаач, чи надад маш хүнд хэрэг хүлээлгэж байна. Биеэ хаацайлахынхаа өмнө чамаас асуухад чи үүнийг хаанаас олж мэдэв ээ? Гэхэд нь

Гортензий толгой өндийлгөж, гараар духаа илж:

-Олон газраас мэдсэн… Суллын нас барснаас хойш зургаа буюу долоо хоносны хойно энэ чигийг Хризогон надад өгсөн гэж тасалдсан дуугаар хариулаад, үнгэгдсэн цаас гаргаж Валерияд өглөө. Валерия тэр цаасы нь авч уншлаа.

“Луций Корнелий Суллад эзэн хаан, дарангуйлан захирагч хувь заяа Эпафродитад нөхөр ёсны баяр хүргэе.

Өнөөдрийн өдрөөс эхлэн “нохойноос болгоомжил гэдэг үгийн оронд, байшингийнхаа гаав ханад “хорт могойноос болгоомжил!” гэсэн үг бичсэн чинь дээр байна. Могойноос чи биш харин могойнуудаас гэх ёстой байна. Учир нь нэг биш, хоёр хорт могой чиний байшин дотор үүрээ засаад байна. Энэ бол Валерия Спартак хоёр юмаа.

Гэнэтийн ууранда бүү автаарай, анхны тахиа дуугарах үеэр гэтэж тэднийг чи хараарай. Тэгвэл чи дэлхий дээр хамгийн хүчирхэг, хамгийн аймшигт хүний нэр ба гэр бүлийг хэрхэн доромжилж байгааг өөрөө үзнэ.

Үүнээс хойш энэ мэтийн заягүй хэргийг тэнгэр чиний мөрөөс зайлуулах болтугай” гэсэн байжээ.

Энэ захидлын анхны үгийг уншихаас эхлэн Валериягийн нүүрэнд гал асах шиг болж, уншиж дүүрэхдээ царай нь үхсэн хүний царай шиг цав цааан болсон байлаа.

-Энэ захидлыг Хризогон хаанаас авсан юм? Гэж Валерия шүдний завсрын бөглүү дуугаар асуулаа.

-Хаaaас ирүүлсний нь санах гэж хичнээн оролдоод тэр санаж чадсангүй нь харамсалтай. Энэ захидлыг авчирсан боол, Суллын нас барсны дараа хэдхэн минутын хойно Кумээс ирсэн гэдгийг л тэр санаж байна гэж Гортензий хариулжээ.

Вөлерия минут хир чимээгүй байснаа, тайван дуугаар дуугарч,

-Бичсэн эзэн нь мэдэгдэхгүй энэ захидал нь Суллын бэлбэсэн гэргий, Валерия Мессала гэмт хэрэг тулгах, ноцтой баримт миний ах Гортензий чамд болж чадахгүй байна гэдэгт би чамайг итгүүлэхийг оролдохгүй… гэлээ.

-Учрыг дурьдвал, Суллыг нас барсны дараа, арав% буюу арван хоёр хоносны хойно, хайрт нөхрөө алдсандаа харамсан гашуудаж гутарсан Метробий, нөхрийн нь алдар нэрийг бузарлагчдаас нөхрийнхөө төлөө өшөө авахыг ариун үүргээ гэж үзээд надад ирж, Спартак та хоёрын холбооны тухай ярьсан. Чиний хүлээн авах өрөөний зэргэлдээ өрөөнд Метробийг дагуулан оруулж өгсөн шивэгчин хүүхнийг тэр авчирч надтай уулзуулсан. Тэгж шөнийн цагаар Спартакийг чиний хүлээн авах өрөө рүү орж байхыг Метробий харсан байна гэлээ

Хэлсэн үг, янагийн үнсэлт, далд дурласан сэтгэл бүхэн минь шивэгчин бүсгүй ба Метробий мэтийн хамгийн адгийн муу амьтанд илэрчээ гэдгийг валерия мэдэж царай нь хувхай цагаан болж:

-Мэдлээ, мэдлээ, мэдлээ, Гортензий минь! Ингэж чи надад гэмт хэргийг хүлээлгэлээ, одоо би өөрөө ярьяа гээд байрнаасаа босож, ууртай царайаар ах тийшээ харж хоёр гараа цээжин дээрээ зөрүүлэн, нү нь омиог бардам гялалзан:

-Тиймээ, би Спартакт хайртай болсон. Би сэтгэл зүрхнийхээ оргилоос түүнд хайртай! Тэгээд яагаав? Гэжээ.

-Ээ, агуу тэнгэр минь, агуу тэнгэр минь! Гэж хашгиран, Гортензий босон харайж, хоёр гараараа нүүрээ дарлаа.

-Тэнгэрийг чи бүү дууд, тэд чинь чамайг сонсохгүй. Харин миний хэлж байгааг сонс гэж Валериягийн хэлэхэд Гортензий:

-Ярь, ярь гэжээ.

-Би түүнд харитай, дуртай би түүнд хэзээд ч хайртай хэвээр байна… гэж Валериягийн давтан хэлэхэд:

Гортензий тэсгэлгүй уурлан түүнийг харж, Валерия гэж зандран зогсоогоод –Би чамаас айж байна… чи ерөөс галзуу эм байна гэхэд нь

-Үгүй, би бол зүгээр л эмэгтэй хүн, тэгээд та нарын дураараа ноёрхох хууль, та нарын тэнэг худал үзэл суртлыг нурааж бидний эмэгтэйчүүдийн гар хөлийг хүлж байгаа, дэлхийг ноёрхогч нар нарын гинжнээс чөлөөлөгдөх гэж шийдлээ. Үүнийгл би хүссэн юм даа. Энэ бол миний галзуурч байгаагийн тэмдэг огт биш, харин ухаан санаа орж байгаагийн тэмдэг байж ч юуны магад гэгчийг би чамд баталж байна. Метробий намайг буруушааж байна, тэр үзэшгүй муу мар?ан, өөртөө гэмгүй байдаг эр хүн бүхний эхнэрүүдийг хардаж вдаг үл бүтэх хүн юм. Харин Гортензий чи, түүнээс намайг буруушаасан зэмлэлийг өдийчинээ үнэлсэн атлаа, түүнийг шалган хянагчаар сонгох саналыг, сенатад оруулахгүй байгаа чинь гайхалтай байна… харин тэр чинь Ромын зан суртахуунд нэртэй хянан шлгагч болж чдаахсан билээ? Метробий бол голомтыг ивгээгч охин тэнгэрийн ариун явдлыг хамгаалаг чмөн… Метробий бол хариулж яваа чоно мөн! Алж хядах явдлаар хотыг дүүргээд, хотын иргэдийг яргалан хядаж байсан Суллад зориулан орд, харш, хөшөө баримал босгож байдаг энэ үзэшгүй бузар Ром хотод завхай бузар нарианаар шөнө бүрийг миний нүдний өмнө, арван хоёр хүснэгийн доор Суллын өнгөрүүлж байсан энэ хотод дутаж байгаа юм бол Метробий мөн байна. Ээ дээ бас эх орны минь хууль бас шударга… энэ хууль ч нададад бас зарим нэгэн зүйлийг зөвшөөрсөн юм шүү. Миний түрүүн хэлсэн бүхнийг нүдээрээ үзхийг нададад зөвшөөрсөнб айна бэлбэсэн эхнэрийн жинтүүн дээр нулимсаа сэм асгаруулах эрхийг нададад олгосон байна. Бас эцсийн эцэст очиж, эзэн ноёнтондоо угсаа залгамжлах үр хүүхэд төрүүлж өгөөгүй ганцхан шалтгаанаар нөхөртөө хаягдаж байх эрхийг нададад бас олгосон байна.

Валериягийн сэтгэл оргилж нүүр нь халуу шатаж, түр зуур чимээгү йбайснаа, нүдээ том болгон, харцаа тогтоон гайхаж өөр рүү нь харж байсан Гортензийн зүг эргэж:

-Тэр хууль ёсоор бол би өөрийнхөө үүргийг зөрчиж байна би мэдэж байна… би үүнийг хүлээж ч байна… тэгэхдээ харин би өөрийгөө хамгаалахыг ч хүсэхгү йбайна, өөрийгөө зөвтгөхийг бас хүсэхгү йбайна. Би Суллын гэрээс Спартакийг дагаа явчиж зүрхлээгүйгээрээ би үүргээ зөрчжээ. Би тэр хүнд хайртай дуртай болсноо гэмт хэрэг гэж огтхон ч үзэхгүй байна, харин би үүндээ их омог бардам бадйаг юм. Энэ хүний зүрх сэтгэл бол эрдэнэ шиг бөгөөд агуу

их юм. Энэ хүн бол их үйл хэрэгт тэнцэхүйц ухаантай хүн, хэрнээ энэ хүн фракий Ромын цэргийн хороодыг ялсан бол энэ хүнийг Сулла ба Сарийгаас ч илүүгээр гайхаж, Ганнибал болоод Митридатаасч илүүгээр энэ хүнээс айх сан билээ!…гэвч тэр ялагджээ, тэгээд та нар түүнийг гладиатор болгосон байна. Түүнийг та нар гладиатор болгосноороо, гладиатор гэдэг нэрийг түүнд олгосноороо, түүний сэтгэл дотрыг өөрчилсөн байх гэж итгэж байна уу: Агуу сэтгэлтэй, хурц ухаантай хүнийг юу ч мэдэхгүй хонь болгон хувиргахад та нарын ганцхан тогтоол шийдвэр хангалттай байх гэж бодож байна уу? гэлээ.

Агуу их илтгэгч хүн, гайхан уйтгарлаж,

-Тэгвэл чи, манай эх орны хуулийн эсрэг, манай хэв заншлын эсрэг, мөн биеэ сахих ёс бүхний эсрэг босч байгаа юм уу? гэлээ.

-Тийм ээ, тийм тийм! Би, босч байна, босч байна. Би Ромын иргэн байхаас татгалзаж байна. Би өөрийнхөө нэр өөрийнхөө гарал үүслээс няцаж байна… Би ямар нэг алсалсан, газар, ямар нэгэн алсалсан мужид очиж суунa, эсхүл би Спартакийнхаа хамт Родопсын уулс юмуу Фракийд очиж сууна. Тэгээд та нар, миний төрөл садан бүхэн, миний тухай үүрд юу ч сонсохгүй болно! Гээд валериягийн сэтгэл догдлон тэсэж чаалгүй босч сандал дээр ойчлоо.

Хэдийгээр Валерия өөрөө, зөв сэтгэж байна гэж ойлгож байгаа боловч буруутай тал түүнд байсан баж болох юм.

Валериягийн зэмнэж ирсэн зам нь бас л тийм цэвэрхэн биш юм. Үнэхээр түүний зүрхийг донсолгосон ганцхан жинхэнэ дурлал болох, Спартакт дурласан дурлалдаа хүртэл Валерия хэтэрхий хөнгөмсөг хөдөлжээ.Гэвч Валерия саяынхаа хэлсэн холбоо муутай боловч, хүчтэй хэдэн үгэндээ, Ромын эмэгтэйчүүдийн амсаж байдаг дарлагдал, доромжлолын тухай үнэн зөв тодорхойлжээ.

Эцгийнхээ хэмжээ хязгааргүй, эрх мэдлийн дор байсан хөвүүдээс дор байдалтай эмэгтэйчүүдийн энэ харамсалтай хүнд байдал мөн улам бүр доройтож байсан гэр бүлийн самуурал задгайрал, боолчууд олширсны гагаар иргэд юм хийдэггүй дэмий байх болсон энэ бүх шалтгаан нь Ромыг нураах бодит шалгаан нь болсон юм. Гортензий дүүгээ өрөвдсөн байдалтай харж байснаа:

-Хонгор Валерия минь ээ одоо бие чинь муу байх шиг байна гэлээ.

Валерия шалав босч ирээд:

-Юу? Үгүй, миний бие тун сайн байна, би… гэтэл нь

-Үгүй, үгүй Валерия минь, намайг үнэмш, бие чинь муу байна… сэтгэл чинь их хөдөлсөн байна…. Сэтгэл их хөдөлсөн учир ухаан чинь балардсан банйа. Чухал хэрги й тухай одоо ярьж болохгүй гэлээ.

-Үгүй би… гэж Валериягийн хэлэхэд:

-Энэ асуултыг шийдвэрлэх явдлаа зохистой цагийг хүртэл хойшлуулъя гэж Гортензий хэлжээ.

-Чамд одооноос хэлчихье –би буцалтгүй шүү… гэж Валерия хэлжээ.

-За… за… энэ тухай дараа ярилцъя… дараа бид уулзана тэнгэр чамайг хэзээд өршгөөж байх болтугай! Би явлаа. Баяртай, Валерия минь баяртай… гэлээ.

-Баяртай, Гортензий! Гэж Валерия хариулжээ.

Уран илтгэгч, охин дүүгийнхээ өөрөөнөөс гарч одлоо.

Хоромхон зуурын дараа Спартак орж ирлээ.

Спартак, Валериягийн хөлийн дор унаж, түүнийг үнсэн хайр дарлалаар дүүрсэн үг, гүн сэтгэлий нь магтан, холбоо муутай үгээр талархан баярлажээ.

Валерия Спартакийг цээжиндээ нааж тэврэн, хэмжээгүй сайн ерөөлт Спартак минь, би хэзээ ямагт, хэзээ ямагт чамтайгаа хамт явахыг хүсэж, би чиний эхнэр чинь болно, чиний эхнэр чинь болно, чиний зочирхог фракийн уулс, чи бид хоёрын дурлалын ордон болог гэлээ.

Валериягийн энэ үнсэлт таалалтад согтуурсан Спртак, өөрийн бие болон бүх ертөнцийг мартжээ.

-Тийм… би чиний…. чиний ямагт…. чиний боол… чиний зарц… чиний… гэж сулхан дуугаар шивгэнэн өгүүлэв.

Гэнэт Спартак эргэж хараад, царай нь цав цагаан болж, Валериягийн тэврэсэн гараас тавиулан мултарч, өөрийнхөө бүх анхаарал сэтгэлийг дайчлан ямар нэгэн юм чагналаа.

-Чи яав? Гэж –Валериягийн сэтгэл зовон асуусанд

-Чимээгүй бай! Гэж рудиарий дөнгөж сонсогдохуйц дуугаар шивгэнэн хариуллаа.

-Грек ба фракий хэл хольцолдсон, зэрэмдэг зэрлэг хэлэн дээр, залуу хүмүүсийн чанга хоолойгоор хүчтэй дуулж байхыг нам гүм тасалгаан дотроос хоёулаа сонслоо.

Аврагч охин тэнгэрийн тэнгэр минь. Эрх чөлөө, эрх чөлөө минь
Агуу хэрэгт, бидний зүрхийг бадрааг
Охин тэнгэрийн тэнгэр минь Эрх чөлөө, эрх чөлөө минь
Аюулт тулалдаанд, үхлийн дотроос өчүүхэн биднийг өршөөн толил
Дайсны хороодтой дайралдан тулалдах
Даваатай тэр дайны үед
Далбаа их жигүүрээрээ биднийг халхлаарай
Охин тэнгэрийн тэнгэр минь Эрх чөлөө Эрх чөлөө минь
Аюултай цагт, боолчууд бидэнд юлд бол
Дарлал ноёрхож байгаа бузар орнуудын
Хамгийн залхуу нь ч зэвсгээ бариг
Хамгийн аймхай нь түрүүнд босог
Гайхамшигт сайхан дөлөөрөө газар дэлхийд бууггун.
Хүчирхэл ноёрхож, хөлс нулимс асгаруулдаг тэр газар
Цус архи хоёрын ус шиг асгарч байдаг энэ газар
Ах, дүүгээ алалдах явдлын галзуурсан энэ газарт

Аймшигт галын чинь оч бууж ирэх болтугай:.
Аврагч охин тэнгэрийн тэнгэр дайнд биднийг удирд
Амьтан бүхний зүрх, ганцхан чамайг хүсч байна.
Эрх чөлөө, эрх чөлөө Бидний давтах дуу болох боловч
Эрэлхэг чадал, уур хилэнгий минь, тэн хувь нэмэгдүүлж аль
Ядарсан бидний мөрөнд хүч чадал аль
Ялалтанд чамайг дуудаж сэлмээ барихаар бид довтолж байна
Юлд зэвсгээ барьцгаая нөхдөө, яргачдыг хядацгаая
Гэсэн үгтэй дуун байжээ.

Валерия энэ дууны үгээс, грек хэлээр хэлсэн хэдхэн үгийг ойлгож авчээ. Харин Спартак бүх амьдрал нь энэ дуунаас нөлөөлөх мэт чих тавин сонсож байлаа.

Спартакийн царайнд тодхон тусаж байсан сандарсан байдал, дув дуугүй зогсож байсан Валериягийн шохой шиг цав цагаан нүүрэн дээр ч бас илхэн харагдаж байлаа. Гэвч Валерия юунаас болж сандарснаа өөрөө ч мэдэхгүй байлаа.

Дууны чимээ алсад замхрахыг хүртэл хоёюулаа дуугүй байцгаалаа. Дараа нь Спартак Валериягийн гарыг үнсэж нулимсаа асгаруулан:

Хайрт… Валерия минь…. Намайг уучил… бүх бие сэтгэлээ бүхэл днь чамдаа зорулж чадахгүй нь байна… чадахгүй нь ээ… учир юу вэ гэвэл би түүнээс хойш өөрийнхөө толгойг өөрөө мэдэхгүй болсон хүн юмаа… гэж хоолой зангиран хэлсэнд:

-Спартак минь! чи юу ярьж байна. Юу гэж чи хэлэв Чиний зүрх сэтгэлийг ганцаараа эдэлж байх эрхийг надтай булаалцалдах тийм ямар эхнэр хүн байдагсан билээ гэхэд гладиатор, уйтгарлан толгой сэгсэрч:

-Үгүй, мини йзаяатай байх явдалд эхнэр хүн саад болсонгүй, тэр нь эхнэр хүн бишээ:. Гэвч… чухам юу надад саад болж байгааг хэлж болохгүй байна… үүнийг хэлж болохгүй юм… би боол ариун бөгөөд зрөчиж болшгүй тангарагүй хүн юм. үүнээс хойш би өөрийн мэдэлгүй болсон хүн. Чамаасаа хол, охин тэнгэр мэт чинийхээ энэрэлтэй үнсэлтээс тасархай байх явдал бол надад хамгийн аз заяагүй хэрэг мөн гэдгийг л чи мэдэж ав гэж Спартакийн хоолой чичрэн дээр хэлснээ дүгнэн хэлж өглөө.

Валерия цочиж, жижигхэн гараараа Спартакийн толгойг барьж өөр тийшээ харуула. –Юу гэнэ? Чи минь дэмийгч байна уу?… чамайг миний болохы чинь ямар хүүхэн хориглов? Хэлж аль. Хэн гэдгий нь хэлж өгөөд намайгзовлонт байдлаас минь салгаад аль? Гэхэд нь

-Миний хайрт, миний хайр хүндэтгэл болсон Валерия минь сонсож бай гэж цээжинд нь тэмцэл оволзон мөргөлдөж байгаа нь аягүй болсон нүүр дээр нь ив илхэн харагдаж байсан. Спартак, тасалдсан дуугаар хэлээд намайг ямар шалтгаан чамаас холдуулж байгааг хэлэх эрх над үгүй байна… би түүнийг

хэлж өгч чадахгүй… харин тэр шалтгаан бол эхнэр хүн биш гэдгийг чи мэдвэл болно… чиний хайр хүрээллээс намайг хэн ч холдуулж чадахгүй гэдгийг л чи минь ойлгох ёстой… ойр ч тэр, хол ч тэр хэзээ боловч би чиний болно, хэзээ ч би чиний, ганцхан чиний бөгөөд, чиний дүр миний тухай сэтгэгдэхүүн бол миний хүндэтгэл миний шүтэх тахих ганцхан шүтээн болно гэдгийг чини амь нас, чиний ариун нэр, өөрийнхөө амь нас, өөрийнхөө нэрээр үнэн голоос батлан тангараглана… гэхэд нь:

Хөөрхий энэ бүсгүй, арай ядан нулимсаа барьж:

-Чи минь яачихав аа? Чи өөрийнхөө нууцыг надад юунд эс хэлнэв. Миний чамд өгсөн хайр дурлал, чамайг үг дуугүй дагах гэсэн миний шийдвэрт чи итгэхгүй байна гэж үү? Энэ тухайгаа би чиний өмнө хангалттай баталж чадсангүй гэж үү? Чи намайг яагаасай гэж байна?… тэр бүхнээ хэлж аль… хэлсэн бүхний чинь хийе, тушаасан бүхний чинь гүйцэтгэе гэхэд нь

Хөөрхий Спартак арга цөхрөн:

-Тэр тухай хэлэх эрх надад бахйгүй, би хэлж чадахгүй, би хэлж чадахгүй гэж хшгирлаа.

Валерия Спартакийг тэвэрлээ. Спартак үргэлжлүүлэн:

-Би буцаад л ирнэ шүү дээ, чиний төлөө тангаргаа эвдэх зөвшөөрөл надад олдмогц би яваад ирнэ, маргааш , нөгөөдөр хэзээ болсон цагт л ирнэ. Тэгэхэд чи намайг уучилна. Чи бид хоёрыг одоо холбож байгаа дурлалаас хүчтэй дурлал байдаггүй л юм бол, чи тэгэхэд надад улам хайртай болно одоо баяртай, миний хүнэтгэн шүтдэг Валерия минь баяртай гээд хөөрхий Спартак ер бусын хүчдлээр, өөрийгөө хүчлэн, хайртай бүсгүйнхээ гараас мултран тавигдаж тэндээс гүйн гарлаа.

Сэтгэлийн зовлон, гашуудалд дарагдсан Валерия ухаан алдан муурч уналаа.

## НЭГЭН СОГТУУ ХҮН ӨӨРИЙГӨӨ РОМЫН АВРАГЧ ГЭЖ САНАСАН НЬ

Ромын байгуулагдсаны он тооллын 68О оны мартын календаас /хоёрдугаар сарын –наас/ арван таван хоногийн урьд, Луций Корнелий Суллын нас барснаас хойш бараг дөрвөн жил өнгөрсний дараа ромынхан баяр ёслол хийж байжээ. Энэ баярыг тэтгэн соёрхогч эх Луперкалийнхаа алдар болон, тариалангийн талбайг үржил шимээр соёрхогч Пана тэнгэр ба гайхамшигт Рем гэгч ах дүү хоёр анх үүсгэн гаргасан байжээ.

Луперкалий гэж Пан-тэнгэрийн нэрэмжит ойн дотор байдаг Палатины толгойн хажуугийн нэгэн агуйг нэрлэнэ. Домгийн ёсоор бол энэ агуй дотор нэгэн эм өлөгчин чоно хөхөө хөхүүлж Ромул, Рем хоёрыг хүн болгосон байжээ. Луперкалийн тахилчид болгохоор патрицүүдийн гэр бүлийн дотроос зориуд цуглуулсан хамгийн алдартай залуучууд энэ өглөө Луперкалийн тахилчид болгохоор патрицүүдийн гэр бүлийн дотроос зориуд цуглуулсан хамгийн алдартай залуучууд энэ өглөө Луперкалийн агуй дотор бүр эрт ирцгээсэн

байлаа. Энэ залуучууд тахилчдын хувцастай байлаа. Удалгүй, сайн язгууртан, баахан залуучууд ирж эд нартай нийллээ. Саяхан ирэгсдийн хоёр нь цав цагаан тоатай бөгөөд толгой дээрээ хэлхээ цэцгийн титэм өмссөн байлаа. Энэ хоёр нь тахил өргөх үед голлох үүрэг гүйцэтгэх ёстой байжээ.

Энэ хэсэг хүмүүсийг дөнгөж ирмэгц, тахилын амьтдыг яргалах тусгай хүмүүс, хутгаар зэвсэглэж хорин ямаа ба хорин нохойн гөлгийг алжээ. Эдгээр амьтдыг алж тахил өргөөний дараа, Луперкалийн тахилчдын нэг нь юлд авч, алагдсан амьтдын цусанд дүрээд, хоёр залуу патрицийн духыг цустлаа.н Харин бусад луперка-тахилчид нь сүүнд дэвтээсэн эсгийгээр тэр патрицуудын духанд наалдсан цусыг арчлаа. Тэдний духан дахь цусыг арилж гүйцэхэдэ залуучууд чанга дуугаар инээлдэцгээлээ.

Бодвол , энэ ёслол нь эрт үеэс уламжлан ирсэн ёслол бөгөөд малчдыг ариутгаж байгаа хэрэг билээ.

Үүний дараа, тогтсон заншлын ёсоор ариулгалын угаалга болж, дараа нь агуйн доторхи тусгай нэгэн газар, луперки тахилчид, ариутгагдсан залуучууд ба тэдний нөхдийн хамт баян тансаг найр цэнгэл хийжээ.

Луперки-тахилчдын найр ширээний рад наргиж байх зуур нь агуй дотор хүмүүс дүүрчээ. Ой мод болон ойр хавийн зам дагуу үй олон хүн шавсан байх бөгөөд эд нарын дотор эмэгтэйчүүд ч маш олон байлаа.

Энэ хүмүүс юунд энд ирцгээв? Гэдэг асуулт удалгүй тодорхой боллоо. Хөл нь хөнгөрч, хөгжилтэй болсон луперки-тахилчид найрынхаа ширээний араас босоцгоож тахилд үориулан салсан амьтдын арьсыг туник дээрээсээ бүслэн мөн тэр амьтдын арьсаар хийсэн ташуур барьцгаан агуй дотроос бөөнөөр гүйлдэн гарч, замд дайралдсан хүн бүхнийг ташуураараа ороолгож гарлаа.

Хүнтэй суугаагүй хүүхнүүд тахилын амьтдын арьсаар хийсэн ташуураар ороолгуулбал хялбар нөхөртэй болно, хүнтэй суусан нь үр хүүхэдтэй, хялбархан болно гэж итгэдэг байсан учир, тэр хишгийг хүртэхийн тул гараа сарвайлган луперки-тахилчдыг тосон гүйлдэж гудамж бүхнээр дүүрчээ.

Ингэж, эртний болон одоогийн шашин бишрэлд ямар нэгэн ёслолыг хийхдээ, их бага боловч садар шалиг, их бага боловч нууц далд шүтлэгтэй, юманд хялбар үнэмшдэг хүмүүсийг түшиглэн, ихэвчлэн хуурмаг үндсэн дээр зохиож, олон хүнийг цуглуулан хөгжүүлэх шалтаг нь байсан юм.

Энэ нэгэн удад, энэ баярын бүх зардлыг луперки-тахилчид өөрсдөө хүлээсэн байжээ. Эчир нь, энэ баяр даар луперки-тахилч гэдэг нэрийг хүлээх явдал бол алдар нэр хүсэх тэдний сэтгэлийг хангаж байсны дээр, луперки-тахилч болж аль ганган сайхан авгай хүхүхнүүдийг ороолгон, хариу шагналд нь тэдний инээмсэглэх царай, уяхан үгийг хүртэж байна гэдээг бол тэдэнд их сайхан санагдаж байсан юмаа.

Луперки-тахмилчдын зарим хэсэг нь бөөнхүмүүсийн хамтаар Тибра голын арал руу очлоо. Тэр үед хүн цөөнтэй байсан энэ арал дээр Эскулапын сүм, Юпитерийн сүм, Фавнын сүм ийм гурван сүм байдаг байжээ.

Биеийн хэлбэр маш сайхны дээр, өндөр нуруутай, хүн чадал төгөлдөр нэгэн залуу хүн фаанын сүмийн хажуу дахь баганат саравчийн нэгэн баганыг түшиж зогсоод, луперки-тахилчдын гүйлдэж байгааг огт сонирхсон янзгүй боловч ажиглан хаж байжээ.

Энэ хүн грекийн уран баримал сэт сайхан мөртэйн дээр толгойн хэв гоё, царай нь омог бардам ажээ. Түүний хав хар үсний нь сүүдэр, өргөн духан дээр нь тусчээ. Нэвтэрхий харцтай, гоё нүд нь бусдын сэтгэлийг булаахуйц ажээ. Энэ залуу хүний хамар нь шулуухан бөгөөд үнэхээр гоё хэлбэртэй, багавта амтай цоровгордуу уруултай энэ хүн, бусдыг эрхэндээ дагуулахуй хүчтэй бөгөөд орчин тойрныг нэвт харж чадах хүн байна гэдэг сэтгэгдэхүүнийг эрх биш бусдад төрүүлжээ. Ер бусын сайхан энэ эрийн цав цагаан царай нь түүнийг улам ч гоё сайхан болгожээ.

Энэ хүн нь Кай Юлий Цезарь гэгч байжээ.

Энэ хүн яг грек маягаар хувцаслажээ. Гал улаан хажлагатай, цав цагаан туник өмсөж улаан өнгийн ноосон эдээр хийсэн бүс бүсэлж дээрээс нь захаараа өргөн цэнхэр зурвастай, цагаан цэмбэн тога өмчжээ.

Энэ үед Юлий Цезарь хорин зургаан настай байжээ. Цезарь нь төрөлөх авъяа чадвар сурсан боловчрол, уран үгийн чадвар, биедээ татах чадах, зүрх зориг сэтгэлээ барих хүч, хэзээ ч хэнд ч тохиолдож байсангүй үзэсгэлэнт сайхан бие царайныхаа ачаар, Ромд хязгааргүй их алдаршсан хүн байжээ.

Кай Юлий Цезарь нь ургийн эгч Юлийнхээ зүгээс Кай Марийн зээ болсон юм. Энэ садангийн холбоо бас бас талархан үзэж нягт холбоотой байдгийнхаа хувьд мрийн намынхны талын хүн болох учир Юлий Цезарь арван найман настай байхдаа Корнелиятай гэр бүл брож суусан юмаа. Суусан хүүхэн Корнелиягийн эцэг нь Луций Корнелий Цинна нь дөрвөн удаа консулын тушаалд сонгогдож байсан хүн бөгөөд тевтонууд ба кимврчуудыг ялагчдын талынхгныг яг баримталсан хүн байжээ. Сулла, дайснуудаа дарж дуусаад дарангуйлан захирагч болмогцоо Марийг талархагч Юлийнхний хоёр хүн цаазаар авах ял зааж бас залуу Кай Юлий Цезарийг эхнэр Корнелиягаасаа сал гэж шаардсан юмаа. Бүр тэр үед, няцашгүй хатуу төмөр мэт зоригтой болсон Цезарь_ Суллын тэр шаардлагыг биелүүлсэнгүй байжээ. Иймийн учир, Сулла Цезарьт алах ял заажээ. Харин Суллын талын нөлөөтэй хүмүүс ба бас голомтыг өршөөгч охин тэнгийн ачаар түүний амь аврагдсан юм.

Гэвч Суллын ноёрхож байгаа үед Ромд үлдэх явдлыг өөртөө аюулгүй гэж Цезарь үзсэнгүй. Цезарийн амийг уучилна уу гэж Суллаас гуйж байсан олон хүнд “энэ залуухан Юлийд, Маркийн үлдэгдэл багагүйгээр хоргодож байгаа юм гэж” дарангуйлан захиргчийн хариулж байсан нь зүгээр хэрэг огт биш байсан юм. Ингэж Цезарь Сабинад очиж, тэндхийн Лациум ба Тибертингийн ууланд

бүгж Суллын нас барах хүртэл тэнд байсан юм. Цезарь Ромд буцаж ирмэгцээ дайнд мордож тэнд эрэлхэг зоригоо үзүүлсэн юм.

Цезарь дайнаас бууж ирмэгцээ алдартай хгүн ухаантныг сонгох мөн хамгийн алдартай уран илтгэгчдийн сургуульд суралцах зорилгоор Грек улсад очихоор явсан юм. Гэвч Цезарийн сууж явсан хөлөг онгоц Фрормакузын дэргэд далайн дээрэмчдэд дайрагдан олзлогдоход, Цезарь зарц нарынхаа хамтаар бас тэдэнд олзлогджээ. Тэгэхэд Цезарь ер бусын нэрэлхэг зоригоо баталснаар ч барахгүй, дараа дэлхий дахиныг ноёрхох бололцоог түүнд өгсөн, бусдыг ноёрхон дагуулах төрөлөх авъяасаа үзүүлсэн билээ. Та нар ямар үнэ авч намайг чөлөөлөх вэ? Гэж дээрэмчдээс Цезарийн асуухад бид чамайг хорин талантаар чөлөөлнө гэж дээрэмчдийн хариулсанд, залуу Цезарь их зан гаргаж, үгүй би бол тавин талантын үнэтэй хүн юм. Иймийн учир тавин талант та нарт өгч өөрийгөө би чөлөөлнө, харин чөлөөлөгдсөнийхөө дараа хөөж очоод та нарыг баримвчлан авч, загалмайлан тэлж ална гэж хариулсан юм.

Юлий овогтны үгэнд хүн итгэнэ гэдэгт бат найдаж байсан Цезарь Эфес, Самос болон бусад ойр хавийн хотод хэдэн зарц нараа явуулж, тавин талалнт мөнгө цугларуулан далайн дээрэмчдэд өгч өөрийгөө чөлөөлөн авсан юм. Цезарь, ингэж чөлөөлөгдөж авмагцаа, зэргэлдээ байсан усан буудлын газруудаас хэдэн трирем хөлөг цуглуулан вач далайн дээрэмчдийн хойноос хөөж гүйцээд, дайран бут цохиж бүгдийг олзлон аваад, эднийг тушаалаар тэлж алах хэрэгтэй гэж преторт шилжүүлэн өгчээ. Тэр претор, дээрэмчдиг боол болгон дам худалдахаар оролдов гэдгийг Цезарь мэдэж, өөрөө шууд тушааж тэр дээрэмчдийг тэлж алуулсан юм. Тэгээд ингэж тушаасныхаа хариуцлагыг би сщенат болон Ромын ард түмний өмнө өөрөө хариуцна гэж мэдэгдсэн юм.

Энэ бүх явдал Юлий Цезарийн нэрийг их алдаршуулжээ. Дараа, хариуцсан Македония мужаа ялт муугаар удирдаж байсан, Кней Корнелий Долабеллыг Цезарь ил бөгөөд зоригтой буруушаан ялласан учир түүний алдар нэр улам ч их манджээ. Далалбеллад хүлээлгэсэн ялаа, Цезарь тэдний их гоё сайхан, ховор нарийн үгээр хамгаалсан учир, хамгийн гайхамшигт уран илтгэгч Цицерон хүртэл их л хүч гаргаж, арай ядан Долалбеллад хүлээлгэсэн ялаа. Цезарь тэдний их гоё сайхан, ховор нарийн үгээр хамгаалсан учир хамгийн гайхамшигт уран илтгэгч Цицерон хүртэл их л хүч гаргаж, арай ядан Долабеллыг цагаатгасан юм.

Папын сүмийн хажуудах багана саравчийн доор зогсож, тэнд үймэлдэж байсан хүмүүсийг харж байсан энэ хүн нь ийм хүн байжээ.

-Кай Юлий Цезарьт баяр хүргэе! Гэж Тит Лукреций Кир түүний хажуугаар гарахдаа дуугарав. Тэгэхэ Цезарь “Бодисын байгалийн тухай” гэдэг найраглалыг хожим бичсэн энэ хүний гарыг барьж

-Сайн байна уу, Кар гэлээ.

Хэсэг алиалагчид ба акробатчдын хамт Цезарийн дэргэд хүрч ирсэн, нүүрийн хөдөлгөөнөөр алиалагч Метробий:

-Гэгээн дүрт Юлий чамд нэр хүнд, алдар гавъяа хүсье гэв. Юлий Цезарь шоолсон маягтай инээмсэглэн:

-Ээ, Метробий Үзтэл чи амьдралаа дэмий өнгөрүүлдэггүй бололтой. Чи бол ганц ч баярыг, баясан цэнгэх өчүүхэн шалтгийг дэмий өнгөрүүлдэггүй байна гэлээ.

-Өөр яахав, гэгээн дүрт минь…. Тэнгэрээс бидэнд заясан энэ насанд цэнгэж л байхаас биш, яахав…. Эмикурээс бидэнд урьдчилан сануулсан ёсоор…. Гэтэл нь

-Мэднээ мэднэ гэж Эпикурийн хэлсэн үгийг давтан хэлэх ажлаас Метробийг Цезарь чөлөөлөн зогсоожээ.

Самнасан үсээ сагсайлгахгүй гэж Цезарь зүүн гарынхаа чигчий хуруугаар толгойгоо маажиж. Метробийг нааш ир гэж баруун гарынхаа долоовор хуруугаар дуудлаа.

Метробий, хамт явсан уран сайханчдаасаа маш яаралтай тасран явахад

-Чамайг бид Эс кулапын гуанзанд хүлээж байя гэж нэгэн нөхөр нь хойноос нь хашгирлаа.

-За гэж алиалагч хүн нөхөддөө хариулав. Цезар ийн дэргэд хүрч очоод:

-Юлий овогтны наран болсон гэгээн Кай чамд тус хүргэх бололцоо надад олдсоныг бодвол ямар нэгэн тэнгэр өнөөдөр намайг ивгээж байх бололтой гэж зусар зальтай хуурамч янзаар инээмсэглэн хэлжээ.

Цезарь түүнийг үзэн ядаж өчүүхэн инээмсэглэн:

-Хамгийн сайн Метробий, миний чамаас хүсэх зүйл бол өчүүхэн бага юмаа. Чи Кней Юлий Норбаны гэрээр очдог уу? гэхэд нь Метробий баярлан:

Очилгүй яахав, өглөгч Норбан наадд сайн байдаг юм…. Их сайн байдаг юм… бүр их эртнээс хойш… миний алдарт анд нөхөр мөнх Луций Корнелий Суллын амьд мэнд байх үеэс эхлэн… их сайн байдаг юм гэж шадар хүний янзтай хэлэв.

Цезарийн нүүрэнд, түүнийг жигшин үзэх царай үл эдэг үзсэнд авч, өнгөндөө Метробийд сайн байгаа байалтай:

-Тэгвэл сайн байна… гээд, түргэн зуур чимээгүй байснаа дуугарч:

-Метробий чи өнөө орой, миний оройн хоолон дээр ирээрэй тэгээд ямар тухай тусламж чамаас хүсч байгаагаа би чамд амрах зуураа хэлж өгье гэв.

-Ээ яасан их заяа вэ?… ямар их хүндэтгэлийг надад соёрхов…. Ерөөлийн дээд болсон Юлий минь чамд маш их баярлалаа… гэхэд нь

-Сайн байна. Баярлан чинь болно. Одоо яв, нөхөд чинь чамайг тэнд хүлээж байгаа. Орой уулзъя гээд. Цезарь агуу хөдөлгөөнөөр Метробийтай салх ёсоо гүйцэтгэсэнд, Метробий мянгантаа талархлаа илэрхийлэн мэхэлзэн ёсолж, Эскулапын гуанз чиглэн явлаа.

Цезарийн саяны уулзсан хүн бол маш муу чанарын хүн юм. Цезарь нь өөрөө, хүүхнүүдийн дунд тун их амжилттай байдаг залуу хүн гэдгийг анхаарч

үзвэл Метробийгаас Цезарийн мэдэж авахыг хшүсэх ззүйл нь дурлалын хэрэг байх нь лавтай байж магадгүй.

Цезарийн урилгыг хүлээнэ гэдэг бол маш их хүндэтгэл мөн гэж үзсэн Метробий, з заяандаа баяр хөөр болсоор Эскулапын гуанзанд хүрэлцэн очиж, урьдаж очоод ширээний ард сууж амжсан нөхөддөө, өөрт тохиолдсон хэрэг явдлынхаа тухай гайхуулан ханамжтай ярьж гарчээ.

Хэхэн цагийн хойно, элбэг сайхан хоолон дээр очно гэдгийг мэдэж байсан боловч Сетробий энд шунамхайгаар хоол идэх, улам шунамхайгаар велитернийн онц сайн дарснаас хойш уусангүй.

Хоол идэж, шог үг хөөрөлдөн, инээж шуугиж байсан учир алиа жүжигч тэр хүн, цаг минут өнгөрөхийг огтхон ч анхаарсангүй. Бас ууж сулласан хундаганыхаа тоог ч мартжээ. Даруй даруйгаар хөнтөрсөн дарсандаа цохигдон, хоёр цаг болсны дараа хөөрхий тэр амьтан ухаан алдатлаа согтуурсан байжээ. Гэвч согтуурн манарсан толгойд нь өчүүхэн гэгээ цоорч, цааш нь ууж болохгүй тэвэл би Цезарийн хоолон дээр очиж чадахгүй болно гэж санаанд нь орлоо. Тэгээд тэр явах гэж хатуу шхийдээд хоёр тохойгоороо ширээ тохойлдрн, багагүй хүчлэн зүтгэж байж, арайхийн хөл дээрээ босож, нөхөддөө явах ёслолоо хэлэх зуураа би явалгүй болохгүй, намайг Цз… Це… Цезарь оройнхоо хооллонд урьсан гэж ээдэрсэн үгээр тайлбарлан хэлжээ.

Метробийг ингэж дуугармагц энд байсан согтуу хүмүүс нэгэн зэрэг нирхийтэл инээд алдаж, түүнийг гуйвалзан тэмтэчсээр гуанзнаас гарахад хойноос нь хурц үгээр их ло шоололдож

-Чи ч “Цезарийнд” мөн гоч байна биз дээ гэж нэг нь хэллээ.

-Хөөрхий Метробий минь, хэл чинь зангилаатай байна даа гэж өгөө нэг нь хэллээ.

-Чи ямар тайзан дээр байгаа биш, бүжиглэх хэрэг юу билээ

-Шулуухан яваач…. Биеэрээ хана арчиж дүүрлээ.

-Цаадах чинь шаварчидтай хэлцэж тохирсон юм байлгүй

-Бүр могой шиг хотролдоод явж байх шив гэх зэргээр шоолжээ.

Ингэж байхад Метробий гудамжинд гарч:

-Та нар муусайн ноорхойчууд намайг шоо…лэ байн уу, шоолж байна уу? Би … Цезарийн хоолон дээр очно… тэр сайхан хүн шүү… гайхалтай хүн… Цезарь, тэр жүж…. Жүж… жүжигчдэд дуртай Капи… Капи… лотийн Юпитерийн өмнө ам алдъя. Би хаашаа явахаа… мэдэхгүй байна… Энэ велитернийн дарсыг … юмтай хольжээ. Эв… Эв… тибадагийн дотор шиг… хуурмаг юмаа… гэж явав.

Өвгөн согтуу, хориод алхам яваад юм бодож түр зуур зогсоод, Юлий Цезарийд очиж хүртэл үлдэж байсан хоёр цагийг велитернийн архид манарсан толгойгоо сэргээхд ашиглахаар шийджээ.

Хаашаа явбал… дээр вэ? …. Толгойн орой өөд…. цвбал дээр балйгүй, тэнд агаар нь…. Арай цэвэр байлгүй, халууцаж байдаг…. Хоёрдугаар сар нь

өвлийн сар гэж үү?… над шиг их уугаагү йхүнд л хоёрдугар сар өвлийн сар бахдаа… хэрэв би, энэ замаар явбал яахав?… тэрвэг би… тэр өглөгч хаан Нумын бунхантай дайралдана… би, тэр Нумыг хэзээ ч дуслын төдий ч хүндэтгэж байсангүй юм. Учир нь тр архинд дургүй байсан юм…. Архинд дургүй гэнэ… арнхинд дургү й гэж худлаа… би тэрийг үнэмшихгнү йанй. Эгерия нимфтай зөвхөн ганц төрийн хэргийн тухай ярилцаж байсан үгүй…. Бас…. Байсан гэдгийг би зөвшөөрөлдөгч хорин тэнгэрийн өмнө баталж чадна.

Метробий, эрүүл хүмүүсийг, ялангуа хөөрхий Нум хааныг хараасар, гуйван явсаар удалгүй Шуургын тэнгэр Фуррины ойд хүрчээ.

-Тэр нь энэ ойн доторхи нарийн зөхөн замаар бага зэрэг төөрч явсан ажээ. Ойн бараг төв дунд байсан асар том нэгэн модыг үзлээ. Энэ модыг эргэн тойрон тэрүүхэн хавьцаа модгүй тал газара байна. Метробий олон жилийн настай энэ модыг налж суулаа.

-Сэтэлий минь зовоож байгаа шуурганаас, зайлсхийн амрах газрыг заавал тэр шуурганы тэнгэрийг ой дотроос олно гэдгийг бодоход үнэхээр сонирхолтой хэрэг байна гэж алиа жүжигч энэ хүн аман дотроо чалчсаар байна.

Метробий чалчсаар байтал толгой нь хүндрэн, удалгүй унтаж хоцорлоо.

Наранд түлэгдэн, хатаж гандаад үр ургамалгүй болсон талд байна гэж Метробий зүүдлэн, бас учиргүй цангаж, хоолой нь хатан цээж нь давчиджээ. Гэвч, түүний аз дайрч бяцхан гол шүжигнэн урсах чимээ сонсогдож… түүнийг чиглэн гүйсэн боловч… хөл нь хүндрэн… чулуу шиг болж… хөлийн нь ул газраас саалхгүй болж… цаашаа явж чадсангүй. Гэвч голын тэр чимээ бас хол хэвээр байлаа. Метробий яаж харснаа өөрөө ч мэдсэнгүй нэг л хартал нь тэр горхиор фалерийн дарс урсаж байжээ… горхины шүржигнэх чимээ, хүмүүсийн шивнэлдэн ярилцахта адил нь гайхалтай хэрэг ээ. Метробийн ам мш их цангаж, голын зүг гүйсээр байж, арайхийн түүний дэргэд хүрч очлоо. Тэр сайхан фалернийн дарснаас залгилахаар газар элэглэн тонгойтолй… гэнэт урдаас нь Нума Помпилий гарч ирээд түүнд уулгасангүй. Нума Помпилий нь маш урт цагаан сахалтай, ширүүн царайтай байлаа. Тэр Метробийг ууртай харцаар харж, элдвээр хараан зэмлэжээ. Энэ Наума Помпилийн дуу нь төмрийн ду умэт хангинасан бөгөөд маш чанга байв… Нума Помпилийн харааж байх зуур бас хүмүүсийн шавнэлдэн ярилцах чимээ Метробийд сонсогдон, тэр чимээ горхины усан дотороос гарч байх мэт түүнд санагдлаа. Басгорхин дотуур урсаж байсан фалернын дарс гэнэт ув улаан цус болон хувирчээ.

Тэгэхд Нума Помпилий их л ууртай зандран:

-Чи цангаж байна уу?… хүчлэн зовоогч чи цусанд шунаж байна уу?… тэгвэл, чи муу аймхай, ах дүү нарынхаа цусыг ууж цап л даа гэлээ.

Зүүд нь улам бүр аймшигтай болж Метробийн зүрх хагарах шиг санагдан. Тэр тайтгаршгүй үгтэй өвгөнөөс айж бүх хүчээр хурдлан зугтсан боловч модны гишүүнээс бүдчин ойчиж явлаа… Метробий сэрээд, нэгэн хэсэг, чухам хаана байгаагаа ч мэдэхгүй, мөн унтсан хэвээр байна уу, аль сэрэв үү гэдгээ ч мэдэхгү

йбайлаа, нүдээ арчиж эргэн тойрон харж, модон дотор байна, шөнө орой болсон байна. Зөвхөн сарны гэрэл модны мөчрийн завсраар гэрэлтэж байна гэдгийг сая мэдлээ. Метробий сэрэхийг аль болохоор оролдсон боловч чадсангүй. Нума Помпилийн хараах дуу хэвээр сонсогдсоор байжээ. Сэрснээсээ хойш, би зүүдэлсэн хэвээр байна гэж өөрөө бодож байлаа. Гэвч тун удалгүй үнэхээр сэрснээ мэдэж, бая яаж всаар энд ирснээ санажээ. Зүүдэнд нь сонсож байсан шивэгнэн ярилцах чимээ нь үэхээр хүчний ярилцах чимээ байлаа. Өөрөөс нь холгүй газар ойн цоорхойд, хүмүүс үнэхээр ярьж байна гэдгийг ойлгож мэдлээ.

Ярьж байгаа тэр хүн, их л оргилсон дуугаар:

-Алсных нь хариунд алах хэрэгтэй. Үхэх л ёстой юм бол дарлагчдыг цэнгүүлэхийн тулд биш харин өөрсдийнхөө тусын тулд үхэхийг бодъё. Хүний дүрстэй боловч цаад муусайн галзуу араатад чинь хүний цусанд Ливийн цөмийн барс шиг, шунахайрч байна. Тэгж л байг. Тэд юлдээ барьж бидний урдаас ирэг гэхэд нь тэдний цус бидний цустй холилдон урсах болно, боол гладиатор хэний боловч дотор ялгаагүй зүрх зохилж байдаг юм байна гэдгийг тэд нар мэдэж аваг. Наран бүгдийг адилхан гийгүүлж газар дэлхий бүгдэ адил үр жимсээ өгөх ёстой, хүн бүгдийн амьдрал жаргал зовлон адилхан хуваагдсан байх ёстой гэдгийг тэд нар мэдэж авах болно гэж Олимпийн тэнгэрийн өмнө тангаргалъя.

Энэ хүний, оргилсон үгээ хэлж гүйцэхэд нь түүнийг сайшаан шивгэнэлдэх чимээ сонсогдлоо.

Энд Бүгд Найрамдах Улсын эсрг зүйлийг сэдэвлэж байгаа хүмүүсийн ухарл болж байгаа юм байна гэдгийг Метробий мэджээ. Бас тэнд өндөр дуугаар дуугарч бйсан хүний дуу, таньдаг хүний дуу шиг Метробийд санагджээ.

Гэвч, энэ нь хэний дуу вэ? Үүнийг урьд хаана сонслоо. Хэзээ сонссоноо Метробий санахгүй л байлаа. Бүр сайн дуулж авах гэж амьсгалаа даран бүх хүчээ дайчлан чагналаа.

-таван жил, нууцаар шургуу ажилласаны дараа, түүнийхээ гэгээн ачид хүрэх цаг одоо л нэг боллоо гэж хэлэх цаг болсон биз гшэж бас нэг сөөнө хоолойтой аяархан дуутай хүн лат хэлээр муухан хэлэх нь сонсогдлоо.

-Одоо л нэг дайтаж, эхлэх, цаг болсон байхаа гэж түрүүний хүнээс ч улам сөөнгө боловч, бүдүүн дуутай нэг хүн асуулаа.

Метробийн сэрж байх үед дуугарч байсан хүний дуу дахин сонсогдож.

-Болсоон гэж хариулаад –Артоикс маргааш явна… гэлээ. Энэ нэрийг сонсож, Метробий түрүүний ярьж байсан хүн хэн болохыг мэдэж авлаа. Ярьж байсан тэр хүн нь Спартак мөн боллоо. Тэгээд тэд нар энд юуны тухай ярилцаж байсан болохыг мөн ойлгож авлаа.

-Арторикс маргааш Равенна руу очиж, таван мянган гладиатораа бэлээн байлга гэж Граникт хэлнэ, тэгээд тэндхийн гладиаторууд манай цэргийн нэгдүгээр легион болно. Крикс, чиний командлах хоёрдугаар легионыг одоо Ром хотод сууж байгаа, манай холбооны гишүүдээс бүрдүүлнэ. Тэдний тоо долоон мянган долоон зуун тавин хүн байлаа. Капуя хотын Лентул Батиатын

сургуулийн арван мянган гладиатораар гурав ба дөрөвдүгээр легион байгуулж Эномай бид хоёр командална гэж Спартак хэлжээ.

-Легионууд болон жагссан, хорин мянган глаиатор гэнэ. Хорин мянга… бас лут байна…. Тамын тэнгэрт тангараглая… бас лут байна… Суллын ба СМарийн бардам зантай цэргүүдийн арыг харна гэж би мөрий тавья гэж Эномай, галзуу мэт баярлан чанга дуугаар хашгирлаа.

-Дарлагдсан, хөөрхий эх орныхоо төлөө, хэрэг ажлынхаа амжилтын төлөө, бид нарыг холбож байгаа ариун бөгөөд үнэнч явдлын төлөө, та нараас хүсэх нь, болгоомжтой сайтар бодолтой байгтун. Ажил хэргээ болгоомжтой явуулах хэрэгтэй, хэрэггүй цагт хэтэрхий зориг гаргавал засаж болохгүй зовлонд ч хүрч болно. Таван хоногийн дотор та нар, манай анхны довтолгооны тухай сонсоно. Эномай бид хоёр, отрядуудаа тосгонд цуглуулах боловч бололцоо тохиолдмогц Кампаньягийн нийслэлд ширүүн цохилт өгөхийг бид ородоно. Тэгэхэд та нар Равенна ба Ромд бүх хүчээ цуглуулаад, бидэнтэй нийлэхээр гарах хэрэгтэй. Капуягийнхны босох хүртэл та нар урьдынхаа адилаар өргөөндөө мгалан тайван, томоотой байх хэрэгтэй шүү гэж Спартак хэллээ.

Спартакийн ярьж дууссаны дараа, дарлагдагсдын холбооны дээд штабынхан болох энд байсан гладиаторууд их л хөөр болон замбарагүй ярилцаж эхэллээ.

Эд нар завсар хоорондоо блгоомжлолын тухай ярилцаж бас найдвар ба сэргэх тухай үг солилцож харилцан бие биендээ баяр хүргэж байснаа тарж эхэллээ. Бүгдээрээ хоорондоо баяртай ярилцан, Метробийн байж байсан газрыг чиглэн явахад Спартак тэднийг дуудаж

-Ах дүү нар минь ээ, бүгдээрээ ганцхан чиглэлд бүү яв, хоёр хоёроороо юм уу эсхүл гурав гурвaараа, бие биенээсээ тав-зургаан зуун алхмын зайтай явцгаа. Хот орохдоо зарим нь Цестийн гүүрээр, нөгөө зарим нь Сублицийн, бусад нь Эмилийн гүүрээр явцгаа гэлээ.

Тушаал ёсоор гладиаторууд зүг бүрдээ тархан явлаа. Айн сандарч модны ёроолд бүгж байсан Метробийн хажуугаар өнгөрөх зуураа Спартак баруун гараараа Криксийн баруун гары атгаж:.

-Чи бид хоёр, шөнө дундын үед өрөөсөн нүдэт Лутациягийнд уулзъя. Тэгэхэд чи, нөгөө бидэнд ирүүлнэ гэсэн зэвсгийг тав хоногийн дотор ирүүлж амжих эсэх тухай мэдэж ирээд надад хэлээрэй гэж хэллээ.

-Манай тэр ачааг аль болох хурдан ирүүлж өгөх гэж амласан луус хариулагч, тэр хүнтэй уулзахаар би одоо яавах гэж байна гэж Криксийн хэлэхэд Эномай тоомсоргүй байдлаар

-Ээ Тэр зэвсгээр бид яах юм. Бидэнд тангараг бидэнд зориг байснаас хойш өөр зэвсгээр яах юм гэлээ.

Крикс салж Цестийн гүүрийг чиглэн, хурдан алхлан одлоо. Спартак, Эномай, Арторикс гурав Сублицийн гүүр рүү эргэлээ.

Гладиаторуудын холдох тутам Метробий улам бүр зоригтой болж:

-Энэ ч харин, тоглоом шиг тоглоом байна даа. Энэ ч харин тоглоом шиг тоглоом мөн дөө.. энэ чинь манай Бүгд Найрамдах Улсад бас ширүүн шуурга буух нь ээ. Зэвсэглэсэн хорин мянган гладиатор гэдэг чинь… Сицильд гарсан боолын дайн шиг дайн дахин гарах гэж байгаа хэрэг байна… Түүнээс ч дор юм болно… энэ Спартак бол Сициллийн боолчуудыг командалж байсан Сициллийн боол Эвныг бодвол зориг сэтгэл хатуутай арга залийн хувьд маш давуу хүн юм… би заяагаар энэ ойд хүрч иржээ… энэ Спартак бол Сициллийн боолчуудыг командалж байсан Сициллийн боол Эныг бодвол зориг сэтгэл хатуутай ар залийн хувь маш давуу хүн юм… би заяагаар энэ ойд хүрч иржээ. Бүгд Найрамдах Улсыг аврах зэвсэг болгон бүхнийг ялагч тэнгэр намайг томилсон хэрэг байлгүй яанав… аргагүй л тэгжээ… ийм нэгэн хэрэгт эрт нэгэн цагт галуу тус болсон гэдэг билээ. Тэгэхэд би яагаад тус болж болдоггүй юм? Түй Өөрийгөө муу галуутай адилтгах санаа, чухам согтуу байхад л толгойд ордог байгаа даа гэх мэтчилэн бодлжээ.

Өөрийгөө, галуутай адилтгасандаа сэтгэл ихэд гомдсон Метробий суусан газраасаа босож, гладиаторууд бүгдээрээ явав уу, эсхүл энэ газар манаач үлдэв үү гэдгийг магадлан мэдэхээр модон дотуур шийдвэр муутай хэд алхлав.

Түүний ингэж б айх завсар нь нөгөө, орой бүрий эхлэх үеэр манай хоолон дээр ирээрэй гэж урьсан Цезарь сана анд нь орлоо. Гэтэл одоо шөнө дунд хариугүй шахаж б айжээ . иймд Местробий их харамсан гашуудсан боловч , за гайгүй , охин тэнгэрийн Фурринагийн ойгоос аюулгүй мултран гарч болох болмогц би Цезарийнд яаралтай гүйж хүрээд ,
энэ нууц хэрцгий хамаг чухлыг хэлж өгье гэдэг санаа төрлөө . нууц хуйвалдааныг илрүүлсэн болох учир Цезарь намайг уучилна гэж алиа жүжигчин дотроо найджээ .

Гладиатруud цөм холджээ гэдгийг мэдэж модон дотрооё гарч Цестий н гүүрийг чиглэн хурдлан явжээ . хэрэв би согтоогүй сэн бол глиадатруудын цуглааны үеэр дайралдаж Фурринагийн модонд очихгүй байсан б айхдаа . иймийн учир , уусан архи ба уумтгай заншлаа ерөөх хэрэгтэй б айна гэж явах замдаа бодож явжээ . тэгэхэд нь тун саяхөан хүртэд хараан зүхэж б айсан Эскулапын гуанзны велитренийн дарс хүртэл түүнд тэнгэрийн рашаа н шиг санагджээ.

Метробий энэ мэт сэтгэсээр явж Цезарийн байшинд хүрээд, дотор нь орлоо. Ромын хувь заяаг шийдвэрлэж ч болзошгүй чухал мэдээ хэлэх гэж хүн ирээд байна номынхоо санд түргэн ирнэ үү гэж хүнээр хэлүүлжээ .

Цезарь анхнадаа Метробийг сул үг чалчигч , архичин хүн гэж үзэж түүнийг огт анзааралгүй байсан боловч бага бодсоныхоо дараа хэлэх үгий нь сонсъё гэж шийдсэн юм

. ингээд Цезарь зочдынхоо өмнө буруугаа хүолээгээд номынхоо сан руу очлоо.

Тэнд Метробий их л сандарсан байдалтай глидиаторуудын хуйвалдааны туахй товчхон хэлж өглөө .

Энэ нь Цезарьт гайхалтай санагджээ . түүний яртьж байгаа эн бүх зүйл нь согтуу хүнд үзэгдсэн хий сэтгэлийн үзэгдэл биш байгаа гэдгийг магадлахын тул Цезарь , алиа жүжигчнээс өдий төдий асуулт асуулаа . тэгж хий сэтгэлийн үзэгдэл биш байжээ гэдгийг нь мэдэж аваад хөмсөг зангидан , их юм бодолхийлэн түр зогссоноо , ямар нэгэн зүйлийг шийдэх бололтой давхийж , мөн инээмсэглэн :

Чиний энэ ярьж байгаа зүйл чинь , үлгэр байга гэдэ нь нэгэн милийн газраас мэдэгдэж байна . Чиний энэ үлгэр Эскулапийн гуанзанд хэтэрхий залгилсан велитернийн дарсаас болсон байна гэж надад санагдана: чи үүнийг хүлээх үү гэж меторбийгээс асуулаа. Тэгэхэд Метробий ,

- Ээ, гэгээн юлий минь велитерийн дарсандп ялангуяа сайн велитерийн дарсанд бол тэсгэлгүй дуртай гэджгээ би хүлээнэ, мөн энэ орой миний толгой хэвийн биш байсан гэдгийг ч үгүйсгэхгүй . харин Фурринагийн ой дотор сонссон зүйлийнхээ тухай бол би батлан тангаргалаж чадна. Учир нь Яникуль толгойн цэвэр агаарт ханатлаа унтаж толгой бүрэн сэр гэсэн үе байсан тул тэрний ярилцсан үгийг нэгд нэггүй сонссон юм . мөн тэр дараалаар нь чамд хэлсэн билээ .
- Тэгээд чи Бүгд Найрамдах Улсаа ийм аюултай байдалд орхиж тэр тухай кон сулын сенатад хэлэхгүй гэж үү гэлээ .
- Цезарь хэвээр толгой санжуулан бодолхийлэн зогссоор байлаа.
-

Байдал минут бзрд улам хүндэрсээр байна гэхэд Цезарь дуугүй зогссон хэвээр л байлаа .

Метробий бас дуугүй боллоо . Түүний ухас ухасхийж байж хөдөлгөөнийг харвал “эх оронч” сэтгэл яаруулан зовоож байгаа нь үзэгдэж байлаа . Нэгэнт минут болсны дараа Метробий дуугарч :

-Тэгээд яах вэ? … гэж асуулаа .

Цезарь толгой өргөж :

- манай эх оронд, үнэхээр ноцтой аюул тохиолдож байна уу, үгүй юу гэдгийг би өөрөө шийдэхийгш хүссэн юмсан, Метробий ! гэхэлд нь
- Ээ , гэгээн Юлий! Хэрэв чи хүсвэл энэ хуйвалдааныг илрүүлсэн гавъяагаа би чамд дуртайя а шилжүүлж өгье . Кай Юлий Цезарь агуу сэтгэлийнхээ үүднээс , бусдын ачийг хариулж чаддагаа хэзээд батлана гэдгийг мэдэж, би түүнд бат найдаж б айна
- Сануулсан зүйл, сайн сэтгэлийн чинь би баярлалаа Метробий . Гэхдээ санамсаргүй тохиолдлоор чиний гарт орсон нуцуаас ашиг хонжихыг үүднээс биш харин тохиолдсон ийм хүнд байдлын үед яавал дээр юм гэдгийг шийдэхийн тул, хэргийн учрыг шалгаж үзэхийг хүснэ .

Метробий зөвшөөрөн толгой дохилоо.

- Одоо чи миний албан өрөөнд оч , тэгээд намайг тэнд хүлээж бай, харин цуааш нь бүү чалчаарай ! Фурринагийн ой дотор сонссон зүйлийнхээ ч тухай тэр, надтай энд ярилцсан зүйлийнхээ тухайд ч тэр , хэнд ч хэлж болохгүй шүү, ойлгов уу Метробий . Нэг цаг болоод би ирнэ, тэгээд , манай эх орны ашиг тусын тул юү хийвэл зохихыг хоёул ярилцъя гэлээ .
- Бүгдийг , би чиний тушааснаар гүйцгэнэ, Цезарь… гэж Метробий хүлээжээ .

Кай Цезарь үхэх үедээ , циркийн уралдааны үед шагналд хүртээдэг жирийн лаврын хэлхээгээр толгойгоо чимэглэсэн байх гэсэн зүйл хувь заяаны тэмдэглэлийн ном дээр байдаггүй билээ . хүний ачийг хариулж чаддаг учир чиний сэтгэлийг би хангах болно гэж Цезарь Метробийд хэлжээ .

Метробийг тэнд нь орхиод , Кай Юлий номынхоо сангийн зэргэлдээ өрөөнд орлоо. Тэнд , хоол идэх үед өмсдөг хувцасаа тайчиж оронд нь юүдэнтэй цув өмсөж толгойгоо бүтээгээд , бас намайг дагаж яв гэж нэгэн боолдоо тушаагаад байшингаасаа гарч либитинийы Венерийн гуанз байдаг муу нарийн гудамжийг чиглэн хурдлан явж одлоо .

Цезарь нь Платинд байдаг байшингаасаа гадна, Субурын төвд б ас нэг байшинтай юм . Ром хотын энэ районд оршин суудаг ядуучуудын дуэнд нэр хүнд олж авахын тулд , Цезарь тэр байшиндаа олонтой ирдэг байсан юм . Сенатын түшмэдийн хувцасны оронд жирийн зузаан туник өмсөж , Субурра ба Эсквилиний бохир харанхуй гудамжнуудаар нэг бус удаа хэсүүчлэн явж заяа

муутай хүмүүст тусламж болгон үлгэрлэшгүй арвин их хишиг хүртээдэг байсан юм . Гаслан зовлон , ичгүүр гутамшиг , танхай балмад явдлаар дүүрэн энэ хэсэг газрын хамгийн бохир, хамгийн цөл булан мухар бүгдийг Цезарь таван хуруу шигээ мэддэг байсан юм . Цезарь өрөөсөн нүдэнт Лутациягийн гуанзанд шууд хүрч түүний хоёрдугаар өрөөнд нь орлоо. Тэнд рудиарий нар ба гладиаторууд хоол идэж б айжээ .

Цезарь тэнд байсан хүмүүстэй ердийн байдлаар мэндлээд, булангийн нэгэн ширээний ард сууж , хоёр аяга архи аввчир гэж эфиопи омгийн шивэгёмн хүүхэнд тушаалаа. Цезарь өөрийгөө огт танигдуулахгүйгээр байж, хамт явсан хүнтэйгээ шалихгүй үгээр ярилцан , гладиаторуудын хооронд юу болж байгааг маш сайн харж бас тэдний юу ярилцаж байгаагий нь сонор соргогоор чагнаж байжээ.

Крикс Эномай хоёрын завсар сууж байсан Спартакийн царай нь цайвар бөгөөд юм бодож уйтгарлсана байдалтай байжээ . суллын нас барснаас хойш өнгөрсөн дөрвөн жилийн дотор фракий язгуурын энэ хүн улам төлөв томоотой болсон юм . Бас духан дээр нь би болсон гүнзгий атираа,
түүний сэтгэлийн түгшүүрэл ба их юм боддогий нь гэрчилнэ.

Цезарь, Спартак гэдэг нэрийг энд сонсож ер бусын чадалтай , аврага их ухаантай хүний царай нүүрэн дээр нь тодхон харагдаж байсан маш өндөр нуруутай сайхан эриг харж, тэр нь Спартак мөн гэдгийг тааварлан мэджээ .

Гладиаторуудыгш агуу их хүний төлөвтэй ажиглан харж байсан Цезарь , Спартак нь үнэхээр агуу хэгийн төлөө өндөр гавъяа байгуулахын төлөө эрэлхэг баатар зүрхтэй , аврага их зөн билигтэй хүн болж төржээ гэдгийг энэ хэдхэн минутын дотор олж харлаа .

Энэ завсар шивэгчин хүүхэн Азур, хоёр аяга дарс авчирлаа . Цезарь түүний нэгийг өөрөө авч нөгөө нэг рүү нь зааж

- Түүнийг чи уу гэж боолдоо хэлжээ .
- Боолынхоо дарсаа ууж байх үед Цезарв бас аягатай дарсаа авч амандаа хүргэж ууж байгаа хүний дүр үзүүлэн , түүнд уруулаа ч хүргэсэнгүй . Цезарь зөвхөн ус л ууж байжээ.
- Нилээд байсны дараа Цезарь байрнаасаа босож гладиаторуудын дэргэд очоод
- Гарамгай Спартак чамд баяр хүргэе! Чамдп заяа ивгээх болтугай! Чи заяатай байвал зохих хүн байна! Чи надтай түр ярилцахыг зөвшөөрөхгүй юу ? гэлээ .

Бүгдээрээ Цезарийн зүг харж,

- Юлий Цезарь гэж хэд хэдэн хүн зэрэг дуугарлаа .

Спартак гайхаж

- Юлий Цезарь! Гэж байрнаасаа бослоо. Спартак урьд нв Цезарийн тухай хүний ярианаас сонсож байснаас биш түүнтэй нэг ч удаа нүү учирч байгаагүы ажээ .

Хожим дарангуйлан захирагч болох байсан Цезарь нөхөрсөг ёсоор инээмсэглэн Дуугүй … дуугүй .. тэгэхгүй бол нэгэн понтифик шөнийн цагаар Субуррын ба Эсквилинийн зуушны газруудаар тэнүүчилж явсан гэдгийг Ром даяар мэдэх болно гэлээ .

Юлийнханы ураг садны энэ хүнийг Спартак нэгэн хэсэг чимээгүй харж байснаа

- Кай Юлий, хэрэв миний тусламж чиний ямар нэгэн хэрэгт тус болж чадвал би өөрийгөө заяатай хүн гэж үзэх болно гэлээ .
- Чи сайн нөхдөө түр орхиод , миний хамтаар явж аль ойр байгаа , хотын хэрмийын дэргэд очихыг чи зөвшөөрөхгүйсэн болов уу гэж Цезарь хэллээ .
- Гладиаторууд гайхсан байдалтай бие биеэ харцбгаалаа . Спартак сэтгэл ханасан байдалтай болж :
- Над шиг хэнд ч мэдэгдээгүй , хоосон ядуу рудиарийд Ром хотын хамгийн сайн язгууртай хамгийн алдартай хүвүүдийн нэгний хамт зугаацан явна гэдэг сайхан хэргээ гэв.
- Эндээ хүлээж бай гэсэн дохиог боолдоо өгөөд, хаалга чиглэн явах зуураа Цезарь эрэлхэг зоригтой хүн бол хэзээд ч хоосон ядуу байдаггүй юм гэж Спартакт хэлжээ .
- Гинжинд орсон арсланд, хүч юуны хэрэг байх аж? Гэж Цезарийн хойноос явж байсан Спартак санаа алдаж хариулав.

Энэ хоёр ер бусын хүн , зуушийн газрын гол таалгааг өнгөрч гудамжинд гараад баруун гар тийш эргэж, одоогоос дөрвөн жилий.н өмнө Кай Веррес гэдэг нэгэн чөлөөлөгдсөн хүнийг гладиаторуудын алсан хотын хэрмийн дэргэдэх тэр газрыг чиглэн чимээгүй явлаа . Хотын захын байшингууд ба Сервий Туллын далангийн завсрын тал тэгнш газар хүрч энэ хоёр урд урдаасаа харж зогслоо . Бие биенээ судлан үзэх гэж байгаа юм шиг урд урдаасаа харж сартай шөнө, задгай газар зогсож байсан Це зарв Спартак хоёрыг холоос харахад сүүмэлзэн харагдах шбөнийн үзэгдэл мэт байлаа . энэ хоёр өөр өөр үзэл санааг баримталсан хүмүүс болохоор дор бүрдээ мэдэж, эсрэ

г тэсрэг хоёр, тугийн тус тусдаа эзэд болохоо мэдэрч харигсблан дарангуйлах ёс ба эрх чөлөө хоёрыг тус тусдаа бүтээн байгуулагчид болохоо дор бүрдээ мэдэрч б айсан юм .

Цекарь урьтан дуугарч :

- Чи хэд хүрэв? Гэж асуулаа . Спартак түүний санааг мэдэж авахыг оролдож байгаа мэт Цезарийг ширтэн харж:
- Би гучин гурав хүрлээ гэж хариуожээ .
- Чи фракий язгуурын хүн үү?
- Тийм ээ.
- Фракий язгуурын хүмүүс бол аюултай цагт буюу тулалдааны үед зоригтой хүмүүс шүү. Чи бол эрэлхэг зориг ба чадалтайгаар ч барахгүй бас сайн язгууртны зан байдалтайн дэр боловсролтой хүн . тийм биз?
- Чи үүнийг хаанаас мэдэв ?
- Нэгэн эмэгтэй хүнээс сонсож мэдсэн юм . Чиний биеэ зориулсан хэрэг ажил болоод чи өөрөө аюулд дайрагдахад хүрээд байгаа одоо т үед тэр тухай ярилцахад хэрэггүй байна гэхэд нь:
- Чи ямар хэргийн тухай , ямар аюул заналын тухай ярьж байна? гэж Спартак гайхан асуулаа .
- Би бүгдийг мэдсэн, би энд ирэхдээ чамд хор хүргэх гэж ирсэнгүй , Спартакаа , харин чамайг аврах сэтгэл намайг захирч энд авчирсан юм . Фурринагийн ой дотор модны цаанаа сууж байан нэгэн хүн энэ шөнө та нарын ярилцсаныгш санамсаргүй сонссон байна билээ .

Спартак найдвар тасарсан мэт болж аймшигтай дуугаар хашгран

Тэнгэрийг зүхье!… гэлээ .

Одоогоор тэр

хүн сонсож мэдсэн зүйлээ консулуудад мэдэгдээгүй байна, би түүнийг саатуулахыг хэдийчинээ оролдовч , тэр нь энэ шөнө юмуу эс бол маргааш өглөө заавал консулуудад мэдэгдэнэ, тэгээд чиний дөрвөн легиолн гладиатор чинь цуглаж амжаагүй байтлаа бут цохигдох болно гэхэд

Спартакийн сэтгэл аймшигтайгаар хямарч хоёр гараараа толгойгоо шүүрэн авч, өтгөн цайвар үсээ , бөөн бөөнөөр нь угзчин тасдаж гаслан уйлах завсраа өөрөө өөртэйгөө ярилцаж б айгаа мэтээр шивэгнэн:

- Ингээд , таван жилийн маань найдвар горьдлого тэмцэл хөдөлмөр нэг мөсөн нурдаг ажээ ! … ингээд дүүрдэг юм байжээ . Ингээд боолын үйлт амьдралд дахиад эргэж ордог болжээ гэлээ .

Нурах болсон хэрэг

ажлаа өдийчинээ их харамсан гасалж шаналан зовж байан Спартакийг Цезарь өрөвдөн харж, сэтгэл нь хөдлөн хүндэтгэж байжээ . Цезарь , Спартакийн өөрийн эрхгүй гайхан сайшаасан юм . Эрх чалаанд дуртай ариун сэтгэлтэй ачаар Ромын буюу Грекийн баатруудад байхуйц тийм байгууллагыг сэдэвлэн бий болгох чадлыг олж зориг чадал , шургуу ажлаараа хорин мянган гладиаторуудыг цуглуулан ёстой уэргүүдийг бий болгож чадсан энэ хүнийг Цезарь их л гайхан харж байжээ .

Цезарь энэ бүхнийг санаж , ямар нэгэн зүйлийг шамдан хүсэх мэт болж нүд нь гялалзан толгой нь эргэж , дотор нь харанхуйллаа . Цезарь нүдээ том нээж Албанийн уулсын оройг ширтэн сэтгэлээ чөлөөтэй тавьж элдвийг боджээ . хэрэв энэ хүнд , хорин мянган хүнтэй дөрвөн легион цэрэг өгвөл хэдхэн жилийн дотор бүх ертөнцийг байлдан дагуулж , Ромын эзэн болж патрицуудын догшин аянга , жирийн ард түмний хүндэтгэлийн ариун шүтээн болох нь байжээ гэж бодлоо .

Ингэж Цезарь – нэгэн талаас айн зовж уйтгарлах сэтгэл төрж, нөгөө талаас алдар нэрийг мөрөөдөх сэтгэл босож нилээд хэдэн минут дуугүй зогсож байлаа .

Спартак хөмсөг з зангидан дуугарч:

- Үгүй, үгүй Кàрателийн Юпитерийн аянгыг дуудан ам алдъя арай ч тэгэхгүй бизээ ! гэлээ .
- Спартак энэ үгийг сонсож :
- Тэгээд чи яах юм ? гэж Цезарь асуулаа .

Спартак , Цезарийын түвшин царайг харж:

- Цезарь чи, манай дайсан уу, аль манай нөхөр үү? Гэж асуулаа .
- Би та нарын нөхөр болохыг хүссэн билээ , хэрхэвч би танай дайсан болохгүй гэлээ .
- Тэгвэл чи яахаас ч буцахгүй юу?
  Биднийг аврах эсэхийг чи шийдэх болжээ .
- Яаж би аврах вэ?
- Бидний нууцыг мэдсэн тэр хүнээ бидэнд шилжүүлж аль.
- Би Ромын хүн, тэгээд италийн бүх боолчуудын босох гэж байхад тэдэнд саад хийж чадах байтлаа , саад хийлгүй ромыг аюулд учруулах гэж үү?
- Чиний зөв , би мартжээ , чи нээрээ ромын хүн л дээ .
- Би бүх ертөнцийг ромын захиргааны дор ороосой гэж байна.

- Тэгэлгүй дээ ! Чи чинь – дэлхийн бүх улс түмнийыг ноёрхогч лат хүн шүү ддээ . Александр Македонскийн санаж байснаас улам их сэтгэл чиний дотор төрсөн шүү дээ . Дэлхийн бүх улс түмнийг ромын бүрэлдэхүүнд шүүрэн хамж авах тэр цагт тэдгээр улс түмнийг гинжилж төмөр хушуундаа зууж бай гэв үү?

Улс түмэн бүхнийг Ром эрхэндээ авч байх , Ромыг чи эрхэндээ авч байх гэв үү! Гэхэд нь Цезарв баярласан бололтой нүд нь гялалзаж байснаа хэвийн байдалтай болж инээмсэглэн:

- Миний санаж хүсч байгаа зүйлийг хэнч мэдэхгүй би ч өөрөө мэдэхгүй байж магадгүй . тэгэхэд Спартак чи бол цэргийн агуу их удирдагч хүний гайхамшигт ухаан гаргаж асар их чадвар дайчлан боолчуудыг армийг цуглуулж том том легион байгуулан тэд нараа дагуулан байлдахад бэлэн болсон байна. тэгээд чи яах гэж байгаа юм . Спартак минь надад хэлж аль ! Чи чухам юундаа найдаж б айна? Гэж асуулаа .

Спартакийн нүд нь гялалзан:

- Би завхайран самуурсан ромын м ертөнцийг нурааж түүний байранд чөлөөтэй ард түмний хөгжиж б айхыг харах гэж хүсэх юм . Би , хүн нь хүнийхээ урд сөгдөж , өөрсдийнхөө төлөө биш харин өвчин зовлон , залхуу хойргыг тарьж байдаг хэсэг хүний төлөө ядран туйлдаж ажил хий ж байх ёсыг номнодог шившдэг хуулийг хөнтөргөхийг хүссэн юм . Би дарлагдагсдын гаслань дууг дарлагчдын цусанд шингээж ромын ялалтуудын дугуйнд хүлээстэй байгаа заяа муутны гинжийг тас цохихыг хүссэн юм . Би тэр гинжний төмрөөр юлд хийж , ард түмний гарт өгч эх нутгаасаа та нарыг хөөн зайлуулж , италд чинь буцаахыг хүссэн юм . Учир нь тэр нутгийн бидэнд тэнгэр хайрласан юм , тиймийн учир та нар манай хилийг гатлахгүй байх ёстой байсан юм .
- Бусдын нэгэн адил санах бодох хүсэлтэй , дурлах хайрлах сэтгэлтэй жаргах цэнгэх хувьтай төрсөн хөөрхмй хүмүүсийг завсар хооронд нь яргалуулан алалдуулж , тэдний цусаар биднийг зэрлэгүүд гэж нэрлэдэг зэрлэг араатан мэт хүмүүсийн сэтгэлээ ханах газар болгосон бүх амфитеатрыг галд шатаах гэж хүссэн юм . Бүхнийг ялгуулагч Юпитерийн аянгын нэрийн

өмнөөс боолын шившигт ёс дэлхий дээр устаад байхыг харах гэж хүссэн юм . Би, эрх чөлөөг эрж явна , эрх чөлөөг хүсч байна , эрх чөлөөг эрж түүнийг уриалж байна, хэн бүхэнд , их бага , хүчтэй хүчгүй ялгалгүй , улс бүхэнд адилхан эрх чөлөөг би хүсч бана. Мөн эрх чөлөөний нэгэн хамт- энх тайван , цэцэглэн бадрал , үнэнч шудрага гэх зэргийг газар дэлхий дээр хүн бүхэн адилхан хүртэж байг гэж үхэлгүй мөнх тэнгэрээс хайрласан тэр бүх дээд заяаг би хүсч байна. Цезарь нэгэн газраа хөдлөлгүй зогсож , Спартакийн хэлсэн энэ үгийг сонсож түүнийг хөөрхийлөн харж байснаа:

- Тэгээд сайн үйлийг хүсээд сэтгэлчлэгч хүн чи дараа нв яах юм ? гэлээ .
- тэгсний дараа хүч түрэмгийлэлийн эрх чөлөө ноёрхож , бүдүүлэг хүчдэлийг оюн ухаан ноёрхож хүн бүхэн тэгш эрхтэй болж, улс түмэн бүхэн ах дүү нар болж , сайн сайхны ерөөл хүн төрлөхтний дунд жигд тахаж байх болно гэж Спартак хариулжээ . Энэ үгээ хэлж байхад нь сэтгэл дотроо агуулж явсан сайн сайхан мөрөөдөл нь нүүрэн дээр нь тусаж байх мэт Спартакийн царай баясгалантай байлаа .
- Сайныг мөрөөдөгч хөөрхий хүн чи! Тэр хүсэж мөрөөдөж б айгаа сайхан зүйлүүдээ бүтнэ гэж найдаж байна уу? гэж дэмжин талархан байдалтай боловч , үл мэдэг шоолох маягтай Цезарь хэлээд- сайныг мөрөөдөгч хөөрхий хүн минь ! гэлээ .

Цезарв түр зуур дуугүй болсноо цааш нь ярьж:

- Спартакаа , чиний хэлснийг сонсож би чамд итгэлээ. Одоо чи миний хэлэх сэтгэлийн үгийг соносож , сайтар жигнэн үз. Цезарв бол сэтгэлийнхээ үгийг хүнд ховор хэлдгийн дээр хүнийг хүндэтгэх нв бүр ч ховор хүн шүү. миний хэлэх үг бол бат бөгөөд хүчтэй гэж мэдээрэй.

Чиний санаачласан хэрэг чинь огт бүтэхгүй хэрэг байна. Чиний зорьсон зорилго чамд байгаа хөрөнгө хоёрыг харьцуулж үзсэн ч тэр чиний санаж зорьж байгаа хэрэг чинь огт бүтэхгүй хэрэг бөгөөд хий хүсэл байна. Чиний хорин мЯнган гладиатор , Ромыг айлган донсолгож чадах байх гэдэгт чи өөрөөч найдахгүй бай гаа бизээ . Чиний найдах гану найдвар бол “эрх чөлөө” гэдэг үгээр чиний тугийн доор цугларсан үй олон боолчууд ч байна. Чиний боолчуудын тоо зуун тавин мянгап яагаад ч хүрэхгүй л дээ . За яахав тэр тоонд хүрдэг ч юм гэж бодъё төмөр мэт сахилгатай болж эрэлхэг зоригоор зоригжож ,

хамгийн сайнаар тулалдах юм ч гэж бодъё . тэгээд яах юм бэ? тэгээд тэд нар чинь Ази Афна байх гэж чи арай санаагүй биз? гар хоосон боолчуд та,
нар хувийн өмчтөн болох иргэдийн өмнөөс тэдний өмч зоорийг бус ниулахаар тулах болно. Тэд нар нь өмч зөөрөө хамгаалан галзуу мэт тулалдах боно. Та нар гомдлоо барахын тул тулалдахад нөгөөдүүл чинь өөрийгөө хамгаалах төрөлх авъяасаараа ту лалдана. Та нар эрх чөлөөний төлөө тулалдана, нөгөөдүүл чинь өмчөө хамгаалахын тулд тулалдана. Нөгөөдүүл
чинь тооны талаар та нараас давуугийн дээр, хот бүхэнд , орон нутгийн хэсэг бүхэнд өөрсдийнхөө хамсаатныг олж байх болно. харин та нарыг бол очсон газар бүхэнд чинь дайсан гэж үзэх болно. Нөгөөдүүлийн чинь гарт улсын сангийн баялаг , түүний дээр патрицуудын хөрөнгө баялаг байх болон. Бас тэдний хамт ромын алдар хүнд , цэргийн туршлагатай удирдагчийн арга ухаан, хот нэг бүр, иргэн бүрийн сонирхол , бүгд найрамдах улсын тоо томшгүй олон хөлөг онгоц , орон бүхний дэмжих цэргүүд , эд бүхэн байх болно. Чиний эрэлхэг чадал, хатуу зориг , агуу их ухаан энэ бүхэн чинь янз бүрийн оронлд төрсөн зэрлэг бүдүүлэг зөрүү гүжирмэг хүмүүсийнхээ дунд, журам тогтоон сахилагажуулахад л зөвлөнө. Хатуу зоригтой , саруул ухаантайгийнхаа хувиар бол чи
цэргийг удирдан командлах чадвартай хүн байна гэдгийг би мэдэж байна гэлээ гэхэд дайсныг ялах хэрэгт чиний цэргийн тоо гүйцэхгүй . Биен дээрх шархаа дараа олж үздэгтэй адил түүний чи дараа нь олж мэдэх болно. Гайхалтай сайхан арга ухаан , гавъяа бүтээлийг байгуулдаг юм ч гэсэн чи ялалтанд хүрч чадна уу? гэхэд нь
Спартак , агуу их хүний хайхрамжгүй байдлаар ,

- Яахав дээ! Ариун хэргийн төлөө амиа л өгнө биз, бидний асгаруулсан цус эрх чөлөөний талыг бордож , дарлагчдын духан дээр шившигт шинэ тамгаа үлдээж , өшөө авагч үй олныг трөрүүлж гаргана бизээ . Энэ бүгд бол хойчийг залгамжлагчиддаа бидний үлдээж өгч үлгэ р дууриал болгох хамгийн сайн зүйл маань тэрээ! Гэлээ .
- Энэ бол агуу хэрэгт сайн дураараа амиа зориулсан хэрэг. Гэхдээ үр үл дэцгүй , ашиггүй л үхэл дээ! Чиний гарт байгаа нөхцөл чинь санасандаа хүрэх бололцоог чамд олгож

чадахгүй гэдгийг би чамд хэлж өглөө . Одоо чамд нотолж өгөх зүйл бол оргилон ундарсан хий сэтгэлийн чинь дүнд холоос зайлд аг хариугүй бариад авлаа
гэтэл харсаар байтал алга болдог хүний нүдэнд үл үзэгдэх хий бодит зүйл юм . Хүн төрлөхтний ой модны орхиж , нийгмээр оршин суух болсон тэр цагаас хойш , эрх чөлөө алга болж , боолчлол гарч ирсэн юм . Ард түмний эрхэн дээр үндэслэсэн манай Ромын бүгд найрамдах улсад боловч , улсын бүх эрх чадал тэдний гарт орж тэд нар үе угсаа залгамжлан улсын эрх чадал тэдний гарт орж , тэд нар үе угсаа залгамжлан улсын эрхийг барьж байна. идэх талхгүй , орох оронгүй , өвлийн хүйтэнд боловч өмсөх хувцасгүй , Ромын дөрвөн сая иргэдийг өрх чөлөөтэй хүмүүс гэж болохгүй би зээ . “Ертөнцийг захирагч” тэр гуйлагчдын ганц баялаг буюу үлдэх ганц хөрөнгө нь бол хөлсөөр саналаа худалдах явдал мөн: тэд
нар бол тэдний саналыг худалдан авах хүн бүхний боол мөн. Иймийн учир “эрх чөлөө” гэдэг үг бол утга чанараа алдсан үг юм энэ
бол ард түмний сэтгэлд ямагт хангинаж байдаг хөгжмийн эгшиг м өн, түүнийг дуугаргаж чадвал гагцхүү ,
хүчээр харгислах явдалд тусалдаг юм .

- Спартакаа , чий өөрөө үзэж байгаа бизээ, би бол үлэмж ихэмсэг зантай патриц хүн юм , би бол ядуу хоосон плебейчүүдийн зовлонт байдлыг ойлгон мэддэг бөгөөд тэднийг өрөвддөг юм . гэвч, патрицуудын сөнөхөөс нааш плебейчүүдийн хэрэг
сайжирч ёчадахгүй Олигархуудын хэргийг устгахыг тжл,
ард түмний хүслийг анхааран үзэх хэрэгтэй юм гэхдээ тэднийг ямагт гартаа барьж , төмөр мэт хатуу сэтгэлийн агуу их хүчээ тэднийг жолоодох хэрэгтэй юм гэж би үзэж байна. хзн нь хүндээ чоно болжээ . нэгэнт хүн төрлөхтөн нь хонь ба чоно , элээ ба тагтаа , идэн залгигч ба залгигдагч болон хуваагдах зурагтай байсан учир , би хойшид яах тухай шийдэж зорилгоо тавьсан .
Би засгийн эрхийг шүүрэн авч, дарлагчид ба дарлагдагчид хоёрын байрыг сольж дарлагдагчдыг дарлагч болгон ,
дарлагчийг дарлагдагч болгон хцвиргах гэж тогтсон юм гэлээ .
- Тэгвэл Цезарв чи, зарим төлөөр надтай адил санаатай юмаа гэж Спартакийн асуухад:

- Тиймээ ,
  би гладиаторуудын зовлонт байдлыг ойлгож боолчуудыг өрөвдөж байдаг бөгөөд тэднийг би хэзээд сайн сэтгэлээр үзэж байдаг юм . Олон түмэн зориулан , ямар нэгэн юм үзүүлэх үедээ тэдний зэрлэг хүслийг хангахыг тул гладиаторуудын зэрлэгээр алалцуулах явдлыг би , хүчирхийлэлээс Илүүгээр уран чадварыг хэрэглэж , хүч чадлаас илүүгээр эв урыг хэрэглэхийн дээр аюултай замд заав ал хэрэгтэй болох зорилого болгоомж хоёрыг заавал санаж явах болно. маш өндөрт хүрэх заяатай хүн гэдгээ би өөрөө мэдэж байна. Би түүндээ хүрэхийг хүсэж байна , хүрч чадна. Зам зуураа дайралдсан бүх гол горхийг нийлүүлэн авч , аврага урсгалаараа далайд шуугин цутгадаг мөрөн шиг замдаа дайралдсан элдэв хүчнийг өөртөө татаж авах чадал надад ашигтай болох учир , би чамд хандаж байгаа юм . Спартак аа, болж бүтэхгүй бослогынхоо тухай санааг орхиж , чи Цезарийн туслагч ,
  түүнтэй хамт замнагч болохгүй юу? Миний элэнц эмэг болох – Венера миний одон болж , амьдралын нарийн зөрийг замаар намайг дагуулан явж их каянд хүргэх ерөөлтэй м . хэзээ нэгэн цагт би ямар нэгэн муж захирах эрхийг гартаа авна, цэргийн удирдагч болно, тэгээд
  би ялалт байгуулан триумфийг авна би консул болж, хаан ширээг түлхэн унагааж , ард түмнийг байлдан дагуулж , төрийн эрхийг гартаа авна .. гээд Цезэрийн сэтгэл их хөдөлжэ нүд нь гялалзкан хоолой нь давхцаж бат итгэлээр нэьвтэрхий бөгөөд чанга дуугаар өгүүлж байхы нь Спартак , харж хоромхон зуур гайхаж байлаа .
- Цезарийн ярьж гүйцэхэд түүний сайхан
  үгийн нөлөөнд байснаа Сыпартак дуугарч:
- Тэгээд дараа нь ? гэж ширүүн байдалтай , өндөр дуугаар асуулаа .

Цезкарийн нүд цахилгаан шиг гяласхийж , сэтгэл хөдөлсөнөөс болж чичирсэн дуугаар шийдьэртэй хариулж :

- Тэгээд ертөнцийг ноёрхоно гэлээ .

Энэ ярианы параа нэгэн хэсэг хоёул дуугүй ыайуээ .

- тэр хэргээ чи орхи л доо, тэр чинь эхэлсэн дороо л сөнөх ёстой юм . тэр бүхний тухай одоохон консулуудад хов хүрнэ. Өөрсдийнхөө эрхийг гартаа зэвсэг барихгүй , харин хууль ёсны үзэмээр орж авахын тул бүх зүйлийг тэвч гэж өөрийнхөө нэгэн адил дорой заяатай нөхдөө сэнхрүүл . Чи миний анд бол тэгээд миний хамт дайнд морд , зоригтой цэргүүдээ би чамаар командлуулъя , тэгээд

чи
багалиас чамд заяасан ер бусын авъяас чадвараа гялалзтал үзүүлжт чадах болно гэж бүр тайвширсан Цезарь , Спартакийг ятгалаа .
тэгэх ямар ч бололцоо алга ! Ямарёч бололцоо алга! Намайг ингэж өндөр үнэлэн бас сайн сэтгэлээр зөвлөгөө өгсөн Кай Юлий чамд сэтгэлийнхээ угаас баярлалаа. Гэвч би хувь заяаныхаа эрхээр заасан замаар явах ёстой адилхан боол нөхдөө би орхих ёсгүй , орхихыг ч хүсэхгүй байна. хэрэв хүмүүсийн хувь Олимпд тэнгэр шийтгэж байдаг юм ол газар дээр алга болсон шудрага байдаг юм бол газар дээр алга болсон шудрага ёс тэнгэр дээр хэвээр байдаг бол манай хэрэг мөхөхгүй . Хэрэв миний өмнөөс хүмүүс тэнгэр хоёр хамтран эсрэг хандвал би
бууж өгөлгүй байсаар Аяксын нэгэн адил зоригтой бөгөөд түвшнээр амиа өгч чадна гэж Спартак хариуллаа .
Цезарв , Спартакийг дотроо дахин магтан гайхаж байснаа түүнийг гарыг чанга атгаж :
- Тэгвэл чи дураараа бол! Хэрэв чиний аймшигггүй зориг ийм байгаа бол би чамд их аз заяа , зөн билэг ерөөе. Аймшиггүй зориг нь аюулаас хамгаалан зайлуулж чаддагийг би мэднэ. Бүх үйл хэрэгт их тус хүргэдэг , хүний хувь заяа бол цэрэг дайны хэрэг үйлс дээр царайгаа хурдан ббрчилдөг шүү. Чиний ажил хэрэг амжилт , ялалтад хүрэхэд маш ойртсон байна. одоо чи Капуя руу яаравчлан оч: та нарын яриаг чагнаж мэдсэн хүн , консулуудад очиж та нарын хуйвалдааныг илрүүлэх явдалд би саад хийж чадахгүй бөгөөд хий ч ёсгүй . хэрэв хувь заяа чиний талд байгаа бол сенатын элчээс урьтаж , капуя очихыг бод… за баяртай гэлээ .
- Кай Юлий чамайг тэнгэр өршөөж байх болтугай … баяртай:
Цезарь , Спартак хоёр дахин гар барилцан хүнгүй болсоэ гудамжаар дуугүй алхлан Либитин ий Венерийн гуанз руу чигэлжээ .
Цезарь идсэн хоолынхоо үнийг төлөөд , боолоо дагуулж гэртээ харилаа .
Спартак нөхдөө цуглуулж тус бүрд нь
хамгийн яаралтай зүйлүүдийг тушаан даалгажээ .
ром хотын глаиаторуудын дотор ямар
нэгэн хуйвалдаан байсны ор тэмдгийг бүрмөсөн устгах даалгаварыг К рикст өгчээ
. Равеннад граник дээр довтлон очихыг Артроикст даалгаад , өөрөө эномагийн хамт хоёр сайн морь эмээллэж ,

бас замдаа морьдын сэлбэг аюах бололцоотой байхын тулд дарлагдагсдыг холбооны кассаас таван талант мөнгө авч Капуягийн хаалгаар гарч Капуяг чиглэн морины хурдаар давхижээ .

Фалерныхаа дарсанд дахин халж , эх орондоо улам их хайртай болсон Метробий , Цезарийн удсанд сэтгэл гь зовж Бүгд Найрамдах Улсаа аврахаар өөрийн нь хэлэх ёсоор бол шув шулуухан Цезарийн хаалагчийн баталснаар бол дугуйлдан өнгөрсөөр консулынд очихоор явсны нь Цезарь гэртээ ирж мэдлээ .

Цезарь их л бодолхийлэн удаан зогссоныхоо дараа:

- Сенатын элч гладиатор хоёр уралдах болжээ . Чухам аль нь түрүүлэхийг хэн яаж мэдэх ажээ? Гэж хэлээд бас бага зэрэг дуугүй байснаа нэмж:
- Хамгийн чухал явдал , хамгийн өёүүхэн зүйлээс нөлөөлөх нь яасан олонтой тохиолдоно вэ! … энэ нэгэн удаад бол гагцхүү морины л чадал мэдэх хэрэг дээ гэлээ .

## БОСЛОГО

Капуя нь бүх Италийн хэмжээнд хамгийн сайхан , хамгийн үржил шимтэй , хамгийн их цэцэглэсэн муж болох Кампаньягийн баян тансаг бөгөөд хөгжилтэй нийслэл нь юм . Энэ үед нийслэл нь Ганнибаллаас ромыг довмлох үе хүртэл маш хүчирхэг сайхан хот байсан бөгөөд Карфаген ба Ромтой мөр зэрэгцэн оролцож байсан аж. Гэвч одоо тэр хүчирхэг чадалнь нь нэлээд буурсан байжээ .

Требий ба тразиманы нууруудын дэргэд ганнибал Ромынхоо ялж , бас Каннын дэргэд тэднийг бүр мөсөн бут нирэгсэний дараа энэ капуя хот дайсны талд шилжин очсон юм . тэгэхэд дайснууд энэ сайхан хотыг авч дараачийнхаа дайны бэлтгэл бааз газар болгосон юм .

Гэвч тун удалгүй ганнибал цохигдсон юм . ганнибалын цлхигдохыг сацуу Капуя хотын наран шингэжээ . ромынхоо , тэр хотын хүмүүсийн заримы нь хядаж , зариммы нь хөөн зайлуулж мөн заримыг нь боол
болгон худалдаж оронд нь ромд үнэнч хэвээр үлдсэн орчин тойрны нутгуудийн хүмүүс ба тариачдыг энд колоничлогчид болгоэ с уулгасан юм .

Тэр үеэс хойш зуун гучин найман жил өнгөрчээ . Суллын аврага хүчдэл ба
мөн түүнээс капуягийн орчин тойронд суулгасан колоничлогёид цэрг ийн хороодын ачаар энэ хот

зарим нэгэн талаар урьдынхаа үзэсгэлэнь сайхан дүрээ сэргээж чадсан юм . зуун мянган хүн амтай бөгөөд маш бат бөх хэрмээр хүрээлэгдсэн гоё сайхан гудамжтай , гайхамшигт дуган сүм , баян тансаг базилик асар том портик орд харш, олон сайхан байшин , амфитеатруудтай энэ Капуя хот нь гадаад үзэмжийнхээ хувьд ромтой мөр зэрэгцэн тэмцэлдэж байснаар ч барахгүй түүнээс ч давж байсан юм . Капуягийн тэнгэр ямагт цэлмэг бөгөөд цэвцэнхэр гайхалтай зөөлхөн уур амьсгал нь хотыг улам ч сайхан болгоно. Энэ талаас нь үзвэл , үүрлийн мөнх ромул хотын оршиж бадаг долоонг толгодын ч уур амьсгал ийм сайхан байдаггүй байжээ .

680 оны хоёрдугаар сарын 20 –ны өдөр оройн наран, өнгө булаалдан тэмцуэлдэж байсан цагаа, ягаан, улаан үүлсийн цаанаас алтан цацралаа тараасаар намуухан тонгойж толгодын цаагуур жаргаж байх үед Капуя хотын хүмүүс ердийн байлдаар үдшийг угтаж ажлаа дүүргэж , зах дэлгүүрүүд хаагдаж байлаа .

Өргөн сайхан Албанийн гудамжаар явж байсан иргэд Аппиевийн замын зүгээс морины хурдаар ирж явсан аравны даргаар толгойлуулсан арван морьтой хүнийг харж гайхан зогсчээ . Эд хүмүүсийн унасан морь шавао шороонд булагдаж ам хамраас нь уур савсаж хазаарын нь амгайгаар хөө чийхэрч хурсан байжээ . Энэ бүхний нь ажвал эдгээр хүмүүс их л яарч сандран ямар нэгэн давчуу яваа бололтой.-

- Тифатины Юпитерийн пайзын нэрлэн ам алдъя! Ингэж их яарч довтлон давхиж яваа хүмүүсийг би одоогоос олон жилийн өмнө Суллаас Марийн талын консул Норбанийг энд Тифанийг Дианы сүмийн орчим ялсан тухай мэдээш хүргэж ирэх үед анх үзсэн билээ гэж нэгэн иргэн, явсан хүндээ хэлжээ .

- Эд нар, Ромоос ирсэн бололтой гэж төмрийн дархан нэгэн хүн, дархчуулийн зүүдэг арьсан хормойвчоо авах зуураа өгүүлжээ .
- Ямар нэгэн шинэ мэдээ хүргэж ирсэн байлгүй?
- Эс бол бидний төлөвлөгөө илэрчив үү? Гэж царай нь жигтэйхэн цайрсан нэгэн залуу гладиатор нөхөртөө шивэгнэн өгүүлжээ .

Морьтой хүмүүс, Ромын нэрийн өмнөөс энэ хотыг захирах, хотын дарга меций Либеоний байшингийн дэргэд хүрч зогслоо. Арванй дарга мориноосоо буун харайж , хотын даргын байшингийн саравчинд орж, шалав намайг хотын дарга д саадгүй оруулж аль ,

Ромын сенатаас явуулсан маш чухад захидлыг би түүнд оруулж өгөх ёстой гэж шаардлаа .
Ингэж байх зуур , юманд дуртай хүмүүс ба морьдыг өрөвдөн нөгөө зарим нь энэ отрядын давхиж ирсэн учир шалтгааны тухай хов таавар үг я рьцгаана , мөн зарим нь ирсэн цэргийн хүмүүстэй ярилцахыг оролдож байжээ .
Капуя хотын, сул дэмий явцгааж байсан энэ хүмүүс, хэргийн учрыг мэдэж авах гэсэн бүх оролдолгоо таавао нь ямар ч амжилт олсонгүй .
Ирсэн цэргийн хүмүүсээс шалж байж сонссон ганц хоёр үгнээс энэ цэргйн хүмүүс ромоос иржээ гэдгйг л дөнгөж мэджээ . Улсын сонирхол улам хүчтэй босон боловч энэ хүмүүсийн ирсэн шалтгааныш тайлж мэдсэн хүн огт үгүй байлаа . Энэ үед хотыэ даргын б айрнаас хэд хэдэн боол , ихл яаралтай гарцгаан тал бүр тийш гүйжээ . үүнийг харж:

- Уухай ! их л чухад явдал болсон юм байх нь ээ гэж капуя хотын нэгэн хүн хэлжээ .
- Юу болж байгааг мэдэхийн тул би хамгийн сайн ооноосоо арван савыг дуртайяа өгөхсөн билээ! гжэ оо энгэсэг худалдаалдаг улаан царайтай , бүдүүн тарган нэгэн наймаач , бас хажуунаас нь дуугарчээ .
- Тэнгэрийн өн билэг болсон иридийн жигүүрийг нэрлэн ам алдъя ! тэр хэн гарч ирэх нв энэ үү?
- Хаана, хаана?
- Яагаав тэр Албанийн гудамжны булан дээр …
- Дээд тэнгэо бидэнд туёлах болтугай !

Хотыэн даргын байшинд цэргийн триубунын орж байх үед, өмссөн хувцас зүүсэн зэвсгий нь харвал гладиаторууд бодолтой , асар том биетэй , мөн тоос шавхайд дарагдсан хоёр явган хүн , зэргэлдээ толгойгоос капуя руу ус дамжуулах хоолойг дагасаар ихл бахардан амсьгал давхцан явж б айжээ.
Энэ хочр нь Спартак , Эномай хоёр байжээ . Энэ хоёр нь хоёрдугар сарын 15 ба 16 –ны завсрын шөнө ром хотооё гарч өртөөний буудал бүрд морь сольж моринйы хурдаар довтлон явсан байжээ . Бослого гарах гэж байгаа тухай мэдээг капуя хотын даргад хүргэхээр бас довтолсон арван морин цэргийн дагуултай аравны дарга , удалгүй энэ хоёрыг замд гүйцэж урд нь орсон байжээ . иймийн учир, мань хоёчр гладиатор морь сольж унах

бололцоогүй болсноор ч үл барам, бас үе үе Аппиевийн замыг орхиж хажуугийн замаар ч явахад тулгарч байжээ.
Хэдий тийм боловч энэ хоёр замаасаа морь худалдан ая унаатай болоод цаашаа ердийн замаар давхижээ. заримдаа төөрсөөр, мөн заримдаа зайдуу замаар даюхиж,
цаг хожсоор Ателлаас капуя орох замд нийлж чадсан юм.
Энэ хоёр, сенатйын элч араас явсан юм. Гэтэл капуяд долоон мильойртож явтал Спартакийн морь багтран унажээ. Ингэж унаж явсан морьо гэнэт ойчиход Спартак газар тулж мориндоо дэмжлэг үзүүлэх гээд зүүн гараа булгалжээ.
Ингэхэд
Спартакийн гарын өвчнийг түүний сэтгэд өвдөхтэй зүйрлүүлбэл юу ч биш байжээ. Учир нь Спартак, дайснаас хагас цагаас урьтаж лентул Батианы гладиаторуупын сургууль дэр очих
гэж найдаж явсан юм гэиэл ингэж гэнэт санамсаргүй тохиолдол азгүй хэрэг, түүний бүх найдварыг тасалжээ. Одоо Спартак дайснаасаа хождон таван жил тасралтгүй хүчдэн
ажиллаж бүтээсэн хэрэг ажлаа бүр мөсөн бут цохигдож байх үед тэнд сая хүрч, энэ бүгдийг нүдээо үзэх явдал тулгарчээ.
Спартак хөл дэээ босон харайж, амин газраа шархалсан арслангийн архирахтай адил дуугаар амьсгалан:
- Ээ дээ бас, Эребийг дуудан ам алдъя! … дүүрчээ! … гэж найдвар тасарсан дуугаар гаслан өгүүлжээ.

Спартакт, ямар нэгэн аймшигтай юм болоогүй гэдгийг магадлахыг хүссэн юм шиг Эномай түүнийг барилан үзсэнээ:
- Чи юу гэнэ вэ?… бидний гар гинжлэгдээгүй, бид гартаа юлдээ барьсаар байга цагт дүүрлээ гэдэг чинь юу гэсэн үг вэ? гэлээ.

Спартак хэсэгхэн зуур болодхийлэн зогссоноо. Эномайгийн морь руу харж:
- Долоон миль … одоо бидэнд долоохон миль газар явах хэрэгтэй байна, биднийг дайсагнагч бүх тэнгэо буруулах болтугай! Гэтэл бид цагтаа хүрэх биүх найдвараа орхих ёстой
болно гэдэг бас хэцүү яа… хэрэв чиний морь бид хоёрыг гурав дөрвөн миль тээж чадвал цаашиих газрыг бид явган явж маш хурдан очихсон билээ. тэгвэл бид дайснаасаа цаг хонжиж чадах болжээ. Бидний төлөвлөгөөг нураах бэлтгэлээ хийхийн тул элч нарын очсоноос хойш тэдэнд бас нэг цаг хэрэгтэй болно шүү дээ гэхэд нь:

- Чиний бодол ч зөв л байна даа . Гэвч, хөөрхий энэ муу морь бид хоёрыг сундлуулан бас миль ч явж чадна гэж үү дээ?… гэв.
- Ингээд хоёулаа үлдсэн мориой шалгаж үзтэл тэр нь ямар ч ашиггүй болсон байжээ . Хөөрхий тэр амьтан бүх биенээс уур савсаж , хөх мах нь таталдан чичирч байла . Энэ морь , бас л түрүүнитй морины нэгэн адл болох н гарцаагүй тулсан байна. иймийн уёчир хоёулаа хоорондоо шалав зөвлөснийхөө дараа, морьдоо орхи од Капуягийн зүг явган явж яаравчлан очихоор шийджээ .
- Хэд хоног хоол ундгүй явж , эцсэн энэ хоёр хүн гайхалтай хурдан алхалсаар , хагасхан цаг хүэрхгүй хцгацааны дотор хотын хэрмийн хаалгын дэргэд хүрсэн байжээ . хаалганы манаачид орсон гарсан хүмүүсийг ажиглан сэжигтнийг баривчлах тушаал өгсөн байж болзошгүй гэж элдэв сээжиг төрүүлэхээс болгоомжлон , амьсгаа дарж , биеэ тайвшруулахаар , мань хоёр , хотын хаалганы наахан түр зур зогсож , амсхийжээ .
- Удалгүй хоёулаа цаашаа замналаа сэтгэл маш их зовж байсан өгүүлшгүй аюул заналыгн уршгаар энэ хоёрын зүрх галзуу хүчтэй цохилж , бүх бие нь чичрэн мөн нүүрнээс нь хүйтэн хөлё дусалж байгааг мэдэж явжээ .
- Ямарч сүрхий , ямар ч аймшигтй аюул занадын өмнө хэзээ ч чичирч үзээгүй Спартак зүрх хүртэл хотын хаалганы дэргэд очих үед учиргүй чанга цохилсонд зүрх минь хагарчихгүй байгаа гэж өөрт нв санагдлаа .
- Энэ хоёрыг , хотын хаалганы дэрэд очиход , хаалганы манаачдын хоёр нь модон бандан дээр хэцийлдэн унтаж , гурав нь ясан тоглоомоор тоглож их л завгнүй ,бас хоёр нь хажуугаараа өнгөрөгсөд буюу хаалгаар орж гарагсдыг харж шоололдон , хоорондоо ярилцаж байжээ .
- Энэ ярилцаж байсан хоёр цэргийн хүний нэг нь бургасаар сүлжиж хийсэн жижигхэн саван дотор хэдэн жижиг зөөлөн бяслаг хийж явсан нэгэн ядуу тариачин эмгэнийг харж, шоолох янзтай:
- Хөгшин элбэч эм чи, яасан эрт зах орж явах юм ! … гэлээ
- Тэнгэр та нарыг өршөөг! гэж номхон байдлаар эмгэн хариулаад ясан чигтээ цаашилж одлоо.
- Цаадха хараач гурван парокийн хамгийн ахмад хамгийн муухай Атропостой адилгүй байна гэж үү? Цаадхын чинь нүүр галд

халж үрчийсэн цаастай адилгүй байна гэж үү? … гэж хоёрцэргийн хүний нөгөөх нь тэр эмгэнийг бас шоолж байлаа .

- Шинэхэн шахсан бяслаг дээрээ хорин сестерцийн нэмэр өгсөн ч би түүний бяслагийг амандаа хийхгүй ! нэлээ .
- Энэ үед Спартак , Эномай хоёр з?үрх ихэд цохилсон , мөн их л уруу царайлж , нам нуруутай болж үзэгдэхийг оролдсоор хотын хаалга руу орлоо.
- За тэр, паркийн хүндэт харуул ч ёстой мөндөө гэж цэргийн хоёрын нэг нь мань хоёрыг харж хэллээ .
- Юпитер , Статорыг дуудан ам алдъя . Энэ хоёр тоос шороо болсон туранхай эцэнхий тэнэмэл гладиаторууд чинь ёстой л Стиксээс гарч ирсэн юм шиг байна ! гэж нөгөөдөх нь хэлжээ.
- Спартак , Эномай хоёр дуугүй номхон байдлаар цааш явсаар, тусгай гинжээр дээрээс тор буулгаж хаадаг хотын халганы нэгдүгэ эр дааманг өнгөрөөд, бас шорон далан ба харуулын байр руу очих шат байдаг хүзүүвчийг өнгөрөөд , хот руу орох жинхэнэ хаалга болох хоёрдугаар хаалга руу орох гэж явтал нь тэдний урдаас хуяг дуулга юлд жад бас морин жад гэх
  зэрэг бүрэн зэвсэгтэй гучин цэргийн дагуултай зуутын дарга гарч ирлээ . Зуутын дарга энэ хүн , өөрийнхөө зуутын тугийг гартаа барьж явжээ . хотын хаалганы даамын дор орж ирээд , цэргийн дарга бүхний хашгардагтай нэгэн адил хашгирч.
- Звэгсгээ бэлдээд ! гэж командлаад

Энэ дууг сонсмогц , хаалганы манааы цэргүүд санаснаас хурдан цэргийн хүний ёсоор бай лдааны цронт болон жагслаа .

Зуутын даргын дохиогоор баривчлагдсан Спартак, Эномай хоёрын найдвар тасарч зүрх нь өвдө хэдэн алхам ухраад бие бие тийшээ харцгаалаа . юлдээ шүүрэн барьж авсан герман хүний баруун гарыг Спартак амжин барьж авч зогсоолоо.

- Үл бүтэх муу сайн амьтад та нар харуул манааны албыг ингэж хаадаг юм уу , залхуу амьтад та нар ингэж манадагуу ? гэж зуутын даргын ширүүн асуусанд , хаалгуудын завсрын хүзүшүвчинд чив чимээгүй болжээ .

Дараа нв отрядынхаа зүүн гар талд нь сэтгэд зовнин зогсож б айсан харуулын дарга тийш харж чи ливий , үүргээ тун муу биелүүлж цэргйн сахилга батыг хайрахгүй байна харуулын дарга тушаалаас би чамайг халж байна, одоо чи отрядын шинэ дарга

Луций Мединийгийн мэдлийн дор оч, энэ хаалганы манаанд хүч нэмэх зорилгоор түүнийг би өөрөө авчирсан юм гээд: бас нэиж , гладиаторууд бослого гаргах гэж баына , сенатын элч нарын баталснаар үзвэл их ноцтой хэрэг болж болзошгүй байна. иймийн учир, хаалганыхаа торыг буулгаж хаалгаа хааж, дайны үед их болгоомжтоы байж ман харуулаа таруу байлгах хэрэгтэй байна гэв.

Харуулын шинэ даргаас хорин дөрвөн цэргээ , хоёр эгнээ болгон жагсааж байх үед нь зуутын дарга Спартак ба Эномай хоёрын зүг хөмсөг зангидан харж,

- Та нар гладиаторууд уу? гэж асуулаа
- Тийм ээ бид гладиаторууд гэж Спартак арай ядан , сандарсан царайгаа булж, зоримог дуугаар хариулжээ .
- Тэгвэл та нар лентулын сургуулийн үладиаторууд байлгүй дээ ? гэхэд нь,
- Гарамгай Подпилий чи андуурчээ бид префект Мeций Либеоныд албан хаадаг улсаа гэж Спартак хариул ж хэллээ .
- Чи намайг таньж байна уу? гэж зуутын дарга асуухад ..
- Би чамайг манай ноёны өрөөнд олонт харсан билээ гэж хариуллаа .

Оройн бүрий эхэлж байсан учир зуутын дарга … энэ хочр гладиаторын асар том биеийг харахаас биш царай нь сайн танигдахгүй байсан учир, тэр нь энэ хоёрыг баахан харж б айснаа

- Нээрэн ч үзсэн юм шиг … байна гэлээ .
- Бид хоёр бол хоёулаа гермэн хүн мeцийн хатан , сайн язгуурт Лидия Домицияд тусгалан томилогдсон очсон юм . тэгээд бид түүний жуузыг ямагь даган явдаг билээ гэжээ .
- Спартак Капуя хотод дөрвөн жил байх зуураа , энэ хотын патрицуудын гэр бүлд хамаарагдсан хэд хэдэн үладиаторыг дарлагдагсдын холбоонд элсүүлж авсан юм иймийн учир Меций Либеоны өмчийн асар том биетэй хоёр герман гладиаторуудыг сайн мэддэг байсан ажээ . ингэж харанхуйгаар далимдуулан энэ заль хэрэглэсэн нь мань хоёрт аврагдах замы нь нээж өгчээ .
- Чи үнэн ярьж байнаа зөв… та нарыг би одоо танилаа… гэж зуутын дарга зөвшөөрчээ. тэгэхэд нь
- Чи бод л доо , бид хоёр Домиция хатнаа дамнан , трибун Тит Сертилианын гадаа хүргэж явахдаа шөнө дундын үед түүний байшингийн нь хаалган дэр чамайг харснаа хүртэл би санаж б айна. Манай хатантны ингэж харанхуй шөнөөр нуун залрах

нь даанч олон л доо… гэж гэмгүй царай гарган Спартакийн ярьж байтал…

- Зэрлэгчүүдийн тэнгэр болох бузар кимврийнхээ төлөө чи дуугүй болооч! Гэж зуутын дарга зандарлаа . Цэргийн хүмүүсийн дэргэд Префектийг хатны хардалтай яьдлыг тухай иим янзаар ярих нв зуутын даргын санаанд огтхон ч тохирсонгүй ажээ .
- Хоёр гладиатор сэтгэл тайвшран , аргагүй л санаа алдаж түр зуур болтол :
- Та нар одоо хаанаас явж багаа юм ? гэж зуутын дарга асуулаа .
- Спартак түр зуур бодсоноо.
- Үнэтэй сав суулга ачсан тээврийг манай эзний кумын байранд хүргэлцэу өгөөд буцаж, явна гэж огт ажиггүй хариулла .

Зуутын дарга минут хиртэй дуугүй байснаа:

- Та нар лентул Батиатын сургууль дээр сэдэвлэгдсэн энэ бослогыг тухай юу ч мэдээгүй юу? гэж гладиаторуудаас асуулаа . тэгэхд Спартак, өөрт нь ойлгогдохгүй юм ярихад дургүйцэж байгаа юу ч мэдэхгүй тайван хүний царай гарган:
- Энэ тухай бид , хаанаас олж мэдэх ажээ? Лентулын догшин сэрэглэн сурагчид ямар нэгэн тэнэг , бодлоггүй хэхрэг хийхээр шийдсэн бол бидэнд түүнээ яалааа гэж хэлэх вэ дээ: тэд нар чинь билний хувь заяанд атаарахдаг юм байхгүй юу. Бид чинь, сайн ноёныхоо дэргэд их сайхан байдаг улс байхгүй юу гэж хариулжээ .

Спартакийн үг их үнэн юм шиг ыбөгөөд маш жирийн байдалтай тул зуутын дарга үнэмшжээ .

- хэдийгээр би гладиатор ын бослогод бүх арга хэмжээг өөрийн бүх бололцоогоор хийх явдал бол миний үүрэг мөн. иймийн учир би тар нарт юлдээ хураалга гэж тушааж байна , ямар чгэсэн та нар гладиаторууд , муухай хүмүүс шүү дээ .. юу ч хийж байж магадгүй улс… та нар юлдээ нааш нь аваад аль! ..: гэж зуутын дарга тушаажээ .
- Түргэн зантай болгоомж муутай Эномай , энэ тушаалыг сонсмогц , Спартакийн бүх оролдлогыг хэрэггүй болгож эргэлтгүй нураах шахжээ .

Учир нь зуутын даргын тушаалыг сонсмогц , мань эр яаран юлдээ суга татан далайтал Спартак зүүн гараараа өөрийнхөө юлдийг хуйнаа нь сугалж , бас баруун гараараа Эномайгийн юлдийн ирэн дээрээс нь барьж аваад хоёулынхаа юлдийг их л найр тавин зуутын

даргад барьж, бас Эномайг цочирдон ямар нэгэн болох болохгүй юм хэлж орхих бий гэж яаран урьтаж

- папилий , би бидэнд итгэхгүй байдаг бол сайнгүй байна. манай эзэн префект , чиний бидэнд итгээгүй чинь лав сайшаахгүй байх . Юуч л гэсэн май бидний юлдийг ав тэгээд биднийг Мецийн гэрт буцааж очихыг зөвшөөрнө үү гэлээ .
- Үзэшгүй муу гладиатор минь би хийсэн хэргийнхээ хариуцлагыг эзний чинь өмнө өөрөө хүлээнэ , одоо та хоёр эндээс арил гэжээ.

Спартак , цухалдан чичирч байсан Эномайгийн баруун гарыг атгаж , бас зуутын даргад мэхийн ёслоод , герман хүнээ дагуулж хотын хэрэм дотор оржээ .

Энэ хоёр , ер бусын хөлтөй байсан. Албаний гудамжаар цаашлах тутмаа, багагүй хүч гаргасан боловч хэтэрхий орйотож гладиаторуудын сургууль дээр очих нь тэгээд манай бүх төлөвлөгөө нурах нь гэдгйг улам бүзр мэдэрч байжээ .

Хотын хаалганаас харвасан сумын хүрэх зайтай газар холдмогцоо хоё улаа лентул Батиатйн сургуулийг чиглэн хар хурдаараа гүйжээ .

Сургуулийн орон байр нь гадна хэлбэрийн талаар бие биенээсээ бага ялгарах олон орон савнаас бүрдсэн байна. Адилхан хэрэгт зориулж барьсан энэ орон савнууд нь хашаагаао мөн адилхан дөрвөн хэсгүүдэд хуваагдсан бөгөөд эдгээрт г ладиаторууп бороогүй өдөр дасгалын хичээл хийдэг юм . Бороотой өдөр бол тэд тусгай бэлтгэсэн байруудад гимнастик ба хатгаж жадлах сургуулиа хийдэг ажээ .

Энэ орой байрны дөрөвний нэг бүрд маш урт коридор байх бөгөөд тус бүр нэг хүн арайхийж багтах маш олон жижигхэн өрөөний ам энэ коридорт зэрэгцэх ажэ . Энэ өрөө нэг бүрд нэгэн гладиатор арайхийж багтаж модны хуурай навч буюу эсхүл сүрэл дэвсэж байдаг байжээ.

Ийм байр нэг бүрд хатгах жадлах сургуулийн тасалгаанаас гадна бас гладиаторуудыг зэвсэг агулахад зориулсан бас нэг жижиг өрөө байдаг ажээ . Энэ иөмөр тоа ба бат бэх царс модон хаалгатай өрөөнд юлд хуяг, хутга, гурван салаат жад гэх зэрэг гладиаторуудыг амцфитеатрт очих үед нь сургуулийн эзнээс тэднэд олговол зохих зэвсэг хадагалагдаж байдаг юм.

Энэ сургуулийн арван найм буюу хорин байшингийн завсар нарийн зөрөг замтай бөгөөд эдгээр байшин нь урьд нэгэн цагт хотын нэгэн хэсэг нь байсан юм . Энэ

үеэс хорин найман жилийн урьд Веций буюу минуций гэдэгРомын м орин цэргийн нэгэн хүний удирдлагын дор бослого гаргах гжэ оролдсоны дараа
энэ сургуулийн бүх дэвсгэр нутгийг хэрмээр хүрээлсэн нь
Ромын сенатын тушаал тэг гэсэн хэрэг байжээ . үүний хэрэм нь ерөөс өндөр бөгөөд зарим газраараа хорин найм, мөн зарим газрараа гучин фут байжээ . иймийн учир энэ сургуулийн байр бол хотын доторхи цайз мөн ажээ .
Хоёрдугаар сарын хорины энэ орой , гладиаторууд бараг бүгдээрээ байрандаа үлдсэн нь их л сонирхолтой бөгөөд ер бус юмаа . Энэ орой гладиаторуудын зарим нь тэд нарын хэрэглэж байхыг зөвшөөрсөн ганцхан хоргүй зэвсэг болох модон юлдээ барьцгаан , хатгах жадлах сургуулийнхаа танхимуудаар довтлох ба
бие хамгаалах сургууль хийж , бусад нь харгалзагчдын үл мэдэх хэлээр учир нь мэдэгдэхгүй дуу дуулцгаан , сургуулийн байруудыг хооронд нв холбоэ байгаа зөрөг замаар хэсэг хэсгээрэ өөдөө сөөргөө холхилцгоож , бас зарим нь коридортоо шахцалдан , зарим нь хавчуу өрөөндөө орж унтахаар завдаж байжээ .
Хөөрхий энэ хүмүүс, хэвийн байдалиай , ямар нэгэн юм хүлээж хүссэн янзгүй болохыг хичнээн оролдовч тэдний нүүр царай, хөдөлгөөнийг ажиглан харсан хүн бүхэнд эд нар ямар нэгэн онцгой чухал зүйлийг хүлээж байна гэдгийг ойлгоход хялбар байжээ .

- Гладиаторууд өнөөдр гадагшаа гарч зугаацахгүй юмуу? Гэж нэгэн манаачийн асуусанд нөгөөдөх нь:
- Хэн мэдэх вэ? хэвийн байдлаас гажиж энэ оройг тэд нар байран дотроо өнгөрүүлэх гэж байгаа юм байлгүй гэж нөгөөдөх нь хэлжээ .
- Тэгвэл , гладиаторуудад сэтгэлтэй , нөгөө муу сайн эмст нь энэ орой олиггүй орой болох нь ээ- тэр эмс нь зэргэлдээ гуанз , зуушийн газруудаар наадуулаа дэмий
  хүлээж энэ оройг өнгөрүүлэх нь ээ.
- Корнелий Суллын хүчин чадлыг дурсан ам алъя энэ чинь нэг л сэжигтэй хэрэг байна!
- Ямар нэгэн бослого гарахаас чи айж байна уу?

Ёстой бослого гарна байхч гжэ би санхагүй байна л даа… яаж мэдэх вэ… гэвч ямар нэгэн үймээн я болж юу магадав… хэн мэдэх вэ? .. будлиан ч магадгүй … үнэнийг чамд хэлэхэд будлиан л болж магадгүй гэж би бодож байна , бас будлиан гаах байх ч гэж нйадаж байгаа.

- Тамын тэнгэр фуриудад тангаргалая гар минь загатнаж б айна ! хэрэв… гэээд нөгөө цэргийн нь хүн үгээ тасалж зогсоод бас чимээгүй бол гэсэн дохиог нөхөртөө өгчээ. Учир нь нөхрийн нь араас энэ сургуулийн захирал бөгөөд эзэн лентул Батиат ирж ярьсан ажээ .

Лентулын ойртож ирэхэд энэ хоёр цэргийн хүн түүнийг хүндэтгэн мэхийн ёсолж мэндэлжээ .

- Манай сургуулийн байранд бараг хүнгүй шахас болдог энэ ц агаар , яагаад өнөөдөө гладиаторууд бараг цөмөөрөө байцгааж байгаа шалтгааныг т а нарын хэн нэг нь мэдэж байна уу? гэж Лентул манааны хүмүүсээс асуулаа .

- Би мэдэхгүй гэж манааны цэргийн нэг нь аман в дотроо дуугарав.
- Чамд хэлэх байтугай бид өөрсдөө энэ тухай гайхаж байна гэж нөгөө нэг нь нуулгүй шууд хариуллаа .
- Тэгээд юу болж байгаа нь энэ вэ? Гладиаторууд ямар нэгэн юм үүсгэх гэж байгаа юм биш биз гэж Батиат хөмсөг зангидан наад хоёроосоо асуулаа .

Лентулын энэ асуултанд наад хоёрын хэн нв ч хариулсангүй байтал префектийн явуулсан нэгэн чөлөөлөгдөгч хүн ирж, гладиаторын наймаачин энэ хүнд учрыг хэлж өглөө . Саяныб ирсэн хүн нь өөрийнхөө ноёны даалгавараар зөвхөн түүний сургууль төдий ч биш харин бүх хот болон бүгд найрадах улсад тохиолдож байгаа аюул заналын тухай Лентулд хэлэх гэж ирсэн байжээ . Бас ямар нэгэн дайралтаас зэвсэг агуулахаа сайтар бэхлэн хамгаалах, мөн сургуулийнхаа бүх хаалгыг хааж бэхэлэхийг Лентулд префект зөвлөсөн байх бөгөөд бас хагас цагаас хэтрүүлэхгүй трибун Тит Сервилианыг хоёр когорт цэрэг ба бас олон хүнтэй, цагдан сэргийлэхийн отрядын хамтаар явуулна гэж хэлүүлсэн байжээ . Энэ мадааг сонсож , Лнтул Батиат гайхан сандарч үг ч хэлж чадахгүй дуугарч чадахгүй бас байрандаа ч хөдөлж чадахгүй , ухаан нь балайрсан юм шиг болж зогслоо. Хэрэв энэ хавьд байсан хүмүүс, тохиолдож байгаа аюул заналын урдаас шуурхай арга хэмжээ авахыг түүнээс шаардаж түүн ухаан оруулаагүйсэн бол инэж балайрсан байдлаараа хичнээн удаан болох байсныг хэн мэдэх билээ .

Лентул ухаан ормоцоо , гладиаторуудад мэдэгдэлгүй шалав зэвсэглэгтү гэж хоёр цэргийн хүмүс ба мөн сургуулийн ажилд тусалдаг хоёр зуун

тавин боолчуудад тушаалаа . дараагаар нв бүгдээрээ , тус сургуулийн байрыг хотын кампанийн Фортуны сүмийн хэсэгтэ й хобож байдаг хаалга руу яаравчлан очиж цаашид яах тухай тушаалыг Лентулд энд өгчээ .
Айж сандарсан Лентулын энэ арга хэсмжээгээ авч б айх зуур, хорин найман настай, бат чийрэг биетэй , аюул заналааас айдаггүй , биеэ хэтэрхий тоосон яаруу түргэн зантай, залуу Тит Сервилиан , профектийн бүх шаардлагыг хангахын тулд мэдлийнхээ дор авч яваа хоёр когорт цэргийн нэгний нь манлайд явж тус сургуудь дээр хүрч иржээ .

- Ээ , Юпитер чамайг хамгаалж , Марс чамд туслах болтугай! Морил! Гэж сэтгэл амаран бадалтай , санаа алдаж Лентулын мэндэлэхэд
- Миний ирэхийг хүртэл энд чинв юү болж б айсныш надад хэлж аль!… тэр үймэгчид чинь хаа байна ? гэлээ .
- Одоо хүртэл ямар ч үймээн хөдөлгөөн гарсангүй мөн үймээн хөдөлгөөний шинж тэмдэ г я үгүй байна гэхэд:
- Одоогоор чи юү хийв? Ямар тушаал өгөв? гэж дахин асуухад нь:

Лентул өгсөн тушаал ш шийдвэрийнхээ тухай трибун Тит Сервилианд товчхон хэлж өгөөд чиний тушуулыг би үг дуугүй даган гээд Сервилианы мэргэн ухаанд бүрэн найджээ .
Тит Сервилианн юу хийх тухайгаа түр зуур бодож байснаа, зэвсэг ба хаалгуудыг хамгаалахаар Лентулын явуулсан отряд нэг бүрд өөрийнхөө хорин цэргийг намж хоёр зуун жараад хүнтэй гол хүчнийхээ хамтаар өөрөө хамгаалж үлдэх Фортунатын хаалганаас бусад хаалгыг хаах тушаал өгчээ .
Энэ тушаад шийдвэрүүдийн биелэгдэж байх үед гладиаторуудын дотор сэтгэл зовнин үймэх явдал хүчтэй болж байлаа . Эд нар хашаан дотор маш олоноороо бөөгнөрөлдөн бөөн нэг бүр нь улам олон хүнтэй болж завсар хоорондоо чанга чанга ярилцаж байжээ .

- Цаана чинь зэвсгийн агуулахыг хааж байна!…
- Тэгвэл биднийг , илчилжээ!…
- Бүр юм маань, илэрчээ!…
- Бид үхжээ!…
- Ядаж Спартак энд байсан бол!…
- Спартак ч алга, Эномай ч алга тэднийг Ромд тэлж алсан байхаа !…
- Бид мөн азгүйяа! …
- үнэнч бус тэнгэрийг зүхье!…
- Цаана чинь хаала хааж байна !…

- Бидэнд зэвсэг байдаггүй!…
- Зэвсэг!…зэвсэг!…
- Хэн бидэнд зэвсэг өгдөг юм?…

Харааж зүхэх
гасалж бархирч байгаа арван мянган хүний дунд удалгүй тэнгэрийн дуун шиг хүчтэй болж , ширүүн шуугианыб үед далайн давалгааны шуугих чиш аймшигтай б олжээ. Харин Спартакийн томилсон легион ба когортын дарга нарын хамтын хүчин дээр гладиаторууд тайвширч , тэднийхээ тушаалбг дагаж тэр дор дорынхоо когортод очицгоожээ . Түрүүхэнд дүрэм журамгүй ярьж шуугиж байсан асар том хорин байрын дотор харанхуй болохтой чацуу нам гүм чимээ аниргүй болсон байлаа. хашаа болгонд нэгэн когорт гладиатор цугларч , сэтгэлээ догдлуулан шийдвэр хүлээж байжээ . Энэ шийдвэрий нь одоо хир, хатгах жадлах , сургуулийн нэгэнтанхимд хуралдах байсан дарга нар ирж өгөх ёстой байсан ажээ .
Энд болж байсан энэ бүх зүйл нь өдий төдий аюул бэрхшээлийг давж Спартак , Эномай хоёр Лектулын сургуулийн дэргэд хүрч ирээд , шөнийн харанхуй гэрэлд асаж байсан харагдаж байсан давирхаатай бамбарын гэрэлд гялалзан харагдаж байсан зэв жад , хуяг дуулга харж нуугдан зогсож байсан үед болж байсан ажээ .

- Энэ чинь цэргүүд үү гэж Эномай Спартакаас шивнэн асуусанд үүнийг харж зүрх нь дэлбэрэх шиг болж байсан Сбпартак
- Тийм ээ , цэргүүд байна гэлээ .
- тэгвэл , хэтэрхий оройтжээ … сургууль бүслэгджээ… одоо бид яах вэ? гэж Эномай хэлэхэд Спартак:
- Байз ! гэлээ .

Спартак , алсын өчүүхэн боловч чимээ сонсох гэж бүх хүчээ дайчлан чагнаж улам улам холдсоор далд орж байгаа бамбарын гэрлийн чиглэлийг бас ажиглан харж байлаа .
- Чимээгүй зогсож б ай гэж Спартак Эномайд хэлээд Ромын цэргийнхээ саяын явж өнгөрсөн зам тийш маш болгоомжтоы дохиж, зургаа долоон алхам явж, шивнэлдэ н ярилцах чимээ сонсож, баруун гараараа саравчлан харжээ .
ингэж хараагаа хурцатган ,% бүх хүчээ дайёлан байж гудамжны адагь явж байсан бөөн бараан юмыг олж харлаа .

тэгмэгц түрүүнийхээ байранд буцаж
ирээд Эномайгийн гар дээрээс хөтөлж энэ гудамжаар гүйжээ. Дараа нь тэр нь зүүн гар тийш эргэж шинэ замаар арван алхам хир яваад зогсож, яаралтай дуугаар шивнэн.
Тэд нар өнгөж сая сургуулийг эхлэн бүсэлж байгаа бөгөөд арай ч бүрэн бүсэлж амжаагүй байна:
одоо тэд цэргүүдээ гудамж бүхний зөрлөг билчир
дээр байрлуулж байна: бид эндхийн төвөгтэй муруй урьтаж , сургуулвд хотын хэрмийн талаас хүрнэ. Энэ хавиар хэрэм нь хуучирсан бөгөөд өндрөөрөө хорин найман фжт хүрэхгүй учир түүгээр нэвтэрч бид сургууль дээр очиж чадна гэлээ .
Гайхамшигт зоригт, цээл самбаатай ер бусын энэ эр , ингэж дорой заяатайгаа тэмцэлдэж байжээ .
Цаашид Спартакийн болсноор болж мань хоёр муруй тахир харанхуй замаар орж явсаар , сургуулийн хэрмийн дэргэд очих гэсэн тэр газраараа хүрч очлоо. Хашаа хэрэм өөд гарч чадах байх гэж огт бодмооргүй аврага том өндөр хэрэм өөд, түүний
өчүүхэн овон твон тэмтчин үзсээр, бас товойж гарсан ганц хоёр чулууны өнцөг олж дөхрөөлсөөр маш хурдан авчирч орой дээр нь гараад цаашаа бууж эхэллээ . Герман хүний хэрмийн цаад уу далд орохтой сацуу Спартаз , хэрмийн шавар хана дотроос цухуйсан нэгэн шоюгор чулуунаас бару ун гараараа барьж , энэ мэт эвгүй шатаар дамжин дээшээ дүүгээрээ дамжих гэтэл нь гар нь маш их өвдөж өөрийн эрхгүй ёолон хөөрхий тэр
ар зоогоороо газар савж ойчлоо. – Спартак аа чи яав? Гэж Эномай бөглүү дуугаар асуугаад сургуулийн хашаан дотор буужээ .

- Зүгээр … зүгээр минйи нөгөө булгарсан гар л … гэж хэлээд тулам болтлоо хавдсан гарынхаа өвдөхийг ч хайхрахгүй орхиод , сэтгэлээ чанга барьж , хэрэм өөд уулын гөрөөё шиг хурдан давхин гарлаа
- Тамын бүх могой заная! Чиний зөв л дөө ? .. бид энэ тухай огт бодсонгүй л дээ .. чи тэндээ намайг хүлээж бай! Би чамд туслахаар дахин гэдэргээ давъя гэж Энимай арай ядан дуугаа бөглүү болгож дуугарлаа .
- Ингэж хэлээд Эномай үнэхээр эргэж хэрмээ давах гэж байтал нь
- Зүгээр.. зүгээр.. битгий хөдөл… би ямар ч тусламж хэрэглэхгүй… төдхөн чам дээр буугаад очно гэж Спартакийн пахин хэлэх нь сонсогдлоо.

- Спартакийн ингэж хэлсний дараа үнэхээр түүний эрэхлэг бие нь хэрмийн орой дээр гарч ирж яваа нь үзэгдэж , бас удалгүй шатаар дамжин бууж яваа юм шиг дамжиж нэгэн чулуунаас нөгөө дээр нь нэгэн цавнаас нөгөө цавыг дамжиж гишгисээр фракий омгийн хүн хэрмийн оройгоос доошилсоор бүр газар бууж иржээ .
- Спартакийн гар нь яаж байгаа бол гэдгийг мэдэхээр Эномай түүн тийш пөхөж очлоо. Рудиарийн хаячиэн болсон царайг олж үзээд цочин зогсчээ . Түүний царай хөв хөх болж нэгэн тийш гөлрөн ширтэж байгаагий нь харвал тэр нь хүнтэй адилгүй харин ямар нэгэн хий биеийн дүрстэй адил байлаа .

Үүнийг хараад гегмэн хүн :

- Спартак! .. Спартак … гэж шивнэн дуудаад энэ зэрлэг хүн, Эномайгийн болхи бүдүүн царай нь иим болж өолох байх гэж огт сonогдмааргүй , урин өрөвдөнгүй болж- Спартак аа чи хүн тэсэшгүй их .. шаналжээ… Спартак аа .. чи муужирч унах гэж байна… энд суу гээд Спартакийг энэрэн тэвэрч гуруугаар нв хана түшүүдэн нэгэн том чулуун дээр суулгажээ .
- Сүүлийн таван хоногийн туруү зовоож ирсэн сэтгэлийн шаналгаа ба мөн гарын өвчнаас болж энэ үед Спартак , үнэхээро тэсэхгүй болж байсан ажээ . Спартакийн царай үхсэн хүний царай шиг болж, нүд нь гантиг чулуу шиг хүйтэн, бас нүүрэн дээгүүр нь хүйтэн хөлс чийхарч , цусгүй ц агаан болсон уруул нь таталдан , гаслан ёолох дуу , тас зуусан шүдэн завсар хааяа нэг тун аяархан сонсогдпож байлаа . Эномай Спартакийг дөнгөж хана налуулмагц түүний толгой нь мөрөн дээрээ санжиж, огт хөдлөхгүй боллоо .
- Спартак амь тавих шиг болжээ . ширүүн дүртэй герман эр төдхөн эмнэлгийн сувилагч болон хувилсан бөгөөд чухам ямар өвчтөн нөхөртөө тусалхааро мэдэхгүй гайхаж ширтэн харж байснаа Спартакийн зүүн гарыг хуруун дээрээс нь барьж ава ад дээш нь зөөлөн өргөж, ханцуйгий нь шамалжээ . Гар нь жигтэйхэн их хавдсан байлаа. Спартакийн гарыг шалав боох хэрэгтэй байна гэж Эномай үзээд дээлийнхээ хормойг цуулж гарлаа .
- Эвгүй хүрэх бүрдээ Спартакийн гарыг хөндөж түүнийг тэсгэлгү й өвтгөж байсан учир энэ бүхэнд Спартак ёолж бас нүдээ алгуураар нээж харжээ.

- Спарак , ухаан ормогцоо , эргэн тойрноо ажиглан хараад, бас хөл дээрээ босон харайж жигших мэт дуугаар:
- Тийм ч баатар байх гэж !… Олимпийн Юпитерийн өмнө ам алдъя би, арчаагүйы муу эм болон хувирчээ . Ах дүү нарыг маань алж ажил хэрэг бүрэн нурж байхад , би муужран унажээ! Ээ муу аймхай ! гэлээ .

Эномай Спартакийг элдвээр аргалж орчин тойрон цөм нам гүм байна, чи дөнгөж хоёрхон минуь ухаангүй байлаа . гар чинь их муу байна гэдгийг арайхийж итгүүлжээ .

Энэ үгийг хэлж байх зуураа герман хүн Спартакийн гарыг чанга боож, уясан боолтынхоо урт үзүүрээр хүзүүн дээгүүр нь тэгнэж өвчтэй гары нь хөндлөн байдалтай болгож өгөөд

- Овоо Гарын чинь өвчин арай дээр болох байгаа . Чи үлдсэн ганц гараараа тулалдавч ялагдашгүй хэвээр байх болно гэж Спартакт хэ лжээ .

Фракий омгийн хүн ойрын нэгэн байшин тийш чиглэн хурдаолн явж

- Бидэнд юлд л олдоосой! Гэлээ.

Үүдний танхимд хүнгүй хоосон байжээ . мань р хоёр түүнийг дайран өнгөрч хашаан дотур орлоо.

Тэнд цугларсан таван зуун гладиатортой нэгэн когорт цэрэг чимээгүы зогсож байлаа . тэд гэнэхэн орж очсон Спартак Эномай хоёрыг харж баярлан шуугижээ .

- Чимээгүй гэж Спартаз тод дуугаар хашграхад Эномай бас :
- Чимээгүй! гэж давтжээ .
- Чимээгүй байцгаа , цэргийн журмаар жагсагтун дэмий сул хашгаралдах цаг одоо биш гэж Радиурийг давтан хэлэхд , жагсагдсдын дотор чимээ бүрэн намджээ .
- Трибун нар, зуутын дарга нар болон бусад дарга нар чинь хаа бана? Гэж Спартак асуулаа .
- Тэд нар , зэргэлдээ байгаа Аврорын байранд цуглаж цаашид юу хийх тухайгаа хэлэлцэж байна. манай сургууль Ромын когортуудаа р бүслэгдсэн , зэвсгийн агуулах , олон хүнтэй цэргийн отрядуудын хамгаалалтанд орсон гэж аравны дарга нэгэн хүн хариулж хэллээ .
- Тэр тухай би мэдсэн гэж Спартак хариулаад , Эномай тийш харж, Аврорын сургууль руу очъя гэлээ.
- Дараа нь өндөр дуугаар,
- Тамын бүх тэнгэрийн төлөө та нарт тушаах нь : журамтай бөгөөд чимээгүй байцгаагтүн гэж гладиаторуудад тушаалаа .

- Энэ хоёр хууин сургуулиас (энэ хоёрын саян байсан сургуулийг хуучин сургууль гэж нэрлэдэг байжээ) гараад Аврорын сургуул гэж нэрлэгддэг нөгөө нэгэн байр руу очиж, тэнд трибун нар, зуутын дарга нар , дарлагдагсдын Холбооны дээд штабын гишүүд гэх зэрэг гладиаторуудын хоёр зуу орчим удирдагчид хуралдаж , энэ аюульай цагаар цаагшид юу хийвэл зохих тухай хэлэлцэж байгаа жадлах хатгах сурлагыг танхим руу шалав явж орлоо.

Радиурийн орж очмогц

- Спартак гэж хэд хэдэн хүн зэрэг хашгирчээ .

Бас хурлыг даргалж байсан нэгэн гладиатор :

- Бид чинь дүүрчээ! гэжээ.
- Хэрэв бид, зэвсгийн ганц боловч агуулахыг булаан эзэлж яөдвал бб асч үхэх болоогүй ! гэж Спартак хариулав.
- Гэвч бид яаж түүнийг авах вэ?
- Ингэхэп бидэнд бамбар олон бий юу? гэж Спартак асуулаа .
- Бидэнд гурван зуун тавь буюу дөрвөн зуу орчим бамбар бий гэлээ.

Тэгвэл тэр чинь л билдний зэвсэг болно доо ! Энэ сургуулийн арван мянган гладиаторуудын дотроос хамгийн зоригтой нь та нар мөн. Энэ орой та нар, арслан мэт эрэлхэг зориг , гавъяа зүтгэлээ илрүүлэн гаргаж , та нар лугаа адпил дорой заяатай нөхөд чинь , зөв хүмүүсээ олж дарга нараа болгон томилжээ гэдгий нь баталж өгөх хэрэгтэй байна. Яахаас ч буцахааргүй биз? гэж Спартакийн нүд баяртай гялалзан асуулаа.

- Яахаас ч буцахгүй ! гэж хоёр зуун гладиатор ганцхан хүн шиг нэгэн зэрэг зоригтой хариулжээ .
- Хэрэв хэрэгцээ тохиолдох юм бол зэвсэг барьсан хүмүүсийн урдаас улаан гараараа тулалдан хонь шиг яргалуулахад бэлхэн үү? Гэхэд нь:
- Бэлхэн! Гэж бас хоёр зуун хүн зэрэг хариулжээ .
- Тэгвэл шалав!… байгаа бүх бамбараа авцгаа ::: хэрэв бололцоо байвал түүнийхээ тоог хоёр дахин .. гурав дахин олон болгоё , тэгээд түүнээ асааж, түүгээрээ зэвсэглэе . Тэгээд бид ойр байгаа зэвсгийн агуулахын манаач нарыг дайран орж, тэднийг хөөж зайлуулаад складыг хаалгыг шатааж ба ттай бөгөөд төгё ялалтаа байгуулахад хэрэглэгдэх хэмжээний зэвсг ийг тэндээс авъя . олимпийн гэгээн тэнгэрийн өмнө ам өлдъя арай ч бид бүр дүүрээгүй байна. Бидэнд бас зориг байна! Хэрэв бид үхэх , ялах уу гэдэг дээрээ хатуу зогсож чадвал харин ч бид ялалтыг хангаж чадна гэлээ .

Радиурийн нүд нь гялалзан зориг сэтгэлээр дүүрэн гийж байгаа нүүр царайгий нь ер бусын гэгээн гэрлээд гийгүүлж байгаа мэт байлаа . Энд байсан хоёр зуун гладиаторын итгэл найдвар , оргилсон хөдөлгөөн нь цахилгаан гүйдэл шиг төрөн гарч байлаа . Эд нар давирхай ба тос түрхэж олсны ургамлын дурсаар хийсэн бамбар , мөн давирхайтай жиргэдэс модыг голоор нь хөндий гарган багцалж , бас голй нь хөндийг шатах бодисоор дүүргэж хийсэн бамбар гэх зэрэг янз бүрийн бамбар хоромхон зуурын дотор цуглуулж ирээд тэд бамбаруудаа асааж, юлд эргүүлэх мэт хөдлөн энэ ядарсан зэвсгээ барьж ямар ч аюулын урдаас буцахгүй очихоор бэлтгэж байжээ .

Ингэж байх үед нь зуутын дарга попилий хотын бзх хаалгануудын харуул манаанп хүч нэмэгдүүлж байсан бөгөөд өөрөө гурван зуу гаруйы цэргийн хүмүүсийг дагуулж гладиаторуудын сургууль дээр ирж трибун Тит Сервилианы командын дор багтан оржээ. Эдэнтэй бараг нэгэн зэрэг шахам Капуя хотын сэргийлэхийн долоон зуу орчим цэрэг префект Меций Либеоны удирдлагын дор Фортунатынг хаалга дээр хрч ирлээ .

Профект нь тавь орчим настай , өндөр нуруутай маш бүдүүн биетэй улбардуу хацартай , цэнхэр нүүртэй хүн байлаа . Энэ хүнийг харахд амгалан түвшин байдалд дуртай , алгуур зөөлөн хөдөргөөнтэй Эпикура мэт архи хоолонд дуртай хүн бол уу гэдэг сэтгэдэхүүнийг эрх биш төрүүлнэ. Энэ хүн Капуягийн префектийг албан тушаалыг олон жил хааж , энэ атаархууштай тушаалын хүнд үзүүлдэг элдэв аятай тавтай бүхэнд их дассан хүн байжээ. Тайван цагт энэ хүний албан үүрэг маш хөнгөн байжээ. Иймийн учир ширүүн борооны үүл хот орон дээр гэнэтхэн тонгойж ирэхэд энэ хүн ямар ч бэлтгэлгүй байсан учир унтсан нойроосоо сая сэрж ихэд айн сандарсан билээ . иймд хөөрхий тэр түшмэл яах ч учраа олохгүй сандран ,

олсны сүрэлд ороогдсон тахианы зулзага ш%иг болсон байжээ .

Хэдий ттийм боловч хэргийн учир хүнд байсан ба нөгөө талаас, эрс шийдьэртэй зоримог зантай , алдар нэрд дуртай гэргий Домиция ньв намайг шийтгэх

боловуу? Айсандаа болж бас

ч зориг төгөлдөр трибун Сервилианы зөвөлгөөг

дагаж хотын дарга меций Либеон нь ямар нэгэн арга хэмжээ аваг гэж шийдсэн юм . гэвч өөрөө ч сайн мэдэлгүй , бас өгсөн тушаал нв ямар днд хүрэхийг ч бодож үзсэнгүй , юу яч болоь ямар нэгэн юм хийх, ямао нэгэн шийдвэр тушаал өгөхөөр шийдсэн байжээ .

Түүний тушаалаар яаралтай цугларсан хотын цагдан сэргийлэхийн цэргүүд биднийг дайнд префект өөрөө дагуулж орог, б идп ганцхан түүнд итгэнэ гэж хашгарлдсан юм . цагдан сэргэийлэхийн цэргүүд ийм шаардлага тавих байх гэж хотын дарга огтхон ч зүүдэлсэнгүй явсан байжээ .

Хөөрхий энэ амьтан , айн сандарч анхандаа би боол зэвсгийн биш ямбаны хүн, бүх зүйлийг урдаас судлан мэдэж байх ба бүх зүйл дээр анхаарал санаачлага тавьж , тушаал шийдвэр өгч байхын тул би , префектийнхээ байранд байлгүй болохгүй гэдгийг итгүүлэхээр оролдо н, айснаасаа олж, алга саам хэрэглэн энэ хүмүүсийн шаардлагаас хойш суухыг бүхий л хүчээрээ оролдсон юм . гэвч капуя хотын сенатын түшмэдийн даралт шахали цагдан сэргийлэхийн хүмүүсийн шуугиан шаардлага , мөн эхнэрийнхээ шаардлагалд автагдан хөөрхий энэ хүн төмөр дуулга өмсөж , юлд зүүж б ас бүслэх хэрэгтэй байжээ . ингээд энэ хүн , Капуягийн цагдан сэргийлэхийн цэргүүдийг толгойлон гладиаторын с ургуулв руу чиглэхдээ , дайсантайгаа тулалдахаар очиж яваа цэргийн дарга хүн шиг биш, харин хүчээр үхлийн оронд очих ёстой ыолсон хүн явж байгаа мэт байжээ .

Фортунатын хаалган дээр Капуягийн цэргүүдийг хүрэлцэн очмогц урдаас трибун Сервилиан , Попилий Лентул Батиат нар дагуултай тосч ирээд дарцйхан авах арга хэмжээний тухай зөвөлгөө хийх нь зайлшгүй хэрэгтэй байна гэж хотын даргад хэллээ .

Тэгэхэд , айн сандарч байгаагаа бусдад мэдэгдэхгүйг оролдсон байдлаа улам хүндрүүлж байсан Меций :

- Тийм ,тийм .. зөвөлгөөн … зөвөлгөөн… зөюхөн зөвөлгөөн хийх ч бага хэрэг… дараагаар нв бас бүгдээрээ мэдсэн үү… бүгд чадах нь уу .. гэдгийг мэдэх хэрэгтэй байна гэж ихл сандчин мэгдчин байж хэлээд ямар нэгэн юм сэтгэсэн хүн болж, бусдад үзэгдэхийг оролдон , минцут хир юм бодсон янзтай чимээгүй байснаа дуугарч,
- Яагаад гэвэл : Бүгд Найрадмадх Улсын бүх хуулийг би мэднэ, тэгээд би хэрэг тохиолдвол сэлэм ч барьж чаддаг хүн юм … хэрэв эх оронд минь хэрэгтэй болбол .. би амиа ч өгөхөд бэлэн байна… гэвч ийм… гэнэтхэн… тэгээд бас… хэзээ хаана… хэний урдаас тулалдахаа ч мэдэхгүй байж… цагдан сэргийлэхийн удирдана гэж үү… яагаад вэ гэвэл ерөнхийдөө … хэрэв ямар дайсантай тулалдахаа мэдэх сэн билээ … би юү хйх вэ… гэвч … гэжээ .

- Префект уймарсан үгээ хэлж дүүрээд эхлээд яихээ дараа нь хамраа маажиж , цааш нь хэлэх үг хичнээн эрэвч олж чадсангүй , тэгээд өгүүлбэр зохион байгуулалтын дүрэм зөрчин “гэвч” гэсэн үгээр хэлэх үгээ төгсгөжээ .

Префектийн төрх байдлыг сайын мэддэг трибун Сервилиан түүний х үнд байдалд орсны нь мэдэж инээмсэглэж байжээ
. Префектийг хүнд байдлаас нь гаргах бас үүнийхээ нэгэн хамт, өөрийнхөө төлөвлөн бодож байсан бүх зүйл ийг хийхийн тул трибун үг хэлж :
Бодвол энэ эсрэгш хуйвалдааныг устгахын тул зэвсэг агуулсан газрыг сайтар сэргийлж хамгаалах ,
мөн гладиаторуудын оргож зайлахаас хамгаалан сургуулийн хашааны хаалгуудыг түгжиж хамгаалах хот руу орох бүх гудамжийг боох ийм төлөвлөгөөг хүлээж авч болууштай байна. Би энэ бүгдийг хийлгэж гүйцсэн билээ .

Төлөвлөгөө санаачлан зохиосноороо ямар нэгэн шийдвэр гаргах ба түүнийхээ хариуцлагыг хүлээх явдлаас хотын даргаыг чөлөөлсөн трибунд х отын дарга их баярлаж.

- Энэ тухай урьдаас санаачлан хийсэн чинь онц сайн байна, гарамгай Сервилиан минь гэлээ.
- Одоо надад зуун тавь орчим цэрэг үлдээд байна. хэрэв тэднийг тус хотын зоригтой цагдаа нартай нийлүүлбэл би тэднийг удирдан босогчдын урдаас шийдвэртэй тэмцэж , бут цохиод торонд нь эргүүлэн хийж чадна гэж Сервилиан өгүүлжээ .

Меций Либеон сайшаан:

- их сайн байна , онц гарамгай боджээ! Тэр чинь ягш миний бодож байсан санал байна ! гээд дайны явуулгын бүх удирдлагыг Сервилиан ганцаараа гартаа авах нь гэж үү дээ гэж санажээ .
- Мэргэн Либеон чи бодвол энэ вуулгуудад шууд гар бие оролцохыг зайлүгүй хүсэж өаыгаа бизээ … гэж Сервилианы хэлэхэд .
- Юу … зоригтой бөгөөд тулалдахдаа дадлагатай чиний энд байхад би юү хийхэв үгүй… хэзээ ч үгүй … гэхэд нв

Трибун хотын даргын үгийг таслан

- Нэгэнт өөрөө хүсэж байгаа учир , эндээс хроёр харваж хүрэх зайтай газраа
байгаа Геркулесын сургуулийн хаалган дээр Капуягийын энэ зуун цэрэгтэй үлдэж , тэнд

одоо байгаа цэргүүдийн хамтаар түүнийг чи хамгаалж болох байна гэв.

- гэвч би бол ерөөс , ямбаны хүн шүү дээ … чи ямар мэдэхгүй биш… хэдий тийм боловч… хэрэв чиний бодол… гэж л … … гэж префектийн хэлэхэд:
- Би чамайг ойлгож байна л даа чи энэ өтгүүдтэй шууд барилдаж авах ажилд оролцохыг хүсэж байх шив дээ , үүндп бид … ч хүрч магадгүй , гэьч тэр хаалуугдыг хамгаалах ажил бол бас чухал ажил байгаа юм . иймийн учраас тэр даалгаварыг чамайг биедээ хүлээж аваасай гэсэн юм гээд Сервилиан, Либеоны чихэнд тултал тонгойж :
- Чамд ямар ч аюул дайрахгүй шүү гэж шивнэн хэлээд, дараа нь өндөр дуугар :
- Гэвч чи өөрөөр шийдвэрлэхийг хүсэж байгаа бол … гэжээ .

Мeций Либеон бага зэрэг зоригжон :

- Үгүй … үгүй … нэвтэрхийг харцтай , зоригтоы залуу минь чи яв, явж тэр босогчдыг хөөж тараа , би зуун, цэргийнхээ хамтаар чиний заасан газарт очъё тэгээд хэрэв д айсан түүгээр нэвтэрч гарахыг оролдвол нь … хэрэв тэд намайг довтолж ирвэл нь хэдийгээр ямбаны хүн боловч залуудаа байгуулж явсан цэргийн гавъяануудаа санаж байна. иймд тэдэнт муу болно гэдгийг та нарч үзнэ, тэд нар ч үзнэ … заяагүй тэр амьтад гашуун зовлон тохиолдно … гэж Мeций либеон , ингэж аман дотроо ярьсаар , мөн бие магтсаар Сервилианы гарыг барьж , энэ арван мянган үймэн босогчдоос болж өөрт нь тохиолдсон зовлонт байдлыг сэтгэлийнхээ гүнд харааж , мэдлийнхээ дор ирсэн цэргүүдээ дагуулж , түүнд даалгагдсан хэсгийн зүг явжээ .
- Энэ үед геркулесын сургуулийн гладиаторууд хашаан дотуураа үймэлдэн бамбараар зэвсэглэсэн бүх үйл аргыг хэрэглэн зэвсгийг агуулахыг эзлэн авах гэж шийдсэн дарга нарынхаа тушаалыг хүлээж, найдах горьдлого тасрах хоёрын завсар хүлээж байжээ. Босогчдоос зэвсгийн агуулахын хаалгыг хамгаалахап амиа өгсөн ч буцахгүй гэж шийдсэн эргүүд боолчууд нийлмэн таван зуун хүн зэвсгийн агуулахад очих замыг хамгаалж байжээ .
- Спартак , Эномай нар ба тэдний нөхөд , зэвсгийн танхим руу очих коридорт гарах гэж байтал нь шөийн харанхуй дотор бүрэн

дуу хангинаж дорой заяатан гладиаторуудын цуглан байсан хашаан дотуур уйтгарт уянгалала тараажээ .

- Чимээгүй ! гэж Спартак нөхдөө зогсоогоод юу болж байгааг чагнахаар зогслоо.

Үнэхээ бүрээ дуугарсны дараагаар тунхаг зарлагч тусгай албаны хүн ий дуун сонсогдож босогчид трцгаан тус тусынхаа байранд очицгоо , эсхүл бүгд найрамдах улсын цэргийн хүчээр хөөн тараана шүү гэж Ромын сенатын нэрийн өмнөөс шаардаж байгаа нь сонсогдлоо.

Энэ албаны хүний зарлсан зүйлий нь хадны цуурна шиг тараан, гладиаторуудын байгаа хашаа бүхний хаалган дээрх бас ийм албаны бусад хүмүүс дандаа нарлаж байгаа нь уйтгартай.

Спартакийн царай уйтгартай болж, газар шагайн түр зуур зогссоноо өөрөө өөртөө зөвлөсөн мэт болж , нөхөд тийшээ харж,

- Зэргэлдээ байгаа зэвсгийн танхимыг одоо бид авч чадвал зэвсгийн бусад агуулахыг эзлэн авахад хүрэлцэх сэлэм тэндээс бид олж авч чадна. Хэрэв бид түүнийг олж авч чадахгүй өбол бидэнд ганцхан зам үлдэнэ. Тэр нь ямаро зам бэ гэвэл манай хоёр легоны ахмад зуутын дарга нар бусад нөхөд дээрээ очих хэрэгтэй. Тэгээд аван таван минутын дараа , манай эрх чөлөөний дууллын чимээ сонсогдохгүй байвал чимээгүй тарцгааж байруудаа оч гэж нөхөддөө хэлэг. Тэр бол бид нараас зэвсгийн газраас эзэлж чадаагүйн тэмдэг олно. Хэрэв ийм болбол бид Геркулесийн сургуулиас нумаар харюаж хүрэх газрыг хагасын хир зайтай газар байгаа явган хаалгыг унагаж түүнийг шатааж орхиод Ганимедын гуанз хүрээд олдсон зүйлээр тэнд зэвсэглэсэн , замдаа дайралдсан саад бүхнийг давж , зуу жар, гуч, - нэг үгээр хэлбэл бидний дотроос амьд үлдсэн бүгд маань Везувий уулын дээр лагерлан байрлаж тэнд эрх чөлөөнийхөө тугийг мандуулна. Тийшээ манай ах дүү нар зэвсэгтэй зэвсэггүй бөөнөөр буюу гнц нэгээр , хамгийн дөт замаар хурэлцэн очиж цуглардаг. Тэгээд тэндээс дарлагдын эсрэг явулах дарлагдагсдын дайн эхэлнэ гэж бүгдэд сонсогдохуйц өндөр дуугаар хэлжээ .

Энэ үед хамгийн аюултай байсан энэ газрыг орхиод явж арайхан шийдэж чадахгүй байсан хоёр ахмад зуутын дарга нарыг харж , Спартак :

Армодий, Клувиан та хоёрыг яв гэж би, дээд штабйн нэрийн өмнөөс та хоёрт тушааж байна гэлээ.

ТУшаал авсан хоёр залуу толгой дарж , зүрхээ шархлуулсан хоёр тийшээ гарч одлоо.
Тэгэхэд нь Спартак , нөхөд тийш эргэж:

- За одоо .. урагшаа ! гэжээ .

Спартак , Эномайгийн хамтар бусдаас түрүүлэн зэвсгийн складын байгаа коридорт орж, түүнийг хамгаалж байсан цэргүүдийг цахилгаан
мэт хурдан дайрч орлоо. Тэр цэргүүдийн
дарга өрөөсөн гартай, өрөөсөн нүд нь сохор нэгэн хүн :

- Урагша ! … урагшаа , довтлооч… муу сайн гладиаторуудыг ! гэж цжргүүддээ тушаан хашгирч байжээ .
- Дүрэлзэн асаж байсан урт иштэй бамбараар зэвсэглэсэн Спартак гараа сунгаж бүх хүчээ айчлан хашгичиж байсан тэр даргын ам руу цохисонд тэр нь сүүлийнхээ үгийг гүйцэд хэлж амжаагүй ураг… гээд зогсчээ . Хуучин дарга тэр хүн муухай орилоод , ухарч эхлэв. Үзэгдээгүй зэвсэг барьж газлуу мэт довютлон , зэвсгийн агуулахын хаалган дээр хамгаалах цэргүүдийг түрэн зайлуулж байсан Спартак , Эномай нарыг цохих гэ хэсэг цэргүүд их л оролджээ .
- Энэ үед , Тит Сервилианы удирдсан цэргүүд Капуя хотын цагдаа нар хоёр хэсэг болж тус бүр нь зууны даргаар удирдуулан босогчдын байсан гурван хашаа руу нэгэн зэрэг чиглэн
  ирж нэгэн дор бөөгнөрөн хуйлралдаж байсан зэвсэггүй гладиатору удыг чиглүүлэн шидэх жад хаялжээ .
- Энэ нь тун аймшигтай муухай үе байлаа . Бороо шиг асгарч байсн суманд туугдаж гладиаторууд муухай
  орилолдон харааж зүхсээр хашаан дотроос зайлахад хүрсэн бөгөөд :
- Зэвсэг! … зэвсэг!… зэвсэг!… гэж нэгэн дуугаар хашгран явах мэт байлаа . дайснй шидэх зэвсэг бороо шиг асгарсаар л байлаа . Ухарч байсан гладиаторууд удалгүй балмагдан сандарч тархан зу гтжээ .
- Энэ үед гладиаторууд коридорт шахцалдан гарах хаалгууд дээр чяихэлдэж бас өрөө тасалгаануудаар хоргодон орж тэнд бие биеэ гишиглэн дарж байсан дээр хараах зүхэх хашгарах бархирах гуйх мөргөх, дуу
  ба шархалсан хүмүүс үхэж байгаа
Шархдагсдын дийлэнх нь ялагсдынхаа гарт орсон боловч , Спартазк тэдний зэвсгий нь хурааж өөрсдий нь суллан тавьжээ . Учир нь өөрийнхөө талд олон хоттой болох хүртлээ олзлогопсон цэргийг өөртөө авч байхгүй гэнж Спартак шийдсэн юм . Лагерьтаа олон тооны олзлогсдыг авч байх явдал бол зарим нэгэн нөхцөлд аюултай байдаг юм .

Энэ тулалдаанд ,мөн галдиаторууд, багагүй хохирчээ . Хоёр зуун тавь гаруй хүн алагдаж , бас шархадсан хүмүүсийн тоо, алагдагсдын тооноос хоёр дахин олон байжээ .

Публий вариний нь Алиц хотноо очиж квессторынхаа бүрмөсөн бут цохигдсон тухай мэдээг мөн эндээс сонсож я мар нэгэн найдвар бүрэн тасарч , эндээ бүгжээ . Хэрэв дайсан дахин дайралдвал эсэргүйцэх хүч чадалгүй болсон Пүблий Вариний хязгаар гүы айн сандартч газар тэнгэрийн бүх бурхад болон өөриын длртойтсон үйл заяча ба үзэшгүы муусайн гладиаторуудыг харааж зүхсээр
Кампаньягаас гарч Апеннины хавцлыг дайрч хамгийн хурдан маршаар явж Бовиамнумд очыиж нуугджээ .

Гурдахан хоногийн дотор хоёр удаагиын гайхамшигь сайхан ялалт үйлдсэн Спартакийг цэргүүд
нь хайр хүндэтгэлээрээ хүрээлэн бас Спартакийн нэр өмнөд Италийн бүх мужаар улам аймшигт нэр болон тархжээ .

Сапртак цагаа дэмитй үэрлэгүй , Кавдинын хавцлаас гарч Кавдиум руу очжээ . Энд Спартак , галл язгуурын , гладиатор Брезовиртай дайралдсан юм . (Манай уншигчид , Брезовирыг дарлагдагсдын холбооны дээд шүүхээс тагнуул Кай Веррес алах ял үаасан тэр өдөр Ром хотын Венера Либитиний гуанзанд байх үеэс мэддэг болсон юм).

Брезовир нь тавин нөхдийнхөө хамт тун саяхан Капуягаас оргож гараад, Спартакийн лагерьт очиж явсан байжээ .

Лентул Батиатын сургуулв дээр одоо хүртэл хоригдлж байгаа твин мянган гладиаторуудыг тэндээс чөлөөтэй гахар нөхцөлтэй болгох нэгэн арга хийх гэж Брезовирын зөвөлгөөгөөр Спартак шийджээ .

Кавдинын хавцлын дэргэд болсон тулалдаанаас хойш гурав хоногийн дараа, Спартак арван мянган байлдагчдыг дагуулан Капуя хотын хэрмийн дэргэд очиж, зэвсэггүй таван мянган гладиаторыг чөлөөтэй нааш нь гаргаж аль энэ шаардлагыг захиргааны байгууллагаас хэрэв биелүүлэхгүйд хүрэх юм бол бид хотыг хүчээр дайран орж гал түймэр шатааж, дээрэмдэн бусниулж хотын иргэдийг эр эм , хөгшин залуу члгалгүй хүйс тэмтрэн хядна гэсэн шаардлагыг тусгай хүн явуулж хотын префект ба сенатад хэлүлжээ .

Спартакийн ялалтуудыбн тухай мэдээ дам үгээр чимэглэгдэн , Капуя хотын хүмүүсиын сонорт хүрсэнд хүн бүхэн их гайхжээ . Хотын хаалганы дэргэд аймшигт энэ дайсан хүрэлцэн ирсэн явдал хотын иргэдийн зүрх сүнсийг догдлуулан шаардлага бүх нийтийнг хамаарс ан юм .

Форум дахь, Дианы сүмд сенат хуралдаж энэ сүмийн дэргэд маш олон хүн цугларчээ . хагасхан цаг хүрээгүй байтаол бүх дэлгүүр хаагдаж , эхнрэүүд үсээ задлан дуган сүмүүдээр цугларч мөргөн залбирчээ . ГЛАДИАТОРУУДЫН ХҮССЭН ШААРДЛАГЫГ ХАНГАН ӨГЧ , кАПУЯ ХОТЫН ИРГЭДИЙГ ХЯДАГДАХ АюУЛААС АВАРХЫГ СеНАТЫ Н ТҮШМЭДЭЭС ШААРДАН ЧАНГА ХАШГРАЛДСАН ЖИРИЙН ИРГЭДИ ЙН ДУУН ГАДАА СОНСОГДОЖ БАЙЛАА .

Ихэд айснаасаа болж царай нь цайж , нүүр нь муруйсан Меций Либеоны хоолой нь чичирч Спартакийн шаардлагын тухай сенатаа айлтгажээ . Хотын даргаас ч багагүй айн сандарч байсан сенатын түшмэл сандарсан байдалтай бие бие тийшээ харж байсан боловч энэ туйлын хүнд аюульай цаг үед санлаа хэлэх хүн гарсангүй .

Ингэж , дор бүрдэ дуугүй болу ямар нэгэн шийдвэр гаргаж, чадахгүй байгаа явдлыг ашиглан ,

Капуя хотыг хамгаалуулахаар Ромын сенатаас явуулсан ,
дөрьөн зогортыг командалж байсан зоригтой туршлагатай , байлдагч ,
цэргийн трибун өөриынхөө бодож байсан зүйлийг хэлэх зөвшөөрөд гуйлаа .
Огтхон ч айж сандраагүй энэ хүн , шүрүүн боловч сайхан үгээр ярьж ,
Спартакиын шаардлага бол хотйын иргэдийн дэмий сүрдүүлэн айлгасан
хэрэг. Энэ хот нь бат хэрмээр хүрээлэдгсэн учир, гладиаторууд орж
ирж чадахгүй,мөн дайрах , хотын хэрэм эвдэх дүүжин дүүгүүр гэх
мэт багаж зэвсэггүй цэргүүд хотыг дайрч зүрхлэхгүй биз гэж батлан
хэлжээ .

Жаргалдаа ташуурсан, Капуя хотын сенатын түшмэд анхандаа айн
сандарч хоолой нь зангиран юм хэлж чадахгүй байсан бол энэ
удаад хорт аалзанд хазуулсан юм шиг байрнаасаа босон харайж зэрэг
зэрэг хашгаралдан , гладиаторууд одоогийнхоосоо цөөн ,
дор зэвсэгтэй байхдаа хоёрхон цагийн дотор Нола хотыг эзлэн авсан юм
. Тэр хотын орон байшингуудын шатааж , бүх иргэдий нь алсан юм, трибун
чи галзуурав уу алдар нэрийн хойноос хөөцөлдөн чиний уршгаар бид
алагдахыг огт хүсэхгүй байна. Тэр таван мянган гладиаторын нь
хотооё гаргаж өгөх явдал бол хамгийн зөв, хамгийн ухаантай арга мөн,
учир
нь тэгвэл бослого ба яргаллын байнгын аюулаас сая зайлах болно гэж өгү
үлжээ… эд нар энэ санлаа , хотын талбай дээр цугларан хотоо
хамгаалагтзн гэж сенатын , хотын талбай дээр цугларансан
ард түмний санад нийлснээс ба Спартакийн шаардлагыг хангаж өгөх
тухаы сенатын олон түшмэдээс оруулсан саналыг хэлэлцүүлэн ,
санал хурааж таслуулахыг Меций Либеоноос шаардаж байсан санал бас
нийлжээ .

… Энэ санал нв бараг нэгэн дуугаар батлагджээ .

Лентулын сургуулв дээр хоригдож байсан таван мянган гладиатор ,
инэж чөлөөлөгсөн хотын гадна гарч , эндээс холгүй
газар Тифаны уулын хормойд лагерилаж байсан
Спартакийн цэргүүдтэй очиж нийлжээ . Очсон энэ
гладиаторуудыг даруй зэвсэглэсэн тэд
нэрээр бүрдүүлсэн гурадвугаар легион байгуулж , даргаар нь Борториксыг
томилжээ. Борториксын урьд гүйцэтгэж байсан морин цэргйн даргын үүрги
йг Брезовирт шилжүүлэн өгчээ .

Спартак хүмүүсийнхээ хамт Нола хотноо буцаж очоод тэндээ гуч ор
чим хоонг болжээ . Спартак шинэ легиондоо , их л дуртай хичээл зааж ,
өдөр бүзр жагсаалын сургууль хийлгэж байлаа . Претор Вариний ,
Спартактай дахин тулалдах зорилгоор шинэ тутам хүчин хуримтлуулж бай
на гэдэг сураг энэ үед Спартакт сонсогджээ . тэгэхэд Спартак , Варинийгаас
урьтах гэж шийдээд : хоёр легион цэргээ Крискийн хамт Нола хотноо орхиж

, өөрөө нэгэн легион цэрэг авч Апенинийг давж, Бовианум хотын хэрмийн дэргэд гэнэт хүрч очсон байна .

Вариний үнэхээр ч Ромын сенатад энэ дайны азгүй муу явцын тухай мэдээ явуулж , мөн урьд эх орныхоо албанд үнэнсээр зүтгэж явснаа дурсан , олон удаагийн тулалдаанд оролцож явсан үнэнч цэрэг надад энэ дайны төгсгөлд хүргэж , азгүй муу хувь заяагаар тохиолдсолн , алдаа гэмээ цагаатгах боломжоог олгож өгнө үү гэж гуйсан байжээ .

Сенатаас зоригт
эр варинийн шудрага хүслийг хангаж хууин цэргийн дөрвөн мянган хүний бүрэлдэхүүнтэй найман когорт цэрэг явуулж бас марс, самнит , пицэн омгийнхон дотроос дахин арван зургаан зогорт цэрэг цуглуулж авах эрхийг түүнд олгосон ажээ . иймийн учир, тэр нь гладиаторуудтай явуулж байгаа дайнаа төгсгөлд нь хүрггэхэд хэрэгтэй хоёр легион цэргийг бүрдүүлэх нөхцөлитэй болсон юм . Цэрэгт удаан албанд хаасан бөгөөд ахмад тушаалын хүний гарцаагүй сайн хүн гэж үздэг претор нь холын харцтаы чадвар сайтай хүмүүс байсан байтал алагдсан Фурийн оронд Лелий Коссинийг квесторын тушаалд томилсон юм
. Ром хотын саяхан ирүүлсэн найман зогорт цэргийг энэ хүнээр командлуу лан Бозинаумд орхиж
Спартакийг Самниум хотод нэвтрэн орох явдалд нь саад хийж бай гэж түүнд тушаагаад
Кавдинын хавцлын дэргэд бут цохигдсон цэргээсээ үлдсэн хоёр мянган хүнийг агуулан өөрөө, шинэ цэрэг татах зорилгоор марсчууд ба пиценчүүдын нутгийг чиглэн очжээ .

Спартак Бовианум хотын дэргэд хүрэлцэн очиж , Коссинийг тулалдаанд дуудахад тэр нв даргынхаа хатуу тушаалыг дагаж , хотоосоо гарахгүй байжээ . Коссиний нь гладиаторуудын урдаас дайрч чадахгүй болсондоо цухалдаж байсан болович, тэдний доромжлол тэдний дуудлагыг тэсвэрлэн хүлээхээр шийдсэн юм .

Ингэхэд Спартак % варинийн төлөвлөгөөг бзрэн ойлгож мэдээд Самниум ба Пиценээс цэргээ татах боломжоог түүнд олгохгүй гэж шийдээд Бовианумын дэргэд абайрлуу лсан лагерьтаа Эномайг нэгэн легион цэрэгтэй нь орхиж өөрөө нэгэн турм морин цэрэг авч Нола хотноо буцаж очжээ .

Спартакийг Нола хотод ирэхэд , түүнийг энд сайхан хэрэг явдлууд угтаж байжээ . нэгдүгээрт Равеннийн сургуулиас таван мянган гаруй галл , герман фракий хүмүүсийг дагуулан гладиатор Граник ирсэн байжээ. Саяхан ирсэн нэгдмэл хүчний хамтаар гладиаторуудын цэрэг нь дөрвөн легионд хуваагдсан хорин

мянган хүнтэй болсон бөгөөд , одоо ч бидний ялагдашгүй болжээ гэж Спартакт санагдах болжээ . Хоёрдугаарт Спартакийн охин дүү Мирца нь гладиаторуудын лагерьт хүрч ирсэнб айжээ . Спартакийг санамсаргүй байтал гэнэт ирсэн охин дүүгээ харж сэтгэл ихэд хөдлөн барялаж нулимс асгаруулан олонт үнсжээ . Дүү нь ахынхаа нүүр , гар, хувцсы нь үнсэж , сэтгэл яхзгааргүй баярлан:

- Ээ хамгийн хайр ах минь ! Спартак минь… Спартак чинь ,,, Аймшигт энэ цуст дайнд , мэсийн ирэн дээр явсан чинийхээ хойноос , миний сэтгэл хичнээн зовж хичнээн айж байв… хаана байвч миний сэтгэд ер амрахгүй … чамайгаа ямагт санаж.: “хэрэв шархадсан бол яадаг билээ?… намайг ирээсэй гэж байгаа болов уу ” … үүнээс тэнгэр чамайг өршөөх болтугай … надаам илүз чамайг хэн ч асарч чадахгүй . Спартак минь . Би дандаа уйлдаг байсан … Ах руу минь намайг явуулж өгөөч ы гэж би сайхан сэтгэлт эзэн авхайгаас .. хамгийн агуу сэтгэлт Валеригаас гуйсан юм … тэгээд хөөрхий тэр эзэн авхай минь , миний хүслийг хангаж өглөө! … сайхан сэтгэлт Юнона ямагт тусалж , байх болтугай ! … тэр минт миний гуйлтыг ханга … намайг чөлөөсөн шүү? Би, одоо чөлөөтэй хүн болсон, үүнээс хойш би ямагт чамтайгаа хамт явна гэх зэрэг үгийг аман дотроо шивэгнэн хэлжээ.

Мирца , бяцхан хүүхэд шиг ахдаа аман дотроо ярьж , хоёр нүднээсээ нулимс мэлмэрүүлэн хөдөлгөөн бүр нь баяр жаргалаар дүүрэн байлаа .

Одоогоос хоёр хоногийн өмнө Равенаас Граникийн хамт ирсэн цайвар үстэй сайхан залуу Арторикс энэ баясгалант уулзалтыг яг ширтэж б айснаа , шийдвэртэй биш байдлаар алхлан ойртож ирээд:

- “Хэзээ ч ялагдаж яваагүй хэзээ ч ялагдашгүй , жолоодогч эрхэм Спартак чи намайгаа тэвэрч үнсэхгүй сэн болов уу гэжээ .
- Арторикс энэ үгээ хэлэх зуураа , Спартакийн бүсгүй дүү тийш хугай нүдээрээ харж байгааг ажвал ахын нв нэшэн үнсэлтийг булаан авах гэж байгаагийнхаа уучлалтыг дүүгээ с нь хүсч байгаа мэт байлаа .

Тэгэхэд Спартаз энэ залууг тэврэн цээжиндээ шахаж:

- Ээ, Арторикс минь !… хоногр Арторикс минь ! Сайхан сэтгэлт залуу минь чамайгаа би тэвэрье!… алив үнсье! Гэлээ .
- Энэ аймшигт дайны анхны үед сүүлийн дотор үйлдсэн гайхамшигт яла лтууд ба сайхан амжилт олсон баяртай явдлын дээр бас дотно хайртай хүмүүс : охин дүү ба Арторикс нартайгаа дахин уулзах хувь заяа Спартакт тохиолджээ .

-

Баяр хөгжилтэй Спартакийн царай удалгүй бүрхэж уйытгарласан байдалтай болжээ . толгойгоо санжуулан , ямар нэгэн зүйлийг бодолхийлэн уйтгарлаж байснаа , гүнээ санаа алдаж , нөхөдтэйгөө салах ёс гүйцэтжгээд , охин дүүгээ дагуулан майхандаа очжээ . Спартак, Валерийгийн тухай асууж сурахыг маш их хүссэн боловч ариун сэтгэлий нь ичингүйрэл хорьж охин дүүгээсээ асууж зүрхлэсэнгүй .

- Харин Спартакийн аз дайрч , хөгжил хөөр болж , зогсолтгүй ярьж байсан дүү нв ямар нэгэн асуулт ч хүлээсэнгүй Спартак валерий хоёрын завсрын холбооны тухай ямар ч сэжиг аваагүй байсан учир , ямар нэгэн далд санаа ч агуулсангүй , ердөө л сул ярьж Суллын бэлбэсэн гэргийн тухай ч бас өгүүлжээ .
- Хоолны ширээний оронд Спартакийн хэрэглэж байсан хэрчим модон дээр боол бааз бин хийж байсан Мирца :
- Спартак минь , би чамд үнэнийг хэлж байна . хэрэв Ромын язгуууртан авхай бүхэн Валериятай адил сан бол боолын журам хууль ёсоор устах сан билээ : тийм эхнэрүүдээс төрсөн хөвгүүд бол цөлөх залхаах, торлогдох шүүх цовдлох дүүжулэх , гладиаторуудыг завсар хооронд нь алалцуулах зэрэг ёс журамтай эвлэрэн сууж чадахгүй байсан билээ гэжээ .

Тэгэхэд Спартак халуунаар дэмжин:

- Тийм ээ , би үүнд итгэж байна … үнэхээр тийм байхсан гэж би бодож байна гэж хариулжээ .

- Ямар нэгэн
авхайтгаас өөрийнхөө гладиаторуудын сургуулийн захиралд хайртай бай дгаас хол илүүгээр , Валерия чамд хайртай байдаг юм . Валерия нь чамайг олонт магтан сайшаадаг ,
ялангуяа чамайг Везувийд лагериа байгуулсанаас чинь хойш бүзр ч олон магтан сайшаадаг болсон юм…трибун Сервиилианыг ялсан тухай гий чинь сонсохдоо… бас Клодий Глабрыг бут цохисны чинь мэдэхдээ … ерөөсөө чиний тухай ямар нэгэн мэдээ сонсохдоо…тэгнэ ”Спартак бол цэргийн их удирдагч болохын тул төрсөн хүн юм!” гэж олонт хэлдэг юм гэлээ . Түмэн зүйл сэтгэлд нь орж өнгөрсөсн цагийн юмйг эгүлэн санаж байсан Спартак дуу алдан:

- Валерия тэгж хэлсэн гэж үү? Гэж тэсч ядан асуужээ .

Ахдаа хоол хийж байсан Мирца:

- Тийм ээ, тийм , яг л тэгж хэлсэн шүү… манайхан эндээ удах уу? Чиний майхныг жаал засалгүй болгохгүй нь ээ. Энэ чинь гладиаторуудын гарамгөа удирдагчийн майхан шиг огт биш байна хамгийн хэрэгтэй зайлшгүй юм хэрэгтэй байна. Чиний энэ майхан чинь хамгийн муу цэрг йн майхан шиг байна. Тийм ээ, Валерия тэгж хэлсэн юмаа… Чи Валериягийн ах уран илтгэгч Гортензийг таних уу?… Валерия нэгэн өдөр тэр ахтайгаа зг зөвлөлдөж , чиний үүсгэсэн энэ дайн шудрага дайн мөн. Хэрэв жиорийн үхэлтэн хүмүүсийн хэрэгийг тэнгэро хардаг юм бол энэ дайнд , Спартак заавал ялах ёстой гэж ахдаа нотлон хэлж байсан юм гэжээ .

Чпартакийн сэтгэл ихэд хөдөлж , царай нь цайж , бие нь чичирч.

- Ээ, Валерия минь, охин тэнгэр минь! … гэж дөнгөж сонсогдох төдий дуугаар шивнгэн хэлжээ .
- Валерия бол сэтгэлийн зовлонтой хүн юм шүү … би мэднэ… хочр нүдээрээ дүүрэн нулимстай байхы нь ч би бас олон удаа сонссон … гэвч , чухам юун сэтгэл шаналан уйлж , санаа алдаж байдгий нь мэдэхгүй байна … Мессала овогтон төрөл садантайгаа эвдэрсэндээ харамсан …нас барсан нөхрийнхөө хойноос гуньдаг юм уу… арай ч тийм баймааргүй юм, ганц л охин Постумия нв юмаа … тэр нь мөн ч хөөрхөн амьтан шүү! гэлээ .

Спартак гүнээ санаа алдаж
гараараа нүднийхэнэ нулимсыг арчлан, майхан дотуураха хурлдан хурдан алхан , яриагаа өөрчлөхийг хүсээж :

- Валериягийн үеэл ах Марк Валерия Мессал Нигерийн тухай ямар нэгэн зүйл мэдэх бол чи ахдаа хэлж аль гэж Мирцагаас асуужээ .
- Мэднэ , мэдпнэ бие нь сайн болсон! … чиний агуу сэтгэлийг тухай бидэнд хүртэд сонсогдсон. Бидний Тускулумыхаа ордонд байх үед , түүний тухай Гортензийн ирж ярихад Валерия чамд баярлан нулимсаа асагруулж басан юм . Валерия Суллын нас барахаас өмнөөс эхлэн Тусмкулумынхээ байранд орсон бөгөөдп одоо жил шахас болж байна гэтэл нь :

Аравтын дарга – нэгэн гладиатор Спартакийн майхны үүдэнд ирж, Ромын хотооё саяхан
ирсэн залуу цэрэг тантай одоохон ярилцахыг хүсэж байна гэнэ
гэж удирдагчдаа мэдээлжээ .

Гладиаторуудын лагерь Ромын цэргийын лагерийн журмаар байгуула гдсан учир, Спартакийн майхан , хамгийн өндөр газарт баригдсан б

айх бөгөөд , майхны нв урд талд тусгай талбар байна. ийм талбарыг ромынхон преторик гэж нэрлэдэг юм . Спартак мйахны өмнөх преторий дээрээ гарч очлоо.
Майхнаасаа гарч очсонд дээр аравтын даргын илтгэж хэлсэн ёсоор маш үнэтэй бөгөөд сайхан зэвсгээр бүрэн зэвсэглэсэн , дөнгөж ара дөрөв хүрч яваа болов уу гэмээр залуухан цэргийн эр зогсож байжээ .
Энэ ц эргийн хүний өмссөн хөө хуягийн бяцхан мөнгөн цагригуудыг хэлхэж хийсэ н байхбөгөөд түүний мөр ба нарийхан бэлхүүс үүд нь яв ц ав таарч өвдөгь нь хүртэл унжжээ .
Энэ хүн мөнгөөр гоёж алтан тавтай хадаасаар эргэн тойрон чимсэн суран бүс бүсэлсэн байжээ .
Хоёр хөлдөө ган бүрхүүвч хийж суран олмоор булчин дээрээ олмож , баруун гараа , бас ган хуягаар бүрхэж , зүүн гартаа хөнгөн бөгөөд дугуй хэлбэртэй төвгөр тал
дээр нь маш нарийн хийцээр хээ угалз товойлгон гаргасан
хүрэд бамбай б айрьжээ . Ердийн оосрын оронд урт бөгөөд бат хийцтэй алтан оосроор баруун мөрөн дээрээ тохуулан оосорлож зүүн ташаан дээрээ бяцхан бөгөөд хөнгөхөн сэлэм зүүжээ . Энэ хөвгүүн ар талын хярны оронл алтан могойгоор чимсэн бяцхан дуулга толгой дээрээ өмсжээ . Цав цагаан царайтай , бяцхан хөьгүү мэт энэ залуу цэргийн мөнгөн дуулга дороос маш нарийн ширхэгтэй улбар шар үс цухуйсан байлаа .
Бүсгүй хүн шиг гангган биетэй энэ сайхан залуугийн том ы бөгөөд гүн далай ус шиг цэв ц энхэр нүждэнд нь шийдэмгий байдал төгөлдөр зориг тусаж байлаа .
Спартак , тэр залууг гайхсан байдалтай харж байсанаа, надтай ярилцахыг хүссэн хүн энэ үү гэсэн байдалтай – майханаас дуудөаж гаргасан аравтын дарга тийш харсанд тэр нь толгой дохиж тийм ээ, энэ хүн мөн гэж хариулсанд Спартак залуу хүн тийш ойртон очиж,

- надтай уулзах гэсэн хүн , чи юу? Чи хэн гэгч хүн бэ? … ямар хэржгээр ирэв? Гэж гайхсан байдалтай асуужээ . Хүүгийн хацар улайж эхэлснээ , тэрхэн дороо цав цагаан болон хувирч түр зуур түдгэлзэж байснаа :
- - Тийм ээ, би байна , Спартак аа , би байна гэж зоригтой хариулж хэлжэ .

Дараа нь бага цзэрэг дуугүй байснаа :

- Чи намайг танихгүй байна уу? гэж нэмж асуужээ.

Тэгэхэд Спартак , хэзээ хаа.а үүнийг үзсэн билээ гэдгээ сэтгэлийнхээ ёроолоос холын нэгэн санаанаас эрхж байгаа юм шиг нэгэн пахин дахин харж байснаа , түүн тийш халзан харж:

- Нээрээ … чамайг үзсэн юм шиг … байх юм … гэвч хаана? … хэзээ ? … үзсэнээ мэдэхгүй байна гэлээ.

Гладиаторын , ингэж хэлсний дараа , хоёулаа дуугүй болжээ . Спартак эхлэн дуугарч,

- Чи ромын хүн үү? Гэж хүүгээс асуулаа .
- Хүү толгой сэгсрэн , инээмсэглэж ,
- Гарамгайы Спартак аа , чиний гарын хүч аврага боловч, үзсэнээ санах талаар бас төдий л аврага биш байна гэлээ . Энэ үгийг сонсч , түүний инээмсэглэлийн хараад, фракийн хүний дотор аянгын гэрлээр гэрэлтэх мэт болж , гэнэт санаанд нь орж ,
- Яана гэнэ ээ? … Юпиторын өмнө ам алдъя ! Чи чинь Эвтибида юу? гэлээ .
- Тийм ээ би Эвтипида байна гэж тэр залуу хүү үнэнээр ньв хэлбэл , тэр залуу бүсгүй хэлжээ . Спартакийн өмнө грек якгуурын хөнгөн явдалт сээтгэнүүр бүсгүй биеэр зогсож байс ан юм .
- Би бас боол шивэгчин хүн шүү дээ! Хамгийн дотно хүмүүсийн минь боол болгон хувиргаж байхы г би нүдээр үзсэн хүн шүү дээ! Би бас ч эх орноосоо хагцан салсан хүн шүү дээ! Би бол ромынхон завхай самуун явдлын уршгаар үзэшгүй муухай, хө нгөн завхай явдалт , сээтгэнүүр хүүхний дэргэд муухай , хүн шүү дээ гэлээ .
- Бүсгүй энэ үгээ хэлж байхдаа уур хилэнгээ барьж байжээ .
- Би чамайг ойлгож байна … олйгож байна гэж Спартакийн царай уйтгартай болж юм болж юм бодсон байда лтай хариулжээ . Бодвол энэ үед Спартакийн санаанд охин дүүгий нь байдал орсон билээ .

Дараа нь түрхэн зуур дуугүй болсноо , дахин толгойго өндийлгөжу их л харамсан хорсон байдалтай санаа алдаж,

-

Аятай эвтэй байдалтай дасаж энхрий амьдралаао элгээ халааж сурса н хонгор бүсгүй чи… юу хийж чадах вэ? Чи энд юү хийх гэв ? гэж асуулаа .

Энэ хонгор бүсгүй маг уурлаж .

- Дельфий Апполон ухааны чинь гэрэлтүүлэг! Чи юу ч санахгүй байна !ээ! … өшөө хонзон агчид – фурийы нарын өмнө ам алдъя!… эцгийнхээ өмнөөс , ах нарынхаа өмнөөс боолчлогдсон эх орныхоо өмнхөөс , дарлагчдын хумих жолоогүй хурьцалд автагдан үрэгдсэн залуу намныхаа төлөө, холг шороонд булагндсан нэр хүндийнхээ төлөө бүх насаар боол байх ёстой болсон мьдралынхаа төлөө би өшөөгөө аварх гэж байна. Үүнийг би чамд хэлсэн билээ . тэгэхд чи, энд намайг юу хийх юм гэж асууж байна гэнэ? Гээд бүсгүйн царай тун хачин болж , маш сайхан нүд нь аймаар болон хувиоч уур хилэнгээр дүүрэн гялалзан асж байсан учир үүний аймшигт золртиг чадлыгСпартак гайхаж сэтгэл нь хөдөлж , грек хүүхэн рүү гараа саарвайж

- Чиний хүссэнээр болог! Бидэнтэй удаан явж чадах бол манай аялалд оролц , тулалдаж ч аддаг бол билний нэгэн хамт дайсантай тулалд гэж спартак хэллээ .

Спартакийн сарвайу өгсөн гар дээрээс чичйрэн атгаж :

- Санасман бүхнээ хийэ чадах байх гэж … би өөртөө найдажэ байна гэж энэ бүсгүйы хөмсөг зангидан их л шийдвэртэй царайгаар хэлжээ .
- Гэвч Спартакийн гараас барьж түүний биенд хүрмэгцээ энэ бүсгүйн ыүх зориг хүч нь ганцхан мөсөн сорогдсон мэт болж, бүх бие нь чичрэн , царай нь үхдлийн царай шиг цав цагаан болж , өвдөг нь аяндаа сөгдөж байх шиг санагдан, арай л муурч унасангүй . Фракий хүн, энэ бүсгүйн хүэрэхд . Эвтибида хүүхний бүх судас шөрмөсөөр хүйтэн жавар гүйх мэт болж палхийн цочсо нд:
- Чи яав? Чи яах гэв? Гэж фракий хүн зөөлөн асуужээ.
- Би чиниы гарыг , чиний сайхан гарыг үнсэх гэсэн юм гэж Спартакийн гарыг халуун уруулаараа ахин дахин үнсэж аман дотроо өгүүлж, ээ , хамгийн алдарт Спртак минь ! гэжээ .
- Агуу их удирдагчийн нүдийг мана бүрхэж , бүх судас шөрмөсөөр нь цус буцлан гэнэт толгой руу нь орж байх шиг санагдан , энэ бүсгүйн цээжиндээ тэврэн авах шахсан боловч , энэ соронзон мэт хүчнээс биеэ чөлөөлөхийг оролдож, бүсгүйн гараас гараа суга татан авч хөндийрөн холдож:
- Дарлагдагсдын хэргийн төлөө зоригт бүсгүй чамд баярлалаа , магтаал сайшаалаа илэрхийлсэнд яинь баярлалаа, гэжвч боолын ёсыг үгүй хийж устгах гэж байгаа бид нар бол өөрсдөө боолын заншлыг устгаж эхлэх ёстой гэж ширүүн хэлжээ .

Эвтибида , ичингүйрсэн мэт болж газар ширтэн дуугүй зогсч байлаа .
Спартак түр дуугүй байснаа дуугарч ,

- Чи манай цэргийн ямар ангид нь орхсон гэж байна гэж Эвтибидагаас асуулаа .
- Тэгэхэд аажмаар биеэ гартаа авч , сэтгэлээ дарж амжсан сээтгэнүүр бүсгүй дуугарч:

Бослогын тугийг чиний анх мандуулсан өдрөөс эхлэн би өдөр бүр өглөөнөөс аваад орой болтол хатгах жадлах сургууль хийэ , бас морин сургуулв хийж байсан юм … би маү сайхан, гурван хурдан морь авчирсан гэж хэлээд , бас Спартак тийш харж, намайг чи өөрийнхөө бие хамгаалагчаар авахгүй юу ? гэжэ .

- Надад бие хамгаалагч байдаггүй юм гэж гладиаторуудын удирдагч хариулжээ .
- Эрх чөлөөнийхөө төлөө боссон боолчуудын цэргийн байгууллагын чи нэгэнт ромын цэргийн журмаар байглснаас хойш, одоо цэргийн чинь тоо дөрвөн легионд хүүртэл өссөн болохоор тэр цэргийн удирдагч чи, ромын цэргийн консул мэтээр эрх ямбөаа эдэлж нэр хүндээ дээшлүүлэхийн тул зохих тушаалын хүмүүсээр биеэ хүрээ лүүлж байвал зөв болно. Маргаашийн өдрөөс эхлэн чамд бие хамгаалах хүмүүс заавал хэрэгтэй болно . учир нь хорин мянган цэргийн тулалдаж байгаа байлдааны талбар дээр нэгэн зэрэг хэд хэдэн газар чи биеэр байлцаж чадахгүй , тэгээд чиний тушаалыг легионуудын дарга нарт хүргэж байх баруун гарын зарлаа нар хэрэгтэй болно гэлээ .
- Спартак энэ бүсгүйн ярьж байхад түүний гайхан харж ширтэн когсож байснаа үгээ хэлж дуусгахад нь:
- Чи бол ер бусын хүүхэн байна ! … гэж аман дотроо шивнэн хэлжээ .

Тэгэхэд нь грек бүсгүы бардам байдалтай дуугарч ,

- Түргэн зантай , зориг чангатай эр хүний сүнсийг агуулсан , эм хүнтий биетэй хүн гэж намайг хэлбэл дээр бизээ гэж хэлээд минут хиртэээ дуугүй байснаа дахин дуугарч ,
- Би бол хянуур ажиглагч , ухаан сэрэглэн , зүрх чангатай хүн юм , би грек лат хоёр хэлийг адилхан сан мэднэ. Өөрийнхөө бүх хөрөнгө болох зургаан зуун талант мөнгөө зориулахаар авчирсан тэр хэрэг, мөн

энэ өдрөөс эхлэн өөрийнхөө бүх амьдралыг баяр ёслолтойгоор зориулсан , тэр үйл хэрэгтээ би ноцтой тусыг хүргэж чадна гэжээ .

Бүсгүй энэ үгээ хэлээд протерийгаас хэдэх алхас хажуу тийшээ зайлсан гладиаторуудын бужигнаж байсан халз дээр очиж чанга исгэрсэнд босогчдод бэлэг болгон Эвтибидагийн авчирсан хоёр тулам алтыг ачаалсан морийг урдаа тууж нэгэн боол хүрч иржээ . Үүнийг тэгнэж авчирсан морь Спартакийн өмнө зогсчээ .

Залуухан грек бүсгүй зр\ориг шийдвэр түргэн авир зэргийг улам бүх гайхаж байсан Спартак , энэ бүсгүйд юу гэж хэлэхийг сайн мэдэхгүй удтал зогсож байснаа сая санаж: энэ лагерь бол эрх чөлөөгөө байлдан олж авахыг хүссэн боолчуудын лагерь мөнг юм . иймийн тул өөрсдийнхөө хэргийн төлөө байлдаж байгаа үбх боолд энэ лагерийг хаалга хэзээд нээлттэй байх нь зүйтэй . Ингээд чамайг гладиаторуудыг лагерь , баяртайгаар хүлээн вч байна. Чиний сайхан сэтгэлийнхэ үүднээс авчирсан энэ бэлгийг хүлээн авах тухай асуудлыг хэлэлцэхээр энэ орой холбооны ахлагчидад цуглрна. Харин , бие хамгаалагчаар ажиллахыг хүссэн чиний хүслийн тухай бол би одоо юу ч хэлж өгч чадахгүй байна. хэрэв гладиаторуудын удирдагч бие хамгаалагчтай байна гэ шийдэгдэх юм бол чиний хүссэнийг матахгүй л байх хэрэгтэй .

Спартак , бүсгүйд дахин баяр хүргэж, түүнд талархсан сэтэлийн энхрий зөөлөн үгийг ширүүн бөгөөд гунигтай дуугаар нэиж хэлээд , бүсгүйтэй салах ёс гүйцэтгэж майхандаа очлоо.

Бүсгүы чулун баримал мэт огт хөдлөлгүй нэгэн газраа зогсож , Спартакийн хойноос майхандаа орон ортол нь ширтэ харж байснаа , сая ухаан орж гүнээ санаа алдаж , Ромын лагерийн журмаар бол холбоонтондоо зориулдаг газар тийш нь газар ширтэн толгой санжлуулан аажим алхалсаар очиж , миний майхныг энд барь гэж боолчуудаа тушаажээ.

- гэвч , би Спартакт хайртай юм … гэж Эвтибида дөнгөж сонсогдом дуугаар шивнэн хэлжээ .
- Энэ үед нь Спартак , Крикс , Граник, Борторикс, Артоорикс, Брезовир нар болон бусад трибунүүдээ майхандаа дуудаж ирүүлээд тэд нартайгаа шөнө маш орйо болтол зөвлөгөөн хийжэ .
- Энэ зөвөлгөөн дээр шийдэж тогтоосон нь сээтэгнүүр грек бүсгүй бэлэг болгон авчирсан чөнгийг хүлээн авч түүгээр Кампаниы мужийн хавь

ойрын хотуудбн зэвсгийн дархны газруудаар олон зэвсэг ,
хуяг бамбай захиалах , грек бүсгүйд , бие хамгаалагч гэдэг хүндэт цол шагнаь олгож дээд удирдгчийн дэргэд байж түүний тушаал шийдвэрийг тарааж
байх есөн залуу эрчүүдийн хамтаар тэр орон
тоон оруулж авах Эвтибидагийн авчирсан зургаан
зуун таланть мөнгөөс арван талань мөнгийг гладиаторуудын цэрги йн үндсэн хүч
нь болох, олон мянган хүнтэй явган цэргийн харилцаанд илэрхий цөөдөж байсан
морьт цэргийнхээ оронд халаа морьк худалдан авахад зориулдах г эж тогтсон байжээ .

- Цэрэг дайны цаашдын ажиллагааны хувьд бол Криксийн хоёр легионы нь
хамтаар Нола хотод орхих тэгээд Крикс нь грачийн хамтаар энэ лагерьт хоёр
хоногийн өмнө ирсэн Равеннийн ьегионыг сургуулв хийлгэж байх , Спартак Броториксийн лщгионы хамт явж Бовинаумын дэргэд очиж Эномайтай нийлж шинэ цэрэг
ыбүрдүүэн авахаас урьтаж Коссиний вариний нарыг дайрах
гэж шийдсэн байжээ .
- Хотын дэргэд лагерилан сууж уйдсан Эномай , хоёр хоногийн түрүүнд эндээсээ хөдөлж , Сульма руу очжээ гэдгийг Спртак Борнианумд хэлж тагнуулын ангиас олж мэ джээ
. Энэ үед Вариний Сульмад цэрэг цуглуулж байна гэдгийг бас таг нуулынхаа хүмүүсээс мэдсэн юм .
- Спартак
, хэдхэн хоногийн дараа эномайд тохиолдох аюултай байдлын бүх талыг ойлгон мэдэж цэргүүдээ зургаахан уаг
амраагаад өөрөөс нь хоёр хоногоор урьтаж явсан Коссинийн хойноос хөөхөөр явжээ .
- Тогтсон каншлыг зөрчихөөсөө
айдаг бүтэлгүй хөгшин цэрэг Коссиний н өдөр тутам хорин миль , хэвийн журмаар аялан явсан байжээ . Спартак нв хөдлөх бзрдээ гуч гаруйя милээр хоёр ахин явж , Кассинийг Ауфиденын дэргэд гүйцэж довтлон сүрхий цохиж хойн оос нь салалгүй хөөсөнд аврагдах найдвараа алдаж ичсэндээ болж амв ь тэмцсэн Коссиний гладиаторуудыг эргэж дайран тэнцүүргүй хүчтэй тулалдаанд амь үрэгджээ. Маргааш нь Спартак хурдан аяллаа үргэлжлүүлэн явж, Эномайг ялагдах аюула

ас нь чөлөөлж ялалтанд хүргэж болох тэр цагаас нь хожимдолгүй хүрч очжээ . Спартак хүрч очиж явцын заяаг өөрчлөх үед, Эномай нь баран найман мянга шахам цэрэгтэй Варинитай тулалдажб айсан ба бас ромынхон хүчтэй түрэлтэнд автагдан хүрч ухарч эхэлсэн байна. ьариний багагүй их алдагдалд хүрч шуурхай зугтан явжээ .

- Спартак цэргүүдээ гурав хоног амраагаад , бүх Лациум даяар торйон явжээ . анагния , Арпинум, Ферентинум, Касинум, Фрегелл хотуудаар ороход хоёр сар хэртэй болжээ . Спартакийн цэрэг Лирисыг өгөрч , Норба , Суэсса- Помеция , Привернум хотудыг эзлэн
  авч Ром хотын хаалга руу ойртон очиход гладиаторудыг дээрэмчи д гэж үздэг ромынхон маш их айн сандарсан юм .
- Энэ хоёр сарын дотор Спартак нь маш олон боол гладиаторыг цуглуулсан учир ,
  дахин хоёр легион байгуулж бүрэнзэвсэглэж авсан юм .

Энэ
үед Публий Вариний нь сенатын сайшаан зөвшөөрсний ачар пиценчү үдийн хүч , авч түрүүн ялагдсаныхаа өшөөг авах хүслээр дүүрэн , наймдугаар сарын сүүлээр Аскулумаас гарчээ
. Вариний нь арван найман мянган цэргийн даргалан , Спартакийнхныг чиглэн хурдан аялан явсан м . Спартак энэ үед, Террацинад хүчр байсан бөгөөд Варинийн ойртон ирж яваа тухайг эндээс мэдэж , түүний урдаас нь тосч явсаар , Аквинумын дэргэд лагерилан буугаад байхадп нь түүн дээр хүрч очжээ . Есдүгээр сарын идын урьд өдөр (есдүгээр сарын 21) энэ хоёр их цэрэг завсраа уулзаж , шийдвэрлэгч тулалдаан эхэлжээ .
Энэ тулалдаан удааширч цус их асгаруулсан тулалдаан болж айлаа . орой тийшээ , ромынхон суларч гладиаторуудын галзуу түрэлтэнд аргагүй витагдан зутахад хүрсэн юм . Гладиаторуудын сүүлчийн түрэлт маш ширүүн байсан учир ромын цэргүүд бүр мөсөн сарнижээ .
Ялагдсан тэднийг тун ширүүн цавчлан яргалсан юм .

Вариний ,
ромынхны алдар нэриыг хмгаалахаар удаан зоригтой тулалдсан боловч Спа ртакийн гарт шархдаж , морио Спартакийн гарт аргагүй орхиж , аз дайрч амь гарсандаа залбирчээ . Энэ цус урсгасан тулалдаанд ромынхон дөрвөн мянган гаруй хүнээ алуулжээ .
Гладиаторууд дайсныхаа зэвсэг, ачаа бараа, байрны хэрэгсэл , тэдний легилнуудын туг даолбаа ба преторын өмнө явдаг хүндэт харуулы нь хүүртэл олзлон явсан байлаа .

# СПАРТАК ЛЕГИОЛНУУДАА ЭРГЭЖ ШАЛГАВ.

Претор Публий Вариний нь Аквинумын дэрэд цохигдоод сарниж тарсан арван найман мянган орчим уэргүүдээ цуглуулж хамгийн туршлагатай цэргийн удардагчийн бүх тактикийн д
дүрмийг урлуулож хэв заншил бүхнийг хөмөрснө үзэшгүй гладиатору Спартакийг өвлийн хүйтнийг харгалзалгүйгээр Ром тийш чиглэн хө длөхөд хүрвэл нь Аппиевийн ба Латинын замуудыг нэгэн зэрэг хамгаалах зорилгоор Норба хот тийш ухарч тэндээ хоргодон су урьшсан юм .

Энэ үед Спартак , цэргүүдээ урьд ромынхны сууж байсан байруудад байрлуулан амраажээ .

Тушаал хүлээж авахаас нааш, энэ лагериасаа хэрхэвч гарахгүй гэдэг ам шахааг Эномайгаас авч ,
түүгээр дөрвөн легионоо даргалуулан энд үлдээгээд Спартак гурван зуун морьт цэрэг дагуулан өөрөөс нь өөр хэнд ч үл мэдэх тусгай зорилгоор дагжжлан нууцаар гарч влаа .

Самниум ба Лациумээр Спартакийн аялан явах зуур нь Нола хотын эдргэд үлдсэн лагерьт нь боолчууд глаидаторууд бөөн бөөнөөрөө очиж байсан учир, Крикс , тав таван мянган хүнтэй гурван шинэ легион байгуулж Арторикс , Брезовир нар ба бас нэг кимвр омгийн , настаы хүнээр тус тус даргалуулсан ажээ . Вильмар гэдэг нэртэй , энэ кимвр язгуурын хүн нь догшин ширүүн авир зантай , архинд дурта боловч , авюрага их хүч чадалтай ариун шудрага зантай хүн тул гладиаторуудын дунд эрхэм сайн хүнд тооцогддог байсан юм . Цэргийн легионууд нь Спартакийн засан ёсоор хатгах жадлах сургуулв , тактикийн арга, дайран давших сургуулийг өдөр бүр хийдэг бөгөөд үүнийгээ их л дуртай , хичээнгүй оролдлоготойгоор хийдэг байжээ. Хүчинд автадан эсм орон, гэр бүл, хайртай дуртай бүхнээсээ хагцан салсан, лорой зантай энэ хүмүүс үнэнч хэргийнхээ баяртай төгсгөлийг үзэж, эрх ч өлөөгөө олж байх гэдэг найдварар зоригтой байсан ба эрх чөлөөний гэгээн тугийг дор бид явж байна гэдэг ухамсар нь доромжлонгдсон нэр хүндээ өөд татаж авах явдалд нь тусалдаг б айсн дээр бид бол агуу явдалт хүмүүс гэж итгэдэг болгосон юм . Амссан гашуун зовлонгийнхоо төлөө өшөө хонзонгоо аюах хүслээ дарлагчидтай зэвсгээ тэнцүүлж үзэх дур хүслийг тэдний дотор бадруулж байжээ . Энэ залуухан эргийн хүмүүсийн оргилсон хөдөлгөөнийг хүндэтгэн ба түүндээ хайртай бай даг явдал улам ч хүчтэй болгож байлаа .

Публий Вариний цэргүүдийг Спартак
, Аквинумын дэргэд ялжээ гэсэн мэдээ лагерьтаа хүрч ирэхэд бүгдээрээ бүх зүрх сэтгэлээрээ нэгэн зэрэг сайшаан , шагшин шуугиж хөгжилтэй дуу дуулж баяр хөөр , яриа хөөр болж байсан юм . Мирца , энэ их үймээн , бас ичх дүлийрэм шуугианыг сонсон , гайхаж бараг бзхэл өдрийг сууэ өнгөрүүлдэг майхнаасаа гарч хажуугаараа өнгөрч явсан нэгэн цэргийн хүнээс, энэ юун тухай их баяр хөөр болж байгаа юм гэж асуужээ .

- Спартак дахин ялж гэнэ!
- Спартак ромынхныг бүр мөсөн бут цохиж гэнэ! Гэхэд
- Хаана?… хэзээ?… яаж?… гэж бүсгүй бас асуужээ .
- Гурав хоногийн өмнө …
- Аквинумын дэргэд …
- Спартак тэр протерыг бут ниргэж морь туг ба хүндэт харуулыг нь цэргүүдийг хүртэл эзэлж авсан гэнэ гэжээ .

Энэ үед Арторикс , протерий дээрч хүрч иржээ . Энэ нь Мирцад ахын нь ялалтын тухай тодорхой хэлж өгөх гэж явса н ажээ . Гэвч Арторикс Мирцагиын дэргэд ирмэгцээ царай нь ув улаан болж чухам юунаас эхлэн ярьж өгөхийг мэдэхгүй болсон байжээ .

- тэгээд … Мирца , сайн байна уу гэж энэ залуу хэлээд бас нүднийхээ харааг хааш нь чиглүүлэхийг мэдэж ядан дэмий л тал бүр тийшээ харж зүүн мөрөн дээгүүр - чи мэдсэн биз… Аквунимын дэргэд гэнэ… бие чинв зкүгээр үү ? гэж асуужээ .

Тэгээд түр зуур тээнэглэзэж байснаа :

- Спартак маань ялсан хэрэг байээ гэж яриагаа төгсгөжээ .

Хэл нь тагнайдаа наалдаж , хэлэх гэсэн үгээ ганц ганцаар нь тасалж байсан явдал өөрт ньв болов инээдтэй санагджээ
. Аротриксын ингэж ичиж зовсны шалтгаан бол
Спартакт үнэхээр дассан бөгөөд ариун сэтгэлтэы , хонгор энэ үе, урьд өмгнө нь тохиолдож байсангүй их хөдөлж , дуугий нь сонсохдоо зүрх нь өгүүлшгүй цохилдог болсон юм .
Мирцагийн дуу түүнд сафигийн ятганы ариун хөгжмийн эгшиг мэт санагдсан сэтгэл санаагий
нь орчлонгийн гүнд шилжүүлэн санасан бодсон бүхний
нь замхруулан мартуулдаг байжээ .
Сүүлийн үед Арториксийн сэтгэл амтат баясгалангаар дүүрч, түүндээ өөрөө бүттэд шумбани жаргаж байсан боловч сэтгэлийн тур баяр

хаанаас яаж ирсэн тухай тааж мэдсэн ч үгүй мөн мэдэхийг ч хүссэн ч үгүй байжээ.
Спараткийг Саминум очсоноос хойш энэ залуу гладиаторууд , удирдагчийнхаа майханд олонт очиж Мирца бүсгүйтээ уулздаг байсан боловч чухам ямар хэргээр , хэзээ энд ирсэнээ өөрөө мэддэггүй байсн юм . Үгүээр ч үь барам энэ залуу элдвийг бодсоор явж лагериасаа гарч хэдэн миль холявчих л удаа үүнд олон тохиолдож байжээ . тэгэвч юу бодож явсаар явж тэгснээ өөрөө мэддэггүй байсан юм .
Ингэж энэ залуу Арторикс Мирцагийн майханд олонтой ордог болсон боловч Мирца хүүхн анзааралгүй сайхан үерхсэний хувьд түүнтэй ямагт дуртайя ярилдаг байжээ . Цаашдах тутам Мирцагиыйн өөрий нь байдал өөрчлөгдөж Арторикстой уулзахад сэтгэл нь хөдөлж царай эь улайж ичингүйрдэг болсон юм .
Тэгэхэд залуу эр , Арторикс өөрийн зүрх сэтгэлийг ажиглан судалж Спартакийн охин дүү Мирцад үнэхээр сэтгэлтэй болсноо мэджээ .
Мирцагийн байдал арай л эгэл биш болсныг Ароторикс ажиж энэ бүсгүй намайг үзэн яддаг болсноос ийм болсон биз гэж шийдээд ий м болсны шалтгаан бол өөрийн нь нэгэн адил янаг сэтгэслийн дөлд автсанаар болсон гэдгийг огтхон ч бодсонгүй . Энэ бүсгүйд миний дуралсантай адил хүчээр энэ бүсгүй надад дур ласан байх
гэдэгт өөрийг итгүүлэхийг Ароникс хүссэнгүй ба бүсгүйн хачин байда лтай болсны шаллтгаан бол өөрийн нь хачин байдалтай болсон шалтгаантай адил андастэй байсан гэж огтхон ч сансангүй . Ингэж , энэ хоёр хүн далд сэтгэлийн ковлонтой болж үргэлжид сэтгэл Түгшүүртэй байдаг болсон юм . ингэж энэ хоёр учрахы ямагт хүсдэг боловч бие биенээсээ буруулдаг , уулзахгүй байхыг оролдовч олонт дайралддаг :
уулзах үедээ ярилцахыг хүсэвч дуугүй байдаг: салах хэрэгтэй болжээ гэдгийг хоёул ойлгож байвч салж чадахгүй , бие биенээсээ нүдээ буруулан газар ширтэн хааяа нэгэн хулгай нүдээр харж удтал нэгэн газар зогсдог болсон юм .
Иймийн учир , Арторикс , Спартакийн шинэ ялалтын мэдээг сонсож фракий хүний майхан орох аятайхан шалтаг олсон юм . Дурласан бүсгүй дээрээ очих үүнээс илүү аян шалтаг байхгүй билээ . ийм их баяртай сайхан мэдээг , өчүүхэн зөрүүд зангаасаа болж Мирцад хэлэхгүй хүрвэл

дэндүү хүүхэд зантай хэрэг болохоор ч барахгүй шууд муухай хэрэг болно гэдэгт биеэ итгүүлэхийг Арторикс оролджээ Арторикс хайрт бүсгүйнхээ майхан
тийш шалав алхлан абяртй сэтгэлээр дүүрэн очиж явахдаа , энэ нэгэн удаад би ичих
айхаас болж царайгаа улайлган дуугүй байхгүй цэргийн эр
шиг зүрхтэй зоригтой байна гэж итгэж явсн юм .
Гэвч Мирцагийн дэрэд очмогцоо , түүний санаж бодож явсан сайхан төлөвлөгөө нь удаа утаа
шиг сарнин замхарч , саваагай явдал хийж байгаад багшдаа баригдсан бяцхан шавь шиг түгдрэн зогсож хэлэх
гэж бэлдсэн сайхан үзгнүүдээ нь нэг мөсөн мартжээ . Утга учир үл мэдэгдэх холбоогүй хэдэн үг хэлж цааш нь юу ч хэлж чадсангүй .
Бас бүсгүйн царай, ув улаан болж, бага цзэрэг түгдэрснийхээ драа:

- Арторикс аа , ахын нь баатр явдлын тухаы дүүд нь ингэж хэлдэг юм уу? гэж үоригтой байдал үзүлэхийг оролдон үл мэдэг чичирсэн дуугаар хэлжээ .
- Бүсгүйн энэ буруушалыг сонсон залуу эрийн царай улайж , зоригоо чангалан , Аквинумын тулалдааны тухай элчийн хэлж ирсэн зүйлийг тухай бүсгүйд дэлгэрэнгүй ярьж өгчээ .

Мирца Арториксийн яриаг анхааралтай сонсож,

- Тэгээдп Спартак шархдаагүы юу? Нээрэн шархдаагүы юм биз ? Түүнд ямар эгэн муу юм тохиолдсонгүы нь үнэн биз? … гэж асуужээ .
- Үнэн, үнэн! Аюултай бүхнээс , урьдынхаа нэгэн адил сэвгүй гарсан гэнэ.
- Тэр
нь тэнгэртэй боловч тэнцэхүйц зоригтой болох учир л би түүний хойноос минут бүр, цаг бүр сэтгэл зовж байдаг юм
гэж Мирца зөөлөн дуугаар хэлжээ .
- Сайхан сэтгэлт бүсгүй минь , санаагаа бүү зов.

Спартакийн гар нь сэлэм байгаа цагт түүний цээж өөд чиглэх сум байхгүй гэж Арторикс хэллээ .

- Тэр ч үнэн л дээ
, Спартак нь Аякс мэт ялагдашгүй хүн болохоос биш Ахиллес мэт үэхлгүй хүн биш гэдгийг би бас мэднэ гэж бүсгүй санаа блдан хариулжээ .
- Манай , шудрага үйл
хэргийг өршөөгч дээдэс тэнгэр манай эрхэм хайрт удардагчийн амь насыг өршөөж байдаг гэж залуу хэлжээ .

Хоёулаа дуугүй болцгоолоо .

Хөөрхөн биетэй, урьхан царайтай , цайвар үстэй бүсгүйг, Арторикс харцыг гакар тусаж сууж байсан Мирца хүүхэн , залуу хүн намайг ширтэн харж байна гэдгийг сэтгэлээрээ мэдэрч айсан бөгөөд дотор таалах баясах, ичих зовох сэтгэлийг нэгэн зэрэг төрүүлж байжээ .

Ингэж минут хир дуугүй сууцгаасан боловч энэ хугацаа нь бүсгүйд , зуун жил болох мэт санагдаж байснаа, гэнэт санаа авч , Арторикс тийш шийвдэртэй харж:

- Чи өнөөдөр легионоо , хээр аваачиж сургууль хийлгэхгүй юу? гэж асуулаа .
- Ээ , Мирца минь, мин й энд байх явдалд чи хичнээн их дургуйцнэ вэ? гэлээ .
- Үгүй, Арторикс аа, тийм биш гэж бүсгүй яаран сандран хариулаад , үгээ тасалж царай нь увулаан болж,
- Чамайг … ноогдсон ажилдаа ямангт шудрага байж, түүнээ ёсчлон хийдэг болох учраас л … тэгж асуусан хэрэг л дээ.. гэж бүсгүй түгдрэн нэмж хэллээ .
- Баяр ёслолоор Спартакийн ялалтыг тэмдэглэхийн тул өнөөдөр бүх легионыг бүтэн амраа гэж Крикс хэлсэн шүү гэж Арторикс хэлжээ .

Үгээр , энэ хоёрын яриа дахин тасалбар болжээ .

Мирца , гладиаторын чиг харалгүй байж

- Үүрд баяртай гэж хэлээд , майхан тийшээ явахаар шийдвэртэй хөдөлтөл:
- Мирца аа, битгий яваач , намайг сонсооч! Би чамд хэлэхийг хүссэнээр удсан зүйлээ хэлэх хэрэгтэй байна … үүнээ би заавал өнөөдөр чамд хэлэх ёстой! Гэж зориг орсон Арторикс яаран хэлжээ
- Чи надад юу хэлэх гэв? Чи надтай юуны тухай ярилцах гэв? Гэж залуугийн үгийг сонсож , гайхсан төдий биш , харин сэтгэл уйтгартай болсон Мирца асуужээ.
- За…миний хэлэхийг сонс… намайг уучил… би хэлэх гэсэн юм … хэлэлгүй болохгүй … гэвч чи миний хэлэх зүйлийг сонсож чамайг бүү уурлаасай гэсэн юм … учир нь миний буруу биш юм тэгээд… бас… хоёр сар ч болжээ гэж Арториксын үгийн холбоо тасалдаж нэгэн хэсэг дуугүй болсноо савнаасаа хальсан голын ус шиг гэнэт асгаран гарч:
- Би чамаас нууж байх мар хэрэгтнй болов? … хэлсэн үг байгаа байдал , сэтгэлийн зовлон энэ бүхнээс илхэн харагдаж байгаа

тэр чамд дурласан сэтгэлээ чамаас нууж байх
аргагүй боллоо, үүнийг нууж байх хэгэг юу байна ?
Чамайг гомдох биы гэж айснаасаа болж, чамайг няцах болов уу гэж шантарснаасаа болж, чамайг надад дургүй бол уу гэж сэжиглэж байсны улмаас болж одоо хүртэл дуугүй байсан юм . Одоо ерөөс тэсэж чадахгүй нь байна , чам руу тэмүүлэх давташгүй хүч, чиний сайхан харц, шингэн дуунд татагдсан дурлалаа хорьж барьж д ийлэхгүй боллоо. Ийм
сэтгэлийн зовлонт байдлын дор үүнээс хойш тэсэж би чадахгүй байн а, ингэж байхыг ч хүсэхгүй байна… үзэсгэлэнт сайхан Мирца минь би ччамд хайртай боллоо , дээдийн дээд хүндэтгэлээр хүндэтгэн явдаг Мирца минь , би чамд хайртай боллоо би өөрийнхөө туг болон Спартакт аль хэр хайртай байдагтайгаа адил чамд хайртай болсон, би чмд өөрөсөө илүү хайртай болсон . Хэрэв би чамд хайртай болсноороо, чиний духргүйцлийг хүргэсэн бол чи намайг уучлаарай. Миний өөрийн хүчин чадал давуу далдын сүрхий хүч , намайг ялжээ , би үнэнийг хэлж байна, тэр далд хүчийг даварх чадал надад үгүй байна! гэлээ .
Арториксын сэтгэл маш их хөдөлсөн уяир хоолой нь чичрэн , үгээ зөөлөн дуугаар хэлсэн юм . Одоо бүсгүй хариу шийдвэрийг хүлээж сэтгэл зовонтолгой дарж номхон зогсож б айлаа .
Мирца залуугийн үгийг, сонсож сэтгэл нь улам бүр хөдөлж байснаа нүдний нь харц улам улам томорсоор дара нь бүдүүн ширхэгтэй нулимсаар хоёр нүд нв дүүрчээ . Артоиксын үгээ хэлж дүүрэх үед , бүсгүйн сэтгэл тэсгэлгүй хөдлөн цээж нь оволзон амьсгал нь давхцаж байлаа . Бүсгүы нилээд удтал хөдлөлгү зогсож нүдний нь нулимс мэлмэрэн асгарч , тонгойж байсан залуугиын цайвар үстэй толгойг уяхан харцаар энхрийлэн харж минут хиртэй дуугүй байснаа:
Ээ, Арторикс минь ! Миний тухай хэзээ ч чи санаж байгаагүйсэн бол сайн байхсаан билээ, надад хайртай болсон тугайыгаа надад хэзээ ч хэлээгүйсэн бол бүр ч сайн байхсан билээ … гэжээ .
Тэгвэл чи надад сэтгэлгүй ажээ , би чамд аягүй үзэгддэг ажээ! Гэж цав цагаан болсон царайтай галл залуу асуужээ .
Агуу сэтгэлт , сайн явдалт залуу хүн чамд би сэтэлгүй ч биш сэтгэлтэй ч биш , чи надад аягүй ч санагддаггүй юм . Хамгийн алдартай хамгийн баян бүсгүй боловч чиний дурлалыг бахархан хүлээж авах ёстоы ,

гэвч чи надад дурласан дурлалаа зүрх сэтгэлээсээ зоригтойгоор арчин зайлуулж … намайг үүрд мартах хэрэгтэй байна … гэлээ .

Тэгэхэд нь хөөрхий тэр гладиатор Мирца тийш бишрэн асуужээ .

- Яагаад тэр вэ? Яагаад тэр вэ? гэж уйтгарт дуугаар асуужээ .

Хоолойгоо эцтэл уйлсан Мирца:

- Яагаад тэр вэ гэвэл , яагаад тэр вэ гэвэл чи надад дурлах ёсгүйы … яагаап тэр вэ гэвэл чи бид хочр бие биендээ дурлалцаж болохгүй ёстой … юм гэж нам дуугаар хариулжээ .

Залуу галл Мирцагийын гар дээрээс шүүрэн авахыг завдсан мэт түүний зүг хэдэн алхам ургаш явж түүний үгийг таслан :

- Юу ? Яана гэнэ ээ? Юу гэж хэлэх вэ ?… болохгүы ёсой гэв үү? Яагаад болохгүы ёстой болсон юм? … гэж сандран асуужээ .
- Болохгүй л ёстой юм даа! гэж уйтгарт боловч эрс дуугаар бүсгүй хариулж : - болохгүй ёстой юм! гэж би чамд хэлж байна шүү гэлээ

Мирца манайхан тийшээ явахаар завдан эргэж нэг алхам явсанд Арторикс хойноос нь явахаар шийдсэн бололтой хөдөлжээ . Гэвч Мирца зогсож, баруун гараараа хорих дохио өгч :

- Зочирхог ёсны нэрийн мнөөс , миний майханд үүнээс хойш ердөө бүү орж ирж бай гэж чамаас гуйя… үүнийг би Спартакийн нэрийн өмнөөс тушааж байна ! гэлээ .

Толгой дээр нь гэнэтхэн нурж ирсэн энэ аймшигт аягнанд бут ниргэгдсэн Арторикс хязгааргүй
хүндэтгэн биширч явдаг Спартакийнхаа нэрийг сонсож толгойгоо бөхийлгөн зогсож, цурхиртал уйлжээ.

Сэтгэлийн зовлонд дайрагдан Мирцагийн царай үхсэн хүний царай шиг цав цагаан болж, нулимсаа арай ядан барьж майхандаа орж далд орлоо .

Галл хүн ухаан балартан , үе мөч нь хөдөлгөөнгүй болж нэгэн газраа яг зогсож ,

- Дурлал :: цаж болох.. үгүй…ёс…той… дурлал… цаж… болох.. үгүй.. ёс…той.. гэнээ үе үе аман дотроо шивэгнэж байлаа .

Лагерийн хэмжээгээр тархсан хүчтэй хөгжмийын дуу
Арториксын зогсонги байдлаас гаргажээ .

Арториксын чих аюултай их дүржигнэн шуугиж байсан учир тэр чимээг намруулахаар хоёр гараараа толгойгоо барьж согтуу мэт гуйвсаар преторий дээрээс зайлж одлоо .

Гладиаторууд Аквинумын дэргэдэх тулалдаанд Спартакийн
ялсан явдлыг хүндтэй ёсоор

тэмдэглэж өнгөрүүлэхээр майхнуудаасаа дуу хуур болж ёслолын дуу дуулж наргиж байяаж байлаа.
Энд ингэж байх үед , Спартак гурван зуун морьт цэрэг дагуулан Ром хотыг чиглэн морины хурдаар давхиж байжээ. Гуравхан зуун хүнтэй байж Аппиевын замаар , өдрийн цагт явах явдал аюултай гэж Спартак үзээд шөнө болгож замд мордсон юм , тэгээд үүр цаймагц замаас зайд байгаа чмар нэгэн партицийн ордонд юм уу , эс бол ой доотр нуугдаж явжээ . Аквинын лагериас гарнаас хойш гурван хоногийн дараа шөнө дундын хир Лабик гэдэг газар хүрч , энд аюул багатай
нууц нэгэн газар морьт отрядаа лагерилан буулгаж , энэ ортрядыг даргалж явсан самнит хүнийг дуудаж, энд намайг хорин дөрвөн цаг хүлээж бай гэж гладиаторуудын удирдагч түүнд тушаажээ .
Хэрэв түүнийг (Спартакийг) энэ хугацаанд багтаж ирэхгүй бол отряд нь ирсэн замаараа дээрх журмаа сахиж Аквинумдаа буцах ёстой байжээ.
Спартак ганцаар , дан морьтой , Тускулум очих замаар явжээ.
Энэ эртний хотыг хүрээлж байдаг үзэсгэнэлт сайхан толгод дээгүүр Лациумын эрүүлжүүлэгч агаараар амьсгалахыг хүсэж энд зүг бүрээс ирдэг ромын патрицуудын олон олон орд харш байдаг байжээ .
Спартак хотоос хоёр миль зайтай газар явахдаа , тариадангийнхаа газар очиж явсан нэгэн тариачин хүнээс, Луциы Суллын бэлбэсэн
авхай Валерия мессалын ордонд очих зам асуужээ . Ингэж замдаа сайн мэдэж аваад зам хэлж өгсөн хүнд баяр хүргээд , сайхан хар морио ташуурдан , заасан замаар нь орж давхилаа . Спартак удалгүй ордонд хүрч, дуулганыхаа саравчийг
буулгаж хонх татаж хаалгачийг дууджээ.
Консул Лукуллын армийн , Марк Валерий Мессала Нигерийн когортын нэгэн цэргийн хүн ирээд , үеэл ахаас нь явуулсан маш чухал мэдээг валерия авхай дээр оруулж өгөхиыг хүсэж байна гэж ордны даргад айлтган намайг оруулж аль гэж хаалгачаас хүссэнд , тэр хаалгач ордны даргыг сэрээхийг ер зөвшөөрөхгүй байлаа .
Спартак арайхийж байж, хаалгачийг үгэндээ оруулж, ордны даргатай уулзаж түүнтэй түр ярилцжээ . Гэтэл ордны дарга хаалгачаасаа ч улам зөрүүд хүн байжээ.
Ордны дарга , Спртакийн ямар ч баталгаа гуйлтыг огт хэрэгсэхгүй , энэ эрт эзэн авхайгаас сэрээхээс шууд татгалзжээ .

- За тэгвэл , яахав, сайн хүн чи, грек бичиг мэддэг үү? Гэж асуужээ .
- Лат үсэг тун муу мэддэг учраас бас … грек бичиг мэддэггүй гэж тэр хариулжээ .
- Трибун Мессалаас намайг үеэл дүү рүүгээ явуулахдаа надад өгч явуулсан үнэмдэх бичгийг гаргаж уншиж чадах грек хэл мэдэх ямар нэгэн грек боол буюу өөр ямар нэгэн хүн энэ ордонд олдох болов уу? гэж асуужээ .
- Спартак , үнэмлэх бичгээ эрж байгаа хүн болж өврөө уудлан , ордны даргын хэлэх хариуг сэтгэл зовон ихүлээж байсан юм . Хэрэь грек хэлээр уншиж чаддаг хүн ордны дотор бий гэж хэлбэл нь үнэмлэхээ гээсэн байна гэж Спартак хэлэх байсн ажээ.
- Гэтэл ордны дарга гүнээ санаа алдан, толгой сэгсэрч уйтгартай царайгаар инээмсэглэн:
- Грек ба грек бус ялгалгүй бүх боол энэ ордноос зугтан, гладиаторуудын л агерь луу явчихсан … гээд дуугаа сулруулан…
- Үзэшгүй муу сайн гладиаторууд , үүрд буруутггч үл бүтэх тэр муу сайныг дээдийн дээд Юпитер үнсэн товрог болгох болтугай ! гэжээ .
- Энэ үгийг сонсож, Спартакийн уур маш их хүрч , ярилцаж байса тэр хүн нь хэдийгээр настай хүн байсан боловч , түүнийг зодож орхимоор санагаж байжээ . Гэвч биеэ барьж Валериягийн ордны даргаас ингэж асуужээ .
- Гладиаторуудын харахаар юунд дуугаа нам болгосон бэ ?
- Яагаад вэ гэвэл … Спартак урьд валерия ба түүний агуу их эр Суллын гэр бүлд хамаарагддаг хүн байсн бөгөөд тэдний гладиаторын сургуулийн кахирал байсан юм … миний онцгой сайн эзэн валерия – түүнийг минь тэнгэо өршөөж, удаан жилийн баясгалант жарглыг ивгээж байх болтугай- Спартакийг агуу их хүн гэж үздэг сул талтай юм … тэгээд Спартакийн тухайд муу хэлэх явдлыг огтхон ч хүлээдэггүй юм тэгээд би тэр тухай нам дуугаар хэлсэн юм гэж хариулжээ.
- Юу гээчиын тэрслэгч эм гээчив тэр чинь…. Гэж Спартак тоглоом болгон хэлжээ.

Тэгэхэд нь ордны дарга хоёр алхам хир хойшоо ухарч, өөртэйгээ ярилцаж байсан энэ хүний хөлөөс нь толгойий нь хүртэл ажиглан ширтэж хараад:

-Ээ чи муу цэрэг , миний хүндэтгэлийн дээж болсон эзэн авхайгий минь ийм муу үгээр шоглох гэв үү чи ! гэжээ .

- Харин сүрхий л хэрэг байна даа!… би түүний чинь огт хараахыг хүсээгүй …
  харин Ромын алдарт авхай байтлаа гладиаторуудын талд байдаг нь .. хашаа юм гэхэд
- Тэр ч үнэн л дээ … энэ бол авгайн сул тал нь юм … гэдгий би чамд хэлсэн шүү гэжээ .
- Би ч ойлгож л байна л даа! Хэрэв боол хүн чи , эзэн авгайнхаа энэ сул талыг патриций хүнд байж болошгүй тал гэж үзэж байгаа болчөлөөтьэй иргэн би чиний эзэн авхайн тэр сул талыг бас тэгж үзэж болдог байгаа даа гэжээ .
- Үүний бүх буруу нь Спартакт л байгаа юм .
- Тэгэлгүй яах вэ , Плутоний очир сүлдээр тангаргалая!… бүх буруу нь Спартак байгаа юм гэж би ч бас хэлж байсан шүү дээ . Спартак л сайхан сэтгэлт язгууртан авхайн сэтгэлийг өөртөө татаж л дээ … гэж Спартакийн хэлэхэд
- Тэр чинь - үзэшгүй муу гладиатор юмаа гэж ордны дарга хариулжээ .
- Спартак чамд ямар муу юм хийсэн бэ? Чи яагаалд түүнийг үзэн ядав?
- Чамд ямар муу юм хийсэн бэ гэж чи надаас асууна уу? Ямар муу юм хийсэн бэ гэнэ ?
- Яагаад би чамаас үүний тухаы асууж багаа юм гэвэо зальхай луйварчин хүн чинь боолчуудад эрх чөлөө олгох ту хай зарласан юм гэж би сонссон юм чи өөрөө боол хүн болох учир түүнийг дэмжих ёстой байсн атлаа гээд, түүний хариу үг хэлж амжихаас урьтаж
- Аль чи өөрөө, худал дүр үзүүлж байгаа юм уу… гэжээ .
- Намайг , худал дүр үзүүлж байна гэнэ чи… намайг худал дүр үзүүлж байна гэнэ чи! I Шүүгдэр тэр өдөр Минос чамд өршөөл болох болтугай! Чи намайг худал дүр үзүүлж байна гэж хаанаас яаж санав?… Тэр бузар Спартак санаачилсан
  тэнэг зүйлээрээ намайг хамгийн дорой заяатай хүн болгосон хүн . Би боол хүн боловч хоёр хүүгээ дэргэдээ авч байхдаа хамгийн аз заятай хүний нэг байан юм ?… Миний тэр хоёр хүү мөн ч сайхан залуучууд шүү ! хэрэв чи тэдний минь харсн бол доо ! хэрэв чи тэднийг минь мэдсэн бол доо! Тэр хоёр минь ихэр юм , ээ бурхан минь ээ, сайхан хөвгүүд Кастор, Поллукс хоёр шиг хоорондоо мөн ч адилхан шүү … гэлээ .
- За тэгээд , тэр хоёр чинь яасан юм? …

- Гладиаторуудын лагерь луу явсан юм, мэдээ чимээ байлаггүй болсоор гурван сар болж байна… амьд байдаг юм уу , хэн мэдэх ажээ ? … хэн мэдэх аж дээ… Самниумыг өршөөгч Сатурн өшөө , өшөө тэр хоёры минь , миний хоёр муухай хүүн миний хайрт хоёр хүүг амьд мэнд явуулах болтугай ! Гээд өвгөн цурхиран уйлж гарлаа . Спартак түүнийг гайхан өрөвдөж минут хиртэй дуугүы харж байснаа
- Боолчуудад эрх чөлөө олгохыг хүссэн Спартакийг муу хэрэг хийжээ . Түүний хойноос дагаж очсон чиний хоёр хүү мөн муу юм хийжээ гэж чи үзэж байна уу? гэж ордны даргаас асуулаа .
- Самниумыг өршөөгч бүх тэнгэрийн өмнө тангаргалая!
- Ромын өмнөөс босно гэдэг чинь – муу хэрэг байхгүй яахав. Тэр тэнэг, гладиаторууд чинь ямар эрх чөлөөниы тухай хэлж байгаа юм ? Би бол Самниумын уулсад эрх чөлөөтэй хүн болж төрсөн юм . ИРгэний дайн гарлаа … (Та нарын төлөө ба Италид оршин суугч бүх хүмүүсиын төлөө иргэний эрхиыг олж авахыг бид хүсэж байна) гэж манай удирдагчид хашгардаг байсан юм . тэгээд би босоцгоосон юм , тэгээд бид тулалдаж гарсан юм ... тэгээд дараа нь яасан бэ … яасан ч юмгүй л, Самниум нутгийн чөлөөтэй салчин хүн байсан ба Мессалын гар бүьлийнхний боол болон хувирсан юм . Энэ сайн сэтгэлт , ариун төлөв гэр бүлийн боол болсон би муугүй л байна. Чөлөөтэйы самнит язгуурын хүн байсан миний гэргий бас боол шивэгчин болж, боолын байдалд хоёр хүү төрүүлсэн юм тэгээд… гэж өвгөн үгээ тасалж түр дуугүй байсныхаа дараа:
нь улбар ягаан биш байсан бол түүний цээж хүзүү, иөр нүүрний нь пароосcий н хосгүй цагаан бөгөөд тунгалаг гантиг чулуугаар , Фидийн мөнх дурсгалт урчуудын барьж бүтээсэн баримал уу гэмээр байсан юм . түүний цэвцэнхэр нүд нь сэргэлэн цогтой бөгөөд бас ширүүн бусдын сэтгэлийг соронзон шиг татахуйц харцта ажээ . Шижир алт шиг улбар шар өнгөтэй , мяндсан нарийн ширхэгтэй боловч, өтгөн үсний нь туяа нүүрэн дээр нь тусчээ .

Анхныхаа нөхөрт хаягдсан , үзэсгэлэнт сайхан энэ хүүхний дэргэд түүний дөнгөж арван дөрөв хүрсэн дүү Клодий ирээдүйн ардын догшин трибун болох хүн зогсож байжээ . Гэвч тэр хүүгийн одоогийн хүүхдэрхүү дэлгэри царайгаараа нь хэдхэн жилийн дараа ромыг атаа хорсол аллага хядлагаар дүүргэх харигс ш ирүүн хүн болно гэж хэн ч тааж мэдэхгүй байжээ .

Кассий Клодия хүүхнийг минут хир дуугүы ширтэн гайхаж ба йснаа ,

Хөнгөн бишрэлт хүмүүсиын сайшаан магтдаг ,
Венер ба диана нар ч энэ бүсгүйгээс гоё байж чадашгүй ! гэлээ

Тит Лукреций Кар инээмсэглэн.

- Энэ хүүхнийг чи Венертай ганц л
  Венертай зүйрлүүл харжин дДианыг зоргонд нь
  орхи түүний үзэсгэлэн гоoo нь энэ зоосчин хүүхний
  гоо сайхантай эн зэрэгцэж чадахгүй гэлээ .
- Энэ сайхан хүүхэнд, зоосчин гэдэг гутамшигт хочийг хэн өгөв ? хэн үүнийг доромжлов? Гэж Кассий ууртай дуугаар асуужээ .
- Хөнгөн завхай явдлаараа энэ хүүхнээс дутахгүй боловч царай зүсээр түүнд хүрэхгүы , бас энэ хүүхнийыг бодвол ичгүүргүй зангаар арай даруу авгай нарын атаа хонзонгоор тийм ч хочтоы болсон биз тэгээд тэд энэ хүүхнийг хорт үгийнхээ бай болгож үзэн ядах сэтгэл илэрхийлсэн биз гэжээ .
- Клодияг зоосчин гэж анх хочилсон авгай тэр байна!
  гэж Меторбийы хэлээд ав , патриций авгайн хуцастай бас маш гоё боловч бараг ширүүн гэмэр хүйтэн царайтай авгайг
  зааж харуулжээ .
- Хэн бэ? Теренция юү… Цицерионы эхнэр үү?
- Тийм ээ … түүнийг номхон даруу нөхөртэйгээ зогсож байгаагий нь хараа биз! гэлээ .
- Катилинатай учлдсан бузар холбоо нь
  хүн бүхэнд хэлэгдсэн Фабиы дүү тэр эм бусдын алдаа дутагдал , заввхрал самуурлыг шоолдог нв таарч дээ!
  Аврага биетэнд тангаргалая! Гэж лукерций шоолдог нь таарч дээ!

Аврага биетэнд тангаргалая!

Гэж Лукреций шоолон инээмсэглэж хэллээ.

- Метробий итгэл тасарсан байдалтай толгой сэгсэрэн:
- Ромынхон хянан шалгагч түшмэдийг дотроос хамгийн гуйвалтай хамгийын хатуу ширүүн нь байсан Катон энэ үед амьд байсан бол одоо энд маш дэлгэр болсон завхайрал самуурлыг засахын тул юу хийх хэрэгтэйг бас шийдэж чадахгүй байхсан байлгүй . Завхайралын улмаас Ром хотод- оршин суух эрхээ алдсан эмэгтэй бүхнийг Росоос зайлуулна гэж шийдвэл Каст ор ба Поллукс нарт танграгалая! Ром хот дан ганц эрэгтэй сүүдэг хот болгон хувиргахсан билээ тэгээд хүн төрлөхтөн цаашдын уламжлалыг байлгахын тул Квирин бурхан сабинын хүүхнүүдийг дахин хулгайглан авчрах явд ал шаардагдах билээ . тэгээд бас одоогийн маань сабиний хүүхнүүд хулгайлсан хүүхгүүд байж чада ж байна уу үгүй юу? гэжээ .
- Яана гэнээ, Меторбий үзэл санааны задралын эсрэг үг хэлнэ гэнээ, хувилгаан Эпикурт тангаргалая мөн ч сонин хэргээ! Чмаайг хянан шалгагч түшмэл болгоё гэдэг ухуулга хийж хамгийн түрүүчийн сонгууль дээр чинийы төлөө би саснадаа өгнө ! гэж Лукреций хэлжээ.
- Энэ үед бөөгнөрч байсан хүмүүс нийтдээ уаашаа хөдөлж явахада мөн Кассиы ч нөхдийнхөө хамт явсаар Клодиягийн зогсож байсан газарт ойрхон байсан Вестын сүмийн портизийн довжооны дэргэд хүрч очлоо .

Тэгэхэд , Кассий баруун гараа уруулдаа хүргэж

- Ромын сайхан хүүхнүүдийн дотроос хамгийн ёсайхан клодия чамд баяр хүргэе! гэж түүнтэй мэндэлжээ .

Залуу хүүхэн толгойгоо бяцхан дохиж , мөн маш хонгор инээмсэглдэн Кассийн мэндлэлд хариулж , түүнийг оргилсон харцаар удаан харж байжээ .

- Энэ чинь мөн ч олон юм амлаж байгаа харц байна даа!

гэж Лукреций инээмсэглэн Касситйд хэлжээ .

энэ хүүхннийг зүг чиний сэтгэлийн тэмүүлэх нь бүрэн зүйн хэрэг байна. ганц хөнгөн завхай явдаьай грек хүүхэн Эвтибидагаас өөр энэ хүүхнээс сайхан хүүхнийг би үзсэнгүй гэж Метробий хэллээ . Лукреций энэ нэрийг сонсмогцоо падхийтлээ цочиж- Эвтибида гэв үү! гээд түр зуур дуугүы байснаа санаа алдаж :

Эвтибида мөн ч сайхан хүүхэн шүү! … одоо тэр хаана явдаг бол ? … гэжээ .
Чи ч үнэмшихгүй биз ээ . тэр чинь одоо гладиаторуудын лагреьт байгаа шүү дээ . Үнэн шүшү! гэлээ .
Үнэмшихгүй яахахв, харин түүнийг тэнд байдгийг би зүй ёс гэж үшзэж байгаа тэр чинь , өөртөө тохирсон газар байгаа юм гэж Лукреций хариулжээ .

- Эвтибида тэр дээрэмчдийн лагерьт байдаг бол тэд нарын нэгний дурлалыг биедээ татах , ганцхан зорилготой юм . Эвтибида өөрөө Спартакт учиргүы их дурлсана юм гэдгийг мэдээрэй гэжээ .

Түр зуур дуугүйы зогсжээ .
Тэгж байтал Меторбий , Лукрецийд хандаж

- Үзэсгэнэлт сайхан Эвтибида , намайг гладиаторуудын лагерьт очихгүй юу гэж олон удаа хэлсэн юм . Чи түүнийг мэдэхгүй юу ? гэхэд.
- Чамайг тэнд очиж яах гэсэн юм ? гэж Лукреций гайхаж асуужээ .
- тэнд чамаас дарс уулгах гэсэн айлгүй , гэвч чи ромд ч дарс багагүы уудаг шүү дээ, тийм ээ… гэж хажуунаас нь Кассий хэлжээ .
- та хроёр шоолж л байна уу… би бас тийшээ очих л байсан юм
- хаашаа , тийшээ?
- Спартакийн лагерьт хувцсаа сольж өмсөөд мөн нэрээ буруулж тэнд очоод түүий төлөвлөгөө зорилго бэлтгэлий нь тагнаж нууцаар консулдаа мэдээлж байхсан бидээ гэжээ .

Хоёр залуу патриций чанга инээжээ .
Меторбий уурлажээ .
- та хоёр бас шоолж байна уу? Гладиаторуудын бослого болох байна гэж хоёр жилийн өмнө консул Луций Лициний Лукуллад очиж би хэлээгүйсэн бил үү? Фуррина дпагинын торлог дотор болж байсан хуйвалдааныгш би илрүүлээгүй бил үү? Гэжээ .

Арториск , Метробийг ууртай ширвэн харж

- Аа тийм бий мэдлээ гэж дотроо боджээ .
- Энэ үед шахцалдаж явсан хүмүүс агуу сайхан брилгатай Сатурнын сзмд хүрчээ . Энэ сүмийн тахилын ширээний цаана хууль цаазууд ба төрийн сан байдагб айжээ . Энд хүмүүсийн шахцалдах нь улам их байсан учир улам ч аяархан явцгаажээ .
- Олон хүнтэй шахцалдан , үхтлээ ядарсан Меторбий Лукреций Кассий нарын

хойноос Арторикс явж сүмийн үүдэн дээр арван таван минут орчим шахцалдан зүтгэж б айж сая см дотор оржээ . мал аж ахуй , газар тариаолангийн ажлыг гүйцэтгэгчдийг төлөөлүлэн үзүүлсэн дүрсүүд ийг дотор гарт нь цэцэрлэгийн хутга бариулан маш уран чадвартай хийсэн Сатурнын хүрэл дүрийг тэд харжээ . хүрэл Сатурнын дотор тал хөндий ыбөгөөд , элбэг дэлбэг арин байхын билдэг тэмдэг болгон тэр зайг олив самрын тосоор дүүргэж байдаг ажээ .

-

Цезарь бурхын алдрыг хүндэтгэн тахил өргөөд тахилын хувцсыг тайлж , сүмээс гарч яваа нь харагдлаа .

Метробий түүнийг харж :

- Хараач хараач тэр гэгээн дүрт Цезарь Семпроныг үзэсгэлэнт гоо бөгөөд цэцэн ухаантай Семпрония хүүхнийыг яасан сүрхий харж байх юм гэжээ .
- Хумих жолоогүы Семпроныг яасан их харж байх юм гэж хэлж болох л байна!
- Хараач, тэр бүсгүйн янаг дурлалын хөө хар нүдэнд нь юутай оч гялалзан ! … тэр бүсгүа Юлийд юутай сайхан инээмсэглэсэн хариулав!…
- Бас , бусад язгууртан авхайчууд ба бүсгүйчүүд Цезарийн хойноос юутай урьхан харнав!…
- Улаан үст Фаустаг бас хараач!…
- Тэр чинь миний үхэлгүй мөнх хувь заяат найз Луций корнелий Суллын охин юм шүү .
- Чамайг , тэр гайхал амьтны сайн анд , ичгүүргүй нөхөр нь байсан юм гэдгийг бид мэднэ. Гэвч ы тэр тухайгаа чамайг ахин дахин хэлж байгаасай гэж огт хүсэхгүй байна.
- Тэр бас ямар шинэ үймээн гараад ирэв?
  Сатурнын алдар нэрийг хүндэтгэн улам чанга ориллодох чимээ гарч байгаа сүмийн хаалга руу харцгаалаа .
- Ядарсан царайтай эцэнхий туранхай бөөн хүмүүс хотын преторыг гар дээрээ дамжлан явцгааж байгаа нь харагдлаа .
- Аа!.. мөн… мөн!… би ойлголоо!… тэд нар чинь Мамертин шоронд сууж ял эдэлж байгаад заншлын ёсоор эн э өдөр суллагдсан хүмүүс байна гэж Лукреций хэллээ .
- Тогтсон заншлын ёсоор тэд нар , гар хөлийнхөө гав гинжийг хувилгаан Сатурнын тахилын тавиураас өлгөх гэж ийшээ иржээ гэж Метробий нэмж хэллээ .

- Кассий тахилын ширээний дэргэд зогсож гоё нэгэн бүсгүй тийш ширтэн харж б айсан догшин ширүүн дүртэй патрицийг зааж :
- Катилиныг хараач, яасан аймаар хүн бэ? дурлахдаа хүртэл бай ширүүн догшин байдаг байна. Гереницн ы дүү бүсгүйг ямар зэрлэг ширүүн , ямар шунахай харцаар тэр харж байх юм бэ
-

Аротрикс патрициг харж, нүдэнд нь баярын оч гялалзан Катили на тийш дөхөж очих гэж байдаг хүчээ үавхан дайчилж олны дотуур шахцалдан зүсэж явлаа .
- Гэвч хүсэх хүслээ биелүүлэх хоёр бол хоёр өөр өөр хэрэг байлаа . Залуу галл хүн хагас цаг шахцалдан тэмүүлсний дараа сая Луцины Сергийын дэргэд хрч очлоо . Арторикс , Катилинын чихэнд :
- Гэрэл эрх ч өлөө гэсэн үгийг шивнэн хэлжээ .

Катилина палхийн хурдан эрргэж , хөмсөг зангидан
- Энэ чинь юу гэсэн үзг вэ? гэж амьтдыг тоглуулагч алиа хүнээс ширүүн асуулаа
- Спартак намайг явуулсан , Катилина чамтай маш чухал хэргийн тухай ярилцах гэж Апулиягаас би ирлээ гэж Арторикс намуу дуугаар хэлуээ .

Патрици залуу галл хүн тийш шалав харж :
- Чиний хэлэх юмыг сонсъя.. сүм дотроос гаръя… тэгээд миний хойноос яваарай .. хоёулаа ямар нэгэн тохиромжтоы далд газар очъё гээд хүн амьтныг тоомосрлодоггүй зантай Катилина хүчирхэг тохойгоороо ярж олны дундуур зам гар гаж , сүм дороос гадагш гарахад Арторикс түүний хойноос хоцролгүй дагаж явжээ .
- Аврага биетний сүмийн ахжуугаар өнгөрч ариун дагинын сүмийн зүг очиж , Катилина зогсжээ .
-

Арторикс Спартакийг захиж даалгасан бүх зүйлийг Катилинад я рьж мөн гладиаторуудын цэргийн хороодын хүчин ёадлыг их л халуун тайлбарлан үзүүлж , Катилины бахархалыг дуудан гаргаж чадаад хэрвээ, Луций Сергий Катилинаар удирдуулбал өди й төдий ширүүн тулалдаанууд хатуужисан жаран мянган боолын зориг шийдвэр нт хэвий чинээ дахин нэмэгдэхэв , тэдний тоо нь ямар богинохон хугацааны дотор хоёр дахин олон болохов яаж ялалтаас ялалтад хүрсээр байж ганцхан жилийн дотор ялагдашгүй ялалтанд хүрсээр байж

ганцхан жилийн
дотор ялагдашгүй хүчин болж Ромын хаалганад тулж очихов гэдг ийг батлан хэлж чадлаа .

- Энэ үгийг сонсож, Катилинагийн нүдэнд фуст гал асаж, шүрүүн догшин царайтай нүүрний нь булчин шөрмөёсүүд таталдан хүчирхэг гараа үе үе сүрхий ширүүн зангидан санаа алдаж байгаа дуу нь зэрлэг араатны архирахтай адил байжээ .

Артоиксын үгээ хэлж дүүрэхэд:

- Залуу хүн , чиний хэлсэн энэ бүхэн миний дурыг татаж байна… гэвч надад чамаас нуух зүйл үгүй байна. хэдийгээр тэр хүмүүс чинь зоригт эрчүүд боловч, боолчууд , босогчид шүү дээ . тэд нарын удирдагч болно гэдэг нь ромын хүн, патриций миний дотор ялагдашгүй гутамшигт сэтгэлийг төрүүлж байна. юу ч л гэсэн … их хэргийн төлөөтрөснө боловч, одоо хүртэлд ямар нэгэн мужийг захирах эрхийг олж авч чадахгүй яваа надад … Өөрийнхөө эрх мэдлийн доор ийм асар хүчирхэг армитай болно гэдэг бодол бол …
- Патриций язгууртай ромын хүн болж төрсөн юм гэдгээ мартах хүртэлд ухаан чинь балартаж , тархи чинь дүрэлзэхгүй биз , бидний толгой дээр сууж байгаа олигархи захиргааг устгахад хүрвэл урван тэрслэгч - дайсан боолчуудын тусламжаар биш харин зэвсэг барьсан ромын чөлөөт иргэдийн гараар хийх ёстой гэдгийг чи мартахгүй биз гэж энэ үед сүмийн булангийн цаанаас гарч ирсэн патриций хэллээ .
- Энэ хүн гуч гаруй насны бөгөөд бие сайхан барьж явдаг боловч, үлэмж ихэмсэг ажээ .
- Лентул Сура! Чи энд байна уу? гэж Катилинагаас гайхан хэлэхэд:
- Тийм ээ энд байна . Чамтай яваа энэ хүн надад сэжигтэй снагдсан учир би чиний хойноос данаж явсан юм . Ромыг гурван Корнилий цувран ноёрхох ёстой гэдэг нь заяагаар заагдсан юм гэдгийг би нэг биш удаа ёчамд урьдчилан сануулсан билээ .

Корнелий Цинна, Корнелий Сулла хоёр Ромыг захирах өнгөрлөө. Гуравдахь Корнелий чиний Ромыг захирах цаг чинь болсон нь заяагаар заагсдан хэрэг . харин өнөөдрийн хувьд бол би чамайг зорьсондоо хүрэх
цагаа ойртуулахын оронд холдуулах алдарт алхам хийхээс чинь зайлулах гэж байна гэлээ .

- Тэгвэл Лентул чи, өөрөө ийм сайхан тохиол дараа хэзээ нэгэн цагт надад тохиолдох байх гэж саанж байна уу? тэгвэл чи тавьсан зорилгоо биелүүлэхийн тул гладиаторуудын цэрэг шиг ийм сүрхий цэргүүдийг цуглуулж бид чадах байх гэж санаж байна уу? гэж асуулаа .
- Хэрвээ гладиаторуудын тусламжийг авахал хүрвэо манай ард түмэн биднийг үзэн ядах болж , бүх итали биднээс буруулах болно гэж би бодож байна. Тэгэх дээр хүрвэл , бид р ромын чөлөөтэй боловч, дутуу эрхтэн иргэд угсаа, залгамжлах эр хээ алдагдсан ба өргөн нийтийн төлөө биш харин ромын нэрийн эсрэг тэмцсэн байгаа зэрлэг боолчуудын төлөө тэмцсэн хэрэг болно… гэж бодож байна. тэр зэрлэгүүд , биднийг нөхдийн анхаарал халамжаар ромын эзэд болсныхоо дараа ямар нэгэн хууль , ямар нэгэн торонд баригдах байх гэж чи санана уу? Тэд нар чинь иргэн бүхнийг дайснаа гэж үзэж биднийг хүртэл яргалах болно гэж Лентул хэллээ .
- Лентулын яриаг цааш нь сонсох тусам Катилинын оргилж байсан сэтгэл нь аажмаар замхарч байгаа нь түүний хөдөлгөөн бүрд тодхон үзэгдэж байлаа . Сурагийн үгээ хэлж дүүрэхэд урьд Гратидианыг гардан алсан Катилина уйтгарлан толгой дарж:
- Чиний үг , хурц иртэй испани юлд мэт, эрс шулуун зүсэж байгаа гэж гүнээ алдан шивгэнэь.

Лентулд ямар нэгэн юм хэлэх гэж Арториксын завдтал тэр нь байз гэж заан дохиод .

- Чи одоо явж Спартактаа оч! Тэгээд , тэд нар танай эрэлхэг зоригийг магтан сайшааж байна , гэвч бид бол Ромын хүмүүс шүү дээ гэж байна гэж хэл. Эх оронд минь аюул нөмөрч ирэхэд завсрын шуугиан Тибра гол дээр нам гүм болдог юм . одоо та нарт бий болёон сайн нөхцөөөөсөө ашиглан өөрсдийнхөө хүмүүсийг Альпийн нурууны цаад руу аваачиж тус бүрийн нь орон нутагт явуул ! Хэрэв цаашид Италид дайн хийхэн хүрвэл өөрт нь зайлшгүй аюултай болно гэж биднийг хэож байна гэж Сдпартактаа хэл. За одоо яв. Замд чинь чамайг бурхан дагаж явах болтугай гэж хэлээд Лентул Сура, их бодол болж байсан Катилиныг сугадан авч дагуулан хотын төвийг чиглэн явжээ . Арторикс улам бүр холдон яваа патрицуудын хойноос нүд дагуулан харж , элдвийг сэтгэлчилэн удаан зогсож байжээ . Энэ байдлаасс нь Арториксийг Эндимион нь гаргажээ . нохой нь цовхчин , эзныхээ

гарыг дахин дпахин долоожээ .
Амьтдыг тоглуулдаг алиалагч болж явсан энэ
хүн Германы курийг чиглэн алгуурхан явжээ .
Сурагийн хэлсэн зүйлийг эрэгцүүлэн бодож , гунигтай явсан Арторикс ,
түүнийг удтал ажиж байсан Метробийг огт анхаарсангүй билээ
. гэьэл Метробий , заримдаа Арториксын арас нь дагаж заримдаа урд
нь орж түүнийг ажиглан тагнаж явсан байжээ .
харин Германы курын өрргөн талбай дээр
гарч очмогцоо Арторикс алиа марзкан Меторбийг харж, тоүүнийг
лор нь таньжээ . Суллын гладиатор байсан хүн байна гэж намайг
Метробий танив уу гэж Арторикс ихэд зовжээ . иймийн учир
яах тухайгаа бодож байснаа олны
дундуур орж Метробийн нүднээс далд орж чадах байх
гэж найдаж алхаагаа хурдалааха шийджээ .
Арториксийг аз заяа нь дэмжих шиг болж түүний
дэргэдэх Сатурнын баярыг Тохиолдуулан ноёндоо лаа бэлэглэхээр цу
гларсан үй олон хүн нэгэн д патрицийн ордны ордны хаалганы
дэргэд бөөгнөрөн шахцалдаж байжээ .
Тэр олон хүний дотор орж бие далдлан Арторикс ,
патрицийн ордон дотор орж очжээ . Одны хаалагчид
хэлэхдээ бэлэг авчирсан
олон хүн талархал илэрхийлэн концерт үзүүлэх хүслээ , эзэн
танд айлтгах гэж яваа хүн гэжээ .
Хаалгач нь Арториксыг олон хүний хамтаар дотогш нэвтрүүлжээ .
Ромын баячууд ба патрицуудын ордон нь нэгэн хэв
маяг байдгийг Арторикс сайн мэдэх учир цэцэрлэгийн нөгөө тал руу
гарах хаалга энэ ордонд байна гэдгийг мэдэж аваад , ирэгсдийн их
шуугианыг ашигдан ордны атриумын нэлттэй байсан
галерейн гудмыг дамжин цэцэрлэгт орж нөгөө хаалгаанд хүрч очоод
. тэнд байан хаалагчид , Би танай эзний дэргэд ирэгсдийн
өамнө концерт үзүүлээд өөр газар очихоор яарч Явна. Намайг энэ
хаалгаар гаргахгүй юу гэлээ . хаалгач үнэмшин их л
найртай инээмсэглдэн хаалгаа нээж түүнийг гудамжинд гаргаж өгчээ .
Арториксийн гудамжинд гарахад нь бүрэнхий болж , байлаа . Хотын
аль ойр байгаа хаалгаар хотоос гарах нь чухал байна
гэдгийг Арторикс ойлгож, Тибр голын зүүн биеийг
дагасан өргөн гудамжаар Тройвын хаалгыг чиглэн явлаа .
Энэ
гудамжаар явж хотын төвөөс холдоход гудамжинлд бараг хүнгүй нам
гүм байсан учир борооны дараа үерлэсэн булиангартай усаа
урсагаж байсан голын ус л үоржигнон сонсогдох байлаа .

Арториксийн гурван зуун орчин алхам газар явсны нь дараа арас нь ямар Нэгэн хүн хурдан хурдан алахсаар ирж явах шиг түүнд санагджээ. Тэгэхэд нь түр зуур зогсож чагнажээ . хөлийн чимээ улам бүр ойртож байсан учир, баруун гараа өювөртөө хийж чинжал хуьгаа гаргаж аваад цаашаа хурдлан алхалжээ . Араас яваа хүн , Метробий юу , аль өөрийн ажлаар яарч яваа хүн үү гэдгийг мэдэхий тул Арторикс гудамжны тохойг ашиглан голын эргийн царс модуудын нэгний ард нуугдаж зогсжээ .

Тэгж байтал л нэгэн хүн амьсгаадан ойртож ирэхэд нь сонсогдоод дараа нь нүүр нь харагджээ … ирсмэн хүн нь Меторбий мөн байжээ .

Меторбий , Арториксиын барааг алдаж гайхан зогсож ийш тийшээ харснаа :

- Хаашаа алга болов байз гэж гайхан ганцаар ярих нь сонсогджэ .

Арторикс , нуугдаж байсан газрааасаа гарч ирээд .

- хамгийн хонгор Метробий минь би энд байна гэжээ .

Меторбий цочин , хэдэн алхам хажуу тийш зайцан, гол ба гудамж хоёрын зааг болж байсан өндрөөсөө босоо хүний бүсэлхийн хиртэй хашааны дэргэд очиж

- Чи чинь , үнэхээр минйи хонгор гладиатор байна л даа… чамайгаа би зөв таньжээ.. чи бид хоёр Суллын Кума дахь ордонд танилцсан шүү дээ… надитай хамь явж , чамайг хоол идээсэй гэж би хүсэж байна… Хоёул Фалерныын сайхан дарс ууя гэж зальхай дуугаар хэлжээ .

Арторикс , алиа марзан Метробийд ойртон очиж

- Аа муу хөгшин урвагч , чи , намайг Мамертинийн шоронгийн хоолон дээр хүгэ өхийг хүсэв үү , цовдллон алагдсан миний хүүрийн махаар Эсквилийн толгодын хэрээнүүдийг хоолуулах гэв үү… гэж намуун болов ширүүн дуугаар хэлжээ .

Метробий ирсэн зүг тийшээ ухарч :

- Яалаа гэж , тэгэх гэсэн хэрэг огт биү

Юугаа чи чинь хэлэв? Хэрвээ чамайг онц сайн фалерын дарсаар зочлох гээгүй бол Юпитер аянгынхаа сумаар намайг алаг гэж ячичирсэн дуугаар үглэн улам бүр ухран байлаа .

үгүй бизээ, адгийын муу архич чи энэ орйодоо шар тибр голын булингарт уснаас цадталаа уух биз! гэж гладаиатор аман дотргоо дуугаран Метробийн дайран орсонд Метробий шинэ гудамны зүгт зугтан

- нөхөд минь ээ!… туслаач!… туслаач!… намайг аллаа!… гэж орь дуу тавьжээ

. гэвч тусламжийн хүрч амжихаас урьд Арторикс хутгаа шүдэндээ зууж, хөөж гүйцээд хүчирхэг гараараа багалзуурдан барьж авчээ .

- Аа чи муу аймхай ..

  намайг хоолонд урихдаа бас нөхдөө урьсан юм бий… нээрэн ч … тэд нар чинь … ирж явна даа…

Дөнгөж түрүүхэн ордонд хоргодож байсан патрицуудийн бөөн боол клиентүүд бамбар барьцгаан ирж явахыг Арторикст үзэгджээ . Тэр хүмүүс меторбийн чанга орилсон дууг сонсж хурдан гүйж иржэ . Арторикс Мещетробийн цээж рүү хэдэн удаа хутгалж

- Ирж яваа тэр хүмүс чинь чамайг

  аварч намайг барьж авч арай амжихгүй байхаа, үл бүтэх б узар минь гэж Арторикс бөглүү д дуугаар хэлээд

  , цээжнээс нь цус цориглон асгарч бараг үхэж байгаа Метрробийг хоёр гараараа тэврэн өргөж голын ус руу ширвэн хаяад :

- Хөшгин архичин чиний сүүлчийнхээ уда уух ус чин энэ голын

  ус болог! … гэжээ .

Арториксийн энэ үгийн дараа , голын ус цалгих чимээ мөн Метробийн муухан дуун сонсогдоод долгилж байгаа булингарт нолын уснаас замхаран чимээ тасарчээ .

Арториксын байгаа газарт тавь жар орчим алхам ойртож ирсэн боолчууд ба клиентүүд

- Метробий ! … бүү ай!… бид чинь хүрч ирлээ .
- Тэр муу гладиаторыг чинь тэлж ална!п
- Тэр чинь билний гараас гарч чадахгүй биз! гэж хашгаралдан явжээ .

Гладиатор гадуур хувцасаа тайлж мөн Эндимион ус руу хаяад өөрөө хашан дээр гарч ус руу үсрэн буужээ .

Туслаач!… үхлээ… туу… гэж Метробий дуугарахад нв дахин нэг удаа сонсогджээ .

Туслахаар ирж яваа хүмүүс нь цуст явдал болсон газар хүрч ирцгээн Метробийд туслах тухай хашгаралдан хашаа дагаж өөдөө сөөргөө сандчин үймэлдэж гүйх боловч үхэж байгаа хүнээ аврах талаар хэн ч юу ч хийж чадсангүй .

Арториксын тухайд яривал , тэр нь нөгө эргийг чиглэн голын усыг эв эрэсхэн самарч явжээ .

Голын эрэг дээр цугларсан Арториксын хараан зүхэж амь алдсан Меторбийнхаа хувь заяаны хойноос гашуудан байх зуур нь мань эр голын нөгөө эрэг дээр гараад , Яникулын толгойг чиглэн хурдлан алхаж , Мөнх хотын дээгүүр улам бүр өтгөрч байсан шөнийн харанхуй дотор үзэгдэхгүй болж одлоо .

# КОНСУЛУУД ДАЙНД МОРДЖЭЭ.
# КАМЕРНЫН ТУЛАЛДААН.
# ЭНОМАЙ НАС БАРСАН НЬ.

ЛУций Сергий Катилинаар удирдуулах гэсэн явдал ямар я найваргүай болсонд гладиаторууд Спартакийн үөвөлгөөн хүлээн авчээ . тэр нь хавар болмогц , Альпийн зүг хөдөлж тэр нурууг даваад босогсод тарцгааж нутаг нутагтаа очиж , дор бүрийнхээ нутгийн хүмүүсийг ромын эсрэг босгохыг оролдох гэсэн зөвлөгөө байжээ . Цэцэн ухаан , холын харцтай болох учир орчин үедээ уэргийн хамгийн гарамгай удирдагч болж чадсан Спартак, Италийн нутаг дэвсгэр дээр ромын эсрэг яьуулсан дайныг цааш хэвээр үргэлжлүүлэн явдал бол зайлшгүй ромын иргэдийн ялалтаар төгсөх болно гэдгийг мэдэж б айсан юм . иймийн учир 682 оны хоёрдугаар сарын сүүлээр маш сайн сургуульай , мөн онц сайн зэвсэглэсэн далан мянаган цэргээ авч Апулиягаас гарч, далайд ойрын замаар Самниумыг чиглэн явжээ .

Спартак ингэж цэргүүдээ авя арав хоног явснйхаа дара тэдний ПАдуса ояих замыг боохын тул консул Лентул Клодиан гэдэг хүн Умбрия гэдэг газарт гучин мянга орчим цэрэг цуглуулаад байна, бас гладиаторуудын эргэж зугтан амь гарч, Апулилаа буцаж очих замыг боохын тулд Геллий Публикола гэдэг өөр нэгэн консул цэргийнхээ хамт хойноос нь гарахад бэлэн байна гэдгийг мэдэж гладиаторуудын явуулах дайн бол аймгшигтай дайн гэдгийг ойлгон мэдэж маш их айн саандарсан сенат тэр хочр консул тус бүрд учиргүй том арми өгёч энэ аюултай ажитлд томилон явуулахдаа гладиаторуудын чадлыг бүр мөсөн дуусгагтүн гэсэн даалгавар өгсөн юм .

Энэ хоёр консул даалгавар асвныхаа дараахь хэдхэн хоногийн дотор уэргээ бүрдүүлж авсан байжээ . Энэ хоёрын нэг нь цэргээ Лациумд нөгөө нь Умбрияд цуглуулсан ажээз .

Бодвол түрүүчиын тулалдаануудад амссан туршлагаа претор Вариний , квещстор Кассиний ,

Орест нарын гладиаторууд дараалан бут цохигдож б айсан явдал лентул ба Геллий нарын алинд нь ч сургаал болж чадсангүй бололтой юу ч болов энэ хоёр консул гладиаторуудын өмнөөс хамтран хүчээр довтлох тухай бодсонгүй байжээ . магадгшлүй энэ нь тэр хоёрын завсрын өрсөлдөөнөөс ч болсон

байж болно, эс бол тактикийн хувиар мөчид бодсоны ч байж болох юм аа .

Спартак , дайснуудын зорилго ямар болохыг мэдэж. Геллийн армийн , Корфиниум ба Амитериумын завсрын зам дээр
уулзан түүнийг уртьдчилан довтлох зорилго өвөрлөж Самниумыг дай ран хурдавчилсан аялал хийжээ.
Спартак , цэргүүдийнхээ хамт энд хүрч ирээд , түүний лагерьт ирж нийлэхийг зүрхлэхгүй байсан боловч нууц тагнуулын мэдээ
зэргэр Спартакт их тус хүргэж байсан нутгийн
боолчуудын тусламжаар Геллий морин цэригийнхнээ ангийг хүлээж Анагия гэдэг газартаа суусаар байна бас арван тав
хоногоос нааш тэндээсээ хөдлөхгүй гэнэ гэдгийг мэдэж авчаа .
Ингэж гладиаторуудын удимрдагч цаашаа хөдөлж ,
Лентултай Умбриягаас явах замд
нв дайралдаж түүнтэй тулалдан бут цохих гэж шийджээ . тэгвэл дараа нь бага зэрэг буцаж Геллийг бут цохиж Падусын зүг явж болох ба эс бол Геллийг ерөөс огт
хайхрахгүй орхиж шууд Альпийг чигэн явж болох байжээ.
Лентул Перузигээс гарч Камеринумыг чиглэн Спартакийн цэргийг дайрах гэж явна
гэдгийг Спартак Лентул хүрснийхээ дараа олон тагнуулынхаа мэдээнээс олж мэдээд , эндээ байж дөрөв тав хоногийн дараа
энд ирэх консулыг хүлээхээр шийдэж сайн байрыг
эзлэн лагериа байгуулж сайтар бэхлэж тушаал өгчээ .
Лагериа байгуулж дүүрсний дараа, орчин торйныхоо газрыг судлахаа р Сапртак мянган морьтой хүн дагуулан гарчээ
. Отрядынхаа манлайд ганцаар сондгой түрүүлэн их бодол болж явсан Спартакийн царай уйтгартай бөгөөд ширүүн харагдаж байжээ .
Чухам юунай тухай бодож чвсан бол доо?
ойрын үед Эномайгийн зан эрс өөр болж ,
Спартакийг урьдынхаа адил хайртай биш болсон
ба мөн түүнийг хүндэтгэн үзэхээ больсоор хэд хэдэн удаа үзүүлсэн байжээ .
Катилина гладиаторуудын
удирдагч болж чадахгүй гэдгээ мэдэгдэсний дараа лагериа Гнатын дэ ргэд байхад болсон цэргийн дээр дарга нарын хурал дээр
гарч байсан. Альпийн нурууг давж цэргүүдээ нутаг нутагт
нь тараах шийдвэрийг эсрэг Эномай ганцаар зогсож байсан билээ
. Спартакийн гаргасан аналыг үл зөвшөөрөх
тухайгаа илэрхийлэхийнхаа
хамт бас гладиаторуудын удардагчийг ширүүн догшин

үгээр дайрч бас ямар нэгэн үл мэдэх дарангуйлалын тухай, бас эрх ямба хэтэрхий ашиглаж бана .
Үүнийг цаашид тэсвэрлэж чадахнгүй байна гэх мэт болон мөн гладиаторууд нь тэгш эрхтэй байхын тул зэвсэг барин боссон юм . ямар нэгэн хүнээс шууд дарангуйлал захирдаг болсноос хойш тэр нь утга чанаараа алдлаа . иймд багшийнхаа үгнээс гардаггүй багачууд хүүхэд шиг түүний л үгээр явж байдгаа болих цаг иржээ гэх мэт далд утгатай олон яриа ярьсан байжээ .
Герман хүний энэ зэрлэг авир хөдлөхийг харж Спартакийн уур оволзон босон харайсан боловч даруй уураа барьж хайрт сайн нөхрөө тайтгаруулах гэж нөхөл ёсны үгийг урин дуугаар хэлж эхэлсэн ажээ . гэвч Энрмай нь Крикс, Граник, нар болон бусад дарга нар бүгд Спартакийн саналыг зөвгшөөрч байгааг мэдмэгцээ , хамт тэмцж явсан нөхдийнхөө хуралд суулцахгүйы гэж галзуу мэт босон харайж , майхнаас гарч явсан байжээ .
Иймийн учир Спартак олон хоног сэтгэл зоврон
Эномайн зан авираа өөрчилсөниы шалтгааныг бодож явжээ .
Эномай Спартактай дайралдахдаа сэтгэл зовсон байдалтай ичингүйрэн дуугүй байдаг болсон ба нүүр учран ярихас дайжин зугтдаг болсон байжээ
Эвтибидагийн үгэнд
орж хэрцгийн догшин үантай болсон Эномайгийн уур хилэн, энгийн даруу зантай тунсаг ариун сэтгэлтэй их удирдагч Спартактай нүүр учрадаа замхран тарах шиг өөрт нь санагддаг байжээ . мөн агуу их удирдагчийнхаа дэргэд байхдаа шудрага ариун сэтгэлээ герман хүний сэтгэл түүнийг өдөөн хатгадаг грек хүүхний эсрэг ханддаг ч байсан юм .
Эномайн зан авир ингэж гэнэт хувирсан шалтгааныш эдэх гэж Спартак хэдийчинээ оролдовч мэдэж чадсангүй . Германчуудын удирдагчтай байгуулсан бузар далд харилцаагаа Эвтибида хүүхэн маш нууц хадгалж байсан учир сайхан санаатай гшудрага зантай Сапртакь аврага заль зохиож Эномайгийн толгойг эргүүлсэн сээтгэнү үр хүүхэн Эвтибидагийн явуулгын тухай огтхон ч бодсонгүы байжээ .
Нөхрийнхөө зан авирыг гайхатай өөрчлөгдсөнийг шалитгаан Эвтибидагаас болсон байх гэж огтхон ч бодсонгүй . Эвтибида аль болохоор Спартактай дайралдахаасаа зайлсхийн явдаг болсоэ учир Спартак тэр хүүхэнийг ч мартсан байжээ .
Спартак Аскулумын орчим газар
явж ирснийхээ дараа сэтгэл өвдөж их юм бодсоор майхандаа орж Э номайг дуудаж ир гэж нэгэн бие хамгаалагчаа явуулжээ .

Хүлээж авсан туүаашаалаа биелүүлэхээр бие
хамгаалагч майхнаас гарч вжээ . Явуулсан хүнээ ирэхийг хүлээх
гэж Спартак бандан дээр очиж сумагц нь
бие хамгаалагч нь буцаж иржээ .

- Эномайд очиж хэлэх гэж явтал тэр ёам дээр ирэх гэж миний
мнөөс ярж явахад нь замд дайралдлаа . .. энэ ирж явна гэж бие
хамгаалагч нь хэлээд Эномайд зам тавьж өгчээ .

Эномай Спартакийн урд ирж зогсоод :

- Гладиаторуудын дээд удирдагчид баяр хүргэе! Чамтай ярих юм байна …
бас гэьэл нь: Сапртак босож , бие хамгаалагчаа яв гэсэн дохио өгөөдд:

- надад ч бас чамтай ярих юм байна гэжээ .

Бие хамгаалагчийгаа гарч явсны дараа Спартак Эномайд их л
урьхан хандаж,

- Ор ор, ах минь , эномай минь , надад юу хэлэх гэв ? хэл хэл гэжээ.
- Би чиний эрх зангий чинь хангах гэж ядарч б
айна чиний тоглоом болж байж чадахгүй
… ядарч байна… залхаж байна… боол л болох юм бол
боол болъё! Ерөөс ромынхон ч боол болсон дээр байна… би
хэний ч зарц болж чадахгүй би тулалдахыг л хүснэ . үүнийг чамд
хэлэх гэсэн юм гэж герман хүн занах дуугаар хэлсэн болович ,,
Спартакийг халзлан харж чадахгүй буруулж байжээ .

Спартак сэтгэл ихэд гуньсан байдалтай тэнгэр
өөд харж гараа наманчлан.

- Юпитерийн аянгаар тангаргалая! Эномай минь чи бзр галзуурав
уу? чи минь ?… гэтэл.

Герман хүн , Спартакийн үгийг тасалж толгой өргөж, бяцхан хоёр
нүдээрээ Спартакийг ширтэн:

- Фреягийн мяндсан үсээр тангаргалая!

Миний ухаан огт саруул хэвээрб айна гэжээ.
Бурхан чамд туслах болтугай!Чиний ихэмсэг зан авирын тухай
гэж чи юу ярьж байна вэ? Хүнд б эрх байлдын эсрэг
зэвсэг барьж хамт тэмцэн яваа нөхдийнхөө аль нэгээр юм уу ,
аль чамаар тоглоом хийх гэсэн хүсэл надад хэзээ ч байгаагүй билээ!

- Би бас тэгж ч хэлээгүй шүү дээ … би ч мэдэхгүй байна …ич…
гээд Эномай илт ичингүйрсаэн нүүрээ буруулан , мэдэхгүй л дээ …
чи … гэвч би ч бас хүн шүү дээ… гэжээ .
- Спартак , Эномайгийн эгц урдаас нь ихл хурц хянуур харцаар харж
, чи урьдынхтайгаа адил үнэнч саяын хэлдэг чинь үүнтэй ямар
холбоотой юм ? Чиний нэр хүндийг лагерийн дотор гутаахыг би
хэзээ ч оролдож байгаагүй билээ?

… Чи яагаад энэ тухай намайг хардахр болсон билээ? Чи надтай яагаад ийм учир нь ойлгогдохгүй , тайлбар нь олдохгүй харилцаатай болсон билээ? үүний шалтгаан нь чухам юунд байна?… би чамайг доромжлоов уу? … аль би чиний өмнө буруутай хэрэгт хийв үү? Аль биелүүлэхээр биедээ хүлээж аваад амь биеэ хайрлахгүй хамтын хүчээр зүттгэж яваад нийтдээ хэргийн өмнө буруутай явдал хийсэн юм надад байна уу?

- Чи намайг доромжиллоо … чи намайг гомдоосон … гэж ч хэлэх юм надад үгүй л байна л даа … чи ч намайг гомдоосонгүй л дээ … тэр ч битгий хэл чи бол чадвартай удирдагч хүн мөн. Чи чадьартай удирдагч мөн болохыг өөрөө баталж чадсан. Чамайг түшиглэж ирсэн эмх замбараагүй олон гла диаторуудыг цуглуулан , сахилга журамтай агуу их арми болгож чи чадлаа… ерөөсөө… чамд буруу хүлээлгэх юм надад байхгүй… гэж Эномай хаиуллаа .

Хэрцгий ширүүн байдлаар эхэлж ярьсан Эномай , дараа нь нилээд зөөлөрч харин яриаагаа нөхөрсөг аялгуугаар төгсгөлөө .

- Тэгвэл яагаад чиний зан авир хуиирав? Яагаад надад уур чинь хүрэв? Миний дургүйцсээр байтал , нийтийн сонгуулиар намайг дээд удирдагч болгосны дараа би бүх нөхөд ялангуяа чамтай үнэнч хань ах дүү нарын харилцаа шиг харилцаатай байгаагүйсэн билүү? гэж Спартакийн хэлэхэд
- Үгүй Спартак минь , бүү эгж хэл л лээ… битгий намайг ингэж хараал даа . би тэгж хэлсэнгүй шүү дээ… би ёчамд тэгж хэлэх гэсэн ч хэрэг биш гэж сэтгэл хөдөлсөн байдалтай үглэн хэлжээ.
- Нутаг нутагтаа тарцгаая гэдэг зөвөлгөөн саналыг гаргалаа гэж байгаа бол би тэр саналыг гаргахаасаа урьд сайтар бодсон юмаа . Бид Италийн газар нутаг дээр ромыг хэзээ ч бүрэн ялж чадахгүй нь гэлдэг дүгнэлтэнд хүрсэнюм . Ром шүү дээ!…
- Ромыг байлдан эзлэнэ гэдэг чинь!… түүний агуу их хүчийыг бут цохиж тирануудын засгийн эрхийг бут ниргэнэ гэдэг чинь!… энэ агуу их хүсэл санаа намайг шөнө ч унтуулахгүй болж зүүдэнд хүртэл намайг тарчиолгадаг болсон гэдгийг чи ойлгохгүй байна уу? … Бренн, Пирр, Ганнибал нараас давуу агу болно гэдэг чинь ! … тэд мэт алдарт цэргүүдийн их удирдагчдын биелүүлж чадаагүй зүйлийг биелүүлнэ гэдэг чинь ! Үнэхээр агуу их алдар биш байхсан бил үү? Италид байгаа Ром

гэдэг бол газрын өмнөгөн дээр аврага биетэнд нэгэн удаа ялагдан б эртээд урьд урьдынхаасаа улам хүчтэйм босож ирж
байгаа Антей мөн . Түүний нэгэн армийн цусыг асгаруулан нам дарахад дахин нэг арми , бас дахин нэг арми тэгээд жар-далан легион цэрэг гаргаж биднийг хэмх дарах болно. Аврага биетний хувилгаан Антейг дарахын тул
түүнийг газар хаялгүй аврага гараараа, багалзуурдан байгаа бүх ул с түмнийг түүний эсрэг босгон , италийн эсрэг бүх талаас нь тойрон довтолж Сервий Туллийнхнийг бүслэн хумьж зургаа долоон зуун мянган хүний хүчээр нэгмөсөн багалзуурдах хэрэгтэй байна. Ромыг ялах ганцхан арга
түүний засгийн эрхийг устгах ганцхан зам бол энэ байна. үүнийг хэрэв бид хийж чадахгүй бол бидний ач нар бидний гуч нар хийж чадах болно. Үүнээс өөр янзын байлдаан үүнээс өөр янзын тэмцэл агуу их ромын хүчин чадлын урдаас, явж чадах
нөхцөлгүй тэгэхэд Ганнибалын бут цохигдсонд адил Митридат бут бут цохигдох ёсгүй . Карфагенчүүд ,
грекүүд болон иберинхины бут цохигдсонтой адилхан Рейнын ард түмэн ба карфагенчүүд бут цохигдох ёстой
. дарлагдагсад бүхэн нэгэн доор босч холбоо байгуулан хөдлөхгүй ювм бол үүнээс өөр ямар ч юм газар дэлхий бүхэн рүү хорт сорогч савраа алгуураар үргэлж сунган тэмтэря байдаг
энэ аврага биет аюулт
хорхойг ялж чадахгүй гэж Спартак зоригжингүй байдлаар их л тагнангүй ярьж , нүд нь цогтой гялалзаж байжээ . Эвтибида хүүхний зальхай муу арганд автагдан дүрэлзсэн
угаасаа үнэнч шударга зантай , Спартакт үнэхээр
зүтгэгч Эномайн зүрх , Спартакийн үгийг сонсож номхорч байжээ . гладиаторуудын удирдагчаас үгээ хэлж дүүрэх үед герман хүн аргадан гуйх б айдлаар гараа сунгаж , нүүр царай нь
ер бусын сайхан гялалзаж байсан Спартак тийш хандаж :

- Ээ Спартак минь уучлаарай… уучлаарай!… чи бол хүн биш ёстой л бурхан байна!… гэж сэтгэл нь догдлон чичирсэн дуугаар хэлжээ .
- Чи бид хоёрын харилцаа дахин ах дүү хүмүүсийн харилцаа шиг болжээ гэдгийг ойлгон мэдлээ . иймийн учир би хүн төрлөхтниы дотроос хамгийын их хувь заяатай нь байна гэж Спартак сэтгэл нь ихэд догдлосон байдалтай дуу алдаж хэлээд, гараа алдалтал Эномай хоромхон зуур түдгэлзэснээ ухасхийн тэвэрч :
- Ээ Спартак , Спартак минь … би чамдаа урьд урьдынхаасаа улам илүү хайртай сүсэгтэй боллоо! Гэж шивэгнэн хэллээ .

Ингэж энэ хоёр хүн , ах дүү хоёр
шиг тэврэлдэн үн дуугүй нилээд зогсож
байснаа Спартак эхлэн дуугарч ,

- Эномай чи яах гэж наашаа ирсэн тухайгаа одоо хэлж өгөхгүй юу! гэж мөн ч сэтгэл хөдөлсөн дуугаар анд нөхөртэй хэллээ .
- Би юү?… за даа.. би одоо мэдэхгүй байна… тэр тухай дахин санах ч хэрэггүй гэж Эномай их л ичсэн байдалтай хэлээд:

Түр зуур дуугүй байснаа сэргэлэн байдалтайгаар дуугар:
- намайг чамайс ямар нэгэн зүйл хүсэхээр ирсэн
байх гэж чи ойлгож байгаа тул надад одоо чамаас хүсэх зүйл байна. юу
гэвэл консул Лентултэй ойрын өдр?үүдэд тулалдах тулааны хамгийн
аюултай газарт нь намайг манай герман хүмүүсийгн
хамтаар явуулж өгнө үү гэж хүсэх байна гэжээ .

Сапртак түүний хайрт сэтгэлийн урьхан нүдээр харж

- Чи минь ямагт иймсэн! Чи ямагт ! Чи ямагт зоригтой Ямагт шудрага сайн ! хамгийн аюултай газры нь чамдаа өгнө гэхэд нь
- Тэгвэл чи миний хүслийн ёсоор болгоно гэв үү? Гэлээ .

Спартак баруун гараа эномайн чиг сарвайж .
- тэглээ , намайг юунаас ч убуцдаггүйы хэзээ ч худал
хэлдэггүй гэдгийг чиы өөрөө мэднэ шүү дээ гэлээ .

Эномай Спартак хоёр эндээ бас ярилцаж байснаа хоёул гарч явлаа . Энэ хоёрын эндээс хэдхэн алхам явсны дараа Арторикс тэднийг гүйцэж ирлээ . Геллийн цэргийн тухай мэдээ олж ирж ажлыг даалгаж энэ
галл угсаатны хүнээр даргалуулан нэгэн мянган морьт
цэрэг тагнуулын ажлаар гурван хоногийн өмнө гладиаторуудын даргаас
Реата гэдэг газар явуулсан юм .

Энэ галл угсааны хүн энэ ажлаас эргэж ирээд, Спартак
, Эномайн хамт явжээ гэдгийгмэдээд тэднийы хойноос гүйн ирсэнбайжээ .
- Сайн байна уу Спартак аа! Геллийн зарим морин цэргүүд
нь түүнийг гүйцэж ирээд Анагия гэдэг газраасаа явсанб айна. Их бодоход л тав хохогоос хэтрэлгүй ирнэ гэж бодох хэрэгтэй байна гэсэн мэдээ авчирчээ .

Спартак энэ мэдээг сонсож бага зэрэг бодолхийлэн байснаа:
- их сайн байна !Маргааү орой энэ лагериас хөдөлж Каиеринум руу явж тэнд нөгөөдөо үдээс өмнө хүрнэ Лентул тэнд нөгөөдөр орой вм уу ,
магадгүй түүнээс хожим дөрөвдөх өдрийын өглөө хүрч очиж магадгүй
. тэгэхэд тэдний цуэргүүд замдаа ядарч хүрнэ. Харин бид амарч амжаад ,
тэднийг зоригтой

дайрч бут цохимогцоо эргэж Геллийн армийг саадгүй үргэлжүүлнэ. Ингэвэл ямар гэж чи бодож байна Эномай ? гэж Спартак асуулаа .
- Энэ санал бол цэргийн агуу их удардагчийн боддог гарамгай санад мөн байна гэж Эномай хариулжээ . Спартакаас Арториксыг чөлөөлөн явуусны дараа Эномай Спартакийг дагуулан майхандаа орж, түүнийг өөрийнхөө бме хамгаалагчдын хамт ширээний ард суулгажээ . Эномайн бие хамгаалагчдийн дотроос гагцхүү Эвтибида байсангүй . Учир нь энэ хүүхэн олон талаар Спартакаас буруулан зайлах шалтгаан юм . Хатуу боловч сайхан амттай тронтын дарс ууж , элэгсэг дотно ярилцаж байсан энэ ярианы үед цаг амархан өнгөрч, герман хүний майхнаас Спартакийн гарах үед анхны бамбар асаах цаг аль хэдий өнгөрсөн байжээ .

- Хүмүүс явж Эномайгийн ганцаар болмогц германчуудын даргын майхан дотор тусгайлан зассан өрөөн дотроос царай нь цонхир цагаан болсон Эвтибида хүүхэн улбар шар үсээ мөрөн дээгүүрээ задгай буулган гарч ирээд хоёр гараа зөрүүлэн элгээ тэврээд Эномайгийн урдаас харж зогсоод:
- Тэгээд Спартак морио хөдөлдөгтэйгээ адил чамайг дуртай тийшээ дахин хөтөлдөг болж байна уу? Өөрийнхөө эрх ямба алдар нэрийг дээшлүүлэхийн тул чиний хүч чадал зориг зүрхийг ашигладаг хэвээр бах хэрэг болж байна уу? гэлээ .Герман хүн хүүхний зүг хорсон занасан байдалтай харж:
- За нөгөөхөө бас дахин ярьж байна уу? тэр бузар гүтэглэгээ чи хэзээ зогсоох м . Бузар ятгалагынхаа хорыг миний цусанд цутгах явдлаа хэзээ болих юм ? Чи бол Фенрисын чононоос ярдаг , гурвант буруудсан эм байна гэж бөглүү дуугаар маш уурта зандарчээ .
- Сайн байна! Олипийн бүр бурхдад мэхийн тангаргалая!… чи зэрлэг араатан байна. Би чамайг үзэн ядах ёстой байтлаа чамд хайртай дуртай болсон тэнэг, үл бүтэх эм миний буруу л даа! Онц сайн байна.
- Намайг саайн анартай ухаан сэргэлэн шудрага нөхөр Спартакаа үзэн яддаг л байвал чи надад хайртай байхгүй бол үгүй байх ёстой болж байна уу?
- Тэнэг эм би ч анхнадаа Спартакийн хуурамч сайн үйл явдалд нь итгэж түүнийг хүн биш амьд бурхан шахууд үзэж байсан юм . гэвч Спартазк бод худал дүрийг үзүүлэн хуурмаг зальхай этгээд , түүнийг хэлсэн үг бүр

, хийсэн ажил бүхэн ньганцхан хүслийн дөлөөр оволзож байдаг юм тэр хүсэл нь алдар нэрийн хүсэл юм
байна гэдгийг хожим өөрийн эрхгүй итгэх болсон юм . үүний дараа сая би чинь тэнэг мал байжээ гэдгээ мэдсэн юм … гэхэд нь эномай учиргүй уурлан чичирэн ,
багалзуурдуулан үхэж байгаа арслангийн дуугаар:

- Эвтибида! Гэж хашгарлаа .
- Би чиний заналаас ч айхгүй байна!

харин чиниы дурлалын үгийг үнэмшээгүйсэн бол дээр байж тэгсэн бол , одоо чамайг үзэн ядаж байгаатайгаа адил ал
хэдийн эхлэн үзэн ядах байсан юм гэж Эвтибида үзэн ядаж хэллээ .

Эномай гар зангидан далайж, галзуу мэт суудлаасаа босон харайж аянгын дуу мэт аймшигт цууриа дуугаар Эвтибида ! гэж хашгарлаа .

Эвтибида гладиаторын зүг ойртон очиж :

- За зоригтой ! Уухай зоригт минь , урагшаа ядуу муу бүсгүйг аврага араатангийнхаа савраар цохь л доо , багалзуурдан ал л даа . тэгвэл чиний нэр алдар циркийн талбай дээр дайснаа алснаас улам их мандах болно! … за зоригтой ! … гэж ихэмсэг зантай байдлаар өдөж хэллээ .

Эвтибидагийн энэ үгээ хэлэхэд нь Эномай ухаан балартатлаа уурлан түүний зүг давшлан очсон боловч ухаан орж бүсгүйг шүүрэн авахаар
Авахаар бэлтгэн очсон гараа дээш өргөж амьсгал нь давхцан.

- Чи эндээс арил… дусал төдий үлдэж байгаа ухаанаа алдахаас минь урьтаж тэр бурхдынхаа төлөө чи эндээс арил… гэж зандарлаа .
- Чиний хэлэх үг чинь энэ үү? … чамд хайртай, газар дээр гану хүн чамд хайртай бүсгүйдээ хэлэх үг чинь ингээд дүүрэв үү? .. Миний чамд хайртай байсны хариу энэ үү? Чамайг хүрээлүүлж байсан миний энхрийлэл янаглалын ачийг хариулж байгаа чинь энэ үү? Миний ганцхан чамайг бодож явдгийн хариу шагнал энэ үү? Сайн байна!… иймл байг даа… би чамайг итгэх байх гэж бодож байх ёстой бай л дээ … ингэж байхад чамд сайн сайн юм их ! ингэж байхад чиний хувь заяаны төлөө сэтгэл зовж яв! Хувь заягүй тэнэг , амьтанй би!… чиний л тухай бодож явжээ!._.. чиний эсрэг хандуулсан бузар хатгалгалаа чамайг аварахын тулд чиний зэрлэг хорслын өө рийнхөө эсрэг хандуулж орхивоо! Гээдд хоромхон зуур дуугүй байснаа ахиж
- харсаарб айж чамайг бусдын хөлийн дор гишгүүлж ёстой байжээ… харсаар байж чамайг үхлийн чинь замд хүргэх ёстой байжээ … ээ

дээ , хэрэв би тэвчиж чадах байсан бол!… юутай ч л
гэсэн үхлээс гашуун энэ зовлонг би өнөөдөр амсахгүй байсан юм… юутай ч л чиний хараал цухалдалыг амсахгүй , үргэлж янаглан дурлаж явсан хүндээ доромжуулан загнуулахгүй байсан юм … энэ ч арай л хэтэрхий бизээ!…

гэж улам нэмэгдэн чичирэх дуугаар хэлээд үгширтэл уйлж гарав. Эвтибидагийн энэ бүхэн нь хөөрхий хүн Эномайгийн санаа сэтгэлийг хөнджээ . Эномайгийн догдлон байсан уур нь алгуур намдаж , бүсгүйн хэлсэн үгийг улам бүр эрэгцүүлэн бодож байснаа дараа нь үнэмшиж хүүхнээ элэгсэг хайрлаж ирлээ . Эвтибида хүүхнийг хоёр гараараа нүүрээ дарж үүдэн тийш чиглэхэд нь үүдэн тийшээ ухасхийн очиж:

- Эвтибида минь … уучил намайгаа… хэлэх үг ч алга хийх зүйл ч алга… намайгаа ингэж бүү хая , би гуйж байна! гэлээ .

Сээтэгнүүр хүүхэн Эномайгийн зүг их зантай дээгүүр харж хорсон занасан байдалтай ,

- Афины ивээгч бурхдын төлөө чи надаас холдон зайл! Намайг чи орхиод аль, чамд дурлаж яваад хаягдсан гутамшигт ковлонгоо би чамаас л хол эдэлье … гэхэд нь Эномай энэ хүүхнийг гар дээрээс нь барьж аваад үл мэдэг хүчдэн майхныхаа мухар тийш хөтлөн..
- Яасан ч явуулахгүй … яасан ч явуулахгүй!… чамайгаа явахад ч би хүргэхгүы шүү .. ингэж намайг хаяад явахад ч би чамайг арай хүргэхгүй шүү.. чи миний үгийг сонсооч… Эвтибида намайгаа уучил!… миниы үгийг дуулаач , би чамайг гуйя гэлээ .
- Чиний хараал, чиний доромжлолыг би дахин сонсох уу? Чинийы над руу дайран довтлох хамгийн аймшигтай зовлонгоос холдон зайлах бололцоог надад олгож аль Эномай минь гэхэд нь:
- Үгүй… үгүй!… Эвтибида минь намайг дахин ингэнэ гэж битгий бод л доо? намайг галзуурахад битгийы хүргэ л дээ ! Миний үгийг сонсооч … үгүй бол би чиний нүдний өмнө багалзуураа тас огтлоно шүү гээд Эномай бүсэндээ байсан чинжаал хутгыг суга татан авахад :

Сээтгэнүүр хүүхэн айн сандарсан дүр үзүүлэн:

- Байлаа!… Байлаа!… гэж бяцхан хоёр гараа авхрага том биетэй хүний зүг сунгаж даруухан нам уятгарт дуугаар
- Хэтэрхий хайрт Энроомай , зүрх сэтгэл минь чи мөн. Чиний амь надад цаглашгүй үнэтэй , чиний амь олдошгүй эрдэнэ мөн ! гэхэд нь .

- Ээ, миний хайрт Эвтибида
  миний сохроор уурлсана явдлыг уучил… уучил…уучил… гэж үнэхээр дурласан хүний зөөлөн дуугаар :
- Чинхий сэтгэлт ч үнэхээр алт шиг сайхан юм , чи ч үнэхээр ариун сэтгэлт хүн байна. галзуу мэт болтол чамайг уурлуулсан явдал ч миний буруу байна. чи ч намайгаа уучлах биз гэж хөлийнхөө дэргэд сунаж байсан аврага биетэй хүний хүзүүгээр хоёр гараараа тэвэрч баясгалант царайгаар инээмсэглэн хэлжээ .

Эвтибида иүр зуур дуугүй байснаа дуугарч
- Би чамдаа хэтэрхий хайртай юм аа!.. чамгүй байж би чадахгүй !Бие Биеэ уучлан энэ явдлаа мартъя… гэхэд нь эномай .
- Аа агуу сэтгэлт Эвтибида минь … сайхан санаат хонгор минь гэжээ .

Хүүхэн Эномайгийн гараас гэнэт сугаран гарч :
- Намайг чамд үнэхээр хайртай гэдэгт чи итгэж байна уу? гэж зальхай дуугаар асуулаа .
- Бүхнийг ялгуулагч Одинын хүчинд итэгдэгтэйгээ адилхан үүнд би итгэж байна гэхэд нь:
- Дианын алтан суманд мэхийн тангаргалая!тэгвэл чи, намайг чамд муу юм хүсэж байна гэж хормохон зуур боловч бодлоо гэж үү дээ? гэхэд нв:
- Би хэзээ ч тэгж бодсонгүй билээ .
- Хэрэв тэгж боддоггүй юм бол чи яагаад миний зөвлөгөөг хүлээж авахгүй байна, тэгвэл чи яагаад, чамд өөрөөсөө илүү хайртай, чамайг хамгтйн их хувь заяатай агуу их хүн болоосой гэж үргэлж бодож явдаг бүсгүйд итгэхгүй харин чамаас урваж чамд хар санаж явдаг нөхөртөө итгэдэг билээ? гэхэд нь Эномай санаа алдан нэг ч үг хариулсангүй харин босож майхан дотроо өөдөө сөөргөө алхалаа .
- Ийм байдал хоёр минут хир үргэлжилж энэ завсар эр эм хоёр хүний аль нь ч нэг ч үг дуугарсангүй ажээ . ингэж байтал Эвтибида түрүүлж зөөлөн дуугаар ганцаар ярьж :
- Би чинь өөрийнхөө ашиг тусын тулд Эномайд сануулан хэлж байгаа юм биш багйаа даа? Сайхан санааныхаа харгаагаар сохроор бишрэх явдлаасаа нь з айлуулах ,
  өөрий нь болон заяа муутай хөөрхий гладиаторуудыг оруулан жарг ахаар хамгийн хортойгоор урван тэрслэгчдийг бэлтгэж б айгаа жорыг зааж өгөхөд өөрийнхөө ашгийн үүднээс хийж байгаа юм биш биз дээ? гэхэд:

- Тэгэх гэж байна гэж чамд ганц ч удаа болович хэлсэн хүнбайна уу? хэн тэгэх гэж байна гэж санаж б багаа юм? гэж Эномай хүүхний өмнө зогсож асуулаа .
- Чи Чи хэлээгүй юу гэж! сээтгэнүүр хүүхэн ширүүн дуугаар хэллээ .
- Би хэлсэн гэж үү? Гэж Эномай гайхан асуулаа .
- Тийм ээ , чи хэлсэн ! үнэндээ чи хоёрын нэгийн сонгож авах хэрэгтэй байна. намайг чамд хайртай яамд хль сайхныг хүсэж явдаг гэдэгт итгэж байгаа бол Спартак биднээс урваж, бидний дайсанд барьж өгөх гэж байна гэдгийг үнэмших хэрэгтэй байна, хэрэв Спартакийг үнэнч сайн үйлт хүн мөн гэж үзэж байгаа бол намайг чамаас урвасан хуурмаг дүрийг үзүүлэнгч гэж үзэх хэрэгтэй бана гэхэд нь:

Харьцуулах сэтгэл талаар тааруухан Эномай бүсгүйнхээ хэлж байгаа энэ олон гарцаагүй баримтаас мултран гарах аргагүй байжээ

- Үгүй … үгүй!.. гэж бараг уйлах шахсан дуугаар хашгаран:
- Ээ дагина минь, Эвтибида минь намайгаа уучил, намайг дайсанд барьж өгөх гэж бодох нь хэрэггүй тэгж чиний санаанд орсон байх ч гэж би огт бодохгүй байна. Чи надад үнэхээр хайртай гэдгээ олон зүйлээр нотолсон билээ … гэвч .. намайгаа уучил.. яагаад Спартак биднээс урвах болсон билээ гэдгийг л би ойлгож мэдэхгүй байна.
- Яагаад ? … яагаад?… гэх юм Яагаав Фундид болсон тулалдааны дараа консул Варрон Лукулл над дээр ирж хэлэв чи гладиаторуудын орхих юм бол чамайг Испанийн армид дэжэш тушаал олгоно , эс бол Африкт префект тушаал олгоно гэлээ гэж Спартак өөрөө хэлж байгаагүйсэн бил үү амархан хууртагч амьтан минь ээ?
- Тэр консулд Спартакийн хэлсэн хариуг чи өөрөө мэднэ шүү дзээ …
- Яагаад тэгж хариулдсан байх гэж заяагүй тэнэг амьтан чи , бодож байна ? Консулын Спартакт амласан тэр зүйл нь Спартакаас тэдэнд хийж өгөх юмнаас нь ач холбогдлоор бага байсан юм гэжээ .
- Эномай дуугүй болж толгой даран майхан дотуураа дахин алхалж эхэллээ .
- Одоо бол тэд нар Спартакт олгоно гэж тэгэхэд амлаж байсан зүйлээ хоёр гурав дахин ихэсгэж дахин хэлэлцээ хийжээ .Тэр тухайгаа Спарта к та нарт хэлсэнгүй гэхэд нь :

Эномай Эвтибидагийн өмнө зогсож :

- үүнийг чи хаанаас мэдэв ? гэж асуужээ .
- Катилиг гладиаторуудыбн армийн командлагч болохгүй юу гэж хэлэхээр Ром хот очсон Рутилийг чи юу гэж бодож байна … Чи түүнийг ганцхан тэр хэргээр л тийшээ очсон байх гэж бодож байна уу? гэхэд нь Эномай
- Хэрэв … тэгээд гэтэл нь :
- Тэр хамгийн зальт муу санаатай тэр хүнд та нао итгэдэг юм байх даа … Спартакаас консултай урьд нүүр учран ярилцаж эхэлсэн хэлэлуээг дахин сэргээн үргэлжэлүүлэхээр ром руу элёин явуулсан гэдгийг гарцаагүй мэджэ байгаа би лав Спартакийн үнэнчид итгэж чадахгүй юм байна гэлээ

Эномай бас майхан дотуураа алхалж гарлаа .

- хэрэь тийм л биш байсан юм бол яагаад заавал тэр Руитлийг чөлөөтэй төрсөн лат- хүн Рутилийг тийш нь явуулсан юм? гэжээ .

Эномай юу ч гэж хариулсангүй .

- Учир нь үл мэдэгдэх шалтгаанаар рутилийг алагдсаныш дараа, Спартак яагаап , өөртэйгээ адилхан цэргийн удирдагчид болох та нартай , хамгийнхаа шудрага Арторихсыг тийш нь амьтан тоглуулагч алиа хүний дүрээр явуулсан юм ? тийш нь яагаад заавал өөрийнхөө дүүд хайртай болсон Арториксыг явуулсан юм ? Өөр хүн яагаад явуулсангүй вэ? Арториксыг Ромоос буцаж ирмэгц яагаад Спартак та нарыг нутаг нутагт чинь тарааж италиас явуулахаар шийдэх хэрэгтэй гэв? Гэхэд нь эномай зогсов.

Эвтибида түр зуур дуугүй байснаа дуугарч:

- Энэ бүхэн нь бүгд ердийн зөв зүй зохихын шудрага хэрэг үү? … хаашаа байна ? … одоо хамаг хүчээ бараад байгаа ром Испанид Сеторий , Азид Митридатын өмнөөс тулах уэргийн хороодыг олж бүрдүүлж чадахгүй болоод байна, цэрэгтэй байтлаа . Ромд тохиолдоод байгаа энэ аймшигтай цаг үел дайсны хотыг дайран орохын оронд гадагшаа зугтана гэдэг чинь юу гэсэн үг вэ? … энэ шүөнө ер нь таарах хэрэг үү? Гэлээ .

Эномай нэгэн газраа хөдлөлгүй зогсож хааяа хааяа толгойгоо удаан дохиж байжээ . Лентул ба Геллийн армиуд гэдэг тэр хоёр арми нь … хэн бүхэнд хуурагдсан хүмүүсийн хараанаас халхалхын тул учир нь үл мэдэг шалтгаанаар гутамшигт муухайгаар бууж өгч зугтах гэж байгаа хэргээ зөв мэт болгохын ул Спартакийн санаанаас авсан арми юм . ..Геллий

… Лентул… болон тэдний арми гэдэг нь тэр юм ! гээд
бодож байгаа зүйлээ өөрөө өөртөө хэлж байгаа мэт үргэлжлүүлэн :
тэр санаж гаргасан Лентул гэгчинхйээ цэргийн явах тагнахаар мянган морь
т цэрэг авч яагаад заавал өөрөө явав,
тэр сэтгэлээсээ санаж гаргасан Геллийн цэргийг тагнуулйнхаа яагаад заавал
Арториксыг явуулав? Яагаад тийш нь та нарын нэгийг явуусангүй вэ? …
гэхэд нь Эномай дөнгөж мэдэгдэхүйу аяархан дуугаар:

- огторгуйн мандлын бүх бурхдад дуудан тангаргалая!
  Хорт санаат дайснйы үгийг үнэмшин мансууран унтаж
  байсан нойроосоо сэрэх цаг чинь нэгэнт болжээ .

Энэ хүнийг урвах зам руу нь түлхсэн өөр шалтгааны тухай бас
өөр баталгаа сонсохыг хүсэж байга бол Суллын бэлбэсэн авгай ,
Ромын патриций авхай Валерия Мессалд Спартак галзуу дурласан хүн
гэдгийг сана. Тэр бүсгүй төлөө түүнд
дурлсана дурлалынхаа төлөө тэр та бүхнийг бүгдийг Ромын сенатад
хүргэж өгнө. тэгээд түүний нь хариунд сенат Спартакт
хайрт бүсгүйгий нь эхнэр болгон өгч , хүүхний хамт бас орд харш , эд
хөрөнгө , эрх ямба олгох болно… гэж Эвтибидагийн их
цог бадрангүй хэлэхэд Эномай фцракий хүний урван тэрслэх болсон
шалтгааныг гарцаагүй баталж байлаа .
Эд мөрийн өдий төдий баримтанд үнэмшин:
- Үнэн!… үнэн!… Спартакийн урвасан нь гарцаагүй боллоо!… гэж
Энолмай зөвшөөрөхөд хорсолт баяраар нүд нь гялалзаж байсан
Эвтибида хүүхэн герсман хүн тийш улам ойртон ирж :
-Тэгээд , хурдлаач!Одоо бас юугаа хүлээж байна вэ ?
… аль үнэнч германчуудын чинь хамтаар чамайг гарч болшгүй ямар
нэгэн хадны хавцалд чихэхийн нь хүлэж байна уу? Тэгвэл та
нар тулалдах ч
аргагүй өолж зэвсгээ хураалгана гутамшигт муухайгаар бууж
өгөхөөс өөр замгүй болно шүү ! Аль та нарыг цовдлон тэлж алахы
нь хүлээж байна уу? гэхэд нь :
- Үгүй… үгүй.. торын бууа аянгыг дурдан тангаргалая! Гээд
герман хүн ухасхийж майхны нэгэн хаяанд байсан
хуягийг шүүрэн авч өмсөөд төмөр малгайгаа бүчлэн сэлмээ бүснээсээ
зүүх зуураа :

- Үгүй! намайг адйсанд чи барьж өгч чадахгүй байхаа !… би
  легион цэргээ … одоо … одоохон … би
  энэ урвагчийн лагериас явлаа … гэхэд нь
- Маргааш бүгдээрээ чиний
  хойноос явна. Чамтай хамт галлчууд иллирийнхэн самнитууд
  явцгаана. Аа , Спартакийн дэргэд фракийнхан ба грекчүүд л

үлдэнэ. Тэгээд , чи дээд командлагч болж, Ромыг довтлон дайрч , эзлэн авсны их алдар нэрийг чи, чи л ганцаараа эдлэнэ… яв.. яв… өөрсдийнхөө хүмүүсийг чимээгүй босгох ажлыг зохио… чи, чамд хайртай хүний зөвөлгөөг сонс… бүх хүний дороос чамайг хамгийн агуу их , хамгийн их алдартай нь байгаасай гэж бодож явдаг хүний зөвөлгөөг сонс! гэжээ .

Хэдхэн минутын дара германчуудын легионы бүрээ дуугарч цаг хүрэхгүй хугацааны дотор эномайгийн арван мянган цэрэги орно майхнаа бууллгаж жагсан лагериас хөдлөхөд бэлхэн боллоо .

Эномайгийн цэргүүд нь лагериас баруун гар талын гол хаалганы дэргэд байрладаг байжээ . хаалганы манааны харуулын даргад Эномай тэмдэгээ хэлж цэргүүдээ хаалгаар чимээгүй гаргажээ . Германчуудын дохиойн бүрээ тэдний зэргэлдээ байдаг галлчуудыг сэрээжээ . тэд нарын зарим нь бүх цэрэг жагсах ёстой юм байна гэж бодож , мөн зарим нь дайсан этгээд гладиаторуудын лагерийг дайрч иржээ гэж санажээ . тэгээд бүгд босцгоон зэвсэглэж майхнаасаа гарцгааан хэн нэгний тушаал хүлээсэнгүй бүрээчиддээ хэлж бүрээ татуулжээ. Удалгүй гладиатоурудын бүх лагерь босоцгоосон бүх легион зэвсэглэсэн байжээ .

Гэнэт дайсан довтолон ирэхэд ямар ч сахилагатай цэргүүд боловч сандран үймэх явдал байдаг утл гладиаторуудын лагерь мөн сандран үймсэн байлаа .

Орноосоо хамгийн түрүүнд босогчдын дотор мөн Спартак босож майхныхаа үүдэн тийш ухасхийн очиж лагерийн төв штабын маа хийж байан нэгэн цэргээс юу болоь гэж асуулаа

Сенатын энэ тунхаг ба крассын уриалга сэтгэл санаагаар унасан иргэний зоригийг хөгжүүлжээ . хамгийн алдарт гэр бүлийн залуучууд сайн сэтгэлийн үүднээс уралдаалан яарч Крассын легионд бүртгүүлдэг бол жээ .
Красс цэргээ маш шамдуу зохион байгуулж , хүмүүсийнхээ дотроос тэдний гарал , үүсэл одоогийн байдал зэргийг харгалзалгүй зөвхөн цэрэг дайны нь дадлага чадварыг харгалзан квестор ба трибуныг сонгон авчээ . Квесторын тушаалд арван нэгэн дайн, т зуун гучин тулалдаанд оролцон хорин хоёр удаа шархдаж , мөн шагнал титэм хүлээж яваад одоо тайван хөдөлмөртөөө буцаж очоод байсан Тибурын газарт хүн Публий Элий Скрофыг томилжээ . гладиаторуудыг нэгмөсөн дарж дуусгахыг зориглого болгон манай алөанд орно уу гэж Скрофийг очиж гуйхаасаа ч Красс буцсангүй .
крассын цэргийн квестор болж төрсөн тибури орхиж түүнийг дагаж ромын зүг явахыг дуртайяа зөвшөөрчээ . Преторт сонгогдсоноосоо хойш аран нэг

хоносны дараа марк Лициний , Ром ба түүний
ойр орчмын мужуудын хуучин цэргүүдээс бүрдүүлсэн дөрвөн
легион цэргээ авч экванчууд ба умбрчуудын нутаг газруудын завсар
орших , Отрикулум хотыг чиглдэн хөдөлжээ .
Энд Крассын нэгэн туслах Авл Муммий гэдэг хүн
туслах хүчин боох нөгөө хоёр легионы нь
бүрдүүлэн зохион байгуулсан байжээ .
Ром хотоос гарах үед крассын лагерийн байрлаж б
айсан ратуменийн хаалган дээр цугларан очсон үй
олонд претор ихэд талархан баяр хүргэжээ . Преторын энэ
аялалд павхарга бүрийн
иргэдийн сайн ерөөлөөр дэвшүүлж байснаарч үл барам, бас
сайхан бэлэг амлан энэ аяллыг даган баясаж байсан
бурхад өршөөл ивгээлээ үзүүлж байна
гэж тахилчид малын гэдэс дотрыг шинжин өгүүлж байжээ .
Нэгдүгээр легионы хоёр когорт нь жирийн агсаалын цэрэг
болон Крассыг дагаж Явахаар шийдсэн хамгийн алдарт гэр
бүлийн залуучуудаар бүрдсэнбайжээ. Тэдний дотор Тит Лукреций Кар,
Кай Лонгин Кассий , Суллын хүү
Фауст нар ба консулын угсаасадны хэдэн зуун хүн болон мроин
уцэргийнхээ үрсадны зуун залуучууд багтсаан байлаа
. Эдгээр залуучуудын төрөл саданг хань нөхөд бас
клиентүүд нв Крассын легионуудын Мильвийн гүүр хүртэл үлдпэж
гаргажээ . Энэ өдрөөс хойш дөрөв хоносны
параа красс цэргүүдийнхээ хамт Отрикулум хүрч
энд цэргүүдээ , сургуулилуулахаар шийдэж сайн байр
эзэлж лагерилан буудаллажээ.
Бас энд байрлахдаа гладиаторууд Ромын зүг Умбиргээс шууд
дайрсан ч пициенчүүдийн мужаар дамжин дайрсан ч
ялгаагүй хамгаалж болох газар мөн болно гэж
Красс урьдаас тааварлан энд буусан байжээ .
Бараг сар шахасм байлдааны ч арга явуулга
хийлгүй красс Отрикулумд Спартак Арециумд байрлан сууж, тус
тцсдаа байлдааны явуулгын бэлтгэл хийж
нөгөө талаас яаж мухардуулах яаж дарах шинэ
төлөвлөгөө зохиох ажлыг тус тусдаа хийж байжээ .
Спартак одоо хөдлөх цаг болжээ гэж үзмэгцээ ,
нэгэн шуургатай шөнө, тун чимээ анир
гаргалгүй лагериасаа гарч явах тушаал легионуддаа өгчээ
. долоон мянган морьт цэрэг, мамилийгээр даргалуулан лагерьтаа үлд

эж нэгэн мянган морьт цэрэг толгойн тагнуул
болж цувааны өмнө явжээ .
Оволзон хуйларч байсан
шуургыг палимдуулан Спартак цэргүүдийнхээ хамт бүхэл шөнө
маргааш өдөр турш шахам явж Игуюиум очжээ .
Тэндээсээ Красст мэдэгдэлгүйгээр явж Камеринум , Аскулум, Сульмо,
Фуцинын нуур, Субиакыг дайран явж Ромочих гэж Спартак бодсон
байжээ . Арециумын лагерьт үлдсэн морин цэргийн анги нь энэ
үед хуучин хэвээр тагнуулаа хийж бас
оыр орчмын хотуудаас далан найман
мянган гладиаторуудын хоол хүнсиг ерийн байдлаар бэлтгэдэг хэвээр
б айжээ . Ийм учраас нутгийн
хүмүүс гладиаторуудын цэрэг Арециумдээ байна гэж ойлгох ёстой
байсан бөгөөд энэ тухай бас красст мэдэгдэх байх
гэж Спартак ойлгож байжээ .
Спартак цэргийнхээ хамт Апенниний уулбн нурууг дагаж маш бартаа
тай замаар өдөр тутам хорин тав гучаас доошгүй
миль газар цэргүүдээ аялуулан явж, пиценчүүдийн нтгаар
дамжин өнгөрч Ром орох байсан
бөгөөд завсрын тохиолдлоор Спартакийн төлөвлөгөө Красст мэдэгдээг
үйсэн бол Спартакийн цэрэг Ром хотын хэрмийн пэргэд гэнэт
хүрч очих байсан юм .
Спартак цэргүүдийнхээ хамт Арециумаас гарч явснаас
нь хойш гурав хоног өнгөрснимй дараа Красс гладиаторуудын цэрэг
Арециумаас гарч ирэхгүй нь гэж бодоод бүх аргыг хэрэглэн их
тулалдаанд Спартакийг дуудан гаргаж нэгэн
мөсөн дарж дайныг дуусгах гэж шийджээ .
Спартакийг зөвхөн өөрийн нь тактикаар дийлж болох юсм гэж
Красс ойлгоод Отрикулумаасаа
хөдөлж хамгийн хурдан аяллараар дөрөв
хоног явж Арециумын дэргэдэх оагерьт нь хүрч очжээ
. Ромынхны цэргүүдийн ойртон ирж яваag Мамилий мэдээд, Спартак
ийн тушаалтыг мөрдөн шөнө чимээгүй лагериасаа гарчээ . маргааш
өглөө нь үүр цайж байх үеэр крассын тагнуулын анги нь босогчдын
лагерийн шороон хрээ хүртэл очоод Спартакийн
цэргүүд лагериласан газраасаа зайлан явсныг сая мэджээ .
Красс энэ мэдээг сонсож ихэд гайхан , Спартак аль замаар явдаг
билээ гэж удаан тааж байснаа, Арециумын эргэн торйон ,
гучин милээс доошгүй газар явж Арециумаас тал бзрдээ гардаг , бүх
замыг судлуулахаар морин цэргээ яаралтай явуулжээ .
Рассын цэргийг ойртон ирэхэд , лагериасаа гарч далд орсон босогчдын морин
цэрэг игивумыг дайран Камериуныг чиглдэн явсан

ба мөн Спартак бүх цэргийнхээ хамт хэд хоногийн өмнө Камеринумыг
дайран өнгөрсөн тухай красс даруй олж мэдлээ .
Тэгээд цэргийн, туршлагатай удирдагч хүн болох красс
Спартакий зорилгыг даруй ойлгон мэдэж ,
Спартакийн замыг боох нарийн ухаантай төлөвлөгөөг боловсруулан зохиожээ. Спарта
к Апеннинын уулын зүүн бэлийг дагаж явсан бөгөөд Красс тэр уулын баруун
бэоийг дагаж Ромын зүг хурдлан аялахаар шийджээ . Ингэж
Спартактай зэрэгүээ замаар нэгэн чиглэлд аяласан Красс ньб араг шув
шулуухан замаар явах болсон бөгөөд харн Спартак тойруу замаар явах ёстой байсан
юм . тийм учир Спартакийн гурав хоног явах газрыг Красс нэгэн өдөр явах
жишээтэй байсан бөгөөд энэ ашигтай тал нь
Спартакийн амжиж хожсон зай, цагийг эргүүлэхийн тул
красст зайлшгүй хэрэгтэй байсан юм .
Ромын легионууд хэцүү аялалд тав хоног гайхам сайшаамаар шамдалагатай явж Реаге
хүрчээ . Красс цэргүүдээ тэнд зогсоож нэгэн өдөр тэднийг амраажээ .
Спартак ер буёсын хурдан аялан явж энэ үед Клитернумд хүрч очжээ
. их борооны дараа үещрэлсэн Велинум гол, Спартакийн замыг фуций нуурын
дэргэд хаажээ . Энэ гол дээгүүр хөвмөл гүүр тавихын тул хоёр хоног цэргүүдээ тэр
гүүрээр гаргахын тул бас нэг хоног энд саатх явдал Спартакт тохиолпжээ .
Спартакийн Клитернумд хүрэлцэн ирсэн тухайг красс тагнуулуудаасаа олж мэдээд Авл
Муммийд хоёр легион цэрэг зургаан зуун мянган хүнтэй туслах хнүчниы хамт
өгч Ьелинум голыг Реагенын дэргэдүүр гатлан гарё голынхоо зүүн гар
талыг дагаж Альфа буцеллиас тийш хурдан аяллаар очиж түүгээр голынхоо баруун
гар талд гарч цаашаа шувт голын баруун гар талаараа нь бүр Клитернум хүртэл явах
хэрэгтэй гэж тушаажээ . Бас Спартактай тулалдаан үүсгэж хэрхэвч болохгүй гэж красс
муммийг хатуу хориглосоноор ч үл барам , харин
намайг хүрэлцэн очиж Спартакийн араас дайрах хүртэл ухарч байх хэрэгтэй гэж
түүнд тушаажээ .
Муммий Крассын тушаалыг ёсчилон биелүүлж Апеннинын уулын хавцлаар
дамжин Субиакад хүрч ханан хадтайы байцагт уулын
хажуу хамгийн тохиромжтой байр эзлэн бууж хоноод маргааш
нь цаашаа явахаар завдан байжээ.
Гэвч дайсанд ухарч өгч хэрхэвч болохгүй , заяагаараа дайрлдсан энэ сайхан
бололцоог ашиглаж Крассын тусламжгүйгээр Спартакийг бут цохиж болно. Уулын
энэ хавцал дотор Спартакт бүх хүчээ зэрэг ашиглаж чадахгүй гэж
цэргийн трибунууд муммийг ятгажээ . мөн трибунууд нь тус бүрийнхээ легионы
нэрийн өмнөөс гарамгай ялалт байгуулна гэж амлан энэ гаднаас халдан орох
газаргүй сайхан байрандаа Спартакийг хүлээе гэж Муммигаас гуйжээ .
Спартакийн цэргийг ямар ч маргаангүй ялна гэ: итгэж байсан
муммий өөрийнхөө итгэлд бүрэн автагдаж маргааш нь Спартакийн цэргйг хүрч
ирэхэд тэдэнтэй тулалдаж гарчээ .
Тэдний эзэлсэн байрнаас ямар ч ашиг
олж чадахгүйгээ Спартак мэдээд арван гурав ба арван дөрөв
дүгээр легионуудаа дайсантай тулалдаж байх завсар нь
бусад легионыхоо дотроос бүх хөнгөн зэвсэгт явган цэрэг
ба харвагчдыг цуглуулан нэгэн
корпус байгуулж орчин тойрны уулсын орой дээр гарцгааж дараа нь
дайсны харвагёч ба дүүгэрдэгч цэргүүд ойр хавийн уулуудын орой бүхнийг эзлэн авч ,
тэндээс янз бүрийн сумуудаар мөндөр шиг харваж бас
ар өвөр хоёроос зэрэг дайрахаар уулнаасаа бууж, иржявахы нь Ромынхон үзэж айх

гайхах хоёр нь хэмжээнээсээ хэтэрч
, зэр зэвсэг хужяг дуулгаа хаяцгаан эргэж харалгүй зугтжээ.
Энэ тулалдаанд ромынхон долоон мянга гаруй хүнээ алуулжээ .

## ГАРГАНЫН УУЛАНД БОЛСОН ТУЛАЛДААНААС ЭХЛЭН КРИКСИЙГ ОРШУУЛАХ ХҮРТЛЭХ ЯВДАЛ

Субиакт болсон тулалдаан гладиаторуудын бахдам сайхан ялалт , ромынхонд маш амуухай хохирлоор дууссан боловч Спартак энэ тула лдаанаас ашигтай зүйл оллоо гэж огт үзээгүй билээ . гэвч Красс , Спартакийг энд нь саатуулж чадсангүй . крассын цэргийн түрүүчийн анги гол наталжээ гэдгийг морьт тагну улуудаасаа сонсож Крассын цэргийг ардаа үлдээж одоо , Ромын зүг явж болохгүй боллоо гэж Спартак даруй ойлгосон юм . иймийн учир Спартак тэр оройдоо Субиакаас гарч лирис голыг эхээр нь гаталж Кампанья руу чвжээ .

_ Авл муммийн бут цохигдсон тухай, красс маргааш орйо
нь сая олж сонсоод Муммийн цэргээс оргож зугтаж гаргасад нь Ром хүрсэн бөгөөд , бас
дахин нам цохиулсан сургийг сонсож Ромынхон бүр ч их айн сандарчээ. Харин красс илгээсэн мэдээндээ тэр их тулалдаан н
айж сандарсан хүмүүсийн ярьсантай адил тийм сүрхий юм огт босон биш гэж бичиж сенатын санааг тайвшруулжээ .
Муммийн легионуудаас оргож зугтаж очсон хүмүүсийг бүгдий
нь яаралтай буцааж над руу явуулна уу гэж мөн тэр айлтгал
дотор дретор гуйсан юм. Хэд хоногий дараа оргогсод бүгд их уруу царайтай , ичиж гутсан байдалтай лагерьтай буцаж ирлээ .
Красс преторийг
тойруулан бүх цэргээ дөрөвлжлүүлэн жагсааж оргож, яваад ирэгсдий н голд нь зэвсэггүй зогсоож үг хэлжээ . Крас илтгэл яриа
сайхан хийдэг хүн байсан юм . Эцэг өвгөдийнхөө гартаа
барьж харьцуулашгүй аюултай бэрх шалгалтыг туулж, дэлхий дахиныг эзэмшүүлсэн тэр зэвсгийн нь хөсөр хаяж аймхай муусайн э мс шиг зугтаж нэр хүндээ гээлээ гэх зэрэг хатуу
ширүүн үгээр цэргүүдээ харааж и, гладиаторууд
нь ормын легионуудыбн аймхай хүмүүс болж хүчтэй зоригтой юм шиг байхаас биш , үнэхээр өөрсдийнхөө гарамгайгаас тийм байсан юм биш гэдгйг батлан халж, бас урьд
ялагдашгүй хүч чадлаараа гайхуулж байсан ромын лүегионууд нв одоо дэлхий дахины доог үзэшгүй муухай легион болжэ гэж таниулав.

Энэ мэтээр дайрснаас
шившигтэй зугтах явдлыг хүлээж чадахгүй , одоо гарамгай үйл ажил , цууриатай ялалт хийх цаг нэгэнт болжээ, үүнийг бүтээхийн тулд та нарт , өөрсдийнхөө нэр сүрийг бодох ромынхоо алдар нэрийг хайрлах хүсэл багадаад байгаа бол төмөр мэт хатуу сахилга бат хамгийн хатуу арга хэмжээний тусламжтайгаар би ялалт байгуулна гээд Красс үгнийхээ төгсгөлд:
_ Зарим нэгэн онцгой үед манай эцэг өвгөдийн хэрэглэж байсан арван хүн тутмаас нэгий нь цаазаар аваачих децимация гэдэг арга хэмжээг хүчин төгөлдөр болгон дахин хэрэглэх гэж байна. Энэ аюултай сүрхий арга хэмжээг тусламжинд хандаагүй болсоор бараг хоёр зуун шахам жил болж байгаа юм . Тэгэвч нэгэнт та нар , мууу дайсны өмнө зэвсэг хаяж шившигтэй зугтсан учир эв нэгдлийн бурхдын өмнө тангаргалая! Энэ арга хэмжээгээр та нарбг шийтгэнэ. Хэтэрхий орой гэмээ мэдэж нулимсаа асгаруулан түүгээрээ дарж, царай нь цав цагаан болон ичингүйрэн та нарын өмнө зогсож байгаа арван мянган аймхай ч энэ арга хэмжээгээр өнөөдөр шийтгэгдэнэ гэжээ.
Крассын хамгийн нэр хүндтэй трибунуд болон патрицууд нь хичээнгүйлэн гуйсан боловч Крас нэгэнт шийдсэн арга хэмжээгээ өөрчилсөнгүй харин өнөө оройны дотор багтан гүйцэтгэх хэрэгтэй гэж тушаажээ .
Яллагдагсад завсраа шодож эхэллээ .
Арван хүнийг төлөөлж алагдах ял ноогдуулсан пайз сугалсан хүн бүхнийг ликторт шилжүүлж байжээ . тэр бүрийг ликтор урьдчилан торлогдож дараа нь толгойгий нь огтолж байжээ .
Энэ айхтар ял , зэвсгээ хаяж, дайснаас зутсан нөхөдэйгаа ямар ч холбогдолгүй , харин дайсантай гарамгай тулалдаж байсан хүмүүст ноогдож байсан явдал ромынхныг сэтгэлд хүнд хар сэтгэгдэхүүнийг төрүүлж байжээ . Муммийн легионуудын дотроос , хэн бүхний мэдээжээр хамгийн зоригтой хамгийн гарамайг сайн тав зургаан цэрэг бусдынхаа аймхай муугийн харгаагаар , цаазлагдах ял ноогджээ.
Зоригтой энэ хүмүүсийг доторoос Эмилий Глабриан гэдэг хорин настай залуу бусдынхаа өрөвдөх хайр сэтгэлийг цлам илүү татжээ . Энэ залуу , Субиакийн дэргэд болсон иулалдаанд гладиаторуудын дайралтанд эсрэг зоригтой тулалдаж, хоёр удаа шархадсан болоч ,б айраа хатуу хамгаалан тулалдаж байгаа нөхдийнхөө зугтаж одоход арга буюу хойноос нь дагсан юм . үүний энэ бүхнийг бүгдээр мэдэж байсан бөгөөд мөн бүгдээр энэ

тухай дээш нь мэдэгдэж байсан боловч алагдах ялын пайз үүнд дайралдсан нь хууль дагасан хэрэг байжээ .
Гарамгай энэ залуугийн гарч ирэхэд түүнийг өрөвдөх бүгдээр нулимсаа асгарулж байсан бөгөөд хэдийгээр царай нь хувхай цагаан болон боловч муций Сцелова, Юний Брут нарын
нэгэн адил зоригитой тайван гарч ирээд преторын өмнө зогсож :
_ Чиний авч байгаа , децимацчлах арга хэмжээ
нь бүгд найрамдах улсын сайн сайхын хэрэгт ашиг тустайгаар
ч барахгүй , сүүлчийн тулалдаанд манай
хоёр легионы хийсэн гутамшигт муухай явдал тул ийм шийтгэл хүлээх ёстой явдал мөн
байна. Мииний хувь заяа буруу хандаж би ингэж үхэх ёстой байжээ. Ахав үхнэ. Гэвч намайг зориг муутай эр
биш дайснаас зугтаагүй хэдийгээр шархадсан боловч ромын хүний ёсоор зоригтой тулалдаж б айсныг Марк Красс чи ч
өөрөө мэднэ , миний нөхөд ч бүгдээр мэдэж б айна. Иймд чамаас би өршөөл гуйх байна. Ликторуудын торлог миний нурууг бүү бузарлаг, тэд нар намайг шууд сүхээр цохиж алах биз гэж эрэлхэг зоригитой гуйжээ . Претор Красс залуугийн үгийг сонсоод: царай нь хувсхийн цайрч :
_ Зоригтой залуу минь , чиний хүсэлтийг хүлээж авахыгш би зөвшөөрч байна , чиний амийг уучлах явдлыг манай
өвөг эцгйн хатуу хууль зөвшөөрөхгүй байгаад би их
харамсан гашуудаж байна… гэлээ .
_ Миний амь нас , эх орны төлөө болох учир байлдааны талбар дээр дайсны гарт үхэх юм уу аль, энд преторий
дээр ликторуудын сүхэнд цавчигдан алагдах хоёрын аль нь
ч надад ялгаагүй .Намайн аймхай муу эр биш гэдгийг миний эх , ард түмэн сенат бүгд нэгэнт мэдсэнээс хойш, бас би
нэр хүндээ хамгаалан үлдэж чадсанаас хойш үхэх гэдэг өчүүхэн хэрэг гэхэд нь Муммийн легионуудын эгнээнээс нэгэнц эрэг:
_ Залуу баатар эр чамайг алахгүй! Гэж хашгаран гарч ирээд хоёр нүднийхээ нулимсыг асгаруулан преторий дэргэд очиж :
_ Алдарт Красс минь ээ, би бол гуравдугаар леионы гуравдугаар зуутын уэрэг ромын иргэн Валерий Атал гэдэг хүн байна. Субиакийн тэнд болсон тулалдаанд би энэ эрэлхэг залуугийн дэргэд байсан юм . Өөрий нь дагуулан бидний зугтан зайлах үед шархтай байсан энэ залуугийн ямар их зоригтой тулалдаж байсныг би нүдээр харсан. Тэгэхэд оргож зугтсан арван хүн
бүрийн нэгийг одоо ликтор цаазаар аваачих ёстой болсон

учир зугтагсадын нэгэн болох намайг алаач, харин эртний ромын хүн мэт тулалдаж байсан энэ залууг орхино уу? гэж гуйжээ .
Байлдааны үед нийтийн сандралд автан дайснаас зугтсан боловч , одоо сайн сэтгэлийнхээ хүслийг илэрхийлсэн энэ цэргийн үг нийтийн сэтгэлийг ихэд хөдөлгөжээ . намайг ал намайг ал гэж булуулдах өр өвдөм сайхан сэтгэлийн тэмцээн Атал, Глабрион хоёрын зөвсөр үүссэн боловч Крассын шийдвэр гуйвалтгүй байсан учир Глабиороныг ликторуудад шилжүүлжээ .
Шийтгэгдэж байсан хоёр легионы цэргүүдийн дунд гомдлын шуугиан сонсогдон мөн олон мянган цэргийн нүдний нулимс гарчээ . тэгэхэд Глабрион нөхөд тийшээ эргэж хараад.
_ хэрэв та нөхөд намайг гэмгүй атлаа алагдаж байна гэдэгт итгэж байгаа бол хэрэв надад тохиолдож байгаа энэ явдал та нарын үнэн сэтгэийн харамслыг дуудан гаргаж байгаа бол хэрэв та нар миний сүнсийг Элигиумд тайтгаруулахыг хүсэж байгаа бол муу сайн гладиаторуудад ар нуруугаа харулалгүй явсаар бүгдээр үхнэ гэж эв санаанб бурхдын төлөө тангаргалая! Гэсэнд:
_ Тангаргалая!… тангаргалая!…
Бурхдын нэрээр тангаргалая! Гэцгээн жаран мянган хүмүүс нэгэн зэрэг хашгарсанг нь аймшигт аянгын дуу мэт нир хийлээ .
_Дээдэс бурхад Ромыг хамгаалах болтугай!…
_Би баяртай үхнэ! Гэж хөөрхий залуу хэлжээ .
Зоригт залуу , нүцгэн
хүзүүгээ ликторын сүхэнд дургүйлэхийн тавьж өгсөнд ликтор эьтэй х урдан хөдөлгөөнөөр сайн
сэтгэлт түүний толгойг тас цавчиж орхисонд цус болсон толгой нь газар өнхрөн ойчиход бүх нийтээрээ айн цочиж түүнийг өрөвдөн элэг эмтэрчээ .
Хацар дээгүүр нь өнхрөн
ажлаа дуусасанд нулимсаа далдлахын тул Марк Красс нүүрээ буруулав.
Ингэж яллан шийтйгэх ажлаа дууссанд , Муммийн легионы оргогсод зэр зэвсэг эргүүлэни олгох тухай, Марк
Красс тушаагаад товч үг хэлж хойшид гладиаторуудаас та нар зугтахгүй бизээ гэсэн итгэлээ илэхийлжээ .
Цаазаар аваачигсад есөн зуун хүний хүүрийнг оршулах тухай бас тушааж , маргааш нь лагерилан газраасаа хөдөлж , Спартакийн замаар хөөжээ . Спартак Ромыг довтолж болохгүй болжээ гэдгийг мэдээд маш хурдан аялж Кампания, самниумыг даран цэргүүдээ Апулия руу аваачжээ . ингэхдээ Крассыг тийш нь дагуулан аваачиж чадах байх гэж Спартак хатуу итгэж байсан юм

. Ромоос зайд газар дайсантай шийдвэрлэх тулалдааныг
хийж дайсны цэргийн легионуудыг бут цохисныхоо дараа Тибрагийн зүг хөдлөнө гэж Спартак найдаж байжээ .
Спартак цэргийнхээ хамт маш хурдан аялсан
боловч, дециманчлах ялалтыг үзэж мэдэрсэн цэргүүдтэй Крассын легионууд Спартакийнхнаас дооргүй хурдан аялжээ .
Ингэж Сипонтумийн ойролцоо даунчуудын нутагт лагерилан буугаад байсан
Спартакийн цэргийг аравн тав хоногийн дотор протер цэргийнхээ хамт гүйцэж очсон юм . Красс энд очихдоо Спартакийн цэргийг нэг талаас өөрийнхөө цэргээр нөгөө талаас далайгаар
хаших зорилготой очсон учир Арпи, Сипонтум хоёрын
завсар буудалллаж ,
Спартактай тулалдаж эхлэх зохистой цагийг хүлээн суужээ .
Энэ цагасс хойш гурав хоног өнгөрсниы дараахь энгэн намухан сайхан шөнө хоёр талын цэргүүдийн нам гүм нойрсож байхад , Крассын бие
хамгаалагч түүний майханд нь ирж сэргээгээд нэгэн гладиатор хүрч ирээд претор тантай онц чухал зүйл ярилцах хүсэлтэй бана гэж Красст илтгэжээ .
Красс нь маш даруу тогтвортой бөгөөдб ага унтдаг хүн байсан юм . Бие хамгаалагчийн илтгэлийг сонсоод босож тэр гладаторыг оруулж ир гэж түүнд тушаажээ .
Энэ гладиатор нь бие багатай сайхан зэвсэгтэй байлаа . Түүний царай нь дуулганыхаа саравчны цаана халхалагдсан байлаа . тэр, Крассын дэргэд
хүрч очоод дуулганыхаа саравчийг өргөж бүсгүй хүний
цайвар царайгаа харуулжээ .
Энэ гладиатор нь зэвсэг барьж хамт тулалдаж явсан ах дүү нараа красст барьж өгөх зорилгоор очсон Эвтибида бүсгүй байжэ .
Марк Лициний Красс, чи намайг танхгүй байна уу? гэж тэр бүсгүй шоглон асуужээ .
Претор үүнийг хаанаа үзснээ санаж ядан , таньж байна… таньж байна… таньсан хүний царай шиг байнаа… гэж түгдчин хариулжээ .
Ямарич эр хүний сэтгэлээс ямагт гардаггүй Эвтибидагийн үнсэлтийг амархан мартаж орхих шив дээ
гэхэд нь:
_ Эвтибида Юпитерийн аянганд тангаргалая!
Яагаад энд яваад ирэв? Энэ шөнийн цагаар юунд ирэв?… юунд ийм зэвсэгтэй ирэв? Гэж Марк Красс ихэд гайхан цочин асуужээ .

Энэ бүсгүйг сэжиглэн болгоомжлох сэтгэл Крассын дотор гэнэт төрж нэгэн алхам гэдрэг ухран хоёр гараа тэврэн зогсож хурц гэрлийн очийг гялалзуулан харж байсан бүсгүйн шаравтар бор нүд рүү нь харж :

Хэрэв чи намайг торондоо оруулан барьж авах гэж ирсэн бол дэмий иржээ зорвсон хэрэг чинь бүтэхгүй гэдгийг урьдчилан сануулъя учир нь би бол Клодий ч биш, Бариний ч биш бас Лифидий Орест ч биш … гэж
ширүүн дуугаар шийдвэртэй хэлэхэд нь: Грез бүсгүйы хэрцгий занг биедээ агуулсан Эвтибида преторийн зүг хорсол хилэнгээр дүүрэн харцаар харж хүйтэн инээмсэглэн :

_ хөөрхий муу Красс минь энэ чинь чиний мохоодуу хүн байх явдалд чинь саад болохгүй бизээ гээд нэгэн минут хир дуугүы байсанаа дахин дуугарч :

_ Красс чи ромынхны дотроос хамгийн баян нь болохоос биш хамгийн ухаантай нь бишээ гэхэд нь красс:

_ Чи яах гэсэан юм? Чи юү гэх гээд байгаа юм? … товчхон хэл л дээ гэхэд нь.

_ Олимпийн Юпитерийн алдарт тангаргалая, би чамд ялалт авчирахдаа намайгингэж хүлээж авах байх гэж огт бодсонгүй . хүнд сайн үйл бүтээж өгшштэй байдан байна!… Мөн ч сайхан шагнал хүртээдэг юм байна… бурхдад тангаргалая! Гэлээ . Красс бүсгүйд бас л сайн итгэхгүй :

_ Чи яах гэж энд ирсэн тухайгаа хэлэхгүй юу? Гэхэд нь Эвтибида , яагаад Спартакийг хэзээ ч мартагдашгүй о үзэн ядах болсон хийгээд тийм явуулгаар яаж арван мянган германг бут цохигдсон тухай өас тэр тулалдааны дараа өшөө хонзон авагч Эриний дагинын нэрийг олж авсан тугайхаа , Красст нэгд нэгэнгүй тоочин хэлээд ,
ромынхноос гладиаторуудыг гялалзсан амжилтаар шийдьвэртэй ялах явдалд нь Криксийн ыбие хамгаалагчийн албан тушаалд томилогдож чадсанаа хэлжээ .

Эвтибидагийын энэ бүгдээ хэлж байхад нь красс түүнийг сорин харж их анхааралтай сонсмож байжээ . Эвтибидаг үгээ хэлж дүүрсний дараа :

_ Чиний саяны хэлсэн энэ
бүх яриа чинть намайг Спартакийн бэлдсэн занганд хийх арга заль байсан бол яахав?… тийм үү хамгийн сайхан бүсгүй Эвтибида чи энэ тухай юу гэж хэлмээр байна? … чиний хэлсэн үг зөв хийх гэж байгаа ажлын ариун болох тухай хэн надад баталж өгөх билээ? … гэж яаралагүй тайван асуулаа.

_хэлсэн бүхнийхээ үнэн
болохын баталгаа болгон өөрийнхөө амь насыг чамд өгье гэв.
_ Чиний энэ чинь зөв
арга заль бол яахав? Боолчуудын үйл явдлыг ялуулахын тул чамайг амь насаа зориулсан байвал чинь яахав? Гэж ямар нэгэн
зүйлийг эрэгцүүлэн бодох шиг болж Красс хэлжэ .
_ Красс чиниы бурхдад тангаргалая!
чи хэтэрхий муу санаатан болжээ!\
_ Хүмүүст хэтэрхий итгэмтгий байснаас хэтрхиы хартай байсан нь дээр шиг чамд санагдахгүй байна уу? гэж Сицилийн претор тайван хэлжээ .
Эвтибида , Крассын зүг шоолон ханасан байдалтай харж түр зуур дуугүйы байснаа :
Хэн мэдэх вэ? … чиний ч зөв байж болно юу ч үл атугай Марк
Красс чи миний хэлэхийг сонс! Спартак, Крикс нар болон
гладиатор нарбн бусад удирдагч надад бүрэн итгэдэг юм гэдгийг би чамд хэлсэн билээ . мөн түүнчлэн үл бүтэх муу фракий хүн чамайг яах бодол тавьж байгаг би мэднэ. Гэлээ .
_ Чи худал хэлээгүй биз? Тэр намайг яах гэж бодож байна?… үзнэ дээ гэж Красс тоглосон байдалтай боловч үнэнээсээ бололтой асуужээ .
Сургаа хурдан чамд хүргэхийн тул ихээхэн цуурига яимээ гарган маргааш үд дунд дөчин мянган хүн Спартакийн удирдлагын
дор Сипонтумаас гарч пецентанчуудын нутаг руу явах гэж байгаа бололтой Барлеттыг чиглэн явна. Энэ үед нь Крикс ,
Спартакаас тасарлаа гэдэг цуурхал тараан, Спартакийн тасарч явсан т ухай мэдээ сонсмогцоо чи Криксийн цэргийг дайран орно.
Тэгэхэд мөн
Крикс яамтай тулалдаж эхлэнэ, тэгэхэд цэргийнхээ хамт зэрэгцээ газр ын модон дотор нуугдаж байсан Спартак хурдан буцаж ирээд
чинийы ахр талаас дайрна, тэгэхэд чиний цэргүүд хэдий их
зоригтой боловч бүгдээрээ цавчигдан алагдана.
_ Яа, Яа! Энэ чинь тэдний нөгөө төлөвлөгөө юү гэж Красс асуужээ .
_ Тиймээ
_ Тэр арганд нь би орох уу, үгүй юу гэдгийг үзнэ дээ!
_ Хэрэв миний энэ тухай чамд хэлээгүй байсан бол Красс минь чи тэр арганд нь заавал орох байсан юм гэдгйг лаьтай хэлнэ. Чи улам их
юм бүтээхийг хүсэж байна уу? Тэдний арга мэхнээс мултрахаасч барахгүй тэднээс чамд бэлдэж тавьсан урхиар нь өөрсдий
нь барьж авахыг чи хүсэж байна уу? Криксийн гучин

мянган цэргийг бут цохиж бүрмөсөн устгаад дараа нь
Спартакийг дайран орохыг чи хүсэж байна уу?
- Тэгэхийг хүсэж байна гэж бодъё… тэгэхийн тул би яах ёстой байна?
- Маргааш үүрээр эндээс хөдөлж Сипонтум руу
явах хэрэгтэй. Чиний тэнд хүрэхэд Спартак цэргийнхээ хамт арван тав хоногийн миль холдсон байна. Чиний тухай
Спартакт мэдээлэх явьдлыг надад даалгана байх тэгэхэд
н би чамайг лагериа хөдлөөгүй байна гэж Спартакт очиж хэлээд буцаж ирж чамайг Гарганын уул
тийү очиж хэрэв Криксийг довтолбол түүнийг сүүлчийнхээ хүчийг ш авхан дуусах
хүртэл хамгаал гэж Спартакаас эцээхэн холдож Гаргаусын хажуу хүрмэгц чи түүнийг дайран орох хэрэгтэй , Криксийн хүнд
байдалд орсон тухай мэдээ ямар нэгэн замаар
Спартакт хүрч Спартакийн эргэ ирж Крикст туслах хүрүтэл
ньв Криксийн цэргийг бүрмөсөн бут
ниргэж амжих цаг чамд хүрэлцээтэй байх болно.
Магадгүй , өөрөөс нь ч илүү нарийн бодож зохиосон байлдааны төлөвлөгөө ярьж байсан энэ бузар бүсгүйг , красс гайхан харж байжээ . хацар нь ув улаан болсон сээтгэнүүр бүсгүйг Красс удтал дуугүй харж байснаа :
- Чөлөөлөгч Юпитерт тангаргалая!, чи бол аймшигт эм байна! Гэлээ .
- намайг эрчүүд ийм болгосон юм
гэж бүсгүй хүйтэн инээмсэглэн хэлээд одоо энэ
тухай ярилцахаа болъё. Харин миний бодож гаргасан төлөвлөгөө тоо цооны тухай чи юу гэж бодож байна?
- Үүнээс илүү саяхавтар бөгөөд нарийн тодорхой төлөвлөгөөг хэн
ч тамд орлоо ч гэсэн бодож гаргахгүй бизээ
. Гэвч давтаж хэлэхэд би чамд итгэхгүй байна…
- Тэгвэл яах вэ , сонсож бай. Урдаа тагнуул гаргаж
их болгоомжтой явуулаадп үдэш болохоос хоёр
гурван цагийн урьд эндээс гарч Сипонтумын зүг явбал чамд
ямар аюул байна? Муугаар бодож , чамайг би мэхэлжээ гэж
бодоход чи гладиаторуудын бүх цэрэг дээр л орно биз. Чи чинь тэртэй тэргүй гладиаторуудын ыүх цэрэгтэй тулалдах гэж байгаа юм иш үү? чи чинь тэдэнтэй шийдвэрлэх тулалдаан хийх гэж тэсч ядан байгаа юм биш үү? Намайг чамд худал хэллээ гэж бод л доо, тэнд
Криксийн цэрэгтэй дангаараа учрахын оронд бас тэнд Спартакийн цэрэгтэй уулзана гэж бодоход аюултай эвь юу байгаа юм ? үүний муу тал нь юу байна ?
Красс бага зэрэг бодож байснаа :

- За чамд итгэж байна… өөрөөр хэлыэл чамд итгэвэл дээр гэж би үзэж байна . Бүгд чиний хэлсэн ёсоор болох юм бол чамд
их шагнал олгоно, бас ромын ард түмэн чиний үзүүлсэн чухал тусла мжийын тухай би сенатад мэдэгдэнэ, тэгээд чи сенатаас бүр ч
их шагнал хүртэнэ гэдгийг би амлан хэлье гэжээ .
- Та нарын шагнал ч надад хэрэггүй!
Ромын ард түмэн ч надад хамаагүй ! Чамд ялалт авчрахдаа чиний тулд биш бас ромынхны тулд ч биш харин Спартакаас өшөөгөө авахын тул авчирсан юм!… хариугаа авна гэдэг бол үгээр
хэлж болшгүй ариун сайхан зүйл гэдгийг чи ойлгон мэлдэрч чадна уу? Үхэж б айгаа Спартакийн цээжин дээр өвдөглөн дарж
байхыг үзэж чадвал үй түмэн үхсэн хүүрүүдийн дунд үхэж б айгаа Спартак сүүлийнхээ амьсгал авч байхы
нь сонсож чадвал!Чиний хайр хишиг ч надад
хэрэггүй Сенатын шагнал ч надад хэрэггүй гэж грек хүүхний нүд хорсол заналаар эргэлдэж чичирсэн дуугаар хэлжээ .
Эвтибидагийн царай эвхэн таталдаж аюумшигтай муухай болсон учир айн жигсэнээсээ болж крассын бие зарсхийжээ .
Эвтибида ухасхийн мориндоо мордоод ромынхны лагериас гэлдэрн гарч цаашаа омоглон морио ширүүн
хатируулан гладиаторуудын оагерийг яиглэн явлаа .
Красс үүр цаймагц майхнаа буулгах тушаал цэргүүддээ өгч, бас легионууды түрүүнд гурван миль зайтай явж далд газар нуугдсан болзошгүй дайснй цэргийг тагнах хэрэгтэй гэж таван яманг морьт цэрэгт тушаагаад , нар
гарсны дараахан өөрөө Сипонтумын зүг хөдөлжээ .
Энэ үед Спартак найман егилн ба мөн морин цэргийнхээ хамтаар Барлеттийн зүйг явж байжээ . Крикс нь өөрийнхөө зургаан легион хамтаар Сипонтумдээ үлдсэн байжээ .
Спартак Крикс хоёрын завсрын
ширүүн хэрүүл маргааныг цлмаас босогчдын цэрэг хоёр тасарч нэг нь Арпийн орчим лагерилаж
байгаа ромынхны легионуудыг хоргилох гэж нөгөө хэсэг
нь Беневтумыг дайран ром
руу явахаар шийдэж гэнэ гэсэн цуу үг орчин хавьд тархаж байжээ . төдхөн энэ цуу үгшийг крассын тагнуул анги түүнд мэдэгджээ .
Ромынхны дарга энэ мэдээг сонсож “Эвтибида
хүүхэн биднийг хуурчээ гэж үзэх сэжиг одоохондо үгүй л байгаа юм байна. Энэ бол сайн хэрэг бизээ” гэж боджээ .
Дараагийн шөнө, Сипонтумээс дөрвөн
миль зайтай байгаа гарганын уулын өтгөн ойн хавцалд Крассын цэ

ргийн чив чимээгүй нуугдаад байх үед нь Эвтибида хүүхэн Барлетта очих замаар морины хурдаар давхиж байжээ .
дайсан Арпигаас гарч ирлээ , бидний арганд орлоо . Спартак ч чи даруй Сипонтумд ирэх биз гэсэн Криксийн мэдээллийг Спартакт хүргэх гэж яваа нь тэр ажээ .
Грек
хүүхэн Спартак хүрэлцэн очиж, түүний сэтгэл зовинолнг асуусан асу ултанд хариулан:

- Красс Сипонтум руу хэдэн мянган
хүнтэй тагнуулын анги явуулсан боловч өөрөө Арпи дахь лагериасаа гараагүй байна. Манай тагнуулын надад
мэдээлсэнээр үзэхэд ромын легионууд лагериасаа
гарахаар бэлдэх тушаал аваагүй байна гэж Крикс хэлүүлж байна гэлээ .
- Ээ бурхдын төлөө Крикс чинь миний бодож б айснаас
ухаантай зальтай хүн байх нь ээ гээд Спартак нэгэн хэсэг дуугүй байсанаа Эвтибидад хандаж :
- Одоо чи буцаж Крикс дээр очиж , тэгээд юу ч болж байсан
лагериасаа ыитгий гар , хэрэв дайсан ирж тулалдау эхэлбэл
бие хамгаалагчдаасаат гурван хүнийг арван
тав таван минутыбн завсартай над руу явуул гэж байна гэж крикст хэл гэжэ э . Тэр гурвын нэг нь яагаад ч гэсэн над дээр ирж чадах байлгүй . Крикс бид хоёрыбн саланги байх
энэ тохиромжтой үеийг ашиглан бид хоёрыг тус тусад нь
бут цохихыг дайсан хичээхгүй ыайгаа
эн яьдлыг бидний хувьд муу зөн билэг болж байна гэж би үзэж байна гэжээ .
- Спартак толгойдоо орж ирж байгаа, му ёрын зүйлийш хөөж гаргах гэж ббайгаа мэт боловч гараараа духаа илсэнээ ,
- Чи лагериасаа гарч энд хүрч иртлээ хичнээн цаг явав? Гэж Эвтибидагаас асуулаа .
- Хоёр цаг хүрэхгүй явлаа .
- Чи морины хурдаар явсан биз дээ?
- Миний морийг хартал андашгүй
- Буцахдаа бас морины хурдаар яваарай

Эвтибида Спартактай салах ёслолоо хийсний дараа морио эргүүлж , Сипонтумын зүг давхиж одлоо .
Эвтибида буцаж ирээд Спартак чамайг Симонтумаасаа
гарч гарганус уулын хормойд очоод, тэнд хаанаасаа ч
орж болшгүй бэхлэгтэй газар орж байрлахыг бод гэж тушааж байна гэжээ .

Үүр цайых хүртэл хоёр цаг байсан бөгөөд Крикс тэр дороо майхнаа яимээгүй буулгах тушаал цжэргүүддээ өгч, нар мандахаас өмнө Криксийн цэргүүд Гарганус очих замд гарсан байжээ .
Криксийн фэрэг, дөрвөн цагийн
дараа тунгалаг устай Атриатикийн далай тийш хандсан маш өндөр уулын хормойд очиход Атриатикийн далайн
усны давалгаан дээгүүр загасчдын онгоцны цав
цагаан адлбаанууд гялалзан харагдаж байжээ .
Крикс цэргийнхээ хамт далайн хөвөөн дээрб
айгаа Граганын уулсын сүүлчийн салбар уулан дээр гарч тал б бүрээсээ хамгаалалттай тохиромжтой газар
зогсож эндээ лагерилан суух тушаал өгч байх үед нь:
- Ромынхон!… Ромынхон!… гэж хашгаралдах чимээ сонсогдлоо .
Энэ урван тэрсэлсэн эмийн заавраар энд ирсэн Крассийн ленгионууд байжээ . Ингэж гэнэт дайсны дайран ирэхэд Крикс айж сандарсангйү хатуу зоригт , цэргийн гарамгай удирдагч хүний ёсоор нгазрын овон товныг анхааран тэнцүүлж легионуудаа байлдаан ы ёсоор жагсаажээ .
Дөрвөн легион дайсан
тийш чиглүүлэн жагсаж дайсантай өргөн эгнээгээр тулалдахын тул б аруун гар талын нь түрүүн лагериа байгуулах гэж байснаа одоо бэлтгэл хүч болгон үлдсэн тав ба зургадугаар үегионуудаа хамгаалж байх тэр толгойноос эхлүүлэн, зүүн гар талы
нь далайн давалгаа мөргөж буцаж байсан элгэн гацаа
хүртэл сунгажээ .
Удалгүй ромийн зургаан легимон шигүү жагсаалаар гладиаторуудынг шуурхай дайран орж иржээ . тулалдаж байгаа хүмүүсийн
орилолдох зэрлэг дуун, зэр зэвсгийнхангинах ячих дүлийрэм дуу
ой цөлийн олон жилийн нам гүм байдлыг зөрчиж энэ ер
бусын чимээний цууриа
нэгэн амнаас нөгөө аманд нэгэн хаднаас нөгөө хаданд шилжин давта гдаж байлаа .
Крикс, Красс нар тус
тусынхаа цэргийн эгнээнүүдийг эргэж тэднээ тулалдаанд
зоригжуулан байжээ
. Энэ тулалдаан нь маш аюумшигт тулалдаан болж байсанб гаа аль ч тал нь ганц ч алхам ухрахгүй байлаа .
Ромынхон хэлхээ эгнээгээр довтолсон учир Криксийн легионуудын хамгийн зүүн гар талын үзүүр нь бүслэгдээгүй байснаас
болж дөрөвдүгээр легионы гурван мянга гаруй хүмүүс сул зогсож байжээ .

үүнийг лүегионы  зомандлагч  самнит  хүн Онаций  мэдээд,  тэр гурван мянган  хүнийг биеэр удирдах  гэж шийдээд  тийшээ  очиж  тэнд "Баруун  гар тийшээ  эргэх" тугшаал  өгч  дагуулан ромынхны баруун  гар  талын  жигүүр  тийш  очжээ. Баруун гар талын  жигүүрийн хамгийн  үзүүр нь  болж байсан ромын  легион  ар өвөр  хоёроосоо  зэрэг  түрэгдсаэн  тодөлгүй бүрэн сарнижээ . Гладиаторуудын  энэ амжилт  хуурамч  бөгөөлд  түр зуурын  амжилт  байжээ .  Учир нгь  сарнисан  энэ  жигүүрийг  командлаж  байсан  квестор  Скрофа  , туслах хүч  болоэн  үлдэж байсан Ромын морин  цэргийн анги тийш  давхиж хүрээд  хамгаалалтгүй хоцорч байсан  гладиаторуудын  зүүн гар  талын  жигүүрийг  зургаан мянган морьт  цэргийн дарга  Кней Квинтид тушаажээ .  Энвд удалгүзй  гладиаторуудын  гурав ба дөрөв д%үгээр  легионуудын эгнээ  ромынхны  морин уэргт араасаа  дайрулан  эвдэрчээ .
Красс, Криксийн  баруун гар талын жигүүрийг  бүслүүлэхээр  хоёр легион  цэргийн мөн зургаан  мянган  харвагчдын  хамтаар  зэрэг  явуулсанд  тэд нар  нь ер  бус  хурдан  шаламгай  явж, гладиаторуудынтуслах хүчний  байрлаж б айсан толгойн  арын   оргил дээр  гарч ыдараа нь  тжр  толгой дээро  гарч ,  мөн  толгойг  тойрон  дугуйран  бууж ирээд,  гладиаторуудын тав ба зургадугаар  легион  довтолжээ .  тэгэхэл нь тав зургадугаар  легион  баруун гар талынхаа  жигүүрийг  газры нь  бололцооны хирээр  сунгаж  байлдааны  шинэ  шугам  бий болгожээ . ингэж  гладиаторуудын  цэргийн  тулалдаан  хоёр эгнээ  нь  сууриараа  далай тийш , оройгоороо  толгой тийш  хандсан  гурвалжны  хоёр тал  нь болжээ .
ЪАюумшигтай  ширүүн  тулалдаан  боллоо.
Гладиаторуудын  баруун гарын  жигүүрийн  бүслэгдэхгүй  байхы нь  Красс харж  , үүний өмнө  Скрофийн ашигласан  Онацийн алдааг  дахин ашиглан  зүүн гары  нь  жигүүрийг  бүслүүлэх зорилгоор  тэр чиглэлд  үлдэж байсан  морин  цэргээ  бүгдийг явуулсанаар  ч барахгүй , түүнийхээ  дээр бас  дайрах  тушаал  тэдэнд  өгчээ .
Ингэж  наян  мянган  цэргийн  урдаас  тулалдсан  гучин мянган  цэрэг энэ  тулалдаанд  гайхмаар  зоригтой  тулалдсан  боловч,  гурван цаг  хүрээгүй  хугацааны  дотор  Криксийн  зургаан легион  нь  тал бүрээс  бүслэгдэн хайр найргүй  хэмх  цохигджээ .
Крикс  тулалдаан  дуусан  дуустал , Спартакийг  ирэх байх  гэж найдаж  байжээ .  Крикс  нөхдийнхөө олошнхийг  алагдсан  байхыг  харж  морио  татаж зогсоон

, өгүүлшгүй уйтгар гашууд автсан нүдээрээ аймшигт ярга болсон талбайг тойруулан харжээ . энэ тулалдааны үед Криксийн унаж явсан морийг дайсан хоёр удаа алсан учир гуравдахь морио унаж явжээ . Криксийн хоёр хацар дээгүүр том том дусал халуун нулимс цувран унаж байжээ . Крикс, Спартакийн ирэх тэр зүгийг ширтэн:

- Ээ, Спартак минь!… одоохон ирж биднийгээ аврахгүй юм уу, биднийхээ өшөөг авахгүй юм уу!… хамгийн гарамгай сайхан гучин мянган нөхдийнхөө ингэж харамсалтай үхсэн байхы нь харахдаа, чи минь яадаг билээ! Гэж чин сэтгэлээсээ Спартакт хайртай дуугаар хоолой нь чичирэн өгүүлжээ .
- Крикс зүүн гараараа нулимсаа шийдэмгий арёаад, бие хамгаалагчид тийшээ хандаж .
- Ах дүү нар минь ээ!… одоо үхэцгээе!… гэж тайван бөгөөд чанга дуугаар хэлжээ . Бие хамгаалагчдийн нь дотроос Эвтибида бүр тулалдаан эхлэх үеэ аваад байхгүй байжээ . Крикс , алагдсан дайснуудын цусанд ув улаан босон сэлмээ өргөж дөрөөгөө жийж, ухасхийн бүх бие нь шархлан хэрчигдсэн боловч үргэлжлэн эсэргүүцсээр байсан хэдэн гладиаторуудыг бүслээд байсан дайсны нэгэн манипул явган цэргийн дэргэд хүрч очоод аймшигт сэлмээ толгой дээгүүрээ эргүүлэн:
- Хүүш ээ , зоригтой Ромынхон !Та нарч нэг хүний өмнөөс гурван хүн ирэхэдээ л зоригтой улс шив дээ! Амиа хамгаалаарай! Би үхэхээр шийдлээ! Гэж чанга дуугаар хашгарчээ .
- Дайсны эгнээн дотор орсон Крикс ба түүний бие хамгаалагч дөрвөн хүн тэдний шуурга мэт цавчилтаас арай ядан амиа хамгаалж байсан ромынхныг газар унаган мориороо гишгүүлэн хядаж гарчээ . Дайсны цэргүүд анхандаа нилээд сарнин ухарч байснаа дараа нь туслах хүч нэмэгдэн ирэх тусам хумирч манипул таван гладиаторуудыг бүсэлжээ . Хүрээлсэн дайсан гладиаторуудын морьдоос нь салган явсан боловч тэд нар галзуу ширүүн тулалдсаар байжээ . Гэвч ромынхон тэднийг тал бүрээс нь довтолсоор байж удалгүй дуусгажээ . Бүх биендээ хавтгай шарх олсон Крикс мөн алагджээ . Крикс жадлагдан унах зуураа, араасаа жадалсан байсан тийш эргэж жадаараа түүнийг шувт шувт жадлан хамт унажээ . таван алхам зайтай газраасаа харвасан суманд дахин дайрагдсан сүүлчийнхээ чадлыг барсан Криксийн жад тэрүүхэн Криксиын жадалсан дайсны ц эргийн цээжинд зоолттой хэвээр үлджээ .

- Спартак минь … чамтай … яалалт ямагт чамтай найзлах болтугай … гэж шивнэн амьсгал хураажээ .

Дайсны өөр нэгэн цэрэг ирж :

- Аа чи одоогоор тэр ертөнц рүү тонилж бай! гэж нэгэн хуучин уэрэг өгүүлжээ .

Бас нэгэн хүн Криксийн эргэн тойрон энд тэндгүй хэвтэж байсан алагдсагсдын хүүрийг зааж энэ хүн манай хичнээн олон хүнийг алж вэ, энэ хүнийг сүнсийг Эриб залгих болтугай! гэжээ .

Ингэж , Гарганын уулын дэргэд болсон тулалдаан , гурван цагийн дотор дуусжээ . Энэ тулалдаан ромынхноос арван мянган хүн алагдаж гучин мячнган гладиатор үхжээ .

Их төлөв шархтай дөнгөж найман зуугаадхан гладиатор амьдаар олзлогдсон байлаа . Крассын тушаал ёсоор олзлогдсон гладиаторуудыг ромынхны өнгөрсөн шөнө явж ирсэн замын дагуу загалмайлан цовдолж алжээ .

Алагдагсдын хүүрийг шатааж дараа н лагериа б айгуулан шуудуу бэхлэлт хийх тушаалыг Красс цэргүүдэдээ үдийн дараа өгчээ . Бас шөнө дунд хүрэл цэргүүдээ аянд бэлтгэхийг трибунд ба зуутын дарга нартаа хэлжээ .

Спартак , Криксийн бие хамгаалагчдын нэг нт ирэх байх гэж тэсэж ядан бүхэл өдөржингөө хүлэж бас шөнө турш хүлээжээ . ингээд хэн ч ирэхгүй болохоор нь маргааш үүрээр хоёр бие хамгалагчдаа тус бүрд нь зуун морин цэрэг өгч Симпонтумд ир гэж явуулжээ . Бас тэр хоёрыг тийш нь явуулдгийн учир нь Спартакийн цэргүүд лагериасаа гарахдаа гуравхан хоногийн хоол авч гарсан бөгөөд тэр нь өнөө орой дуусах байсан юм .

Спартакийн явуулсан хочр бие хамгаалагчдийн түрүүчийнх нь Сипонтум хүрч ирээд, Криксийн цэргүүдийг тэндээсээ явчихсан байхы нь үзэж маш гайхаж яахаа ч мэдэхгүй байснаа нөгөөхийнхөө хүлээж цаашид яах тухайгаа зөвлөн шийдэх гэж тогтоожээ . тэдний шийдэж чадахгүй гайхам мэлмэрч байх үед нь ромынхон анх гарч ирэхэд үед нь Криксээс Спартак руу явуулсан хоёр бие хамгаалагчид нь давхиж ирээд тэдний унасан морьд нь тоос шороонд дарагдсан байсны дээр багтран амьсгаадаж байжээ .

Энэ дөрвөн бие хамгаалагчийн , Эвтибидагийн урвагё бузар санааг ойлгож , Криксийн ямар аюултай байдалд орсныг мэдэж маш их айж сандран Спартакт мэдэгдэхээр морины хурдаар давхиж очжээ.

Тэдний
хүрч очих үед нь Гарганийн ууланд болж байсан тулалдаан төгсгөлд өө хүрч байсан ажээ .
Энэ урвагч үзэшгүй муу явдлын
тухай мэдээг сонсож түүний аймшигт гай уршиг ямар болохыг ойлго сон Спартакийн царай үхсэн хүний царай шиг хувхай цагаан болж :
- Халаг минь , тамын бурхдад тангаргалая ! Явцгаая!
Шадав явцгааж Сипонтум очъё! Гэжээ .
Мориндоо мордох зуураа Граникийг дуудаж:
- Намайг легион цэргийн яаралтай маршаар авч очих ажлыг чамд даалгая, цэрэг бүрийн хөл жигүүртэй яргалагдсан ах дүү нар маань алагдаж байна! Би морьт цэргийн хамт түрүүлэн очиж тэдэндээ туслаж байя… та нар минь ариун бүхний төлөө яаран нисэж хүрцгээ! Гэдэг үгийг нулимсандаа зангирсан дуугаар хэлж дуусмагаа найман мянган морьт цэргээ удирдан Сипонтумыг чиглэн хурдлан давхижээ .
- Фаг хагас давхиж хүрэхэд нв ядарч цуцсан морьдоос нь уур савсаж байжээ . Энэ дөрийг хүртэл Криксийн цэргийн лагерилаж байсан газрын орчим Спартак, ямар нэгэн аз завшаанаар амьд үлдсэн гладиаторуудптай дайралджээ .
Спартак амьсгалаа барьж ядан:
- Өшөө аваг Юпитерийн төлөө, юу болсоэн тухай хэлж өгөө ыгэжээ .
- Бид бут цохигдсон … биднийг устгасан … манай зургаан легионоос зөвхөн нэрнь үлдэнэ гэж тэдний хариулахад :
- Халаг хөөрхий муу сайн ах дүү нар минь !… халаг , хайрт Крикс минь ! гэж Спартак гайхаш тасран хашгараад ,
хоёр гараараа нүүрээ дарж тэсэж Ядан уйлжээ .
- Спартакийн ингэж сайхан сэтгэл угаас ариун ёсоор гашуудан байхы нь харж түүний бие хамгаалагчид ба морин цэргийн дарга нар дув дуугүй зогсож байжээ .
- Аймшигт мэдээ сонсож сандран зовж байсан бүх хүний царай эрэлхэг баатар удирдагчийнхаа нулимсыг харж улам барайжээ .
- Удтал анир чимээ гарсангүй байтал Спартакийн дэргэд байсан мамилий дугарч :
- Хамгийн ариун явдалд Спартак минь Зоригт .. аймшигт цагт хатууж… гэж чичирсэн зөөлөн дуугаар хэлжээ .
- Халаг Крикс минь!… хөөрхий минь Крикс минь!… гэж Спартак гашуудан ду алдаад барун гараараа мамилийн хүзүүгээр тэвэрч нүүрээ цээжин дээр нь унаган дахин уйлжээ .

- Түр зуур болсны дараа өндийж ирэхэд нь нүүр нулимсандаа нойтон болсон байлаа . Зүүн гарынхаа алгаар нүдээ арчжээ .
- Спартак минь , хатууж!… үлдсэн найман легионоо яаж аврах тухай бодоцгооё гэж мамилий хэлжээ .
- Тэр зөвөө!. Зайлшгүй үхэх аюулаас хамгаалах арга замыг олж тамын муу шулам эмийн бузар урвалтыг гай гамшигийн уршгаар тохиолдох аюулын багасгах хэрэгтэй байна. Одоо ухарая. Энэ хүнд тулалдааны дараа найм- арван цагаас бага хугацаанд багтаж, Крассын легионууд Гарганын уулнаас хөдөлж ёадахгүй байдлаа сайжруулахын тул тэр хугацаагий нь ашиглах хэрэгтэй байна гээд Спартак бие хагаалагчдынхаа нэгэнд хандаж
- Өдөр тутам гучин миль газар аялан Минервиум ба Веневийн дайрч явбал тав зургаа хоноол луканчуудыг нутаг хүрнэ, т энд шинэ боолчууд бидэнтэй нийлнэ: хэрэв бид тэнд Красстай тулалдах чадал олж авч чадахгүй юм гэхэд бид тэндээс бруцүүдийн муж руу явж тэндээсээ Сицилийн хүрч тэндхийн боолчуудын дугд болслогын дөли йг дахин дүрэлзүүлэн чадна гэжээ .
- Учиргүй давхиж ядарсан мориндоо хагас цаг амраасны дараа Гарган ууланд болсон аюулт тулалдааны дараа амьд үлдсэн боловч тамир тэнхээ нь тасарсан найман гладиаторуудын авч буцах тушаалыбг морин цэрэгтээ өгчээ .
- Спартак , өөрөө гурван морин цэргээ дагуулан Гарган ууланд очиж , Криксийн хүүрийг олж ирэхээр шийджээ . Эгэл хүний хувьд чи аюул ослоос огт айхгүй байж болно. Гэвч чи асар хүнд бөгөөд и ариун их үйл явдлын удирдагч зүрх судас нь болох хүн тул аюул заналын урдаас шууд явж болохгүй гэж Спартак ийн тийшээ явах явдлы нь Граник хорих гэж оролджээ .
- Би эсэн мэнд явж гурван хоногийн дараа Апеннинын уулан дээр та нарыг гүйцэж очно байх гэж бат итгэж байна. Хэрэв үхэх явдал надад дайралддаг юм гэлээ гэхэд , гарамгай зоригт Граник чамд , хүрэлцэхүйц туршлага , нэр хүнд холын хараа байна иймд чи дарлагчдын эсрэг явуулж байгаа дайнаа суурьтай шуу рхай явуулж чадна гэжээ .

Граник хичнээн оролсон боловч Спартак зорьсоноо өөрчлөхийг хүссэнгүй .

Ингээд Спартак морьт отряд дагуулан гарган уулын зүг явж энэ ууланд хүрмэгцээ , эндэх газрын байдлыг судлуулах ба мөн дайсны аяллын чиглэлийг судлуулахаар морьт цэргийнхээ

хэсгийг явуулжээ . Тэд нараасаа сэтгэл тайвшруулах мэдээ сонсожээ, мориноосоо бууж морио хөтлөн явган явах тушаал цэрэгтээ өгчээ . Тэгээд тэд нар Сипонтумээс гарган уулаар дайрч далай руу явах замын хоёр захын ой дотуур явжээ. Энэ шигүү ой дотуур явахдаа сэлмээрээ мод цавчлан өөрсөддөө зам гаргаж явжээ . ингэж хоёр цаг гаруй царс ба нарсан модоор тал бүрээсээ хүрээлэгдсэн ойн бяцхан халз дээр гарч очсон тэнд жилийн ихэнхийг энэ ой дотроо өнгөрүүлэх мод огтлогч хэдэн хүмүүсийн урц байжээ.

Энэ ой дотор бидний ирсэн тухай ромынхонлд мэдээ хүргэүүзэй гэж болгоомжлон , мод хийж байгаа энэ хүмүүсиыг юуны өмнө баривчлан авч манаагаах харгалзуулан ба дайсанд дохио тэмдэг болгосон байж магадгүй гэж асаж байсан түүдгээ унтраа гэж тэдэнд тушаагаад бас туйлын чимээгүй б айцгаан сэрэмжтэй чагнаж б ай гэж Спартак голадиаторууддаа тушаажээ .

Спартакийн тааж байсан ёсоор Красс легионгуудаа авч Сипонтумын зүг явжээ . Анхны тахай дуугармагу замаар орж, төдий л болгоомжилсон янзгүзй аялан явж байгаа ромынхон явган цэргийн хөлийн яимээ мөн морьдын хөлийн төвөргөөн , хүмүүсийн ярилцах чимээг гладиаторууд сонсчээ . Ромынхон өөрсдийгөө ялагчид гэж үзэн сэтгэл дээр байсан бас ойр хавь дайсан байхгүй гэж итгэж байсан учир ингэж чөлөөтэй явсанб айжээ .

Ромйнхон цэргийн ёүүлчийн хэсгийн холдмогц Спартак гурван зуун морь цэргээ дагуулан хурдлан давхисаар явж Гарган уулыбн бэлээс эхлэн далайн хөвөө хүртэл үргэлжилж байсаан тулалдааны уудам талбай дээр хүрч очжээ . Энэ аймшигт тулалдааны мөрийг харж Спартакийн нүд нь харанхуйлан зүор нь эмтэрч байжээ .

Овоорч байсан алагсдынг хүүр нь замын боож байсан байсанд Спартак мориноосоо буун харайж морио нэгэн цэрэгт бариулаад сэтгэл зүрх нь шантран аймшигт энэ талын дундуур алхалжээ . Нүүр фарай нь үзэшгүй муухай болтлоо зэмдэглэгдэн үхэж , хувхай цагаан болсон царайтай нөхөдз нь түүний алхам бүрийг нь дайралдаж байхад хоёр нүд нь нулимсаар дүүрэн явжээ .

Цээж рүүгээ олон удаа жадлуулан үхсэн , морин туурайнд навлын яс нь бүрэн няцарсан байсан Брезоврыг дөнгөж таньжээ . Бас нэгэн газар алагдсан , зургадугаар легионы дарга эрэлхэг Ливий Гранденийн хүүр

, өөрийн нь алсан дайснуудын хүүрэнд бараг булагдах шахсан байхыг харжээ . Түүнээс цаашаа Онацийн хүүр байсан ба бас түүнээс арай цаахна , бүх бие нь дүүрэн шарх болсон авч амьд амьд байсан гуравдугаар легионы дарга Касстай дайралджээ . Энэ нь суларсан дуугаар тусламж эрж байсан бөгөөд түүнийг өргөн авч хамгийн дотно асрамжаар хүрээлжээ . Ингэж Спартад, үхсэн хүүрээр зай завсаргүй бүрхэгдсэн өргөн талбай дээгүү хоёр цаг гаруй сэтгэл зүрх нь эмтрэн явж, хэсэглэн цавчлагдсан цус нөж болсон Криксийн хүүрийг сая олжээ . Криксийн нүүр нь харин гэмтээгүй хэвээр байсанөбөгөөд , амьд байх үед нь түүнийг онцгойлж байсан ариун сайхан зориг чадал нүүрэн дээр нь гэрэлтэж байжээ . Спартаз газар сөгдө унаж , хайрт андынхаа нүүрийг дахин дахин үнсэж :

- Хайрт Крикс минь хамгийн бузар хар урвалтын уршгаар амиа алджээ ! Чи минь намайгаа бүх тэнгэр өшөө хонзон авагчид Фури нарт , Гекатын муу ёрт тангаргалая! Хамгийн бузар урвагё эмийг дайлан усны хязгааргүй гүнд нуугдаж байвч, Тартарын тамын ёроолгүй нүхэнд хоргодож байсан ч олж чиний алагдсаны хариу , цуст хямралын хариуг авна гэ хайрт дүү чинийхээ амьсгалгүй болсон хүйтэн биеий чинь түшиж суугаад тангаргалая!… гэжээ . Сөгдөн сууж байсан газраасаа босож ирэхэд нь Спартакийн хоёр нүдэнд цус харваж улаан болсон байсны дээр хурц гэрэлтэн гялалзаж б айжээ . хоёр гараа дээү нь өргөу тэнгэр өөд харж байснаа Криксийн биеийг гар дээш нь өргөж нэгэн цэргийг дагуулан далайн усын дэргэд очоод түүнийг эвдэрч тамтарсан зэвсэг цус болсон хувцас хунры нь мултлан авч биеийг нь далайн усанд дүрж сайтар угаагаад өмсөу явсан бараан өнгийнг тога тайлж түүгээрээ биеий нь ороогоолд үүнийг морьдийнхоо хат хүлээж байсан морин цэргүүд дээрээ аваачиж өг гэж цэрэгтээ тушаажээ .

Кастын биеийн байдал маш хүнд байсан учир түүнийг муу замтай газраар морин дээр авч чвж болохгүй байлаа . иймийн учир түүнийг тэр хавьд байсан нэгэн патрицийн айлын ордны захирагч босогчдын үйл хэргийг бүх зүрх сэтгэлээрээ сайшаадаг нэгэн хүнд өгч сайтар асрамжлуулахаар түүнд даатгажээ . Криксийн хүүрийг сайтар ороож морин дээр ачсаны дараа тэр морийг Спартак өөрөө хөтөлж морьт цэргийн отряддаа буцах замдаа гарчээ .

Красс цэргийнхээ хамт Канныг яиглэн явжээ гэдгийг Спартак Арпи д ирж мэджээ . иймийн уир Спарак тэндээсээ гарч Гердонейг чиглэжээ . Арпигаас гараад дөнгөж ганц миль газар явж байтлаа Цуст

муухай үзэгдлийг харжээ
. Гарганыг ууланд болсон тулалдаанд Красст олзлогдсон гладиаторуу дыг тэд нар замын дагуу ургасан соднуудад дүүжилсэн байжээ
. Найман зуун олзлогсдыг алж замын хажуугийн мод
бүхэнд дүүжилсний дундуур явж байхдаа Спартакийн царай
нь таталдан хуювхайрч нүд нь хурц гялалзаж явжээ .
Замын хажуугаар дүүжлээстэй байсан
хүүрүүдийн дотор өөрийнхаө фракий нутгийн зоригт
эр Мессемберийгийн дүүрэн шархалж цус нөж болсон бие дүүжлээсэ тэй байхыг
Спартак харж гараараа нүдээ дарж шүдээ тачигнатал хавирч явснаа:
- Марк Красс чи олзлогсдыг дүүжилж байнга уу ? Чи ч лут шив дээ
! Марк красс! Чи тэднийг аялалдаа саад болно гэж төвөгшөөгөө шив дээ . Ээ бурхаддаа тангаргалая!, цэргийн хэрэгт хамгийн алдар т ,
ромынхон та нараас юм бүхэн сурах хэрэгтэй юм байна …
би нилээд юманд сурлаа… харин одоо хэн ингэхийг сурч авах л үлдэж байгаа юм байна … гэхэд
- ийм ромынхон гладиатор биднийг хүний эрхтэй гэж үздэггүй байх нээ!… тийм үү! Тэгвэо бид инь зэрлэг араатан бузар, хорхой ,
ярганы мал байх нь ээ! тийм бол, яахав тийм л биз,
тартарын залимтай дөлөнд тангаргалагя! Бид гладиаторууд
ч бас ромынхон хуулийн эрхтэй биш гэж үзнэ. Нулимсны
хариуд нулимс цуснй хариуд цус гэж зандран хашгарчээ .
Спартак бартаатай нарийн зөрөг замаар морь хайрлалгүй шөнийн турш давхиж дараагийн
өдрйн үд дунд легионууд дээрээ хүрч буусан байлаа .
Спартак тэр шөнөдөө цэргээ
авч хурданг аяллаар Венузийг чиглон очиж , хотын
дэргэд лагерийнхаа оронл цэргүүдээ дагуулан ууолын оройд гарчээ
. къраст дайраган бут цохигдохгүйн тулд тохиромжгүй
газар буудаллан , дараах дутагдах
байдлыг тэсвэрлэхээс биш яахав гэж цэргүүдээ хэлжээ .
Энэ үед Ромйын цэргийн УДИРДАГЧ Рубил хүрэлцэн очиж, тэнд төв байраа барьжээ . Красс квестор Скрофийн удирдлагын
дор дөрвөн легион арван мянган ьуслах цэрэг, таван мянган
морьт ц цэргийн Андрийд явуулжээ .
Скрофа нь Крассын төлөвлөгөө ёсоор Венузийн зүг нэг замаар явах бөгөд Красс өөрөө нөгөө замаар мөн энэ үг замаар явах
бөгөөд красс өөрөө нөгөө замаар мөн энэ зүг явах байжээ . гарганын ууланд болсон тулалдааны үед алагдсан арван мянган хүмүүсийнхээ з арим хагасыг нөхөх цэрэг цуглуулж дахин нэг

легион байгуулахаар Барнум , Брүндизиум болон
ойр хавийн хотуудад Краас хүмүүс явуулжээ .
Претор Красс сенатад захидал явуулж саяныхаа ялалтын ач холбогдо
лыг хэтэрхий нэмж мэдээлсний дээр
сэтгэл санаагаар унасан гладиаторуудын лузанчуудын нутаг
тийш ухарлаа, хоёр корпус цэргээрээ хавчин тэднийг няц шахах гэж
байна гэж бичжээ .
Хоёр хоног амасрынхаа дараа дайсны тухай
мэдээ цуглуулж ирэхээр морин цэргээ явуулж бас хоёр хоносны
дараа зайсны тухай тодорхой мэдээ сонсож Венузээс шөнө гарч өдөр
шүөнө хоёрын турш явж Рубид гэнэт очжээ. Тэнд маш чанд нуугда
н түр буудаллаж цэргүүддээ зургаахан цаг
амраагаад үд дунд гэнэт Крассын цэргийг дайрахаар гурван
цаг тулалдаж легионуудыг нь зад цохижээ
. Энэ тулалдаанд ромынхны зургаан мянган хүн алагдаж гурван
мянган хүн олзлогпсон байжээ .
Найман цагийн
дпараа Спартак цэргийнхээ хамт эндээсээ гарч Метапонтумын зүг
явжээ . Робийн дэргэдэх тулалдаанд лзлон авсан ромын
цэргүүдээс бараг бүгд ромын патрицуудын гэр бүлийн л дотроос гарсан
хүмүүс болох дөрвөн зуун хүнийг амьдаар нь бусалд хоёр мянга
зургаан зуугий нь зам дагуулан дүүжлэн загалмайлан тэлж алах тушаал
өгчээ.
Спартак амьдаар үлдээж авсан дөрвөн зуун хүнийнхээ дотроос нэгий
нь суллан тавьж : Спартак ромын ц эргийн удирдагчийн хатуу
харгис жишээг дууриаж олзолсон цэргүүдээ дуужлэн аллаа . хойшид ч
бас тэгж байх гэнэ гэж Крассдаа очиж хэл бас энд
байгаа дөрвөн зуун олзлогсдыг нэг зуугий
нь грек хүүхэн Эвтибидагаар сольж авахгүй юу гэж байна гэж
миний нэрийн өмнөөс Крассдаа хэл
гэж энэ залуу партицад даалгажэээ
. Эвтибидаг ромынхон лагерьт нуугдаж байгаа гэдэгт Спартак итгэж
байжээ .
Спарбтак дөрөв
хоног явж Метанпонтум хүрээд тэндээсээ Фурийг чиглэжээ
. хотйг дайран авч
энд боолцуудыг цуглуулан шинээр легионууд байгулахын тул
энэ хотдоо бэхлэн суужээ .
Найм хоногийн дотор арван зургаан мянга
гаруй боолчууд Спартакийн цэрэгт
ирж нийлсэн бөгөөд тэднийг яаралтай сургахыг хичээжээ

. Ингээд найман легион бүрээсээ хоёр хоёр
мянган хүнийг арван хоёр легион бүрдээ адил тоогоор хувааж өгчээ . Ингэж Спартакийн тугийн дотор нэгдсэн цэргийн тоо дахин жаран дөрвөн мянгад хүрчээ . Тэдний тавин зургаан мянга нь явган цэрэг, найман мянга нь морин цэрэг байжээ.

## СПАРТАК ЛУКАНИД
## ТАВЬСАН ТОРОНДОО ОРСОН ШУВУУНЫ АНЧИН

- Мирца минь хоёр
  жилийн турш надаас нууж ирсэн тэр уйтгарт нууцаа чи одоо надад нээж өгөх хэрэгтэй . Мирца минь ээ!

Хэрэв чи намайг хумсыэн чинээ атугай ч хайрладаг бол хэрэв чиний сэтгэл дотор чинь
гадаад өнгө царайтайгаа адил хиргүй тунгалаг хилэнцгүй ариун ахул, чи тэр нууцаа өнөөдөр надад хэлж өгөх байх. Би чамд зүрх сэтгэлээсээ хайртай шүү, үүнийг ойлгож үзээч!гээд Арторикс , Криксийг оршуулснаас хойш хорь хоног өнгөрсний дараа Спартакийн майхны үүдэнд зогсож Мирцад хэлсэн юм.

Энэ үед гладиаторуудын лагещрь Лукинд байсан бөгөөд олон тооны боол шинээр нэмж ирсэн учир Спартакийн явган цэргийн тоо далан мянгад хүрээд байжээ . Мөн сураг дуулбал эдний өмнө Красс дал наян мянган цэрэгтэй ирж яваа сонсогджээ .

Майхны аман дээр Арторикст зэрэгцэн гадагш гарч чадахгүй зогсож байсан мирца биендээ яв цав сайхан тохирсон уртаараа өвдөгь нь хүрсэн хуяг өмссөн нь мөнгөн өнгөөр гялалзаж байсны дээр хөлдөө төмөр бэхлэвч хийж , баруун гартаа мөн төмөр дугтуй углаж зүүн гартаа бяцхан дугуй хүрэл бамбай барьсан байжээ . ыбас тэр бүсгүйн гоёмсог биенээс бяцхан сэлэм зүүлттэй байсан дээр толгой дээр богинохон нуруувчтай мөнгөн дуулга өмсөөнб айжээ .

Хамгийн бяцхан чимгийг хүргтэл Эвтибидагийн зэвсгийн чимэг янзыг дууриалган хийсэн энэ бүрэн зэвсэг хэрэглэлийг Равеннын дэргэд лагерилаж байх үед Мирцад ах нь хийлгэж өгсөн байжээ .

Стэглэийнхээ үгийг тоочин хэлсэн энэ залууд Мирца хариулж :

- Арторикс аа! Юу гэж байгаа чинь энэ вэ? гэж буруушааж хэлжээ .

Галл хүн бүсгүйн зүг гүн их дурлалын нүдээр харж :

- Юу , юу гэж ! Би чамд хэлээгүйсэн бил үү? Би чиний нүдэнд хэтэрхий муухай харагддаггүй үүнийг би өөрөө мэднэ. Өөр хүнд хайртай дуртай болоогүй гэдгээ, чи надад мянга түм дахин хэлсэн тэгээд , яагаад миний галын дөл шиг оволзож байгаа дурлаллд хариулахаасаа тэгж дургүйцнэ вэ? гэж урьхан дуугаар хэлэхэд нь:

- Чи, чи яах гэж намайг зшовоонов ? Юунд намайш байцаанав? Би чамтай ханилах ёсгүй , хэзээ ч би чинийх болохгүй … гэж сэтгэл хөдөлсөн дуугаар бүсгүйн хариулахад Арториксын царайы улам цайвар болж:

- Би шалтгааныг нь мэдэхийг хүсэж байна! Хувь заяаныхаа оргил дээр гарахын оронд хүн яагаад зовлонгийн ёроолгүй нүхний амсар луу унах ёстой билээ гэдгийг мэдэж болох байгаа дээ! гэлээ .

- Арториксын хэлж байгаа үг нт түүний сэтгэл зүрхний энь угаас гарсан үг байсан бөгөөд тэр үг нь маш даацтай хүнд байжээ .

- Мирцагийн нүд н дурлалын очоор гялалзан… янаг хонгор залуугийн зүг ширтэж байлаа .

- Энэ хоёрын бзх бие нь чичрэн, хоёул бие биеэсээ нүд салгалгүй ширтэн дув дуугүй хөдлөлгүй хэдэн минут когсо ж байтлаа Арторикс эхлэн дуугарч:

- Мирца … би аймхай муу эр бш шүү… чи ч ӨӨРӨӨ МЭДНЭ БАЙХ ТУЛАЛДААНД БИ Ямангь тэргүүн эгнээнд явж, ухрах цагт хамгийн ард явдаг шүү. Аймшигт цагт би амай хайрладаггүй билээ … гэвч одоо намайг хүүхэл иг уйлж байхыг харж байгаа биз. Хайрт хонгор дагина минь ээ ::: Сэтгэл зүрхний янаг минь ээ! надад хайртай гэдгээ хэлээё

… ивээлт дагинын өршөөлт урин харцаараа өчүүхэн намайгаа илбэн таа лаач! Хувь заяаны минь энэ сайхан гэрэл үүрд миний нүдний өмнө гийн цацарч байхыг зөвшөөрөөч гээд Арторикс Мирцагийн гарыг шунамхай т аалан олонт үнсэж байхад нь Мирцагийн бзх бие нь дагжин чичирч байлаа :

- Болиоч Ароторикс аа!… явж үзээч… чиний энэ үг … надад ямар их хүнд озвлон учруулж байгааг чи мэддэг болоосой… гэж шивнэн хэлж байжээ .

- Урьхан хонгор харц чинь хуурмаг байсан ыол … түүнийгээ шууд л хэлэх хэрэгтэй … зоригтой байх хэрэтэй… “Арторикс-ааа надад найдвал дэмий, би өөр хүнд хайртай болсон шүү” гээд л хэлбэл дээр шүү дээ гэхэд нь :

- Чамаас өөр хүнд б хэзээч хайртай болохгүй хэнд ч би хайртай болоогүй байна, хэнд ч хайртай байгаагүй юм! гэж бүсгүйн үгээ таслан хэлсэнд Арторикс учиргүй баярлан:

- Чи надад хайртай гэнээ!… над шиг баярлах цаг бцрхдад байдаг болов уу? гэж дуу алджээ .

Мирца бүсгүй залуугийн гараас сулран

- Бурхад гэнээ , бурхдад баясах цаг байхаар барахгүй баяр жаргалаа доторoo согтуурч байдаг байх… харин чи бид хоёр бол бие биендээ далдуур дурлан, дурлалынхаа бадарсан дөлийг халуун үнсэлтээр хэзээ ч холбож чадахгүй заяатай ажээ…

Бид хоёрын дурлалаа холбохыг хэн хорих аж гэж Арторикс хэлэхэд Мирца :

- Тэгэхийг хэн хорьж байна гэдгийг чи битгий эр … юу хорь ж байгааг мэдэхийг битгий хүч бид хоёрын нийлж жаргах явдлыг хувь заяа маань хорьж байна … энэ бол хүнд … ширүүн бөгөөд .. туулж давагдашгүй хувь заяа юм … чи одоо яв… цааш нь мэдэхийг битгий хүс гэж уйтгарт дуугаар хэлээд цурхиртал уйлжээ .

Арторикс , сандран, бүсгүйг тайтгаруулахыг оролдож, гары нь үнсэх гэж барьтал бүсгүй Арториксын гарыг зөөлөн боловч шийдвэртэй түлхэн зайлуулж:

- Арторикс минь чи надаас холдож зайл хэрвээ чи ариун сэтгэлть шудрага сайн хүн бол надаас холдож зайл! Гэж байхад нь Нумидийн шивэгчин бүсгүй Центул ойролцоо өнгөрч явжээ . Энэ шивэгчин бүсгүй нь одоогоос хорь хоногийн өмнө Тарентумаас гүйж гладиаторуудыг лаге рьт ирсэн юм байжээ . Энэ бүсгүйн , энд ирэх өдөр нь хамаагүй юм чалчлаа гэж эзэн авхай нь түүний хэлий нь тас огтлуулсан байжээ .

Мирца энэ бүсгүйг харж:

- Центул! Центул! Гэж дуудаад.

- Центул тэр ирж явна… Арторикс чи одоо нэг явдаг байгаа даа гэж би итгэж байна гэж залууд хэлжээ .

Галл үндэсний залуу , бүсгүн гарыг үнсэж :

- Тэр нууцаа, яагаад ч л гээн надад хэлж өгөх байх гэхэд нь :

- Яасан ч үгүй гэж хариулжээ .

Энэ үед Центул Спартакийн майхнй дэргэд хүрч ирсэндп амтат мэдрэхгүй уйтгаргт сэтгэлээр дүүрэн Арторикс претороос гарч яаралгүй алхлан холджээ . Мирца , майхны баганаас уяатай байсан хундан хонийг зааж, хоёул явж энэ хониор Луканын марс бурханд тахил өргөх үү гэж Нумади нутгийн бүсгүйд хэлсэнд:

Харгис эзэн авхайдаа хэлээ тас огтлуулсан хөөрхий энэ бүсгүй толгой дохиж зөвшөөрч байгаагаа мэдэгджээ .

Удалгүй энэ хоёр бүсгүй, Акрикс гол руу хандсан декуманын хаалгаар лагериасаа гарч явлаа . Энэ хоёр лагериасаа нэг миль зайтай газар байгаа, орой дээр Луканын Марсад зориулсан сүлдтэй нэгэн бяцхан толгой

дээр гарчээ. ЭНнд
, Мирца грекийн занүил ёсоор дайны бурхдад хониор тахил
өргөж гладиаторуудын цэргүүдийг өршөө ивгээхийг түүнээс гуйжээ .

Мирцагийн энэ сүмд байх үед нь ьагнуул хийхээр өглөө гарсан
Спартак буцаж ирж явтлаа , гэнэт дайсны эргүүлийн хүмүүстэй дайралдаж ,
ромын цэргүүдийн хамт Грументум руу
ирж явна гэдгийг тэднээсм олж мэджээ .

Хоёр хоногийн дараа үд дунд претор цэргийнхээ хамт
хүрч ирээд гладиаторуудын өмнө байлдааны ёсоор жагсаажээ .

Хоёр тал бүр байлдааны дохио
өгч хоёр талын цэрэг уулзаж аймшигт тулалдаан болжээ
. Тулалдаан дөрвөн уаг гаруй үргэлжилж , хоёр тал нь ав
адилхан зоригтой ав адил шийдэмгий байлдаж босогчдын зүүн
гарын жигүүр нь дйилдэж эхэлжээ . Учир
нь гладиаторуудын легионуудад шинэ тутам ирэгсдийн ихэнх
нь ромынхны ширүүн түрэлтийг эсэргүүцэх туршлага чадвараар бага байсан
юм . Толгой ба цээжиндээ шарх олсон Арторикс гайхамшигт их
зориг гарган арслан мэт тулалдаж бб айсан хэдий
болов легионуул нь улам бүр сарнин ухарсаар байжээ .

Спартак галзуу мэт энд давхиж ирээд аянгын дуу мэт том дуугаар:

Ромынхныг ялж б айсан та
нарын ялалтууд чинь тэднийг зоригт арслан болгож, өөрсдий
нь аймхай туулай болгов уу? Гиперборийн марсын нэрийн төлөө зогс!
надтай зэрэгцэн явж дайсантай тулалд! Баатар зоригоо үзүүлцгээ ,
дайсныг ямагт дйилж байсантайгаа адил одоо ч б ас дийлнэ гэж хашгараад ,
бамбайгаа ирж явсныхаа дайсан руу хаяж орхиод алагдсан нэгэн
гладиаторуудын сэлмийг зүүн гартаа барьж гладиаторуудын сургууль
дээр довтолдогтойгоор адил хоёр сэлэм зэрэг эргүүлэн ромынхныг дайран
оржээ . Ингээд Спартак хоёр сэлдмээ цахилгаан
мэт эргүүлэн аймшигт хүчээр цавчилж байсан
учир ромынхон сарнин задарч , дараа нь ухарч эхэлжээ .
Гладиаторууд үүнийг харж зориг сэтгэл нь хөгжин ,
дахин бадрангүй тулалдаж гарлаа .

Энэ үед нь Марий, Сулла нараар командлуулж байсан хамгийн ахмад хашири цэргийн бүрэлдэхүүнтэй , Ромын цэргийн гол хүч нь гладиаторуудын цэргийн гол хүчийг дайрч байсан бөгөөд гладиаторууд ромынхны аймшигт ширүүн дайралтыг эсэргүүцэж хү ч хүрэхгүй болж сарнин дараа нь ухарч эхэллээ .

Спартак гол хүчнийхээ ард , бэлтгэл хүч болж байсан морин цэрэг тийшээ ухасхийн очиж түүнийг хорин эгнээ болгон жагсааж байлдаангы хоёрдахь шугам байгуулжээ .Сарнин тархсан легионууд нь хоёр шугмаар завсраар лагерьтаа буцаж болох болгожээ .

Гэвч Спартакийн энэ тугшаал үлэмж их алагдан сарниж, тарж зугтаж байсан төвийн ба зүүн гарын жигүүрийн цэргүүдийг аварч чадахгүй байлаа, харин Граникийн хатуу удирдлагыни дор явсан баруун гарын жигүүр нь тулалдсан хэвээрээ ухарч байжээ .

Ялж байсан дайсны ширүүн довтолгоог саатуулахаар Спартакийн өөрий нь шууд удирдлагын дор морин цэргийн аймшигт ширүүн дайран орхолд гладиаторуудыбн морин цэрэгт бут ниргэгдэхийн тул дайсны цэргүүд довтолгоогоо зогсоон дпугуй ба гурвалжин хэсгүүд болон жагсаж тулалдахад хүрчээ .
Морин цэргийн довтолгооны дунд ромынхон үлэмжхэн их алдагдал хохиро л амсжээ .

Красс өөрийнхөө морин уэргийг тулалдаан оруулахаар завдсан боловч нэгэнт харанхуй болж эхэлсэн учир чадсангүй , хоёр тал тулалдааныг зогсоох дохио өгч , хоёр арми тус тусынхаа байранд буцжээ .

Тулалдаан дуусжээ . Энэ тулалдааны дунд ромынхон таван мянган хүн алагдааж гладиаторуудын найман мянган хүн алагдаж мянга хоёр зуун хүн олзлогджээ .

Спартак бруттүүдийн нутгаар дамжин Конценсия орохоор шийдэж шөнийн цагаар Грументумаас чимээгү й гарч явжээ . Спартакийн цэргийнхээ хамтаар Пандузия хүрч явахад түүнийг Крассын элч гүйцэж очжээ

. Урьд Спартакийн цэрэгт олзлогдсон нэг
зуун хүнээ Эвтибидагаар сольж авахаасаа татгалзаж б айсан Красс ,
манай тэр зуун хүнийг эргүүлж өгч, оронд нь Грументумын дэргэд манайд олзлогдсон мянга хоёр зуун гладиаторуудаа авахгүй ву? Гэж
энэ элчийг явуулсан байжээ .

Спартак Граниктайгаа зөвлөснийхөө дараа, тэдний зуун хүнээр мянга хоёр зуун хүнээ сольж авахыг зөвшөөрч , уул солилцох ажлаа гурав хоногийн дараа Росцианумд гүйцэтгэхээр Крассын элчтэй харилцан тохиролцжээ .

Крассбн элчийг буцсаны дарааш, Спартак бодож байтлаа, Ромын цэргийн удирдагч ингэж олзлогчдоо солилцоё гэж элч ирүүлэхдээ ба Спартакийн цэргийг саатуулж алдсан цагаа хожих зорилгыг нэгэн адил тавьжээ гэдгийг нь
мэдэв. Ингээд олзолсон зуун хүнээ тус бүр хос морьтой мянган хоёр зуун морин цэрэгт
Роцианумд очуулахаар шийдээд тийшээ явах морин цэргийнхээ Мамилийгэ эр командлуулжээ . Урьдаар бүх хүнээ авч гүйцсэний дараа зуун хүний нь өгөх хэрэгтэнй , мянга хоёр зуун хүндээ авч очсон морьдоо унуулж , дөрөв хоногий дараа миний очих Темез рүү очих
хэрэгтй тэдний талаас урвах мэхлэх ямар
нэгэн бяцхан сэжиг тэмдэг мэдэгдвэл тэдний энэ
патрицуудын мах цусны тасархай болох тэр зуун хүний нь тасар цавчилж хаяад тэдэнд олзлогдслн гладиаторууды нь заягий нь түшүүлж орхиод өөрсдөө даруй буцаж ирэх хэрэгтэй гэж мамилийд хатуу тушаажээ .

Пандузийгээс гарч
Темез очиж явах замдаа Спартак нэгэн зэвсэгт отрядтай дайралджээ. Тэр нь Кай Ганникийн олж цуглуулсан халтар хултар сургуулилсан таван мянган боолчуудб айлаа . Ганник нь Спартакт учруулсан гай зовлонгоо гэмшиж явсанб өгөөд өнгөрсөн гэмт хэргээ цагаатгахын тул хүндтэй үйл ажил бүтээж босогчид нэмэр хүч авчирч яваа нь энэ байсан ажээ . Ингээд , хойшид сахилга батыг хатуу сахиж явна гэж ганник ам шахаагаа өгчээ .

Спартак энэ самнит хүнийг цэргийн нь хамт ах дүү ёсоор хүлээн авч Ганникийг нэгэн легионы даргаар дахин томилжээ .

Ромынхонд олзлогдож байсан мянга хоёчр зуун хүнээ аваад тав хоногийн дараа мамилий буцаж иржээ . Спартак бүх уэргийнхээ өмнө олзлогоос буцаж ирэгсдэд хандаж дайсанд амьдаараа олзлогдсон гладиаторуудыг амиараа аврах, ромын зуун патрицад олзлогдсолн манай лагерьт хэзээд бэл эн байдаг юм бишээ. Хэрэв ийм сайхан завшаан та нарт энэ удаа тохиолдоогүйсэн бол та нар одоо замбн хажццгийн модуудаар дүүжлээстэй Апеннинын ойн элээ хэрээг тэжээж байхсан билээ гэх зэргээр хатуу зэмлээд дайснй гарт амьдаараа орж дарааа нь дүүжлэгдэн алагдсанаас тулалдаж явсаао алагдсан нь дээр гэжээ .

Красс, Спартакаас хорь гаруй хоног хождож Темезд хүрч иржээ . Спартак энэ хугацаанд , Лукиния Апулия Мессапия , Япигия зэргээс нэмэгдэл хүч тасралтгүй ач байсан бөгөөд одоо түүний арми нь бараг зуун мянган хүнтэй болсон байжээ .

Хэдий тийм боловч Спартак энэ үед Тирренын далайн хөвөө орчим хөвж б айсан киликийн далайн дээрэмчидтэй уулзаж ярилцан та нар манай цэргийг Сицилд аваачиж өгөхгүй юу бид та нарт гучин талант өгье гэсэн юм . Гладиаторуудыг их юм дээрэсдсэн гэж амьтан ярилцах боловч тэд нарт гучин талантаас илүү мөнг ө байсангүй ажээ .

Далайн дээрэмчид Спартакийн хүсэлтийг авснаар ч барахгүй мөн хэлэлцээг хийсэн Граникаас арван талантын дэнчин авсан боловч гладиаторуудыг онгцондоо суулгахаар болзсон өдрийнхөө өмнөх шө нө нь Телезээс нууцаар явчсан байжээ . Бодвол Ромынхон өшөөгөө биднээс авах байх гэж айснаас болж тэгсэн билээ .

Далайн хөвөөнөөс холдож яваа дээрэмчдийн хөлөгий дарвуулуудыг гладиат орууын лагериас харж б айх үед нв тагнуулын манипул лагерьтаа хурдлан ирж Марк Крассын ойртон ирж яваа тухай мэдэгджээ .

Гладиаторууд яаран зэвсэглэж ,б айлдааны шугамаар жагсжээ . дайсны легионуудын байлдаанб ёсоор жагсаж амжихаас урьд анхны зургаа н легионоос бүрдсэн Спартакийн нэгдүгээр эгнээ нь ромынхныг ширүүн дайран орж , тэдний эгнээг сүрхий сарниалж гарлаа .

Спартак хоёрдугаар эгнээндээ дөрвөн
легион жагсааж хоёр жигүүрийн хажуугаар дөрвөн
мянган морьт цэрэг жагсжээ .

Хэрэв энэ удаад цохигдсоноос хүрвэл ,
Спартак бүх цэргийнхээ хамт Темезд хоргодон байж дайсныг
ялахад тохиромжтой цагийг хүлээх гэж шийдсэн
бөгөөд одоо тэнд хоёр легионоо орхижээ . Спартак нь учирч болох
хүнд байдлаас яаж гарах тухайгаа аль хэдийн бодсон байлгүй .

Нэгдүгээр эгнээг тулалдаанд дагуулж орохынхоо өмнө Спартак тэр
эгнээний зургаан легионы дарга нарт тушааж ,
хэрвээ ухрах явдал тохиолдвол ухарч хоёрдугаар эгнээнийхээ ард орох
хэрэгтнй гэж урьдчийлан хэлсэн юм .

Тулалдаан хэдэн цаг үргэлжилж байлаа . Үдийн хирд Красс шинэ
нэмэгдэл хүч авчирч баруун ба зүүн жигүүрийн хоёр
тийш нь өргөтгөжээ.. Тэгэхэд нь хоёр
талаасаа бүслэгдэхгүйн тулд байлдааныг командалж байсан Граник цэргүүдээ
ухрах тушаал өгчээ
. Дарга нарын анхаарал мөн чадамгай ажиллагааны ачаар , ухрах ажил
нь маш хурдан бөгөөлд завсар завсраар орж ар талд гарчээ .

Ромынхон цэргүүд , гладиаторуудыбг зкугтлаа гэж ойлгоод хойноос нь хөөж
гартал тэдний өмнөөс гладиаторуудын цэргийн шинэ эгнээ гарч
ирээд галзуу хүчээр дайрсанд ихээхэн хохирч аргагүй ухарчээ .

Шинэ легионуудыг нэмж ,
шинээр улам ширүүн тулалдаан явуулахаар шийдэж марк Красс баруун
ба зүүн жигүүр тус бүрээсээ нэг
нэг легион цэргээ нэмж дайныг шинээр эхлэхдээ гладиаторуудын цэргийг б
үслэнэ гэж найдаж байсан боловч , Спартакийн цэргиийн
хоёр жигүүрээр гарч очсон морин цэрэг
нь Ромын цэргйн их удирдагчийн санасан аргы нь бүрсмөсөн задалжээ .

Түрүүн ухарсан граник энэ үед
нь зургаан легиошноо байлдааны журмаар дахин ажгсаасанб
өгөөд морьт цэргэ давшуулах тухай крассын тушаал өгөхөд нь
Спартак, цэргүүдээ жагссан

хэвээр нь журамтай ухраж граник командалсан шугмын араар ороход 8граникийн эгнээ ромын легионуудтай дахин тулалдахад бэлэн бол жээ .

Ингэж гладиаторуудын цэргүүд хоёр эгнээ болж дайсантай ээлжлэн тулалл даж мөн ээлжлэн ухарсаар орой
болтол Темезийн хотын хэрмийн дэргэд ухран очжээ . марк
Красс давуу тоотой цэрэгтэйнхээ ашгийг гаргаж чадсангүй .
иймийн учир тулалдааныг зогсоох дохионы бүрээ татахаас өөр юу
ч Красст үлдсэнгүй . Ингээд Крассын цэрэг, Темезийн
эргэн тойрны толгодын бэлээр буудаллажээ.

- Үл бүтэх муу гладиатор үзэшгүй муу гладиатор , түүний юу л
гэж муугаар нэрлэх бол нэрлэгтүн , энэ хараалд идсэн хар Спартак
нь цэргийн их удирдагч хүний бүх чанарыг хадгалсан хүн юм
даа гэж Красс өөрийнхөө квестор Скрофд хэлэхэд нь :

- Спартак бол эрэлхэг зоригтой ,
мэргэн хараатай ямар ч яриагүй цэргийн гарамгай их удирдагч хүн мөн гэ ж шууд л хэл л дээ гэж сэтгэл нь өвдөн хэлэв.

Долоон цаг гаруй үргэлжилсэн энэ тулалдаан ингэж дуусжээ. Энэ тулалдаа нд зургаан мянган гладиатор ромынхны долоон мянган
хүн тус тус алагджээ .

Ромынхы алагдал илүү байсан боловч
Спартакийн цэргийн ухарч Темезад бүглээ гэж үзээд Красс өөрийгөө
ялагёч гэж нэрлэн гладиаторууд түгжигдсэн , тэд нар одоо амь
гарч чадахгүй хорь гучин хоногийн дотор байлдааныг бүрэн дуусгана гэж
би найдаж байна гэж Красс сенатад захидал бичжээ .

Хотын хэрмийг бүр түрүүн , өргөн шуудуугаар бэхэлж авсан Спартак ,
их болгоомжтой байсны дээр батлан хамгаалах бүх арга хэмжээг
авсаар боловч , энэ бүслэлтээс хэрхэн яаж гарах аргыг
далдуур бодсоорбайжээ .

Хотын иргэдийг ямар
боловч нэрийдлээр хотын хэрмийн гадна гарахыг бүрмөсөн хориглож ,
хотын хэрэм ба түүний бүх хаалган дээр харуул манаа тавьжээ .

Энэ тушаалыг сонсож, удаан хугацаанд хаалтттай байж
, өлсгөлөн зовлонд учрах нь гэдгээ мэдэж , хотын иргэд ихэд айж сандарсан байх юм

Спартак хотын иргэдийн айж
сандарсан энэ байдлыг ашиглан, хоригдон өлсгөлөн зовлонд удаан учрах а юулаас гарёч болох нэг арга байна. Энэ нь хотын дотор байгаа бүх төрлийн хөлөг онгоц, загасчдын завь зэргийг цуглуулан авчирч өгөх
хэрэгтэй бас хөлөг онгоц, , завь хийж чадах мэргэжилтэй
хүмүүс бүхнээ цуглуулж бидний Сицили рүү явах далайэн тээврийн хөлөг онгоц хийлгэж өгөх хэрэгтэй гэж хотын захиргаанд мэдэгджээ .

Темеза хотын иргэд үүнийг зөвшөөрё удалгүй далайн эрэг дээр хэдэн
зуун ажилчин хэдэн мянган гладиаторуудын хамтаар гар
нийлэн ажиллаж төдий л том биш боловч олон тооны онгоц
хөлөг хийж гарчээ .

Красс гладиаторуудын төлөвлөгөөг эргэлзэлгүй ойлгож, Фурия, Метопонтум, Гераклия, Тарентум, Брундизинум, хотуудад элч мордууланг хотын
хэрэм бэхлэлт эвдэх олон тоотой зэвсэг багаж нэн даруй ирүүлэх хэрэгтэй гэж шаарджээ . Хэрвээ, хэрэм эвдэх дүүжин зэрэг зэвсэгтэй болохгүй бол дайн удаашрах байна гэдгийг Красс ойлгосон юм .

Темезийн дэргэд болсон тулалдаанаас хойш хэд хоног өнгөрсний
дараа нэгэн
өдөр Эвтибида ромынхны лагерь дотор ганцаараа хэсэж явтлаа, дайсны бү гж байгаа хотын орчим очиж, тэдний харуул манаанд аль болох
хирээр ойртож , хотынхэрмийг нэвтрэх газар бана уу гэдгийг мэдэж б ас тэр хотод сэм нэвтрэн орох арга хайвал яасан юм гэдэг
санаа түүнд төржээ .

Тэгээд Эвтибида Тарентумаас худалдаж авсан хоёр шивэгчнээрээр хүрэн өнгийн будаг бэлдүүлж , түүгээр гар нүүрээ будаж царайгаа
танигдашгүй болтол өөрчлөн эфион хүүхэнтэй адил болж мөн
шивэгчин бүсгүйн хувцас өмсөж улбар шар үсээ өргөн бараан
алчуураар тумайлдаж зангидаж шавар ваар гартаа барьж үүр цайхаас
хэдэн цагийн өмнө лагериасаа гарч явлаа . Эвтибида орой дээгүүр нь

Темеза хотын хэрэм гарсан
толгойг яиглэн одов. Энэ толгойн хажууд булаг байдаг ажээ .

Хуурамч энэ эфиопи бүсгүй ,
шөнийн харанхуйд болгоомжтой явсаар, булгийн дэргэд хүрч очоод ,
хүмүүсийн аяархан шивнэлдэн ярилцах мөн
хэдэн сэлэм хуягнууд харших чимээ сонсдож , энэ булгийн хамгаалсан
гладиаторудын зкогорт нь энд байгаа бололтой гэж мэджээ .

Тэгээд орчин тойрны газрыг судлахыг тул зүүн гар
тийшээ чимээгүй эргэж толгойн бэлийг дагаж явлаа .

Тэндээсээ хагас миль хир явж байтлаа харлан харагдаж байгаа
модон дотор ямар нэгэн барилга байхыг үзээд , ажиглан
харж сзм болохыг мэджээ .

Эвтибида яахав гэж бодов түр зуур зогсож байснаа , хотын хэрмээс
нилээд зайтай газар байгаа энэ сзмийг гладиаторууд эзлээгүй байх гэж
шийдээд сүмийг чиглэн зоригтой байдлаар хурдан алхалж очлоо.

Сүмийн барилга бага боловч цул гантиг чулуугаар дориун маягаар их
хөөрхөн барьсан өарилга байлаа.
Геркулес Оливарид зориулан барьсан энэ сүмийг
гладиаторууд хамгаалалдаа аваагүй юм байна гэдгийг мэдээд дотор
нь орохоор шийджээ .

Энэ сүм хоосон юм байна гэж бодоод гарах
гэж байтлаа тахилчийн хувцасьай өвгөн
хүн сүм дотор байхыг гэнэт харжээ
. Энэ өвгөн гайхамшигт сайхан гантиг чулуугаар бүтээж хийсэн далдуу мо
дон бороохойтой Геркулесийн дүрийн өмнө байгаа тахилын газрын
дэргэд сэтгэл бодолдоо дарагдпан зогсож байлаа .

Грек хүүхэн тахилчийын дэргэд очиж, би бол
дайтагчийн ойртон ирэхэд айж, зэргэлдээ хуурай аманд бүгж
байгаа нутгийн
нэгэн газартай хүний шивэгчин юм сүмийн доторхи уснаас нэг ваар авч
болох болов уу гэж лат хэлээр барагтайхан хэлжээ .

Тахилч Эвтибидаг ус авах газар зааж өгөх зуураа түүнтэй ярилцан , дайны гай уршгийн тухай хэлж, дайны гол уршиг нь ард түний хөгжлийн ганц голомт болох шашин, уналтын байдалд орсон явдал мөн гээд үргэлжлүүлэн:

- Бурханд мөргөх бишрэх явдал нь италичуудын онцгой чанар нь ямагт болж байан м , тиймийнг ч учраас бурхад тэдэнд үргэлж өгөөмөрч сайн байж тэднийг ивгээн тэтгэж байсан юм одоо бол яаж байна, Эпикурийн үзэл дэлгэрч бурхан шүтээнийг үл ойшоох , тахилчдыг доромжлох явдал дэлгэрч байна , энэ мэтийн доромжлолын хариуд бурхад зүй ёсоор хилэгнэн хүнд шийтгэл тохож байна.

Италид гашуун зовлон учруулж байгаа сүүлийн жилүүдийн олон бослого үймээн дайн нь огторгуйн хилэнгийн зайлшгүй тодрол байгаа юм гэжээ .

Ялангуяа Темеза хотыг эзлэн хоргидсон явдал ба хотооё гадагү хүнийг гаргахгүй болсны гйах уршгийн тухай тахилч өвгөн ихэд дургүйцэн ярьж бурханд т ахид өргөхөөр хэн ч ирэхээ байлаа , тахил өргөе гэж бодо ч өгвөл зохих аравт барьцаа авчирч чадахгүй байна гэжээ . Энэ бүглд нь хөөрхий тэр өвгөний сэтгэлийг зовоох болсон нь ойлгомжтой билээ . Учир нь: Геркулест тахил өргөх ыүрд өвгөн найрлаж өргөл тахил бүр нь өвгөн тахилчийнх болж байдагсан билээ. Нэг үгээр хэлбэл , энэ Геркуесийн сүмийн тахилч , хуурдан мунхрагсдын шүтллэгийн хэмжээг орон бүхний шашин бүрийн лаи нарын үеэс үед заншиж ирсэн ёсоор тэдний авчирч барьсан өргөл барьцын чанар ба хэмжээгээр дүгнэдэг байжээ.

Луканчууд ба бурцуудийн бүх муж даяар өргөмжлөгдсөн тахигддаг байсан оливарийн Геркулесын энэ сүмд нэг ч хүн шагайнхыг больсоор хорь хоног болж байна гэж санаа алдан тахилчийын хэлэхэд:

- Тэгвэл би гэр орон , хөрнгө зөөрөө, хөдөлшгүй бат байлгахын тул биеэр ирж, Оливари Геркуесын сүмд өргөл барьц баригтун , ядаж л хүнээр дамжуулан явуул гэж эзэндээ би хэлье гэж бат итгэсэн тэнэгдүү шивэгчний дүрийг үзүэн Эвтибида муухан лат хэлээр хэлэв. Тахилч баярлан:

- Сайн бүсгүй чамайг Геркулес өршөөж байх болтугай гээд сүсэг бишрэл бүсгүйчүүдийн сэтгэл зүрхэнд илүү орших нь олонтой байдаг. Манай бурханд өргөл тахил өргөхөөр огт хүн ирэхгүй болсоор хорь хоног болж байна гэж би чамд түрүүхэн хэлсэн билээ . Тэгвэл арай ч худал болно. Учитр нь гладиаторуудынг лагериас нэгэн бүсгүй хоёр удаа ирж өргөл тахил өргөсөн тэр бүсгүй бол ариун сүсэг бишрэтэй бүсгүй юм гэжээ .

үүнийг сонсож Эвтибидагийн нүд нь баяртай гялалзан бүх бие нь чичирэх шиг болжээ .

- Юу гэнээ дайсны лагериас нэгэн бүсгүй ирсэн гэж чи хэлэв үү?

- Тийммээ , зэвсэг зүүсэн бас бүсэндээ сэлэмтэй хүүхэн хоёр удаа ирсэн ирэх бүрв нь түүнийг чамьай адил негр хүүхэн дагаж явна билээ. Негр хүүхэн нь хэлгүй юм . хөөрхий түүний хэлийг эзэн авхай нь тас огтлуулсан юм гэнээ . Эвтибида айн цочсон мэт болж палхийгээд юм бодож түр зуур лдуугүй байснаа , юм мэдэхгүй цагаан санаатай хүний дүр үзүүлэн.

- Дайсан ч атугай дээдэс бурхдад бишрдэг байна… маргааш би … үүр цайхаас урьд … наашаа ирнэ… өдөр бол гладиаторуудаас айж бана … ялагдашгүй Оливарийн Геркулест өргөлд тахил явуулах талаар эзунээ зө вшөөрүүлж чадаагүй бол би өөрийнхөө хир хэмжээнд тохирсон өргөд барьц авчирна гэжээ .

- Тахиллч, бишрэлт сайхан сэтгэль хүүхнийг магтан сайшааж чамайг Геркулес өршөөж байна гэ хэлээд , гаргаж өгөх зуураа өгсөж уруудахад аятай нууц зам хүүхэнд зааж өгчээ .

- Итгэлийг эвдэгч грек бүсгүйн баяр нь хэмжээгүй их байжээ . Учир нь найдаж горьдсоор давуу сайн хань хамсаатныг олж авчээ . тахилч нь хомхой ховдог , биеэ худалдахад бэлэн хүн болох нь ил байсан учир, түүнд хээл хахууль өгч , түүний тусламжтайгаар хотын хэрмийг нэвтрэн орох ямар нэгэн зам олдох төлөвтэй байсан юм . Юу ч л гэсэн энэ тахилчийн тусламжтайгаар Спартакийн дүү

хүүхнийг алж, Спартакт аймшигт гашуун зовлон ‘учруулна гэж Эвтибида найдсан учир тэгж түүний зүрх нь хүчтэй цохилсон байжээ .

- Маргааш шөнө нь грек хүүхэн нэг хурга , гахайн бяцхан торой хоёр , цав цагаан тагтаа дөрвийг авч лагериасаа гарч , тахилчийн үзааж өгсөн замаар явж Геркулесын сүмд очжээ . Сүмийн тахилч хаалгаа нээж ядуу шивэгчийн өргөл барьцыг хүлээн авлаа .

- Эвьтибида дараалан ьав зургаан хоног Геркулесын сүмд ояиж Аий Стендидийн (тахилч нь ийм нэртэй байжээ) санаагэвтэйхэн тэмтрэн мэдэж аваад дараа түүнтэй хэлэлцэн дохиролцсоор бэлдэж байсан явуулгандаа түүний г дасгажээ . Дараа нь Эвтибида илчлэн би бол шивэгчин хүүхэн биш , харин ромынхонд албан хаадаг хүн юм . Ромынхон та нарыг туславал чамайг болооп бусад тахилчдыг красс гар татахгүй шагнах болно. дайснй бүгсэн хотыг гэнэт дайран орохын тул хотын хэрмийг хялбэар нэвтрэн орох газрыг зааж өгөх хэрэгтэй гэжээ .

- Иймэрхүү ярианд урлдаас бэлтгэгдсэн тахилч анхандаа гайхсан хүн болж :

- Тэгвэл чи , эфиопи шивэгчин биш б айх нь ээ? ромынхоны солнирхолыг найдьарьай хамгаалагч грек хүүхэн байх нь ээ? … намайг бас сайхан хуурав аа!

- Тэр бол цэргийн арга заьв байсан юм ..

- Би ч чамайг буруушаахгүй байна. Хамгийн дээдэс бурхад зүй ёсоор ариун сүсэг бишрэлээрээ аларшсан ромынхонд үйл хэргийг хамгаалж байна. Геркулес бурхны тахилчид бид нар нь манай бурхныг хамгийн үнэнчээр шүтэж, түүнд зориулан гайхамшигт сайхан зургаан дуган сүмийг хотуудаараа барьсан ромынхоны талд байх ёстой .

Сэтгэл нь баярлан , нүд нь гялалзан байсан Эвтибида:

- тэгвэл чи, Крассын төлөвлөгөөнд туслах хүн шив дээ?

- Чадах хирээрээ тус хүргэхийг л бодъё… гэвч юугаар тусалдаг билээ гэж тахилч хариулжэ .

Энэ хоёр хурдан зөвшөөрөлцжээ . хотод нэвтрэн орно гэдэг бол маш аюултай боловч, ямар нэгэн гэмгүй хэргийн нэрийдлээр нэвтроэн орохыг бодъё . тэр нь Мирцагийн зүгээс дэмжлэг олох байх гэж найдаж байсан юм . Түүнийг энд ирээд буцахад нв эвдрэн бутарсан газар тийш эрэг гангатай эгц бэлийг дагаж хүрдэг замыг би мэднэ. Хэрмийн тэр хэсгийг гладиаторууд ёүрхий бэхэлсэн байж болох боловч түүгээр дамжин хот руу төвөггүй нэвтэрч болно гэж нэмж хэлжээ . Хэрэв ажлаа дууссанб дараа крассаас тахилчид олүгох их шагналаас урьдчилан арван талань мөнгө олг охыг Эвтибида амлажээ .

Дараа шөнө нь Эвтибида багагүй хөдөлмөр зарцуулж нүүр гараасаа хүрэн будгаа салгаад ,ц
эрэг хувцас өмсөж Геркулесын сүмд очсон боловч, тэн Аий Стендидий байсангүй
. Бусад тахилчдаас нь сонсвол түрүүн мирца ирж Геркулест тахил өргөөд буцсан бөгөөд түүнтэй хамтран хот орхооор Аий Стендидий явчихсаан байжээ .

Эвтибида сүмийн дотор нуугдан , зүрх сэтгэл нь айх найдах хоёрыбн заалган дзээр доглон цохилж тахилчиын буцаж ирэхийг бүх л өдрийн турш хүлээжээ. Тахилч орой болсон хоной орж хотын хэрмийн нуранхай байсан газрыг шинэчлэн сэлбүүлсэн байна, цэргийн хашир болгоомжтой их удирдагч Спартак нь хотын хэрмийг ал хэдийн нь эргэн торйон шалгаж муудсан газар бүхний нь бэхлэн сэлбэсэн байна гэж ярилаа .

Эвтибида тахилчийн мэдээг сонсож , ихэд урам хугаран мөн Спартакийн болгоомжийг тэсэж ядан хараан зүхжээ .

Эвтибида бодол болон удаан дуугүй байснаа :

- Гладиаторын дүү Мирца энэ сүмд дахиж хэзээ ирэх вэ? гэж асуулаа.

- За… би сайн мэдэхгүй байна… Геркулесь зориулагдсан барын өдөр болох- нөгөөдрийн антимахийн өдөр ирдэг бол уу

даа… энэ өдрөө Коса арлаас эмэгтэй хүний хувцас өмссөн Геркулесын оргож гарсан дурсгал болгон манай
бурхад эмэгтэй хүний хувцас өргөдөг юм . нөгөөдөр сүмд очиж , тийм өргөл барьцад босогчид
ба ялангуяа ахынхаа зэвсгийг даатгах санаатай байна! гэж фракий хүний дүү бүсгүй , надад хэлсэн биолээ гэжээ .

Грек бүсгүй, хязгааргүй баярлан, тэнгэр өөд харж :

- Ээ! Юпитер чи шудрага баына! Геркулес чи ч шудрага байна! Олимпийн бүх бурхад шудрага байна! Чамаас одоо хүртэл авч байснаасаа улам илүү их хортойгоор өшөөгөө авна даа . Одоо чамаас ёстой цусит замаар өшөөгөө авна даа гэхэд нь : тахилч гайхаж :

- Чи ямар өшөө авах тухай хэлж байна? Өшөө хонзон авах явдлыг бурхад ивгээдэг ч үгүй сайшаадаг ч үгүй гэдгийг чи мэднэ шүү.. гэлээ .

Эвтибида түүнд хариулж :

- Тийм ээ , гэвч, ямар ч үндэсгүй учруулсан , хүнд хорголын хариуг авах гэж байгаа бол … тамын бурхдаар
ч барахгүй энгэрийн бурхад хүртэд дэмжин туслах бизээ гээд Эвтибида алтан гинжин оосортой бариулд нь үнэтэй чулуу шигтгэсэн сэлмээ тайлж аваад Стендидийн барьж :

- Шудрага ёсоор өшшөөгөө авах явдлыг тэнгэрийн бурхад ч таална биз тийм ээ Стендидий ? гэж асууж байхад
нь тахилч Эвтибидагийн бэлгийг ховдог нүдээрээ ширтэн харж байнсныаа:

- Тэгэлгүй яахав… шудрага бусаар чамайыг хорсгосон бол… авах өшөө нь шудрага бол … тэгэлгүй яахав ёрөөсөө өшөө авах явдлыг бурхны баяр гэдэггүйсэн билүү? гэжээ .

Эвтибида , хоёр том бадмаарага чулуун нүдтэй бяцхан алтан могойгоор оройгий нь ороолгож хийлгэсэн мөнгөн дуулга толгой дээрээсээ авч тахилчид дахин барилаа .

Тахилч Эвтибидагийн барьцыг хүлээн аваад хомхой нүдээ тойруулан харж байхад нь :

Би энэ өёүүхэн зүйлийг ялагдашгүй Геркулест барьж б айна маргааш дахиж арван талань мөнгө, ялагдашгүй Геркулест авчирч өгнө гэж тэр хоёр үгий нь онцгойлон хэлээд , Геркулесын тахилч чамайг өшөөгөө авах миний ажилд тус хүргэнэ байх гэж энэ бүхнийг хийж байна гэв.

- Кастор ба Поллукст тангаргалая! Чини авахыг хүсэж байгаа өшөө чинь авагдвал зохих өшөө тул … би чамд туслах хэрэгтэй байлгүй яахав! Прозерпинийн пайзанд тангаргалая гэжээ .

- Маргааш шөнө энд , үнэнч шудрага бөгөөд зоригтой хоёр, цэргийн нуух хэрэгтэй гэж Эвтибидагийн хэлэхэд тахилч хоёр алхам ухарч :

- Энд үү… сүм дотор уу… Геркулес бурхны ариун байрыг бузарлах гэж үү? … чиний хоёр цэргийн энд нууж ,б айхы минь мэдвэл гладиаторууд намайг дүүжилж алах болно, ийм аюултай юм би өөртөө хийх гэж үү? гэлээ .

- Өшөөгөө авах явдалд минь туслана гэж чи тун саяхан хэлээгүйсэн билүү гэж Эвтибида өгүүлжээ .

- Миний бурхны сүмд ирж… түүний Мирцагийн … алагдах явдалд би… зөвшөөрч чадахгүй .. энэ бол тахидч хүний нэрэнт ч тохир охгүй хэрэг... харин түүнийг олзлон барьж аваад ... чамд өгөх тухайяригдаж байсан бол өөр хэрэг байхсан билээ …. Гэжээ .Үүнийг сонсож , Эвтибидагийн ногоон нүд нь хорслоор гялалзан уруул дээр нь учир нь үл мэдэгдэх инээмсэглэл би болж :

- Тийм ээ , тийм ! Олзлон авч.. түүнийг миний гарт өгөх хэрэгтэй…

Спартак өөрөө ирж дүүгийнхээ оронд биеэ надад тушаахгүй юм бол нь Мирцаг би … би өөрийн гараар алахыг хүсэж байна! гэлээ .

ЯЧамайг, түүнийгээ яахы чинь .. би мэдэхийгш ч хүсэхгүй байна.. харин ц ус асгаруулсан гэмт хэрэгт гар оролцохгүй… хүн алах хэрэгт л оролцохгүй …гэдгээ би мэдэж б айна гэж – тахилч зусардан хэлээд- чиний тэр

үнэнч цэргүүдэд чинь нуугдах газар зааж өгнө, тэр газар нь энүүхэнд … замынхаа дэргэдэхнэ … хүн нуугдуулэ байхын төлөө би болгосон юм шиг сайхан торлог дотор бий!

Тэндээс яинь тэр хүүхэн зугтаж алга болох юм биш биз дээ?

Торхирууг тороор барихын тул тарьж ургуулсан юм шиг торлог юм шүү гэж чамд хэлсэн шүү тэгэхээр яаж зугтаж алга болдог юм …

- За, за тэгвэл сайн байна.. чиний саналаар бологл доо… бузар хэрэгт гар оролцохгүй болж сэтгэл чинь ч амраг гэж Эвтибида нарийн утгатай хэлээд :

- Би бол нэг сайхан юм саналаа гэж нэмж хэлэв:

- Чухам юу санав!

- Чи нөгөө хоёр тахилчдаа дуулгалгүйгээр надтай хамт доошоо тал руу бууя, тэгээд тэнд хоёул элыэг арвин хоолтой … ширээний ард сууж хоол идье… тэгэх зуураа чамайг Оливарийн Геркулесийн тахилчаар ч барахгүй , ёстой иргэн шудрага хүн мөн байна гэдгийг яиний царай дээр олж харахыг би хүсэж байна гэхэд нь тахилч дургүйццсэн дүр үзүүлэн Бурхдад тангаргалая! Тэгвэл чи надад итгэхгүй байгаа юм шв дээ?

- Үгүй , чамд итгэхгүй байгаа хэрэг биш … харин ариун бус сэтгэлдээ эргэлзэж б айна .

- Хэрэг байна уу даа, мэдэхгүй байна…

- Надтай тийшээ очих хэрэг байна уу гэж байна уу… байлгүй яахав . Чамд өгөх гэж миний амалсан арван таван таланьыг нааш нь авчирчихад туслах хэрэг байна түрүүн би арван таланв өгнө гэсэн байхаа ?

- Арван тав, арван тав, гэж чи хэлсэн шүү дээ! гэж тахилч яаран хэлэв

- Арав гэж хэлсэн байлаа ч гэсэн … тэр бол ташаа болжээ .

- Өшөөтнөөсөө өшөөгөө авахын төлөө би бурхдад арван талань өргөнө! Тэгээд шудрага сайн Стендидий надтай хамт явах уу тэгвэл өнөөдөр сэтгэл чинь ханана шүү ! гэлээ .

-

тахилч Эвтибидагийн өгсөан титэм ба сэлмийг эвтэйхэн газраа хадгал ж орхиод , түүний хамт ромынхны лагерь луу явлаа .

- Марк Красс нь грек хүүхнийг маш итгэдэг болсон учир түүнийг ганцаараа буу үзэмжээрээ дагуулж ирсэн хүмүүсийн хамт лагериасаа чөлөөтэй гарч , орж байхы энь огт хориглосонгүй болсон байжээ .

- Эьтибида , Стендидийн + зориулан лагерьтаа элбэг арвин будаалга хийсэнд тахилч Эвтибидаг итгэхгүй байсны улмаас амссан гашуудлаа будаалган дээр уусан найм-арван хундага онц сайн чанарын дарсандаа живүүлэн бүрэн мартжээ .

- Энэ үед н грек хүүхэн итгэлт сайн Ксенократыгаа дуудаж ирүүлэн түүнтэйгээ ямар нэгэн зүйлийн тухай шивнэлдэн ярилаа .

- Шөнө дунлдын хирд Эвтибида хүүхэн толгой дээрээ ган дуулга амсөж , бяцхан боловч сэлэмийнхээ оосрыг баруун мөрөн дээрээ тохож , хэтэрхий хөлчүүрсний улмаас хөл дээрээ төдий л баттай тогтож чадахгүй байсан тахилчийг дагуулан лагериасс гарч явлаа .

- Эвтибида ба Аий Стендидий нарын ард хэдэн алхмын зайта газар марк Алициний Крассын боолчууд болон капподоки нутгийн хоёр боол бүзрэн зэвсэгтэй дагаж явжээ .

- Эн нарын Оливари Геркулесын сүм өөд явж бах зуур нь бид Темезад юу болж байгааг тур зуур харъя. Энд Спартак олон тооны онгоц хөлөг бэлдэж гүйцсэнээс хойш гурав хоног болжээ . Гэвч маш олон хүнийг нэгэн зэрэг авч явж чадахгүй байсан учир арван таван мянган хүнийг явуулах харанхуй шөнийг хүлээж байжээ .

- Бүх л өдрийн турш, улам бүр бүрхэж байсан тэнгэрийн бараан үүлний цаанаа байсан нар жаргамагц , Спартак тушаал өгч далайн

хөвөөн дээр лагерилаж байсан гурван лүегион майхнууды
нь чимээгүй буулгаж хөлгийн зүг очуулаад Граникт тодорхрой заавар ө гснийх нь дараа дөнгөуж анхны бамбарын уаг болмогц хөвөн одох тушаал өгчээ .

Гладиаторуудын далайн
тээврийн хөлгүүд Темезаг гарч гүн далайг чиглэн нам гүм явжээ .

Африкийн зүгээс хүчтэй шуурч байсан сирокко-
салхи хэдийгээр далайчид аврага биетний хүчийг гарган тэмцэж байсан боловч Сицилийг чиглэх бололцоог тэдэнд олгосонгүй .

Гладиаторууд , галзуу
мэт хүчлэн сэлсээр далайн хөвөөгөөр хэдэн миль ургшлуулж чадсан боловч анхны тахиан дууны дараа цаг хир хугаацаа өнгөрсний дараа далайн давалгаа улам ширүүсч тэднийг эргүүлж
далайн хөвөөнд буцаасанд Граник арван
таван мянган босогчддоо Никотерийн орчмын цөл эрэг дээр гарах тушаал өгөөд, тэндээсээ даруй хүмүүсээ уулан дээр гаргаж учирсан явдлын тухай мэдээг Спартакт хүргүүлдэхээр зуутын дарга нэгийг арван
цэргийн хамтаар хөнгөн хөлгөөр явуулжээ .

Тахилч Эвтибида хоёр, Оливари Геркулесын сүмд ойртон очоод ,
капподазк нутгийн хоёр боолыг хотоос сүмд ойртон очих
замын хажууханд байдаг царс модны торлог дотор орхижээ
. Энэ хэсэг торлогоос холгүй газар гладиаторуудын толгойн сэргийлэхийн б айрласан нэгэн орд байдаг ажээ . Капподак нутгийн энэ
хоёр хүмүүсийн аяархан ярилцах яимээ ба хөлийн яимээ
үе үеийн хүчтэй салхиар дамжин ирж байгааг сонсож байжээ .

- Эрцидан , тэгэхээр тэр
  залуухан амозоны хүүхнийг амьдаар барьж авахыг бүх талаар хичээх хэрэг үү гэж нэгэн боол нь нөгөө боолоосоо төрөлх, хэлээрээ шивнэн асуулаа .

- Чадаж л гэмээж нь амвдаар нь баръя, Аскубари минь гэж Эрцидан хариулжээ .

- Би ч бас , чадвал … гэсэн шүү дээ гэж нөгөөдөх нь хэллээ .

- Чи үнэнийг хэлэхэд сэлэм юм уу , аль яинжаал хутганы тусламжтайгаар бие хамгаалах гэж түүний тэмцэхийгш хармагцаа , би түүнийг хоёр цохиод л алж орхино. Бас гладиаторуудын аяархан ярилцах нь бидэнд дуулдаж байгаас хройш тэр муу уйланхайн чарлахыг тэд нар сонсож орхих байх гэж бодоход шууд л алчихаас өөр аргагүй .

- Тэд сонсолгүй яахав,тэгээд биднийг ирж дайрна , бид алагдах болно.

- Чиний зөвөө, Юпитерт тангаргалая! … тэрийг бодоод миний сэтгэл зовж байна.

Хоёр боол , сэтгэд зовнон бодол болж дуугүй сууцгаажэ
Салхинд модны навч саржигнахын зэрэгцээгээр торлог дотуур хүний явах хөлийн чимээ тэр хоёрт тодхон сонсогдлоо .

Аскубари сэлмээ сугалан:

- хэн бэ ? гэж бөглүү дуугаар асуулаа .

Эрцидан , нөхрийнхөө адил сэлмээ сугалан

Хэн бэ ? гэлээ .

- Чимээгүй байцгаа – би Эвтибида байна …
  би орчин хавийн газар үзэж явна… ардаа болж байгаа хэргийн тухай сана зовох хэрэггүй , харин замаар л сайн харж байгтун гээд грек хүхэн торлог дотор орж үзэгдэхгүй боллоо .

Аскубари, Эрцидан нар удаан дуугүй байснаа Аскубари, тун аяархан дуугарч .

- Эрцидан !

- Юу!

- Арьс бүтэн амьд мэнд гарахын тулд энэ хэргээс яаж
  нэр хүндтэй мултрах тухай бодох хэрэгтэй байна.

- Тэгье! тэгье! Чи аргаа ололв уу?

- Олох шиг д байна.

- За ямар арга?

- Тэр бяцхан амазон хүүхний гараад ирэхэд нь хоёулаа нум сумаа бэлдье тэгээд арван хоёр – арван таван алхам ойртож ирэхэд
нь хоёр сайн сумаа тавьж орхъё. Нэгий нь хүзүү рүү нь нөгөөгий т цээж рүү нь … тэгвэл тэр орилж я чадалгүй үхнэ гэдгийг би батлана .
За энэ төлөвлөгөө ямар байна?

- Мундаг байна.

- Аскубари! Муугүй төлөвлөгөө байна шүү!

- Эсэргүүцэх гэхээр нь алж орхисон гэж нөгөө тэр хүүхэнд хэлнэ биз

- Онц сайн байна!

- Тэгвэл ингэж шийдэх үү?

- Шийдье.

Ингээд капподок нутгийн энэ хоёр хүн , нум сумаа бэлдээд ямар нэгэн чимээг маш нарийн ажиж ямарч чимээ аниргүй зогсож байлаа

Энэ үед нь Эвтибида үүр цайхыг тэсэж ядан хүлээж сэтгэл зовинон

Орчин хавьдаа өөдөө сөөргөө явж байжээ . Эвтибидаад цаг огт өнгөрч байсан бөгөөд олон удаа , торлогийн бүр зах гладиаторуудын толгойнг сэргийлэхэд тулж очтол буцаж ирж байжээ.

Тэгж явтлаа бүхэл шөнийн турш хүчтэй шуурч байсан сирокко салхи намдсаар бүр зогсохыг үзэж , зүүн зүгийн тэнгэрийн хаяа болох Апеннинын уулын хяр руу хартал
нь тэнд хуримталж байсан үүл цайвар шар өнгөтэй болон хувирч байхыг харж үүнийг тэмдэг болохыг мэдэж, сэтгэл амсхийн санаа алджээ .

Тэгээд Эвтибида , гладиаторуудын толгойн сэргийлэх байрласан ордонд очих зам дээр дахин гарч , түүнийг чиглэн болгоомжтой явлаа . Дөнгөж хёр зуун алхам явтал нь :

- Хэн бэ? гэж бөглүү ширүүн дуугаар урдаас нь асууж түүнийг зогсоолоо .

- Тэр нь орчин тойрныг эргэж шалгахаар , үүр цайхаас уртьд толгойн сэргийлэхээс гарсан гладиаторуудын эргүүл байжээ .

- Эвтибида түүнд юу ч хариулалгүц шууд эргэж торлог чиглэн хурдлан гүйжээ .

Түүнийг хариулахгүй болохоор нь хойноос нь хөөж гарлаа .

Грек хүүхэн ба түүний хойноос хөөж явсан хүмүүс тун удалгүй торлогьв ойртон ирлээ . Торлогийн захад, капподакийн хоёр хүн нум сумаа бэлэн дэлгээд мирца хүүхнийг хүлэж байжээ .

- Хөлийн чимээ сонсож байна уу? гэж Аскубари нь Эрциданаасаа асуусаанд

- Сонсож байна

- Тэгвэл б элэн бай

- Би бэлэн байна.

Шөнийн өтгөнхаранхуй шингэрч үүрийн гэгээ туяарё байсан учио бчцхан биетэй цэргийн хүн хурдан ойртож ирэхийг хоёр боол харсан боловч түүнийг чухам хэн болохы нь нүүрээр нь таньж арайхан болохгүй байна.

- Нөгөөх чинь байна.. гэж дөнгөж ойлгогдох төдий дуугаар Аскубари нөхөртөө хэллээ .

- Тийм байна … хуяг … дуулга … өмссөэн байна… ийм жаахан биетэй – зайлшгүй л эмэгтэй хүн байна.

- Мөн байна .. мөн байна…

Капподаки нутгийн хоёр хүн нум сумаа шагай зэрэг харвалаа . хоёр сум шуугиж очоод: нэг нь Эвтибидагийн мөнгөн хөө хучгий нь цөм уохиж цээжинд нь нөгөө сум нь түүний хүзүүнд нь зоогдлоо . гүйж яваа олон хүний хөлийн чимээ удалгүй Аскубари, Эрцидан нарт сонсогдлоо .

- Зэвсгээ бэлд! Гэж чанга дуугаар хашгарах бас сонсогдлоо

- Каппадоки нутгийн хоёр хүн нус
  сумаа шагайж зэрэг ухаан жолоогүй гүйж одлоо . Аравтын
  дарга дөрвөн гладиаторуудын бүрэлдэхүүнтэй эргүүлийн анги, хоолой нь
  хоржигнон бөглүү дуугаар ёолж байсан боловч ганч
  үг хэлэх чадалгүй болсон Эвтибидагийн дэргэд зогслоо .

Гладиаторууд Эвтибидаг замын хажууд гарга ууцаар нь царсан мод түшүүлэн суулгаад дуулгы нь толгой дээрээс нь авсанд өтгөн шар үс нь үхэж байгаа хүний мөрөн дэр намиран бууж ирлээ . Үүнийг харж нэгэн зэрэг:

- Эмэгтэй хүн байна ! гэлцлээ .

Үхлийн нь тэмдэг орж цавц агаан болсон нүүрий нь харах гэж бөхийлгөмөгцөө бүгд таньж :

- Эвтибида байна! гэж нэгэн зэрэг өгүүлжээ .

Энэ үед нь энд гладиаоруудын манипул ирж шархдсан хүнийг тойрлоо .

Шархадсан хүн нь байхад шархдуулсан хүн нь бас баых ёстой . Тавин хүн явж хүн алсан тэр хүнийг олж ирэх хэрэгтэй , тэр эндээс холдож чадаагүй байх ёстой гэж цэрэг командалж явсан зуутын дарга хэллээ .

Таван гладиатор Оливари Геркулесын сүм өөд гүйж очиж, бусад нь үхэж байгаа хүнийг хүрээлэн зогсож тэдэнд үгүүлшгүй их гай зовлон авчирсан Заяа муутай энэ бүсгүйн үхлийн өмнөх тарчилгааг , царайгаа барайлган дув дуугүй харж байжээ .

Эдний зуутын дарга хэсэг дуугүй байснаа ширүүн дуугаар дуугарч :

- хараал хүртсэн урвагч эм ! Эвтибида! Чи энэ цагаахр энд юу
  хийэ явсан бэ? … хэн чамайрг шархдуулав? үүнийг би мэдэхгүй байна…
  гэвч чамайг ямар нэгэн хорт муу арга дахиж хийх
  гэж яваад түүндээ өөрөө орж үхэж байга чинть тэр бизээ гэдгийг тааж
  байна гэж зандарлаа .

Эвтибидагийн омголтон хөхөрсөн хушуу нь хөдлөн туйлдан ёолох дуун гарч , гладиаторуудад надаас холд гэсэн дохио гараараа өглөө.

Тэгэхэд нь зуутын дарга гараараа түүнийг занаж :

- Чадахгүй ! Чи муу , урван тэрслэгч манай гучин мянган ах дүү нарыг алуулсан … чиний урван тэрсэлсэн хэргийг чамд сануулж үхлийн чинь өмнөх тарчилгааг улам их болгож өшөөгөө авалгүй үхсэн нөхдийнхөө сүнс сүүдрийг хөөрхийлөн байна гэж зандарлаа .
- Эвтибида толгойгоо цэжин дээрээ унаглаа . хэрэв тэр нь үе үе тасалдах хүнд дуугаар ёолж байсангүйсэн бол үхжээ гэж санаж болох байлаа .
- Каппадокийн хүмүүсийн хойноос явуулсан тавин гладиатор энэ үед буцаж энэ шархдуулсанг барьж авсан Эрциданыг авч ирлээ .
- Баришдаж ирсэн энэ хүн мэдсэн бүхнээ доочин хэлсэнд гладиаторууд болж өнгөрсөн энэ явдлыг учрыг ойлгон мэдэж авлаа .
- - Энд юу болж байна ? гэж эмэгтэй хүний дуу гарлаа .

Энэ нь Геркулесын сүмд очиж явсан Мирца байжээ . Зуутын дарга мирцад зам тавьж түүнийг дунгуйран зогсож байсан гладиаторууд дотор оруулж

- Чамайг алуулахаар энэ муу бузар эм Эвтибидагийн бэлдсэн сум нь Геркулесын өршөөлөөр урвагч эмийг өөрий нь нэвт харваад байгаа нь энэ гэлээ .
- Эвтибида Мирцагийн дууг сонсож , толгойгоо өндийлгөн үзэн ядаж хорсон буцалж нүд нь гялалзаж мирцаг ширтэж байснаа, юм ц хэлэх гэсэн мэт уруулаа мурилзуулаад түүнийг барьж авах гэсэн мэт хуруугаа сарвайлган хоёр гараа ургаш сунган маш их хүч швахан бүх биеэрээ урагш ухасхийгээл д сүүлчийн дуу нь тасарч толгойгоороо мод мөргөж амьгүй бие нь хөсөр уналаа .

- Энэ нэгэн удаад , шувууны анчин торондоо өөрөө орох нь энээ гэж зуутын дарга хэлээд мирца болон
бусад хүнээ дагуулан үзэшгүй муухай урвагч эмийн
хүүрээс дуугүй холдон явлаа .

## ЭЦСИЙН ТУЛАЛДААН .
## БАРДАНУСЫН ДЭРГЭД ЦОХИГДСОН НЬ . НАС БАРСАН НЬ.

Граник Спартакт мэдээ хүргүүлэхээр явуулсан бяцхан хөлөг онгоц Мирцагийн нүдэн дээр Эвтибидагийн үхэж байгаа энэ үед нь темеза хот хүрч ирлээ .

Бруццийн иргэд , Граникийн буусан мэдээг сонсож , Спартак их бодол болж цаашаа яадаг билээ гэж удаан бодож байснаа Арторикс тийш хандаж – За яая гэхэв … нэгэнт граник арван таван мянган хүнийхээ хамт Никотерийн дэргэд байгаагаас хойш… үлдсэн бүх цэргээ далайгаар тийш нь очуулж , тэнд байлдааныхаа ажиллагааг улам хүчтэй сэргээн явуулахаас биш гэлээ .

Спартак , ирсэн онгоцыг Граник тийш буцааж маргааш шөнө, бүх хөлөг онгоцоо Темезад ирүүл гэсэн тушаал түүнд явуулжээ . найман шөнө л дараалан бүх цэргээ цувуулж , Никотери руу явуулжээ . ХРомынхны анхаарлыг татахын тул бүх энэ өдрүүдэд хуурай газрын зүгээс дайралт хийж байх хэрэгтэй гэж Спартак тушаасан байжээ . Харин морин цэргүүдийнхээ хамт Спартакийн өөрийн нь явсан сүүлчийн тэр шөнө гладиаторууд дайралт хийсэнгүй .

Спартак , Мамилий ба морин цэргийг суулгасан сүүлчийн хөлөг онгоцууд хөдөлж далайн хөвөөгөөр хэдэн миль холдмогц Темеза хотынхон яаран очиж болж өнгөрсөн хэрэг явдлын тухай Красст мэдэгджээ .

үүнийг сонсож ромын цэргийн их удирдагч ухаанаа гартал уурлаг Спартакийн цэргийнхээ хамт оргож явах гэж байгаа тухай ямар

нэгэн аргаар мэдэгдэхээсээ айж болгоомжилсон Темеза хотынхныг элдвээр хараан зүхжээ . Хүрээллээс мултран
гарсан гладиаторууд дайныхаа ажиллагааг улам хүчтэй явуулах боно. Красс нь гладиаторуудтай явуулах дайныг ч дууссаан гэж үзэхэд бэлэн байсмнаар ч барахгүй мөн энэ тухай ромлд захидлаар мэдэгдсэн байжээ .

Спартакийн тухай мэдээлэхээсээ айсан Красс Темеза хотын иргэдэд үлэмж их торгууль хүлээлгэн маргааш
нь цэргүүддээ тушааж лагериасаа хөдлөн Никотерийг чиглэн хөдөлжээ .

Гэвч Спартак нь Никоьерт хүрсэн өдөртөө , үүрээр бүх легионыхоо хамт замд гарч , хорин цагийн турш аялсныхаа дараа сая Сициллеумын
дэргэд лагерилан буужээ.

Маргааш нь тэндээсээ хөдөлж, Регниум орсон бөгөөд замдаа боолчуудыг уриалан нийлүүлж явжээ . Спартак Региумд онц сайн газар эзлэн гладиматоруудаас гурван өдөр ,
гурван шөнө турш ажиллуулан бэхлэлт бариулж
шуудуу ухуулж орж ыолшгүй бат бэх лагерь байна байна
гэж красст төвөггүй мэдэгдэхүйц тийм лагерь байгуулжээ .

Красс үүний хараад Спартакийг эсвэл албаар тулалдаанд гаргах эсвэл бууж өгөхөд хүргэх гэж шийджэ . Тэгээд красс нь Плутарх , Аппиан, Флор нарын зэрэг гэхчлэн хүмүүсгүй байсансан бол хүн
үнэмшихийн аргагүй тийм сүрхий барилга барьж ёстой
л Ромын бэхлэлт байгуулж авчээ .

Орчин тойрны газар нутгийн байдал
нь ямар аргаар цэрэг дайны явуулга хийвэл зохихыг аяндаа
өөрөө зааж өгч байгаа газар болохыг
красс харж тэндхийн нарийн хүзүүвчийг давуулан
цэргүүдээрээ хэрэм бариулжээ. Ингэж хэрэм бариулахдаа нэг талаас ажилгүй дэмий сууж удаахад цэргүүдээ хүргэхгүй , нөгөө талаас дайсны цэргийг хоол ундаа залгуулах газраас нь таслах зорилгыг тус тус тавьсан юм
.
Красс богинохон хугацааны дотор нэгэн далайгаас нөгөө далай хүртэл урт аараа гурван зуун стадий , өргөн ба гүнээрээ аран таван

фут шуудуу суваг ухуулж, мөнг үүнийхээ хөвөөг дагуулан ер бусын өндөр ер бусын бат бэх хэрэм бариулжээ .

Инэгж ромынхны зуун мянган цэрэг тэр лут барилгаа барьж байх завсар нь Спартак , Бруцийгээс ирж түүнийг цэрэгт нийлсэн арван нэгэн мянган боолоор дахин хоёр легион байгуулж түүндээ цэргийн сургууль зааж байсны дээр мөн Крассын занганаас яаж гарах тухайгаа аль хэдийн бодож олсон байжээ .

Арван хоёр хоног болсны хойно нэгэн өдөр Арторикс Спартакт хадаж :

- Спартак аа дайсан ыиднийг бүсэлж хоргонд хийж байгааг харахгүй байна уу? гэж асув.
- Дайсан биднийг хашчихлаа гэж чи бодож байна, тэгээд Клод Үлабр Везувид намайг торонд хийчихлээ гэж бас л итгэж байсаан вм .
- Арав хоногийн дараа хүнё дүүрнэ шүү дээ .
- Хэний хүнд дүүрэх гэж ?
- Манай
- Хаана?
- Энд
- Аа тийм үү! Хонгор Ароторикс минь ээ , арав хоногийн дара бид эндээ байсан хэвээр байна гэж чамд хэн хэлэв?
- Аорторикс , хамгаас холын харцтай цэргийн их удирдагч хүнд санад зөвлөгөө өгөх гэснээсээ ичиж , дув дуугүй болон толгойгоо бөхийлгөн зогсож байлаа . Спартак, ичиж зовсон энэ залууг өрөвдөхн урьхан харцаар харж инээмсэглэн мөрий эь тогшин :
- Арторикс аа, хоол хүнснийхээ тухай надад сануулдаш чинь сайн боллоо , харин бид нар өөрслдийнхөө тухай сэтгэл ковох хэрэггүйы . Крассыг бариулсан хэрэмийнхээ дэргэд мангууран , амаа ангайж зогсож байтал нь хаяад бид явчихсаан байна гайгүй гэлээ .

- Гэвч Красс нь цэргийн туршлагатай их удирдагч хүн гэдгийг зөвшөөрөх хэрэгтэй бизээ !

- Тийммээ, энэ гурван жилийн дотор бидний өмнөөс ирж байсан цэргийн удирдагчдийн дотороос хамгийн их туршлагатай нь красс мөн гэж Спартак хэлээд, минут хир дуугүйы байснаа:- гэвч Красс биднийг бас л ялж чадаагүы л байна шүү гэж нэмж хэллээ .

- Чамайг амьд байгаа цагт Красс ялж ч чадахгүй л дээ

- Ароторикс минь ! Би чинь зөвхөн хүн шүү ээ .

- Үгүй , чи бол билний ухаан , чи болд билднийы хүч , чи бод биднийг туг мөн. "Дарлагдал сөнөтүгэй үгээгүйчүүд зол жаргал , боолчуудад эрх чөлөө" гэсэн санаа чиний дотор төргж, бий болон чиний дотор амилан өсөж байдаг юм . Манай нөхдийн дотрооё хамгийн ганируугийн нь номхтогон дарж байдаг гэээ чамаас цацарч байдаг юм, чиний амьд байгаа цагт тэд нар чиний хүссэн бүхнийг хийж, бүтэхгүй юмыг бүтээж байх болно, чиний амьд байгаа цагт тэд нар , өдөрт гучин мильгазар аялж ядрах зовох бүхнийг даж, өдөрт даарах бүхнийг давж, дайантай арслан мэт тулаллдаж б айх болно, хэрэв чи үхэх юм бол чиний хамтаар манай туг сөнөж хорь хоногийн дараа бид бүгдээрээ алагдан байлдан дуусах болно … чиний амь насыг бурхдад удаан өршөөн хамгаалж биднийг бүрэн ялалтанд хүргэх болтугай!

Энэ үед нь нэгэн зуутын дарга Спартакийн дэргэд ирж :

- Дайсны лагериас оргож гарсан далмат ба иллирий нутгийн гурван мянган дүүгүүрдэгчид преторын хаалган дээр ирээд биднийг ах дүү нарынхаа эгнээнд багтаан авна уу гэж хүсэж байна гэсэн мэдээ авчирчээ

- Спартак, тэр гурван мянган хүний хүсэлтийн тухай түр бодож байснаа лагерийн хаалга руу очиж :

- Өөрийнхөө тугаас урвана гэдэг бол гарамгай цэргийн хүмүүст бай болшгүй , буруушал зэмлэл хүлээлгэвэл зохих хэрэг мөн . Урван тэрслэгчдийн хамгаалан дайсны лагерьт оргож ирэгчдийн эгнээндээ багтааж авна гэдэг бол цэргийн шудрага удирдагшч хүнд байж ыолшгүй зүйл болохоор ч барахгүй аюултай хэрэг мөн. Учир нь өөрийнхөө зорьсон хэрэг , өөрийнхөө тугаас урван ирж хэлэхдээ тэднийг үнэн голоосоо иржээ гэдэгт итгээгүйгээс ч болсон байж болнго , эсвэл өөрийнхөө цэргүүдэд хортой жишээ үзүүлэхээсээ дургүйцсэнээс бол сон байж болох юмаа.

- Тэгээв Спартак тэднийг хүлээж авангүй .

- Долоо хоног өнгөрсний дара орой бзрий болохоос өмнөхөн аравтын ба зуутын дарга нар гладиаторуудын майхнуудаар хэсэн, явж танаро бүрээ үлээж дохио өгөхийг хүлээлгүй м аш чимээгүй , орон майхнаа буулгаж лагериасаа хөдлөхөд бэлэн болсон байх хэрэгтэй гэсэн Спартакийн тушаалыг зарлажээ .

Энэ үед морин цэргүүд мөних удирдагчийн тушаал ёсоор маш их хэмжээний мод бэлтгэн шөнийн цагаар лагерьтаа авчрахаар сүх авч ойд очсон байлаа .

Анхны бамбарын цагаар Спартак тушаал бгч, лагерь дотор том түүдэг а саалгаад , хоёрдахь өдөртөө тасралтгүй орж байсан цас борооны хавхавчийн дор, уэргээ авч маш чимээ аниргүй о лагериасаа хөдөлж, одоохон хирдээ хэрмээр арай хашаалагдаагүй байыса н крассын шуудууны тэр хэсгийг яигдэн очоод морин цэргийн бэлдэж ирсэн мод ба мөчрөөр крассын шуудууг дүүргүүлж мөн зургаан мянган цэргээр урьдчилан бэлдүүлсэн олон шуудай шороогоор д ээгүүр өргөн газраар тавиулжээ . Ингээд Спартак цэргүүддээ тушаал өгч, энэ гүүрээр маш чимээгүй гарцгааж цас бороог анхааралгүй зогсолтгүй явж, Каулони хүрэх хэрэгтэй гэжээ

Спартак өөрөө морин ц эргийнхээ хамт үлдэж дайсны лагерийн ойролцоо байсан модон дотор нуугдаж байгаад дараахь өдрийн үд хирд хоол

хүнс бэлдэхээр орчин хавийн газруудаар явж байсан дйсны хоёр легион цэрггийг дайран орж хагасхан цагийн дотор ромынхон дөрвөн мянга гаруй цэргийг хядаж хаяад Каулонийг чиглэн давхиж одлоо .

Ингэж Спартак цэргийнхээ хамт бүслэлтээс гарч явсан байхыг мэдэж, Марк Красс тэсгэлгүй гайхан:

- Ээ дээ , бас … тамын бурхдад тангаргалая

Энэ үгий нь сонсож Спартакийн нүүрнээс гал гарах мэт болж, хөмсөг зангидан, Крассын зүг заналхийлэн урагш алхсан боловч биеэ барьж , маш ууртай бөгөөд чирчирсэн дуугаар

- Орго гэн ээ? … урав гэнээ…? тэгсэнд орвол ыүх нөхдийнхөө хамт явж байгаад байлдааны талбай дээр алагдвал хол дээр гээд гарах хаалгын зүг явах замдаа :

- Баяртай Марк Красс гэжээ .

Спартак хаалганы  босгонд  хүрээд  зогсож  ромын цэргийн  удихрдагчийн  зүг хандаж:

- Чамтай би анхны  тулалдаан  дээр уулзах байгаа?
- Уулзана.
- Чи надтай үзэлцэнэ биз?
- Үзэлцэнэ
- Баяртай красс аа
- Баяртай

Спартак ордны  хашаан  дотор гарч , мориндоо  ухасхийн  мордоод , явцгаая,  гэж өараа  бологсоддоо  тушааж , морины  хурдаар  лагерийнхаа  зүг давхиж  одлоо .

Лагерьтаа  дөнгөж хүрмэгээ , цэгүүддээ  тушаал өгч , орон майхны  нь буулган  Браданус,  голыг  төлөөр туулж  Петелийн  зүг  явжээ .  Петелид  шөнө хүрч , тэндээ  лагерилан  буужээ .

Маргааш өглөө  нь үүрээр  Спартакийн  тангуулчид  ромын  цэргийн арваны дарга нэгэн   хүнийг  олзлон  барьж  авчирлаа  Тэр хүн нь  Брундизумэд  цэргийнхээ хамт  уугаад  байан  Лукуллээс , Красст  мэдээ хүрггэж  явсан хүн байлаа .

Аврагдах  , ямар ч найдвар  Спартакт  алга  болжээ .
Эцсийн  шийдвэрлэх  тулалдааныг  хийж чадвал ,
Крассыг  ялж  үзэх  ганцхан  зам үлджээ.
Спартакийн  хувь  заяа  үүгээр  шийдвэрлэгэх болжээ .

Иймийн  учир Спартазк  цэргийнхээ  хамт  Брадануcд  буцаж  очоод,  голын зүүн  хөвөөгөөс  нэгэн миль  зайтай  газар лагерилан  буужээ .  нэгэн өдрийн  өмнө Спартакийн  байрлаж байсан  газар болох , голын баруун  гарын  хөвөөн  дээр одоо  Крассын  цэрэг лагерилан  буусан байжээ .

Красс шөнийн  дотор цэргүүдээ  голын зүүн  гар талын  хөвөөн дээр  гаргаж  , гладиаторуудын  лагриас  хоёр миль   зайтай  газар  лагерилан  буулгажээ .

Үүр
цайж байхад Ромынхны дөрвөн когорт цэрэг, лагерийнхаа хамгаалалтанд ш уудууг гүнзгийрүүлэн байжээ .
түлээ авахаар модонд очиж явсаан гладиаторуудын гурван зогорьт цэрэг тэднийг коригтой дайран оржээ .

нөхдийнхөө хашгаралдах чимээг сонсож хамгийн
ойр лагерилаж байсан ромынхны нэгэн легионы бүх
уэрэг хамгаалалт далангийнхаа цаанаас гарч ирэв.

Лагерьтаа байцгааж байсан
гладиаторууд зэвсэг хангинах яимээ сонсож зоомол хашаан дээрээ гарч хараад тулалдаан болж байхыг мэдэж , нөхөддөө туслахаар яаран очжээ . Ингээд хоромхон зуурын дотор тулалдаан эхэлжээ .

Энэ үед Спартак , ьалерияд бичсэн захидлаа хуйлж байв.

Спартак захиагаа лаанб тосоор лацдаж бяцхан гуугаараа тэмдэг дарж битүү мжлээд , валериягийн явуулсан гурван гладиаторуудын нэгэнд өгч:

- Та нарын хайртай эзэн ноёнтон хүргэх энэ захайг та нарт итгэмжлэн өглөө- гжэ
  Спартакийн хэлэхэд захиа хүргэхээр хүлээж авсан гладиаторууд:

- Бид эзэн ноёгтойгоо хайртай байдгийнхаа нэгэн адил чамд бас хайртай байдаг юм гэлээ .

- ийм үг хэлсэнд сайн сэтгэль ах дүү та нарт баярлаад , зэлүүд зам, бартаатай зөргөөр маш болгоомжтой өдөр шөнөгүй явж,
  энэ захиаг хүргэх хнэрэгтэй. Хэрэв азгүй явдал тохиолдож , та нарын нэг нь осолдоход хүрюэл захиаг нөгөөх нь дамжуулан авах хэрэгтэй Энэ захиаг хүргэж өгөх талаар болдог бүхнийг хийх хэрэгтэй 6 одоо та нар явцгаа Бурхан та нарыг өршөөж явах болтугай

гурван гладиатор Спартакийн майхнаас гарч явлаа .

- Та нар декуманын хаалгаар гараарай… гэлээ.

Спартак , тулалдаан болж байх чимээ сонсож, юу болсныг мэдэхээр гүйж одлоо . дайсантайгаа сүүлчийнхээ тулалдаан хий гэж шийдсэн Красс

ч бас гарч иржээ . Цэргийн хоёр
их удирдагч тус тусынхаа легионуудыг байлдааны журмаар жагсаажээ .

Спартак эгнээнийхээ өврөөр явж эргэхдээ :

- Ах дүү нар минь ээ, бүх байлдаан ямар төгсгөлтэй болохыг өнөөдрийн бидний тулалдаан шийдвэрлэх болно. Усан замаар ирж Брундизиумд буудалласан Лукулл бидний араас ирж, явна, бидний баруун гар талаас одоо самниум ирж явна. Помпей занаж байна , бидний өмнө Красс байна. Өнөөдөр нэг бол ялах, эс бол бүгд алагдах болжээ . Урьдчилан Крассынг цэргийг устгаж дараа нь Помпейгийн цэргийг дайран орох хэрэгтэй байна, эсвэл Ромынхныг өдий төдий удаа ялж явсан зоригт эрчүүдийн ёсоор бүгдээрээ алагдаъя Манай зорьсон үйл ажил нь ариун шудрага ажил тул бидний хамт үхэхгүй . Цусаар дамжин ялалтанд хүрэг.

- Хохирол сүйрлийг амссан хатуужилтай явсны дүнд л сая агуу их бодол хүсэл туйлдаа хүрч биелдэг юм . Гутамшигт бузар аймшигт бузар амьдарлаар амьдарсанд орвол , эрэлхэг зоригтой тэмцэж яваад хүндэт ёсоор үхсэн дээр. Бид алагдавч цусаараа тэмдэг дарсан ариун өв хөрөнгө болох өшөөгөө авч ялалтанд хүрэх зам , эрхчөлөө , тэгш эрхийн тугийг хойчийг залгамжлагчиддаа үлдээж өгнө. Ах дүү нар минь ээ алхам ч ухарч болохгүй нэг бол ялалт байгуулъя , эс бол бүгдээр алагдая гэж цэргүүддээ хэлжээ .

- Энэ үгийг хэлж байхад нь нүмиди үүлдрийн , ум зандан мод шиг хөө хар морий нь авчирч өгөхөд нь Спартак сэлмээ суга татан авч мориныхоо цээж рүү зоож орхиод :

- Өнөөдөр надад морины хэрэг үгүй : хэрэв би ялагч болбол дайсны морьдлос дуртайгаа унах болно , хэрэв бут цохигдвол надад морины хэрэг хэзээ ч тохиолдохгүй гэлээ .

- Гладиаторууд , Спартакийн хэлсэн үг хийсэн ажлаас дүгнэж , одоогийн энэ тулалдаан сүүлчийын тулалдаан болохыг ойлгож , өндөр дуугаар

Спартакт баяр хүргээд , одоо биднийг командлан тулалдаанд оруулж аль гэж түүнээс шаарджээ .

- Спартак л дохио өгч , бүрээ ,
  хонх чанга дуугарч, гладиаторуудын ухасхийн дайсныг дайран орлоо .
- Ширүүн борооны дараа үүлнээс буусан аймшигт үерийн ус замдаа тохиолдслн бүхнийг урвуулан хөрвүүлж эвдэн сүйтгэж ойр орчмын газа р далай мэт давалгаалан оволзох шиг гладиаторууд ромынхныг дайран о ржээ.

Энэ
аймшигт ширүүн довтолгоонд автан, Крассын лдегионууд тээнгэлзэн хохил ж байсанаа ухарч эхэллээ .

Спартак тэргүүн эгнээний төвд явж дайснууд тулалдан хүч чадал ,
эрэлхэг зоригийн гайхамшигийг сэлмээрээ үзүүлж , хүч чадал ,
эрэлхэг зоригийг гайхамшигийг сэлмээрээ үзүүлж явлаа
. Дайсны цэргийн гуйвж байхыг
харж мамилийд зориулан тусгай дохионы бүрээ тэтэх тушаал өгчээ .

Найман мянган морьт цэргийнхээ хамт, явган цэргийн ард байсан
мамилий дохионы бүрээ сонсож, цэргийнхээ хамт давхин
гладиаторуудын зүүн гарын жигүүрээр торйоэн хоёр стадий гаруй
газар түрүүлэн цэргээ тараан баруун гар тийш эргэж ромынхныг эгнээг
чиглэн морины хурдаар давхиж очлоо .

Байлдааны
шугамыг анхааралтай ажиж, гуйвж байгаа легионуудад зоригжуулан байсан,
Красс дайсны морьт цэргийн урдаас тосож очих, тушаалыг Квинтэд өгчээ
. Ромынхны арван таван мянган морьт цэргийн дотроос арван
мянга нь гайхалтай хурдан тасарё мамилийг тосож очлоо . Крассын баруун
гарын жигүүрийг сарнисан дээр нь дайран орж бут цохих
гэж найдаж явсан мамилий дайснй морьт цэргийн гарамгай
хүчтэй учран, түүнтэй ширүүн тулалдаан хийх хэрэгтэй болжээ .

Энэ үед ньмумий дөрвөн легион цэргийнхээ хамт гладиаторуудын баруун
гарын жигүүрийг бүслэхээр ширүүн довтолжээ . Граник, бэлтгэол
байсан сүүлчийнхээ хоёр легионыг авч Муммийг тосож дайрлаа .

Ромынхан нь илүү тооны цэрэгтэй болох нь маш тодхон харагдаж байлаа . Гладиаторуудыбн төв хэсэгтэй тулалдаж байсан ромынхны легионууд улам бүр ухарсаар байсан бөгөөд бүр зугтаж эхлэхийн даваан дээр Красс бэлтгэлд байсан сүүлчийнхээ гурван легион цэргийг тийш нь аваачиж , ухарч байсан цэргүүддээ зайлж өг гэж тушаажээ . Тэд нар нь арван таван минутын дотор зүүн, баруун тийш ухран зайлж шинээр сая ирсэн когортуудаа зай тавьж өглөө . Саяны ирсэн когортууд нь Красс ба Мамерк нарын удирдлагын дор Спартакийг ширүүн дайрч орлоо .Төвд улам ширүүн , улам аймшигт тулалдаан боллоо . Энэ үед нь үлдэж ббайсан, ромынхны таван мянган морьт цэрэг , мамилийн морин цэргийн зүүн газрын жигүүрийг тойрон очиж түүнийг араас нь дайрч орлоо .

Гладиаторуудын морьт цэрэг бут цохигджээ . хэдийгээр Граник маш уран чадвар гарамгай хүч гарган тулалдаж гладиаторууд ер бусын хүчдэл гарган тэмцэж байсан боловч баруун жигүүрийнхээ шувтрах үзүүрээр тойруулан мумийг алджээ .

Одоо гладиаторуудыг амь гарах , ялах найдвар зоригжуулахаа болвж , хайран амиа үнэ хүргэж солих шунал өшөөгөө авах, шийтгэл хүмүүсийн хүсэл зоригжуулж байжээ .

Энэ тулалдаан , цус урсгагч ярганын газар мэт болжээ .

Бүслэгдэн хүрээлэгдэж , бас урдаасаа түрэгдэж байгаа гладиаторуудын хоёр жиүгүүр хол ухарсан байлаа . Харин Спартакийн биеэр оролцон , зоригтой тулаллдаж , мөн түүний дэргэдэх Аториксын байсан төв хэсгийн цэргүүд дайсантай тэмцсэн хэвээрбайжээ .

Граник легионуудаа бут цохигдсон байхыг харж гол тулалдаан болж байсан газар тийш гүйж хүрээд , өөрийн гараар нэг зуутын дарга, хоёр аравтын дарга, найм- арав цэргийн хүнийг алаад дараа нь хорин жаданд нэвт жадлагдан цусаа асгаруулан үхжээ .

Мөн түүний дэргэдэх, аравдугаар легионы дарга македони нутгийн Эростен , бүх биеэр дүүрэн шарх олж зоригт эрийн ёсоор нас байжээ .

Оройн бүрийг болжээ . Гэвч, шархтан цус нөжөө цувуулсан , эцэж ядарсан , гладиаторуудбн дайсантай үргэлжлэн тэмцсээр лб айжээ . Эд нар нь одоо зоригтой эр хүмүүси мэт биш харин зэрлэг араатан мэт тэмцэж байлаа .

Спартак, нэгч алхам ухарсангүй . Харин өөрийнхөө мянган хүмүүсийг манлайлан дагуулж, ромынхны
зургадугаар легион дотор хушууран орсон байлаа. Дайснй тэр
легион нь дан хуучин уэргээр бүрдсэн боловч,
Спартакийн дайралтанд хариу цохилт өгч ч адахгүй л байлаа .
Спартак өөрөөсөө холгүй
газар тулалдаж явсан Крассыг үргэлж дуудсаар явжээ .
марий суллаа нарын цэрэгт байсан хэдэн зоригтой хүмүүсийн
хамтаар трибун мамерик, Спартакийг дайран очиж тэр бүгд алагджээ .
Спартазкийн цахилгаан мэьхурдан
бөгөөд хальтрашгүй сэлмэнд дайрагдан төдхөн зуурын дотор хоёр
зуутын дарга, найм буюу арав аравтын дарга нар алагджээ . Эд нар н
Спартакийн цавчилтад явж хариулбал зохихыг цэргүүддээ харуулах гэсэн
билээ гэв. Тэд нар нь
яаж харуулахыг харуулахын оронд яаж алагдахыг харуулжээ .

Байлдааны талбар дээр улам бүр харанхуй болж байсан боловч, төгс ялж байсан ромынхонлд үргэлжлэн тулалдах явдал шаардагджэ . сар гарч энэ цуст тулалдааны аймшигт талбайг мөнгө өнгөт гэрлээрээ гийгүүлжээ .

Гуичн мянган гаруй гладиаторууд мөн, арван найман , мянган ромчууд , өргөн хөндий дотор ар өврөөрөөр хэвтсэн байлаа . тулалдаан төгсөж, үхлээс арай ядан амь гарсан цөөн
тооны гладиаторууд найман цаг үргэлжилсэн тулалдаанд туйлдаа хүртэлд я дарч , хавь ойрын уул толгодыг чиглэн зугтаж оджээ .

Гэвч, бас нэгэн хэсэгхэн газар жигтэй ширүүн тулалдаан болж ц
ус асгаруулсан байлаа

Энэ нь
Спартакийн дагаж түүний жишээгээр цуцалтгүй хүчээр тэмцсээр байсан тө вийн хэсэг ажээ .

- Крассаа?… чи хаана байна?… чи надтйа тулалдана гэсэн шүү дэ… красс чи хаана явна гэж Спартак үе үе сөөнгө моолойгоор дуу нь тасалдан хашгарч явлаа .

- Мирцаг , байлдан болж байгаа газраас зайлуул гэж Спартак аль түрүүн , хоёр цагийн өмнө тушаасан юм .
  Мирцаг эндээс бараг хүчээр шахам холдуулахад , тэр нь зогсолтгүй уйлж явлаа .

Дахин нэг цаг өнгөрлөө .
Спартакийн бамбай дайснй суманд дайрагдан шүүрэн тор шиг болсон байжээ .

Энэ үед Спартак үлдэж байсан сүүлчийнхээ хоёр нөхөр болох Вибсальда Арторикс хоёрынхоо алагдахыг харжээ .
Цээжээ цөм харвуулсан Арторикс газар унахдаа :

- Спартак аа … Элизиумд… дунд … чамтайгаа уулзана… гэж найз нөхөртөө, урьхан дуугаар хашгарч хэлээд амь тавьжээ .

- Долоо найман зуун дайсанд гав ганцаараа бүслэгдэн бүх биеэрээ дүүрэн шархтай, Спартак аймшигт сэлмээ, цахилгаан мэт хурдан эргүүлэн биендээ ойртож ирсэн бүхнийг тасар цавчлан унага ж явжээ . Өөрөөс нь арван хоёр алхмын зайтай газраас шидсэн шидэх, жад ирж зүүн гар талын сүүжин орчим зоогдоход,
  Спартак сөхрөн унасан боловч, дайсны урдаас бамбайгаа тосгуулж ,б ас сэлмээрээ ажиллаж байхы нь харахад , центавруудад бүслэгдсэн Геркулес мэт маш гайхалтай байлаа .Тэгж байтал арван алхмын зайтай газраас шидсэн долоо найман шидэх жад ирж нуруундаа зоогдоход түрүүлгээ унахдаа:

- Ва…ле..рия… гэдэг ганцхан үг хэлжээ .

Тулалдаан бүр эхлэх цагаас аваад сүүлчийнхээ минутыг хүртэл баатар зоригтой тулалдаж явсныг харж байсан ромынхон Спартакийн үхсэн биеий г тойрон зогсож үг дуугүй гөлрөн харж байлаа .

Түүхэнд тэмдэглэгдсэн цэргийн хамгийн агуу их удирдагчидтай мөр зэрэгцвэл зохих, ариун сайхан сэтгэл, нэвтэрхий саруул ухаан цуцашгүй эрэлхэг зориг, ховорхон гарамгай хүч, онцгой мэргэн оюун ухааныг нэгэн зэрэг биедээ хослуулсан ер бусын их хүний амьдралын нь сүүлчийн өдөр ингэж өнгөрчээ .

Хоёр цагийн дараа, ромынхны эндээс явцгаажээ . Гашуудан харж байсан сарны цайвар гэрлийн дор аймшигт тулалдааны талбар нам гүм байхад шархтай ба үхэж байгаа хүмүүсийн шаналан ёолох дуун хааяа сонсогдож байлаа .

Үхсэн хүмүүсээр дүүрэн энэ талын дунд сүүдэр мэт нэгэн юм сүүмэлзэн явж байхы нь харагдлаа .

Тэр нь аяархан явсаар , хамгийн удаан хамгийн ширззн тулалдаан болсон газар хүрч очлоо . Тэр нь цэргийн хүн бололтой сарны гэрэл тусахад түүний зэвсэг өмссөн, дуулга нь гялазан харагдлаа . тэр цэргийн хүн удаан займран явсаар , Спартакийн унасан газарт хүрч очоод тэнд зогслоо . Энэ цэрэг цэвэрхэн нуруутай боловч бага биетэй хүн байлаа . Энэ хүн , гладиаторуудын их удирдагчийн биеийг олон олтлоо , алагдсан хүн нэг бүрийг бөхийн ажиж явжээ . Энэ цэргийн хүн , Спартакийн биений дэргэд очиж сөхрөн суугаад , түүний цайвар шар үстэй толгойгий нь арайхийн өргөж, Спартакт алагдсан ромын нэгэн зуутын даргыг дэрлүүлжээ .

Тэр бяцхан биетэй гладиаторуудын хувхай цагаан болсон нүүрэн дээр нь сарны гэрэлд туслаа . Тэр нь амьгүй болсон Спартакийн нүүрэнд хушуугаа нааж, цурхиртал уйлан, эл эг эмтрэн хөөрхийлэлтэй үнсэж байжээ .

Энэ цэргийн хүн нь мирца мөн болохыг манай уншигчид тааж мэдсэ байлгүй . мирца нь гладиаторуудын бурмөсөн бут ццохигдсоны дараа Спартакийн даалгавараар түүнийг харгалзаж байсан хүмүүсээс нуугдан гарч байлдааны талбар дээр буцаж ирсэн байжээ . мирца энд ирэхдээ , Спартак Арторикс нарыг амьд байхгүй гэдгийг мэдсэн боловч хайрт хүмүүсээ сүүлчийн удаа үнсэх ганцхан хүэслтэй ирсэн ажээ .

Мирца Спартакийн нүүрийг үнсэн, цурхиртал уйлж:

- Ээ Спартак минь … хонгор ах минь … чамайгаа ямар болсон байхы чинь үзэх минь энэ вэ! Эрүүл газар чиний биед нэг чүлдсэнгүй . хичнээн их шарх байна вэ? … Ямар их цус вэ!… гэж сулхан дуугаар үглэж байжээ .

гашуудалт энэ нам гүмийн дотор шаналан ёолж байгаа авиануудын дотроос нэгэн авиа хамгийн ойр
хамгийн тод сонсогдоход бүсгүй ажиглан чагнасан боловч ,
байрнаасаа хөдлөлгүй амьгүй болсон Спартакийн нүүрийг үнсэн таалсаар суужээ .

түрүүчийн хүний шаналан ёолох дуун дахин сонсогдлоо . Энэ удаад ёолохын зэрэгцээгээр ямар нэгэн үг
хэлж байгшаг ажиж болмоор байжээ .

мирца энэ үед бяцхан ухааран , ажиж чагнатал үхэж б айгаа нэгэн хүний өөрийн нь нэрийг удаан хэлж байхы нь сонсогдлоо .

Бүсгүйн бүх бие арзас хийж , хөл дээрээр босон харайж , духан дээгүүр нь хүйтэн хөлс чийхран , айн сандарё хоёр нүд нь том болж :

- Бурхдын төлөө !… хэн бэ!… хэн намайг дуудав? … гэж түүний хэлж байгааг ямар нэгэн хүн сонсож байга мэт өндөр дуугаар асуусныг өөрөөч мэдсэнгүй .

Мирца минь! Мирца минь! гэж үхэж байгаа тэр хүний дахин хэлэх нь энэ удаад тодхон сонсогдлоо . Үүнийг сонсож мирца гэнэт баярлан:

- Юу вэ? … Арторикс уу?… Арторикс минь гэж үү? Гэж дуу алдаад , үхэгсдийн хүүрэн дээгүүо дүүлсээр явж чимээ сонсогдсон газарт хүрч очсонд , нуур шиг тунасан цусанд дотор Арторикс хэвтэж царай нь хувхай цагаан болж, бие нь хөрсөнб айжээ
. Үхлийн хүйтэн савaрт чанга баригдсан Арторикс хөшсөн зовхио хааяа нэг нээж байлаа . Мирца түүнтэй зэрэгцэн хэвтэж , хүйтэн болсон нүүрий нь дахин дахин үнсэж :

- Чи минь амьд байна… миний хайрт, миний хонгор Арторикс минь! Чинийхээ амийг би аварч ч магадгүй шүү дээ… шархы чин боож өгье… аюулгүй газар чамайгаа би аваачъя… гэжээ . Мирцагийн энэ

үг мөн хайрт үнсэлтийн дөл нь үхэж байсан Арториксыг хөшсөн байдлаас нь сэргээжээ . Арторикс үхэж байсан ч нүдээ нээж ,

- Чи миний мирца юу? … чамтайгаа уулзах минь энэ үү? … ийм хурдан уу?… тэгвэл Элизиумд ирээд байна уу? … тэгээд яагаад Элизиумд ийм хүйтэн байдагт юм ? гэж сулхан хэлжээ .

Бүсгүйн хайр дурлалын тгэл нь ундран:

- Үгүй! Үгүй хонгор минь! Бид Элизиумд очоогүй байна… би байна, би чиний Мирца байна! … чи минь амьд байна… чи минь үхээгүй .. чиний амьд байх явдалд надад хэрэгтэй … иймд чи минь үхэхгүй гэж дуу алдлаа .

- Тэгвэл энэ чинь , энэ насанд болж байгаа хэгэг үү? … би амьд байгаа юм уу? Амьд байхдаа… чамайгаа үнсэх… хувьтай байжээ?…

- Тийм тийм . Арторикс минь .. чи минь үхэх ёсгүй … би чинь чинийх шүү дээ … бүх зүрх сэтгэлээрээ чинийх р шүү дээ …

- Би баяртай үхэж байна! Миний залбиралыг … Гез сонссон…

Арторикс сэтгэл баясан , зүрх нь догдолж , сүүлчийн тамир барагдан дуу нь суларчээ .

Арторикс Мирцаг үнсэн:

- Мирца минь ээ , би чинь үхэж байх шиг байна шүү … гэлээ .

- Чи минь ганцаараа битгий үх .. намайгаа хүлээ… хоёулаа хамт үхэж , хамт Элизиумд очъё гээд Арториксын бүсэнд байсан чинжал хутгыг шүүрэн авч гүрээнийхээ судсыг зоригтой тас огтолж орхиод хайрт залуугаа чанга тэвэрч,

- Чамтайгаа хамт үхэж, сайн заятны сүнс орших газар хамт очъё гэжээ .

- Чи минь … яаж байна? гэж үхэж байгаа Арториксын дөнгөж сонсогдох төдий дуугаар асуухад.

- Чинийхээ амсаж байгаа зовлонг хуваан амсалцаж байна… хайрт хонгор минь гэжээ .

Мирца гүрээнийхээ судсбг бараг тас огтолсон учир мөн л зовж үг хэолдэг болжээ . гэвч мирца Арториксыг чанга тэвэрсэн хэвээр үнсэж байжээ .Хөөрхий энэ хоёрын бие сүүлчийнхээ үнсэлтээр нийлсэн хэвээр царцжээ .

Энэ үед хоёр гладиатор , талын дундуур маш болгоомжтой явсаар Спартакийн унасан газарт хүрч ирлээ . Энэ хоёр Спартакийн биеийг авч явсан, энэ хоёр хүнийг эндээс хоёр миль зайтай газар замын дэргэд үхэр хөллөсөн модон тэрэг хүлээж байсан ажээ .

Спартакийн биеийг тэр тэргэнд ачиж, дээрээс нь тэрэгний хажууд байсан хэдэн шуудай будаа ачиж, Спартакийн биеийг тээж явга гэж огт сэжиглэмээргүй болгож хөдөлсөнд тэрэгний хойноос хоёр цэргийн хүн дагаж явжээ .

Энэ хоёр цэргий хүн нь валериягийн Тускулан дахь ордны дарга Либедийн ихэр хөвгүүд Ацилий, Аквидий хоёрб айсан юм . Энэ хоёр хүн, алагдсан их удирдагёчийн биеийг ялагчдын бузар доромжлолд хүргэхгүйн тулд хайрт эзэн авхайнхаа ордонд аваачиж өгөхөөр яваа нь энэ байжээ .

Брадануст болсон тулалдаанаас хойш арван тав хоног өнгөрсний дараа гладиаторуудын дан төгсгөл болжээ . Энэ аймшигт яргаллаас амь гарсан нь уул хадаар тархан удирдсан хүнгүй хэсүүчлэн зугтаж явсан тэр хэдхэн мянган хүмүүсийг нэгэн талаас Крассын цэргүүд нөгөө талаас Помпейн цэргүүд салгалгүй намнасаа р явж , хэдхэн хоногийн дотор хэрчлэн алж дуусжээ . дөнгөж зургаахан мянган хүн амьдаараа олзлогдсоныг капуягаас ром очих Аппиевийн замын дэргэдүүр цувуулан дүүжлэн алжээ .
Браданусын тулалдаанд алагдагсдын дотор Спартакийн биеийг олох гэсэн оролдого нь дэмий болж түүнийг олж чадсангүй . Энэ талаар янз бүрийн таамаглал ихэд ярилцаж байсан боловч түүний гану нь ч үнэн байдалд огт хавирсангүй балаа .
Бараг дөрвөн жил шахам үргэлжилсэн энэ дайн ингэж төгсчээ . Энэ дайны үед гладиаториууд , эрэлхэг зоригтой тулалдаж эрх чөлөөгөө олж авбал зохих , мөн агуу их үйл хэрэг бүтээж чадах хүмүүс болохыг үзүүлж өгчээ .

Одоо энэ түүхээ төгсгөн, уншигчидынхаа анхаарлыг тус номынхоо хоёр баатартай дахин уулзуулъя.
Браданусын дэргэд ыолсон тулалдаанаас хорин хоёр хоногийн дараа, красс , помпей нар бослого дарсан алдар хүндээ марган %
консулын суурийг булуулдагн бие биеэ үзэн ядаж, бие биендээ атаархан өжтөөрхөж цэргүүдэ авч Ром очиж явах үед нь гоо сайхан валерия гашуудлын бор өнгийн хувцастай , тускулум дахь орлдныхоо конклав ьанхимын нэгэн сандал дээр сууж байжээ .
Мессалын охины царай цонхигор цайвар болж , саяхан амссан гүн гашуудалын тэдмэг нүүрэн дээр нь тодхон харагдаж байжээ .
Удаан уйлж зовхи нь хавдаж нүд нь улайжээ .
Түүний мяндсан зөөлөн ширхэгтэй өтгөн хар үс нь гайхамшигт сахан мөрөн дээр нь намиран бууж, зүрх сэтгэлийг нь шаналган тарчилгаж байсан аймшигт гашуудлынтэмдэг түүний мойл хар нүд нь тунгалаг сайхан царайд нь тодхон харагдаж байлаа . валерия , хөөрхөн хийцтэй гантиг чулуун ширээний дэргэд шанаагаа тулж суусан балаа . Ширээн дээр нь грек урчуудын алт шарж хийсэн хүрэл бамбай байлаа .
Валерия нэгэн гартаа цаас барьж , хав хар нүдээрээ бамбайн зүг ширтэн суужээ .
“Надад учирсан гашуудалтай тэмцэх ийм сүрхий гашуудал байдаг болов уу!” гэж байгаа мэт тэсгэлгүй гашуудан байгаа нь хөөрхөн царайн дээр нь тодхон харагдаж байсан . Энэ гоо сайхан авгайг Ниобеятай адилтгаж болхо мэт байлаа .
Мөн тэр ширээний дэргэдэх бандан дээр цайвар шар үстэй хөөрхөн Постумия , гашуудлын хувцастай зогсож байжээ . Бяцхан охин , бунхны гадар чимэглэлийн цутгамал товгор хээ угалзыг дагуулан жаахан гараараа зурж, удаан дуугүй суулаа а гэж ээждээ уцаарлаж байх мэт сэргэлэн нүдээрээ хааяа хааяа эхийнхнээ зүг харж байлаа .
Валерия гөлөрсөн байдлаасаа гэнэт гарч ,б аруун гартаа барьж байсан захиагаа харж, түүнээ дахин уншлаа . тэр захидлы нь үг ийм байжээ :

*“ДАГИНА МЭТ ВАЛЕРИЯ МЕССАЛД СПАРТАКААС*
*БАЯР ХҮРГЭН ЗОЛ ЖАРГАЛ ХҮСЪЕ*

Дагина мэт Валерия минь ээ, чамдаа хайртай учир би Марк Красстай уулзаж ярилцлаа. Чинийхээ төлөө болон мөн чи бил хоёрын хайрт охин Постумийнхаа төлөө , түүнтэй уулзахыг би зөвшөөрсөн юм . Гэвч Сицилийн претор, хэрвээ намайг нөхдөөсөө урваж нөхдийгөө барьж өгвөл миний амийг хэлтрүүлэн, намайг чөлөөт иргэн болгоно гэдээ .

Иймд нөхдөөсөө урваж тэднийгээ д дайсанд барьж өгч , нэрээ үүрд бузарласанд орвол чинийхээ ачийг үл бодогч хүн, охиныхоо өмнө нинжин сэтгэлгүй хүн болсон минь дээр гэж үзлээ .

Энэ захидлыг чамд хүрэх үед би амьд байхгүй билээ . Одоо бид шийдвэрлэх том тулалдааны босгон дээр байна, тэр тулалдаанд миний амь , нэр хүндтэй үрэгдэнэ.

Миний хувь зохиол ийм байжээ .

Чамдаа, миний учруулсан бүх зовлонгийн төлөө, дагина мэт валерия чамаасаа уучлал хүсэх хэрэгтэй байна гэж үхлийнхээ босгон дээр хүрсэн энэ үедээ би бодлоо .

надад хайртайгийнхаа төлөө, хайрт охиныхоо төлөө зоригоо чангалан амьдрах хэрэгтэй гэж үхлийнхээ замд мордсон би чинь чамаасаа хүсье.

Нулимсандаа шахагдсан хоолой минь зангирч амьсгалд минь давхцаж байна. Чамайгаа үүрд мөнхийн сүнсийг минь диваажинд уулзан тэврэнэ гэдэг ганцхан найдвар- миний сэтгэлийг тайгаруулж байна.

Чинийхээ зүг Спартакийн зүрхний сүүлчийн нь цохилт сүүлчийн нь оюун , сүүлчийн нь үнсэлтийн хамт хийсэн хүрнэ

валерия Спартакийн захидлыг уншиж дуусаадп , уруулдаа нааж, үнсэн цурхиртал уйлжээ .

- Ээжээ, чи юунд уйлна вэ? гэж охиныхоо уйтгарлан асуухад , Постумийнхаа буржгар үстэй цайвар шар толгйогий нь илбэж:
- Хөөрхий охин минь ! Зүгээр … зүгээр битгий уйтгарла

Хайрт минь ! гээд Охиныхоо толгойг тэврэн дахин дахин үнсээд бас асгаруулан уйлжээ .

Постумия эхийгээ буруушаасан бололтой

- Яагаа ч үгүй байтлаа, уйлаад яаж байгаа юм ? Намайг, уйлахад , чи муу охин гэдэг шүү дээ тэгвэл одоо чи өөрөө муу байх нээ .. гэлээ .

Хөөрхий Валерия охиноо улам чанга үнсэж эрхлүүлж:

- Битгий тэгж хэл , чамайг тэгэхээр ээж чинь улам их шаналан зовж байна гэхэд нь:
- Чамайг уйлахад би бас зовж байна
- Одоогоос эхлэн миний цорын ганц хайр сэтгэл болсон чи минь , хонгор сэтгэлтэй зориг хатуутай ажээ гэжээз .

Хөөрхий Валерия захидлаа дахин үнсэж өвөрлөөд , Постумиягаа өвөр дээрээ суулгаж , арай ядан нулимсаа барьж :

- хөөхий бяцхан охин минь зөв хэлжээ , үнэхээр би муу хүн байжээ … одоо би сайн болно… Би үргэлж сайн хэвээрб айж , зргэлж чамайгаа бодож байгдаг болно. Чи хөөрхий муу ээждээ хайртай байх уу? гэжээ .

- Би хэзээд , чамдаа хайртай байна! гэж
  постумия хэлээд ээжийнхээ хүзүүгээр тэвэрч үнслээ .

Ээжийнхээ тэврэлтээс чөлөөлөгдөн , Пастумия бумбыг гараараа илж байжээ . Удтал , конклав танхимд анир чимээ гарсангүй

- Ээжээ үүний дотор юу байдаг юм хэлж өгөөч гэж Постумия ээжээсээ гэнэт асуулаа .

Валериягийн нүд нулимсаар дүүрч , тэнгэр өөд гашуудан харж,

- Хөөрхий бяцхан охин минь!… гээд хүчдэн нулимсаа барьж:
- Энэ бумбан дотор хөөрхий, эцгийн чинь чандар оршдог юм гэж чичирсэн дуугаар хэлээд дахин цурхиртал уйлжээ .